



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ - II (2015 ОН)

**УЛААНБААТАР ХОТ
2016 ОН**



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН


**СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН
ЭМХЭТГЭЛ - II
(2015 ОН)**



УЛААНБААТАР ХОТ
2016 ОН

**JUDICIAL GENERAL COUNCIL
JUDICIAL RESEARCH, INFORMATION AND TRAINING INSTITUTE**

**COMPILATION OF RESEARCH
STUDIES - II
(2015)**

The logo is a circular emblem with a light blue background. In the center, there is a golden scale of justice. The scales are flanked by two golden hands, one on each side, as if holding the scales. The entire central design is encircled by a golden laurel wreath. At the bottom of the wreath, there are several white lotus flowers.

**ULAANBAATAR, MONGOLIA
2016**

DDC

363.251001 42

C-701

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:

Т.Мэндсайхан	Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга
Ц.Мандах	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач, хууль зүйн ухааны доктор /LL.D/
Э.Өлзийлхам	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судалгаа хариуцсан ахлах референт /MA, LL.M/
С.Билгүүн	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн мэдээлэл хариуцсан ахлах референт / LL.M/

ЭМХЭТГЭСЭН:

Б.Ариунзаяа	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач /LL.M/
-------------	---

СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД:

Судлаачид:

Б.Ариунзаяа /LL.M/

Ч.Бат-Уянга

Ж.Ганзориг

Л.Галбаатар

Ц.Мандах /LL.D/

Э.Өлзийлхам /Докторант/

Г.Солонго

М.Сэлэнгэ

Т.Түмэнцэцэг

Шүүгчид:

П.Соёл-Эрдэнэ

Д.Баатархүү

Цаасны хэмжээ:

Хэвлэсэн тоо:

Хэвлэлийн хуудас:

Хэвлэлийн компани:

ISBN 978-99973-2-867-0

DDC
363.251001 42
C-701

Edited by

Mendsaikhan T. /Ph.D/ Executive Secretary General, Judicial General Council
Mandakh Ts. /LL.D/ Director, Judicial Research, Information and Training Institute
Ulziilkham E. /Ph.D Candidate/ Senior Researcher, Judicial Research, Information and Training Institute
Bilguun S. /LL.M/ Senior Researcher, Judicial Research, Information and Training Institute

Compiled by

Ariunzaya. B /LL.M/ Researcher, Judicial Research, Information and Training Institute

RESEARCH TEAM:

Researchers:

Ariunzaya B. /LL.M/

Bat-Uyanga Ch.

Ganzorig J.

Galbaatar L.

Mandakh Ts. /LL.D/

Ulziilkham E. /Ph.D
Candidate/

Solongo G.

Selenge M.

Tumentsetseg T.

Judges:

Soyol-Erdene P. /Justice/

Baatarkhuu D.



ISBN 978-99973-2-867-0

ӨМНӨТГӨЛ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн нь бүх шатны шүүхийг судалгаа, мэдээллээр хангах, шүүн таслах ажлын болон захиргааны ажлын практикийг судлах, шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг сургаж дадлагажуулах хуульд заасан чиг үүргийг 2014 оны 4 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлж байна. Шүүхийн судалгааны чиг үүргийнхээ хүрээнд тус хүрээлэн нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар бодлогын судалгаа, шүүхийн практикийн судалгаа, лавлагаа, зөвлөмж боловсруулж, шүүгч, судлаач, олон нийтийн хүртээл болгодог.

Энэхүү эмхэтгэлээр тус хүрээлэнгээс 2015 онд хийж гүйцэтгэсэн судалгааны бүтээгдэхүүнийг эмхэтгэн эрхэм шүүгч, шүүхийн захиргааны ажилтнууд, судлаач, хуульчид Та бүхэнд толилуулж байна.

2015 оны хувьд тус хүрээлэнгээс гүйцэтгэсэн судалгааны ажлын дийлэнх хэсэг нь шүүх судлал, шүүхийн эрх зүйн хүрээнд тулгамдсан зарим асуудал, тухайлбал, шүүгчийн хараат бус байдал, сахилга, хариуцлагатай байдал, ёс зүйн гомдол шийдвэрлэх асуудал, шүүхийн иргэдийн төлөөлөгч, шүүгчийг сэлгэн ажиллуулах эрх зүйн зохицуулалт зэрэг асуудалд голчлон чиглэсэн болно. Цаашид судалгааны нэр төрөл, агуулгыг чанаржуулж сайжруулах, судалгааны үр дүнг эргэлтэд оруулж, бодлогын шийдвэрт тусгах чиглэлээр цөөнгүй ажил хүлээж байгааг дурдах нь зүйтэй.

Түүнчлэн тус хүрээлэнгээс шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх нэгдсэн аргачлалын төслийг санаачлан боловсруулж, шүүгчид, эрдэмтэн судлаачид, хуульчдаар хэлэлцүүлсэн бөгөөд аргачлалыг энэ эмхэтгэлээр Та бүхний хүртээл болгож байна.

Эмхэтгэлд орсон судалгаа, лавлагаа, зөвлөмж зэрэг бүтээгдэхүүн нь урьд хэвлэгдээгүй тул энэ чиглэлээр шимтэн судалдаг хэн бүхний цаашдын судалгааны ажилд дэмжлэг болно гэж найдаж байна. Эмхэтгэлтэй танилцаж, судалсан Та бүхэн цаашид боловсронгуй болгох, сайжруулах тал дээр санал, зөвлөмж, шүүмжээ манай хаягаар ирүүлэхийг хүсье.

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын
хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор

Ц.Мандах

ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт.....	1
БОДЛОГЫН СУДАЛГАА.....	1
ШҮҮГЧИЙН ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО.....	2
Удиртгал.....	2
Нэг. Шүүгчийн хариуцлагын тухай ойлголт: хариуцлагын хэмжүүрийг тодорхойлох нь.....	4
Хоёр. Шүүгчийн ёс зүйн хариуцлага, шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэх бусад арга хэрэгсэл.....	11
Гурав. Шүүгчийн мэргэшлийн ур чадварын түвшинг үнэлж, дүгнэх асуудал.....	26
Дөрөв. Шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах, огцруулах асуудал: монгол улсын болон гадаадын зарим улсын туршлага.....	35
Монгол улсын шүүхийн шүүгчийн хариуцлагын тогтолцоо, өнөөгийн байдлыг боловсронгуй болгох нь: дүгнэлт, санал, зөвлөмж.....	49
ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ГОМДОЛ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА.....	57
Удиртгал.....	57
Нэг. Монгол улсад шүүгчийн ёс зүйн гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжилт, тулгамдсан асуудал.....	57
Хоёр. Шүүгчийн ёс зүйн гомдол шийдвэрлэсэн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ.....	66
Гурав. Молдав, ОХУ, Эстони, Япон улсын шүүгчийн ёс зүйн гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа.....	73
Дүгнэлт.....	85
ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ТОГТОЛЦООГ ОНОВЧТОЙ БҮРДҮҮЛЭХ НЬ.....	88
Удиртгал.....	88
Нэг. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн зохицуулалт, эрх зүйн байдал.....	89
Хоёр. Гадаадын зарим улс дахь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцооны хэлбэрүүд.....	98
Дүгнэлт.....	114
ШҮҮГЧИЙГ СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ.....	119
Удиртгал.....	119
Нэг. Шүүгчийг сэлгэн ажиллуулах эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал.....	119
Хоёр. Шүүгчийг сэлгэн ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь.....	126
Дүгнэлт.....	132
СУДАЛГАА.....	135
ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ БА МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ ДЭХ ИРГЭНИЙ ХЭРГИЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ АЖИЛЛАГАА.....	136
Удиртгал.....	136
Нэг. Монгол улсын олон улсын иргэний процессын эрх зүйн зохицуулалт, түүхэн хөгжил.....	138
Хоёр. Гадаад улсад шүүхийн баримт бичгийг гардуулах.....	146
Гурав. Нотлох баримтыг хилийн чанадад бүрдүүлэх.....	149
Дөрөв. Шүүхийн үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох.....	152
Тав. Гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх, татгалзах.....	155
Дүгнэлт.....	159

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙГ ДАВЖ ЗААЛДАХ, ХЯНАЛТЫН ШАТНЫ ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШИЙДВЭРИЙН ҮНДЭСЛЭЛ, ТӨРӨЛ	162
Удиртгал.....	162
Шүүхийн шийдвэр, магадлалыг өөрчилсөн, хүчингүй болгосон үндэслэл, процессын зөрчил.....	162
Дүгнэлт.....	172
ЛАВЛАГАА.....	175
ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ШҮҮГЧИЙН ТОО БА 100.000 ХҮН АМД НОГДОХ ШҮҮГЧИЙН ТООН ХАРЬЦУУЛАЛТ	176
ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ШҮҮГЧЭЭР ТОМИЛОГДОХ НАСНЫ ДООД ХЯЗГААРЫГ ТОГТООСОН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	179
ӨРШӨӨЛ БОЛОН УУЧЛАЛЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ	185
ШҮҮХ ХУРАЛДААНЫ ЯВЦЫГ ОЛОН НИЙТЭД ШУУД ДАМЖУУЛАХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА	195
ШҮҮГЧИЙН АЖЛЫН АЧААЛЛЫГ ТООЦОХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА	201
АРГАЧЛАЛ	207
ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ.....	208
Удиртгал.....	208
Нэг. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний ерөнхий ойлголт	208
Хоёр. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний үндсэн бүтэц.....	210
Гурав. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний агуулга.....	210
ХАВСРАЛТ	215
Хавсралт №1 /Шүүх дэх иргэдийн төлөөлөгчийн оролцоог оновчтой бүрдүүлэх нь/215	
Хавсралт №2 /Олон улсын иргэний процессын эрх зүй ба Монгол Улсын шүүх дэх иргэний хэргийн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаа/	222
Хавсралт №3 /Шүүх хуралдааны явцыг олон нийтэд дамжуулах гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт, туршлага/	224

TABLE OF CONTENTS

List of Abbreviations

POLICY STUDIES

1. JUDICIAL ACCOUNTABILITY SYSTEM
 - i. Introduction
 - ii. One. Concept of Judicial Accountability: Determining Accountability Assessment Tools
 - iii. Two. Judicial Ethical Responsibilities and Other Instruments for Improving Judicial Accountability
 - iv. Three. On the Evaluation and Assessment of Professional Skills of Judges
 - v. Four. Taking Disciplinary Actions Against the Judges and Resignation of Judges: Challenges in Mongolia and Best Practices from Other Countries
 - vi. Five. Improving Judicial Accountability in Mongolia
 - vii. Conclusion and Recommendations
2. PROCEDURES ON RESOLVING COMPLAINTS RELATED TO JUDICIAL CONDUCT
 - i. Introduction
 - ii. One. Current Procedures on Resolving Complaints Related to Judicial Conduct in Mongolia and its Challenges
 - iii. Two. Case Analyses Related to Judicial Conduct
 - iv. Three. Procedures on Resolving Complaints Related to Judicial Conduct in Moldova, Russian Federation, Estonia and Japan
 - v. Conclusion and Recommendations
3. IMPROVING THE LEGAL ENVIRONMENT OF THE JUROR SYSTEM
 - i. Introduction
 - ii. One. Legal Regulation and Status of Jurors
 - iii. Two. Forms of Participation of Jurors in Some Countries
 - iv. Conclusion and Recommendations
4. IMPROVING THE LEGAL ENVIRONMENT FOR THE ROTATION OF JUDGES
 - i. Introduction
 - ii. One. Legal Regulation of the Rotation of Judges in Mongolia
 - iii. Two. Improving the Legal Environment for the Rotation of Judges
 - iv. Conclusion and Recommendations

STUDIES

5. INTERNATIONAL CIVIL PROCEDURE LAW AND MONGOLIAN JUDICIAL ASSISTANCE IN CIVIL MATTERS
 - Introduction
 - i. One. Legal History on the Development of the International Civil Procedure Law in Mongolia
 - ii. Two. Issuing Judicial Documents Abroad in Civil Matters
 - iii. Three. Taking Evidence Abroad in Civil Matters
 - iv. Four. International Access to Justice
 - v. Five. Recognition, Enforcement of Foreign Court Decisions and Refusing to Enforce Foreign Court Decisions
 - vi. Conclusion and Recommendations
6. STARE DECISIS FOR APPELLATE AND SUPREME COURT DECISIONS IN ADMINISTRATIVE CASES
 - i. Introduction
 - ii. Grounds for Amending and Reversing Decisions of First Instance and Appellate Courts
 - iii. Conclusion and Recommendations

REFERENCE

7. MINIMUM AGE REQUIREMENTS FOR JUDICIAL APPOINTS IN OTHER COUNTRIES
8. NUMBER OF PROFESSIONAL JUDGES PER 100,000 CITIZENS IN SOME COUNTRIES
9. CONSTITUTIONAL REGULATION OF AMNESTY AND PARDON IN SOME COUNTRIES
10. LEGAL REGULATIONS AND BEST PRACTICES ON BROADCASTING COURT SESSIONS IN SOME COUNTRIES
11. METHODOLOGY FOR ASSESSING THE CASELOAD OF JUDGES IN SOME COUNTRIES METHODOLOGY

APPENDICES

12. GUIDELINES AND METHODOLOGY OF CASE ANALYSIS



Товчилсон үгийн жагсаалт

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЗСБНХУ	Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс
ИБУИНВУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨАБНУ	Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс
УИХ	Улсын Их Хурал
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШСМСХ	Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн
ШУА	Шинжлэх ухааны академи
ШЁЗХ	Шүүхийн ёс зүйн хороо
ШЁЗХД	Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм
ЭСЯ	Элчин сайдын яам



БОДЛОГЫН СУДАЛГАА

ШҮҮГЧИЙН ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО¹

Удиртгал

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд баталсан Шүүхийн багц хууль нь шүүхийн бие даасан, нээлттэй, ил тод байдлыг хангах, шүүхийн захиргаа, төсвийг бие даалгах, шүүх, шүүгчийн ажлын ачааллыг зохистой болгох, шүүгчийн ур чадвар, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх зорилгыг агуулсан. Гэвч иргэд, олон нийтийн дунд шүүгчдэд хариуцлага тооцох асуудал ямагт хурцаар тавигдаж,² энэ нь иргэдийн шүүхэд итгэх итгэлд нөлөөлөх гол хүчин зүйл болж байдаг тул шүүгчийн хариуцлагын тогтолцоо сэдвийг энэ бодлогын судалгааны хүрээнд судалж, шүүхийн шинэтгэлийн үр дүнг гурван жилийн дараа үнэлэх, шүүгчдийн ёс зүйн талаарх ойлголт, сэтгэлгээ өнгөрсөн хугацаанд хэрхэн төлөвшиж, тэдний нийгмийн өмнө хүлээх үүрэг хариуцлага хэр дээшилснийг авч үзэхийг зорьсон. Бодлогын судалгааны удирдамжийн дагуу тус судалгааны зорилго нь шүүгчийн ёс зүй, мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг үнэлж дүгнэх болон шүүгчийн сахилга-ёс зүйн хяналтыг хэрэгжүүлэх механизм (цаашид “шүүгчийн хариуцлагатай байдал” гэх)-ыг боловсронгуй болгох зорилгоор гадаад улсын сайн туршлагыг харьцуулан судалсны үндсэн дээр үндэсний эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлж болох боломжит хувилбарыг дэвшүүлэхэд оршино.

Монгол Улсын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “шүүгч” гэж “хуульд заасан үндэслэл, журмын дагуу томилогдон, хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг сахиулан хамгаалахаар тангараг өргөсөн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа Монгол Улсын иргэнийг” хэлнэ гэж тодорхойлсон байдаг. Шүүхийн эрхэм зорилго бол хүний эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, хууль дэг журмыг дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх³ болон хэн боловч олон улсын стандартад нийцсэн шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангахад чиглэгдэнэ. Энэ зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд улс орон бүр шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг баталгаажуулдаг. Шүүх нь үндсэн хуульт ёс болон шударга ёсыг батлан хамгаалах хамгийн хүчтэй арга хэрэгсэл болдог тул шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдал нь эрх зүйт ёс болон эрх мэдэл хуваарилах онол, сургаалын салшгүй нэг хэсэг болдог. Бие даасан, хараат бус шүүх Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон ардчилсан дэг журмыг баталгаажуулж байдгаараа эрх зүйт ёсыг бий болгодог. Үүгээрээ Монгол Улс бусад улс орны нэгэн адил шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бататгаж өгсөн.

¹ Энэ бодлогын судалгааг Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирал Ц.Мандах /LL.D/, Шүүхийн судалгаа хариуцсан ахлах референт Э.Өлзийлхам /Ph.D Candidate/, судлаач Ч.Бат-Уянга нар хамтран гүйцэтгэсэн болно. Тус бодлогын судалгааны Япон улсын эрх зүйн зохицуулалттай хэсгийг ШСМСХ-ийн судлаач Б.Ариунзаяа, ОХУ-ын эрх зүйн зохицуулалттай хэсгийг ШСМСХ-ийн судлаач Л.Галбаатар нар боловсруулав. Түүнчлэн хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ч.Энхбаатарт (Sc.D) энэ бодлогын судалгаанд үнэтэй шүүмж өгсөнд талархал илэрхийлье.

² Иргэдээс Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүгчийн хариуцлагын асуудлыг хэзээ авч үзэх вэ гэсэн захидал, хүлээлт, шаардлага тогтмол ирж байдаг. Тухайлбал, иргэн Г.Аюушмагаас ирсэн захидлыг ШЕЗ-ийн вебсайтад байршуулсан болно. <http://www.judcouncil.mn/main/2576--.html>

³ Д.Дамдин-Од, “Шүүгчийн хамгийн том хариуцлага бол өөрөө өөртөө тооцох хариуцлага л байдаг” /Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас: <http://www.judcouncil.mn/main/2023--.html/> (2015.07.15).

Монгол Улсын хувьд шүүхийн бие даасан байдлыг Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт зааснаар, “шүүх нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас бие даасан байх бөгөөд шүүх эрх мэдлийг аливаа байгууллага, этгээдээс хараат бусаар хэрэгжүүлнэ” гэж тодорхойлсон. Шүүгч нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хуульд захирагдаж, хараат бус, зарчимч, төвийг сахисан байхыг шаардана. Шүүгч бүрэн эрхийнхээ хүрээнд өөрийн дотоод итгэлээр гаргасан шийдвэртээ хариуцлага хүлээдэггүй. Хэрэв шүүгчид шийдвэрийнх нь төлөө хариуцлага хүлээлгэвэл Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйл, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан “Шүүгчийн хараат бус байдал халдашгүй байх бөгөөд шүүгчийн хараат бус байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар баталгаажуулна” хэмээх зохицуулалтыг зөрчиж, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх болно. Өөрөөр хэлбэл, шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлээр гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээхгүй байх нь олон улсын хэмжээнд мөрдөгддөг шүүхийн бие даасан, хараат бус байдлын баталгаа болдог. Гэхдээ энэ нь шүүгчид ямар ч тохиолдолд хариуцлага тооцож болохгүй гэсэн зүйл огт биш, харин энэ нь шүүгчид хариуцлага тооцохдоо хараат бус байдалд нөлөөлж болохгүй гэдэг хэм хэмжээний илрэл юм.

Шүүгчийн ажил мэргэжил, албан тушаал өөрөө өндөр хариуцлага шаардсан, шүүгч алдах эрхгүй онцлогтой мэргэжил юм. Шүүгчид гагцхүү мэргэжлийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ гаргасан аливаа ёс зүйн зөрчлийн төлөө сануулах, цалингаас хасах, огцруулах зэрэг шийтгэлийг ногдуулдаг. Шүүгчийг ноцтой, зүй бус үйлдэл гаргасан, сахилгын зөрчил болон эрүүгийн гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд огцруулах үндэслэл болно. Шүүгчийг огцруулах процессын ажиллагаа нь шударга явагдах ёстой. Шүүгчийг санамсаргүйгээр гаргасан алдаа эсхүл хуулийн тодорхой нэг тайлбартай санал нийлэхгүй байгаагийн төлөө огцруулах эсхүл бусад шийтгэл ногдуулж болохгүй. Цаашилбал, шүүгчид өөрийн шийдвэрээс үүссэн аливаа мөнгөн хохирлын төлөө хариуцлага хүлээхгүй. Тухайлбал, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Шүүгчийн алдаа, гаргасан зөрчлөөс хувь хүн, хуулийн этгээдэд учруулсан гэм хорыг Иргэний хуульд заасан үндэслэлийн дагуу төр хариуцан арилгана” гэж заасан байдаг.

“Шүүгчийн хариуцлага” гэдэг ойлголтыг шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлаас салгаж үл болох, нэг зоосны хоёр тал юм. Хариуцлагатай мэргэшсэн шүүх нь олон нийтийн итгэл, хүндлэлийг хүлээдэг бол шүүхийг хараат бусаар ажиллуулах гэсэн олон нийтийн итгэл, хүсэл эрмэлзэл нь шүүхийг хараат бус байх, зарчимч байх шаардлагыг тавьдаг.⁴ НҮБ-ын тусгай илтгэгч “Шүүгч болон хуульчийн хараат бус байдал”-ын талаарх тайландаа “Улс орнууд шүүхийн хариуцлагын талаарх олон улсын хэм хэмжээг баталж, хөгжүүлэх талаар хамтран ажиллах төдийгүй дотооддоо үр дүнтэй, бодитой, ил тод, олон улсын хүний эрхийн талаар хүлээсэн үүрэгтээ нийцэхүйц шүүхийн хариуцлагын иж бүрэн тогтолцоог бий болгох талаар анхаарах шаардлагатай” гэжээ.⁵ Түүнчлэн тус тайланд “шүүгч,

⁴ Шүүхийн ерөнхий зөвлөл, “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад шүүхийн захиргааны үүрэг, тулгамдсан асуудлууд” олон улсын онол-практикийн бага хурлын илтгэлийн эмхтгэл, 2014 он, Улаанбаатар, 19 дэх тал

⁵ Gabriela Knaut, Report of the Special Rapporteur on the Independence of Judges and Lawyers – Judicial Accountability, 2014, A/HRC/26/32 United Nations, General Assembly

прокурор, өмгөөлөгчдийн хүлээх хувь хүний хариуцлага нь тус тусын ажил мэргэжилд хамаарах бөгөөд хувийн хариуцлагын асуудал нь тэдгээрийн мэргэжлийн, зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа, тусгайлан олгогдсон эрх болон хууль, шүүхээс гадуурх хувийн харилцаанд нэгэн зэрэг хамаарагдах” талаар тусгасан байна. Иймд “Шүүгчийн хариуцлагын тогтолцоо” сэдэвт бодлогын судалгааны хүрээнд шүүгчийн хариуцлагын тухай ойлголт: хариуцлагын хэмжүүрийг тодорхойлох, шүүгчийн ёс зүйн хариуцлага болон хариуцлагыг дээшлүүлэх бусад арга хэмжээ, шүүгчийн мэргэжлийн ур чадварын түвшинг үнэлж, дүгнэх асуудал, шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах, огцруулах асуудал: Монгол Улсын болон гадаадын зарим улсын туршлага зэрэг дэд сэдвийн хүрээнд авч үзэж, эдгээр асуудлын хүрээнд Монгол Улсад хэрэгжүүлж болох санал, зөвлөмжийг дэвшүүлсэн болно.

Нэг. Шүүгчийн хариуцлагын тухай ойлголт: хариуцлагын хэмжүүрийг тодорхойлох нь

1.1. Шүүгчийн хариуцлагын тухай ойлголт

Хүний эрхийн суурь баримт бичгүүдэд⁶ тусгаснаар “хүн бүр хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр тэгш эрхийн үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй”. Монгол Улсын Үндсэн хуульд ч мөн адил хүн бүр “шударга шүүхээр шүүлгэх”⁷ эрхтэйг бататгасан байдаг. “Шударга шүүхээр шүүлгэх” нь хүний үндсэн эрхийн нэг⁸ бөгөөд шүүх эрх мэдэл энэ эрхийг хангахад зорих ба хангагдах эсэх нь тухайн улсад төрийн эрх мэдлийг зүй зохистойгоор хуваарилж чадсан эсэхээс шалтгаална.⁹ Ардчилсан, эрх зүйт төрийн гол шинж нь “төрийн эрх мэдэл хуваарилах”¹⁰ онолын дагуу эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван салаа мөчирт хуваан, тэдгээрийн дунд хяналт, тэнцвэрийн зарчмыг хангасан байх бөгөөд ингэснээр хүний үндсэн эрхийг баталгаатай хангах боломжтой юм.¹¹ Бие даасан, хараат бус, тал үл харах, үр дүнтэй шүүх тогтолцоог

⁶ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 10 дугаар зүйл; Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 10 дугаар зүйл; Европын хүний эрхийн конвенцын 6 дугаар зүйл болон бусад олон улсын баримт бичгүүдэд тус тус заасан байна.

⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13, 14.

⁸ Гонзалез де Рио ба Неру, Хүний Эрхийн Төлөв Байдлын тухай илтгэл, (A/48/40), 1993 он, 20 дахь тал

⁹ Justice F.B. William Kelly, “An independent judiciary: the core of the rule of law by justice”

<http://www.docdatabase.net/more-an-independent-judiciary-the-core-of-the-rule-of-law-47284.html>

¹⁰ Энэ ойлголтыг анх английн философич Ж.Локк үндэслэж, Францын философич Ш.Л.Монтескью орчин үеийн утгаар тодорхойлсон. Ш.Монтескью өөрийн “Хуулиудын амин сүнс” бүтээлдээ, Төрийн эрх мэдэл хуваарилах онолын үндэс нь “хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг нэг этгээдэд буюу байгууллагад нэгтгэвэл, эрх чөлөө хэрэгжихгүй бөгөөд эзэн хаан болон хууль тогтоогчид дарангуй хуулийг тогтоож, хэрэгжүүлэх аюул тулгарна. Түүнчлэн шүүх эрх мэдэл хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс тусгаарлагдаагүй тохиолдолд мөн эрх чөлөө үл оршино. Хэрэв шүүх эрх мэдэл, хууль тогтоох эрх мэдэлтэй нэгдвэл, иргэдийн амьдрал, эрх чөлөө дур зоргын золиос болж, шүүгчид хууль тогтоогчид болно. Хэрэв шүүх эрх мэдлийг гүйцэтгэх эрх мэдэлтэй нэгтгэвэл шүүгчид дарангуйлагчид болох бололцоог бүрдүүлнэ” гэж үзсэн. Ш.Л. Монтескью /орч. Т.Төмөрхөлөг/ “Хуулиудын амин сүнс”, 2008 он, Улаанбаатар

¹¹ United Nations, “Human rights in the administration of justice: A Manual on Human Rights for Judges, Prosecutors and Lawyers” Professional training series No. 9, 2008, New York and Geneva

<http://www.ohchr.org/Documents/Publications/training9add1.pdf>

бүрдүүлэх, иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангахад шүүхийн бие даасан болон шүүгчийн хариуцлагатай байдал гэсэн хоёр ойлголт голлох нөлөөтэй.

Хариуцлагыг ерөнхийдөө хариуцлага хүлээх, өөрийн үйлдлийн төлөө хариуцлага тооцуулахад бэлэн байх эсхүл хариуцлагатай байдал гэж тодорхойлдог.¹² Хариуцлагатай байдал гэдэгт тухайн хувь хүн өөрийн мэргэшил болон албан тушаалынхаа чиг үүргийг хэрэгжүүлэхдээ зан суртахуун болон ёс зүйн стандартыг мөрдөж ажиллах, гаргасан алдааныхаа төлөө хариуцлага хүлээх тухай ойлголт багтдаг.¹³ Шүүгчийн хариуцлагын талаар академич Ж.Амарсанаа онцлохдоо, “Хариуцлагатай байхын тулд шүүгч нар өөрсдөө боловсруулж, өөрсдөө хүлээн зөвшөөрч, өөрсдөө сайн дурын үндсэн дээр дагаж мөрддөг ёс зүйн дүрмээ ягштал баримталж ажиллах ёстой. Хариуцлагатай байна гэдэг сэтгэл зүрх, дотоод итгэл мэдрэмж, үнэний зориг, шударга ёсыг шүүгч өөртөө цогцлоон бүрдүүлэхийг хэлнэ. Хариуцлагыг тогтоон төлөвшүүлэх чухал хүчин зүйл бол шүүмжлэлийг хүлээж авах дотроо цэвэрших, эрүүл саруул эрчийг бүрдүүлэх явдал юм”¹⁴ гэж тодорхойлжээ. Монгол Улсад шүүгчийн хариуцлага гэдгийг дан ганц тухайн хүний зан авирын түвшинд ойлгож, хэрэгжүүлдэг байсан уламжлалт хандлагаас салж, үүнийг шүүгч нь “мэдэх ёстой юмаа мэдээгүй, хийх ёстой юмаа хийгээгүй” гэсэн өргөн хүрээнд авч үзэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.¹⁵

Олон улсын түвшинд байнгын анхаарал хандуулдаг нэг чухал асуудал нь улс орнуудын хувьд шүүхийн байгууллагын бие даасан байх баталгаагаар хангах тогтолцоог бататгах болон хөгжүүлэх явдал юм. Олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд шүүгчийн хариуцлагын талаар дэлгэрэнгүй тодорхойлолт хараахан гарч ирээгүй байна. Хэдий тийм боловч эдгээр баримт бичигт шүүхийн үйл ажиллагаанд шүүгчид хэрхэн зохистой байдлаар албан үүргээ гүйцэтгэх, ёс зүйтэй болон ёс зүйн стандартад нийцэж албан үүргээ гүйцэтгэх талаар “үүрэг”, “хариуцлагатай байдал”, “хариуцлага” зэрэг олон нэр томъёотой шүүгчийн хариуцлагын тухай ойлголтыг илэрхийлэхэд ашигладаг.

Шүүгчийн хариуцлагын гол зорилго нь шүүгчийн хараат бус байдлыг хадгалах, дээшлүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл, шүүгчийн хувьд “хараат бус байдал” гэсэн ухагдахуун нь эдлэх эрх төдийгүй хүлээх үүрэг юм. Шүүгч хараат бус байх ёстой, мөн олон нийтэд тэгж ойлгогдох ёстой. Үүний дагуу хараат бус байдал хэмээх ойлголтод хамаарах бүх зарчмыг хангахуйц байх ёстой. Шүүгчийн хариуцлагатай байдал нь “хуулийн дээр хэн ч байх ёсгүй” хэмээх эрх зүйт ёсны гол ойлголтын нэг бөгөөд шүүгч нь зан суртахууны болон мэргэжлийн хувьд ёс зүйгүй, зохисгүй байдал гаргахаас урьдчилан сэргийлэх ойлголтыг илэрхийлдэг. Шүүгчийн хариуцлагын стандартыг гол төлөв ёс зүйн дүрмийн дагуу тавих ба үлдсэн орон зайг шүүгчийн хараат бус байдлын зарчмууд болон олон улсын хүний эрхийн стандартуудаар нөхөж байдаг. Шүүгч мэргэшлийн үйл ажиллагаа төдийгүй хувийн орчинд биеэ авч

¹² Merriam-Webster dictionary online www.merriam-webster.com/dictionary/accountability

¹³ Gabriela Knaut, Report of the Special Rapporteur on the Independence of Judges and Lawyers, A/HRC/26/32 United Nations, General Assembly

¹⁴ Түүнчлэн доктор, профессор Б.Чимид “Хариуцлага гэж замбараа нацаггүй ярьцгаадаг боловч зах хязгааргүй ойлголт биш. Хэлсэн үг, өгсөн амлалт, хүлээлгэсэн итгэл, эрхэлсэн ажилдаа эзэн болдог, хүний мөс, ажил хэрэгч чанарыг илэрхийлсэн ёс суртахуун, улс төр хууль зүйн үнэлэмж юм” гэжээ. Ж.Амарсанаа, Ч.Сайнсанаа (ред), Б.Чимид, Төрийг засах ёс, 2014, Улаанбаатар, 21 дэх тал.

¹⁵ Н.Лүндэндорж, “Шүүгчийн ёс зүй ба хариуцлага” сэдэвт хэлэлцүүлэгт хэлсэн үг, Улаанбаатар, 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр <http://www.judcouncil.mn/main/2950--.html>

явахдаа ёс зүйн дүрэм, албан тушаалын хувьд оноосон үүрэг, хариуцлагыг ухамсарлан шүүгчийн сахилга, ёс зүйн стандартыг мөрдлөг болгох үүрэг хүлээдэг.¹⁶ Шүүгчийн алдааны төлөө хүмүүс хэт өндөр үнэ төлдөг тул шүүгч нь шүүгчийн болон хуульчийн мэргэжлийн хариуцлагыг дээд зэрэгт авч явах шаардлагатай ба үүнд ёс зүйн үүрэг, хариуцлага, хүн чанар, нэр төр зэрэг олон асуудал хамаардаг.¹⁷

1.2. Шүүхийн бие даасан байдал ба шүүгчийн хараат бус байдал

Шударга шүүхийн үндэс нь шүүхийн бие даасан байдал юм. Шүүхийн хараат бус байдал нь нэгдүгээрт, шүүх эрх мэдэл нь гүйцэтгэх, хууль тогтоох эрх мэдлээс ангид, бие даасан байх; хоёрдугаарт, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч субъект болох шүүгч нь аливаа нөлөөллөөс (олон нийтийн болон хэргийн оролцогчид г.м.) ангид, бие даан ажиллаж, гагцхүү хуульд захирагдан шийдвэр гаргадаг байх тухай ойлголт юм. Өөрөөр хэлбэл, шүүхийн хараат бус байдал нь хоёр утгыг өөртөө агуулна. Нэгдүгээрт, шүүх эрх мэдэл улс төр болон бусад төрийн байгууллагаас хараат бус байснаар шударга ёсыг хангах үндэс болох, хоёрдугаарт, шүүгчийн эрх мэдлээ хэрэгжүүлэх хараат бус байдлыг буюу шүүгч шүүн таслах ажиллагааг явуулахдаа хуулийн объектив утгын дагуу эрх мэдлээ хэрэгжүүлэх байдлыг илэрхийлнэ.¹⁸ Шүүхийн хараат бус байдал алдагдахад эрх мэдлийн тэнцвэрт байдал алдагдаж, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж, нийгмийн үнэт зүйл үгүй болгоход хүргэдэг. Үүний улмаас хараат бус шүүхийн гадуур шударга ёс, ардчиллыг тогтоох, хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх, хамгаалах бололцоогүй болдог.¹⁹ Шүүхийн хараат бус, бие даасан байдал хангагдсан эсэхийг шүүх бие даасан захиргаатай байх, эдийн засгийн баталгаатай байх зэрэг олон үзүүлэлтээр хэмжинэ.

НҮБ-аас шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд чухал баримт бичиг баталсан нь “Шүүх эрх мэдлийн бие даасан байдлын тухай үндсэн зарчмууд” (цаашид “НҮБ-ын Үндсэн зарчмууд” гэх) юм.²⁰ Тус зарчмуудад шүүгчийн хараат бус байдлыг хангахад шүүгчийн **албаны** (*institutional independence*) болон **хувийн** (*individual independence*) хараат бус байдлыг хангах, бэхжүүлэх шаардлагатай гэдгийг тусгажээ.²¹ Шүүгчийн **албаны хараат бус байдлыг** хангах, бэхжүүлэх нь төрийн эрх мэдлийг хэрхэн хуваарилснаас буюу хууль тогтоогчийн хүсэл зоригоос хамаарна. НҮБ-ын Үндсэн зарчмуудын 1 дүгээр зүйлд “Шүүхийн хараат бус байдлыг

¹⁶ Gabriela Knaut, Report of the Special Rapporteur on the Independence of Judges and Lawyers, A/HRC/26/32 United Nations, General Assembly

¹⁷ Л.Мөнхсайхан, Ж.Наранцацрал, М.Батсуурь, “Хуульчийн ёс зүй” гарын авлага, Хууль зүйн яам, “Хууль зүйн салбарыг сайжруулах төсөл”, 2013, Улаанбаатар, 16 дахь тал

¹⁸ Тухайлбал, Япон улсын Үндсэн хуулийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь хэсэгт “Шүүгч бүр өөрийн дотоод итгэлээр бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хараат бус байх бөгөөд гагцхүү Үндсэн хууль болон бусад хуульд захирагдана” гэж зааснаар шүүхийн хараат бус байдлыг бүрдүүлж, шүүгчийн шүүн таслах үйл ажиллагааны хараат бус байдлыг тодорхойлж өгчээ. Моригива Ясутомо, “Хуульчийн ёс зүй”, 2007 он, Улаанбаатар, 338-343 дахь тал

¹⁹ Н.Лүндэндорж нар “Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь” бодлогын тойм судалгаа, 2010 он, Нээлттэй нийгэм форум, Улаанбаатар

²⁰ “Шүүхийн хараат бус байдлын НҮБ-ын үндсэн зарчмууд” (Basic Principles on the Independence of the Judiciary), НҮБ-ын 1985 оны 8 дугаар сарын 26-аас 9 дүгээр сарын 6-ны өдөр Миланд болсон VII их хурлаар баталж, Ерөнхий ассамблейн 1985 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 40/32, 1985 оны 12 дугаар сарын 13-ны 40/46 дугаар тогтоолоор сайшаасан. Энэ бодлогын судалгаанд “Шүүхийн хараат бус байдлын үндсэн зарчмууд”-ыг Н.Лүндэндорж, О.Энхбаатар нарын орчуулсан хувилбарыг ашиглав.

²¹ United Nations, “Human rights in the administration of justice: A Manual on Human Rights for Judges, Prosecutors and Lawyers” Professional training series No. 9, p.120

төрөөс баталгаажуулж, тухайн улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид тусган баталгаажуулж, засгийн газар болон түүний харьяа байгууллагууд шүүхийн хараат бус байдлыг хүндэтгэж, сахин биелүүлнэ”, харин энэ баримт бичгийн 7 дугаар зүйлд “Гишүүн улс нь шүүх эрх мэдлийг чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрээр хангана” гэж заасан нь шүүгчийн албаны хараат бус байдлыг хангах, бэхжүүлэхэд чиглэсэн заалт юм.

Эдгээр заалтыг хангах механизмын заримаас дурдвал:²²

- Шүүхийн захиргаанаас буюу удирдлагаасаа хараат бус байх;
- Шүүхийн төсөв чиг үүргээ хэрэгжүүлэхэд хангалттай байх;
- Шүүгчийг сэлгэн ажиллуулах, ажлаас огцруулах, чөлөөлөх үндэслэл тодорхой, зүй ёсны байх;
- Шүүгчийн шийдвэр гаргах процесс хараат бус байх, шүүгчийн шийдвэр халдашгүй, эцсийн байх зэрэг болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйл, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан “Шүүгчийн хараат бус байдал халдашгүй байх бөгөөд шүүгчийн хараат бус байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар баталгаажуулна” хэмээн шүүхийн албаны хараат бус байдлыг хангасан.

Шүүгчийн *албаны хараат бус байдлыг* хууль тогтоомжоор бүрэн хангах боломжтой байдаг бол *хувийн хараат бус байдлыг хангах* нь хууль тогтоомжоос илүүтэй тухайн шүүгчийн өөрийн мэдлэг, чадвар, хандлагаас ихээхэн хамаардаг. Шүүгчийн *хувийн хараат бус байдлыг* хангахад дараах арга хэрэгсэл чухал болно. Үүнд:²³

- Шүүгчийн сонгох, томилох, дэвшүүлэх процесс нь мэргэжлийн ур чадвар, ёс зүйд суурилсан, аливаа ялгаварлан гадуурхах явдлаас ангид шударга байх;
- Шүүгчээр ажиллах хугацаа нь хараат бус байдлыг хангахуйц хангалттай удаан байх;
- Шүүгчийн цалин, хангамжийн баталгаатай байдал;
- Шүүгчийг урамшуулах тогтолцоо бодит шалгуурт үндэслэх;
- Шүүгчид хариуцлага тооцох үндэслэл хууль тогтоомжид тусгагдсан байх, үйлдсэн зөрчил, хүлээлгэх хариуцлага хоорондоо зохистой түвшинд байх зэрэг болно.

Дээр дурдсанаас харахад шүүхийн бие даасан байдал ба шүүгчийн хараат бус байдал нь харилцан уялдаатай бөгөөд шүүх эрх мэдлийн баталгаа нь албаны болон хувийн хараат бус байдлаараа ялгарч байна.²⁴

Европын холбооны²⁵ шүүгчдийн зөвлөлийн шүүгчийн хараат бус байдал болон хариуцлагыг үнэлэх аргачлалд дурдсанаар шүүгчийн хараат бус байдлыг

²² Мөн тэнд

²³ Мөн тэнд, р.123

²⁴ Түүнчлэн энэ талаар Европын зөвлөлийн Сайд нарын хорооноос 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр баталсан “Шүүгч: хараат бус байдал, үр нөлөө, хариуцлага” зөвлөмжийн 1 дүгээр бүлгийн 4 дэх хэсэгт дурдсан байна.

²⁵ Европын холбооноос гаргасан баримт бичиг, үнэлгээний тайлан зэргийг түлхүү ашигласан бөгөөд энэ нь Европын холбоо шүүхийн хараат бус байдал, хариуцлага болон шүүхийн шинэтгэлийн асуудлаар эрчимтэй ажиллаж, сайн туршлага бий болгож байдагтай холбоотой юм.

объектив, субъектив гэж ангилсан байна.²⁶ *Объектив хараат бус байдал* гэдэгт хараат бус байдлын хууль зүйн үндэс бүрдсэн эсэх, шүүхийн төсөв хангалттай эсэх, шүүх байгууллагын бие даасан байдал зэрэг хэд хэдэн ойлголтыг авч үзэж, эдгээрийг шүүгчийг томилох, чөлөөлөх, дэвшүүлэх зэрэг хүний нөөцийн асуудал зэрэг шалгуураар үнэлж байна. *Субъектив хараат бус байдал* гэдэгт шүүгчийн хараат бус байдлын талаар олон нийт, шүүхээр үйлчлүүлэгч, хамтран ажиллагсад болон шүүгчид өөрсдөө юу гэж үздэг талаарх ойлголт, төсөөлөл хамаардаг байна.²⁷

(1) Шүүгчийн хараат бус байдал шүүгчийн хариуцлагатай уялдах нь

Шүүгчийн хараат бус байдал нь шүүгчийн хариуцлагын тухай ойлголттой хамт яригдана. Эдгээр нь нэг зоосны хоёр тал юм.²⁸ Шүүгчийн бие даасан байдалд халдахгүйгээр шүүгчид хэрхэн хариуцлагыг нэмэгдүүлэх вэ гэдэг нь анхаарал татсан асуудал байсаар ирсэн.²⁹ Иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрх, энэ эрхийг эдэлснээр хангагдах бусад эрхүүдийг хамгаалах гол баталгаа нь шүүгчийн хараат бус байдал юм. Шүүгчийн хараат бус байдалд илүүтэй анхаарч, шүүгчид ямар нэг баримтлах стандарт тавихгүйгээр түүнд шүүх эрх мэдэл олгох нь эргээд хүний эрхэд халтай гэж үздэг. Шүүгчийн хараат бус байдлыг хангахгүйгээр шүүгчийн хариуцлагын асуудлыг чухалчлах нь мөн адил хүний эрхэд халтай юм. Хараат бус байдлыг нь хангаагүй тохиолдолд шүүх төрийн захиргааны аль нэг байгууллагатай ижил болдог.³⁰ Иймд шүүгчийн хараат бус байдал болон хариуцлагатай байдлын хооронд зохих тэнцвэрийг хангах ёстой юм.

Шүүгчийг хэн, хэрхэн “шүүх” буюу шүүгчийн хариуцлагын талаарх ойлголтыг дэлгэрүүлэн авч үзье. НҮБ-ын Үндсэн зарчмуудаар шүүгчийн хараат бус байдлыг албаны болон хувийн гэж ангилан авч үзсэнийг дээр дурдсан. Шүүгчийн хувийн хараат бус байдлыг хангах нь шүүгчээс ихээхэн хамаарах ба энэхүү хараат бус байдлаа хангах нь шүүгчийн хариуцлага болно. Өөрөөр хэлбэл, хараат бус ажиллах нь шүүгчийн хувьд хангагдах ёстой эрх төдийгүй биелүүлэх, мөрдөх ёстой хариуцлага юм.

НҮБ-ын Үндсэн зарчмуудын 18 дугаар зүйлд зааснаар шүүгчийг гагцхүү цаашид албан үүргээ гүйцэтгэх боломжгүйг нотолж байгаа мэргэжил, ур чадварын хангалтгүй байдал болон зан төлөвийн зөрчил дутагдал гаргасных нь төлөө ажил, албан тушаалаас нь чөлөөлж болох тухай заажээ. Энэ нь шүүгчийн хараат бус байдлыг хангасан зохицуулалт болохын хамт шүүгчийн хариуцлагын хүрээг заасан чухал ойлголт юм. Тодруулбал, шүүгч нь мэргэжлийн болон зан суртахууны зохих

²⁶ ENCJ Project 2013-2014, “Independence and Accountability of the Judiciary”, 13 June 2014, Rome

²⁷ Объектив, субъектив хараат бус байдлыг шүүгчийн албаны, хувийн гэж ангилан тайлбарласан байна. Тухайлбал, Япон Улсад 1948 оны 59 дүгээр хууль болох Шүүхийн тухай хуулийг баталж, энэ хууль нь хэрэгжиж эхэлмэгц Шүүхийн бүтцийн тухай хууль, Шүүх байгууллагын хууль хэрэгжүүлэх журам, Шүүгчийн шийтгэлийн тухай хууль, Захиргааны шүүхийн хуулиуд хүчингүй болж, улмаар шүүх эрх мэдлийн хараат бус байдал хэрэгжих үндэс нь тавигдсан гэж үздэг. Монгол Улсад ч мөн адил 2013 оны Шүүхийн багц хууль батлагдсанаар шүүхийн захиргааны бие даасан байдлыг хангах зэрэг асуудлуудыг нарийвчлан зохицуулсан эрх зүйн орчин бүрэлдэн бий болсон.

²⁸ Stephen B. Burbank, *Judicial Independence at the Crossroads*, 2002, Sage publications, p. 16

²⁹ Gabriela Knaut, Report of the Special Rapporteur on the Independence of Judges and Lawyers, A/HRC/26/32 United Nations, General Assembly

³⁰ ENCJ Project on Independence and Accountability 2014-2015, 5 June 2015, The Hague

стандартыг хангах ёстой гэсэн үг юм.³¹ Эдгээр стандартыг хангаснаар шүүгчийн хувийн хараат бус байдал бүрдэнэ гэж хэлж болох юм. Түүнчлэн НҮБ-ын Үндсэн зарчмуудын 19 дүгээр зүйлд “сахилга батын шийтгэл хүлээлгэх, ажлаас түр болон бүрэн чөлөөлөгдөх ажиллагаа нь тогтсон шалгуур, хэм хэмжээгээр тодорхойлно”, 20 дугаар зүйлд “шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах, түр болон бүрмөсөн албан тушаалаас нь чөлөөлөх ажиллагаа хараат бус хяналтад байна” гэсэн нь шүүгчийн хариуцлага болон шүүгчийн бие даасан байдал хоорондын тэнцвэрийг хангах тухай заажээ.

Европын холбоо 2010 оноос шүүхийн шинэтгэл хийж эхэлсэн. Энэхүү шинэтгэлийн зорилтын нэг нь “шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэхийн хамт хариуцлагатай байдлыг хангах” арга хэмжээг авч хэрэгжүүлэх байв. Улмаар 2013 онд “Шүүхийн бие даасан байдал болон хариуцлагын тухай” Софигийн тунхаглалыг баталсан. Тус тунхаглалаар шүүгчийн хариуцлагын асуудлыг шүүгчийн ёс зүйн дүрэмтэй холбосон байна.³² Шүүгчийн хараат бус байдлын баталгааг хангахдаа зөвхөн шүүгчийн шүүн таслах ажиллагаанд гэж явцуурдаггүйтэй адил шүүгчийн хариуцлагын асуудал ч шүүн таслах ажиллагаагаар хязгаарлагдахгүй. Өөрөөр хэлбэл, шүүгч шүүн таслах ажиллагаанд төдийгүй хувийн амьдралдаа ч шүүгч мэргэшилтэй хүний хувьд зохих стандартыг мөрдөх ёстой. Энэ нь ихэвчлэн шүүгчид тавигдах ёс зүйн стандартаар илрэлээ олох бөгөөд шүүгч шүүн таслах ажиллагаанаас бусад үед ч итгэл төрүүлэхүйц байх ёстой юм.³³

Тухайлбал, Япон Улсад шүүгчийн хараат бус байх талаар хэрхэн зохицуулсныг судлан үзвэл, Япон улсын Үндсэн хуулийн 76 дугаар зүйлийн 76.3-т шүүгчийн үйл ажиллагааны хараат бус байдлыг баталгаажуулахын хамт 78 дугаар зүйлд шүүгчийн халдашгүй байдлыг мөн хангасан байна. Энэ зүйлд заахдаа “шүүгч нь сэтгэцийн болон биеийн эрүүл мэндийн байдлын улмаас ажил үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон, албан тушаалаас нь эгүүлэн татах талаар ард нийтийн хэлэлцүүлэг болсноос бусад тохиолдолд албан тушаалаас нь чөлөөлөхийг хориглоно. Шүүгчид гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болон бусад агентлагаас сахилгын шийтгэл ногдуулахыг хориглоно” гэж заасан. Түүнчлэн Япон улсын Үндсэн хуулийн 79 дүгээр зүйлийн 79.6 ба 80 дугаар зүйлийн 80.2 дугаар зүйл заалтаар шүүгчийн цалин хөлсийг баталгаажуулсан байна.³⁴

(2) Шүүгчийн хариуцлагын хэмжүүрийг тодорхойлох нь

Олон улсын жишиг хандлагаар шүүгчийг зөвхөн цаашид албан үүргээ гүйцэтгэх боломжгүйг нотолж байгаа мэргэжил, ур чадварын хангалтгүй байдал болон зан төлөвийн зөрчил дутагдлын шалтгаанаар ажил, албан тушаалаас нь

³¹ Шүүгчийн хариуцлагын асуудалд шүүгчид хүлээлгэх эрүүгийн хариуцлагын асуудал ч яригддаг. Гэвч энэ нь эрүүгийн эрх зүйн тусдаа асуудал тул эл асуудлыг энэ бодлогын судалгааны хүрээнд авч үзээгүй болно.

³² Европын Шүүгчдийн зөвлөлийн зөвлөл, Шүүгчийн бие даасан байдал ба хариуцлагын тухай Софигийн тунхаглал, 2013(The General Assembly of ENCJ Meeting Sofia 5th – 7th June, 2013 Sofia Declaration “On judicial independence and accountability”)

³³ Richard L.Aynes, “Evaluation of Judicial Performance: A Tool for Self-Improvement”, *Pepperdine Law Review* 32, Issue 2 <http://digitalcommons.pepperdine.edu/cgi/viewcontent.cgi?article=2009&context=plr>

³⁴ Япон Улсын Үндсэн хууль, орчуулсан П.Амаржаргал, 2011 он, Улаанбаатар

чөлөөлж болохоор заасан³⁵ нь шүүгчийн хараат бус байдлыг хангасан зохицуулалт болохын хамт шүүгчийн хариуцлагын хүрээг заасан чухал ойлголт юм. Шүүгчийн хариуцлагын асуудлыг нэгдүгээрт, хариуцлагын тогтолцоо бүрдсэн байх, хоёрдугаарт, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал хангагдсан байх, гурвдугаарт, шүүгчдэд итгэх олон нийтийн итгэл хангагдсан байх зэрэг шалгуураар үнэлж болох тухай зарим судлаачид дурддаг.³⁶ Өөрөөр хэлбэл, олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлж, шүүгчийн хараат бус байдлыг хангах замаар хариуцлага хүлээлгэх тухай асуудал яригдана. Шүүгчийн буруутай, ёс зүйгүй үйлдэл нь олон нийтэд ил болох тохиолдолд энэ нь эргээд тухайн шүүгчид цаашид ажиллахад асар их сэтгэл зүйн хүндрэлтэй байдал үүсгэж байдаг тул түүнийг заавал ажлаас нь чөлөөлөхгүйгээр олон нийтийн зэмлэл хүлээлгэх нь ноцтой хариуцлагын арга хэмжээ болж чаддаг.³⁷ Иймд шүүгч нь олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг хангах талаар мэргэжлийн болон зан суртахууны зохих стандартыг хангах ёстой ба шүүгчийн хариуцлагыг хэмжүүр энэ хүрээнд байна гэсэн үг юм.

Европын холбооны шүүгчдийн зөвлөлийн шүүгчийн хараат бус байдал болон хариуцлагыг үнэлэх аргачлалд шүүгчийн хариуцлагыг тодорхойлохдоо бие даасан байдлыг үнэлэх шалгууртай адил объектив, субъектив гэж ангилсан байна. Энд анхаарах зүйл нь тус аргачлалд шүүгчийн хараат бус байдлыг үнэлэхдээ шүүх байгууллага болон шүүгчийн бие даасан байдлыг хамтад нь авч үзсэн бол шүүгчийн хариуцлагыг үнэлэхдээ хувь шүүгчид илүү хамааруулж авч үзжээ. Шүүгчийн хариуцлагын асуудал нь шүүх байгууллагаас шүүгчид илүүтэй хамаарах ба ингэснээр илүү үр дүнтэй гэж үзсэн байна.³⁸

Объектив хариуцлага гэдэгт хэргийн хөдөлгөөн, шүүгчийн эсрэг гомдол гаргах боломж, шүүхийн нээлттэй байдал, шүүгчийн ажлаа тайлагнах байдал, аудит зэрэг шүүхийн үйл ажиллагааг хянах гадаад хяналт байгаа эсэх зэрэг асуудлыг хамааруулсан ба үүнийгээ үнэлэхдээ шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх, шүүгчийг огцруулах, чөлөөлөх процесс бий эсэх, шүүхийн үйл ажиллагаа, шүүхийн шийдвэрийн үндэслэл иргэнд ойлгомжтой эсэх зэрэг шалгуур үзүүлэлтийг тавьжээ. Эдгээр шалгуур үзүүлэлтийн заримаас дэлгэрүүлэн дурдвал, шүүгчийн ёс зүйн дүрэм бий эсэх шалгуур үзүүлэлтийг шүүгчийн ёс зүйн дүрэм байдаг эсэх, байдаг бол олон нийтэд нээлттэй эсэх гэсэн хоёр асуултаар үнэлсэн байна. Харин шүүхийн үйл ажиллагаа иргэдэд ойлгомжтой эсэх гэдгийг шүүхийн үйл ажиллагааг иргэдэд тайлбарладаг эсэх болон шүүгчдийн сургалт³⁹ явагддаг эсэх гэсэн шалгуураар үнэлжээ.

Иймд энэ бодлогын судалгаанд шүүгчийн ёс зүйд тавих стандарт буюу ёс зүйн хувьд хүлээлгэх хариуцлага; шүүгчийн мэргэшлийн ур чадварт тавих стандарт буюу мэргэшил, ур чадварын хувьд хүлээлгэх хариуцлага; шүүгчийн хариуцлагыг

³⁵ International Commission of Jurists, "International Principles on the Independence and Accountability of Judges, Lawyers and Prosecutors", Practitioners Guide No.1, 2007, Geneva, p.55; "Шүүх эрх мэдлийн бие даасан байдлын тухай үндсэн зарчмууд"-ын 18 дугаар зүйл

³⁶ Б.Амарсанаа, "Шүүгчийн ёс зүй ба хариуцлага" сэдэвт хэлэлцүүлэгт хэлсэн үг, Улаанбаатар, 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр <http://www.judcouncil.mn/main/2950--.html>

³⁷ Мөн тэнд

³⁸ Энд яригдаж буй хариуцлагын асуудал нь шүүгчдэд хүлээлгэх хариуцлагын асуудал гэхээсээ илүүтэйгээр тогтолцооны хувьд шүүгчид хариуцлага тооцох механизмыг бүрдүүлсэн эсэхийг үнэлэхэд чиглэсэн юм.

³⁹ Шүүгчдийн сургалтын агуулгад шүүхийн процесс, шүүхийн шийдвэрийн агуулгыг талуудад ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар тайлбарлах аргачлал орсон эсэхийг мөн үнэлдэг.

нэмэгдүүлэх бусад арга хэмжээг тусгав.⁴⁰ Үүнд, шүүгчийн хариуцлагыг авч үзэхдээ олон улсын эрх зүйн нийтлэг ерөнхий хэм хэмжээг авч үзэхээс гадна бусад улс орны эрх зүйн тогтолцоо, практикт тулгуурлан шүүгчийн үйлдлийг хэрхэн хэмжигдэхүйц байдлаар томъёолсон талаар дэлгэрэнгүй авч үзсэн. Түүнчлэн Япон, Молдав⁴¹ зэрэг улсад шүүгчийн ёс зүй, хариуцлагын тухай бие даасан хууль байдаг бөгөөд үүний дагуу шүүгчдэд ёс зүйн хариуцлага тооцох механизм үйлчилдэг талаар мөн дурдах болно.

Хоёр. Шүүгчийн ёс зүйн хариуцлага, шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэх бусад арга хэрэгсэл

2.1. Шүүгчийн ёс зүйн хариуцлага, ёс зүйн стандарт

Шүүгчийн хараат бус байдал шүүгчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд гол баталгаа болдог хэдий ч энэ нь мөн шүүгчдэд өөрийн ёс зүйгүй үйлдлээ нуун дарагдуулах, халхавчлах бамбай болж болдог.⁴² Үүнээс сэргийлэхийн тулд шүүгч ёс зүйн хариуцлага хүлээх бөгөөд шүүгчийн зан суртахууны хувьд хангах ёстой стандартуудыг шүүгчийн ёс зүйн дүрмээр тодорхойлно. Шүүгчийн мэргэжлийн ёс зүй нь шүүх эрх мэдлийн хараат бус байдал, шүүхэд итгэх итгэлийн баталгаа болдог.⁴³ Шүүгчийн ёс зүй гэдэг нь шүүгчийн мэргэжлийн онцлогоор нь нөхцөлдсөн ёс суртахууны хэм хэмжээ, зарчим ба биеэ авч явах байдлыг илэрхийлж байдаг. Шүүгчийн ёс суртахуун гэвэл ёс суртахууны зарчим, хэм хэмжээг ухамсарлах үйлдэл, үнэлэмж юм.⁴⁴ Шүүгчийн хариуцлагын тогтолцооны зорилгыг шүүгч өөрөө өөртөө хариуцлага алдсанаа мэдрэх өндөр хэмжээний ёс зүйг төлөвшүүлэх явдал гэж үзэх явдал ч байдаг.

Шүүгчид тавих ёс зүйн стандарт⁴⁵ нь шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаанд болон хувийн зан суртахуунд тавигдах шаардлагаас бүрдэнэ. Мэргэжлийн үйл ажиллагаанд тавигдах ёс зүйн шаардлага нь хараат бус байх, шударга байх, төв голч байх зэрэг зарчмуудыг агуулах бол хувийн зан суртахуунд тавих шаардлага нь хүнлэг байх, эр зоригтой байх, харилцааны ур чадвартай байх зэрэг чанаруудыг багтаана. Шүүгчийн ёс зүйн стандартаар шүүгчийн хувьд хориглох зан үйлийг тодорхойлсноор тухайн үйлдлээс урьдчилан сэргийлэх, энэ үйлдлийг хийсэн тохиолдолд хариуцлага зайлшгүй хүлээлгэх тогтолцоо бүрдүүлэх учиртай юм. Гэвч

⁴⁰ Монгол Улсын шүүхийн шүүгчийг огцруулах, хариуцлага тооцож буй өнөөгийн байдлыг судалж, үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор энэ бодлогын судалгааны хүрээнд анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдээс санал асуулга авсан болно. Тус судалгаанд нийт 91 шүүгч хамрагдсанаас сум дундын шүүхийн 25 шүүгч, дүүргийн шүүхийн 30 шүүгч, захиргааны хэргийн шүүхийн 18 шүүгч, давж заалдах шатны шүүхийн 18 шүүгчид байсан. Судалгааны асуулгад оролцсон шүүгчдийн 33 хувь нь эрэгтэй, 67 хувь нь эмэгтэй бол 11 хувь нь 3 хүртэлх жил, 9.9 хувь нь 4-6 жил, 16.5 хувь нь 7-10 жил, 62.6 хувь нь 11-ээс дээш жил ажилласан байна. Эндээс харахад тус судалгаанд шүүн таслах ажиллагааны хувьд харьцангуй туршлагатай шүүгчид хамрагдсан гэж үзэхээр байна.

⁴¹ Энэтхэг Улсад мөн адил Шүүгчийн хариуцлагын тухай хууль (Judicial Standards and Accountability Bill) үйлчилж байдаг.

⁴² International Commission of Jurists, *The Independence and Accountability of Judges, Lawyers and Prosecutors: Accountability*, 2007, p.55.

⁴³ Моригава Ясүтомо, Хуульчийн ёс зүй, 2007, Улаанбаатар, 352 дахь тал

⁴⁴ М.Золзаяа, М.Сайнзаяа, “Шүүгчийн ёс зүйн зөрчил, сахилгын шийтгэлийн тухайд”, Философи эрхийн судлал, XXIII боть, 2008., Улаанбаатар, 219 дэх тал

⁴⁵ НҮБ-аас баталсан 1985 оны “Шүүх эрх мэдлийн бие даасан байдлын тухай үндсэн зарчмууд”, 2002 оны “Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмууд”, “Шүүгчийн ёс зүйн Лондонгийн тунхаглал”.

энэ стандарт нь шүүгчийг шийтгэх, хариуцлага тооцох бус шүүгчийн ёс зүйг дээшлүүлэх арга зүйн зөвлөмж болох эерэг зорилготой байдгийг анхаарах ёстой юм.⁴⁶

Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах үүрэг бүхий хараат бус, төвийг сахисан байгууллагын өмнө шүүгчид өөрсдийн үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээдэг байх нөхцөлийг “Шүүх эрх мэдлийн бие даасан байдлын тухай үндсэн зарчмууд”, “Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчим” зэрэг зарчмуудаар тогтоож байгаа бөгөөд НҮБ-ын Үндсэн зарчмууд нь хүчин төгөлдөр хуулиар тогтоосон журам, ёс зүйн хэм хэмжээг сайжруулах, боловсронгуй болгох эрхэм зорилгыг агуулдаг. Улс орнуудын шүүгчийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгох ёс зүйн хэм хэмжээ нь тодорхой бөгөөд мэргэжлийн үйл ажиллагааны чиг үүрэгт нь тохирсон байх шаардлагыг хангасан байна.

Дээрх олон улсын зарчмуудад шүүгчид эдгээрийг мөрдөж, иргэд, олон нийтийн өмнө зохистой байдалтай харагдах нь шүүгчийн хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаанд зайлшгүй чухал болохыг тэмдэглэж, шүүгч үүргээ зохих ёсоор гүйцэтгэх үйл ажиллагааг тусгасан байна. Хуульч мэргэжлийн хувьд олон улсын хэм хэмжээ, стандартад сахилгын шийтгэл ногдуулах ажиллагаа нь мэргэжлийн үйл ажиллагааны ёс зүйн дүрэмд тулгуурлаж байх тухай тусгасан байна. Шүүгчдээс авсан санал асуулгын судалгаагаар сахилга-ёс зүйн хяналтыг бүрдүүлж байгаа өнөөгийн тогтолцоо, ёс зүйн зөрчлөөр хариуцлага тооцох механизм гэсэн асуудлын хүрээнд шүүгчдийн 46.2 хувь нь шүүгчдэд хариуцлага тооцох боломжийг хэт их олгосон, хараат бус байдалд нөлөөлөх боломж үүсч байна, 37.4 хувь нь одоогийн зохицуулалт нь шүүгчийг хариуцлагатай байх байдлыг дээшлүүлж чадаж байгаа хэдий ч эдгээрийг сайжруулах шаардлагатай, 5.5 хувь нь хангалтгүй буюу шүүгчийн хариуцлагыг дээшлүүлж чадахгүй байна, харин 11 хувь нь хангалттай сайн буюу шүүгчийн хариуцлагатай байдлыг дээшлүүлж чадаж байна гэж тус тус үзсэн байна. Үүнээс харахад судалгаанд оролцсон шүүгчдийн тодорхой хувь (42.9 хувь) нь одоогийн үйлчилж буй шүүгчийн хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлагатай, шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэхэд хангалтгүй байна гэж үзжээ.

Монгол Улсын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Шүүгч Шүүгчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана” гэж заасны дагуу шүүгчийн ёс зүйн асуудлыг Монголын Хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны Удирдах зөвлөлийн 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 1/08 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмээр зохицуулж байна.⁴⁷ Тус дүрэм нь шүүгчийн мөрдөх ёс зүй, зан үйлийг тогтоон хэвшүүлэх, бие даасан хараат бус, нэр хүнд бүхий шүүх эрх мэдлийг төлөвшүүлэн бэхжүүлэх, хамгаалах зорилгыг агуулсан баримт бичиг юм. Шүүгчийн ёс зүйн дүрэм нь Үндсэн хууль, соёрхон баталсан олон улсын гэрээнд үндэслэсэн шүүхийн албан тушаалтан шүүгчийн дагаж мөрдөх хамгийн чухал зарчим юм.

Шүүгч эрх мэдлээ айдасгүй, хараат бус хэрэгжүүлэхийн зэрэгцээ өөрөө хариуцлагатай байх үүднээс баталсан энэхүү дүрмийг олон улсын эрх зүйн

⁴⁶ Report ENCJ working group on Liability 2007-2008

⁴⁷ Монгол Улсын Шүүхийн менежментийг боловсронгуй болгох үзэл баримтлал (Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2004 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 70 дугаар тогтоол)-ын 3.3-т зааснаар Шүүхийн хүний нөөц, сургалт, давтан сургалтын менежментийн зорилтуудын хүрээнд шүүгчийн ёс зүйн дүрмийг боловсронгуй болгох тухай тусган цаг үеийн шаардлагад нийцүүлэн өөрчлөн, шинэчилж ирсэн байна.

стандартад тулгуурлан сайжруулах үйл явц үргэлжилсээр байна. “Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмууд”, “Шүүх эрх мэдлийн бие даасан байдлын тухай үндсэн зарчмууд” зэрэг олон улсын шүүгчийн ёс зүйн талаарх зарчмуудыг судалгааны асуулгад хамрагдсан шүүгчдийн 8 хувь нь сайн мэднэ, 50 хувь нь бага зэрэг буюу ерөнхийд нь мэднэ, 42 хувь нь эдгээр баримт бичгээс илүү Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийг сайн мэддэг гэж хариулсан байна. Иймд Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэмд олон улсын хэм хэмжээ, зарчмыг үндэсний эрх зүйн тогтолцоо, туршлагад нийцсэн байдлаар тусгах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагыг хэлбэршүүлэх хамгийн шалгарсан арга нь шүүгчийн ёс зүйн дүрэм юм.⁴⁸ Шүүгчийн ёс зүйн дүрмийг хэрэгжүүлж буй практикийг харахад дүрмийг зөрчсөн тохиолдолд тодорхой хариуцлага хүлээлгэдэг (АНУ, Итали зэрэг улсууд), зөрчсөн тохиолдолд тодорхой хариуцлага хүлээлгэдэггүй зөвхөн үйл ажиллагаандаа баримтлах жишиг дүрэм (Канад, Австрали, Эстони зэрэг улсууд) байдлаар хэрэглэдэг байна.⁴⁹ Шүүгчийн хараат бус байдлыг хангахад шүүхийн тогтолцоо чиглэж байх ба энэ хэрээр шүүгч өөрөө хараат бус ажиллахыг ямагт зорих ёстой. Өөрөөр хэлбэл, хараат бус ажиллах нь шүүгчийн хувьд хангагдах ёстой эрх төдийгүй биелүүлэх, мөрдөх ёстой хариуцлага юм. Энэ хүрээнд шүүгчийн ёс зүйн дүрмийн зохицуулалт чиглэдэг.

2001 онд Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх тухай *Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмууд* батлагдсан нь олон улсын түвшинд шүүгчийн ёс зүйн дүрмийн жишиг баримт бичиг болжээ. Дүрмийн зорилго нь үндэсний шүүхийн тогтолцоонд тус дүрмийг үлгэрлэсэн шүүгчийн ёс зүйн дүрэм батлуулах, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн юм. Тус баримт бичиг нь шүүгчийн баримтлах:

- Хараат бус байх (independence);
- Тал үл харах буюу төвийг сахих (impartiality);
- Үнэнч шударга байх (integrity);
- Зохистой байх (propriety);
- Тэгш хандах (equality);
- Зохих ёсоор гүйцэтгэх чадамжтай байх (competence and diligence) хэмээх зургаан гол зарчим, түүнийг бататгах, хангахын тулд хүлээх үүргийг тодорхойлсон юм.

Эдгээр зарчмууд, түүнд агуулагдах хэм хэмжээний заримаас дурдвал, **хараат бус байх** зарчмын хүрээнд шүүгч нь хувь хүн төдийгүй шүүгч хэмээх мэргэшилтэй хүний хувьд хараат бус, бие даасан байдлыг чанд хадгална. Үүнд:

- Гаднын шууд болон шууд бус оролцоогүйгээр (үүнд: хууль тогтоогч, хэргийн талууд, бусад шүүгч, улс төр, эдийн засаг болон бусад бүх

⁴⁸ United Nations Office on Drugs and Crime, Resource Guide on Strengthening Judicial Integrity and Capacity, 2011, New York

https://www.unodc.org/documents/treaties/UNCAC/Publications/ResourceGuideonStrengtheningJudicialIntegrityandCapacity/11-85709_ebook.pdf

⁴⁹ Giuseppe De Federico, “Judicial Accountability and Conduct: An Overview” in A. Seibert-Fohr (eds.), “Judicial Independence in Transition: Strengthening the Rule of Law in the OSCE Region, 2012, Springer-Verlag, Berlin

нөлөөлөл), бодит баримтад тулгуурлан, хуулийн заалтыг бүрэн ойлгон, шийдвэр гаргах;

- Шүүгчийн ёс зүйн стандартыг хэрэгжүүлэхдээ үлгэр дууриал болохуйц байж шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлж, шүүхийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх.

Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн зорилго болон тус дүрмийн гуравдугаар бүлэгт шүүгчийн олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс зүйн талаар заасан байна.

Тал үл харах буюу төвийг сахих зарчим нь шүүхийн шийдвэр төдийгүй шийдвэр гаргах үйл явцад хамаарна. Үүнд:

- Шүүгч нь шүүн таслах ажиллагаа төдийгүй бусад үед ч олон нийтэд итгэл төрүүлэхүйц, хэргийн оролцогчдод тал үл харсан, хараат бус байдлаар харагдах;
- Шүүгч нь шүүн таслах ажиллагааны өмнө болон шийдвэр гаргахдаа мэргэжлийн алдаа гаргахаас сэргийлэх;
- Шүүгч тухайн хэргийг шударгаар шийдвэрлэх боломжгүй, эсхүл шийдвэр гаргах боломжгүй гэж өөрийгөө үзсэн бол шүүх хуралд оролцохоос татгалзах.

Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэмд шүүгчийн хэргийн оролцогчтой баримтлах ёс зүйн талаар заасан хэдий ч шүүн таслах ажиллагааны өмнө болон шийдвэр гаргахдаа мэргэжлийн алдаа гаргахаас зайлсхийх тухай болон шүүх хуралд оролцох боломжгүй тохиолдолд шүүх хуралд оролцохоос татгалзан гарах тухай заалт ороогүй байна. Түүнчлэн шүүгчийн ёс зүйн дүрэмд ёс зүйн зөрчил гэдэгт “хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй”⁵⁰ гэжээ. Энэ заалт нь шүүгчийн мэргэжлийн алдаа гаргахаас сэргийлэх талаарх Бангалорын зарчимтай үл нийцэх мэт харагдаж байгаа ч зарим судлаачдын үзэж байгаагаар шүүгч нь үйл ажиллагаандаа Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийг шүүгчийн ёс зүйн дүрмийн нэгэн адил баримтлах үүрэг хүлээж байдаг тул тус дүрмийн 1.6 дугаар зүйлийн 1-т заасан “хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хууль зүйн мэдлэг, ур чадвартай байж, нямбай хариуцлагатай ажиллана” гэсэн заалтыг үндэслэл болгон шүүгчийн мэргэжлийн алдаа нь мөн ёс зүйн зөрчилд хамаарах шинжтэй байна гэж үздэг.⁵¹ Гэсэн хэдий ч Шүүхийн ёс зүйн хороонд ирж буй гомдлын дийлэнх хувийг шүүгчийн мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаатай холбоотой байдаг тул эдгээр хэргийг хэрэгсэхгүй болгодог. Иймд шүүгчийн ёс зүйн дүрэмд “Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зүй бусаар явуулахаас ямагт зайлсхийх бөгөөд хэргийн

⁵⁰ Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 2

⁵¹ Б.Уранцэцэг, “Шүүгчийн ёс зүйн хүрээ хязгаар” илтгэл, “Шүүгчийн ёс зүй ба хариуцлага” сэдэвт хэлэлцүүлэг, Улаанбаатар, 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр <http://www.judcouncil.mn/main/2950--.html>

оролцогчдын эрхийг зөрчихгүй байх боломжит бүхий л арга хэмжээг авна” гэдгийг Шүүгчийн ёс зүйн дүрэмд тусгах шаардлагатай байна.

Үнэнч шударга байх зарчмын хүрээнд шүүгч нь “шударга байх” нь шүүхийн үйл ажиллагааны үндсэн зарчим болохыг санаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно. Өөрийн үйл ажиллагаагаар олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийг зорино. Үүнийг Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 1.3 дугаар зүйлд зааснаар шүүгчийн баримтлах зарчимд хамаарна.

Зохистой байх зарчмын хүрээнд шүүгч нь албаны болон хувийн бүхий л үйл ажиллагаандаа зохисгүй байдал гаргахыг хориглоно. Үүнд:

- Шүүгчийн ёс зүйн дүрэмд нийцүүлэн биеэ авч явах;
- Олон нийтийн өмнө хэн нэгний дарамт, шахалтгүйгээр өөрийн ухамсраар жирийн иргэний хувьд зүй зохисгүй гэж дүгнэгдэх үйлдлийг хийхгүй байх;
- Шүүгч нь өөрийн болон гэр бүлийн хэн нэгний санхүүгийн талаарх мэдээллийг тухай бүр зохих журмын дагуу мэдүүлж байх;
- Шүүгчийн бүрэн эрхийнхээ хүрээнд олж авсан нууц мэдээллийг шүүгчийн үйл ажиллагаанаас өөр бусад тохиолдолд дэлгэрүүлэх, бусдад дамжуулах, мэдээлэхийг хатуу хориглох.

Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.3 дугаар зүйлд шүүгчийг зохисгүй байдал гаргахгүй байх тухай заасан бөгөөд үүнийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд заасан зохисгүй байдлаар тодорхойлсон байна. Гэвч “зохисгүй байдал” гэдгийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.9-д зааснаар буюу “хууль, хянан шийдвэрлэх ажиллагааны хэм хэмжээ, энэ дүрмийг зөрчсөн, эсхүл шүүгчийн хараат бус, зарчимч, төвийг сахих байдлыг алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг” ойлгоно хэмээн хэт ерөнхий байдлаар томъёолсон байна. Харин эдгээрийг дээрх Бангалорын зарчимд заасны дагуу дэлгэрэнгүй, тодорхой үйлдлийг зааж томъёолох нь энэ талаар аливаа үл ойлголцол, маргаан гарахаас сэргийлэх боломжтой байна. Тухайлбал, мэдээллийн технологийн орчин үеийн дэвшилттэй уялдан олон нийтийн цахим сүлжээнд шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ нэгэн адил үйлчилдэг байх гэдгийг Шүүгчийн ёс зүйн дүрэмд тусгах боломжтой юм.

Тэгш хандах зарчмын хүрээнд “шүүхийн өмнө хүн бүр тэгш эрхтэй байх” зарчмыг баталгаажуулж, үйл ажиллагаандаа ялгаварлан гадуурхах явдлыг хориглоно. Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.1 дүгээр зүйлд заасан “ялгаварлах үзэл гаргахгүй байх” тухай заалт нь тэгш хандах зарчмын үндэс болж байдаг хэдий ч үүнийг олон улсын хэм хэмжээний дагуу өргөжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, “шүүгч шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхдээ хэрэгт хамааралгүй шинжээр нь ямар нэг хувь хүн, бүлэгт илүү хандах, алагчилсан байдлыг үгээр болон биеэ авч явж буй байдлаараа илэрхийлэх ёсгүй” гэсэн Шүүхийн ёс зүйн Бангалорын зарчмын 4.3 дахь хэсэгт орсон заалтыг Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэмд оруулах боломжтой юм.

Үүргээ зохих ёсоор, бүрэн дүүрэн гүйцэтгэх чадамжтай байх нь шүүгчийн үйл ажиллагааны хамгийн чухал хэсэг юм. Үүнд:

- Шүүн таслах үйл ажиллагаа нь шүүгчийн хамгийн чухал чиг үүрэг байх;
- Шүүгч нь өөрийн мэргэжлийн ур чадварыг шүүн таслах үйл ажиллагаанд бүрэн зориулах бөгөөд үүнд шүүн таслах, шийдвэр гаргах төдийгүй шүүхийн байгууллагатай холбоотой бүхий л үйл ажиллагаа хамаарах;
- Шүүгч нь өөрийн мэдлэг, чадвараа дээшлүүлэх, шүүн таслах үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хувийн зан чанараа сайжруулахад ямагт анхаарах үүрэгтэй ба энэ зорилгоор шүүгчдийн дунд зохион байгуулагдах сургалтад хамрагдах;
- Олон улсын хууль тогтоомж, гэрээ, конвенц болон хүний эрхийн хэм хэмжээг тогтоосон бусад баримт бичгүүд, холбогдох өөрчлөлтүүдийн талаар тогтмол мэдээлэлтэй байх;
- Шүүгч нь шүүн таслах үүргээ, ялангуяа талуудад шүүгчийн шийдвэр гардуулах үүргээ үр өгөөжтэй, шударга, боломжит хугацаанд гүйцэтгэнэ гэж заажээ.

Шүүгч ямагт мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх шаардлагатай гэдгийг онцолсон дээрх зарчмыг хангасан заалтыг Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэмд нарийвчлан тусгах шаардлагатай байна. Жишээлбэл, “шүүгч мэдлэг, чадвар болон шүүн шийдэх ажиллагааны үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зан төлөвөө дээшлүүлэх боломжит алхмуудыг хийж байх, энэхүү зорилгоор шүүхийн хяналт дор шүүгчдэд зориулан бэлтгэсэн сургалт, бусад арга хэрэгслийг ашиглавал зохино” гэсэн Шүүхийн ёс зүйн Бангалорын зарчмын 6.3 дахь хэсэгт орсон заалтыг оруулах боломжтой юм. Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг бусад улс оронд шүүгчийн ёс зүйн дүрэмдээ хэрхэн нарийвчлан, хэмжигдэхүйц байдлаар тусгасан талаар авч үзье.

АНУ-ын хувьд тус улсын Шүүгчийн ёс зүйн дүрэм нь 4 гол зарчим, эдгээрийг агуулсан бусад хэм хэмжээнээс бүрддэг. Үүнд:

1. Шүүгч нь бие даасан, шударга, тал үл харах зарчмыг мөрдөж, зүй зохисгүй байдал гаргахаас сэргийлэх үүрэгтэй;
2. Шүүгч нь үйл ажиллагаандаа үл ялгаварлах, үүргээ зохих ёсоор, хичээнгүй, хамтран гүйцэтгэх зарчмыг баримтлах;
3. Шүүгч болон шүүгчид нэр дэвшигч нь улс төрийн болон бусад шүүгчийн тал үл харах, шударга байх, бие даасан байх үүрэгтэй харшихуйц үйл ажиллагаа эрхлэхийг хориглоногөж заасан байдаг.

Үүнээс онцлон дурдвал шүүгч нь үүргээ зохих ёсоор, хичээнгүй, хамтран гүйцэтгэх гэсэн заалтын хүрээнд “шүүн таслах болон захиргааны аливаа үүргээ зохих ёсоор, хичээнгүйлэн гүйцэтгэх”, “бусад шүүгч болон шүүхийн захиргаатай хамтран ажиллах”⁵² үүргийг хүлээсэн байдаг. Энэ заалт нь шүүгч хангалттай хууль зүйн мэдлэг, чадвартай байх, шийдвэр гаргахдаа хариуцлагатай байх, хэргийн

⁵² Энэ нь шүүх шийдвэр гаргахад хамаарахгүй.

талаар хувийн санал бодлоо илэрхийлэхгүй байх, хэргийг хугацаандаа шийдэх зэрэг агуулгатай юм.⁵³

ОХУ-ын хувьд тус улсын Шүүгчийн ёс дүрэм нь шүүгчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг *нэгт*, нийтлэг баримтлах, *хоёрт*, албаны буюу мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах, *гуравт*, шүүн таслах үйл ажиллагаанаас бусад буюу хувийн амьдралдаа баримтлах гэж ангилсан байна. Мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээнд бие даасан байх, тал үл харах, бодитой байх, тэгш байдал, үүргээ зохих ёсоор гүйцэтгэх бүрэн эрх, ухамсартай байх зэрэг зарчмуудыг тусгасан бол хувийн зан чанарын хувьд улс төрийн болон шүүгчийн үйл ажиллагаанд харшлах үйл ажиллагаа эрхлэхгүй байх зэргийг зааж өгсөн байна.

Тус улсын Шүүгчийн ёс зүйн дүрэмд шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотойгоор мөрдөх хэд хэдэн үүргийг шүүгчид оногдуулсан байна. Тухайлбал, тус дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “шүүгчээс шүүхийн захиргааны үйл ажиллагаан дахь үүргээ зохих ёсоор гүйцэтгэх бүрэн эрх, ухамсартай байх чухал шаардлагатай” гэсэн бол 11.2 дэх хэсэгт “Шүүгч нь үүргээ шударгаар, мэргэжлийн өндөр түвшинд, тухайн хэргийг мэргэшсэн байдлаар, цаг хугацаанд нь шийдвэрлэх бүхий л шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэх, эвлэрэхэд нь тусална”, 11.3 дахь хэсэгт “шүүгч нь хүн бүр хэргээ шударга шүүхээр боломжит хугацаанд шийдвэрлүүлэх эрхийг хангахад чиглэсэн арга хэмжээг авах бөгөөд шүүх хуралдааныг зохих ёсоор удирдан явуулах, нэг ижил цагт хэд хэдэн хэргийн шүүх хуралдааны товьг зарлахаас сэргийлэх, зохих бэлтгэл хангагдаагүй зэргээр шүүх хуралдааныг олон удаа, үндэслэлгүйгээр хойшлуулахаас урьдчилан сэргийлнэ” гэжээ. Түүнчлэн Шүүгчийн ёс зүйн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэгт “шүүгч нь ОХУ-ын хууль тогтоомжийн өөрчлөлт, олон улсын эрх зүйн хэм хэмжээ, тэр дундаа хүний эрхийн салбарын олон улсын конвенц, бусад баримт бичиг, тэдгээрийг практикт эрх зүйн хэм хэмжээ болгон хэрэглэх, үүний дотор Европын Хүний эрхийн шүүх, ОХУ-ын Дээд шүүх, Үндсэн хуулийн шүүхийн практикийг судалж, мэдсэн байна” гэсэн үүргийг оногдуулсан байна.

Япон Улсын Шүүхийн тухай хуульд заасан шүүгчийн албан ажлын дүрэм, журмын талаар товч дурдвал:⁵⁴

- *Ажилдаа хариуцлагатай хандах үүрэг:* “Шүүхийн захиргааны хяналт тавих эрх нь шүүгчийн шүүх эрх мэдэлд нөлөөлөх, түүнийг хязгаарлах явдал болохгүй” гэж заасан бөгөөд үүний дагуу шүүхийн захиргааны хяналт тавих эрх бүхий этгээд нь шүүн таслах үйл ажиллагаанд нөлөөлж болохгүй юм.
- *Нууцыг хадгалах үүрэг:* Төрийн албан хаагч нь албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн нууцыг задруулж болохгүй.
- *Нэр хүндээ хамгаалах үүрэг:* Төрийн албан хаагч нь албан ажил, хувийн харилцаанд ч төрийн албан хаагчид итгэх олон нийтийн итгэлд сэв суулгах, төрийн нийт албан хаагчийн нэр хүндийг гутаах үйлдэл хийж болохгүй.
- *Хориглох зүйл:* Шүүгч парламент болон орон нутгийн захиргааны хурлын гишүүн болох, улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа явуулах, цалин хөлстэй

⁵³ ABA Model Code of Judicial Conduct, amended in 2010

http://www.americanbar.org/content/dam/aba/administrative/professional_responsibility/2010_mcjc_final.aurhcheckdam.pdf

⁵⁴ Моригива Ясүтомо, “Хуульчийн ёс зүй”, 2007 он, Улаанбаатар, 338-343 дахь тал

өөр ажил эрхлэх, худалдаа болон ашгийн төлөө бусад үйл ажиллагаа эрхлэх зэрэг нь хориотой байдаг.

Молдав Улсын 2015 онд шинэчлэн баталсан Шүүгчийн ёс зүй болон мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “с”-д заасны дагуу шүүгч нь “өөрийн мэргэжлийн үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй биелүүлж, хуулиар тогтоосон хугацааг баримтлах бөгөөд хуулиар тогтсон хугацааг заагаагүй бол үүргээ аль болох боломжит хугацаанд биелүүлэх”, мөн зүйлийн “f”-д “шүүгч нь өөрийн үүргээ биелүүлэхдээ хуулийг зөв хэрэглэж, хэргийг шударга, үр дүнтэй, удаашруулалгүй шийдвэрлэх” гэсэн шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой үүргийг оноосон байдаг бөгөөд эдгээрийг зөрчих нь сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болдог байна.

Шүүгчийн ёс зүйн дүрэм нь шүүгчид хариуцлага оногдуулах “гол арга хэрэгсэл” учраас дээрх олон улсын болон ОХУ, Молдав зэрэг орны туршлагад нийцүүлэн өргөжүүлэх шаардлага гарч байгааг үгүйсгэхгүй. Шүүгчид нь мэргэжлийн алдаа, зөрчил, мэргэжлийн үүрэгтээ хайнга, хайхрамжгүй хандах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг буруу удирдах, хэрэг хянан шийдвэрлэх хугацааг цалгардуулах, хуралдааныг үндэслэлгүйгээр хойшлуулахгүй байх зэрэг нь шүүхэд итгэх иргэд, олон нийтийн итгэлийн тулгуур болдгийг онцгойлон чухалчлах шаардлагатай байна.

2.2. Шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэх бусад арга хэрэгсэл

Олон улсын болон гадаадын зарим улсуудын практикаас харахад шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэхэд ёс зүйн болон мэргэжлийн хувьд хүлээлгэх хариуцлагаас гадна бусад арга хэрэгсэл байдгаас дурдъя. Зарим тохиолдолд энэхүү бусад хэмээх арга хэрэгсэл нь шүүгчийн ёс зүйн болон мэргэжлийн хариуцлагын нэг хэсэг болж байгаа ч түүнийг хэрэгжүүлэх арга зам нь бие даасан тогтолцоо, арга хэрэгсэл болж байгаа онцлогоос хамаарч ийнхүү ангилав.

(1) Хэргийн хөдөлгөөний удирдлага ба шүүгчийн хариуцлага

Шүүхийн хэргийн хөдөлгөөний удирдлагын тогтолцооны нэг чухал асуудал бол шүүгчид хэрэг хуваарилах ажиллагаа юм. Хэргийн хөдөлгөөний удирдлага нь шүүхэд хянан шийдвэрлэгдэхээр ирсэн бүх хэргийн хөдөлгөөнийг удирдахыг хэлэх бөгөөд энэ нь хэрэг үүсгэхээс эхлэн хэрэг хянан шийдвэрлэгдэж, шүүхийн шийдвэр гарах хүртэлх бүх үе шатыг хамарсан тогтолцоо юм.⁵⁵ Түүнчлэн хэргийн хөдөлгөөний удирдлагын менежмент нь шүүхийн менежментийн гол төдийгүй хамгийн үр ашигтай асуудал байдаг.⁵⁶ Тухайлбал, АНУ-д шүүхээр шийдвэрлэж буй хэрэг, маргааны тоо үлэмж өсч, ээдрээ төвөгтэй байдал нэмэгдсэнээр шүүх эрх мэдэл, шүүхийн захиргааны үйл ажиллагааг боловсронгуй болгож, иргэнд хүрэх шударга ёсны шаардлага тулгарсан. Энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор 20 дугаар зууны эхний хагаст хэрэгжүүлсэн шүүхийн зохион байгуулалтыг оновчтой тогтоох,

⁵⁵С.Билгүүн. “Сайн туршлага: Шүүгчид хэрэг хуваарилах ажиллагаа”, Шүүх эрх мэдэл №3, 2014 он, Улаанбаатар, 19 дэх тал

⁵⁶ David C. Steelman “Improving case flow management: A brief guide”, 2008, National Center for State Courts, p.2

нөөцийг үр ашигтай хуваарилах зэрэг шинэтгэлийн үйл явцын үргэлжлэл нь хэргийн хөдөлгөөний удирдлагын үүсэл байсан.⁵⁷

Хэргийн хөдөлгөөнийг үр ашигтай, зохистой удирдаж чадвал хэргийн талуудын эрх хуулийн хүрээнд, тэгш хангагддаг.⁵⁸ Өөрөөр хэлбэл, хэргийг хуваарилахдаа тогтоосон дүрэм, журмыг зөрчсөн эсхүл дүрэм, журам нь хувь шүүгчийн хараат бус байдлыг хангалттай хамгаалаагүй тохиолдолд хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч зэрэг хэрэгт нэг талын сонирхолтой этгээдэд шүүгчид нөлөөлөх боломж олгох, шүүгчдийн ажлын ачаалал харилцан тэнцвэргүй болох, процессын ажиллагаа удаашрах, улмаар шүүхэд итгэх иргэд, олон нийтийн итгэл алдагдах сөрөг үр дагавартай.⁵⁹ Ингэснээрээ шүүгчийн хариуцлагатай байдалд нөлөө үзүүлэх талтай юм.

Эдгээрээс харахад шүүхийн менежмент нь шүүхийн хариуцлагатай байдлын чухал хэсэг болдог.⁶⁰ Түүнчлэн хэргийн хөдөлгөөнийг удирдаж, хянаснаар хэргийн шийдэгдэх хугацаа багасаж, иргэний шударга шүүхээр шүүлгэх эрх хангагдах бол нөгөө талдаа шүүхийн төсвийг хэмнэдэг. Хэргийн хөдөлгөөний менежмент нь техник технологийн дэвшилттэй салшгүй холбоотой. Иймд шүүгчдэд тухайн шинэ программыг эзэмших, процессын хуулиуд дахь хугацаатай холбоотой заалтуудыг чанд мөрдөх, цаашилбал хэргийг хугацаанд нь шийдэхийн тулд шаардагдах хувийн чадваруудаа (хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт, төлөвлөлт) нэмэгдүүлэх хариуцлагыг бий болгодог.⁶¹

“Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмууд”-д зааснаар “*шүүгч шүүн таслах бүх үүргээ, тэр дундаа баталгаажсан шийдвэрээ гардуулах үүргээ үр өгөөжтэй, шударга, **боломжит хугацаанд биелүүлнэ***” гэж заасан.⁶² Түүнчлэн ОХУ-ын Шүүгчийн ёс зүйн дүрэмд “шүүгч нь үүргээ шударгаар, мэргэжлийн өндөр түвшинд, тухайн хэргийг мэргэшсэн байдлаар, **цаг хугацаанд** нь шийдвэрлэх бүхий л шаардлагатай арга хэмжээг авна” гэсэн бол АНУ-ын Шүүгчийн ёс дүрэмд заасан “шүүгч нь шүүн таслах болон захиргааны аливаа үүргээ зохих ёсоор, хичээнгүй гүйцэтгэнэ” гэх заалтыг мөн адил хэргийг хугацаанд нь шийдвэрлэх үүрэг өгсөн гэж ойлгодог.

Энэ ч үүднээс хэргийн хөдөлгөөний удирдлагын менежменттэй холбогдох шүүгчийн хариуцлагын ойлголт нь шүүхийн мэргэшлийн болон ёс зүйн үйл ажиллагаанд хийх үнэлгээний нэг шалгуур үзүүлэлт болох нь түгээмэл байна.⁶³ Шүүгч өөрийн үйл ажиллагаанд холбогдох процессын хуулиуд дахь хэргийн хугацаатай холбоотой заалтуудыг баримтлах үүрэгтэй. Гэвч шүүгчийн хэргийн хөдөлгөөний менежментийг хэрэгжүүлэх үүрэг нь түүнийг шүүхийн шийдвэрийн чанарт анхаарахаас илүү тоон үзүүлэлтэд ач холбогдол өгөх сөрөг үр дагаварт хүргэж болохыг анхаарах нь зүйтэй.⁶⁴ Иймд хэргийн хөдөлгөөний удирдлагад

⁵⁷ С.Билгүүн. “Хэргийн хөдөлгөөний удирдлага гэж юу вэ?”, Шүүх эрх мэдэл эмхэтгэл №1, 2014 он, Улаанбаатар, 53 дахь тал

⁵⁸ David C. Steelman, “Improving case flow management: A brief guide”, 2008, National Center for State Courts, p.2

⁵⁹ С.Билгүүн. “Сайн туршлага: Шүүгчид хэрэг хуваарилах ажиллагаа”, Шүүх эрх мэдэл №3, 2014 он, Улаанбаатар, 19 дэх тал

⁶⁰ ENCJ Project 2013-2014, Independence and Accountability of the Judiciary, 13 June 2014, Rome

⁶¹ Evan Bell, “Judicial case management”, *Judicial Studies Institute Journal*, 2009:2

⁶² “Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмууд”-ын 6.5 дахь хэсэг

⁶³ William Davis, “The Role of Court Administration in Strengthening Judicial Independence and Impartiality”

⁶⁴ Evan Bell, “Judicial case management”, *Judicial Studies Institute Journal*, 2009:2

тодорхой давтамжтайгаар үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд процессын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтой юм.

Дэлхий дахинд үүссэн эдийн засгийн хямрал нь Европын ихэнх улсын шүүх тогтолцоонд таагүй үр нөлөө авчирсан. Тухайлбал, шүүхээр шийдвэрлэх хэргийн тоо ихсэх хэдий ч (эдийн засгийн хямралаас үүдсэн орон тооны цомхтголтой холбоотой хөдөлмөрийн маргаан болон дампуурал зарлах зэрэг иргэний хэргийн маргаан өссөн) шүүхийн төсөв улам багасаж, зарим оронд шүүгчдийн цалинг бууруулсан байна.⁶⁵ Үндсэн хуулийн тогтолцоо, хууль зүйн уламжлал зэргээс шалтгаалан улс орнуудын хууль, шүүхийн тогтолцоо ялгаатай ч ихэнх улсад шүүх эрх мэдэл эрх зүйт ёсны гол багана, шүүхийн бие даасан байдал ардчиллын үнэт зүйл гэдгээрээ ижил шинжтэй байна.⁶⁶ Иймд шүүхийн төсвийг танасан энэ нөхцөл, байдал нь шүүхийн хараат бус байдалд нөлөөлөх ёсгүй гэдэгт Европын холбооны улсууд санал нэгдэж, 2011 онд Вильнюсын тунхаглалыг баталсан. Тус тунхаглал нь шүүхийг бие даасан, хариуцлагатай, үр ашигтай байх чиглэлд шинэчлэл хийхээр зорьсон юм. Энэ шинэчлэлийн гол зорилго болох шүүхийн хариуцлагатай, үр ашигтай байдлыг хангахад дараах хоёр зорилт чухал үүрэгтэй гэж үзсэн нь хэргийн хөдөлгөөний удирдлагын менежмент хэчнээн чухлаар тавигдах болсныг илтгэнэ. Үүнд:

- Шүүхийн процессыг хялбар болгох, хэргийн хөдөлгөөний менежментийг сайжруулах, энэ хүрээнд технологийн дэвшлийг ашиглах;
- Шүүхийн менежмент, хэрэг хуваарилах ажиллагааг оновчтой болгох.

Монгол Улсад шүүхийн захиргааны удирдлагыг хангахын тулд 2007 онд ШЕЗ-өөс “Эрүү, иргэн, захиргааны хэргийн хөдөлгөөний стандарт”-ыг боловсруулан баталсан бөгөөд нийт шүүхүүд 2008 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн энэ стандартыг дагаж мөрдөж байна. Хэргийн онцлогоос шалтгаалан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа өөр өөрөөр явагддаг. Хэргийн хөдөлгөөний удирдлага нь хэргийн ачааллыг судалж, дүн шинжилгээ хийх, шүүхийн хүний нөөцийн бодлогыг тодорхойлох, хэрэг, маргааныг үр нөлөөтэй, бүтээмжтэй, хариуцлагатай шийдвэрлэх арга замыг судалж хэрэгжүүлэх зэрэг хэрэг, маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэдэг.⁶⁷

Монгол Улсын Шүүхийн захиргааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.21 дэх хэсэгт “Хэргийн хөдөлгөөний удирдлагын чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл хэрэгжүүлнэ” гэж заасан. Шүүхийн ерөнхий зөвлөл нь хэргийн хөдөлгөөнийг удирдах зарчмын хүрээнд процесс ажиллагааны сахилгыг мөрдүүлэх, хяналт тавих механизмыг бүрдүүлэх, хэрэг, маргааныг шүүн таслах ажиллагааг үр нөлөөтэй, бүтээмжтэй, хариуцлагатай шийдвэрлэх арга замыг боловсруулах үүрэгтэй. Хэргийг хүлээж авснаас хойш түүнд ямар ажиллагаа хийгдэж байгаа, хэрэгт хэр зэрэг хугацаа зарцуулж байгаад хяналт тавих нь тухайн шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль процесс дээр хугацаа алдсан болохыг тогтоож, сахилга хариуцлага тооцох ач холбогдолтой юм.

⁶⁵ “ENCJ Project 2011-2012 Judicial Reform in Europe” report

⁶⁶ Мөн тэнд

⁶⁷ Монгол Улсын шүүхийн менежментийг боловсронгуй болгох үзэл баримтлал, ШЕЗ-ийн 70 дугаар тогтоол, 2004 он.

Дараагийн хэсэгт шүүгчийн үйл ажиллагаа, хэргийн хөдөлгөөний хяналтыг хэрэгжүүлэх тогтолцоо хэрхэн хэрэгждэг талаарх Эстони улсын шүүхийн тогтолцоо, туршлагыг авч үзье.

Эстони Улсын шүүхийн тогтолцоонд⁶⁸ шүүхийн дарга⁶⁹-г тухайн шүүхийн шүүгчдээс сонгогдож, 5 жилээр Хууль зүйн сайдаас томилогдсон шүүгч байдаг бөгөөд тэрээр шүүн таслах үйл ажиллагаатай холбоотой ажлуудыг зохион байгуулах, шүүгчдийн зөвлөгөөнөөс баталсан шүүгчдийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үүрэгтэй. Анхан болон давж заалдах шатны шүүгчдийн хэрэг хуваарилалтыг тухайн жилдээ баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу зохион байгуулна. Шүүгчдийн дунд хэргийг хуваарилахад дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Шүүхэд ирсэн хэрэг, маргаан тус бүрийг шүүгчдийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хуваарилна;
2. Хэрэг, маргааныг түүврийн аргаар шүүгчдийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хуваарилна;
3. Хэрэг, маргааныг хуваарилахад шүүгчдийн ажлын ачааллыг тэнцүү тооцно.⁷⁰

Шүүхийн дарга нь шүүгчдийн үүргийн биелэлт болон хэргийн хөдөлгөөний тогтолцооны дагуу мэдээллийг дамжуулж байгаа эсэхэд хяналт тавина. Тухайлбал, шүүгчдээс тайлбар авах, үйл ажиллагааны журмыг баримталж байгаа эсэхэд шалгалт хийж, бусад шаардлагатай мэдээллийг цуглуулах эрхтэй.⁷¹ Давж заалдах шатны шүүхийн шүүхийн дарга нь анхан шатны шүүхийн шүүгчдэд мөн хяналт тавина. Хэрэв шүүгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зайлшгүй хэрэгжүүлэх процесс ажиллагааг хийгээгүй, тухайлбал, зохих хугацаанд шүүх хуралдааныг явуулахын тулд хуралдааныг хангалттай хугацаанд зарлаагүй, шүүх хуралдааныг зохион байгуулахад төлөвлөсөн хугацаа нь зохих хугацаанд шүүн таслах ажиллагааг явуулах боломжгүй байгаа нь илэрхий байгаа бол шүүхийн дарга нь шүүн таслах ажиллагааг боломжит хугацаанд явуулах тухай дараах шийдвэрийг гаргаж болно. Үүнд:

1. шүүгчид процесс ажиллагааг хэрэгжүүлэх эсхүл дуусгавар болгоход хангалттай үндэслэл бүхий хугацаа тогтоож өгөх;
2. шүүгчид хуралдаан болон ажлын цагийг зөв хуваарилах талаар зохион байгуулалтын заавар, удирдамж өгөх;
3. шүүгчийн үйл ажиллагааны төлөвлөгөөг харгалзан шүүгчдийн дунд хэргийг

⁶⁸ Бүгд Найрамдах Эстони Улсын Үндсэн хуулийн 148 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн үндсэн тогтолцоо нь Дээд шүүх /хяналтын шатны шүүх/, тойргийн шүүх /давж заалдах шатны шүүх/, мужийн шүүх, захиргааны хэргийн шүүх /анхан шатны шүүх/-ээс бүрдэнэ. Дээд шүүх бол Эстони Улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үздэгээс гадна давхар Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих эрх бүхий шүүх болно. Дээд шүүх нь хяналтын шатны шүүхийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс гадна давхар Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг онцлогтой. /Эстони Улсын Үндсэн хуулийн 149 дүгээр зүйл./ 2016.01.02-ны байдлаар Эстони Улсын шүүх нь 242 шүүгчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. /Supreme Court website: <http://www.riigikohus.ee/?id=188> Эстони Улсын Парламент нь 2002 онд Шүүхийн тухай хуулийг баталж, хамгийн сүүлд 2014 онд нэмэлт өөрчлөлт оруулж, мөрдөж байна.

⁶⁹ Эстони Улсын шүүхийн дарга нь тухайн шүүхийн Ерөнхий шүүгч болно.

⁷⁰ Эстони Улсын Шүүхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 2 (Courts Act, passed 19.06.2002, RT I)

⁷¹ Эстони Улсын Шүүхийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 1

дахин хуваарилах;

4. онцгой тохиолдолд хэргийн ээдрээ төвөгтэй байдал, шүүгчийн мэргэшил болон шүүгчдийн ажлын ачааллыг тооцсоны үндсэн дээр хэргийг хуваарилахдаа үйл ажиллагааны төлөвлөгөөг мөрдлөг болгохгүй байх зэрэг болно.⁷²

Шүүгч нь шүүхийн даргын өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд шүүхийн дарга нь түүний эсрэг сахилгын арга хэмжээ авах ажиллагааг эхлүүлж болно. Сахилгын зөрчил гэдэг нь шүүгчийн буруутай үйлдлийг хэлэх бөгөөд үүнд шүүгч албан үүргийг биелүүлээгүй эсхүл хангалттай биелүүлээгүй гэсэн үндэслэлүүд ордог байна.⁷³

(2) Хөрөнгө орлогын мэдүүлэг

Шүүгчийн хариуцлага хэмээх ойлголт нь шүүгчийн шүүн таслах ажиллагаанд болон түүнээс бусад үйл ажиллагаанд хамаарна. Бусад үйл ажиллагаа хэмээх ойлголтод шүүгчийн хувийн санхүүгийн харилцаа ч хамаарах бөгөөд үүнд олон улсын түвшинд тодорхойлсноор авлига, ашиг сонирхлын зөрчил, төсвийн мөнгө буруу зарцуулах зэрэг нь хамаардаг.⁷⁴ Шүүгчийн хариуцлагын асуудал нь эцсийн дүндээ шүүхийн шийдвэрт гадны нөлөө орохоос урьдчилан сэргийлэх, энэ ч үүднээс шүүгчийг ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байлгах зорилготой гэж үзэх хандлага ч байдаг.⁷⁵

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй үр дүнтэй аргад нийтийн албан тушаалтнууд хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлэх явдал юм.⁷⁶ Үүний зэрэгцээ шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч субъектүүд, ялангуяа шүүгч хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргах нь түүний хүлээх хариуцлагын нэг хэсэг болоод багагүй хугацаа өнгөрч байна. Тодруулбал, шүүгч хөрөнгө, орлого, ашиг сонирхлын зөрчлөө хуульд заасны дагуу үнэн зөв мэдүүлдэг байх үүрэгтэй. Үнэнч чанар нь тухайн хүнд итгэх суурь болдог. Иймд зарчимч хүн бол итгэл даахуйц, найдвартай байдаг. Шударга байх зарчимд дур зоргоор аашлахгүй байх, хүнийг ялгаварлан гадуурхахгүй байх, хууль, ёс зүйд нийцсэн зөв шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулах гэсэн ойлголтууд эн тэргүүнд багтана.⁷⁷

“Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмууд”-ын 4 дүгээр зүйлийн 4.7 дэх хэсэгт “шүүгч хувийн болон санхүүгийн итгэмжлэгдсэн этгээдийн хувь орлогыг мэдэж байх ёстой, мөн гэр бүлийн гишүүдийнхээ санхүүгийн хувь орлогын тухай мэдээлэлтэй байх бүх арга хэмжээг авч байна” гэж заасан байдаг.⁷⁸ Хэдийгээр шүүгчид хөрөнгө орлогоо мэдүүлэх явдалд таатай ханддаггүй, хувийн санхүүгийн асуудалд нь халдсан хэрэг гэж үзэх нь олон байдаг ч, энэ арга нь авлига, ашиг

⁷² Эстони Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйл

⁷³ Шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах ажиллагаа гэсэн хэсгээс дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.

⁷⁴ Heike Gramckow, “International trends—Strengthening judicial independence and accountability”

⁷⁵ Linn Hammegren, “Judicial Independence and Judicial Accountability: The Shifting Balance in Reform Goals” in Future Trends in State Courts, 2005

⁷⁶ Transparency International, “Asset declaration regimes in selected Asian countries” 2013

⁷⁷ О.Мөнхсайхан, “Монгол Улс дахь шүүгчийн сонгон шалгаруулалт шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг сайжруулах нь” Нээлттэй нийгэм форум, 2015 он, Улаанбаатар, 22 дахь тал

⁷⁸ http://www.unodc.org/pdf/crime/corruption/judicial_group/Bangalore_principles.pdf

сонирхлын зөрчил, төсвийн мөнгийг буруу зарцуулахаас урьдчилан сэргийлэхэд чухал хувь нэмэр оруулсан.⁷⁹

Улс орнууд шүүгчийн хөрөнгө орлогоо мэдүүлэх үүргийг 3 түвшинд зохицуулж байна.⁸⁰Үүнд:

а/ Үндсэн хуульд тусгах;⁸¹

б/ Үндсэн хуулиас бусад хуульд тусгах;⁸²

в/ Шүүх болон шүүгчийн дүрэмд тусгах.⁸³

Хөрөнгө орлогоо мэдүүлж буй байдал нь шүүгчийг авлига авсан гэдгийг илрүүлж, нотлохоос илүүтэйгээр ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийн шүүх тогтолцоонд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилготой. Ингэснээр шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх ач холбогдолтой.⁸⁴ Шүүгчийн хариуцлага гэдэг ойлголт, үүний дотор ёс зүйн хариуцлага нь эцэстээ шүүхийн шийдвэрт аливаа гаднын нөлөө орохгүй байх, гаднын нөлөө орсон гэж ойлгогдохуйц нөхцөл бий болохоос сэргийлэх зорилготой юм. Аливаа нөлөө орсон тохиолдолд ихэвчлэн шүүгчид бодит болон бодит бус ашиг, давуу байдал бий болсон байдаг. Харин үүнийг илрүүлэх арга нь хөрөнгө орлогын мэдүүлэг гэж гадаад улсын практик болон олон улсын эрх зүйн баримт бичгээс харагдаж байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй үр дүнтэй арга нь нийтийн албан тушаалтнууд хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлэх явдал болсон ба Монгол Улсад холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүгч нь хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлэх үүрэгтэй субъект болно. Иймд хөрөнгө орлогын мэдүүлэг нь шүүгчийн хариуцлагатай байдлыг дээшлүүлэх нэг арга хэрэгсэл болох бөгөөд энэ судалгаанд хамрагдсан шүүгчдийн 52.7 хувь нь үүнтэй санал нийлж байна.

(3) Авлигаас ангид байх

Дээрхээс харахад шүүгчийн хариуцлагын тогтолцоонд хамаарах бусад ойлголтын нэг нь авлигаас ангид байх асуудал байна. НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын зорилгын “с” хэсэгт “төрийн хэрэг, төрийн эд хөрөнгийн шударга, хариуцлагатай, зохистой удирдлагыг дэмжихэд оршино” гэж заасан бөгөөд энэ ойлголтод дараах зүйлийг хамруулан авч үзсэн байна. Үүнд:

1. Авлигатай тэмцэхийн тулд оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн төрийн албан тушаалтныхаа шударга, үнэнч, хариуцлагатай байх явдлыг дэмжинэ.

2. Оролцогч улс бүр төрийн чиг үүргийг зөв, эрхэм бөгөөд зохистойгоор биелүүлэх ёс зүйн дүрэм буюу жишгийг өөрийн байгууллагын болон эрх зүйн тогтолцооныхоо хүрээнд хэрэглэхийг чармайна гэж заасан байна.

Өөрөөр хэлбэл, төрийн албан тушаалтнууд болох шүүгчийн шударга, үнэнч, хариуцлагатай байх явдлыг дэмжиж, шүүгчийн төрийн чиг үүргээ зөв, эрхэм бөгөөд

⁷⁹ USAID, Guidance for Promoting Judicial Independence and Impartiality, 2001, Technical Publication

⁸⁰ Keith E.Henderson, “Asset and Income Disclosure for Judges: A Summary Overview and Checklist”, <http://siteresources.worldbank.org/INTLAWJUSTINST/Resources/IncomeAssetDisclosure.pdf>

⁸¹ Колумб Улсын Үндсэн хуулийн 122 дугаар зүйл (Colombia’s Constitution 1991 (rev. 2005) Article 122)

⁸² Польш, Уганда, Эл Сальвадор зэрэг цөөнгүй улсууд

⁸³ АНУ, Аргентин зэрэг улсуудын “Шүүгчийн ёс зүйн дүрэм”

⁸⁴ Mira Gur-Arie and Russell Wheele, “Judicial Independence in the United States: Current Issues and Relevant Background Information” <http://www2.fjc.gov/sites/default/files/2012/JudIndep.pdf>

зохистойгоор биелүүлэх ёс зүйн дүрмийг мөрдүүлэхийг оролцогч улс орнуудад үүрэг болгосон байна. “Авлига” гэдгийг Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 1 дүгээр бүлгийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт зааснаар “мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг. Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт төрийн тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарах этгээд болно гэж заасан.

Бүх шатны шүүхийн шүүгч нь Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 2 дугаар бүлгийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт зааснаар төрийн тусгай албан тушаалд хамаарна. Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан этгээд хөрөнгө, орлогын мэдүүлгээ албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байх хугацаандаа жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй”, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ өөрөө үнэн зөв гаргах үүрэгтэй”, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт “Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй буюу санаатай худал мэдүүлсэн бол энэ нь түүнийг албан тушаалаас нь огцруулах, түдгэлзүүлэх, халах үндэслэл болно” гэж тус тус заасан нь шүүгчид хариуцлага тооцох бусад арга хэмжээний нэг арга хэрэгсэл болно.

(4) Шүүгчийг мэргэшүүлэх, дадлагажуулах

Зарим улс оронд шүүгчийг томилохын хамт томилсны дараа болон өмнө нь түүнийг дадлагажуулах, мэргэшүүлэх тогтолцоотой байх ба энэ нь ур чадвартай, мэргэшсэн шүүгчийг бэлтгэх, шүүхийн шийдвэр алдаагүй, зөв гарахад чухал хувь нэмэр оруулдаг. **Эстони Улсын** тухайд анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигч⁸⁵ шүүгчийн дадлагын ажлыг хийх шаардлагатай байдаг. Гэвч Шүүгчдийн Шалгалтын Хорооноос тухайн нэр дэвшигч нь туршлагатай, нэр хүндтэй хуульч бөгөөд ямар ч эргэлзээгүйгээр шүүгчийн албан үүргийг гүйцэтгэх боломжтой гэсэн үндэслэл бүхий шийдвэр гаргасан бол түүнийг дадлагын ажил хийлгэхээс чөлөөлөх, эсхүл дадлагын хугацааг 1 жил хүртэлх хугацаагаар багасгаж болно. Дадлагын ажлын зорилго нь шүүгчид нэр дэвшигчид шаардлагатай мэдлэг, туршлага олгох, нэр дэвшигч нь шүүгчийн албанд тохирох эсэхийг түүний хувийн зан чанараас нь олж тогтооход чиглэгдэнэ. Шүүхийн дарга нь шүүгчид нэр дэвшигчийг Шүүгчдийн Шалгалтын Хорооны саналыг үндэслэн шүүгчийн албанд дадлагын хугацаанд томилно. Үүнээс өмнө Шүүгчдийн Шалгалтын Хорооноос нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэгийг шалгаж, түүнтэй ярилцлага хийсэн байна.⁸⁶ Шүүгчийн дадлагын ажлын хугацаа 2 жил байна. Энэ хугацаанд тухайн нэр дэвшигч нь хэрэг,

⁸⁵ Шүүгчид нэр дэвшигч гэдэг нь шүүхийн байгууллагад Шүүгчдийн Шалгалтын Хорооноос гаргасан саналын дагуу шүүхийн даргаас дадлагын хугацаанд ажиллахаар томилогдсон хүнийг хэлнэ.

⁸⁶ Timo Ligi, “Judicial Independence in Estonia” in A.Seibert-Fohr (eds.), “Judicial Independence in Transition: Strengthening the Rule of Law in the OSCE Region, 2012, Springer-Verlag, Berlin, p.758

маргааныг шүүх хуралдаанд оруулахад бэлтгэхэд оролцох, шүүх хуралдааны хэрэг хөтлөх зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ. Дадлагын ихэнх хугацааг тухайн нэр дэвшигч нь томилогдсон шүүх дээр хийх бөгөөд шүүхийн дарга нь Шүүгчдийн Шалгалтын Хорооны санал болгосноор нэр дэвшигчийн дадлагын ажлыг удирдах шүүгчийг томилно. Нэр дэвшигч нь дадлагын ажлын тодорхой нэг хэсгийг өөр шүүхэд хийх ёстой ба үүний дагуу анхан болон давж заалдах шатны шүүхэд ажилласан туршлагыг олж авдаг. Түүнчлэн дадлагын хугацааны нэг хэсгийг Дээд шүүх, Прокурорын ерөнхий газар, Хуульчдын холбоо болон гүйцэтгэх засаглалын байгууллага эсхүл орон нутгийн засаг захиргааны байгууллагад хийж болдог.⁸⁷

Шүүгчид нэр дэвшигч дадлагын ажлыг дуусгасан бол анхан шатны шүүхүүдэд зарласан сонгон шалгаруулалтад оролцож, шүүгчийн шалгалтыг өгөх эрх нээгдэнэ. Гэвч дадлагын ажлыг дуусгасан болон шүүгчийн шалгалтад тэнцсэн гэсэн үндэслэлээр шууд шүүгч болохгүй.⁸⁸ Хэрэв нэр дэвшигч дадлагын хугацаанд шүүгчийн шалгалтад тэнцэхгүй бол дадлагын хугацаа нь түүнийг шалгалтад тэнцэх хүртэл үргэлжилж болно. Хэрэв нэр дэвшигч нь шүүгчийн шалгалтыг дадлагын хугацаанд өгч тэнцсэн хэдий ч шүүгчээр томилогдоогүй бол шүүхийн дарга нь дадлагын хугацааг нэр дэвшигчийн хүсэлтээр шүүгчээр томилогдох хүртэл, шүүгчийн шалгалтыг өгч тэнцсэнээс хойш 3 жилээс хэтрэхгүй хугацаанд сунгана. Энэ хугацаа дуусгавар болсон бол нэр дэвшигч байх эрхээ алдана. Түүнчлэн Шүүгчдийн Шалгалтын Хорооноос нэр дэвшигч дадлагын ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн гэж үзвэл түүнийг чөлөөлнө. Шүүхийн дарга нь Шүүгчдийн Шалгалтын Хорооны зөвшөөрлөөр нэр дэвшигчид сахилгын шийтгэл оногдуулж болно.⁸⁹

Япон Улсын хувьд шүүгчээр томилогдсоноос хойш 10 жил болоогүй этгээд нь туслах шүүгч болдог. Гэхдээ өмгөөлөгч, прокурор хийж байсан хугацааг энэ 10 жилд багтааж тооцдог. Тухайлбал, хуульчийн шалгалтад тэнцсэн хүмүүсээс шүүгчээр томилогдсон тохиолдолд “туслах шүүгч” болгож хэрэг хянан шийдвэрлэнэ.⁹⁰ Туслах шүүгч нь 10 жил ажилласны дараагаар “шүүгч” болох ба энэ асуудлыг Улсын Дээд шүүхийн тусгай хорооноос хянаж шийдвэрлэнэ. Өөрөөр хэлбэл, 10 жил ажилласан л бол шууд шүүгч болдоггүй. Тус хорооны дүгнэлтээр шүүгч болох боломжтой гэсэн туслах шүүгчийг шүүгч болгох бол харин шүүгч болох боломжгүй гэсэн туслах шүүгчийн шүүгч байх эрхийг нь хасна. Ингэж шүүгч байх эрхээ хасуулсан туслах шүүгч нь өмгөөлөгч, прокуророор ажиллах эрх нь нээлттэй хадгалагдана.

Туслах шүүгч нь дангаар бус гагцхүү шүүх бүрэлдэхүүнтэйгээр хэрэг хянан шийдвэрлэнэ. Мөн нэг хэрэгт хоёроос дээш туслах шүүгч оролцохыг хориглодог. Түүнчлэн тэрээр Ерөнхий шүүгч болох эрхгүй байдаг.⁹¹ Гэвч 5-аас дээш жил туслах шүүгчээр ажилласан бол Улсын Дээд шүүхийн шийдвэрээр “онцгой” туслах шүүгч болгож, дангаар хэргийг шийдвэрлэх эрхтэй болгодог. Мөн шүүхийн шийдвэрээс бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дангаар шийдвэр гаргах эрхтэй байдаг.

(5) Ард нийтийн хяналт

⁸⁷ Эстони Улсын Шүүхийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 2

⁸⁸ Timo Ligi, “Judicial Independence in Estonia”, p.758

⁸⁹ Мөн тэнд

⁹⁰ Япон Улсын Шүүхийн тухай хууль 43 <http://law.e-gov.go.jp/htmldata/S22/S22HO059.html>

⁹¹ Япон Улсын Шүүхийн тухай хууль 27.1 <http://law.e-gov.go.jp/htmldata/S22/S22HO059.html>

Япон улсын дээд шүүхээр анхлан томилогдсон шүүгч нь томилогдсоноос хойших эхний Парламентын сонгуультай зэрэгцэн ард нийтийн хяналтад ордог. Өөрөөр хэлбэл, ард нийтийн санал асуулгаар “Тухайн шүүгчийг огцруулах, эсхүл үргэлжлүүлэх эсэх” асуудлыг шийдвэрлэдэг байна. Эхний санал асуулгаар огцроогүй шүүгч нь дахин 10 жил тогтвортой ажиллах эрхтэй ба 10 жилийн дараа дахин ард нийтийн санал асуулгад оролцдог. Энэ тогтолцоог Үндсэн хууль болон Улсын дээд шүүхийн шүүгчийн ард нийтийн хяналтын тухай хуулиар зохицуулдаг байна. Гэвч нэг шүүгч тэр бүр дахин хяналтад орохгүй бөгөөд одоогийн байдлаар нэг ч шүүгч энэ хяналтаар огцорч байгаагүй болно.⁹²

Гурав. Шүүгчийн мэргэшлийн ур чадварын түвшинг үнэлж, дүгнэх асуудал

3.1. Шүүгчийн мэргэшлийн ур чадварын түвшинг үнэлж, дүгнэх нь: үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

Шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, зөрчигдсөн эрхийг сэргээх, гэм буруу нь тогтоогдсон этгээдэд ял шийтгэл оногдуулах зэргээр шударга ёсыг сахиулах үйлчилгээг хүргэдэг. Харин шүүхээс үзүүлж буй шударга ёсны үйлчилгээний чанарыг хэмжих нэг үзүүлэлт, арга хэрэгсэл нь шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны түвшинг үнэлэх тогтолцоо *Judicial Performance Evaluation* болохыг олон улсын туршлагаас харж болно. Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг үнэлэх ажиллагааны үндсэн зорилго нь тухайн шүүгчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, шүүгчийн зан төлөвийн стандартыг төлөвшүүлэх замаар мэргэжлийн үйл ажиллагааны түвшинг сайжруулахад оршино.⁹³ Ийнхүү шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны түвшинг тодорхойлсноор мэргэшсэн, чадварлаг шүүгчдийн тоо нэмэгдэхээс гадна оновчтой, зөв шийдвэрийн тоо ч нэмэгдэх хандлагатай байдаг.

Шүүгч нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэшлийн ур чадварыг эзэмшсэн байх ёстой. “Мэргэшлийн ур чадвар” гэдэгт шүүгчийн хууль, эрх зүйн мэдлэг, шүүн таслах үйл ажиллагааг удирдах арга хэлбэр, нотолгооны онолын талаарх мэдлэг, шүүгчийн хандлага, харилцааны ур чадвар, ажлын зохион байгуулалт зэрэг олон шалгуурыг авч үзнэ.⁹⁴ НҮБ-ын Үндсэн зарчмуудын 10-т “шүүгчийн албан тушаалд шилж, сонгогдсон хүн нь өндөр ёс суртахуун, чадвар, эрх зүйн салбарт зохих бэлтгэл, мэргэжил эзэмшсэн байх ёстой” гэж заасан.

Европын Шүүгчийн зөвлөлөөс 2012 онд баталсан “Шүүгчийг томилоход тавих наад захын стандартын тухай Дублины тунхаглал” (цаашид “Дублины тунхаглал” гэх)-д зааснаар “шүүгчийг сонгохдоо түүний хувийн ур чадвар, оюуны чадвар, ёс зүйн байдлыг шалгуур үзүүлэлт болгох ёстой” гэж заасан. Оюуны чадварыг шалгахдаа түүний хууль зүйн болон соёлын мэдлэг, задлан шинжилгээ хийх ур чадвар, шүүн таслан ажиллагаанд хараат бус байх чадваруудыг шалгах ёстой. Хувийн ур чадварыг шалгахдаа түүний зан чанарын тэвчээртэй, итгэлтэй,

⁹² Overview of the Judicial System in Japan http://www.courts.go.jp/english/judicial_sys/overview_of/overview

⁹³ М.Туяа, “Шүүгчийн мэргэжлийн түвшинг үнэлэх ажиллагаа түүний зорилго, үр нөлөө”, “Шүүх эрх мэдэл” эмхэтгэл №1, 2014 он, Улаанбаатар хот, 15 дахь тал

⁹⁴ Пим Алберс, “Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагаанд өгөх үнэлгээ”, 2013 оны 9 дүгээр сарын 2-оос 6-ны өдрүүдэд шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг үнэлж, үүнтэй холбогдуулан боловсруулагдсан журмын төсөлд өгсөн зөвлөмж www.judcouncil.mn/menews/382--.html

мэдрэмжтэй, нийтэч, шударга чанар, хамтран ажиллах зэрэг чадваруудыг шалгана. Дублины тунхаглалын 12 дугаар зүйлд “нэгэнт сонгогдон ажиллаж буй шүүгчдийн мэргэшлийн үйл ажиллагаанд өгөх үнэлгээ нь шүүгчээр анх сонгоход тавьж буй шалгууртай адил байх ба энэ үнэлгээ нь шүүгчийн ажлын гүйцэтгэлд тулгуурлах ёстой” гэжээ. Гэхдээ анхан болон давж заалдах, түүнчлэн дагнасан шүүхийн шүүгчдийн шалгуур үзүүлэлт өөр өөр байх ёстой байдаг.⁹⁵

Эдгээр чадварыг шүүгчид эзэмшсэн эсэхийг илрүүлэн тогтоох шалгуур үзүүлэлтүүдээс заримыг дурдвал:⁹⁶

1. *Хууль зүйн чадварыг*⁹⁷ шалгахад эрх зүйн онол, салбар эрх зүйн онолын мэдлэг болон процессын эрх зүй, нотолгооны онолын талаарх мэдлэг эзэмшсэн байдал (хууль тайлбарлаж буй байдал) болон хэргийн шалтгаант холбоог илрүүлэх чадварыг илрүүлэхийг эрмэлздэг. Ингэхдээ тухайн шүүгчийн шийдвэрийг “зөв, буруу” гэсэн байдлаар бус харин шүүгчийн шийдвэртээ хүрч буй арга зам, чадварыг шалгахыг урьтал болгоно. Түүнчлэн шүүгч нь мэдлэг, ур чадвараа сайжруулахын тулд өөрийгөө дайчилж, бие даан хөгжүүлж буй байдалд ч үнэлгээ өгдөг.⁹⁸
2. *Харилцааны ур чадварыг* шалган тогтооход аман болон бичгийн харилцааны ур чадварт тулгуурлан дүгнэлт хийнэ.
3. *Шүүгчийн зохион байгуулалт, удирдах ур чадварыг* үнэлэхэд түүний шүүх хуралдаанд бэлтгэх, процессын хуулиуд дахь хугацаа баримтлах буюу хэргийн хөдөлгөөний менежмент хийх, түргэн хугацаанд оновчтой шийдвэр гаргах, ажлын цаг ашиглалт зэрэг чадваруудыг шалгуур үзүүлэлт болгон дүгнэлт гаргана.

Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны үнэлгээг бүрэн дүүрэн, бодитой гаргахын тулд янз бүрийн, өөр хоорондоо ялгаатай үнэлгээний арга хэрэгсэл, механизмыг ашиглахыг зөвлөдөг бөгөөд олон улсын жишиг, практик хандлагаас харахад тухайн судалгаа, үнэлгээ нь хамгийн багадаа санамсаргүйгээр, урьдчилж төлөвлөөгүй байдлаар авагдсан шүүн таслах ажиллагааны дүгнэлт, шүүхийн шийдвэрүүд дээр хийгдсэн кейс судалгаа,⁹⁹ шүүгчийн өөрийн хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийн статистик, тухайн шүүхээр үйлчлүүлсэн хүмүүсийн санал,

⁹⁵ Without Fear or Favor in 2011: A New Decade of Challenges to Judicial Independence and Accountability

⁹⁶ АНУ-ын БАР-ын холбооны “Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны үнэлгээ” /2005/, Европын Шүүгчдийн зөвлөлийн “Шүүгчийг томилоход тавих наад захын стандартын тухай Дублины тунхаглал” /2012/, АНУ-ын [Transparent Courthouse: A Blueprint for Judicial Performance Evaluation](#) /2006/-ыг тус тус үндэслэв.

⁹⁷ “Хууль зүйн ур чадвар” гэдгийг хууль, эрх зүйн ойлголтыг үйл баримт болон тодорхой нөхцөлийг хэрхэн тайлбарлаж, үндэслэл болгож байгаа оюуны чадамж хэмээн тодорхойлж болно.

⁹⁸ Office of Democracy and Governance Bureau for Democracy, Conflict, and Humanitarian Assistance U.S. Agency for International Development “Guidance for Promoting Judicial Independence and Impartiality” 2002

⁹⁹ Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх явдал нь шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагаанд үнэлэлт өгөх арга болно. Шүүгчийн онолын мэдлэг, нотолгооны эрх зүйн чадвар зэрэг хууль зүйн чадварууд болон шүүхийн шийдвэрт тавигддаг хэлбэрийн шаардлагуудыг хангаж ажилладаг эсэхийг үнэлэхдээ шүүгчийн шийдвэрт анализ хийнэ. Түүнчлэн шүүхийн шийдвэр нээлттэй байх буюу олон нийтэд хүртээмжтэйгээр, тухайлбал, цахим хуудаст байршуулдаг байх нь шүүгчийн шийдвэрийн чанарыг сайжруулах нэг аргын болдог. Учир нь шүүхийн шийдвэр нийтлэгдсэнээр шийдвэр нь олон нийтэд нээлттэй болохоос гадна судлаач, эрдэмтдийн дунд судалгааны эргэлтэд орох ач холбогдолтой байдаг.

шүүгчийн эсрэг гаргасан аливаа ёс зүйн гомдол, шүүгчийн хамрагдсан сургалтаас олж авсан мэдлэг зэргийг шалгах шаардлагатай байдаг.¹⁰⁰

Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагаанд өгөх үнэлгээ нь шүүгчийн бие даасан байдал, шүүгчийн ажлын чанарыг дээшлүүлэх зорилготой юм.¹⁰¹ Өөрөөр хэлбэл, мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг үнэлэх ажиллагааны үр дүнг ашиглахдаа тухайн шүүгчийн цалинг бууруулах, огцруулах зэрэг сөрөг үр дагавартай арга хэмжээ авахыг шүүгчийн хараат бус байдлын зөрчил гэж үздэг. Үүний оронд мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, тодорхой чиглэлээр сургалтад хамрагдахыг даалгах зэрэг хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх арга хэмжээ авахыг санал болгодог. Мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг үнэлж, дүгнэх нь зөвхөн тухайн шүүгчийн мэдлэг, ур чадвар, түүний ажлын бүтээмжийг дээшлүүлэх эерэг үр дагаварт хүргэхэд чиглэгдэнэ.¹⁰² Түүнчлэн шүүгчийн мэдлэг, ур чадварыг тухайн шүүгч өөрөө тодорхойлж, хөгжүүлэх үүрэгтэй тул шүүгчийн ёс зүйтэй уялдуулж шийдвэрлэх нь шүүгчийн хараат бус байдалд нийцнэ гэж үзэх хандлага байдаг.

Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны үнэлгээнд хэрэглэгдэх жишиг, стандарт, шүүгч /дээд шатны шүүхийн/-д, тэргүүн болон ерөнхий шүүгч /*court presidents*/-д тавигдах наад захын шалгуур үзүүлэлт, стандартыг тодорхойлохдоо шүүхийн систем, шүүхийн өөрийн оролцоотойгоор тодорхойлж гаргаж ирэх нь зүйтэй юм. Эдгээр стандартууд нь тухайн шүүгчийн туршлага, ажлын чиглэл /эрүүгийн эрх зүйн, иргэний эрх зүйн, захиргааны эрх зүйн салбарын шүүгч/-тэй уялдаж байхаас гадна шүүгчийн зэрэг дэв, албан тушаалын зэрэглэл /анхан шатны, дунд шатны, давж заалдах шатны, Дээд шүүхийн шүүгч, шүүхийн танхимын тэргүүн, Ерөнхий шүүгч г.м./ болон тэдгээрийн хууль эрх зүйн мэдлэг, ур чадвар, шүүн таслах ажиллагааг удирдах арга хэлбэр, шүүгчийн хандлага, ажлын гүйцэтгэл зэрэг үзүүлэлттэй нягт уялдаатай байх ёстой. Эдгээр стандартад үндэслэж тухайн шүүгчийн ажлын гүйцэтгэл нь: “онц сайн” буюу дундаж гүйцэтгэлээс дээгүүр, “сайн” буюу шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны үнэлгээний хамгийн бага үзүүлэлт, хэм хэмжээг хангаж байгаа, “хангалттай” буюу хамгийн бага үзүүлэлт, хэм хэмжээг л хангаж байгаа, “хангалтгүй” буюу шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны үнэлгээний хэм хэмжээнээс доогуур гэх зэргээр үнэлдэг¹⁰³ байна.

3.2. Монгол Улсын шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны үнэлгээ хийхэд тулгамдаж буй зарим асуудал

Нийгмийн харилцаа улам бүр тэлж, хэрэг, маргааны цар хүрээ нэмэгдэхийн хэрээр шүүгчээс хуулийг зөв хэрэглэх өндөр түвшний мэдлэг, ур чадварыг шаарддаг. Монгол Улсад шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг тогтоох ажиллагааг Шүүхийн багц хууль батлагдахаас өмнө Улсын Дээд шүүхийн тогтоолоор тухайн цаг үеийн нөхцөл байдалд нийцсэн шалгуур үзүүлэлт, үе шат, хамрах хүрээнд явуулж байжээ.¹⁰⁴ Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийг

¹⁰⁰ Пим Алберс, “Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагаанд өгөх үнэлгээ”, 2013

¹⁰¹ Without Fear or Favor in 2011: A New Decade of Challenges to Judicial Independence and Accountability <http://www.foster.com/documents/dri-without-fear-or-favor-2011.aspx>

¹⁰² М.Туяа, “Шүүгчийн мэргэжлийн түвшинг үнэлэх ажиллагаа түүний зорилго, үр нөлөө”, “Шүүх эрх мэдэл” эмхэтгэл №1, 2014 он, Улаанбаатар, 17 дахь тал

¹⁰³ Пим Алберс, “Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагаанд өгөх үнэлгээ” www.judcouncil.mn/menews/382-.html

¹⁰⁴ Н.Мөнхзул, “Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны мониторинг”

хамгаалахын тулд шүүгч хараат бус байхын зэрэгцээ хариуцлагатай буюу ёс зүйн дүрмийг сахин биелүүлэх, хууль хэрэглээ, онолын болон шүүн таслах ажиллагааг удирдан зохион байгуулах мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх явдал чухал байдаг. Улмаар Шүүхийн багц хууль батлагдсанаар шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааг үнэлэх эрх зүйн үндсийг баталгаажжээ.

Шүүхийн багц хуульд шүүгч нийгэм, эрх зүйн хөгжил, хууль тогтоомжийн өөрчлөлтөд нийцүүлэн өөрийн мэдлэг боловсрол, ур чадвараа ямагт дээшлүүлж байх шаардлагатай гэсэн үзэл баримтлалын хүрээнд тодорхой цаг хугацааны давтамжтайгаар шүүгчийн “мэргэшлийн түвшинг нь тогтоож” байх зохицуулалт шинээр нэвтрүүлсэн.¹⁰⁵ Ингэж ур чадварыг үнэлэх нь тухайн шүүгч ажлын байрныхаа шаардлагыг хангаж байгаа эсэхийг үнэлж дүгнэх бололцоог бий болгосон. Харин зарим иргэд дээрх хуульд заасны дагуу Шүүхийн мэргэшлийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүгчдийн үйл ажиллагаанд хоёроос гурван жилд нэг удаа үнэлэлт, дүгнэлт өгөх нь шүүхийн хараат бус, бие даасан байдалд нөлөөлж байна гэж үзэн Үндсэн хуулийн Цэцэд хандсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтээр¹⁰⁶ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсэгт шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны түвшинг тогтоох үнэлгээ, дүгнэлт нь хоёр жилийн хугацаанд хүчинтэй байж тухайн шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлөх эсэх асуудлыг Ерөнхий зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх үндэслэл болохоор заасан нь Үндсэн хууль зөрчсөн, шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааг үнэлэгч үндсэн зорилтоос хазайсан зохицуулалт болсон гэж үзсэн байна. Үүнээс харахад хэдийгээр шүүгчийн мэргэшлийн түвшинг тогтоох явдал нь шүүгчийн хараат бус байдалд халдах хэрэгсэл биш хэдий ч энэ ажиллагааг хэрэгжүүлэхэд шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болголтгүйгээр харин тухайн шүүгч нь өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлсэн эсэхийг үнэлэх арга хэрэгсэл болгох нь зүйтэй юм. Ингэснээр шүүгчийг ёс зүйн шаардлагыг хангаагүй, ёс зүйн зөрчил гаргасан гэж Шүүхийн ёс зүйн хороонд гомдол гаргаж болно. Энэ тохиолдолд тухайн шүүгч нь иргэд, олон нийтийн хяналтан дор шүүн таслах ажиллагаа явуулах мэдлэг, чадварынхаа хувьд хуулийн шаардлага хангасан эсэхэд үнэлүүлж, дүгнүүлэх боломжтой болно. Хэрэв энэ шаардлагыг хангаагүй гэдэг нь тогтоогдвол түүнд хариуцлага тооцдог байх нь эрх зүйт ёсны зарчимд нийцэх юм.¹⁰⁷

Хуульд заасан эрх олгогдсон этгээдийн гаргасан журамд зааснаар шүүгчийн мэргэшлийн түвшинг тогтоох нь шүүгчийг хараат байлгах, захиргаандаа оруулах бус харин шүүгчийн хувьд өөрийн мэдлэг, ур чадварын түвшинг танин мэдэх, түүнийгээ

<http://www.judcouncil.mn/menews/print:page.1,383--.html>

¹⁰⁵ Хууль тогтоогч “Шүүхийн багц хууль”-ийг батлахдаа шүүгчийн хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт “Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны түвшинг гурваас таван жилд дүгнэх...”-ээр, улмаар Шүүхийн захиргааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.2-т “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3-т заасан шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг тогтоох ажлыг Ерөнхий зөвлөлийн удирдамжийн дагуу зохион байгуулж, үнэлгээ өгч, дүгнэлт гаргах”-аар, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсэгт “...үнэлгээ, дүгнэлт тухайн шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлөх эсэх асуудлыг Ерөнхий зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх үндэслэл...” байхаар тус тус заасан байна.

¹⁰⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлт, “Шүүхийн захиргааны болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай”, дугаар 05, 2015 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

¹⁰⁷ Мөн тэнд

дээшлүүлэх ач холбогдолтой байдаг. Ингэснээр иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийн баталгаа улам нэмэгдэх болно. Шүүгчийн мэргэшлийн түвшинг тогтоох нь түүний шүүн таслах ажиллагаанд хяналт тавих, хөндлөнгөөс оролцох асуудал бус, харин шүүн таслах ажиллагаатай холбоогүй үйл ажиллагаа гэж хууль тогтоох байгууллагын зарим гишүүд үзсэн байна.¹⁰⁸ Гэтэл тэдний зарим нь үзэхдээ шүүгчийн ажлын чанар бүтээмж хянагдах ёстой хэдий ч энэхүү үнэлгээг Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн мэргэшлийн хороо хийх ёсгүй. Шүүгчийг гагцхүү ёс зүйн хувьд тэнцэхгүй эсхүл мэргэжлийн үүргээ биелүүлж чадахгүй тохиолдолд л ажлаас нь чөлөөлж болно.¹⁰⁹ Шүүхийн мэргэшлийн хороо дүгнэлт гаргаад, дүгнэлт нь сөрөг гарсан тохиолдолд ажлаас нь чөлөөлөх нь шүүгчийн бие даасан, хараат бус байдалд нөлөөлөх хандлага бий болсон гэж үзжээ.¹¹⁰ Түүнчлэн хууль тогтоогчид шүүгчийн хараат бус, бие даасан байдал болон шүүгчийн хариуцлагын асуудлыг хамтад нь авч үзэх ёстой. Шүүгчийг хараат бус, бие даасан байлгана гээд энд шүүгчийн хариуцлагагүй, хууль зөрчдөг, ёс зүйгүй байдлыг дэмжиж болохгүй гэдгээ хууль тогтоогчид нэгэнтээ илэрхийлжээ.¹¹¹

Дээрхээс харахад, шүүгчийн мэргэшлийн түвшинг тогтоох нь шүүгчийн хараат бус байдалд халдах бус харин шүүгчийн хувьд өөрийн мэдлэг, ур чадварын түвшинг танин мэдэх, үүнийгээ дээшлүүлэх ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, шүүгчийн мэргэшлийн түвшинг тогтоох нь түүний шүүн таслах ажиллагаанд хяналт тавих, хөндлөнгөөс оролцох асуудал бус харин шүүн таслах ажиллагаатай холбоогүй үйл ажиллагаа юм. Түүнчлэн шүүгчийг хугацаагүй томилдог тул шүүгчийн мэргэшлийн түвшинг тогтоох нь нэг талаар шүүгчийг зүй бус нөлөөллөөс хамгаалах эрх зүйн хамгаалалт болно. Харин мэргэжлийн ур чадваргүй, ёс зүйгүй нь нэгэнт тогтоогдсон шүүгчийг хамгаалах тогтолцоо биш юм. Шүүгчийн мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэхэд, шүүгч нь өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх үүргээ биелүүлээгүй нь тогтоогдвол ёс зүйн хувьд тэнцэхгүй гэж үзэн Шүүхийн ёс зүйн хороонд гомдол гаргах боломжтой юм. Шүүгч нь шүүн таслах ажиллагаа явуулах хуулиар олгосон бүрэн эрхээ эдэлж, төрийн нэрийн өмнөөс хэрэг, маргааныг таслан шийдвэрлэдэг, шударга ёсны буюу нийтийн үйлчилгээг үзүүлдэг нийтийн албан тушаалтан юм. Иймд шүүгч нь иргэд, олон нийтийн хяналтад шүүн таслах ажиллагаа явуулах мэдлэг, чадварын хувьд тухайн шүүгчийн албан тушаалд тавигдах хуулийн

¹⁰⁸ Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл www.parliament.mn/files/download/113771

¹⁰⁹ 1985 оны НҮБ-ын "Шүүх эрх мэдлийн бие даасан байдлын тухай үндсэн зарчмууд"-ын 18 дахь хэсэгт шүүгчийг гагцхүү ёс зүйн хувьд тэнцэхгүй болон мэргэжлийн үүргээ гүйцэтгэх чадваргүй тохиолдолд огцруулна. Ёс зүйн хувьд тэнцэхгүй гэдэг нь шүүгч өөрийгөө тасралтгүй боловсруулах, хөгжүүлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд ёс зүйн хувьд тэнцэхгүй гэж үзнэ гэж заасан. Түүнчлэн эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй болсон тохиолдолд шүүгчийг ажлаас нь чөлөөлж болно гэж УИХ-ын гишүүн Ж.Батзандан УИХ-ын 2015 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдааны үеэр илэрхийлжээ.

¹¹⁰ Монгол Улсын Их Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл www.parliament.mn/files/download/113771

¹¹¹ Ийм учраас холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурал Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хүлээж авахын зэрэгцээ шүүгчийн хариуцлагын асуудлыг нухацтай авч үзэх ёстой гэдгийг УИХ-ын гишүүн Ж.Батзандан УИХ-ын 2015 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдааны үеэр онцолсон.

шаардлага хангасан байх ёстой. Хэрэв тус шаардлагыг хангахгүй бол түүнд хариуцлага тооцдог байх нь эрх зүйт ёсны зарчимд нийцсэн шийдвэр болно.¹¹²

Энэ судалгааны хүрээнд Монгол Улсын зарим шүүгчээс шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагаанд хийх үнэлгээг ямар шалгуур үзүүлэлтээр явуулахыг дэмжих тухай судлан тогтоохоор санал асуулгыг явуулсан. Мэргэшлийн үйл ажиллагаанд дээрх байдлаар хууль зүйн ур чадварыг шалган тогтоох явдлыг судалгаанд оролцсон шүүгчдийн 61 хувь нь, шүүгчийн мэдлэг, ур чадвараа сайжруулахад өөрийгөө хөгжүүлж буй байдалд үнэлгээ хийхийг 42.2 хувь нь, харилцааны ур чадварыг ярианы болон бичгийн ур чадварт түшиглэн дүгнэлт хийхийг 42.2 хувь нь, шүүхийн шийдвэрүүдээс тодорхой хэсгийг авч, кейс судалгаа хийж, дүн шинжилгээ хийхийг 42.2 хувь нь тус тус дэмжсэн байна. Харин судалгаанд оролцсон шүүгчдийн 53.3 хувь нь тухайн шүүхээр үйлчлүүлэгчдийн санал, дүгнэлт /үүнд, өмгөөлөгч, прокурор, нэхэмжлэгч, хариуцагч г.м/-ийг шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны үнэлгээнд оруулах, шүүгчийн эсрэг гаргасан гомдол болон түүний оролцсон сургалтын талаарх мэдээллийг үнэлэхийг 47.8 хувь нь, шүүгчийн зохион байгуулах, удирдах чадварыг үнэлэхийг судалгаанд оролцогчдын 21.1 хувь нь тус тус дэмжээгүй байна.

Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны ур чадварын үнэлгээ нь хангалтгүй гарсан тохиолдолд судалгаанд оролцсон шүүгчдийн 86.7 хувь нь шүүгчийн мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэхэд чиглэгдсэн давтан сургалтад заавал хамруулах, 10 хувь нь уг үнэлгээг Шүүхийн мэргэшлийн хорооноос Шүүхийн ёс зүйн хороонд шилжүүлж, сахилгын арга хэмжээ авах (сахилгын арга хэмжээнд цалин хөлсийг түр хугацаагаар бууруулах, цалин олголтыг зогсоох, өөр шүүхэд шилжүүлэх, албан тушаал, зэрэг дэвийг бууруулах, шүүгчээс чөлөөлөх г.м.), 3.3 хувь нь огцруулах үндэслэл болдог байх нь зүйтэй боловч энэ тохиолдолд эцсийн шийдвэрийг шүүх гаргадаг байх нь зохимжтой гэж тус тус хариулсан байна.

Дээрхээс харахад шүүгчийн албан тушаалд тавигдах шалгуур үзүүлэлт болох мэргэжил, ур чадварт тавигдах шаардлагыг шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг тогтоосноор тодорхойлж болохоор байна. Ийнхүү түвшин тогтоосноор шүүгч өөрийнхөө мэргэжлийн үйл ажиллагаа явуулах мэдлэг, чадвараа ямар түвшинд байгааг танин мэдэхийн зэрэгцээ гарсан үнэлгээнд дүгнэлт хийж өөрийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах бол, нөгөөтээгүүр, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүгчдэд ямар төрлийн сургалтыг түлхүү явуулах шаардлагатай гэдэг цаашдын шүүгчдийн сургалтын бодлогыг тодорхойлоход дөхөмтэй болно. Дараах хэсэгт гадаадын зарим улсуудад шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагаанд үнэлгээ хийдэг жишгийг авч үзье.

3.3.Гадаадын зарим улс дахь шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны үнэлгээ

Хорват Улсын Бүх шүүгчдийн зөвлөгөөний ерөнхий шүүгчдийн зөвлөлөөс “Шүүгчдийн үйл ажиллагааны түвшинг үнэлэх аргачлал”-г 2007 онд баталсан байна. Тус аргачлалын 1 дүгээр зүйлд анхлан томилогдсоноос хойш шүүгчээр ажиллаад 2

¹¹² Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт “Шүүхийн захиргааны болон Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай”, Дугаар 05, 2015 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

жил болсон шүүгч, түүнчлэн өөр шүүхэд томилогдох болсон үед, мөн шүүгчийн албан тушаалд томилогдсон болон ерөнхий шүүгчид нэр дэвшсэн бол Шүүгчдийн зөвлөлөөс тухайн шүүгчийн ажлын гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгдөг байна.¹¹³

Тус аргачлалд үнэлгээг тооцох шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон байна. Үүнд:¹¹⁴

- Шүүгчийн ажлын бүтээмж */performance/*: Шүүгчийн шийдвэрлэсэн хэргийн нийт тоог хэргийн төрлөөр нь болон шийдвэрлэх ёстой байсан нийт хэргийг хэргийн төрлөөр ажлын цагийг үр ашигтай зарцуулснаар нь хувь тэнцүүлэн бодож бүтээмжийг бодит тоогоор тооцоолж гаргадаг. Шүүгчийн гаргасан шийдвэр эрх зүйн тогтоосон стандартад нийцэж байгаа эсэхийг эрх зүйн тодорхой шалгуурын төрөл (ангилал) тус бүрийн дүнгийн нийлбэр нь 100 хувь байвал шүүгч өөрийн үүргээ сайн биелүүлсэн байна гэж үзнэ (тус аргачлалын 3-6 дугаар зүйл).
- Шүүгчийн үйл ажиллагаандаа холбогдох процедур, журмыг баримталдаг эсэх */meeting of deadlines/*: Шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаандаа холбогдох процессын хууль, журамд заасан хэрэг хянан шийдвэрлэх хугацааг баримталж шийдвэрээ бичиж, гардуулснаар нь үнэлэх ба 100 хувь хугацаанд нь шийдвэрээ бичиж, гардуулсан бол 10 оноо, 75 хувьтай бол 5 оноо, 75-аас доош хувьтай бол 0 оноо өгнө (тус аргачлалын 7 дугаар зүйл).
- Шүүгчийн ур чадварын үзүүлэлт */performance quality/*: Анхан шатны шүүхийн шүүгчийн шийдвэр нь давж заалдах шатны шүүхээр хянагддаг тул хэрхэн чанартай шийдвэр гаргасан эсэх талаар үнэлнэ. Энэхүү шалгуурын дагуу шүүгч нь хамгийн багадаа 3 жилийн дотор нийт шийдвэрлэсэн 40 хэргийг дээд шатны шүүхэд нь хянасан байх шалгуур тавигдана. Тус шалгуурын дагуу тухайн шийдвэрийн чанарыг шийдвэрлэсэн нийт хэргийн хэдэн хувийг дээд шатны шүүхээс буцааснаар нь үнэлдэг(тус аргачлалын 8-10 дугаар зүйл).
- Шүүгчийн мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх буюу хөгжүүлж байгаа байдал */professional development/*: Шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу мэргэжлийн ур чадвараа хэрхэн хөгжүүлж байгаагаас хамаарч үнэлгээ өгдөг байна. Тухайлбал, шүүгч нь жилд хууль зүйн чиглэлийн хичээл (клиник сургалт, семинар)-г тодорхой их дээд сургуульд заасан бол 5 оноо, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан бол 5 оноо, хууль зүйн шинжлэх ухааны ном, товхимол бичиж хэвлүүлсэн бол 5 оноо, Шүүхийн академийн шаардлага, хэрэгцээнд зориулж судалгаа, сургалтын материал хэвлүүлсэн бол 3 оноо, мэргэжлийн уулзалт болон эрдэм шинжилгээний бага хуралд илтгэгчээр эсхүл хурал даргалагчаар оролцсон бол 3 оноо, шүүгчдийн зөвлөгөөнд

¹¹³ Council of Presidents of all Judges' councils in the Republic of Croatia, "Methodology for the evaluation of judges"

<http://pak.hr/cke/propisi.%20zakoni/en/MethodologyForEvaluationofJudges/Methodology.pdf>

¹¹⁴ Мөн тэнд

хүргүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэлд 2 оноо, бие даан мэргэжлийн уулзалт болон эрдэм шинжилгээний бага хуралд оролцсон бол 1 оноог тус тус өгдөг(тус аргачлалын 11-14 дүгээр зүйл).

- Шүүгчийн мэргэжлийн ур чадварыг онцгой тохиолдолд үнэлэх */judicial performance evaluation in specific cases/*: Шүүгчийн зан төлөвийн хандлагыг шүүгчээр ажиллаж байх үед нь үнэлэх, зарим тохиолдолд тусгайлан шүүгчийн ажилдаа хандах хандлага, хамт олон, тэр дундаа шүүхийн захиргааны ажилтнуудтай харьцах харьцааг бичгээр болон яриагаар өөрийгөө илэрхийлэх чадварыг үнэлнэ (тус аргачлалын 15 дугаар зүйл).

Румын Улсын Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааг үнэлэх зорилго нь шүүгчийн мэргэшлийн гүйцэтгэлийг сайжруулах, шүүхийн үр нөлөөг дээшлүүлэх, шүүх эрх мэдэлд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд оршдог. Шүүгчдийг 3 жил тутам бие даасан Үнэлгээний хороо үнэлдэг ба тус Үнэлгээний хороо нь шүүхийн дарга ба тухайн шүүхэд ажилладаг 2 шүүгчээс бүрдэнэ. Эдгээр шүүгч, шүүхийн даргыг Шүүгчдийн эсхүл Хуульчдын Үндэсний Институтэд тусгай сургалтад хамруулж мэргэшсэн үнэлгээ тогтоох эрх олгодог байна.¹¹⁵

Үнэлгээний хороонд мэргэшлийн үнэлгээг гаргахдаа тухайн шүүгчийн шүүх дэх бүртгэл, баримт бичиг, мэргэжлийн үйл ажиллагааны мэдээлэлтэй танилцах эрх олгож байдаг.¹¹⁶ Үнэлгээний процесст зориулсан удирдамжийг гаргасан бөгөөд үүнд тухайн шүүгчийн ажлын гүйцэтгэл, чанар, мэргэжлийн сургалтад хамрагдсан байдал зэргийг агуулсан Үнэлгээний хуудас /маягт/ ордог. Үнэлгээний хороо нь шүүгчийг дараах 14 шалгуур үзүүлэлтээр 1-10 хүртэлх оноогоор үнэлнэ. Үүнд:¹¹⁷

- Хуулийг хэрэглэх, тайлбарлах чадвар;
- Үйл ажиллагаандаа холбогдох процедур, журмыг баримталж байгаа байдал;
- Шүүн таслах чадвар/Шийдвэрийн чанар/;
- Шийдвэрлэсэн хэргийн ээдрээ төвөгтэй байдал;
- Хугацаандаа үүрэг даалгавар гүйцэтгэсэн байдал;
- Үндсэн хуулийн шүүх ба Европын Хүний эрхийн шүүхийг байгуулсан эрх зүйн акт болон эдгээр шүүхийн хэрэг хянан шийдвэрлэж буй практикийн талаарх мэдлэг;
- Шаргуу, хичээнгүй байдал;
- Идэвх санаачилга;
- Нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх чадвар;
- Ажлын сахилга бат;
- Хамт олон, шүүгчдэд хандах хандлага;
- Иргэдэд хандах хандлага;
- Мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахиж буй байдал зэрэгт үнэлгээ өгдөг.

Хэрэв үнэлгээний дундаж оноо буюу 6 онооноос бага үнэлгээ авсан бол шүүгчийг хангалтгүй үнэлгээ авсан гэж үздэг. Ийм үнэлгээ авсан шүүгчид Үндэсний Институтэд тусгай сургалтад хамрагдах үүрэг өгч, сургалт дууссаны дараа шалгалт

¹¹⁵ Пим Алберс, “Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагаанд өгөх үнэлгээ”, 2013 он

¹¹⁶ Romania Judicial Functional Review, 2013

¹¹⁷ Jesper Wittrup, “Analysis of the system for measuring and monitoring judicial performance in Romania”, 2006

авна. Хэрэв шүүгч шалгалтад тэнцэхгүй бол түүнийг мэргэжлийн ур чадвар дутмаг байна гэж үзэж, ажлаас чөлөөлнө. Ийнхүү 2 удаагийн үнэлгээнд удаа дараахангалтгүй үнэлгээ авсан шүүгчийг мөн ажлаас чөлөөлөх үндэслэл болно. Гэвч ийм тохиолдол Румынд ховор гарч байна. Хэрэв шүүгч үнэлгээнд сэтгэл хангалуун бус байгаа бол Шүүхийн Дээд Зөвлөлд үнэлгээний хорооны шийдвэрийг давж заалдаж болдог. Гэхдээ түүний үнэлгээ нь “маш сайн” гэсэн үзүүлэлтээс доогуур байгаа тохиолдолд л уг Зөвлөлд хандах боломжтой.¹¹⁸

ХБНГУ-д шүүгчийн ажлыг хэрхэн үнэлдэг талаар Шүүхийн мониторингийн төслийн зөвлөх Хатагтай Веберийн танилцуулснаар авч үзье.¹¹⁹ Нэгдүгээрт, шүүгчийг үнэлэх үнэлгээний зарчмуудыг тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, үнэлгээ хийхэд ямар зарчмыг тодруулна. Үүнд, бүх мужийн хэмжээнд шүүгчийн үнэлгээг нэг ижил загвараар авах, хувь хүний ашиг сонирхлыг хамгаалсан байх, тухайн ажил мэргэжилд тохирч байх шаардлагатай.

Шүүгчийг бүх насаар нь томилогдсоны 3 жилийн дараа үнэлгээ хийдэг ба дахин үнэлгээ хийдэггүй. Харин удаан хугацаагаар чөлөө авсны дараа, зэрэг дэвдэвших зэрэг тохиолдолд үнэлгээг хийнэ. Энэ тохиолдолд Ерөнхий шүүгч тухайн шүүгчийн талаар дэлгэрэнгүй үнэлгээ хийж, мэргэжлийн ямар нэг шалгалт авдаггүй. Ерөнхий шүүгч дэвших тохиолдолд дээд шатны шүүхийн Ерөнхий шүүгч шүүгчийн ажлын гүйцэтгэлийг үнэлнэ. Энэ үнэлгээг хийхийн тулд Ерөнхий шүүгч нь тухайн шүүгчийн шийдвэрлэсэн хэргүүдийн заримыг нь авч, судалж, мөн шүүх хуралдаанд нь суудаг байна.

Ийнхүү хувь хүний зан чанар, мэргэшлийн гэсэн 2 хэсгээс бүрдсэн үнэлгээг дахин дээд шатны Ерөнхий шүүгчид хүргүүлдэг. Үнэлгээнд гарын үсэг зурсны дараагаар шүүгчтэй үнэлгээний талаар ярилцана. Үүнд, шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлээр гаргасан шийдвэрийг үнэлэх асуудал яригдахгүй. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хатуу тогтоосон хугацаа байхгүй тул энэ асуудал үнэлгээнд ордоггүй. Хэргийг “хурдан шуурхай шийдэх”, “зөв шийдэх” зэрэг үгс шүүгчдийн ажилд хэрэглэгдэх ёсгүй ба энэ тохиолдолд үнэлгээнд болгоомжтой ханддаг. Шүүгч үнэлгээний дүнг эсэргүүцсэн тохиолдолд Захиргааны хэргийн шүүхэд давж заалдаж болно.¹²⁰

Үнэлгээнд “тохирохгүй”, “хараахан тохирохгүй”, “тохирно”, “сайн”, “онц сайн”, “онцгой сайн” гэсэн үнэлгээ өгнө. “Сайн” гэсэн үнэлгээ авсан бол шүүгчийг дэвшүүлэхгүй. Хэдийгээр үнэлгээг хүн хийж байгаа нь субъектив байдлыг гаргах талтай ч үнэлгээг хоёр шатны Ерөнхий шүүгч хийж байгаа тул хариуцлагатай ханддагаараа онцлог юм. Үнэлгээний тодорхойлолтыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид хүргүүлж, дараа нь Хууль зүйн сайдад танилцуулна. Сайд шүүгчээр томилох хүний саналыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид хүргүүлнэ. Харин Шүүгчдийн зөвлөл хуралдаж саналыг хүлээн авахгүй бол өөр хүнийг санал болгож болно. Түүнчлэн Хууль зүйн сайд тухайн шүүгчийн хүлээн авахгүй байх тохиолдол гарч болно.

¹¹⁸ Пим Алберс, “Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагаанд өгөх үнэлгээ”, 2013 он

¹¹⁹ Д.Ариунцэцэг, “Шүүхийн алдаа юу, шүүгчийн алдаа юу? /Шүүгчийн алдааны тухай эргэцүүлэхүй/”, Монголын төр, эрх зүй, 2013 №2(72), 20-21 дэх тал

¹²⁰ Otto Mallmann, “Experience in Germany in evaluating quality of justice and of judicial decisions” (Lecture given at Tartu, Estonia on 18 June 2008 at the international conference on “Quality of judicial decisions and evaluation thereof” held by the Supreme Court of Estonia in co-operation with the Consultative Council of European Judges (CCJE)) http://www.riigikohus.ee/vfs/755/Mallmann_CCJE.pdf

Дээрх гадаад улс орны туршлагаас харахад шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааг үнэлэх үнэлгээний шалгуурт тухайн шүүгчийн мэдлэг, ур чадварыг үнэлэхээс гадна шүүгчийн ёс суртахууны байдал, шүүгчийн ажлын бүтээмж, шүүх үйл ажиллагааг удирдах чадвар, арга хэлбэр, шүүгчийн хандлага зэрэг нэмэлт үзүүлэлтүүдийг шүүгчийн мэргэшлийн гүйцэтгэлийг сайжруулах болон анхлан томилогдоод тодорхой хугацаа болсон, албан тушаал дэвших буюу Ерөнхий шүүгчид нэр дэвших боломжийг тодорхойлох зорилгоор хийдэг байна. Эдгээр улсын туршлагыг Монгол Улсад нэвтрүүлж, шүүгчид нэр дэвшсэн тохиолдолд тухайн нэр дэвшигчийн шүүгчийн мэргэшил, ур чадварт үнэлгээ хийх, дүгнэлт гаргах аргачлал, шалгуур үзүүлэлтийг “Шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаар дүгнэлт гаргах журам”, “Шүүгчийг сонгон шалгаруулах журам” эсхүл “Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшин тогтоох журам” зэрэг холбогдох эрх зүйн актад тусгаж болох юм. Энэ тохиолдолд Хорват, Румын болон ХБНГУ-ын үнэлгээ хийх дэлгэрэнгүй аргачлал, шалгуурын нийтлэг жишгийг нэвтрүүлж болно. Түүнчлэн шүүгчээр ажиллаж байгаа хүн тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгч, давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшсэн тохиолдолд сонгон шалгаруулалтыг Шүүхийн мэргэшлийн хороо эсхүл Шүүхийн ерөнхий зөвлөл мерит зарчмаар¹²¹ явуулж, тухайн шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт¹²² хийж болох юм.

Дөрөв. Шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах, огцруулах асуудал: монгол улсын болон гадаадын зарим улсын туршлага

4.1. Олон улсын эрх зүйн хүрээнд шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл, журам

Олон улсын эрх зүйн хүрээнд улс орнууд шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах, огцруулах үндэслэл, журмыг тодорхой болгох үүрэг хүлээдэг бөгөөд шүүгчийн гаргасан үйлдэл нь түүнийг огцруулах үндэслэл болох эсэхийг бие даасан, хараат бус бүрэлдэхүүн шударгаар зохион байгуулсан хуралдааны дагуу шийдвэрлэх ёстой байдаг. Тухайлбал, НҮБ-ын Үндсэн зарчмуудын 17-д “Шүүгчийн мэргэжлийн чадвар болон шүүхийн байгууллагын талаар гаргасан аливаа гомдол, хүсэлтийг холбогдох журамд нийцүүлэн хуулийн дагуу шударгаар шийдвэрлэнэ. Шүүгч нь шударгаар шүүгдэх эрхтэй. Хэргийг эхний шатанд шалгах ажиллагаа нь шүүгч өөрөө шаардаагүй бол нууц байх ёстой” гэж заасан байна. Түүнчлэн НҮБ-ын Үндсэн зарчмуудад шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах тухай саналыг давж заалдах боломжоор хангасан хууль тогтоомжийг батлахыг үүрэг болгосон байна. Тухайлбал, 20 дугаар зарчимд “Шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах, түр болон бүрмөсөн албан тушаалаас нь чөлөөлөх ажиллагаа хараат бус хяналтад байна” гэжээ.

Европын Холбооны Зөвлөлөөс шүүхийн хараат бус байдлын талаар гаргасан зөвлөмжид шүүгчийг огцруулах үндэслэлийг нарийвчлан зохицуулах талаар

¹²¹ Мерит сонгон шалгаруулалтын нэг бүрэлдэхүүн нь шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг үнэлэх ажиллагаа болно.

¹²² Дэлгэрэнгүйг О.Мөнхсайхан “Монгол Улс дахь шүүгчийн сонгон шалгаруулалт: Шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг сайжруулах нь”, Шүүх эрх мэдэл №4, Улаанбаатар, 2014 он, 16-40 дэх талаас үзнэ үү.

тодорхой удирдамжийг гаргасан. Үүнд, “томилогдсон шүүгчид тэтгэвэрт гарах хүртэлх хугацаанд албан тушаалаас нь хангалттай үндэслэлгүйгээр бүрмөсөн огцруулж болохгүй. Эдгээр үндэслэлийг хуулийн дагуу тодорхой томъёолсон байх шаардлагатай бөгөөд үүнд шүүгчийн чиг үүргийг хэрэгжүүлэх боломжгүй болсон, эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн болон ёс зүйн дүрмийг ноцтойгоор зөрчсөн тохиолдлууд орно” гэжээ.¹²³ Цаашилбал, Европын Холбооны Зөвлөлөөс шүүгчийг огцруулах ажиллагааны талаар тодорхой шалгуурыг тогтоосон. Тухайлбал, шүүхийн хяналтад байх тусгай байгууллагыг байгуулах болон шүүгчийг өөрийгөө өмгөөлөх бүхий л процессын баталгаагаар хангахыг зөвлөжээ. Үүнд, “сахилгын арга хэмжээ авах шаардлагатай тохиолдолд улс орнууд хуулиараа шүүхээс хянан хэлэлцэх боломжгүй тохиолдолд аливаа төрлийн сахилгын шийтгэл, арга хэмжээг авах эрх бүхий тусгай мэргэшсэн байгууллагыг байгуулах асуудлыг авч үзэх, мөн түүнчлэн энэ байгууллагын шийдвэрийг дээд шатны шүүхийн байгууллага хянаж, эсхүл дээд шатны шүүхийн байгууллага нь өөрөө ийм төрлийн байгууллагатай байхаар зохицуулах”¹²⁴-ыг зөвлөсөн байна.

Хуулиар шүүгчид Европын Хүний эрхийн конвенцод заасан бүхий л зайлшгүй ажиллагааны хамгаалалтыг эдлэх зүй зохистой процесс ажиллагааг зохицуулах шаардлагатай байдаг. Үүнд, “хэргийг тодорхой цаг хугацаанд хянан хэлэлцэж, шүүгчид тэдний эсрэг дэвшүүлсэн аливаа асуудалд хариу өгөх эрхийг эдэлнэ” гэжээ. Шүүгчийн талаарх Европын дүрмээр эдгээр асуудлыг зохицуулсан ба, нэн ялангуяа, энэ байгууллагын бүрэлдэхүүн нь процесс ажиллагаа, шүүгчийн процессын баталгааг хангах болон зүй бус үйлдэлтэй нь тухайн шийтгэл нийцсэн байх шаардлагатайг онцолсон. Энэ дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1-т “хуулиар заасан аль нэг чиг үүрэгтэй хайнга хандсан шүүгчийг хамгийн багадаа тал хувь нь шүүгчдээс бүрдсэн бүрэлдэхүүнтэй тусгай шүүх (*tribunal*) эсхүл эрх бүхий байгууллагын шийдвэр, санал, зөвлөмж болон бүрэлдэхүүний гишүүд санал нэгдсэн тохиолдолд л шийтгэл оногдуулж болох бөгөөд энэ ажиллагаа нь талуудыг хэргээ танилцуулах боломжоор хангаж, шүүгчдэд өөрсдийгөө төлөөлөх боломжоор хангасан байх тохиолдолд хэрэгжинэ”¹²⁵ гэдгийг онцолжээ.

Шийтгэлийг гаргасан гүйцэтгэх байгууллага, тусгай шүүх, эсхүл шийтгэлийг зарлаж буй эрх бүхий байгууллагын шийдвэрийг дээд шатны давж заалдах эрх бүхий байгууллагад давж заалдах эрх нь хэрэгжих ёстой. Африкийн орнуудад шударга шүүхийн талаарх удирдамжид зааснаар шүүгчийг ноцтой үйлдэл гаргасан эсхүл шүүгчийн чиг үүргийг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд л огцруулахаар заасан байна. Энэ удирдамжид “шүүгчид шүүгчийн албан тушаалд нийцэхгүй ноцтой зөрчил гаргах, шүүгчийг чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болгосон биеийн болон сэтгэл зүйн чадваргүй болсон тохиолдолд огцруулах эсхүл түр хугацаагаар албан тушаалаас нь түдгэлзүүлж болохоор”¹²⁶ заажээ. Мөн түүнчлэн Африкийн удирдамж нь шүүгчийг шийдвэрийг нь өөрчилснийх нь төлөө огцруулахыг хориглосон цорын ганц эрх зүйн баримт бичиг бөгөөд үүнд, “Шүүгчийг дээд шатны

¹²³ Recommendation No.R (94) 12, Principle VI.2.

¹²⁴ Recommendation No.R (94) 12, Principle VI.3.

¹²⁵ European Charter on the Statute for Judges, art 5.1.

¹²⁶ Principles and Guidelines on the Right to a Fair Trial and Legal Assistance in Africa, Principle A, paragraph 4 (p).

шүүхээс шийдвэрийг нь давж заалдах журмаар өөрчилснийх нь төлөө огцруулж эсхүл сахилгын шийтгэл ногдуулахыг хориглоно¹²⁷ гэжээ.

Олон улсын эрх зүйд шүүгчийг огцруулах үндэслэлд ноцтой зүй бус үйлдэл гаргах, сахилгын болон эрүүгийн гэмт хэрэг үйлдэх зэрэг нөхцөлүүд хамаардаг бөгөөд шүүгчдийг огцруулах асуудлыг шударга хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар авч хэлэлцэх ёстой байдаг. Шүүгчийн албаны болон хувийн хариуцлагын ойлголт нь шүүгчийн гаргасан алдаанаас үүсэх хууль зүйн үр дагавар болох иргэний болон эрүүгийн хариуцлагаас ялгаатай. Шүүгч Эрүүгийн хуульд заасан авилга авах, эрх мэдлээ урвуулан ашиглах, албаны шугамаар олж авсан нууц мэдээлэл задруулах зэрэг гэмт хэрэг үйлдсэн бол тус улсын иргэнийхээ хувьд эрүүгийн хариуцлага хүлээх бол шүүгчийнхээ хувьд албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүртэл хариуцлага хүлээдэг байна. Олон улсын шүүгчдийн холбооноос баталсан “Дэлхийн шүүгчийн түгээмэл дүрэм”-д шүүгчдийн иргэний болон эрүүгийн хариуцлагыг тодорхой заасан байна. Тус дүрмийн 10 дугаар зүйлд шүүгчийн бие даасан байдал нь нөлөөлөлд автахгүй нөхцөл дор шүүгчийг иргэний хэрэгт хариуцагчаар татаж болох боломжтой улсад иргэний хэргийн хариуцагчаар татаж, эрүүгийн хэргийн хариуцлага хүлээлгэж, түүнчлэн баривчилж болно гэсэн байдаг.¹²⁸

4.2. Монгол Улсын шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл, журам

Монгол Улсын шүүгчийн эрх зүйн байдлыг Шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хууль, Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм зэрэг баримт бичгүүд тодорхойлж байна. Шүүхийн захиргааны тухай хуульд зааснаар Шүүхийн мэргэшлийн хороо нь шүүгч, Ерөнхий шүүгчид нэр дэвшигчээс Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх талаар үнэлгээ өгөх,¹²⁹ Шүүхийн ёс зүйн хороо нь шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх¹³⁰ эрхтэй байна.

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар шүүгчийн бүрэн эрхтэй холбогдох дараах ойлголт байна. Үүнд:

1. Бүрэн эрхийг түдгэлзүүлэх;
2. Хугацаанаас нь өмнө чөлөөлөх;
3. Огцруулах.

Шүүгчийн сахилгатай холбогдох асуудлаар дээрх зохицуулалтыг хэрэглэх үндэслэлийг дурдвал:

Бүрэн эрхийг түдгэлзүүлэх нь:¹³¹

- хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн;
- шүүгчээс огцруулах тухай захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал гарсан.

Огцруулах нь:¹³²

- шүүгчийн албан тушаалтай хавсарч үл болох үйл ажиллагаа эрхэлсэн;

¹²⁷ Principle A, paragraph 4 (n) 2.

¹²⁸ Дэлхийн шүүгчийн түгээмэл дүрэм (The Universal Charter of the Judge), 1999

¹²⁹ Монгол Улсын Шүүхийн захиргааны тухай хууль, 23

¹³⁰ Монгол Улсын Шүүхийн захиргааны тухай хууль, 32

¹³¹ Монгол Улсын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, 17.1

¹³² Монгол Улсын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, 18.4

- сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээсэн;
- хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нь хүчингүй болгосон;
- албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж шүүгчийн хараат бус байдалд нөлөөлсөн, аливаа нэг этгээдийн талд шүүхийг үйлчлүүлсэн буюу үйлчлүүлэхээр дарамт үзүүлсэн Ерөнхий шүүгчийг огцруулах.¹³³

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар шүүгч зөвхөн хуульд захирагдах, шударга ёсны зарчим болон шүүгчийн ёс зүйг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн бол холбогдох сахилгын болон хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ. Шүүгч энэ хууль, шүүгчийн ёс зүйн дүрэм, шүүхийн байгууллага дахь хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хуулиар тогтоосон журмыг зөрчсөн бол түүнд дор дурдсан сахилгын арга хэмжээний аль нэгийг авна. Үүнд:

- сануулах;
- зургаан сар хүртэл хугацаагаар 30 хүртэл хувиар цалинг бууруулах;
- огцруулах.¹³⁴

Эдгээр зохицуулалтаас харахад Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль дахь шүүгчийн хариуцлагатай холбогдох заалтууд болон Шүүгчийн ёс зүйн дүрэм зөрчсөн тохиолдол нь сахилгын арга хэмжээ авах үндэслэл болно. Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийг нийт 4 удаа шинэчлэн баталсан бөгөөд 2014 оны дүрмийн 1.4 дүгээр зүйлийн 1-т “шүүгч хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг ёс зүйн зөрчил”-д тооцохоор заасан байна. Түүнчлэн хуучин 2010 оны Шүүгчийн ёс зүйн дүрэмд “шүүгчийн гаргасан зөрчил нь нийгмээс шүүх эрх мэдэл, шүүгчдэд итгэх итгэлийг бууруулах төдийгүй эрх зүйт төрийн нэр хүнд, хууль дээдлэх зарчимд хохирол учруулдаг учраас шүүгч бүр Үндсэн хууль, бусад хууль болон энэхүү дүрмийн хэм хэмжээнд захирагдах үүрэгтэй” гэж шүүгчийн ёс зүйн зөрчлийн нийгмийн хортой үр дагаврыг тодорхой заасныг шинэчилсэн дүрмээс хассан нь учир дутагдалтай болжээ. Хуульчийн гаргасан алдаа нь ёс зүйн зөрчил мөн эсэхийг зөв тодорхойлоход ёс зүйн дүрэмд ёс зүйн шаардлагыг зөв тодорхойлох нь онц ач холбогдолтой байдаг.¹³⁵

Шүүгчийн гаргасан зөрчил нь ёс зүйн зөрчил мөн эсэхийг ШЕЗ-ийн дэргэдэх Шүүхийн ёс зүйн хорооны гишүүд сахилгын хэрэг үүсгэн шалган тогтоох ба хэрэв ёс зүйн зөрчил мөн бол хариуцлага тооцно. Гэхдээ ёс зүйн зөрчил нь шүүх эрх мэдлийн нэр хүндэд хэрхэн, ямар хэмжээгээр нөлөөлсөн нь хариуцлага хүлээлгэх шалгуур болно. Тухайлбал, шүүх эрх мэдлийн нэр хүндэд ихээхэн хохирол учруулахааргүй ялимгүй зөрчилд “зөвлөх, анхааруулах” гэх мэт дахин тийм зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.¹³⁶ Практикт шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчих явдал гарсаар байна. Тухайлбал, Шүүхийн багц хууль мөрдөгдөж эхэлснээс хойш 2008 оноос 2015 оны эхний хагас жилийн байдлаар Шүүхийн Ёс зүйн сахилгын хороонд шүүгчийн ёс зүйн асуудлаар иргэд, байгууллага, хуулийн

¹³³ Монгол Улсын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, 18.5

¹³⁴ Монгол Улсын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, 37.1

¹³⁵ Л.Мөнхсайхан, Ж.Наранцацрал, М.Батсуурь, “Хуульчийн ёс зүй” гарын авлага, Хууль зүйн яам, “Хууль зүйн салбарыг сайжруулах төсөл”, 2013, Улаанбаатар, 77 дахь тал

¹³⁶ Мөн тэнд 79 дэх тал.

этгээдээс давж заалдах болон анхан шатны 690 шүүгчид холбогдох 938 гомдол, хүсэлт ирсэн байна. Шүүхийн ёс зүйн хорооноос 2013 онд иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс 165 гомдол, хүсэлтийг хүлээн авч, 7 шүүгчид буюу 4.2 хувьд нь сахилгын шийтгэл оногдуулж, 2014 онд 208 гомдол, хүсэлтийг хүлээн авч, 7 шүүгчид буюу 3.4 хувьд нь сахилгын шийтгэл ногдуулсан¹³⁷ бол 2015 оны эхний хагас жилийн байдлаар 95 гомдол, хүсэлтийг хүлээн авч 4 шүүгчид буюу 4.2 хувьд нь сахилгын шийтгэлийг тус тус оногдуулсан байна.

Шүүхийн ёс зүйн хороонд гаргасан шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдсон гомдол, хүсэлтийг авч үзэхэд сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоол нь нийт шийдвэрлэсэн сахилгын хэрэгтэй харьцуулахад 90 гаруй хувьтай байна. Энэ нь иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс шүүгчийн эсрэг гаргасан гомдол, хүсэлтийн дийлэнх хувь нь шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохгүй болох талаарх Шүүхийн ёс зүйн хорооноос шийдвэр гарсан байна. /График 1, 2/ Өөрөөр хэлбэл, эдгээр гомдлын дийлэнх хувь нь одоогийн үйлчилж буй Шүүгчийн ёс зүйн дүрмийн 5.1 дүгээр зүйлийн 6-д заасны дагуу Шүүхийн ёс зүйн хорооноос харьяалан шийдвэрлэх хэргийн төрөлд хамаарахгүй шүүгчийн “мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой” гомдлууд гарч байдаг.¹³⁸ Тухайлбал, шүүгч нь холбогдох хуулиудад заасан хугацааг баримтлахгүй байх,¹³⁹ хүний эрх, эрх чөлөөг хангаагүй байх¹⁴⁰ тохиолдол гаргах зэрэг мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил гаргасан тохиолдлууд байна.

График 1. Шүүгчид ногдуулсан сахилгын шийтгэлийн төрөл



¹³⁷ 2014 онд Шүүхийн ёс зүйн хорооноос нийт 7 шүүгчид сахилгын шийтгэл ногдуулсан 5 тогтоол, магадлалыг (1 шүүгчид шүүгчийн албан тушаалаас нь огцруулах, 3 шүүгчид цалин бууруулах, 3 шүүгчид сануулах) Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал, Улсын дээд шүүхийн тогтоолоор хэрэгсэхгүй болгосноор 2014 онд ёс зүйн зөрчил гаргаж, сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч байхгүй байна.

¹³⁸ Б.Уранцэцэг, “Шүүгчийн ёс зүйн хүрээ, хязгаар” илтгэл, “Шүүгчийн ёс зүй ба хариуцлага” сэдэвт хэлэлцүүлэг, 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр, Улаанбаатар <http://www.judcouncil.mn/main/2950--.html>

¹³⁹ Б.Сарантуяа, “Хэргийн хөдөлгөөний удирдлага ба шүүгчийн хариуцлага” илтгэл, “Шүүгчийн ёс зүй ба хариуцлага” сэдэвт хэлэлцүүлэг, 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр, Улаанбаатар <http://www.judcouncil.mn/main/2950--.html>

¹⁴⁰ Б.Уранцэцэг, “Шүүгчийн ёс зүйн хүрээ, хязгаар” илтгэл, “Шүүгчийн ёс зүй ба хариуцлага” сэдэвт хэлэлцүүлэг, 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр, Улаанбаатар <http://www.judcouncil.mn/main/2950--.html>

График 2. 2013 оноос 2015 оны эхний хагас жилийн байдлаар нийт хүлээж авсан гомдол болон шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан дүнг харьцуулсан нь



Шүүгчдэд сахилгын хариуцлага тооцох асуудал нь шүүхийн хараат бус зарчмыг хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай байдаг. “Дэлхийн шүүгчийн түгээмэл дүрэм”-ийн 11 дүгээр зүйлд, “Шүүхийн захиргаа болон шүүгчдийн сахилгын хэргийг шүүгчдийн жинхэнэ хараат байдлыг алдагдуулалгүйгээр зохион байгуулах ёстой бөгөөд эдгээрт бодит болон ач холбогдол бүхий асуудалд анхаарал хандуулан” гэжээ.¹⁴¹ Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шүүгчдийг огцруулах болон тэдэнд сахилгын шийтгэл ногдуулах асуудлын хүрээнд хараат бус байдлын баталгааг зохих түвшинд хангасан гэж үзэхээр байна. Шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах болон огцруулах асуудлыг шүүх эрх мэдэлд өөрт нь олгосон байна.

Шүүгчдэд хариуцлага тооцох хамгийн эцсийн, хатуу арга хэмжээ бол түүнийг огцруулах юм. 1995-2014 онд нийт 47 шүүгчийг ШЕЗ-ийн санал болгосноор Ерөнхийлөгчийн зарлигаар огцруулсан байна. Монгол Улсын Ерөнхийлөгч шүүгчдийн 29 буюу 61.7 хувийг “шүүгчээс огцруулах тухай шүүгчийн сахилгын хорооны шийдвэр хүчин төгөлдөр болсон” гэсэн үндэслэлээр, 8 буюу 17 хувийг “сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээсэн” гэсэн үндэслэлээр харин үлдсэн 10 буюу 21.3 хувийг “шүүгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон” гэсэн үндэслэлээр тус тус огцруулсан байна. Энэ статистик тоон дүнгээс харахад шүүгчдэд Ёс зүйн хорооны шийдвэрийг үндэслэн хариуцлага тооцож, Ерөнхийлөгчийн зарлигаар огцруулсан байна.

Шүүгчийн ёс зүйн хорооны чиг үүрэгтэй адил чиг үүрэг бүхий Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил, сахилга, ёс зүйн байдалд Хуульчдын холбооны хүсэлтээр дүгнэлт гаргах, хуульч Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хуульчийн мэргэжлийн дүрмийг зөрчсөн эсэх болон хуульчийн мэргэжил, ур чадварын түвшинд эргэлзсэн тухай маргааныг шүүгч, прокурор, өмгөөлөгчийн гомдлын дагуу хянан

¹⁴¹ Дэлхийн шүүгчийн түгээмэл дүрэм (The Universal Charter of the Judge), 1999

шийдвэрлэж, хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг. Мэргэжлийн хариуцлагын хороо нь 30 гишүүний бүрэлдэхүүн (шүүгч 18, прокурор, өмгөөлөгчдийн төлөөлөл тус бүр зургаа байна. Мэргэжлийн хариуцлагын хорооны шүүгч гишүүдийн 10 нь анхан шатны шүүхийн шүүгч, зургаа нь давж заалдах шатны шүүхийн шүүгч, хоёр нь хяналтын шатны шүүхийн шүүгч)-тэй байх бөгөөд гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна. Энэ хороонд 2014 онд нийт 191 гомдол, мэдээлэл ирснийг холбогдох субъектээр нь ангилан үзвэл: Шүүгчид холбогдох 37 маргааныг шалгаснаас 3 маргааныг шийдвэрлэж, ШЕЗ-д шүүгчийн албан тушаалаас огцруулах санал хүргүүлсэн байна.¹⁴² Ийнхүү шүүгчийн ёс зүйн болон мэргэжлийн хариуцлагын асуудлыг тусдаа, бие даасан байгууллагууд шийдвэрлэх нь эргээд давхардал, хийдэл үүсгэх, хэргийг хэрэгсэхгүй болгох тохиолдлыг нэмэгдүүлэх үр дагавартай байгааг олон судлаачид онцолж тэмдэглэсэн байдаг.¹⁴³ Иймд Монгол Улсад шүүгчид ёс зүйн хариуцлага тооцох нэг л байгууллага, эрх зүйн орчныг бий болгох шаардлага зүй ёсоор тулгарч байна. Дараагийн хэсэгт зарим улсад шүүгчид хариуцлага тооцох арга, механизмыг хэрхэн давхардуулалгүйгээр, нарийн процессын зохицуулалттайгаар бий болгосон талаар авч үзэх болно.

4.3. Гадаадын зарим улсын шүүгчийн хариуцлагын тогтолцоо

(1) Канад улсын шүүхийн зөвлөл: Шүүгчийн хариуцлага

Иргэд, олон нийтийн зүгээс шүүгчдийг мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг хүсдэг. Ингэхийн тулд шүүгчид бие даасан, хараат бус байдлаа хадгалсан, ямарваа нэгэн дарамт шахалтаас айж эмээлгүйгээр шүүхийн танхимд шийдвэрээ танилцуулах чадвартай байх шаардлагатай байдаг. Энэхүү үндсэн хуулийн үзэл баримтлал мөн Канадын шүүхийн тогтолцоонд байдаг¹⁴⁴ бөгөөд шударга шүүхийн асуудал бол шүүгчийн ёс зүйн стандарттай салшгүй холбоотой хэмээн Канадын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч Беверли Маклалин үзсэн байна.¹⁴⁵ Шүүгчийн үйлдэл нь мэргэжлийн болон ёс зүйн стандартад нийцэхгүй байгаа тохиолдолд албан тушаалаас нь огцруулах, эсхүл эрүүгийн хариуцлага хүлээлгэх зэрэг арга хэмжээ авч, шүүх үйлчлүүлэгчдийнхээ өмнө хариуцлага хүлээнэ.

Канад Улсад шүүгчид хариуцлага тооцох асуудлыг бүх шатны шүүхийн зөвлөлүүдээс хэрэгжүүлж байна. Канадын Шүүхийн Зөвлөл нь холбооны түвшинд томилогдсон 1100 гаруй холбооны шүүх болон орон нутгийн шүүхийн дээд шатны шүүхүүдийн шүүгчдийг хариуцаж ажилладаг.¹⁴⁶ Бусад доод шатны шүүхүүд болон орон нутгийн шүүхүүдийн шүүгчидтэй холбоотой гомдлыг тухайн харьяалах нутаг дэвсгэрийн шүүхийн зөвлөлөөр шийдвэрлэнэ. Канадын Шүүхийн Зөвлөлийг Шүүгчийн тухай хуулиар байгуулсан бөгөөд энэ байгууллагын эрхэм зорилго нь “үр

¹⁴² Энэ мэдээллийг судлаач Б.Өлзийсайхан боловсруулсан болно.

¹⁴³ О.Мөнхсайхан, “Монгол Улс дахь шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам”, “Шүүгчийн ёс зүй ба хариуцлага” сэдэвт хэлэлцүүлэг, 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр, Улаанбаатар <http://www.judcouncil.mn/main/2950-.html>; Г.Эрдэнэбат, “Шүүгчийн ёс зүй ба хариуцлага” сэдэвт хэлэлцүүлэгт хэлсэн үг, 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр, Улаанбаатар

¹⁴⁴ John Evans, “Adjudicative Independence: Canadian Perspectives” in *II – Independence and Accountability of Judges and Adjudicators*, p.114

¹⁴⁵ Canadian Judicial Council, *Annual Report*, April 1, 2013 – March 31, 2014, p.4

¹⁴⁶ Canadian Judicial Council’s website, “About the Council” <https://www.cjc-ccm.ca/english>

ашигтай, нэгдмэл байдал болон хариуцлагыг сайжруулах, Канадын дээд шатны шүүхийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх” явдал юм.¹⁴⁷ Зөвлөл нь бусад 38 гишүүдээс бүрддэг бөгөөд үүнд Канадын дээд шатны шүүхийн Ерөнхий шүүгчид болон дэд Ерөнхий шүүгчид, холбооны болон орон нутгийн шүүхийн зарим ахлах шүүгчид багтдаг.¹⁴⁸

Канадын Шүүхийн Зөвлөл нь иргэд, олон нийт болон Ерөнхий Прокуророос ирүүлсэн шүүхийн шийдвэртэй холбоотой бус гагцхүү шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг мөрдөн шалгах эрх мэдэлтэй байна.¹⁴⁹ Зөвлөлөөс гомдлыг авч хэлэлцэхдээ тухайн шүүгчээс гомдолтой холбоотой тайлбар авч, гомдлыг нэг бүрчлэн авч хэлэлцэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлдэг. Гомдлыг хүлээн авсны дараагаар Канадын Шүүхийн Зөвлөлийн Шүүхийн ёс зүйн хорооны (*Judicial Conduct Committee*) гишүүн нь гомдол тус бүрийг хянаж үздэг. Практикт Канадын Шүүхийн Зөвлөлийн ихэнх гомдлыг хэрэгсэхгүй болгодог, учир нь эдгээр нь шүүгчийн ёс зүйтэй холбоотой бус харин шүүгчийн шийдвэртэй холбоотой эсхүл харьяаллын бус шүүгчтэй холбоотой гомдол байдаг байна.¹⁵⁰ Хэрэв гомдлыг энэ байдлаар нэн даруй шийдвэрлээгүй бол гомдлыг нэмэлт мөрдөн шалгалтад явуулдаг. Мөрдөн шалгалтын тайланг 3 эсхүл 5 шүүгчээс бүрдсэн Хяналтын Бүрэлдэхүүн (*Review Panel*) -ээр авч хэлэлцдэг. Энэ нь шүүгчтэй холбоотой гомдлыг шийдвэрлэх ажиллагааны хоёрдугаар үе шат гэж ойлгож болно.

Хяналтын Бүрэлдэхүүнээс гомдлыг үндэслэлгүй гэж үзвэл хэргийг хэрэгсэхгүй болгоно. Хэрэв Хяналтын Бүрэлдэхүүнээс гомдлыг үндэслэлтэй боловч огцруулах хүртэлх ноцтой үндэслэл болохгүй гэж үзвэл гомдлыг хэрэгсэхгүй болгож, анхааруулах эсхүл шүүгчийн зөвшөөрснөөр сэтгэл судлаачтай уулзалт товлохыг зөвлөнө.¹⁵¹ Энэ хүртэлх үе шатыг олон нийтэд ил болгохгүй. Өөрөөр хэлбэл, шүүгчтэй холбоотой гомдол нь ноцтой үр дагаварт хүргэх хэмжээнд хүрээгүй бол энэ үйл ажиллагааг хаалттай явуулна. Хэрэв Хяналтын Бүрэлдэхүүнээс шүүгчийг албан тушаалаас нь огцруулах хангалттай ноцтой үндэслэл байна гэж үзвэл уг гомдлыг Канадын Шүүхийн Зөвлөлийн Мөрдөн шалгах хороонд (*Inquiry Committee*) илгээдэг. Тус Хорооноос хэргийг олон нийтийн дунд хэлэлцүүлэг (*public hearing*) явуулж, Канадын Шүүхийн Зөвлөлийн нийт гишүүдэд тайлан бэлтгэж өгдөг. Энэ нь шүүгчийн гомдлыг хянан хэлэлцэх ажиллагааны гуравдугаар үе шат болох бөгөөд олон нийтэд нээлттэй явагддаг байна. Хэрэв Зөвлөл нь тайлангийн үндсэн дээр шүүгчийн үйлдэл нь Үндсэн хуулийн 99 дүгээр зүйлд заасны дагуу зохисгүй үйлдэл болсон гэж үзвэл Хууль зүйн сайдад шүүгчийг албан тушаалаас нь огцруулах тухай шийдвэрийг Парламентад танилцуулахыг санал болгож болдог. Парламент нь шүүгчийг огцруулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Мөрдөн шалгах хороонд цөөн тооны гомдол ирдэг бөгөөд ихэнх гомдолд албан ёсны мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэлгүйгээр Ёс зүйн хорооноос хэрэгсэхгүй болгодог байна. Тухайлбал, 2013-2014 онуудад Зөвлөл нь ойролцоогоор 201 гомдлыг хүлээн авч, 138 гомдлыг янз бүрийн үе шатанд хянаж,

¹⁴⁷ Judges Act, R.S.C. 1985, Part II Canadian Judicial Council, s. 60(1).

¹⁴⁸ Canadian Judicial Council's website, "About the Council" <https://www.cjc-ccm.ca/english>

¹⁴⁹ Мөн тэнд

¹⁵⁰ John Evans, "Adjudicative Independence: Canadian Perspectives" in *II – Independence and Accountability of Judges and Adjudicators*, p.117

¹⁵¹ Мөн тэнд

шийдвэрлэсэн.¹⁵² Канадын Шүүхийн Зөвлөл байгуулагдсанаас хойш 8 гомдлыг Мөрдөн шалгах хороонд авч үзсэн байна.¹⁵³

Дээрхээс харахад Канад Улсад шүүгчийн ёс зүйн гомдол шийдвэрлэх ажиллагаа нь гурван үе шаттай, нарийн дэг журамтай явагддаг байна. Түүнчлэн шүүгчийн ёс зүйн зөрчил нь түүний мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой байна. Нэгээс хоёрдугаар үе шат хүртэл шүүгчийн ёс зүйн гомдол шийдвэрлэх ажиллагаа нь олон нийтэд хаалттай явагдах бол огцруулах тухай асуудлыг олон нийтийн дунд явуулж, хэлэлцүүлдэг байна. Ингэснээр шүүгчийг огцруулах эсэх асуудал олон нийтэд ил болдог бөгөөд энэхүү гуравдугаар үе шатаас шүүгчийг огцруулах нь үндэслэлтэй гэж үзвэл Хууль зүйн сайд болон түүнээс Парламентад танилцуулж, шийдвэрлүүлдэг байна. Монгол Улсад энэ байдлаар шүүгчийн гомдол шийдвэрлэх ажиллагааг гурван үе шаттайгаар, нарийн дэг журам, бүрэлдэхүүнээр шийдвэрлүүлэх практикийг үндэсний эрх зүйн тогтолцоонд нийцэх байдлаар нэвтрүүлж, Шүүхийн ёс зүйн хорооны үйл ажиллагааг шинэчлэх боломжтой байна.

(2) Япон Улсын шүүгчийн хариуцлага, ёс зүй

Япон Улсад Үндсэн хуулиар тогтоосон тодорхой процессын дагуу шүүгчийг огцруулахаас бусад тохиолдолд түүний хүсэл сонирхлоос гадуур шилжүүлэх, түдгэлзүүлэх, цалин хөлсийг нь бууруулж болохгүй.¹⁵⁴ Тус улсын Шүүхийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд шүүгчийн ёс зүйн талаар шүүгч албан үүргээ зөрчих эсхүл албан үүрэгтээ хайнга хандах, нэр хүндээ гутаах үйлдэл хийсэн тохиолдолд шүүхээс шийтгэл хүлээлгэх ба тус хуульд шийтгэлийн төрөл, процедурыг заасан байдаг.¹⁵⁵ Үүнд “албан үүрэгтээ хайнга хандах” гэдэгт хуулийг хэрэглэх буюу сахиулах тал дээр ноцтой алдаа гаргах, хууль бус шийдвэр гаргах, шүүх хуралдааныг хойшлуулах, хадгалах ёстой тэмдэглэлийг алга болгох, нууцыг задруулах зэрэг нөхцөл хамаарах бөгөөд хянах эрх бүхий байгууллагын шийдвэрийг биелүүлэхгүй байх, хяналт тавих үүрэг бүхий этгээдийг хянах үүргээ биелүүлэхгүй байх зэрэг нөхцөл мөн адил хамаарна.¹⁵⁶ Монгол Улсаас ялгаатай нь шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор гаргасан мэргэжлийн алдааг ёс зүй зөрчил гэж тооцох бөгөөд үүнд шүүх хуралдаан хойшлуулах, хууль бус шийдвэр гаргах, шүүх хуралдааны тэмдэглэлийг үрэгдүүлэх зэрэг нөхцөлийг шүүгчийн ёс зүйн зөрчилд тооцсон байна.

Шүүгчийн шийтгэлийн тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан шийтгэлийн төрөл нь “сануулах буюу 10,000 хүртэл иенээр торгох” гэж заасан байна. Ердийн төрийн албан хаагчаас ялгаатай нь зүйл нь шүүгчийг ажлаас чөлөөлөх, цалин бууруулах шийтгэл байхгүй. Мөн сэтгэл санаа болон биеийн байдлаас шалтгаалан шүүгч өөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрвэл шүүгчийг ажлаас нь чөлөөлж болдог.¹⁵⁷

¹⁵² Canadian Judicial Council, *Annual Report*, April 1, 2013 - March 31, 2014, p.9-10

¹⁵³ John Evans, “Adjudicative Independence: Canadian Perspectives”, p.118

¹⁵⁴ Япон Улсын Шүүхийн тухай хуулийн 48 дугаар зүйл

¹⁵⁵ 第四十九条裁判官は、職務上の義務に違反し、若しくは職務を怠り、又は品位を辱める行状があつたときは、別に法律で定めるところにより裁判によつて懲戒される。Article 49: If a judge has violated his/her official duties, neglected his/her jobs or degraded himself/herself, that judge shall be subjected to disciplinary action by judicial decisions as provided for by applicable law.

¹⁵⁶ Моригива Ясүтомо, “Хуульчийн ёс зүй”, 2007, Улаанбаатар, 338-343 дахь тал

¹⁵⁷ Япон Улсын Шүүхийн тухай хуулийн 48 дугаар зүйл

Япон Улсад Импичментийн шүүхийг Үндсэн хуулийн дагуу байгуулж, шүүгчийг албан тушаалаас нь огцруулах эсэх талаар хянан хэлэлцэж, шийдвэрлэдэг онцлогтой юм. Япон Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлд импичментийн тухай тодорхой заасан ба тус зүйлийн 1-д Парламент нь шүүгчийг огцруулах эсэх талаарх гомдлыг хэлэлцэж шийдвэрлүүлэхээр Парламентын дээд болон доод танхимын төлөөлөгчдөөс бүрдсэн Импичментийн шүүхийг байгуулна гэжээ.¹⁵⁸ Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлд Импичментийн шүүхийн шийдвэрээр албан тушаалаасаа огцорсон хүн шүүгчээр сонгогдох эрхгүй байдаг.¹⁵⁹

Импичментийн тухай хуулиар шүүгчийн огцруулах ерөнхий 2 үндэслэлийг тогтоосон. Шүүгчийн импичментийн тухай хууль¹⁶⁰-ийн дараах зөрчлийг гаргасан шүүгчийг огцруулж болдог. Үүнд, тус хуулийн 2.1.1-т “мэргэжлийн болон албан үүргээ ноцтой зөрчсөн эсхүл албан үүрэгтээ ноцтой байдлаар хайнга хандсан”, 2.1.2-т “шүүгч нь албаны болон хувийн орчинд өөрийн нэр төрөө алдах ноцтой үйлдэл гаргасан тохиолдолд шүүгчийг огцруулна” гэжээ. Тухайн шүүгчийн үйлдэл нь ноцтой хэмжээнд хүрсэн тохиолдолд дээрх хуулийн дагуу шүүгчийг огцруулах, харин огцруулах хэмжээнд хүрэхээр зөрчил биш гэж үзвэл Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуулиар сахилгын шийтгэл ногдуулж байна. Гомдлын хороо нь Импичментийн шүүхэд шүүгчийг огцруулах өргөдөл гаргах эрх бүхий төрийн байгууллага юм.¹⁶¹ Импичментийн шүүх нь Гомдлын хорооноос ирүүлсэн хэргийг хянан шийдвэрлэн, шүүгчийг огцруулах эсэхийг шийдвэрлэнэ.

1948-2014 онд Гомдлын хорооны хуралдаанаар шүүгчийг огцруулах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан хэргийг авч үзвэл, Импичментийн хуулийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу “Мэргэжлийн болон албан үүргээ ноцтой зөрчсөн эсхүл албан үүрэгтээ ноцтойгоор хайнга хандсан” үндэслэлээр 94.5 хувийг шийдвэрлэсэн бөгөөд үүнээс 49.2 хувь нь “илт хууль бус шийдвэр гаргасан” гэсэн үндэслэлээр, 14.8 хувь нь “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зөрчсөн”, 9.2 хувь нь “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зүй бусаар явуулсан”, 2.0 хувь нь “хурлын протоколд худал зүйл бичсэн”, 2.3 хувь нь “үндэслэлгүйгээр хэрэг хойшлуулсан”, 0.2 хувь нь “шийдвэр гардуулалтыг зүй бусаар хойшлуулсан”, 3.5 хувь нь “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохих хяналт тавиагүй”, 0.5 хувь нь “шүүх хуралдааны бичлэгийг зохих ёсоор хадгалаагүй”, 0.3 хувь нь “эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг зүй бусаар явуулсан”, харин үлдсэн 9.6 хувь нь дээрхээс бусад үндэслэлээр огцруулах талаар дүгнэлт гаргасан байна. Эдгээрээс харахад шүүгчийг огцруулах үндэслэлд шүүгчийн мэргэжлийн ёс зүйн алдаа болох илт хууль бус шийдвэр гаргах, шийдвэр гардуулалтыг зохих хугацаанд хийгээгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохих

<http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?re=02&ky=%E8%91%97%E4%BD%9C%E6%A8%A9&page=1>

¹⁵⁸第六十四条 国会は、罷免の訴追を受けた裁判官を裁判するため、両議院の議員で組織する弾劾裁判所を設ける。Article 64. The Diet shall set up an impeachment court from among the members of both Houses for the purpose of trying those judges against whom removal proceedings have been instituted. 弾劾に関する事項は、法律でこれを定める。Matters relating to impeachment shall be provided by law.

¹⁵⁹ <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?ft=1&re=02&dn=1&x=0&y=0&co=01&ia=03&ky=constitution&page=20>

¹⁶⁰ Япон Улсын Шүүгчийн импичментийн тухай хууль 裁判官弾劾法

<http://law.e-gov.go.jp/htmldata/S22/S22HO137.html>

¹⁶¹ Япон Улсын Гомдлын хорооны цахим хуудас: <http://www.sotsui.go.jp/>

ёсоор явуулаагүй, үндэслэлгүйгээр хэрэг хойшлуулсан зэрэг шүүгчийн мэргэжлийн болон албан үүргээ ноцтойгоор зөрчсөн тохиолдлууд оржээ.

(3) ОХУ-ын шүүгчийн хариуцлага

ОХУ-ын “Шүүхийн шинэтгэлийн үзэл баримтлал” гэх бодлогын баримт бичгийг 1992 онд тус улсын парламент /Төрийн Дум/-аас баталсан. Энэ баримт бичигт шүүхийн шинэтгэлийн талаарх Засгийн газрын төлөвлөгөөг тодорхойлсон бөгөөд шүүгчийн хараат бус байдлын баталгааг бэхжүүлэх болон шүүгчийн хариуцлагын асуудлыг зөвхөн хуулиар зохицуулахад чиглэсэн.¹⁶² Шүүхийн шинэтгэлийн үзэл баримтлалын дагуу 1992.06.26-ны өдөр “ОХУ-ын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай” хууль батлагдсан.¹⁶³ Тус хуулиар шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх боломж,¹⁶⁴ шүүгчийг огцруулах үндэслэлийг хуульчилсан.¹⁶⁵Тодруулбал, “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 13 дугаар зүйлд шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, шүүгчийг огцруулах асуудлыг зохицуулсан. Тус зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүхийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг үрэгдүүлсэн буюу алга болгосон нь тогтоогдсон бол шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, шүүгчийг огцруулах талаар Шүүгчдийн мэргэшлийн зөвлөлөөс шийдвэр гаргана.¹⁶⁶ Өөрөөр хэлбэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эцсийн бүтээгдэхүүн болсон шүүхийн шийдвэрийг үрэгдүүлсэн тохиолдолд шүүгчийг огцруулах хүртэл сахилгын арга хэмжээ авдаг байна.

ОХУ болон Монгол Улсын хувьд аль аль нь “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай” хуультай байна. Гэхдээ Монгол Улсын хувьд 2012 оноос ийм тусгайлсан хуультай болсон бол ОХУ-ын хувьд 1992 оноос эхлэн хуультай болж, 1993, 1995, 1999, 2000, 2001, 2004, 2005 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулжээ.Монгол Улсад шүүгчийн бүрэн эрхийг Ерөнхийлөгч түдгэлзүүлэх бол, ОХУ-д Шүүгчдийн мэргэшлийн зөвлөлөөс энэ чиг үүргийг дангаар хэрэгжүүлнэ.Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх үндэслэлийн хувьд ОХУ-ын дараах зохицуулалт Монгол Улсын хуульд тусгагдаагүй байна. Үүнд,хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг тодорхойгүй шалтгаанаар алга болгосон буюу үрэгдүүлснээ хүлээн зөвшөөрсөн үндэслэл орох юм.

Шүүгчийн ёс зүйн зөрчилд хариуцлага хүлээлгэх асуудлыг “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 12.1 дүгээр зүйлд тусгасан. Энд зааснаар Шүүгчийн ёс зүйн дүрмийг бүх Оросын шүүгчдийн чуулганаас баталдаг.¹⁶⁷ Ёс зүйн зөрчил гаргасан шүүгчид дараах хариуцлага хүлээлгэнэ. Үүнд:

¹⁶² Верховный Суд Российской Федерации. 1990 – начало 2010-х гг.Верховный Суд Российской Федерации <http://www.supcourt.ru>

¹⁶³ Закон РФ от 26 июня 1992 г. N 3132-1 “О статусе судей в Российской Федерации” (с изменениями и дополнениями) <http://base.garant.ru/10103670>

¹⁶⁴ ОХУ-ын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13-р зүйлийн 1 дэх хэсэг.

¹⁶⁵ ОХУ-ын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 14-р зүйлийн 1 дэх хэсэг, 15-р зүйлийн 1 дэх хэсэг.

¹⁶⁶ ОХУ-ын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13-р зүйлд 2009.11.09-ний өдрийн “N 246-ФЗ” дугаартай Холбооны хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд Холбооны хуулийн албан ёсны хэвлэлд нийтлэгдсэнээс хойш 120 өдрийн дараа хүчин төгөлдөр болсон. Федеральный закон от 9 ноября 2009 г. N 246-ФЗ “О внесении изменений в отдельные законодательные акты Российской Федерации в связи с совершенствованием законодательства о дисциплинарной ответственности судей” Принят Государственной Думой 23 октября 2009 года, Одобрен Советом Федерации 30 октября 2009 года http://base.garant.ru/196562/#block_6

¹⁶⁷Шүүгчийн ёс зүйн дүрмийг Бүх Оросын шүүгчдийн чуулганаас 2012.12.19-нд баталсан.

- мэдэгдэх;
- сануулах;
- огцруулах.¹⁶⁸

Мэдэгдэх хариуцлагыг тухайн шүүгчид сахилгын зөрчил гаргасан гэж үзэж бусад хариуцлага хүлээлгэх шаардлагагүй ч мэдэгдэх шаардлагатай гэж Шүүгчдийн мэргэшлийн зөвлөл шийдвэрлэсэн тохиолдолд хүлээлгэнэ. Харин сануулах хариуцлагыг сахилгын зөрчил гаргасан шүүгчид мэдэгдэх хариуцлага хүлээлгэх боломжгүй буюу мэдэгдэх хариуцлагыг өмнө нь хүлээлгэсэн тохиолдолд Шүүгчдийн мэргэшлийн зөвлөлөөс энэ шийдвэрийг гаргана. Шүүгчийг огцруулах хариуцлагыг Шүүгчийн ёс зүйн дүрэм болон хуульд заасан зөрчлийг гаргасан шүүгчид хүлээлгэнэ. Ийм зөрчилд шүүн таслах ажиллагааны зарчмыг гажуудуулсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь оролцогчдын эрхийг зөрчсөн, шүүгч шүүн таслах ажиллагааг үргэлжлүүлж чадахгүй болсон буюу тухайн хэргийг хуульд заасан зохих хугацаанд шийдвэрлэж чадаагүй зөрчил хамаарна. Өөрөөр хэлбэл, хэргийн хөдөлгөөний удирдлагыг бүрэн хэрэгжүүлж чадаагүй буюу хуульд заасан хугацаанд хэргийг шийдвэрлэж чадаагүй гэсэн асуудал шүүгчийг огцруулах үндэслэл болдог байна.

“ОХУ-ын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 12.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар шүүгч ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд түүнд зөрчил гаргасныг илрүүлснээс хойш 6 сарын дотор, зөрчил үйлдсэнээс хойш 2 сарын дотор сахилгын хариуцлага хүлээлгэнэ. Энэ хугацаанд ээлжийн амралттай буюу чөлөөтэй байх хугацааг оруулахгүй. “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 12.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх Шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг ОХУ-ын Дээд шүүхийн Сахилгын танхимд давж заалдаж болно. Тус хуулийн 12.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт зааснаар шүүгч ёс зүйн зөрчил гаргаснаас хойш 1 жилийн дотор дахин сахилгын хариуцлага хүлээгээгүй бол түүнийг ёс зүйн зөрчилгүйд тооцно. Дашрамд дурдахад, шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэх асуудлаарх Шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийн хуралдаан нь төрийн болон хувийн нууцыг хамгаалах, хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд нээлттэй явагддаг байна.¹⁶⁹

Шүүгчдийн мэргэшлийн зөвлөл нь орон нутгийн болон бүсийн 13 шүүгч, олон нийтийн 7 төлөөлөгч болон ОХУ-ын Ерөнхийлөгчийн нэг төлөөлөгч буюу төрийн албан хаагчаас бүрдэнэ. Шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийн гишүүн бүр 4 жилээр сонгогдоно. Шүүгч-гишүүд нь шүүгчдийн зөвлөгөөний нууц санал хураалтаар сонгогдох бол олон нийтийн төлөөлөгчид бүс нутгийн хуулийн дагуу бүс нутгийн хууль тогтоогчоос томилогддог.¹⁷⁰ Ийнхүү ОХУ-д шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны алдааг ёс зүйн зөрчилд тооцож, нэг байгууллага буюу Шүүгчдийн мэргэшлийн зөвлөл нь шүүгчид ёс зүйн хариуцлага тооцох асуудлыг шийдвэрлэж, нэг удаа уг асуудлыг Дээд шүүхийн Сахилгын танхимд давж заалдах боломжтой байна.

<http://www.supcourt.ru/catalog.php?c1=English&c2=The%20Judicial%20System%20of%20the%20Russian%20Federation&c3=&id=9625>

¹⁶⁸ Law on the Status of Judges in the Russian Federation http://www.supcourt.ru/print_page.php?id=9624

¹⁶⁹ Securing justice: The disciplinary system for judges in the Russian Federation. Report of an ICJ mission. 2012 <http://www.refworld.org/pdfid/530efd114.pdf>

¹⁷⁰ ОХУ-ын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11-р зүйл

(4) Эстони Улсын шүүгчийн хариуцлага

Эстони Улсад шүүгчид сахилгын шийтгэл ногдуулахад Шүүхийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн сахилгын зөрчилд шийтгэл ногдуулах бөгөөд сахилгын зөрчил гэдэг нь шүүгчийн буруутай үйлдлийг хэлэх бөгөөд үүнд өөрийн албаны үүргийг биелүүлээгүй эсхүл хангалтгүй биелүүлсэн зэрэг үндэслэлүүд орно. Түүнчлэн шүүгчийн зүй бус үйлдэл нь сахилгын зөрчилд тооцогдоно.¹⁷¹ Сахилгын шийтгэл нь дараах төрлүүдтэй. Үүнд:

- сануулах;
- 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулах;
- цалингийн хэмжээг бууруулах;
- огцруулах.

Хуульд шүүгчийн сахилгын зөрчлийн тухай гомдол гаргах асуудлаар тодорхой журмыг заагаагүй. Шүүгчдийн эсрэг аливаа гомдлыг шүүгчдийн сахилгын хэрэг үүсгэх эрх бүхий байгууллагад гаргах боломжтой юм. Гомдлыг хэн гаргаж болох талаар хязгаарлалт байхгүй, түүнчлэн гомдлын талаар тоон мэдээлэл дутмаг байдаг.¹⁷² Гэвч шүүхийн дотоод журамд гомдол гаргах талаар зохицуулсан байдаг. Тухайлбал, шүүгчийн эсрэг гомдлыг шүүхийн даргад гаргах бөгөөд тэрээр шаардлагатай тохиолдолд сахилгын хэрэг үүсгэнэ.¹⁷³

Шүүгчид холбогдох сахилгын хэргийг хэлэлцэхэд Сахилгын Хорооны дарга нь Сахилгын хорооны гишүүдээс 5 гишүүнтэй бүрэлдэхүүнийг байгуулах бөгөөд үүнд Дээд шүүхийн 3 шүүгч, анхан болон давж заалдах шатны шүүгчдээс тус бүр 1 шүүгчийг оролцуулна. Сахилгын хорооны 5 гишүүдээс бүрдсэн бүрэлдэхүүн сахилгын хэрэг, маргааныг шүүхийн журмаар хянан хэлэлцэнэ. Шүүгчийг түр хугацаагаар чөлөөлсөн эсхүл түүний цалинг бууруулсан тохиолдолд энэ тухай шийдвэрийг мэдсэнээс хойш 10 хоногийн дотор Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд давж заалдах гомдлыг гаргаж болно. Хэрэв шүүгч буруутай гэдэг нь тогтоогдвол Сахилгын хорооноос шүүгчийг сахилгын зөрчил үйлдсэн буруутайд тооцож, сахилгын шийтгэл оногдуулна. Хэрэв шүүгч нь сахилгын зөрчлийг гаргаагүй бол Сахилгын хорооноос түүнийг цагаатгасан тогтоол гаргана. Сахилгын шийтгэл оногдуулсан шүүгч шийдвэрийг уншиж сонсгосноос хойш 30 хоногийн дотор Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд давж заалдах гомдол гаргаж болно.¹⁷⁴

Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс Сахилгын хорооны шийдвэртэй холбоотой дараах шийдвэрийг гаргаж болно. Үүнд:

1. Шүүгчийг илүү хөнгөн сахилгын зөрчил гаргасан гэж үзэж, сахилгын шийтгэлийг хөнгөрүүлнэ;
2. Хэрэв шүүгч Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд давж заалдах гомдлыг гаргаагүй бол Сахилгын хорооны шийдвэр нь тодорхой хугацааны дараа

¹⁷¹ Эстони Улсын Шүүхийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 2

¹⁷² Timo Ligi, "Judicial Independence in Estonia", p.771.

¹⁷³ Анхан шатны шүүгчдийн талаарх гомдлыг давж заалдах шатны шүүх болон шүүхийн даргад нь гаргаж болох бөгөөд бүх шүүгчдийн эсрэг гомдлыг Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гаргаж болно. Сахилгын зөрчил шийдвэрлэх ажиллагааг сахилгын шийтгэлийг төлөвлөснөөр эхлүүлнэ. Дараах этгээдүүд сахилгын ажиллагааг эхлүүлэх эрх эдэлнэ. Үүнд: 1) Бүх шүүгчдийн эсрэг Дээд шүүхийн Ерөнхий шүүгч; 2) Бүх шүүгчдийн эсрэг Хуулийн дээд түшмэл; 3) анхан шатны шүүгчийн эсрэг давж заалдах шатны шүүхийн дарга 4) шүүхийн дарга нь тухайн шүүхийн бүх шүүгчдийн эсрэг; 5) Дээд шүүхийн зөвлөгөөнөөс Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн эсрэг. /Эстони Улсын Шүүхийн тухай хууль/

¹⁷⁴ Эстони Улсын Шүүхийн тухай хуулийн 97 дугаар зүйл

хүчин төгөлдөр болно.

Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс Сахилгын хорооны шийдвэрийг давж заалдсан гомдолтой холбогдуулан гаргасан шийдвэр нь уншиж, сонсгосноор хүчин төгөлдөр болно. Эрүүгийн хэрэгт холбогдсон нь тогтоогдсон эсхүл Сахилгын хорооноос шүүгчийг огцруулах тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон бол энэ шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш шүүгчийг огцруулсанд тооцно. Ийнхүү Эстони улсад шүүгчийн сахилгын зөрчилтэй холбоотой гомдлыг тухайн шүүхийн дарга нь авч үзэж, шаардлагатай бол Сахилгын Хороог байгуулан шийдвэрлүүлж, уг шийдвэрийг шүүгч нь нэг удаа Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд гаргаж болдог байна.

(5) Молдав Улсын шүүгчийн хариуцлага

Молдав Улсад шүүгчид хариуцлага тооцох асуудлыг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Сахилгын хороо болон Шүүгчийн хариуцлагын тухай хууль болон Шүүхийн дээд зөвлөлийн тухай хууль зэрэг хуулиудаар зохицуулж байгаа бөгөөд 2007 оноос хойш Хэргийн хөдөлгөөний нэгдсэн удирдлагын системийг хэрэгжүүлж байна. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой ёс зүйн зөрчилд хариуцлага тооцох хэд хэдэн үндэслэлийг заасан байна. Тухайлбал, мөн хуульд шүүгч нь “шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд хууль тогтоомжид заасан шаардлагыг нарийн баримтлан биелүүлж, хуулийг нэг мөр тайлбарлан, хэрэглэх”¹⁷⁵ үүрэгтэй гэсэн бол тус хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “е”-д Шүүгчийн ёс зүйн дүрмийг баримтлах үүрэг хүлээнэ гэжээ. Эдгээр үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Шүүхийн дээд зөвлөлөөс шүүгчийг “санаатайгаар эсхүл ноцтой байдлаар хайхрамжгүй хандсаны улмаас хуулийг нэг мөр хэрэглээгүй бөгөөд үүнийг нь дээд шатны шүүх тогтоож, илт буруу шийдвэрийг хүчингүй болгосон бол”,¹⁷⁶ “хэргийг зохих хугацаанд шийдвэрлээгүй эсхүл заавал дагаж мөрдөх хуулийн хэм хэмжээг зөрчсөн”,¹⁷⁷ “шүүхийн шийдвэрийн хувийг хэргийн оролцогчид гардуулах хугацааг зөрчсөн”¹⁷⁸ зэрэг үндэслэлээр сахилгын зөрчил гаргасанд тооцож, сахилгын шийтгэлийг хүлээлгэдэг байна.

Түүнчлэн хэрэв шүүгч нь шийдвэрээ гаргахдаа хуулийг санаатайгаар зөрчөөгүй бол шүүхийн шийдвэрийг давж заалдах журмаар хүчингүй болгосон, өөрчилсөн нь шүүгчид хариуцлага тооцох үндэслэл болохгүй.¹⁷⁹ Хэрэв шүүгч санаатайгаар хууль зөрчиж, шийдвэр гаргасан бол энэ нь сахилгын зөрчил болно. Үүний дээр хуулийг хайхрамжгүй байдлаар зөрчиж, шийдвэр гаргасан нь үлэмж хэмжээний материаллаг болон сэтгэл санааны хохирол учруулсан бол шүүгчид хариуцлага хүлээлгэдэг байна.¹⁸⁰ Молдав улсад шүүгчийн ёс зүйн зөрчилд хуулийг нэг мөр тайлбарлан хэрэглээгүй байх, илт буруу шийдвэр гаргасан байх, хуулийг санаатайгаар зөрчсөн нь тогтоогдсон зэрэг үндэслэлүүд орох бөгөөд Шүүгчийн дээд зөвлөлөөс шүүгчид хариуцлага тооцдог байна.

¹⁷⁵ Молдав Улсын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “с” (Law on the Status of Judge, no. 544-XIII from 20.07.1995)

¹⁷⁶ Молдав Улсын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “b”

¹⁷⁷ Молдав Улсын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “f1”

¹⁷⁸ Молдав Улсын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “h1”

¹⁷⁹ Молдав Улсын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

¹⁸⁰ Мөн тэнд

**Монгол улсын шүүхийн шүүгчийн хариуцлагын тогтолцоо, өнөөгийн байдлыг
боловсронгуй болгох нь: дүгнэлт, санал, зөвлөмж****Дүгнэлт**

Энэ бодлогын судалгаанд шүүгчийн хариуцлагын тогтолцоотой холбоотой асуудлыг шүүгчийн хариуцлагын хэмжүүрийг тодорхойлох, шүүгчийн ёс зүйн хариуцлага, шүүгчийн мэргэшлийн ур чадварын түвшинг үнэлж, дүгнэх асуудал болон шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах, огцруулах зэрэг дэд сэдвийн хүрээнд онол, практикийн хэмжээнд авч үзлээ. Иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангахад шүүхийн бие даасан, хараат бус байдал болон шүүгчийн хариуцлагатай байдлыг дээшлүүлэх шаардлагатай байдаг. Монгол Улс олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн шүүгчийг сонгох, томилох, дэвшүүлэх процесс нь мэргэжлийн ур чадвар, ёс зүйд суурилсан, аливаа ялгаварлан гадуурхах явдлаас ангид шударга байх, шүүгчээр ажиллах хугацаа нь хараат бус байдлыг хангахуйц хангалттай удаан байх, шүүгчийн цалин, хангамжийн баталгаатай байдал, шүүгчид хариуцлага тооцох үндэслэл хууль тогтоомжид тусгагдсан байх, үйлдсэн зөрчил, хүлээлгэх хариуцлага хоорондоо зохистой түвшинд байх зэрэг шалгууруудыг хууль тогтоомждоо сайн тусгаж өгсөн гэдэг нь харагдлаа. Хэдийгээр эдгээр шалгуур нөхцөл тодорхой хэмжээнд хангагдсан боловч шүүгчийн ёс зүйд тавих стандарт, шүүгчийн мэргэшлийн ур чадварын түвшин, түүний шалгуур үзүүлэлтүүд, шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах, огцруулах зэрэгт тодорхой хэмжээний өөрчлөлтүүдийг хийснээр шүүгчийн бие даасан байдалд халдахгүйгээр шүүгчийн хариуцлагатай байдлыг дээшлүүлэх боломжтой гэдэг нь мөн харагдлаа.

Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах, шүүхийн үр нөлөөтэй ажиллагааг дээшлүүлэх, шүүх эрх мэдэлд итгэх олон нийтийн итгэлийг сайжруулах зорилгоор мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг үнэлж дүгнэдэг, тэр нь зөвлөмжийн чанартай, тогтолцоог судалгаа, тооцоотой нэвтрүүлэх нь зүйтэй байж болох юм. Энэ үнэлгээгээр хангалтгүй дүн авсан шүүгчийг давтан сургалтад хамруулж, ур чадварыг дээшлүүлэх боломжтой болно. Тухайлбал, Румын Улсад шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг тогтоох шалгалтад тэнцээгүй тохиолдолд тухайн шүүгчийг хоёр удаа давтан сургалтад хамруулаад дахин шалгалт авахад тэнцээгүй тохиолдолд шүүгчийн албан тушаалаас огцруулдаг байна. Ингэснээр анхнаасаа ур чадварын хувьд тэнцэхгүй шүүгчийг томилохгүй байхад дөхөм болох юм. Түүнчлэн шүүгчийн хариуцлагатай байдлыг дээшлүүлэх үүднээс хэргийн хөдөлгөөний менежментийг техник, технологийн дэвшилттэй уялдуулан улам боловсронгуй болгож, шүүгчдийн цаг ашиглалт, ажлын төлөвлөлт, хуваарилалт зэргийг бодитой тооцож, шүүгчдийн ажлын ачааллыг зохистой хуваарилах, шүүгчдэд хариуцлага тооцох нэг механизм болговол шүүгчийн хариуцлагатай байдлыг сайжруулах чухал арга хэрэгсэл болохоор байна.

Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийг мэргэжлийн үйл ажиллагааны чиг үүрэгт нь тохирсон байх шаардлагыг хангах үүднээс шүүгчийн ёс зүйг олон улсын стандартад нийцүүлэн илүү тодорхой болгох шаардлага зүй ёсоор тулгарчээ. Түүнчлэн шүүгчийн сахилга-ёс зүйн хяналтыг бүрдүүлж байгаа тогтолцоо болох Шүүхийн ёс зүйн хорооны гомдол шийдвэрлэх ажиллагааг Канад Улсын нэгэн адил гурван үе шаттай, нарийн дэг журамтай өөрчилж болохоор байна. Үүнд, нэгээс

хоёрдугаар үе шат хүртэл шүүгчийн ёс зүйн гомдол шийдвэрлэх ажиллагаа нь олон нийтэд хаалттай явагдах бол огцруулах тухай асуудлыг олон нийтийн дунд явуулж, хэлэлцүүлж, огцруулах шаардлагатай гэж үзвэл Ерөнхийлөгчид энэ тухай танилцуулж, шийдвэрлүүлж болох юм.

ОХУ болон Япон Улсын хувьд шүүгчийг мэргэжлийн үйл ажиллагаагаа зохих түвшинд биелүүлээгүй тохиолдолд огцруулах хүртэл арга хэмжээ авдаг. Тухайлбал, ОХУ-ын “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль”-д заасны дагуу хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг тодорхойгүй шалтгаанаар алга болгосон буюу үрэгдүүлснээ хүлээн зөвшөөрсөн бол шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх үндэслэл болдог. Харин Япон Улсын хувьд шүүгчийг огцруулах үндэслэлд илт хууль бус шийдвэр гаргах, шийдвэр гардуулалтыг зохих хугацаанд хийгээгүй, хэрэг хянан шийдвэр ажиллагааг зохих ёсоор явуулаагүй, үндэслэлгүйгээр хэрэг хойшлуулсан зэрэг шүүгчийн мэргэжлийн болон албан үүргээ ноцтойгоор зөрчсөн тохиолдлууд ордог байна.

Монгол Улсын хувьд шүүгч, шүүгчийн туслах хуульд заасан хугацааг баримтлан ажлын зохион байгуулалт сайтай, жигд ажилласан тохиолдолд шийдвэрийг хуульд заасан хугацаанд гардуулах, хэргийг эмхэтгэх, архивд шилжүүлэх ажиллагааг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх нь иргэнд хүрэх шударга ёсны үйлчилгээний чанарт ахиц гаргахад дөхөм болно хэмээн ШЕЗ-ийн Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсээс гаргасан зарим судалгаанд харуулжээ. Иймд хугацаа хэтрүүлсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулсан, мэргэжлийн үйл ажиллагаандаа хайнга хандсан шүүгчид хариуцлага тооцох тогтолцоо байхгүй байгааг анхаарч, Эстони Улсын нэгэн адил шүүхийн дотоод хяналтын тогтолцоог сайжруулах шаардлага тулгарч байна. Тухайлбал, Эстони Улсад шүүхийн дарга буюу Ерөнхий шүүгч нь тухайн шүүхэд шүүн таслах үйл ажиллагаатай холбоотой ажлуудыг зохион байгуулах, шүүгчдийн зөвлөгөөнөөс баталсан шүүгчдийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үүрэгтэй ажилладаг. Тэрээр шүүгчдийн хэргийн хөдөлгөөний удирдлагыг хангах чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавьдаг бөгөөд шүүгчдээс тайлбар авах, үйл ажиллагааны журмыг баримталж байгаа эсэхэд шалгалт хийж, бусад шаардлагатай мэдээллийг цуглуулах эрх эдэлнэ. Хэрэв түүний тогтоосноор шүүгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зайлшгүй хэрэгжүүлэх процесс ажиллагааг хийгээгүй бол шүүгчид хуралдаан болон ажлын цагийг зөв хуваарилах талаар зохион байгуулалтын заавар, удирдамж өгөх, шүүгчийн үйл ажиллагааны төлөвлөгөөг харгалзан шүүгчдийн дунд хэргийг дахин хуваарилах зэрэг ажлыг зохион байгуулдаг. Харин шүүгч түүний даалгаврыг биелүүлээгүй бол тухайн шүүгчийн эсрэг сахилгын хэрэг үүсгэх эрх эдэлдэг гэсэн нарийн зохицуулалттай байдаг тул Эстони Улсад шүүгчийн хэргийн хөдөлгөөний удирдлага харьцангуй сайн хэрэгжиж, шүүгчид үндэслэлгүйгээр хуралдааныг хойшлуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа алдагдуулах зэрэг асуудал бага гардаг байна.

Молдав Улсын хувьд шүүгчид хуулийг чанд баримтлах үүргийг нэлээн хатуу тавьдаг бөгөөд Шүүхийн дээд зөвлөлөөс шүүгчийг “санаатайгаар эсхүл ноцтой байдлаар хайхрамжгүй хандсаны улмаас хуулийг нэг мөр хэрэглээгүй бөгөөд үүнийг нь дээд шүүх тогтоож, илт буруу шийдвэрийг хүчингүй болгосон бол”, “хэргийг зохих хугацаанд шийдвэрлээгүй эсхүл заавал дагаж мөрдөх хуулийн хэм хэмжээг зөрчсөн”, “шүүхийн шийдвэрийг үйлдэж, хэргийн оролцогчид хувийг нь гардуулах

хугацааг зөрчсөн” зэрэг үндэслэлээр сахилгын зөрчил гаргасанд тооцож, сахилгын шийтгэлийг хүлээлгэдэг байна. Түүнчлэн хэрэв шүүгч нь шийдвэрээ гаргахдаа хуулийг санаатайгаар зөрчсөн гэдгийг давж заалдах шатны журмаар тогтоож, шийдвэрийг хүчингүй болгосон, өөрчилсөн бол энэ нь шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах зөрчил болдог байна. Тэр бүхий л хуулийг хайхрамжгүй байдлаар зөрчиж, шийдвэр гаргасан нь үлэмж хэмжээний материаллаг болон сэтгэл санааны хохирол учруулсан бол шүүгч мөн хариуцлага хүлээдэг байна. Монгол Улсад энэ туршлагыг нэвтрүүлэхийн тулд нэмэлт судалгаа хийж, шүүгч өөрийн шийдвэрийн төлөө хариуцлага хүлээхгүй гэсэн хуулийн зохицуулалттай хэр зөрчилдөх вэ гэдгийг судалж, нэвтрүүлэх боломжтой юм.

Эцэст нь, Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн хүрээнд баталсан Шүүхийн багц хууль хэрэгжиж эхэлснээр Монгол Улсын шүүхийн тогтолцоо нь олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцэж, шүүхийн бие даасан, хараат бус байдал улам бүр бэхэжсэн нь сайшаалтай байна. Гэвч Монгол Улсад шүүгчийн ёс зүйн асуудлыг мэргэжлийн ёс зүйгээс салгаж авч үзсэнээр шүүгчдийн олон алдаа дутагдал иргэдийн шүүхэд итгэх итгэлийг бууруулж болзошгүй байна. Иймд энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд “Шүүгчийн хариуцлагын тогтолцоо” сэдэвт бодлогын судалгаанаас шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бүрэн дүүрэн хангасан орчинд хариуцлагатай байдлыг дээшлүүлэх зарим арга хэмжээг хэрэгжүүлэх дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

Санал, зөвлөмж:

Шүүгчийн хариуцлагатай байдлыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна:

- Хэргийн хөдөлгөөний менежментээр шүүгчийг хариуцлагажуулахаас гадна хэргийн хөдөлгөөний бодит байдалд дүн шинжилгээ хийж, шүүгчийн ажлын ачааллыг зохистой түвшинд хүргэх. Үүний тулд шүүгчийн орон тоог нэмэх шаардлагатай эсэх, процессын хуулиуд дахь хэрэг шийдвэрлэх болон бусад холбогдох хуулийн хугацаанд өөрчлөлт оруулах нь илүү оновчтой эсэх, эсхүл шүүгчдийн ур чадварыг дээшлүүлэхэд анхаарах эсэхийг тодорхойлох. Энэ төрлийн судалгааг хийж, оновчтой эрх зүйн зохицуулалтыг боловсруулсны дараашүүгчийг хуулийн хугацааг чанд баримталж, шүүхийн шийдвэрийг гаргуулах үүднээс *“Шүүгч шүүн таслах бүх үүргээ, тэр дундаа баталгаажсан шийдвэрээ гардуулах үүргээ үр өгөөжтэй, шударга, боломжит хугацаанд биелүүлнэ”* гэсэн Шүүхийн ёс зүйн Бангалорын зарчмын 6.5 дахь хэсэгт орсон заалтыг Шүүгчийн ёс зүйн дүрэмд тусгах.
- Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэмд шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотойгоор *“Шүүгч нь үүргээ шударгаар, мэргэжлийн өндөр түвшинд, тухайн хэргийг мэргэшсэн байдлаар, цаг хугацаанд нь шийдвэрлэх бүхий л шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэх, эвлэрэхэд нь тусална”* гэсэн заалтыг оруулах.
- Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэмд шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотойгоор *“Шүүгч нь хүн бүр хэргээ шударга шүүхээр*

боломжит хугацаанд шийдвэрлүүлэх эрхийг хангахад чиглэсэн арга хэмжээг авах бөгөөд шүүх хуралдааныг зохих ёсоор удирдан явуулах, нэг ижил цагт хэд хэдэн хэргийн шүүх хуралдааны товыг зарлахаас сэргийлэх, зохих бэлтгэл хангагдаагүй зэргээр шүүх хуралдааныг олон удаа, үндэслэлгүйгээр хойшлуулахаас урьдчилан сэргийлнэ” гэсэн заалтыг оруулах.

- Шүүгчид ёс зүйн хариуцлага тооцох үндэслэл нь гагцхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гадуурх ёс зүйн зөрчлөөр хязгаарлагдаж байгааг өөрчилж, хууль тайлбарлан дотоод итгэлээрээ шийдвэр гаргаснаас бусад хэрэг хянан шийдвэрлэх журам, хугацааг зөрчиж, ноцтой хохирол учруулсан бол ёс зүйн хариуцлага оногдуулдаг болгох.
- *“Шүүгч төв голч байдлаар шийдвэрлэх боломжгүй гэж үзсэн эсхүл ийм байдлаар шийдвэрлэх боломжгүй нь илэрхий үндэслэлтэй хэргүүдэд шүүгч өөрөө тухайн хэргийг шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарна”* гэсэн Шүүхийн ёс зүйн Бангалорын зарчмын 2.5 дахь хэсэгт орсон заалтыг Шүүгчийн ёс зүйн дүрэмд тусгах.
- Мэдээллийн технологийн орчин үеийн дэвшилттэй уялдан олон нийтийн цахим сүлжээнд шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ нэгэн адил үйлчилдэг байх.
- *“Шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зүй бусаар явуулахаас ямагт зайлсхийх бөгөөд хэргийн оролцогчдын эрхийг зөрчихгүй байх боломжит бүхий л арга хэмжээг авна”* гэдгийг Шүүгчийн ёс зүйн дүрэмд тусгах.

Шүүгчийн ёс зүйн стандартын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна:

- Шүүгчийн ёс зүйн дүрэм болон Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийг шинэчлэн найруулж батлах, ингэхдээ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Шүүхийн захиргааны тухай хуультай уялдуулах.
- Шүүгчийн ёс зүйн дүрмийг бүхэлд нь олон улсын шүүгчийн ёс зүйн стандартад нийцүүлэн илүү тодорхой болгох. Бусад улсын шүүгчийн ёс зүйн дүрэм нь тодорхой хэдэн асуудалд нарийвчилж, ихэнх хариуцлага тооцох үйлдэл, эс үйлдлийг ерөнхий байдлаар тусгадгийг харгалзан үзсэний үндсэн дээр Шүүгчийн ёс зүйн дүрмийн зарим заалтыг нарийвчлах, заримыг өргөн хүрээнд авч үзэх.
- Шүүгч зохисгүй, нэр хүндээ алдах үйлдэл хийсэн, шүүхийн нэр хүндийг дордуулсан, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг алдагдуулахаас ямагт зайлсхийдэг байх.
- *“Шүүгчид чин шударга байдлыг хадгалахын тулд шүүгч нь бусдын үндэслэл бүхий буруутгал, зэмлэлд өртөхгүйгээр биеэ авч явах, шүүгчийн биеэ авч явах байдал, үйл ажиллагаа нь шүүхийн чин шударга байдалд итгэх иргэдийн итгэлийг ямагт баталж байх ёстой. Шударга ёс зөвхөн хэрэгжиж байх төдийгүй, хэрэгжиж буй нь харагдаж байх ёстой”* гэсэн Шүүхийн ёс зүйн Бангалорын зарчмын үзэл санааг Шүүгчийн ёс зүйн дүрэмд шинээр оруулах.

- “Шүүгч шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхдээ хэрэгт хамааралгүй шинжээр нь ямар нэг хувь хүн, бүлэгт илүү хандах, алагчилсан байдлыг үгээр болон биеэ авч явж буй байдлаараа илэрхийлэх ёсгүй” гэсэн Шүүхийн ёс зүйн Бангалорын зарчмын 4.3 дахь хэсэгт орсон заалтыг Шүүгчийн ёс зүйн дүрэмд оруулах.
- Шүүгч ямагт мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх шаардлагатай гэдгийг онцолж, “Шүүгч мэдлэг, чадвар болон шүүн шийдэх ажиллагааны үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зан төлөвөө дээшлүүлэх боломжит алхмуудыг хийж байх, энэхүү зорилгоор шүүхийн хяналт дор шүүгчдэд зориулан бэлтгэсэн сургалт, бусад арга хэрэгслийг ашиглавал зохино” гэсэн Шүүхийн ёс зүйн Бангалорын зарчмын 6.3 дахь хэсэгт орсон заалтыг Шүүгчийн ёс зүйн дүрэмд тусгах.
- Шүүгч нь Монгол Улсын хууль тогтоомжийн өөрчлөлт, олон улсын эрх зүйн хэм хэмжээ, тэр дундаа хүний эрхийн олон улсын конвенц, бусад баримт бичиг, тэдгээрийг практикт эрх зүйн хэм хэмжээ болгон хэрэглэх, шүүхийн практикийг цаг ямагт судалж мэдлэг, ур чадвараа дээшлүүлдэг байх.
- Шүүгчийн ёс зүйг өндөр байлгах нь шүүхийн байгууллагын тэргүүлэх үүрэг бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн ёс зүйн хорооноос шүүхийн анхан, дунд шатны сургалтуудыг шүүгчдийн дунд тогтмол зохион байгуулж, эдгээр сургалтын агуулгад Хуульчийн ёс зүй, Шүүгчийн ёс зүй, Бангалорын зарчмууд зэрэг шүүгчийн мөрдвөл зохих олон улсын хэм хэмжээг тусгах.

Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг үнэлэх, дүгнэхэд дараах саналыг дэвшүүлж байна:

- Шүүгчийн мэдлэг, ур чадварыг байнга сайжруулах, шүүгчийн мэргэжил, ур чадварт хандах олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, нийгмийн өмнө хүлээсэн шүүхийн үүргийг хангах зорилгоор Монгол Улсын шүүхийн шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан шүүгчийн хараат бус байдалд халдахгүй байдлаар үнэлж, дүгнэх. Тодруулбал, шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг үнэлэх, дүгнэх явдал нь шүүгчийн эрх зүйн байдалд сөрөг үр дагаварт хүргэж болзошгүйг харгалзан, энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд “шүүх бие даасан, шүүгч хараат бус байх” зарчмыг гол шалгуур болгох.
- Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг Шүүхийн ерөнхий зөвлөл Шүүхийн мэргэшлийн хороотой хамтран үнэлж байх, ийнхүү үнэлсэнтэй холбогдуулан тухайн шүүгчид сахилгын хариуцлага оногдуулах, албан тушаалаас нь огцруулах, чөлөөлөх, цалингийн хэмжээг хасах зэрэг арга хэмжээ авахыг хориглох. Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны түвшинг үнэлсэн үр дүнг шүүгчийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхэд шаардлагатай шүүхийн сургалтын бодлогыг тодорхойлж, шүүгчдэд арга зүйн зөвлөмж гаргахад ашигладаг байх.

- Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшний үнэлгээний журамд “хангаалтгүй дүн авсан шүүгчдийг давтан сургах, үүний дараа түүний ажлын гүйцэтгэлийг дахин үнэлэх” гэсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгох.
- Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг үнэлж дүгнэх явцад шүүгч ёс зүйн зөрчил гаргасан талаарх мэдээлэл ирсэн тохиолдолд энэ асуудлыг шийдвэрлүүлэхээр Шүүхийн ёс зүйн хороонд харьяалуулан шилжүүлдэг болгох. Энэ нь Шүүхийн мэргэшлийн хороо болон Шүүхийн ёс зүйн хорооны харьяаллыг давхардуулахгүй байхад ач холбогдолтой.

Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшин тогтоох журмыг боловсруулахад дараах саналыг дэвшүүлж байна:

- Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшин тогтоох журамд үнэлгээ хийх зарчмыг тодорхой болгох. Тухайлбал, бүх үнэлгээг нэг ижил, батлагдсан удирдамж, загвараар хийх, хувь хүний эрх ашиг сонирхлыг хамгаалсан байх, шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг нийтлэг байдлаар олон нийтэд нээлттэй болгох¹⁸¹ г.м.
- Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшин тогтоох журамд үнэлгээний шалгууруудыг нарийвчлан тусгаж, тус бүрд нь үнэлгээ өгөх явдлыг нарийвчлан зохицуулах. Үүнд, шүүгчийн ажлын бүтээмж, үйл ажиллагаандаа холбогдох процедур, журмыг ханган баримталж байгаа байдал, ур чадварын үзүүлэлт буюу шийдвэрийн чанар, мэргэшлийн ур чадвараа дээшлүүлэх буюу хувь хүний болон мэргэжлийн ур чадвараа хөгжүүлж буй байдал, шүүх үйл ажиллагааг удирдах арга хэлбэр, шүүгчийн зан төлөвийн хандлага, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахиж байгаа байдал зэрэг шалгуур үзүүлэлтээр үнэлгээг өгдөг байх.
- Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшин тогтоох журамд түвшинг тогтоосон үнэлгээ, дүгнэлтийг гаргахад ашиглах аргачлал, удирдамжийг нарийвчлан тусгах. Түүнчлэн түвшин тогтоох “шалгуур, үзүүлэлтийн үнэлгээ”-г тооцох суурь нөхцөл болон хянан шийдвэрлэсэн хэргийн чанар, ачааллыг хэрхэн тооцох, үнэлж, дүгнэхтэй холбоотой процессын асуудлыг бүхэлд нь нарийн зохицуулж тусгах. Ингэсэн тохиолдолд дээрх журмаас гадуур, аливаа нэг удирдамжаар “түвшин тогтоох ажлыг зохион байгуулах”, эсхүл аргачлал гаргаж “үнэлгээ, дүгнэлт”-д ашиглах явдлаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.
- Тодорхой хэрэг, маргааныг холбогдох эрх зүйн эх сурвалжийг тайлбарлан хэрэглэж, шийдвэрлэсэн эсэхийг задлан шинжилж, дүгнэх зорилгоор шүүгчээр ажилласан жилээс хамааран 10-30 хүртэлх¹⁸² шийдвэрийг

¹⁸¹ Шүүгч тус бүрээр дүнг ил тод болгох нь шүүгчийн хараат бус байдал болон олон нийтийн шүүхэд итгэх итгэлд сөрөг нөлөө үзүүлж болзошгүйг харгалзан үзэж, ил тод байх зарчмыг хязгаарлагдмал хүрээнд баримтлах нь зүйтэй юм.

¹⁸²Одоо мөрдөгдөж байгаа 2013.10.15-ны өдрийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 165 дугаар зарлигаар батлагдсан “Шүүгчийг сонгон шалгаруулах журам”-д дээд шатны шүүхийн шүүгчээр ажиллах мэдлэг, чадварыг дүгнэхдээ 6 хүртэлх хэрэг, маргааны шийдвэрийг тохиолдлын журмаар сонгон авч дүгнэхээр

тохиолдлын журмаар сонгон авч үнэлгээ өгөх. Мөн шийдвэрийн чанарыг үнэлэх зорилгоор дээд шатны шүүхээс буцаасан, хүчингүй болгосон шийдвэрийн эзлэх хувиар оноо өгдөг болох.

- Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг тогтоосон үнэлгээний хүчинтэй байх хугацааг богино хугацаагаар тогтоож, хангалттай эсхүл хангалтгүй үнэлгээ авсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэхийг зохицуулах. Түүнчлэн хангалтгүй үнэлгээ авсан шүүгч өөрөө хүсвэл дахин үйл ажиллагааныхаа түвшинг үнэлүүлэх боломжоор хангах талаар шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшин тогтоох журамд нарийвчлан тусгаж өгөх.
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанарын үзүүлэлт нь шүүгчийн ажлыг үнэлэх гол шалгуур байхад анхаарч, тус үнэлгээг илүү дэлгэрэнгүй болгож, нийт мэргэшлийн үйл ажиллагааны үнэлгээнд эзлэх хувь, оноог өндрөөр тогтоож өгөх.
- Ерөнхий шүүгчийн сонгон шалгаруулалтад нэрээ дэвшүүлсэн шүүгчийн удирдан зохион байгуулах авьяас, манлайлах ур чадварт үнэлгээ өгдөг байх. Үүний тулд нэр дэвшигчийг илүү шударга, бодитой үнэлэх боломжийг хангах зорилгоор түүнд тавих болзол, шаардлагыг илүү нарийвчлан тодорхойлж, нэгдмэл ойлголтод хүрэх.¹⁸³

Шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах, огцруулах асуудлын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна:

- Шүүгчийн ёс зүйн дүрмийн 5.1 дүгээр зүйлийн 6-д заасан *“Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагаанаас бусад ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг Шүүхийн ёс зүйн хороо харьяалан шийдвэрлэнэ”* гэдгийг *“Шүүгчийн шүүн таслах үйл ажиллагаанд албан үүргээ биелүүлээгүй, хангалтгүй биелүүлсэн ёс зүйн зөрчил болон бусад ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг Шүүхийн ёс зүйн хороо харьяалан шийдвэрлэнэ”* гэж өөрчлөх. Энэ хүрээнд Шүүгчийн ёс зүйн дүрмийн агуулгыг шүүгчийн мэргэшлийн болон хувийн ёс зүйтэй холбогдох агуулгаар өргөтгөх.
- Шүүгчийн ёс зүйн гомдол, хүсэлтийг судлах, хянан шийдвэрлэх Шүүхийн ёс зүйн хорооны үйл ажиллагааг боловсронгуй болгох. Үүнд, Шүүхийн ёс зүйн хорооны ажлын албаны ажлын ачаалал, гишүүдэд тавигдах үндсэн шалгуур зэргийг дахин нягталж үзсэний үндсэн дээр шүүгчийн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоход хяналтын институцийн бүтэц бүрэлдэхүүн болон гомдол шийдвэрлэх ажиллагааг илүү нарийвчилсан дэг журамтай, үе шаттайгаар өөрчлөн зохион байгуулах.

заасан нь бүрэн дүүрэн үнэлэхэд хангалттай хэрэг, маргааны шийдвэрийн тоо биш юм. Түүнчлэн тус журамд тухайн шүүгчийн ажилласан жилээс хамаарч шийдвэрлэсэн хэрэг, маргааны шийдвэрийг тоо нь хэлбэлздэг уян хатан зохицуулалт тусгагдаагүй байна.

¹⁸³О.Мөнхсайхан, “Монгол Улс дахь шүүгчийн сонгон шалгаруулалт шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг сайжруулах нь”, Нээлттэй нийгэм форум, Улаанбаатар, 2015 оны судалгааны тайлангаас дэлгэрэнгүй үзнэ үү.

- Шүүгчийн ёс зүйн болон мэргэжлийн хариуцлагын асуудлыг Шүүхийн ёс зүйн хороо болон Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо шийдвэрлэдэг чиг үүргийн давхардлыг арилж, шүүгчийн мэргэжлийн ёс зүйн алдааг нэг байгууллага буюу Шүүхийн ёс зүйн хороо шийдвэрлэж, огцруулах саналыг Ерөнхийлөгчид өргөн барьдаг байх.
- Шүүгчийн ёс зүйн хариуцлагын үр нөлөөг дээшлүүлэх үүднээс сахилгын шийтгэл хүлээсэн шүүгчийн ажил сайжирсан байх, бусдад түүний сахилгын шийтгэл хүлээсэн явдал нь нөлөө үзүүлсэн байх зэргийг дахин хянаж, судалдаг байх.

-oOo-



ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ГОМДОЛ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА¹⁸⁴**Удиртгал**

Шүүхийн шинэтгэлийн тулгамдсан зорилтын нэг нь шүүхийн хараат бус байдлыг хангаж хамгаалах, баталгаажуулах явдал байсаар ирсэн. Үндсэн хуульд “шүүх бие даасан байх”, “шүүгч хараат бус байх”, “шүүгч зөвхөн хуульд захирагдах” гэсэн харилцан хамааралтай зарчмуудыг тусгаж, тэдгээрийг хангах зохион байгуулалт, эрх зүйн хийгээд улс төр-эдийн засгийн баталгаа, механизмын үндсийг тогтоож, түүний эрх зүйн орчинг бүрдүүлэх суурийг тавьж өгсөн байна.¹⁸⁵ Гэхдээ шүүхийн хараат бус байдлыг хуулиар баталгаажуулж өгөхөөс гадна шүүгч өөрийн “хараат бус байдлаа” сахин хамгаалах чин хүсэл, хөндлөнгийн нөлөөнд автахгүй байх өндөр ёс зүй, сахилга баттай байх явдал шаардлагатай. Нөгөөтээгүүр, Шүүх эрх мэдлийн нэгэн чухал зорилт нь иргэдийн шүүхэд итгэх итгэлийг хадгалах бөгөөд үүний тулд шүүгч ёс зүйтэй, сахилга, хариуцлагатай байх хэрэгтэй. Иймд шүүхийн хараат бус байдал, хариуцлагатай байдал хоёр нь нэгэн зоосны хоёр тал мөн.

Шүүгчийн ёс зүйн түвшинг дээшлүүлэх, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, ёс зүйн зөрчил гаргасан шүүгчид хариуцлага оногдуулах зэрэг ажлыг удирдан зохион байгуулах зорилгоор Шүүхийн ёс зүйн хороо нь 2013 оноос шинэчлэн байгуулагдан ажиллаж байна. Шүүхийн ёс зүйн хороо нь Шүүгчийн ёс зүйн дүрмийг баримтлан иргэд, албан тушаалтан, хуулийн этгээдээс шүүгчид гаргасан гомдлыг хянан хэлэлцэн, зохих шийдвэрийг гаргадаг. Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг зохицуулдаг Шүүгчийн ёс зүйн дүрэм нь хэдий чухал ач холбогдолтой ч түүнийг хэрэглэж, хэрэгжүүлдэг процессын үйл ажиллагаа нь мөн адил чухал ач холбогдолтой.

Энэхүү судалгаагаар шүүгчийн ёс зүйн гомдлын талаарх материаллаг хэм хэмжээ бус шүүгчийн ёс зүйн гомдлыг хянан шийдвэрлэж буй процессын хэм хэмжээг боловсронгуй болгох асуудлыг авч үзлээ.

Нэг. Монгол улсад шүүгчийн ёс зүйн гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжилт, тулгамдсан асуудал**1.1. Монгол Улсад шүүгчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс**

Шүүгчийн ёс зүй бол шүүх эрх мэдлийн тулгуур мөн.¹⁸⁶ Шүүгчийн мэргэжлийн ёс зүй нь шүүх эрх мэдлийн хараат бус байдал, шүүхэд итгэх итгэлийн баталгаа болдог.¹⁸⁷ Гэхдээ шүүгч хүн мэргэжлийн үүргээ биелүүлж байхдаа л ёс зүйтэй байх ёстой бус, мэргэжлийн үйл ажиллагаандаа болон хувийн амьдралдаа ёс зүйг баримтлах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, шүүгчид тавих ёс зүйн стандарт нь

¹⁸⁴ Тус судалгааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх ШСМСХ-ийн судлаач Б.Ариунзаяа /Л.М./, судлаач Ж.Ганзориг нар хамтран гүйцэтгэсэн болно.

¹⁸⁵ Ж.Амарсанаа “Ардчилсан эрх зүйн ёс”, Улаанбаатар, 2009 он, 14 дэх тал

¹⁸⁶ Ж.Амарсанаа, Б.Чимид, Р.Мухийт, Л.Төр-Од “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэл” УБ, 2010 он, 26 дахь тал

¹⁸⁷ Моригава Ясутомо “Хуульчийн ёс зүй”, УБ, 2007 он, 352 дахь тал

шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаанд болон хувийн зан суртахуунд тавих шаардлагаас бүрдэнэ.¹⁸⁸

Монгол Улсад шүүгчийн хариуцлага, ёс зүйн хэм хэмжээний эрх зүйн үндсийг Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хуулиуд тодорхойлж байна. Шүүхийн захиргааны тухай хуульд зааснаар Шүүхийн мэргэшлийн хороо, Шүүхийн ёс зүйн хороо байх ба (Шүүхийн мэргэшлийн хороо нь шүүгч, Ерөнхий шүүгчид нэр дэвшигчээс Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх талаар үнэлгээ өгөх)¹⁸⁹ Шүүхийн ёс зүйн хороо нь шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх¹⁹⁰ бүрэн эрхтэй. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар шүүгч зөвхөн хуульд захирагдах, шударга ёсны зарчим болон шүүгчийн ёс зүйг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн бол холбогдох сахилгын болон хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ. Уг хуулиар, шүүгч энэ хууль, шүүгчийн ёс зүйн дүрэм, шүүхийн байгууллага дахь хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хуулиар тогтоосон журмыг зөрчсөн бол сануулах, 6 сар хүртэл хугацаагаар 30 хүртэл хувиар цалинг бууруулах, огцруулах гэсэн арга хэмжээний аль нэгийг авна.

Эдгээр зохицуулалтаас харахад Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль дахь шүүгчийн хариуцлагатай холбогдох заалтууд болон Шүүгчийн ёс зүйн дүрэм зөрчсөн тохиолдол нь сахилгын арга хэмжээ авах үндэслэл болно.

Монгол Улсын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Шүүгч Шүүгчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана” гэж заасны дагуу шүүгчийн ёс зүйн асуудлыг Монголын Хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны Удирдах зөвлөлийн 2014.02.28-ны өдрийн 1/08 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”-ээр /цаашид “Шүүгчийн ёс зүйн дүрэм” гэх/ зохицуулж байна.¹⁹¹ Тус дүрэм нь шүүгчийн албаны үйл ажиллагаа болон хувийн амьдралдаа баримтлах зарчим, даган биелүүлэх хэм хэмжээг тодорхойлж, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, шүүгчийн ёс зүй, хариуцлагатай байдлыг бэхжүүлж, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах зорилгыг агуулсан баримт бичиг юм.

Шүүгчийн ёс зүйн дүрэмд зааснаар “Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаанаас бусад ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг Шүүхийн ёс зүйн хороо харьяалан шийдвэрлэнэ”¹⁹² гэсэн бөгөөд Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4-т “Ёс зүйн хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг Ерөнхийлөгч батална” гэж заасны дагуу шүүгчийн ёс зүйн гомдол, зөрчлийг хянан шийдвэрлэх процесс ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013.10.15-ны өдрийн 167

¹⁸⁸ НҮБ-аас баталсан 1985 оны “Шүүх эрх мэдлийн бие даасан байдлын тухай үндсэн зарчмууд”, 2002 оны “Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчмууд”, “Шүүгчийн ёс зүйн Лондонгийн тунхаглал”.

¹⁸⁹ Шүүхийн захиргааны тухай хууль, 2012, 23 дугаар зүйл

¹⁹⁰ Шүүхийн захиргааны тухай хууль, 2012, 32 дугаар зүйл

¹⁹¹ Монгол Улсын Шүүхийн менежментийг боловсронгуй болгох үзэл баримтлал (Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2004 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 70 дугаар тогтоол)-н 3.3-т: Шүүхийн хүний нөөц, сургалт, давтан сургалтын менежментийн зорилтуудын хүрээнд шүүгчийн ёс зүйн дүрмийг боловсронгуй болгох тухай тусган цаг үеийн шаардлагад нийцүүлэн өөрчлөн, шинэчилж ирсэн байна.

¹⁹² Монгол улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм 5.1.6

дугаар зарлигаар баталсан Шүүхийн ёс зүйн хорооны дүрмээр (Цаашид “ШЁЗХД” гэх) зохицуулж байна. Уг дүрмийн дагуу Шүүхийн ёс зүйн хорооны гишүүдийн бүрэн эрх, чиг үүрэг, гомдлыг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа нь явагдаж байна. Хорооны дүрэм нь Ёс зүйн хорооны бүрэлдэхүүн, чиг үүрэг, гомдлыг хүлээн авах, шалгах харилцаа, гомдлыг хянан хэлэлцэх хуралдаан болон нийт гишүүдийн хуралдааныг зохион байгуулах, хуралдааны дэг, хуралдаанаас гарах шийдвэр, хөөн хэлэлцэх хугацаа гэм мэт асуудлыг зохицуулжээ.

1.2. Шүүхийн ёс зүйн хорооны бүтэц, чиг үүргийг тодорхойлсон байдал

(1) Шүүхийн ёс зүйн хорооны бүрэлдэхүүн, чиг үүрэг

Шүүхийн ёс зүйн хороо (цаашид “ШЁЗХ” гэх) нь шүүгчийн сахилга, хариуцлага, ёс зүйг сахин хамгаалдаг орон тооны бус байгууллага мөн.¹⁹³ ШЁЗХ нь Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн дагуу нэр хүндтэй хуульч, эрдэмтэн, судлаач зэрэг есөн гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Эдгээрийг шүүгчдээс 3, Хуульчдын холбооноос 3, Төрийн захиргааны төв байгууллагаас 3 хүнийг нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч баталдаг. Одоогийн байдлаар, их дээд сургуулийн багш, чөлөөт судлаач 3, төрийн захиргааны байгууллагын удирдах ажилтан буюу төрийн жинхэнэ албан хаагч 4, төрийн бус байгууллагын ажилтан 1 гээд нийтдээ 8 гишүүн ажиллаж байна.¹⁹⁴ Эдгээр хүмүүсийн 4 нь эрдэмтэн, судлаач боловч үлдсэн гишүүд нь “төрийн захиргааны албан тушаалтан” байгаа нь хуульд заасан “хуульч, эрдэмтэн, судлаачид” харьяалагдах эсэх эргэлзээтэй.

ШЁЗХ-ны гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь гурван жил байх бөгөөд түүнийг нэг удаа улируулан томилж болно.¹⁹⁵ Харин ШЁЗХ-ны дарга, бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө орон гарвал өөр гишүүнийг нөхөн дэвшүүлж болохоор байна. Гэвч шинээр томилогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байхаар зааж өгчээ.

Шүүхийн захиргааны хуульд зааснаар ШЁЗХ-ны дарга нь Ёс зүйн хорооны ажлыг зохион байгуулах, хуралдааныг даргалах, өөрийн түр эзгүйд хуралдаан даргалагчийг томилох эрхтэй бол гишүүн нь гомдол, хүсэлтийн дагуу шүүгчид сахилгын хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзах, гомдол хүсэлтийг шалгаж дүгнэлт гаргах, сахилгын хэргийг шалгаж шийдвэрлэх бэлтгэл хангах, ажлыг зохион байгуулах, ШЁЗХ-ны хуралдаанд таслах эрхтэй оролцох гэсэн эрхтэй байна.

(2) Ажлын албаны үйл ажиллагаа

ШЁЗХ-ны ажлын алба нь орон тооны байх бөгөөд ажлын албаны дарга 1, хянан шалгагч референт 4, шинжээч 1 гэсэн бүрэлдэхүүнтэй. Ажлын албаны чиг үүрэг нь гомдлыг хүлээж авах, гишүүнд танилцуулах, гишүүний даалгавраар баримт, мэдээлэл бүрдүүлэх, ёс зүйн хорооны хуралдааны тэмдэглэлийг хөтлөх, хуралдааны тогтоол магадлалыг гомдол гаргагч, шүүгчид хүргүүлэх, цугларсан нотлох баримт, хуралдааны тов, захирамжийг холбогдох гишүүдэд хүргүүлэх, тогтоол, магадлалыг гомдол гаргагч болон шүүгчид хүргүүлэх гэх зэрэг байна.

¹⁹³ Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм 2.1 дэх заалт

¹⁹⁴ Шүүхийн ёс зүйн хорооны цахим хуудас <http://judcouncil.mn/ysdarga.html>

¹⁹⁵ Шүүхийн захиргааны тухай хуулийн 32.5 дахь заалт

ШЕЗХ-ны даргад ажлын албаны дарга болон хянан шалгагч референт, шинжээчийн ажил үүргийн зааг, хуваарилалт, байхгүй боловч нийтлэг байдлаар хорооны гишүүний даалгасан ажил үүргийг хийхээр тусгагдсан байна. Практикаас үзэхэд, хянан шалгагч референт нь ирсэн гомдлыг хариуцан авч, гишүүний зааврын дагуу баримт, мэдээлэл цуглуулж, хуралдаанд оролцдог бол шинжээч нь тэмдэглэл хөтлөх, хуралдааны бэлтгэл хангах зэрэг туслах шинжтэй ажил гүйцэтгэнэ.

Ажлын албаны хувьд гомдол хянан хэлэлцэх хуралдаан, нийт гишүүдийн хуралдаанд хянан шалгагч референтийн чиг үүрэг тодорхойгүй,¹⁹⁶ явцуу, хязгаарлагдмал шинжтэй байна. Өөрөөр хэлбэл, хянан шалгагч референт нь гомдол гаргагч, шүүгчийн эрх, үүргийг хангаж оролцуулах, гэрчийн мэдүүлэг цуглуулах, албан байгууллагаас баримт гаргуулах гэх зэрэг (бие дааж) хяналт, магадлан шалгалт хийх эрх хэмжээгүй байна. Гишүүний даалгаврын дагуу баримт мэдээлэл цуглуулах үүрэгтэй боловч энэ нь хязгаарлагдмал шинжтэй байна.

Шинжээчийн хувьд мөн адил хуралдааныг зохион байгуулах, хуралдааны тэмдэглэл хөтлөх зэрэг ажлыг хэрэгжүүлэх ба хянан шалгагч референттэй ажлын зааг, ялгаа нь харагдахгүй байна.

ШЕЗХ-ны бүрэлдэхүүн, дарга, гишүүд, ажлын албаны чиг үүргийн зохицуулалт, түүний хэрэгжилтэд дараах асуудлууд тулгамдаж байна:

1) Шүүгчийн ёс зүйн асуудлыг хянан шалгаж сахилгын шийтгэл оногдуулах эрх бүхий этгээдийн дийлэнх нь төрийн захиргааны албан тушаалтан байх нь ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй. Шүүх эрх мэдэл нь бие даасан, хараат бус байх ёстой атал шүүгчийн эрх зүйн байдалд нөлөөлөх субъект нь гүйцэтгэх эрх мэдлийн субъект байх нь зохимжгүй. Иймд Шүүхийн захиргааны тухай хуульд заасан нэр хүнд бүхий хуульч, эрдэмтэн, судлаач гэдэг зүйлийг дэлгэрүүлэн тайлбарлах зүйтэй байж магадгүй.

2) ШЕЗХ-ны дарга, ажлын албаны даргын чиг үүргийн уялдаа холбооны тухай зохицуулалтыг нарийвчлан зохицуулах хэрэгтэй.

3) ШЕЗХ-ны ажлын албаны чиг үүргийг хянан шалгах эрхтэй болгож өргөжүүлэх. Тухайлбал, гомдол хүлээн авсан гишүүн болон ажлын албаны хянан шалгагч референтийн чиг үүргийг тодорхой болгож, ирсэн гомдлыг шалгах, нотлох баримт цуглуулахад идэвхтэй оролцохоор болгох хэрэгтэй.

4) Түүнчлэн ШЕЗХ-ны гишүүд нь шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэдэг боловч хорооны гишүүдийн ёс зүйн асуудлыг хэрхэн хянах вэ гэдэг асуудал орхигджээ. Шүүгчийн зохисгүй, ёс зүйгүй байдлыг шүүмжилж гомдол гаргасан этгээдийн эрх ашгийг хамгаалах, нөгөө талаас шүүхийг хамгаалах, шүүхийн нэр хүндийг бэхжүүлэх зорилго бүхий ШЕЗХ-ны гишүүд шүүгчээс өндөр ёс зүйтэй байх шаардлага тавигдах нь дамжиггүй.

1.3. Ёс зүйн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж буй байдал

Шүүгчийн ёс зүйн гомдлыг хянан шалгаж ажиллагааг 4 үе шатаар хувааж авч үзэж болно. Үүнд Нэгд, гомдол хүлээн авах, шалгах үе шат, Хоёрт гомдол хянан

¹⁹⁶ Судлаач нь 2015.11.13-ны өдрийн Ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдаан болон 2015.12.04-ний өдрийн Нийт гишүүдийн 3 хуралдаанд ажиглагчаар оролцож, тэмдэглэл хөтлөв.


хэлэлцэх үе шат, Гуравт сахилгын хэргийг хянан шийдвэрлэх үе шат, Дөрөвт шүүхэд давж заалдах үе шат хэмээн ангилж болно.

(1) Гомдол хүлээн авах, шалгах ажиллагааны шат

Иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд нь ШЁЗХ-нд шүүгчийн ёс зүйн зөрчлийн талаар гомдол гаргаснаар ёс зүйн гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлдэг. ШЁЗХ-ны ажлын алба нь гомдлыг хүлээж авсан даруйд хорооны даргад танилцуулж, дарга нь хянан шалгах гишүүнд хуваарилна. Хянан шалгах гишүүн гомдлыг хүлээж авсан өдрөөс хойш шүүгчид танилцуулж, шаардлагатай баримт, мэдээлэл цуглуулна. Баримт мэдээлэл цуглуулахдаа гишүүн нь хянан шалгагч референтэд даалгавар өгч болно. Шаардлагатай баримт цуглуулсны дараа хорооны даргад танилцуулга бичиж, хуралдааныг зарлана. Хорооны дарга гомдлыг хянан хэлэлцэх бусад 2 гишүүдийг томилно.



Зураглал 1. Монгол Улсын ШЁЗХ-нд шүүгчийн ёс зүйн гомдол шийдвэрлэх ажиллагаа




(2) Гомдол хянан хэлэлцэх үе шат

ШЁЗХ-ны Даргад гомдлыг хянан үзэж сахилгын хэрэг үүсгэх, эс үүсгэх асуудлыг 3 гишүүний бүрэлдэхүүнтэй шийдвэрлэнэ гэж заасан бөгөөд одоогоор ШЁЗХ нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэх хуралдаан хэлбэрээр шийдвэрлэж байна. Хуралдаанд шүүгч болон гомдол гаргагч биеэр оролцож болно. Хуралдааны шийдвэр олонхийн саналаар гарна.

Сүүлийн үед гомдлыг хянан хэлэлцэх хуралдаан нь шалгах, нотлох, шийдвэрлэх чиг үүргийг нэг субъектэд төвлөрүүлсэн, хорооны гишүүдэд механик ачааллыг үүсгэдэг гэх шалтгаанаар гомдлын хянаж сахилгын хэрэг үүсгэх асуудлыг заавал хуралдаанаар хийх шаардлагагүй гэх шүүмж, санал бодол гарч ирж байна.¹⁹⁷

Зураглал 2. Монгол Улсын ШЁЗХ-ны хуралдааны үе шат



(3) Сахилгын хэргийг хянан шийдвэрлэх үе шат

Гомдол хянан хэлэлцэх хуралдаанаас сахилгын хэрэг үүсгэх тогтоол гарсан бол тогтоолыг гардуулснаас хойш 10 хоногийн дотор нийт гишүүдийн хуралдаан хийж, сахилгын хэргийг хянан шийдвэрлэнэ. Мөн гомдол хянан хэлэлцэх хуралдаанаар шүүгчийг ёс зүйн зөрчил гаргаагүй гэж үзэж, сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсаныг гомдол гаргагч эс зөвшөөрвөл, нийт гишүүдийн хуралдаанд давж заалдаж болдог. Нийт гишүүдийн хуралдаанаас магадлал гарна. Магадлалаар

¹⁹⁷ О.Мөнхсайхан нар "Монгол улс дахь шүүхийн захиргааны загвар, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам" 2015 он, 112 дахь тал

сахилгын шийтгэл оногдуулах, эсхүл сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох, дахин шалгуулах, сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолд сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолыг хүчингүй болгох, эсвэл хэвээр батлах шийдвэр гаргана.

Нийт гишүүдийн хуралдааны дараалал гомдол хянан хэлэлцэх хуралдаантай ижил явагдана. Энэ хүртэл шүүгчийн ёс зүйн гомдол шийдвэрлэх ажиллагааг ШЁЗХ бие даан хэрэгжүүлдэг.

(4) Шүүхэд давж заалдах үе шат

Нийт гишүүдийн хуралдаанаар сахилгын шийтгэл оногдуулах, эсхүл сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгодог. Гэвч энэ нь шүүгчийн ёс зүйн гомдлыг шийдвэрлэх эцсийн үе шат биш юм. ШЁЗХ-ны магадлалыг маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг магадлалыг гардан авснаас хойш 14 хоногийн дотор эд гомдол гаргах эрхтэй.¹⁹⁸ Түүнчлэн хуульд нэмэлт өөрчлөлт орохоос өмнө эцсийн байдлаар шийдвэрлэдэг байсан боловч 2014.04.10-ны өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр ийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Улсын дээд шүүх рүү гомдол гаргаж болохоор болжээ. Ингэснээр нэг ёс зүйн гомдлыг 4 хуралдаан, 4 шийдвэр, 4 шатаар дамжин эцэслэн шийдвэрлэж байна.

Шүүгчийн ёс зүйн гомдлыг хянан шийдвэрлэж буй нийт үе шат болон тэдгээрийн ажиллагааг судлан үзэхэд дараах хэд хэдэн асуудал анхаарал татаж байна:

- 1) Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1-т “Шүүгч энэ хууль, шүүгчийн ёс зүйн дүрэм, шүүхийн байгууллага дахь хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хуулиар тогтоосон журмыг зөрчсөн бол” түүнд сахилгын хариуцлага оногдуулахаар байгаа бөгөөд үүнд шүүхийн байгууллага дахь хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хууль, дүрэм, журмыг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэж болох нь харагдаж байна. Гэвч шүүх дотроо хөдөлмөрийн сахилга бат муу, дотоод журмыг удаа дараа зөрчих, мэргэжлийн буюу албан үүрэгтээ хайхрамжгүй хандах зэрэг зөрчил гаргасан шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах эрх хэмжээ байхгүй. Түүний зэрэгцээ энэ тухай ШЁЗХ-д хүсэлт тавьж болох нь эргэлзээтэй.
- 2) ШЁЗХ-ны хуралдааны дэгээс харахад, гомдол гаргагч болон шүүгч нь тэгш байдлаар тайлбараа гаргаж мэтгэлцдэг. Зарим тохиолдолд оролцогчдын гаргаж өгсөн нотлох баримтад тулгуурлан гомдол, хэргийг шийдвэрлэж байна. Ингэж гомдол гаргагч, шүүгчийг тэгш байдлаар оролцуулж байгаа нь шүүгчийн зөрчлийг үнэн зөвөөр илрүүлэхэд хүндрэлтэй байдалд хүргэдэг. Учир нь гомдол гаргагч, шүүгч хоёр нь зөрчил гаргасан эсэх талаар маргалдаагүй, төрийн тусгай албан тушаалтан болох шүүгчийн зөрчил гаргасныг шалгахыг шаардаж буй харилцаа юм. Иймээс гомдол гаргагч, шүүгч хоёр нь тэгш эрхтэй субъектууд биш учраас ШЁЗХ нь шүүгчийн зөрчилтэй холбоотой нотлох баримтыг цуглуулж, хэрэг үүсгэх, хуралдаанд хэрэг үүсгэсэн байр сууриа хамгаалах зэргээр оролцох илүү тодорхой болгох хэрэгтэй.

¹⁹⁸ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, 35.2 дахь заалт

- 3) Аливаа Ёс зүйн гомдол шалгах ажиллагаа цаг хугацаа их авахаас гадна олон шат дамжлагатай гэдэг нь харагдаж байна. ШЁЗХ-ноос гарсан шийдвэрийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, цаашлаад Улсын дээд шүүх хүчингүй болгох эрхтэй болсон нь ШЁЗХ-ны шийдвэр үр нөлөө багатай болсон байгааг харуулж байна.

1.4. Гомдол хянан шийдвэрлэх хугацаа ба хөөн хэлэлцэх хугацаа

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 34.1-д зааснаар гомдлыг хүлээж авсан өдрөөс гомдол хянан хэлэлцэх хуралдааныг 30 хоногийн дотор хийх ба хорооны дарга шаардлагатай тохиолдолд гомдол шалгах хугацааг 30 хоногоор 1 удаа сунгаж болохоор байна. Тэгэхээр гомдол, хүсэлт хүлээж авснаас хойш гомдлыг шалгаж хянан хэлэлцэх дээд хугацаа нь нийт 60 хоног байна. Гомдол хянан хэлэлцэх хуралдаан болсноос хойш 7 хоногийн дотор тогтоолыг бичгээр үйлдэнэ. Харин 10 хоногийн дотор оролцогчдод хүргүүлнэ. Ингэхээр гомдол хүлээж авснаас хойш хуралдааны тогтоолыг оролцогчдод гардуулах хүртэлх дээд хугацаа нь 77 хоног болж байна.

Харин нийт гишүүдийн хуралдааныг ямар хугацааны дотор хийх нь тодорхой биш байна. ШЁЗХД-ийн 5.1-д “нийт гишүүдийн хуралдаан сахилгын хэрэг, гомдлыг 10 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ”, Шүүхийн захиргааны тухай хуулийн 35.1-д “Ёс зүйн хороо сахилгын хэргийг 30 хоногийн дотор нийт гишүүдийн олонхын ирцтэйгээр хэлэлцэн, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ” гэсэн байгаа нь хоорондоо зөрчилджээ. Хэзээнээс эхэлж дээрх хугацаануудыг тоолохыг зааж өгөөгүй учраас өдгөө ШЁЗХ өөрийн боломжит хугацаанд нийт гишүүдийн хуралдааныг зарлаж, хуралдуулж байна. Илүү хүчин чадалтай хуулийн заалтыг барьж үзвэл, сахилгын хэрэг үүсгэсэн эсхүл сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолд гомдол ирсэн тохиолдолд гомдол ирснээс хойш 30 хоногийн дотор гомдлыг шийдвэрлэнэ гэж ойлгохоор байна. Ингэвэл, ШЁЗХ нь гомдол хүлээж авснаас хойш гомдлыг шийдвэрлэж дуусах эхний хугацаа нь 90-107 хоног буюу 3 сар орчмын хугацаа байна. Гэхдээ үүнээс цааш шүүхэд давж заалдвал тодорхойгүй хугацаагаар үргэлжилдэг байна.


2014 оны байдлаар ШЁЗХ-ноос нийт 276 тогтоол, 70 магадлал гарчээ. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал 17, Улсын дээд шүүхийн тогтоол 7 байна. ШЁЗХ-ны нийт 276 тогтоолоос хугацаа хэтэрсэн тогтоол 144, хугацаандаа шийдвэрлэсэн 85 тогтоол байгаа бол үлдсэн 47 тогтоолд нь хугацаа тавигдаагүй, он, сар зөрүүтэй гэсэн зөрчилтэй байна. ШЁЗХ-ны тогтоол, магадлалын хүрээнд авч үзвэл, нэг гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг 5 сард багтааж шийдвэрлэсэн нь хугацаа маш их алдсаныг харуулж байна. Улсын дээд шүүх хүртэл явсан гомдлын хугацааг тооцоолбол, гомдол ирснээс хойш 6-8 сарын хугацаанд эцэслэн шийдвэрлэгдсэн байна.¹⁹⁹

Түүнчлэн ШЁЗХ-ны гомдол хянан хэлэлцэх хуралдааны дийлэнх хувь нь хойшилсон байна. Энэ нь Шүүхийн ёс зүйн дүрэм шинэчлэн батлагдаж, шинэ дүрэм

¹⁹⁹ ШСМСХ-ийн судлаач Ж.Ганзориг тус судалгааны тоон мэдээг боловсруулан, хэрэг шийдвэрлэх дундаж хугацааг гаргав.

2014.03.01-ний өдрөөс дагаж мөрдөгдөхөөс хамаарч шинэ дүрмийн хэрэгжилтийг хүлээж ихэнх хурал хойшлогдох үндэслэл болсон байна.

График 1. Гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан хугацаа



Шүүхийн ёс зүйн хорооны дүрмээр сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 1 жил өнгөрсөн бол сахилгын шийтгэл оногдуулахгүй гэж²⁰⁰ заасан бол Ёс зүйн дүрмээр ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл оногдуулж болохгүй гэж заасан уг 2 дүрэм хоорондоо илэрхий зөрчилдөж байгааг харуулна.²⁰¹ Энэ нь уг хоёр дүрмийг боловсруулсан субъект өөр өөр байдгаас улбаатай. ШЁЗХ-ны хуралдаан дээр хөөн хэлэлцэх хугацааг тоолоход аль дүрмийг барих вэ гэдэг асуудал улмаар үүсч байна.

Түүнчлэн хөөн хэлэлцэх хугацаа тоолох, тасалдах журмын тухай зохицуулалт шаардлагатай байна.

Хоёр. Шүүгчийн ёс зүйн гомдол шийдвэрлэсэн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

Энэ хэсэгт иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагатай холбогдуулан гаргасан гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх ШЁЗХ-ны тогтоол, магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шүүхийн магадлалд дүн шинжилгээ хийлээ. Ингэхдээ зөвхөн 2014 оны шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийсэн ба энэ нь шийдвэрлэгдсэн хэргүүд дээр бүрэн гүйцэд ажиллахыг зорьсонтой холбоотой. Дүн шинжилгээ хийхдээ шийдвэрүүдийн тоо баримт, шинж чанар, агуулга зэргийг харгалзан үзэж нэгтгэх болон задлах аргаар шинжлэв. Ингээд эхлээд ШЁЗХ-ны Гомдол хянан хэлэлцэх хуралдааны тогтоол, нийт гишүүдийн хуралдааны магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шүүхийн магадлал, Улсын дээд шүүхийн тогтоол гэсэн дарааллаар авч үзнэ.

2.1. Шүүхийн ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдааны тогтоол


Шүүхийн ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдаанаар 2014 онд нийт 276 гомдол хянан шийдвэрлэснээс сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан 229 тогтоол, сахилгын хэрэг үүсгэсэн 23 тогтоол, хойшлуулсан 21 тогтоол, нэмэлт

²⁰⁰ Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм, 5.17 дахь заалт

²⁰¹ Шүүгчийн ёс зүйн дүрэм 5.1.4 дэх заалт

шалгалт хийхээр буцааж хугацааг сунгасан 3 тогтоол байна.²⁰² Нийт гомдлын 83 хувьд сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэжээ,

График 2. Гомдол хянан хэлэлцэх хуралдааны тогтоолын төрөл



Шүүхийн ёс зүйн хороонд 2014 онд ирсэн нийт 276 гомдлыг ирүүлсэн субъектээр нь ангилж үзвэл, иргэн 194, хуулийн этгээд 48, өмгөөлөгч 20, албан тушаалтан 14 гомдол тус тус гаргасан байна.

Иргэн	Хуулийн этгээд	Өмгөөлөгч	Албан тушаалтан
194	48	20	14

Шүүхийн ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдаанаар сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолууд дийлэнх хувь буюу нийт 229 байх бөгөөд эдгээрээс “гомдолд дурдсан асуудал нотлох баримтаар тогтоогдоогүй” гэсэн үндэслэлээр 37.9% (87), “өөрийн хүсэлтээр болон өндөр насны тэтгэвэрт гарсны улмаас Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн” гэх үндэслэлээр 9.2% (21), “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүгчийн ёс зүйн зөрчилд тооцогдохгүй” гэсэн үндэслэлээр 24% (55), “шүүгчийн гаргасан аливаа шийдвэр, захирамж хууль зүйн үндэслэлтэй эсэх, шүүгч хууль буруу хэрэглэсэн эсэхэд Шүүхийн ёс зүйн хороо үнэлэлт дүгнэлт өгөх эрхгүй” гэсэн үндэслэлээр 13.5% (31), “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй” буюу мэргэжлийн алдаа нь ёс зүйн зөрчил биш гэсэн үндэслэлээр 6.6% (15), “гомдол гаргагч гомдлоо буцаан авсан” гэх үндэслэлээр 3% (7), “хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн” гэх үндэслэлээр 2.6% (6), “гомдолд шүүгчийн нэр болоод ямар ёс зүйн зөрчил үйлдсэнийг дурдаагүй” гэх үндэслэлээр 1.7% (4), “шүүгч зохих ажиллагааг хийсэн учраас ёс зүйн зөрчил гаргаагүй” гэх үндэслэлээр 1.3% (3) нь тус тус шийдэгджээ.

Эндээс үзэхэд, ШЁЗХ-ны сахилгын хэрэг үүсгэхээс татгалздаг гол үндэслэлүүд нь “шүүгчийн ёс зүйн зөрчил нь нотлох баримтаар тогтоогдоогүй” болон “шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой үйлдэл, эс үйлдэхүй нь ёс зүйн зөрчилтэй хамааралгүй, Ёс зүйн хорооны эрх хэмжээний

²⁰² 2014 онд албан ёсоор 282 гомдол хүлээн авсан боловч судалгаанд 276 гомдлыг авч оруулсан. Зөрүүтэй гомдол, шийдвэрүүдийн хувьд шийдвэрүүд дутсан, он сар өдөр зөрсөн гэсэн шалтгаанаар судалгаанд оруулаагүй байна.

асуудал биш” гэдэг үндэслэл байна. Нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлийн хувьд оролцогчоос хангалтай нотлох баримт гаргаж өгөөгүй, эсхүл Ёс зүйн хороо нь нотлох баримтыг хангалттай цуглуулж чадаагүй, гуравдагч байгууллагаас баримт мэдээлэл гаргуулж авах эрх хэмжээ Ёс зүйн хороонд байхгүй гэсэн шалтгаанууд харагдаж байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц нь шүүгчийн ёс зүйн зөрчил биш гэсэн үндэслэлийн хувьд хэргийн хөдөлгөөний удирдлагыг шүүгч зүй бусаар явуулсан болон хэрэг таслан шийдвэрлэхэд мэргэжлийн алдаа, дутагдал гаргасан гэсэн 2 дэд үндэслэлд хувааж болохоор байна. Мэргэжлийн алдааны хувьд, шүүгч хэргийг хууль хэрэглэж, хараат бусаар, өөрийн дотоод итгэл үнэмшлээр шийдвэрлэх бүрэн эрхтэй бөгөөд энэ нь шүүхийн хараат бус байдалтай холбоотой учир хэргийг буруу шийдвэрлэсний төлөө шүүгчид хариуцлага оногдуулах нь буруу. Ийм алдааг засах эрх нь гагцхүү дээд шатны шүүхэд хадгалагддаг. Харин шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь бүхий л үйлдэл, эс үйлдэхүйг “ёс зүйн зөрчил” биш гэж үзэх шалтгаан, нөхцөл нь эргэлзээтэй байна. Тухайлбал, шүүх хуралдааныг зүй бусаар хойшлуулсан, хэргийн хугацаа хэтрүүлдэг, хавтаст хэргийг хаяж үрэгдүүлсэн, удаан хугацаагаар хадгалсан гэх зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлэх албаны чиг үүрэгтээ хайнга хандсан үйлдлийг хэрхэх вэ гэдэг асуудал тулгамдаж байна.

Одоо Шүүхийн ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдаанаар сахилгын хэрэг үүсгэсэн үндэслэлийг авч үзье. Нийт 23 тогтоолоос, “хүний эрхэм чанарыг хүндэтгэн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлээгүй” гэх үндэслэлээр 9, “хэргийн оролцогч нартай ялгаварлан харьцаж, хэргийн оролцогчтой тусгайлан утсаар ярьсан” гэх үндэслэлээр 6, “шүүх хуралдаан дундуур гарч явах, утсаар ярих зэргээр хэргийн оролцогчдод илт хүндэтгэлгүй харьцсан” гэх үндэслэлээр 4, “хуралдааны тэмдэглэлийг хуульд заасан хугацаанд гаргах ажиллагаанд хяналт тавилгүй, хэргийн оролцогчдод дуулгаагүй, хэргийн зохигчдыг хуулийн хугацаанд хуралдааны тэмдэглэлтэй танилцах боломж олгоогүй” гэх үндэслэлээр 2, “авилга авсан байж болзошгүй” гэх үндэслэлээр 1, “шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэсэн мэт ойлголтыг бусдад төрүүлсэн” гэх үндэслэлээр 1 тогтоол тус тус гарчээ.

Эндээс үзэхэд шүүгчийн ёс зүйн зөрчил байж болзошгүй үйлдлүүдэд хэрэг үүсгэснээс гадна “хугацаа хэтрүүлсэн” үндэслэлээр мөн хэрэг үүсгэсэн байгаа нь харагдаж байна. Энэ нь дээр дурдсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удирдлага буюу хэргийн хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэх шүүгчийн албаны чиг үүргийг ёс зүйн зөрчил гэж үзэж болохыг харуулснаараа сайшаалтай байна.

Шүүхийн ёс зүйн хорооны гомдол хянан хэлэлцэх хуралдаан хойшилсон нийт 21 тогтоол нь дахин нэмэлт ажиллагаа хийх, нотлох баримтуудыг цуглуулах, гомдол гаргагчийн хүсэлтээр, эсхүл ашиг сонирхлын зөрчлийн улмаас, гомдлуудыг нэгтгэж хэлэлцэхээр болсон гэх зэрэг үндэслэлүүдээр хойшилсон байна. Харин нэмэлт шалгалт хийхээр буцааж, хугацааг сунгасан тогтоолууд нь нэмэлт тайлбар авах шаардлага гарсан, шүүхэд очиж тодруулах, нэмэлт шалгалт хийх үндэслэлээр хугацааг сунгасан байна.

2.2. Шүүхийн ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдааны магадлал

Шүүхийн ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаас гарсан 70 магадлалаас 59 магадлалыг²⁰³ судлан үзвэл, сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолыг хэвээр баталсан 26, сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолыг хүчингүй болгож гомдлыг дахин шалгуулахаар буцаасан 9, сахилгын хэрэг үүсгэсэн тогтоолыг хүчингүй болгохгүйгээр дахин шалгуулах буцаасан 3, хуралдаан хойшлуулсан 9, сахилгын хэрэг үүсгэсэн тогтоолыг хүчингүй болгон, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон 7, сахилгын шийтгэл оногдуулсан 5 байна.

Эндээс үзвэл сахилгын хэргийг хянан үзээд сахилгын шийтгэл оногдуулсан 5 магадлал байх бөгөөд сануулах 1, цалин бууруулах 3, огцруулах 1 шийтгэл оногдуулжээ. Эдгээр 5 хэргийн факт болон сахилгын шийтгэл оногдуулсан үндэслэлийг товч танилцуулъя.

Хэрэг 1: Шүүгч С-ийн хэргийн оролцогчийн хүсэлтийг шийдвэрлэхээс татгалзсан үйлдэлд сануулах шийтгэл оногдуулжээ.

Хэрэг 2: Шүүгч М нь шүүх хуралдааны үеэр хэргийн оролцогчдод хандаж хувийн үзэл бодлоо тайлбарласныг "шүүгч нь тодорхой үйлдлийг өөрийн дотоод итгэлээр үнэлж дүгнэх бүрэн эрхтэй хэдий ч шүүх хуралдааны болон бусад үед хэргийн оролцогчидтой тэдний эрхэм чанарыг хүндэтгэн, шүүхэд итгэх итгэл үнэмшлийг алдахааргүй наад захын харилцааны соёлтой харилцах ёс зүйн үүрэгтэй" гээд Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.1-т гэсэн заалтыг зөрчсөн гэж 3 сарын хугацаагаар цалингийн 20%-иар бууруулах шийтгэл оногдуулсан байна.²⁰⁴

Хэрэг 3: Шүүгч А нь өөрийн шийдвэрлэж байгаа хэргийн оролцогчийн нөхөртэй нөгөө талыг байлцуулахгүйгээр уулзаж, цүнхтэй зүйл хүлээн авсан нь хараат бус байх, төвийг сахих шүүгчийн үүргийг зөрчсөн гээд Шүүгчийн ёс зүйн дүрмийн 2.3-т "Шүүгч нь зохисгүй байдал гаргаж болохгүй бөгөөд бусдад ийнхүү ойлгогдохоос зайлсхийнэ.",²⁰⁵ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.5-т заасныг тус тус зөрчсөн тул 3 сарын хугацаагаар цалингийн 30%-иар бууруулах сахилгын шийтгэл оногдуулсан байна.²⁰⁶

Хэрэг 4: Шүүгч Б нь шүүхийн хэлэлцүүлгийг явуулахдаа хэт нэг талыг барьсан гэх үндэслэлээр Шүүгчийн ёс зүйн дүрмийн 3.2.1, 1.3.1 дэх зарчмыг тус тус зөрчсөн тул 3 сарын хугацаагаар цалингийн 30%-иар бууруулах сахилгын шийтгэл оногдуулсан байна.

Хэрэг 5: Шүүгч Н нь өөрийн нөхрийн зээл авсан банкны хэргийг шийдвэрлэхдээ банкны талд шийдвэрлэсэн байх ба шүүгч нь энэ тухай хөрөнгө орлогын мэдүүлэгтээ мэдүүлээгүй явдлыг "хэрэв шүүгч хөрөнгө, орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлээгүй бол уг шүүгчийг үнэнч шударга зан чанартай эсэхэд төдийгүй,

²⁰³ Үлдсэн 11 магадлалын тухайд дутуу, эсхүл он, сар тавигдаагүй, хэргийн оролцогчдын нэрс тодорхойгүй зэргээс хамаарч судалгаанд оруулаагүй болно.

²⁰⁴ "Шүүгч нь хэргийн оролцогчдод эрх тэгш, төвийг сахисан, хүнлэг ёсоор хандаж, хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг төрүүлэхүйц харилцааны соёлыг эзэмшсэн байна."

²⁰⁵ Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийн 1.3 дугаар зүйлийн 1.9-д тодорхойлсон утгаар ойлгоно.

²⁰⁶ "Шүүгч нь мэргэжлийн ёс зүйгээ ухамсарласан, шударга ёсыг эрхэмлэдэг, хүний эрхийг дээдлэх, бусдын нөлөөнд автахгүй, бие даасан шийдвэр гаргах чадвартай байх"

хэрэг маргааныг хуулийн дагуу шударгаар шийдвэрлэдэг эсэхэд олон нийт эргэлзэхэд хүрнэ. Гэр бүлийн гишүүнийхээ зээлийг мэдүүлэх талаар хуульд заасан үүргээ зөрчих нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг сэвтүүлсэн үйлдэл учраас бусдад материаллаг хохирол учруулсан эсхүл албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой эсэхээс үл хамаарч сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно” хэмээн Авилгын эсрэг тухай хуулийн 13.8.4-т заасныг үндэслэн шүүгчийг ажлаас нь огцруулах сахилгын шийтгэл оногдуулсан байна.²⁰⁷

Эндээс үзвэл, ШЁЗХ нь сахилгын шийтгэл оногдуулах магадлалд факт болон дүрмийн заалтыг уялдуулан тайлбарлаж, үндэслэлээ тодорхой зааж өгсөн байгааг дурдах нь зүйтэй.

2.3.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал

Гомдол гаргагч болон шүүгч нь Шүүхийн ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаас гарсан магадлалыг эс зөвшөөрөл Захиргааны хэргийн давж заалдах шүүхэд хандах эрхтэй бөгөөд 2014 оны байдлаар нийт гишүүдийн хуралдааны 16 магадлалыг давж заалдсан байна. (Эдгээр 16 магадлалын 11 нь гомдол гаргагч талаас давж заалдсан “Сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолыг хэвээр баталсан” агуулгатай магадлал бол үлдсэн 5 нь шүүгч давж заалдсан “Сахилгын шийтгэл оногдуулсан” агуулгатай байлаа) Эндээс үзэхэд, шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан шийдвэрийг бүгд8 эс зөвшөөрч давж заалдсан байна.

Захиргааны хэргийн давж заалдах шүүх дээрх иргэдээс гаргасан “сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан” 12 магадлалыг хянаж үзээд бүгдийг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн бол шүүгчид “сахилгын шийтгэл оногдуулсан” 5 магадлалыг бүгдийг нь хүчингүй болгожээ. Сахилгын шийтгэл оногдуулсан магадлалыг хүчингүй болгож, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон Захиргааны хэргийн давж заалдах шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд дараах 3 үндэслэлийн улмаас ШЁЗХ-ны шийдвэрийг хүчингүй болгосон байв.

- 1) ШЁЗХ нь харьяалан шийдвэрлэх эрх зүйн үндэсгүй асуудлыг шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл, “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 32.2-т заасан “Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ”, ШЁЗД-ийн 1.4.2-ийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй.” гэсэн заалтын дагуу шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шийдвэр алдаатай эсэхээс үл хамаарч ёс зүйн зөрчилд тооцогдохгүй гэсэн зарчмыг барьжээ.
- 2) ШЁЗХ нь процессын хэм хэмжээг чандлан бариагүй нь шийдвэрээ хүчингүйд тооцуулах гол үндэслэл болжээ. Тухайлбал, ШЁЗХ нь гомдлыг шалгахдаа “шүүх хуралдааны тэмдэглэл тус шүүх хуралдааны бусад оролцогчид, өмгөөлөгч, прокурорын тайлбар болон холбогдох нотлох баримтыг цуглуулахгүйгээр зөвхөн гомдол гаргагчийн гомдол, шүүгч М-ийн гаргасан

²⁰⁷ “Нэг жилийн цалинтай тэнцэх буюу түүнээс их хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй, худал мэдүүлсэн, эсхүл хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан бол албан тушаалаас нь огцруулах буюу ажлаас халах”

тайлбарт үндэслэн шүүгчийн ёс зүйн зөрчил гаргасан гэж дүгнэн сахилгын шийтгэл оногдуулсан нь буруу байна”²⁰⁸ гэжээ. Өөрөөр хэлбэл, ШЕЗХ нь гомдолд хамаарал бүхий шаардлагатай баримт, мэдээллийг цуглуулах талаар “Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3.3-т²⁰⁹ заасан үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйн улмаас шийдвэрийг хүчингүй болгожээ. Түүнчлэн “ШЕЗХД-ийн 2.10, 3.3.2, 3.3.3, 3.3.4-д заасантай нийцээгүй даалгавар өгөх тухай захирамж, хурлын тэмдэглэл нь гарын үсэг, тамгагүй, гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа сунгасан шийдвэр гаргаагүй, гомдлыг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч томилоогүй, хуралдааны тов тогтоогоогүй зэрэг зөрчил гаргасан” гэдэг үндэслэлээр сахилгыг хэргийг хэрэгсэхгүй болгосон.

- 3) ШЕЗХ нь “Шүүгчийн ёс зүйн дүрэмд заасан сахилгын шийтгэл оногдуулж болох хөөн хэлэлцэх хугацааны талаарх зохицуулалтыг буруу тайлбарлан, дүгнэлт хийж, сахилгын хэргийг шийдвэрлэсэн байх тул”²¹⁰ магадлалыг хүчингүй болгожээ.

Эндээс үзэхэд, ШЕЗХ нь өөрийн үйл ажиллагаанаас хамаарах болон үл хамаарах шалтгаанаар шийдвэрээ хүчингүйд тооцуулж байна. Үл хамаарах шалтгааны хувьд, ШЕЗД-д шүүгчийн ёс зүйн зөрчлийн хүрээ хязгаар буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүгчийн ёс зүйн зөрчлийг зааг ялгааг тодорхой зааж өгөөгүйгээс “ёс зүйн зөрчил мөн” гэж үзсэн нь үндэслэлгүй болсон. Мөн ШЕЗД-д заасан хөөн хэлэлцэх хугацаа хэтэрхий богино байгаа учраас шүүгчийн ёс зүйн зөрчлийг илрүүлэх, хариуцлага тооцохдоо алдаа гаргажээ.

ШЕЗХ-ны үйл ажиллагаанаас хамаарах шалтгааны хувьд, ШЕЗХ ёс зүйн гомдол хянан шийдвэрлэх хэм хэмжээг чандлан барилгүй процессын алдаатай шийдвэр гаргаснаараа өөрийн шийдвэрийг хүчингүй болгох нөхцлийг бүрдүүлжээ. Энэ нь нэг талаар ШЕЗХ-ны гишүүдийн хариуцлагаас, нөгөө талаар ШЕЗХД нь процесс ажиллагааг нарийвчлан, бүрэн гүйцэд зохицуулж чадаагүйтэй холбоотой байж болохоор байна.

2.4. Улсын дээд шүүхийн тогтоол

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс Улсын Дээд шүүхийн хяналтын шатанд 8 хэрэг ирсэн бөгөөд үүний 1 нь “сахилгын шийтгэл оногдуулсан” шийдвэрийг хүчингүй болгосонтой холбогдуулж иргэнээс давж заалдах гомдол ирснийг хангахгүй орхиж шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, Улсын дээд шүүхээс шүүгчийн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон Захиргааны давж заалдах шатны шүүхийн магадлал хууль зүйн үндэслэлтэй гэж үзжээ. Харин 1 сахилгын шийтгэл оногдуулсан хэргийг дахин хянуулахаар буцаажээ. Бусад 5 хэрэг нь “сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоол” болон “сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон

²⁰⁸ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2014.06.25-ны өдрийн Ш/04 дүгээр магадлал

²⁰⁹ ШЕЗХД-ийн энэ заалтад гишүүн шаардлагатай гэж үзвэл Ажлын албаны ажилтнаар баримт, мэдээлэл бүрдүүлэх даалгавар өгч болох ба энэ тохиолдолд гишүүн захирамж гаргаж, ажилтны хийх ажлын үндсэн чиглэлийг тодорхойлсон байх тухай заасан байдаг.


²¹⁰ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2014.10.08-ны өдрийн Ш/07 дүгээр магадлал

тогтоол"-той холбогдуулж иргэний гаргасан гомдол байх ба үүнийг мөн хэвээр баталжээ.

2.5.Дүгнэлт

ШЕЗХ-ны гомдол хянан хэлэлцэх хуралдаанаар 2014 онд 276 гомдол шийдвэрлэгдсэний 23 нь сахилгын хэрэг үүсгэсэн тогтоол гарч, эдгээрийн 5-д нь Нийт гишүүдийн хуралдаанаар сахилгын шийтгэл оногдуулжээ. Эдгээр 5 хэрэг нь Захиргааны хэргийн давж заалдах шүүхээр “хөөн хэлэлцэх хугацаа баримтлаагүй”, “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй”, “шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шийдвэр алдаатай эсэхээс үл хамаарч ёс зүйн зөрчилд тооцогдохгүй” гэх үндэслэлүүдээр хэрэгсэхгүй болжээ. Түүнчлэн Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд сахилгын шийтгэл оногдуулсан 1 хэрэг хандсан боловч мөн адил “хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн” гэдгээр хангагдаагүй үлджээ.

Үүнээс харахад ШЕЗХ-д ирсэн гомдлууд цөөнгүй байгаа боловч сахилгын хэрэг үүсгэж, сахилгын шийтгэл оногдуулсан хэрэг үүсээгүй байна. ШЕЗХ өөрийн эрх хэмжээний хүрээнд ёс зүйн гомдлыг шийдвэрлэж, нийт гомдлын 13,8%-д сахилгын шийтгэл оногдуулсан байгаа ч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон Улсын дээд шүүхээр бүгдийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, шүүгчдийн ёс зүйн гомдлыг хөндлөнгийн шинжтэй ШЕЗХ бус, шүүх эцэслэн шийдвэрлэж байгааг харуулж байна.



Дараагийн чухал асуудал бол ШЕЗХ-ны ёс зүйн гомдлыг хянан шийдвэрлэж буй ажиллагаа буюу процессын асуудал байна. ШЕЗХ-ны шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх явцад гомдол хянан хэлэлцэх хуралдаан болон нийт гишүүдийн хуралдааны зарим шийдвэрүүд дутуу, гомдол гаргасан хугацааг тэмдэглээгүй, даалгавар өгсөн захирамж нь тамгагүй, танилцуулга гарын үсэг зураагүй, огноо байхгүй, хурлын тэмдэглэл хөтөлсөн хүний гарын үсэг, тамга дараагүй, гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа сунгасан шийдвэрээ гараагүй, гомдол хянан хэлэлцэх бүрэлдэхүүнийг хуралдаан даргалагч томилоогүй, хуралдааны тов тогтоогоогүй, гомдлын хувийг шүүгчид ажлын 2 өдөрт багтаан хүргүүлсэн эсэх нь тодорхойгүй, хуралдааны тов зарласан боловч хэзээ болох нь ойлгомжгүй, эсхүл хугацаагаа тодорхой заагаагүй зэрэг зөрчил дутагдлууд илэрсэн. Үүнээс үүдээд, гомдол шийдвэрлэх хугацааг тооцох боломжгүй болох цаашлаад процессын алдааны улмаас Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс хүчингүй болгуулах нөхцөл болж байна. Иймд ШЕЗХ нь ёс зүйн гомдол шийдвэрлэх ажиллагааг дүрмийн дагуу хариуцлагатай хэрэгжүүлэх явдалд анхаарах хэрэгтэй байна.

Гурав. Молдав, ОХУ, Эстони, Япон улсын шүүгчийн ёс зүйн гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа

Энэ хэсэгт Молдав, ОХУ, Эстони, Япон улсуудын шүүгчийн ёс зүй, сахилга, хариуцлагын тогтолцоо, хариуцлага оногдуулах үндэслэл, ёс зүйн гомдлыг хэрхэн хянан шийдвэрлэдэг тухай авч үзнэ.

Олон улсын эрх зүйн түвшинд шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах үүрэг бүхий хараат бус, төвийг сахисан байгууллагын өмнө шүүгчид өөрсдийн үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээдэг байх нөхцлийг “Шүүх эрх мэдлийн бие даасан байдлын тухай үндсэн зарчмууд”, “Шүүгчийн ёс зүйн Бангалорын зарчим” зэрэг баримт бичгээр тогтоож байна. Эдгээр баримт бичигт шүүгч нь зохистой байдлыг эрхэмлэж, иргэд, олон нийтийн өмнө зохистой харагдах нь зайлшгүй чухал болохыг тэмдэглэж, хэрэглэх зарчмууд, шүүгч зохих ёсоор үүргээ гүйцэтгэх хүрээнд явуулж болох үйл ажиллагаа зэргийг тусгасан байна. Хуульч мэргэжлийн хувьд, олон улсын хэм хэмжээ, стандартад сахилгын шийтгэл оногдуулах ажиллагаа нь мэргэжлийн үйл ажиллагааны ёс зүйн дүрэмд тулгуурлаж байх тухай тусгасан байна.

3.1. Молдав улс дахь шүүгчийн гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа²¹¹

Тус улсад шүүгчид хариуцлага тооцох асуудлыг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Сахилгын хороо болон Шүүгчийн хариуцлагын тухай хууль болон Шүүхийн дээд зөвлөлийн тухай хууль зэргээр зохицуулж байна. (Молдав Улсын 2015 онд шинэчлэн баталсан Шүүгчийн ёс зүй болон мэргэжлийн үйл ажиллагааны дүрмийг баримтлан үүнийг зөрчих нь сахилгын шийтгэл хүлээх үндэслэл болдог байна.)

Иргэд шүүгчийн ёс зүй, мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг Шүүхийн дээд зөвлөлд гаргах бөгөөд тус зөвлөл нь гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шалгаж, шийдвэр гаргана.²¹² Шүүхийн дээд зөвлөлөөс иргэдээс ирсэн гомдлын талаар шүүгчид мэдэгдэж, түүнчлэн гомдол гаргагчид гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээлнэ. Хэрэв Шүүхийн дээд зөвлөлөөс тухайн шүүгч нь сахилгын зөрчил гаргасан гэж үзвэл сахилгын хэрэг үүсгэнэ. Шүүхийн дээд зөвлөлийн аль ч гишүүн шүүгчдийн эсрэг сахилгын хэрэг үүсгэх эрхтэй.

Шүүхийн дээд зөвлөлд Сахилгын Хороо байдаг бөгөөд тус хорооноос сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж, шийдвэрийг гаргах бөгөөд гарсан шийдвэрийг Шүүхийн дээд зөвлөлөөс баталгаажуулна. Шүүгчийг сахилгын зөрчил гаргасан тохиолдолд зөрчлийг гаргасныг илрүүлснээс хойш 6 сарын дотор, зөрчил үйлдсэнээс хойш нэг жилээс хэтрэхгүй хугацаанд сахилгын шийтгэл оногдуулна.²¹³ Сахилгын хэрэг үүсгэх ажиллагааг Шүүхийн дээд зөвлөлийн нэг эсхүл

²¹¹ Тус хэсгийг ШСМСХ-ийн судалгаа хариуцсан ахлах референт Э.Өлзийлхам (LL.M, MA) гүйцэтгэв.

²¹² Шүүхийн дээд зөвлөл нь 11 гишүүнтэй бөгөөд эдгээрийн тав нь орон тооны бус гишүүд байна. Үүнд, Хууль зүйн сайд, Дээд шүүхийн Ерөнхийлөгч, Давж заалдах шатны шүүхийн Ерөнхийлөгч, Эдийн засгийн шүүхийн Ерөнхийлөгч болон Ерөнхий прокурор байна. Үлдсэн гурван гишүүдийг Дээд шүүхийн хамтарсан танхимын нууц санал хураалтаар, гурван гишүүдийг Парламентаас сонгох бол гурван гишүүдийг хууль зүйн профессороос сонгоно. (Молдав Улсын Дээд шүүхийн зөвлөлийн тухай хуулийн 3 дугаар зүйл)

²¹³ Молдав Улсын Сахилгын хороо болон Шүүгчийн хариуцлагын тухай хуулийн 11 дүгээр зүйл

гурван гишүүнээс эхлүүлсэн бол тухайн хэргийг эхлүүлсэн гишүүн нь шүүгчийн сахилгын зөрчлийн үндэслэлийг анхан шатны журмаар шалгаж, түүнээс тайлбар авч болно. Түүнчлэн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотлох баримтыг бүрдүүлж буй материалыг авч үзэхээс өмнө шүүгчид хүргүүлнэ. Хэрэв шаардлагатай бол нэмэлт баримт, материалыг гаргуулна. Түүнчлэн, шүүгч нь хуулийг зөрчсөн тохиолдолд тухайн шүүгчийн хянан шийдвэрлэсэн хэргийн материалыг авч үзэх зэрэг нэмэлт баримт материалыг гаргуулж болно.²¹⁴

Сахилгын хэргийг Сахилгын Хороонд эсхүл Шүүхийн дээд зөвлөлд хүргүүлснээс хойш 1 сарын дотор авч үзнэ.²¹⁵ Сахилгын хэргийг хамгийн багадаа Сахилгын Хорооны гишүүдийн гуравны хоёрын ирц бүрдсэнээр авч хэлэлцэнэ.²¹⁶ Хэрэг үүсгэсэн Шүүхийн дээд зөвлөлийн гишүүн нь шийдвэр гаргахад санал өгөхгүй. Сахилгын хорооноос шүүгчээс гадна бусад оролцогчдыг хуралдаанд дуудах, шүүгчийн хүсэлтээр эсхүл тэднийг байлцуулалгүйгээр шийдвэрийг гаргах эсэхийг шийдвэрлэнэ.²¹⁷ Сахилгын хорооноос дараах шийдвэрийг аль нэгийг гаргана: сахилгын шийтгэл оногдуулах; сахилгын шийтгэл оногдуулалгүйгээр хэргийг хэрэгсэхгүй болгох; эсхүл Шүүхийн дээд зөвлөлд шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгуулахаар материал хүргүүлэх зэрэг болно.²¹⁸ Сахилгын хорооноос сахилгын хэргийг дараах тохиолдолд хэрэгсэхгүй болгоно: Шүүгчид хариуцлага тооцох үндэслэл байхгүй; шүүгчид хариуцлага тооцох хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсон; сахилгын шийтгэл оногдуулах шаардлагагүйгээр хэргийг хуралдаанаар хэлэлцэж, шүүгчид үр дүнг мэдэгдэхийг хангалттай гэж үзсэн зэрэг болно.²¹⁹

Сахилгын хорооны шийдвэрийг давж заалдаагүй бол шийдвэрийг баталгаажуулахаар Шүүхийн дээд зөвлөлд шийдвэрийг гаргаснаас хойш долоо хоногийн дотор хүргүүлнэ. Шүүгчийг огцруулах тохиолдолд Шүүхийн дээд зөвлөлөөс энэ тухай саналыг аль шатны шүүх байхаас хамааран Ерөнхийлөгч эсхүл Парламентад хүргүүлнэ.²²⁰ Шүүхийн дээд зөвлөлийн шийдвэрийг давж заалдах хүсэлтээ сонирхогч этгээд хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор Дээд шүүхэд шийдвэрийг гаргаж болно.²²¹

Сахилгын хорооноос шүүгчид дараах төрлийн сахилгын шийтгэлийг оногдуулж болно. Үүнд: анхааруулах, сануулах, донгодох, зэрэг дэвийг буруулах, огцруулах тухай санал гаргах зэрэг болно.²²² Сахилгын шийтгэл оногдуулахад Сахилгын хорооноос сахилгын зөрчлийн төрөл, түүний үр дагавар болон хүндрүүлэх нөхцөл байдал, шүүгчийн зан авир, шүүгчийн буруутай үйл ажиллагааны хэр хэмжээ болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ.²²³ Сахилгын шийтгэлийн хугацаа дуусгавар болох эсхүл хүчингүй болтол шүүгч зэрэг дэв ахих боломжгүй.²²⁴

²¹⁴ Молдав Улсын Сахилгын хороо болон Шүүгчийн хариуцлагын тухай хуулийн 14 дүгээр зүйл

²¹⁵ Молдав Улсын Сахилгын хороо болон Шүүгчийн хариуцлагын тухай хуулийн 16 дугаар зүйл

²¹⁶ Молдав Улсын Сахилгын хороо болон Шүүгчийн хариуцлагын тухай хуулийн 15 дугаар зүйл

²¹⁷ Молдав Улсын Сахилгын хороо болон Шүүгчийн хариуцлагын тухай хуулийн 18 дугаар зүйл

²¹⁸ Молдав Улсын Сахилгын хороо болон Шүүгчийн хариуцлагын тухай хуулийн 19 дүгээр зүйл

²¹⁹ Молдав Улсын Сахилгын хороо болон Шүүгчийн хариуцлагын тухай хуулийн 19.4 дэх заалт

²²⁰ Молдав Улсын Шүүхийн дээд зөвлөлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 болон 5 дахь хэсэг

²²¹ Молдав Улсын Шүүхийн дээд зөвлөлийн тухай хуулийн 25 дугаар зүйл

²²² Молдав Улсын Сахилгын хороо болон Шүүгчийн хариуцлагын тухай хуулийн 23 дугаар зүйл

²²³ Молдав Улсын Сахилгын хороо болон Шүүгчийн хариуцлагын тухай хуулийн 19.3

²²⁴ Молдав Улсын Сахилгын хороо болон Шүүгчийн хариуцлагын тухай хуулийн 24 дүгээр зүйл

Сахилгын хорооноос шүүгчийг огцруулах тухай санал гаргах эрх эдэлнэ. Үүний дараагаар Шүүхийн дээд зөвлөлөөс шүүгчийг огцруулах тухай саналыг Ерөнхийлөгч эсхүл Парламентад гаргана.²²⁵ Хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, “шүүгчийг шүүхийн нэр хүндэд нөлөөлөхүйц эсхүл хуулийн 22 дугаар зүйлд заасан сахилгын зөрчлийг удаа дараа гаргасан, шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны үнэлгээгээр шүүгчийн албанд тохирохгүй гэдэг нь илэрхий болсон зэрэг үндэслэлээр огцруулна”²²⁶ гэж заасан байна.

3.2. ОХУ дахь шүүгчийн гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа²²⁷

ОХУ-ын “Шүүхийн шинэтгэлийн үзэл баримтлал” гэх бодлогын баримт бичгийг 1992 онд тус улсын парламент /Төрийн Дум/-аас баталсан. Энэ баримт бичигт шүүхийн шинэтгэлийн талаарх Засгийн газрын төлөвлөгөөг тодорхойлсон бөгөөд шүүгчийн хараат бус байдлын баталгааг бэхжүүлэх болон шүүгчийн хариуцлагын асуудлыг зөвхөн хуулиар зохицуулахад чиглэсэн.²²⁸

Шүүхийн шинэтгэлийн үзэл баримтлалын дагуу 1992.06.26-ны өдөр “ОХУ-ын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай” хууль батлагдсан.²²⁹ Шүүгчийн ёс зүйн зөрчилд хариуцлага хүлээлгэх асуудлыг “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 12.1 дүгээр зүйлд тусгасан. Энд зааснаар Шүүгчийн ёс зүйн дүрмийг бүх Оросын шүүгчдийн чуулганаас баталдаг.²³⁰ Ёс зүйн дүрмийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгчээс шүүхийн захиргааны үйл ажиллагаан дахь үүргээ зохих ёсоор гүйцэтгэх бүрэн эрх, ухамсартай байх чухал шаардлагатай. Хоёр дахь хэсэгт зааснаар шүүгч нь үүргээ шударгаар, мэргэжлийн өндөр төвшинд, мэргэшсэн байдлаар, цаг хугацаанд нь шийдвэрлэх бүхий л шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэх, эвлэрэхэд нь туслах талаар заасан. Гурав дахь хэсэгт зааснаар шүүгч нь хүн бүр хэргээ шударга шүүхээр боломжит хугацаанд шийдвэрлүүлэх эрхийг хангахад чиглэсэн арга хэмжээг авах бөгөөд шүүх хуралдааныг зохих ёсоор удирдан явуулах, нэг ижил цагт хэд хэдэн хэргийн шүүх хуралдааны товыг зарлахаас сэргийлэх, зохих бэлтгэл хангагдаагүй зэргээр шүүх хуралдааныг олон удаа, үндэслэлгүйгээр хойшлуулахаас урьдчилан сэргийлнэ. Тав дахь хэсэгт зааснаар шүүгч нь ОХУ-ын хууль тогтоомжийн өөрчлөлт, олон улсын эрх зүйн хэм хэмжээ, тэр дундаа хүний эрхийн салбарын олон улсын конвенц, бусад баримт бичиг, тэдгээрийг практикт эрх зүйн хэм хэмжээ болгон

²²⁵ Молдав Улсын Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 25.2 дахь заалт

²²⁶ Тус санал асуулгад Монгол Улсын нийт 91 шүүгч хамрагдсанаас сум дундын шүүхийн шүүгч 25, дүүргийн шүүхийн шүүгч 30, захиргааны хэргийн шүүхийн шүүгч 18, давж заалдах шатны шүүхийн шүүгч 18 тус тус хамрагдсан байна. Судалгааны асуулгад оролцсон шүүгчдийн 33 хувь нь эрэгтэй, 67 хувь нь эмэгтэй бол 11 хувь нь 3 хүртэлх жил, 9.9 хувь нь 4-6 жил, 16.5 хувь нь 7-10 жил, 62.6 хувь нь 11-ээс дээш жил ажилласан байна. Энэ нь харьцангуй шүүн таслах ажлын туршлагатай шүүгч нар судалгааны асуулгад хамрагдсан гэж үзэхээр байна.

²²⁷ Тус хэсгийг ШСМСХ-ийн судлаач Л.Галбаатар гүйцэтгэв.

²²⁸ Верховный Суд Российской Федерации. 1990 – начало 2010-х гг. Верховный Суд Российской Федерации <http://www.supcourt.ru>

²²⁹ Закон РФ от 26 июня 1992 г. N 3132-1 "О статусе судей в Российской Федерации" (с изменениями и дополнениями) <http://base.garant.ru/10103670/>

²³⁰ Шүүгчийн ёс зүйн дүрмийг Бүх Оросын шүүгчдийн чуулганаас 2012.12.19-нд баталсан.

<http://www.supcourt.ru/catalog.php?c1=English&c2=The%20Judicial%20System%20of%20the%20Russian%20Federation&c3=&id=9625>

хэрэглэх, үүний дотор Европын Хүний эрхийн шүүх, ОХУ-ын Дээд шүүх, Үндсэн хуулийн шүүхийн практикийг судалж, мэдсэн байх үүргийг хүлээнэ.

Ёс зүйн зөрчил гаргасан шүүгчид мэдэгдэх, сануулах, огцруулах²³¹ гэсэн хариуцлага оногдуулна. Мэдэгдэх хариуцлагыг тухайн шүүгчид сахилгын зөрчил гаргасан гэж үзэж бусад хариуцлага хүлээлгэх шаардлагагүй ч мэдэгдэх шаардлагатай гэж Шүүгчдийн мэргэшлийн зөвлөл шийдвэрлэсэн тохиолдолд хүлээлгэнэ. Харин сануулах хариуцлагыг сахилгын зөрчил гаргасан шүүгчид мэдэгдэх хариуцлага хүлээлгэх боломжгүй буюу мэдэгдэх хариуцлагыг өмнө нь хүлээлгэсэн тохиолдолд Шүүгчдийн мэргэшлийн зөвлөлөөс хүлээлгэнэ. Шүүгчийг огцруулах хариуцлагыг Шүүгчийн ёс зүйн дүрэм болон хуульд заасан зөрчлийг гаргасан шүүгчид хүлээлгэнэ. Ийм зөрчилд шүүн таслах үйл ажиллагааны зарчмыг гажуудуулсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь оролцогчдын эрхийг зөрчсөн, шүүгч шүүн таслах үйл ажиллагааг үргэлжлүүлж чадахгүй болсон буюу тухайн хэргийг хуульд заасан зохих хугацаанд шийдвэрлэж чадаагүй зөрчил хамаарна.

“Шүүгчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 12.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар шүүгч ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд түүнд зөрчил гаргасныг илрүүлснээс хойш 6 сарын дотор, зөрчил үйлдсэнээс хойш 2 сарын дотор сахилгын хариуцлага хүлээлгэнэ. Энэ хугацаанд ээлжийн амралттай буюу чөлөөтэй байх хугацааг оруулахгүй. “Шүүгчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 12.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх Шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг ОХУ-ын Дээд шүүхийн Сахилгын танхимд давж заалдаж болно. Тус хуулийн 12.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт зааснаар шүүгч ёс зүйн зөрчил гаргаснаас хойш 1 жилийн дотор дахин сахилгын хариуцлага хүлээгээгүй бол түүнийг ёс зүйн зөрчилгүйд тооцно.

Дашрамд дурдахад, шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэх асуудлаарх Шүүгчдийн мэргэшлийн зөвлөлийн хуралдаан нь төрийн болон хувийн нууцыг хамгаалах, хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд нээлттэй явагдана.²³²

3.3. Эстони улс дахь шүүгчийн гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа²³³

Эстони Улсад шүүгчид сахилгын шийтгэл оногдуулахад Шүүхийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэх бөгөөд сахилгын зөрчил гэдэг нь шүүгчийн буруутай үйлдлийг хэлнэ. Үүнд өөрийн албан ёсны үүргийг биелүүлээгүй эсхүл хангалтгүй биелүүлсэн зэрэг үндэслэлүүд орно. Шүүгчийн албыг хашихад тодорхой хоригууд байдаг бөгөөд шүүгч нь өөрийн хөрөнгийг мэдэгдэх үүрэг хүлээнэ. Түүнчлэн шүүгчийн зүй бус үйлдэл нь сахилгын зөрчилд

²³¹ Translation: Law on the Status of Judges in the Russian Federation http://www.supcourt.ru/print_page.php?id=9624

²³² Securing justice: The disciplinary system for judges in the Russian Federation. Report of an ICJ mission. 2012 <http://www.refworld.org/pdfid/530efd114.pdf>

²³³ Уг хэсгийг ШСМСХ-ийн судалгаа хариуцсан ахлах референт Э.Өлзийлхам (LL.M, MA) гүйцэтгэв.

тооцогдоно.²³⁴ Сахилгын шийтгэл нь сануулах, 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний торгууль оногдуулах, цалингийн хэмжээг бууруулах, огцруулах гэсэн төрөлтэй байна.

Хуульд шүүгчийн сахилгын зөрчлийн тухай гомдол гаргах асуудлаар тодорхой журмыг заагаагүй. Шүүгчдийн эсрэг аливаа гомдлыг шүүгчдийн сахилгын хэрэг үүсгэх эрх бүхий байгууллагуудад гаргах боломжтой юм. Гомдлыг хэн гаргаж болох талаар хязгаарлалт байхгүй, түүнчлэн гомдлын талаар тоон мэдээлэл дутмаг байдаг.²³⁵ Гэвч шүүхийн дотоод журамд гомдол гаргах талаар зохицуулсан байдаг. Түүнчлэн шүүгчийн эсрэг гомдлыг шүүхийн даргад гаргах бөгөөд тэрээр шаардлагатай тохиолдолд сахилгын хэрэг үүсгэнэ. Анхан шатны шүүхийн шүүгчдийн талаарх гомдлыг давж заалдах шатны шүүх болон шүүхийн даргад нь гаргаж болох бөгөөд бүх шүүгчдийн эсрэг гомдлыг Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гаргаж болно.

Сахилгын зөрчил шийдвэрлэх ажиллагааг сахилгын шийтгэлийг төлөвлөснөөр эхлүүлнэ. Дараах этгээдүүд сахилгын ажиллагааг эхлүүлэх эрх эдэлнэ. Үүнд:

- 1) Бүх шүүгчдийн эсрэг Дээд шүүхийн Ерөнхий шүүгч;
- 2) Бүх шүүгчдийн эсрэг Хуулийн дээд түшмэл;
- 3) анхан шатны шүүгчийн эсрэг давж заалдах шатны шүүхийн дарга
- 4) шүүхийн дарга нь тухайн шүүхийн бүх шүүгчдийн эсрэг;
- 5) Дээд шүүхийн зөвлөгөөнөөс Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн эсрэг.

Сахилгын ажиллагааг эхлүүлж буй этгээд нотлох баримтыг цуглуулж болох бөгөөд сахилгын хэргийг шийдвэрлэхэд шаардлагатай тайлбар өгөхийг шаардах эрхтэй. Сахилгын хэрэг эхлүүлсэн этгээд сахилгын шийтгэл болон бусад холбогдох материалыг Сахилгын Хороонд хүргүүлэх бөгөөд тус хорооноос сахилгын хэрэг эхлүүлсэн шүүгчид хуралдаан эхлэхээс 10 хоногийн өмнө мэдэгдэнэ. Шүүгч болон түүний өмгөөлөгч нь сахилгын шийтгэлтэй холбоотой материалыг шинжлэн судлах эрхтэй.

Шүүгчид холбогдох сахилгын хэргийг хэлэлцэхэд Сахилгын хорооны дарга нь Сахилгын хорооны гишүүдээс 5 гишүүнтэй бүрэлдэхүүнийг байгуулах бөгөөд үүнд Дээд шүүхийн 3 шүүгч, анхан болон давж заалдах шатны шүүгчдээс тус бүр 1 шүүгчийг оролцуулна. Дээд шүүхийн Сахилгын хорооноос шүүгчдийн сахилгын зөрчилтэй холбоотой хэрэг, маргааныг хянан хэлэлцэж, шүүгчдэд сахилгын шийтгэл оногдуулна. Сахилгын хорооны 5 гишүүдээс бүрдсэн бүрэлдэхүүн сахилгын хэрэг, маргааныг шүүхийн журмаар хянан хэлэлцэнэ.

Сахилгын хорооноос сахилгын хэргийг хэлэлцэхэд шүүгчийг албан тушаалаас түр хугацаагаар чөлөөлөх шийдвэр гаргаж болно. Ингэсэн тохиолдолд шүүгч болон шүүхийн даргад мэдэгдэнэ. Чөлөөлөх тухай шийдвэр гаргахад Сахилгын хороо нь шүүгчийн сахилгын зөрчлийн хэлбэр болон хүндрүүлэх нөхцөлийг авч үзнэ. Хэрэв шүүгчийн нөхцөл байдал нь шүүхийн нэр хүндэд ноцтойгоор халдах бол Сахилгын хорооноос сахилгын хэргийг хянан хэлэлцэх асуудлыг шийдвэрлэх хүртэл шүүгчийг албан үүргээс нь чөлөөлж болно. Хэрэв

²³⁴ Шүүхийн тухай хуулийн 87.2 дахь заалт

²³⁵ Timo Ligi, "Judicial Independence in Estonia", p.771.

шүүгчийн эсрэг сахилгын хэрэг үүсгэх үндэслэлгүй гэж үзвэл Сахилгын хорооноос гарсан шийдвэрийн дагуу шүүгч нь албан үүргээ үргэлжлүүлж болно.

Сахилгын хэргийг хэлэлцэхэд Сахилгын хорооны дарга нь даргалагч шүүгч байна. Сахилгын зөрчлийг нь хянан хэлэлцэж буй шүүгчийг Сахилгын хороонд ирүүлнэ. Шүүгч өмгөөлүүлж болно. Шаардлагатай бол гэрч болон бусад хүмүүсийг хуралдаанд ирүүлж болно. Сахилгын хорооны хуралдаан дээр даргалагч шүүгч сахилгын зөрчлийг танилцуулж, төлөвлөгдөж буй шийтгэлийг мэдээлнэ. Сахилгын хэрэгт буруутгагдаж буй шүүгч нь өөрийн хэрэгт мэдээлэл өгч, гэрч болон хуралдаанд оролцож буй бусад хүмүүсээс мэдүүлэг авна. Сахилгын хорооны гишүүд шүүгч, гэрч, бусад оролцогчдоос сахилгын шийтгэлтэй холбоотой асуулт тавьж болно. Нотлох баримтыг үнэлсний дараа сахилгын хэрэгт холбогдсон шүүгч өөрийн саналаа хэлэх эрхтэй. Сахилгын хорооны хуралдааны тэмдэглэлийг хөтөлнө.²³⁶ Хэрэв шүүгч буруутай гэдэг нь тогтоогдвол Сахилгын хорооноос шүүгчийг сахилгын зөрчил үйлдсэн буруутайд тооцож, сахилгын шийтгэл оногдуулна. Хэрэв шүүгч нь сахилгын зөрчлийг гаргаагүй бол Сахилгын хорооноос түүнийг цагаатгасан тогтоол гаргана. Сахилгын шийтгэл оногдуулсан шүүгч шийдвэрийг уншиж сонсгосноос хойш 30 хоногийн дотор Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд давж заалдах гомдол гаргаж болно.²³⁷

Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс Сахилгын хорооны шийдвэртэй холбоотой дараах шийдвэрийг гаргаж болно. Үүнд:

3. Шүүгчийг илүү хөнгөн сахилгын зөрчил гаргасан гэж үзэн шийдвэрийг өөрчилж, сахилгын шийтгэлийг хөнгөрүүлнэ;
4. Хэрэв шүүгч Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд давж заалдах гомдлыг гаргаагүй бол Сахилгын хорооны шийдвэр нь тодорхой хугацааны дараа хүчин төгөлдөр болно.

Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс Сахилгын хорооны шийдвэрийг давж заалдсан гомдолтой холбогдуулан гаргасан шийдвэр нь уншиж, сонсгосноор хүчин төгөлдөр болно. Эрүүгийн хэрэгт холбогдсон нь тогтоогдсон эсхүл Сахилгын хорооноос шүүгчийг огцруулах тухай шийдвэр хүчин төгөлдөр болсон бол энэ шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш шүүгчийн албанаас огцруулсан гэж тооцно.

3.4. Япон улс дахь шүүгчийн гомдол шийдвэрлэх ажиллагаа

Япон улсын Төрийн албан хаагчийн тухай хуулиар шүүгч нь төрийн тусгай албан хаагч болдог. Шүүгч нь “бүх нийтэд үйлчлэх бөгөөд түүний ажил нь ард түмнээс даалгаж өгсөн төрийн алба юм. Үүнээс хамаарч Төрийн албан хаагчийн тухай хуулиар шүүгчийн хөдөлмөрийн эрх, улс төрийн үйл ажиллагаанаас эхлээд бусад олон төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглосон байдаг. Түүнчлэн ердийн албан хаагчаас илүү өндөр шаардлага тавигддаг. Үүнээс хамаарч нэр хүндээ хамгаалах үүрэг ногддог бөгөөд төрийн албан хаагчийн итгэлд сэв суулгах, төрийн нийт албан хаагчийн нэр хүндийг гутаах үйлдэл хийж болохгүй ялангуяа шүүгч нь

²³⁶ Шүүхийн тухай хуулийн 96 дугаар зүйл

²³⁷ Шүүхийн тухай хуулийн 97 дугаар зүйл

төрийн тусгай албан хаагчийн хувьд шүүгчийн албан ажил цэвэр, шударга, тэгш байхыг шаарддаг учраас хэрэгт холбогдогчид үл итгэх итгэл төрүүлэх, жирийн иргэдийн зүгээс шүүмжлэлд өртөхөөр үйлдэл хийхгүй байх талаар биеэ цэгнэж байх ёстой” хэмээн тусгасан байдаг.²³⁸

Япон улсад манай улстай адил тусгайлсан Ёс зүйн дүрэм байхгүй. Учир нь Үндсэн хууль төрийн албан хаагчийг огцруулах явдал бол ард түмний эрх мэдэл гэдэг үзэл баримтлалыг тусгаж, шүүгчид хариуцлагыг хүлээлгэх гол үндэслэл нь иргэдийн шүүхэд итгэх итгэлийг алдагдуулсан, шүүхийн нэр хүндийг дордуулсан, шүүгч хүнд байх ёсгүй зохисгүй үйлдэл²³⁹ гэх зэргээр уян хатан чанартай зохицуулсан байна. Гэхдээ Шүүхийн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль зэрэгт шүүгчийн хориглох зүйлсыг заасан бөгөөд зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээнэ.

Япон улсад шүүгчийн хариуцлагыг зохицуулдаг 2 хууль үйлчилдгээрээ их онцлогтой байна. Нэг нь Шүүгчийн импичментийн тухай хууль²⁴⁰ бөгөөд энэ хууль нь шүүгчийг огцруулах журам, процессыг хуульчилсан байдаг. Уг хуулийн 2.1.1-т “мэргэжлийн болон албаны үүргээ ноцтой зөрчсөн эсвэл албаны үүрэгтээ ноцтой хайнга хандсан”, 2.1.2-т “албаны үүргээ биелүүлж байгаа эсэхээс үл хамааран, шүүгчийн хувьд нэр төрөө ноцтойгоор алдах зохисгүй үйлдэл хийсэн тохиолдолд” шүүгчийг огцруулна” гэжээ. Шүүгчийг огцруулах шийтгэл нь тухайн шүүгчийн эрх хэмжээг хүчингүй болгож байгаа тул шүүх эрх мэдлийн бие даасан байдалд халдах аюултай. Иймд энэ эрх хэмжээг Парламентын гишүүдээс бүрдсэн Гомдлын хороо болон Импичментийн шүүх хэрэгжүүлдэг. Зөвхөн Импичментийн шүүх шүүгчийг огцруулах бүрэн эрхтэй. Парламент нь шүүгчийн огцрох эсэх асуудлыг шийдвэрлэж буй нь Хууль тогтоох эрх мэдлээс шүүх эрх мэдэлд нөлөөлж байна гэсэн шүүмжлэл байдаг ч энэ тохиолдолд Парламентын гишүүдээс бүрдсэн байгууллага гэдэг нь ард түмний төлөөлөл гэдэг утгаар нь хүлээн зөвшөөрдөг байна. ажилладаг байна.

Харин шүүгчийн хариуцлагыг зохицуулдаг нөгөө хууль нь Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хууль бөгөөд тус хуулиар шүүгчдийг огцруулахаас бусад сахилгын шийтгэл оногдуулах тохиолдолд хэрэглэнэ. Тухайлбал: сануулах, торгууль зэрэг шийтгэл оногдуулахад дээд шатны шүүхийн шүүгчдийн зөвлөл доод шатны шүүхийн шүүгчид сахилгын шийтгэл оногдуулдаг тогтолцоо ажилладаг байна. Шүүгчийн зөрчил нь ноцтой хэмжээнд хүрээгүй эсхүл хөдөлмөрийн сахилга бат муу шүүгчийг заавал огцруулах шаардлагагүй гэж үзвэл шүүх дотроо шийдвэрлэх ёстой гэж үздэг байна. Энэ утгаараа бусад захиргааны байгууллагаас шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах асуудалд оролцохыг Үндсэн хуулиар хоригложээ.²⁴¹

(1) Шүүгчийн импичментийн тогтолцоо

²³⁸ Моригива Ясумото “Хуульчийн ёс зүй”, УБ, 340 дахь тал


²³⁹ Импичментийн шүүхийн цахим хуудас 弾劾裁判 <http://www.dangai.go.jp/intro/intro2.html>

²⁴⁰ Шүүгчийн импичментийн тухай хууль 裁判官弾劾法
<http://law.e-gov.go.jp/htmldata/S22/S22HO137.html>

²⁴¹ Үндсэн хуулийн 78 дугаар зүйл “Шүүхийн сахилгын шийтгэлийг Захиргааны байгууллага явуулж болохгүй” гэжээ. <http://law.e-gov.go.jp/htmldata/S21/S21KE000.html>

Япон улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлд “Парламент нь шүүгчийн огцруулах асуудлыг шийдвэрлэхдээ дээд ба доод танхимын гишүүдээс бүрдсэн Импичментийн шүүхийг байгуулна. Шүүгчийг огцруулах асуудлыг тусгай хуулиар зохицуулна” гэжээ. Парламентын тухай хуулийн 16 дугаар бүлэгт “Импичментийн шүүх”-ийн тухай зохицуулсан байх ба үүнд шүүгчийг огцруулах асуудлыг хоёр танхимыг төлөөлөх ижил тооны гишүүдээс бүрдсэн Импичментийн шүүхээр хэлэлцэж шийдвэрлэх, Импичментийн шүүхийн Ерөнхий шүүгчийг гишүүд нь сонгохыг зааж өгчээ. Харин Шүүгчийн импичментийн тухай хуулиар Импичментийн шүүх ба Гомдлын хорооны үйл ажиллагаа, бүрэлдэхүүн, чиг үүрэг, гомдол хянан шийдвэрлэх процессыг нарийвчлан зохицуулжээ. Гомдлын хороо ба Импичментийн шүүх нь Парламентын хуралдаан хаалттай үед ч гэсэн байнгын үйл ажиллагаагаа явуулдаг төрийн байгууллага юм. Ингээд Гомдлын хороо, Импичментийн шүүхийн тус бүрийг чиг үүрэг, уялдаа холбоог танилцуулъя.

Зураглал 3. Япон улс дахь Шүүгчийн гомдлын хороо болон Импичментийн шүүхийн тогтолцоо



Гомдлын хороо нь шүүгчид ирсэн гомдлыг хянан хэлэлцээд сахилгын хэрэг үүсгэх болон эс үүсгэх асуудлыг шийдвэрлэх эрхтэй. Гомдлын хорооны гишүүд нь

Парламентын дээд доод танхимаас тус бүр 10 гишүүн байхыг заажээ. Түүнчлэн орон тооны бус гишүүд нь дээд, доод танхимын гишүүдээс тус бүр 5 гишүүн байна. Бүрэн эрхийн хугацаа нь сонгогдсон бүрэн эрхийн хугацаатай ижил байх аж. Импичментийн шүүхийн шүүгч нь давхар Гомдлын хорооны гишүүн байж болохгүй байна.

Шүүгчийн тухай гомдол гаргах субъект нь иргэн, байгууллагаас гадна Дээд шүүх байж болдгоор онцлогтой. Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч нь өөрийн шүүхийн болон харьяалагдах анхан шатны шүүхийн шүүгчийг огцруулах шаардлагыг Дээд шүүхэд хандан гаргаж болно. Дээд шүүх нь шаардлагыг хянан үзээд хариуцлага тооцох нь зөв гэж үзвэл Гомдлын хороонд шаардлага гаргана.

Гомдлын хорооны ажлын алба нь шүүгчид гаргасан гомдолтой холбоотой судалгаа явуулна. Өөрөөр хэлбэл, тухайн хэрэгтэй холбоотойгоор гэрчтэй уулзах, шүүх хуралдааны бичлэгийг шаардаж авах, бусад судалгааг явуулах ба үүнийг хорооны гишүүн томилно. Хорооны гишүүн өөрөө шаардлагатай тохиолдолд томилолтоор явж шалгах эрхтэй. Хөөн хэлэлцэх хугацааны хувьд, шүүгч зөрчлийг үйлдсэнээс хойш 3 жил өнгөрвөл шүүгчийг огцруулах гомдол гаргаж болохгүй.²⁴²

Гомдлын хорооны хуралдаан хаалттай явагдана. Гомдлын хорооны гомдлыг хянан хэлэлцэх хуралдаанаас сахилгын хэрэг үүсгэх, хуралдааныг хойшлуулах, эсхүл хэрэг үүсгэхээс татгалзах гэсэн шийдвэрийн аль нэгийг гарна. Гомдлын хороо нь сахилгын хэрэг үүсгэхээр шийдвэрлэвэл Импичментийн шүүхэд өргөдөл гаргаж хэргийг шийдвэрлүүлдэг. Энэ утгаараа Гомдлын хороо нь нэг ёсондоо прокурорын шинжтэй байгууллага юм.


Харин Импичментийн шүүх нь дээд доод танхимын гишүүдээс тус бүр 7 гишүүн байхыг заажээ. Орон тооны бус гишүүд нь дээд, доод танхимын гишүүдээс тус бүр 4 гишүүн байна. Импичментийн шүүх нь Шүүгчийн импичментийн тухай хуульд заасан журмыг хатуу чанга баримтлахын зэрэгцээ зарим нарийн ажиллагаагаа “Импичментийн шүүхийн дүрэм”-ээр тогтоож өгдөг. Энэхүү дүрэмд зарим ажиллагааг Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тухай хуулиар зохицуулахаар заажээ.

Импичментийн шүүхэд шүүгчид сахилгын хэрэг үүсгэсэн өргөдөл ирсэн тохиолдолд нэн даруй тухайн шүүгчид хүргүүлнэ. Импичментийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх хуралдаанд шүүгч заавал оролцох шаардлагатай бөгөөд шүүгч хуралдаанд оролцож чадахгүй бол дахин хуралдааны товыг шинэчилнэ. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд шүүгч ирээгүй бол байлцуулахгүйгээр хуралдааныг явуулна. Түүнчлэн хуралдаанд Гомдлын хорооны дарга эсвэл аль нэг гишүүн заавал оролцож, хэрэг үүсгэсэн байр сууриа илэрхийлдэг. Хэрэг хянан шийдвэрлэх хуралдаан нээлттэй явагдах бөгөөд оролцогчид мэтгэлцэх зарчмыг баримтална.

Хуралдаан эхлэхэд, хуралдааны танхим доторх дэг журмыг Импичментийн Ерөнхий шүүгч хариуцна. Хуралдааны шийдвэр нь 10 гишүүнээс дээш байж хүчинтэй байдаг. Огцруулах шийтгэл авсан шүүгч нь тодорхой хугацааны дараа Импичментийн шүүхэд дахин хандан эрхээ сэргээлгэх боломжтой.

²⁴² Импичментийн шүүхийн тухай хууль 12.1

Зураглал 4. Япон улсын Импичментийн шүүхийн хуралдааны дэг



(2) Шүүгчийн ёс зүйн гомдол шийдвэрлэсэн байдал²⁴³

Япон улсын Гомдлын хороо болон Импичментийн шүүх байгуулагдсанаас хойш буюу 1948 оноос 2014 оны дуустал нийт 18017 гомдол хүлээж авснаас 9 гомдолд хэрэг үүсгэж, сахилгын шийтгэл оногдуулжээ. 1948-2014 оны хооронд гомдол, шаардлага гаргасан субъектыг авч үзвэл, Улсын дээд шүүхээс 8, өмгөөлөгч 2659, иргэн 893474 байжээ.

Түүнчлэн дээрх хугацаанд Гомдлын хорооны хянан хэлэлцсэн гомдол шаардлагын агуулгыг хэргийн ангиллаар нь авч үзвэл, иргэний хэрэг 64,2%, захиргааны хэрэг 7,6%, эрүүгийн хэрэг 18,9%, гэр бүлийн хэрэг 3,3%, бусад хэрэгтэй холбоотой гомдол 5,9% байжээ.

1948-2014 онд Гомдлын хорооны хуралдаанаар шүүгчийг огцруулах үндэслэлтэй гэж үзэн сахилгын хэрэг үүсгэсэн үндэслэлүүдийг авч үзвэл, Шүүгчийн импичментийн тухай хуулийн 2.1.1 дэх хэсэгт заасны дагуу “Мэргэжлийн болон албан үүргээ ноцтой зөрчсөн эсвэл албаны үүрэгтээ ноцтой хайнга хандсан” үндэслэлээр шийдвэрлэсэн хэрэг 94.5 хувийг эзэлж байгаа бөгөөд үүнд “илт хууль бус шийдвэр гаргасан” гэсэн үндэслэлээр 49.2 хувь, “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зөрчсөн” – 14.8 хувь, “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зүй бусаар явуулсан” – 9.2 хувь, “хурлын протоколд худал зүйл бичсэн” – 2.0 хувь, “үндэслэлгүйгээр хэрэг хойшлуулсан” – 2.3 хувь, “шийдвэр гардуулалтыг зүй бусаар хойшлуулсан” – 0.2 хувь, “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохих хяналт тавиагүй” – 3.5 хувь, “ шүүх хуралдааны бичлэгийг зохих ёсоор хадгалаагүй” – 0.5 хувь, “эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг зүй бусаар явуулсан” – 0.3 хувь, бусад – 9.6 хувь эзэлж байна. Харин тус хуулийн 2.1.2 дахь хэсэгт заасны дагуу “албаны үүргээ биелүүлж байгаа эсэхээс үл хамааран, шүүгчийн хувьд нэр төрөө ноцтойгоор алдах зохисгүй үйлдэл хийсэн тохиолдолд” гэдэг үндэслэлээр шийдвэрлэсэн хэрэг 5,5 хувийг эзэлж байна. Үүнд тухайлбал, олон нийтэд “хориотой мэдэгдэл, илтгэл” тавьсан гэх үндэслэлээр 2,6%, “албан тушаалаа урвуулан ашигласан” гэх үндэслэлээр 0,2, бусад үндэслэлээр 2,3% байна.

Дээрх сахилгын хэргүүдийг эцсийн байдлаар хянан шийдвэрлэж сахилгын шийтгэл оногдуулдаг Импичментийн шүүхийн нийт 9 шийдвэр байдаг аж.²⁴⁴ Үүнд: Осакагийн анхан шатны шүүхийн шүүгчид 2012 оны 11 сарын 13-нд Гомдлын хороо сахилгын хэрэг үүсгэж Импичментийн шүүх нь 2013 оны 4 сарын 10-нд огцруулах шийдвэр гаргажээ. Шүүгч нь метронд явж байгаа эмэгтэйн юбкан доогуур утсаа хийж бичлэг хийсэн нь баригдсан бөгөөд түүнийг “энэ үйлдэл нь эмэгтэй хүний бэлгийн халдашгүй байдалд муугаар нөлөөлсөн дордуулсан үйлдэл мөн бөгөөд энэ нь шүүгч хүнд байх ёстой хүний эрхийг дээдлэх, тэр тусмаа эмэгтэй хүний эрхийг дээдлэх ухамсар дутаж байгаагийн илрэл бөгөөд ард түмний шүүгчид итгэх итгэл болон хүндлэлийг алдагдуулсан хэрэг учраас Шүүгчийн импичментийн тухай хуулийн 2.1.2-т нийцэж байна” гэсэн үндэслэлээр огцруулжээ. Үцүномия хотын анхан шатны шүүхийн шүүгчийн мөн огцруулан шийдвэрлэжээ. Учир нь шүүгч нь “шүүхийн захиргааны ажилтанд хандан түүний үйлдлийг нь байнга хянаж байгаа гэж

²⁴³ Гомдлын хорооны цахим хуудас <http://www.sotsui.go.jp/data/index3.html>

²⁴⁴ Импичментийн шүүхийн цахим хуудас <http://www.dangai.go.jp/lib/index.html>

ойлгуулан, нэр төр, бэлгийн халдашгүй байдалд нь заналхийлсэн шинжтэй мэссэж, мэйл дахин дахин илгээсэн” байна. Үүнийг Импичментийн шүүх “Эрүүгийн хэрэг үйлдсэн үндэслэлээр хоригдож байгаа ч гэсэн энэ шүүхээр дамжихаас нааш шүүгчийн статус нь хэвээр байна. Тиймээс шүүгчийн уг үйлдэл нь ард түмний шүүхэд итгэл итгэлийг хөсөрдүүлсэн үйлдэл мөн учир Шүүгчийн импичментийн тухай хуулийн 2.1.2-т нийцүүлэн огцруулна” гэж шийдвэрлэсэн байна. Мөн Токиогийн анхан шатны шүүхийн шүүгчид холбогдуулан гарсан гомдлыг Гомдлын хороо хүлээн авч сахилгын хэрэг үүсгэн Импичментийн шүүхэд шилжүүлсэн ба шүүх нь тус ондоо шүүгчийг огцруулан шийдвэрлэжээ. Шүүгч нь “хариуцаж буй дампуурлын хэрэгтэй холбоотой оролцогчоос Гольфийн хэрэгслүүд бэлгэнд авсан” тул энэ нь “албан үүргийн болон ёс суртахууны хувьд байж боломжгүй явдал бөгөөд шүүхийн нэр хүндийг дордуулсан тул Шүүгчийн импичментийн тухай хуулийн 2.1.1, 2.1.2-т нийцэж байна” гэжээ.

(3) Шүүхийн дотоод хариуцлага

Шүүгч нь мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргасан ч гэсэн тэр нь огцруулах хүртэл ноцтой хэмжээнд хүрээгүй үед шүүх байгууллага дотроо сахилгын хариуцлага хүлээлгэдэг. Учир нь Үндсэн хуулийн 78 дугаар зүйлд “Шүүхийн сахилгын шийтгэлийг Захиргааны байгууллага явуулж болохгүй” гэжээ.

Шүүх дотроо сахилгын хэрэг шийдвэрлэх дүрмийг Дээд шүүх нь баталжээ. Дээд шүүхийн дотор Шүүхийн ажилтны ёс зүйн хороо гэж байх бөгөөд энэ нь Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, Дээд шүүхийн дүрэмд үндэслэн байгуулагдсан байдаг. Энэ хороо нь сахилгын хуралдааныг зохион байгуулах, доод шатны шүүхүүдэд сахилгын хуралдааны шийдвэрийг танилцуулах нийтлэх зэрэг ажлыг удирдан зохион байгуулдаг аж.

Шүүхийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд “шүүгч нь албан үүргээ зөрчиж, эсвэл албан үүрэгтэй хайнга хандсан, эсхүл зэрэг дэвийг нь буулгах үйлдэл, эс үйлдэл хийсэн тохиолдолд тусгай хуулиар зохицуулсан журмын дагуу сахилгын шийтгэл оногдуулна” гэжээ. Мөн энэ хуулийн 52 дугаар зүйлд шүүгчийн хориглох зүйлсийг дурдсан. Тухайлбал, “Парламент болон Нутгийн өөрөө удирдах байгууллагын гишүүн болж улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа эрхлэх, Дээд шүүхийн зөвшөөрөлгүйгээр, бусад шагналтай ажил хийх, бизнес эрхэлж, ашиг олох зорилготой өөр үйл ажиллагаа эрхлэх” нь хориотой ажээ. Эдгээрийг зөрчсөн шүүгчид хариуцлага оногдуулахад, тухайн шүүгчийг харьяалах дээд шатны шүүх нь сахилгын хэрэг үүсгэн хянан шийдвэрлэдэг байна. Шүүхийн захиргааны хянан шалгах харьяалал нь тухайлбал Дээд шүүх нь Дээд шүүхийн ажилтнууд болон доод шатны шүүхийн ажилтнуудыг хянах эрхтэй. Давж заалдах шатны шүүх нь өөрийн шүүхийн болон харьяалах доод шатны шүүхийн ажилтнуудыг хянах эрхтэй гэх мэт байна.

Харин сахилгын шийтгэл оногдуулах ажиллагааг Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хууль юм. Тус хуульд “Үндсэн хуульд заасны дагуу биеийн байдлын улмаас болон өөрийн хүсэлтээр шүүгчээс чөлөөлөгдөхийг хүссэн тохиолдолд” болон “шүүгчид сахилгын болон мэргэжлийн, ёс зүйн зөрчил, түүнчлэн хуулиар хориглогдсон үйлдлийг хийсэн тохиолдолд сахилгын шийтгэл оногдуулах

тохиолдолд” уг хуулийг хэрэглэхийг зөвшөөрчээ. Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуулиар шүүгчийн сахилгын шийтгэлийн төрөл нь сануулах болон 10000 иэнээс дээшгүй торгууль байна гэж тогтоосон.

Давж заалдах шүүх өөрийн харьяалах шүүгчийн асуудлыг шийдвэрлэхдээ, 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй комисс, Дээд шүүхийн хувьд Их суудлын хуралдаанаар шийдвэрлэнэ. Хуралдаанаар бодит байдал болон нотлох баримтыг үндэслэлтэй бичих хэрэгтэй. Түүнчлэн тухайн шүүгчээс нь заавал тайлбарыг нь сонсох хэрэгтэй байдаг аж. 2001 онд нэгэн шүүгч улс төрийн шинжтэй мэдэгдэл хийсэн учир Улсын дээд шүүхийн бүрэлдэхүүний хурлаар авч хэлэлцэн, сануулах сахилгын шийтгэл оногдуулсан тохиолдол байна²⁴⁵.

Дүгнэлт

Шүүгчийн ёс зүйн гомдлыг хянан шийдвэрлэх харилцааг Шүүхийн захиргааны тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн ёс зүйн дүрэм болон Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм гэх эрх зүйн актад тулгуурлан зохицуулж байгаа нь зарим талаар хоорондоо зөрчилдөх байдлыг үүсгэж байна. Эдгээрээс шүүгчийн ёс зүйн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг нарийвчлан зохицуулж буй нь Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм бөгөөд хэрэгжүүлэгч нь ШЕЗХ юм.

Шүүгчийн ёс зүйн асуудлаарх хууль тогтоомж болон дүрмийн зохицуулалтыг нэг мөр болгох шаардлагатай байна. Учир нь Шүүхийн ёс зүйн дүрэм болон Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм нь хооронд зөрчилтэй зохицуулалтууд цөөнгүй байгаагаас гадна эдгээр дүрмүүд нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хуультай зөрчилдсөн, утга агуулгын уялдаа холбоогүй заалтууд их байгаа нь ШЕЗХ-ны үйл ажиллагаа саатах, доголдох нөхцөлийг бүрдүүлж байна. (Түүнчлэн ШЕЗХД-ийн зарим зүйл заалт, утга агуулгын хувьд ойлгомжгүй, харилцаагаа бүрэн зохицуулж чадахгүй байгаа нь энэхүү дүрмийг шинэчлэн найруулах, эсхүл нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй болсныг харууллаа). Энэ нь Шүүгчийн ёс зүйн дүрмийг баталдаг субъект болон Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийг баталдаг субъект нь өөр байгаагаас үүдэлтэй байж болох юм. Тэгвэл яаж энэ 2 субъектын үйл ажиллагааг уялдуулах, хоорондын зөрчлийг хэрхэн арилгах талаар эргэн харах цаг болжээ.

Харин Шүүхийн ёс зүйн хорооны гомдол шийдвэрлэж буй ажиллагааны хувьд хэд хэд хэдэн асуудал байна. Тухайлбал, өмнөх тогтолцоонд шүүгчийн ёс зүйн асуудлыг шүүгчид хянан шийдвэрлэдэг байсныг болиулж, ШЕЗХ-ны бүрэлдэхүүнд шүүгч, прокурор орохыг хориглож хөндлөнгийн шинжтэй ёс зүйн хороог бүрдүүлэхийг зорьсон. Гэвч ШЕЗХ-ны шийдвэрийг давж заалдах боломжтой болгосноор ШЕЗХ-ны сахилгын шийтгэл оногдуулсан шийдвэрийг бүгдийг хүчингүй болгож, харин сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан шийдвэрүүдийг хэвээр үлдээжээ. Нөгөө талаар, ШЕЗХ-ны шийдвэрийн эрх зүйн үр нөлөө нь багасч, бие даасан байдал нь үгүйсгэгдэж байгааг харуулж байна. Иймд ШЕЗХ-ны шийдвэрийг давж заалдаж буй тогтолцоог эргэн харж үзэх, боломжит шинэ хувилбарыг бодох цаг

²⁴⁵ Шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан шүүгчдийн зөвлөлийн тогтоол
<https://www.eda-jp.com/satsuki/2001/fukuoka/010330.html>

болжээ. Хэрэв ШЁЗХ-ны шийдвэрийг эцсийн шийдвэр болгох нь зүйтэй гэж үзвэл ШЁЗХ-ны процессын алдаатай шийдвэр гаргавал, хуулийг буруу тайлбарлан хэрэглэвэл, мөн түүнчлэн хүний шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх эрхийг хэрхэх вэ гэдэг асуудал гарч ирнэ.

Гэвч нөгөө талаар, ШЁЗХ-ны үйл ажиллагаа нь доголдолтой байгааг бас үгүйсгэх боломжгүй. (Тухайлбал, ШЁЗХ-ны бүрэлдэхүүнд эрдэмтэн судлаачид орно гэж заасан атлаа төрийн захиргааны байгууллагын удирдах ажилтан орсон байх нь хэр зохилтой вэ?) Шүүх эрх мэдлийн хараат бус байдлын үүднээс, гүйцэтгэх эрх мэдлийн салаа мөчир болох төрийн захиргааны байгууллагын ажилтан шүүгчийн эрх зүйн байдалд нөлөөлөх нь хэр зохистой вэ гэдэг асуудал үүснэ. Иймд “эрдэмтэн, судлаачид” гэдэгт хэнийг ойлгох талаар тодорхой тайлбарлан, төрийн захиргааны байгууллагын ажилтан орохыг хориглох нь зүйтэй байна.

Түүнчлэн, ШЁЗХ-ны чиг үүрэгтэй холбогдуулан, “хянан шалгах” чиг үүрэг нь хязгаарлагдмал байгаа нь шүүгчийн ёс зүйн зөрчлийг илрүүлэх, нотлох баримт цуглуулах, үнэлж дүгнэхэд нөлөөлж байна. Тухайлбал, ШЁЗХ нь нотлох баримтыг бие даан цуглуулахаас илүүтэй оролцогчдын гаргаж өгсөн нотлох баримт дээр тулгуурлаж дүгнэлт хийх, шүүх хуралдаан дээр гомдол гаргагч, шүүгч 2 нь тэгш эрхтэйгээр оролцох зэрэг нь “иргэний хэрэг хянан шийдвэрлэх” ажиллагаатай төстэй байдаг. Гэтэл гомдол гаргагч нь шүүгч гэх тусгай субъектын эсрэг гомдол гаргаж, шүүгчийн ёс зүйн зөрчлийг илрүүлэхийг шаардаж буй нь иргэн хоорондын маргааныг шийдвэрлэдэг шүүхээс өөр харилцаа гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, шүүгчийн ёс зүйн гомдол шийдвэрлэх ажиллагааны зорилго нь гомдлын дагуу “шүүгчийн ёс зүйн зөрчлийг илрүүлэн хянан шийдвэрлэх” болохоос “шүүгч, иргэн хоёрын маргааныг таслан шийдвэрлэх” ажиллагаа бус юм. Иймд ШЁЗХ-ны “хянан шалгах” чиг үүргийг өргөжүүлэх, гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмыг тодорхойлох шаардлагатай байна.

Мөн шүүгчийн сахилгын шийтгэлийн зорилго нь шүүгчийг шийтгэхдээ бус шүүгчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг багасгах байдаг учраас уян хатан чанартай байх нь чухал. Гэтэл Монгол Улсад “огцруулах” шийтгэл оногдуулсан шүүгч нь тодорхой хугацааны дараа эрхээ сэргээлгэх боломжийг зохицуулж өгөөгүй байна. Иймд эрхээ сэргээлгэх боломжийг мөн баталгаажуулж өгөх шаардлагатай байна. Ингээд судалгааны үр дүнд тулгуурлан дараах саналыг дэвшүүлж байна.

Санал, зөвлөмж

1. Хэм хэмжээний зөрчилдөөнийг арилгах

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль хийгээд Шүүхийн захиргааны тухай хууль дахь Шүүхийн ёс зүйн хорооны тухай зохицуулалт, шүүгчийн ёс зүйн асуудлын тухай зохицуулалт болон Шүүгчийн ёс зүйн дүрэм, Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн зөрчилдөөнийг арилгаж, нэмэлт өөрчлөлт оруулах.

2. Шүүхийн ёс зүйн хорооны бүрэлдэхүүн, чиг үүргийг шинэчлэх

Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд төрийн захиргааны албан тушаалтан орохыг хориглох.

Хуульч, эрдэмтэн, судлаачдын төлөөллийн тоог шинэчлэх

3. Шүүхийн ёс зүйн хорооны хянан шалгах чиг үүргийг өргөжүүлэх

Ёс зүйн хороо нь шүүгчид сахилгын хэрэг үүсгэх үндэслэл байгаа гэж үзвэл холбогдох шалтгаан, нөхцөлийг судлах үүрэгтэй. Шаардлагатай судалгааг хийлгэхийг ажилтанд даалгаж, даалгавар авсан ажилтан нь тухайн судалгаагаар холбогдуулан гэрчийг олох, мэдүүлэг болон тэмдэглэл, бичлэгийг цуглуулах эрх хэмжээтэй байх. Зардлыг Ёс зүйн хорооноос гаргах. (Одоо байгаа хянан шалгагч референт нь нотлох баримт цуглуулах, гэрчийн мэдүүлэг авах зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх мэргэшил, ур чадварт нийцэх эсэх нь эргэлзээтэй байна.)

Аливаа иргэн, байгууллага, албан тушаалтан нь Ёс зүйн хорооны тусгай ажилтны шаардсан бичлэг, хураагуур, мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй болгох.

4. Шүүхийн ёс зүйн хорооны гишүүний баримтлах ёс зүй

Ёс зүйн хорооны гишүүд нь Ёс зүйн дүрмийн хэм хэмжээг баримтлах үүрэгтэй болохыг тусгаж өгөх, эсхүл Ёс зүйн хорооны гишүүний ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх

5. Ёс зүйн гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг илүү тодорхой болгох

Ёс зүйн гомдол хянан шийдвэрлэх зарим ажиллагаанд нотлох баримт цуглуулах, хэрэг үүсгэх, хуралдааны дэг гэх зэрэгт бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан хуулийн зүйл, зарчмыг төсөөтэй хэрэглэж болох асуудлыг судлах.

6. Ёс зүйн хорооны шийдвэрийг шүүхэд давж заалдах тогтолцоог өөрчлөх, шинэ тогтолцоог нэвтрүүлэх

Шүүхийн ёс зүйн хорооны шийдвэр эцсийнх байх уу, эсхүл давж заалдаж болох эсэх, Шүүхийн ёс зүйн хорооны эрх зүйн байдлыг тодорхой болгох талаар шинэ хувилбарыг дэвшүүлэх.

7. Огцруулах шийтгэл оногдуулсан шүүгчийн эрх сэргээгдэх боломжийг хуульчлах

Ёс зүйн хорооны шийдвэрээр огцорсон шүүгч нь тодорхой хугацааны дараа дахин шүүгчийн эрхээ сэргээж болохоор зохицуулах.

8. Хөөн хэлэлцэх хугацааны өөрчлөлтийг хийх

Хөөн хэлэлцэх хугацааны нийтлэг журмын тухай зохицуулалт нэмэх, мөн хөөн хэлэлцэх хугацааг уртасгах

-оОо-

**ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ТОГТОЛЦООГ ОНОВЧТОЙ
БҮРДҮҮЛЭХ НЬ²⁴⁶****Удиртгал**

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн төлөөллийг оролцуулах нь шүүхийн ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс тавих хяналтыг сайжруулах, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зэрэг олон чухал ач холбогдолтой. Иргэд өөрсдөө шүүн таслах ажиллагаанд оролцох нь бидний бий болгохыг зорьж буй “эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно”²⁴⁷ гэсэн зорилготой нийцэх томоохон алхам юм. Үүнийг улам бүр тодотгож Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна.”²⁴⁸ хэмээн шүүн таслах ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах боломжийг олгожээ. Эндээс бид Үндсэн хуулиар иргэдийн төлөөлөгчдийг хэрхэн оролцуулах журмыг тогтоохыг хууль тогтоогчдод үлдээжээ гэдгийг харж болно.²⁴⁹ Иймд Улсын Их Хурал Үндсэн хуулийн үзэл санааны хүрээнд иргэдийг хэрхэн үр нөлөөтэй, бодитойгоор шүүн таслах ажиллагаанд оролцуулах тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх боломжтой юм.

Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах нь Монгол Улсын хувьд шинэ ойлголт биш юм. Тодруулбал, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгч оролцуулах, шүүн таслах ажиллагаанд шийдвэр гаргах эрхтэй оролцох тогтолцоог хэрэгжүүлж байжээ. Энэ нь зөвхөн анхан шатны шүүхүүд бус давж заалдах болон хяналтын шатны шүүх дээр хэрэг шийдвэрлэхэд иргэдийн оролцоотой шийдвэр гаргадаг байсан байна. Энэ тухай 1960 оны Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлд “Бүх шатны шүүхэд хэрэг шүүн таслах явдлыг хэрэв хуульд зориуд тусгайлан заагаагүй бол ардын төлөөлөгчдийг оролцуулан байнгын шүүгч нар гүйцэтгэнэ”²⁵⁰ гэснээс харж болно.

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх хэмжээ, оролцох хэлбэр болон зохион байгуулалтыг нарийвчлан зохицуулах, иргэдийн төлөөлөгчийн оролцоог баталгаажуулах, улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалыг бодит байдлаар хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий байх зохицуулалтуудыг агуулсан “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай” анхны бие даасан хуулийг 2012 онд баталсан. Гэвч тус хуулийн “хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд шүүх бүрэлдэхүүнд оролцох” гэсэн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс иргэн шүүх хуралдаанд оролцож шийдвэр гаргах нь

²⁴⁶ Тус судалгааны ажлыг ШСМСХ-ийн судалгаа хариуцсан референт Т.Түмэнцэцэг, судлаач Л.Галбаатар нар хамтран гүйцэтгэсэн болно.

²⁴⁷ Монгол Улсын Үндсэн Хууль, 1992, “Төрийн мэдээлэл” №1

²⁴⁸ Монгол Улсын Үндсэн Хууль, 1992, “Төрийн мэдээлэл” №1

²⁴⁹ УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч, УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин 2013.08.28-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбар.

²⁵⁰ Ред.Б.Баярсайхан, Д.Баянбилэг, “Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл”, Тавдугаар боть. 2010 он, Улаанбаатар, 164 дэх тал

мэргэжлийн шүүгчийн хууль хэрэглэх, эрх зүйн шийдвэр гаргах, шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож байна ²⁵¹ хэмээн тайлбарлаж, хүчингүй болгосон юм.

Судалгааны зорилго

1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлал болсон “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна” гэсний дагуу 2002 онд баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь иргэдийн төлөөлөгчийн оролцооны талаар зохицуулсан. Гэвч Монгол Улсын шүүхийн 2014 оны сонгомол шийдвэрт хийсэн судалгаанаас ²⁵² харахад шүүх хуралдаан дээр гаргасан иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг тусгасан шүүхийн шийдвэр 4 байгаа нь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт шүүхийн шийдвэрт нөлөөлдөг эсэх, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс түүнийг хэрэгт ач холбогдол бүхий гэж дүгнэдэг эсэхэд эргэлзэхэд хүргэж байна.

Иймд “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцоог оновчтой бүрдүүлэх нь” сэдэвт бодлогын судалгааны хүрээнд Монгол Улсын шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоог бэхжүүлэх, үр нөлөөг нэмэгдүүлэхэд бусад улсын сайн туршлагад тулгуурлан хэрэгжүүлэх бодлогын хувилбар дэвшүүлэхийг зорилоо.

Тайлангийн бүтэц

Судалгааны ажлыг “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн зохицуулалт”, “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдал”, “Гадаадын зарим улс дахь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцооны хэлбэрүүд” гэсэн гурван бүлэгт ангилж, Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, түүхэн уламжлал, өнөөгийн нөхцөл байдал, шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах процесс, эрх үүргийн харилцан уялдаа, дүгнэлтийг агуулга, ач холбогдол, хүлээлгэх хариуцлага гэсэн дэд сэдвүүдэд ангилан авч үзэж, ХБНГУ, Япон, АНУ, БНСУ, ОХУ, Тайвань зэрэг улс орнуудын шүүн таслах ажиллагаа дахь иргэдийн оролцооны хэлбэрийг судлаж, санал, зөвлөмж дэвшүүлэв.

Нэг. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн зохицуулалт, эрх зүйн байдал

1.1. Эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал

Иргэд шүүн таслах ажиллагаанд оролцож хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх тухай ойлголт нь Английн Эзэнт гүрний үеэс үүсэлтэй бөгөөд колони байсан улс орнууд уг тогтолцоог бүрэн болон хэсэгчлэн нутагшуулан авахдаа

²⁵¹ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол, 2014.01.08, №01

²⁵² ШЕЗ-ийн дэргэдэх ШСМСХ-ээс эрхлэн бэлтгэсэн “Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл-I боть” эмхэтгэлд эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн нийт 390 шийдвэрээс зохих үнэлгээ хийсний үндсэн дээр хэрэг, маргааны чиглэлээр анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрээс эхний 10-т орсон шийдвэрийг сонгон нийт 77 шийдвэрийг оруулсан.

иргэдийн оролцоотой шүүхийн агуулгыг авч үлджээ. Тухайн үед газрын маргаан ихээр гарч байсан бөгөөд зөвхөн эзэн хаанаас томилогдсон эрх бүхий шийдвэр гаргагч хэт нэг талыг барьсан шийдвэр гаргах тохиолдол цөөнгүй байсан тул иргэд өөрсдийн оролцоотойгоор маргааныг шийдвэрлэх нь илүү шударга ёсонд нийцсэн шийдвэр байсан тул уг тогтолцоог өргөн хүрээнд хүлээн зөвшөөрч, цаг хугацааны явцад зарим нэг өөрчлөлт, шинэчлэлт орсоор өнөөг хүрчээ.

Монгол Улсын хувьд ч иргэдийн төлөөллийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах туршлага зөвхөн ардчилал хөгжсөн өнөө үед яригдаж буй сэдэв биш юм. Өмнө нь БНМАУ-ын аливаа шүүх таслах газруудыг байгуулах дүрэм /1926.04.16/-ийн 1.1-т “Хошуудын жинхэнэ ардын шүүх таслах газруудад аливаа хэргийг нэг түшмэл ба ард олноор сонгосон хоёр төлөөлөгчөөр шийтгүүлбэл зохино”²⁵³ гэснээс хэрэг, маргааныг зөвхөн мэргэшсэн шүүгч бус иргэдийн оролцоотой шийдвэрлэдэг байсан нь харагдана. Үүнээс гадна 1940 оны Үндсэн хуулийн 50 дугаар зүйлд уг зохицуулалтыг бататгаж, “Аливаа шүүх таслах газруудаас хэргийг таслахдаа хэрэв хуульд зориуд заасан хэрэг биш бол байнга суух шүүн таслагчаас ардын төлөөлөгчийг оролцуулан гүйцэтгэж байх”²⁵⁴ гээд 1960 оны Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлд “Бүх шатны шүүхэд хэрэг шүүн таслах явдлыг хэрэв хуульд зориуд тусгайлан заагаагүй бол ардын төлөөлөгчдийг оролцуулан байнгын шүүгч нар гүйцэтгэнэ”²⁵⁵ гэсэн байна. Эндээс Монгол Улс шүүн таслах ажиллагаанд иргэдийг оролцуулж, шийдвэр гаргах боломжийг олгодог байсан түүхэн уламжлалыг харж болох юм.

Харин 1994 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн 16 дугаар зүйлд “Шүүх анхан шатны журмаар эрүүгийн онц хүнд гэмт хэргийг хамтран хянан шийдвэрлэхэд 3, хүнд гэмт хэргийг хамтран хянан шийдвэрлэхэд 2, бусад гэмт хэргийг хамтран хянан шийдвэрлэхэд 1 иргэдийн төлөөлөгчийг оролцуулна”²⁵⁶ гэсэн нь иргэдийн төлөөлөгчийн оролцоог тусгайлан заасан зохицуулалт байсан. Гэвч тус хуулийн 49 дүгээр зүйлд иргэдийн төлөөлөгчийн эрх, үүргийг тодорхойлохдоо “Иргэдийн төлөөлөгч хэргийн материалтай танилцах, түүнээс хэрэгцээтэй зүйлийг тэмдэглэж авах, шүүхийн байцаалтад оролцож, шүүгдэгч, хохирогч, гэрч, шинжээчид асуулт тавих, нэмэлт нотлох баримтыг судлах талаар хүсэлт тавих, шүүх хуралдааны протоколтой танилцах, түүнд засвар оруулах хүсэлт гаргах, шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл давж заалдах гомдол гаргах эрхтэй. Иргэдийн төлөөлөгч өөрийн дотоод итгэл, эрхийн ухамсрыг үндэслэн шүүх хуралдаан дээр шинжлэн судалсан бүх нотлох баримтыг үнэлж, хэргийн бүх байдлыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь судалж үзсэний үндсэн дээр шүүгдэгч гэм буруутай эсэх талаар

²⁵³ Б.Баярсайхан, Д.Баянбилэг /ред/, “Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл”, Хоёрдугаар боть. Улаанбаатар, 2010 он, 611 дэх тал

²⁵⁴ Б.Баярсайхан, Д.Баянбилэг /ред/, “Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл”, Дөрөвдүгээр боть. Улаанбаатар, 2010 он, 63 дахь тал

²⁵⁵ Б.Баярсайхан, Д.Баянбилэг /ред/, “Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл”, Тавдугаар боть. Улаанбаатар, 2010 он, 164 дэх тал

²⁵⁶ Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 1994, “Төрийн мэдээлэл” №5

дүгнэлтээ бичгээр өгөх үүрэгтэй. Иргэдийн төлөөлөгч эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар дүгнэлтээ бичгээр гаргах боломжгүй бол энэ талаар шүүх хуралдааны протоколд тэмдэглүүлж дүгнэлтээ амаар гаргаж болно”²⁵⁷ гэсэн нь иргэдийн төлөөлөл шүүх хуралдаанд шүүн таслах эрхтэй оролцох бус зөвхөн гэм буруутай эсэх талаар дүгнэлт гаргах, дүгнэлтээ уншиж сонсох төдий байхаар зохицуулалт болж шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоог хязгаарлах хандлагыг бий болгожээ.

1.2. Монгол Улсын өнөөгийн эрх зүйн зохицуулалт

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна”,²⁵⁸ 2012 оны Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ ил тод байдал, шударга ёс, олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор иргэдийн төлөөлөгчийг хуульд заасан журмын дагуу оролцуулах бөгөөд иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно”²⁵⁹ гэсэн зохицуулалтууд нь шүүх хэрэг, маргааныг иргэдийн төлөөлөгчтэй хамтран шийдвэрлэх, харин ямар байдлаар оролцуулах нь хууль тогтоогчийн эрх хэмжээний асуудал гэж үзэж болохоор байна. Тодруулбал, шүүн таслах ажиллагаанд иргэдийн төлөөлөгчид оролцох нь төрийн нэг чухал эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хүн амын “суверенит” илрэх нэг хэлбэр юм.²⁶⁰ Иймээс ардчилсан улс орнууд иргэдийн оролцоотой шийдвэр гаргахыг илүүд чухалчлан үзэж байна.

Энэ үүднээс 2012 онд батлагдсан “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль”-иар иргэд шүүх хуралдаанд шийдвэр гаргах эрхтэй байхаар зохицуулсан боловч түүний “хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд шүүх бүрэлдэхүүнд оролцох” гэсэн гол агуулгыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс иргэн шүүх хуралдаанд оролцож шийдвэр гаргах нь мэргэжлийн шүүгчийн хууль хэрэглэх, эрх зүйн шийдвэр гаргах, шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож байна гэж үзэн холбогдох заалтуудыг хүчингүй болгосон.²⁶¹ Иймд шүүхийн иргэдийн төлөөлөгч нь өнөөгийн нөхцөлд шийдвэр гаргах бус, өмнө хэрэгжиж байсны адил “идэвхгүй” хэлбэрээр оролцсон хэвээр үлдэж байна.

Иргэдийн төлөөлөгч шүүх бүрэлдэхүүнд орох нь шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлж буй хэлбэр бус шүүгч, иргэдийн төлөөлөгч нар хамтран тухайн хэрэг, маргааныг шийдвэрлэх асуудал юм. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд

²⁵⁷ Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 1994, “Төрийн мэдээлэл” №5

²⁵⁸ Монгол Улсын Үндсэн хууль, 1992, “Төрийн мэдээлэл” №1

²⁵⁹ Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 2012, “Төрийн мэдээлэл” №11

²⁶⁰ Ханнс-Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи, “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар”, 2009 он, Улаанбаатар, 243 дахь тал

²⁶¹ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоол, 2014.01.08, №01

хөндлөнгөөс оролцож болохгүй” гэсэн агуулгыг хөндлөнгөөс оролцож байна гэж үзсэн нь зөв бус тайлбар болжээ. Харин Шүүхийн тухай хуульд зааснаар “шүүхийн бүрэлдэхүүн гэдэгт шүүгч, Ерөнхий шүүгч”-ийг хамруулсан нь хуулийн уг агуулгатай илүү зөрчилдсөн байна.

Ингээд шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх хэмжээ, оролцох хэлбэр болон зохион байгуулалтыг илүү нарийвчлан зохицуулсан, иргэдийн төлөөлөгчийн оролцоог баталгаажуулахыг зорьсон “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хууль”-ийн зарим гол шинэлэг зохицуулалтыг танилцуулъя.

- *Иргэд өөрсдийн хүсэлтийн дагуу шүүх хуралдаанд оролцох эрх нээлттэй болсон.*

Шүүхийн иргэдийн төлөөлөгч гэхээр ахмад настай иргэн байдаг гэсэн хандлага өөрчлөгдсөн. Тухайн анхан шатны шүүхийн харьяаллын нутаг дэвсгэрт оршин суудаг, 25 насанд хүрсэн, ял шийтгүүлж байгаагүй, сонгогдсон үедээ эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн оролцогч биш, монгол хэлээр чөлөөтэй ярьж, ойлгодог Монгол Улсын иргэн хэн боловч оролцох боломжтой. Энэ нь иргэдийн эрх зүйн мэдлэгийн нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдолтой юм.

- *Иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах тогтолцоог бий болгосон.*

Өмнө нь шүүхийн ажилтан мэт хэдхэн хүн байнга шүүх хуралдаанд оролцдог байсан хэлбэрийн төдий байдлыг арилгаж, орон нутгийн иргэд өөрсдөө оролцох боломж бүхий сонгон шалгуулах тогтолцоо бий болсон. Ингэхдээ тухайн орон нутгийн хүн амын тоог үндэслэн баталсан жишиг тоог харгалзан иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг тухайн орон нутгийн анхан шатны шүүхийн тамгын газар нутгийн захиргааны байгууллагатай хамтран гаргана. Уг иргэдийн нэрсийн жагсаалтаар мэдээллийн сан бүрдүүлж, улмаар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс иргэдийн төлөөлөгчдийн нэрсийн жагсаалтыг баталдаг. Нэрсийн жагсаалтад нэр нь орсон иргэдээс сонгон шалгаруулахдаа долоо хоног тутам 10-15 хүний нэрсийн дэд жагсаалтыг цахим хэлбэрээр тохиолдлын журмаар гарган тухайн шүүхийн тамгын газрын дарга батална. Дэд жагсаалтад нэр орсон нэг, нөөцөд бүртгүүлсэн хоёр иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаан тус бүрд сугалаагаар хуваарилна.

- *Иргэдийн төлөөлөгчийн хараат бус байдлыг хуульчилж өгсөн.*

Шүүгч, прокурор, өмгөөлөгчийн хувьд хараат бус байх тухай асуудал өмнө яригддаг байсан бол иргэдийн төлөөлөгчийн хараат бус байдалд нөлөөлөх аливаа хэлбэрийг хуулиар хориглосон. Хэрэв иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд нөлөөлөхийг оролдсон үйлдэл хийвэл нөлөөллийн мэдүүлэг бөглөнө. Иймд аливаа хөндлөнгийн нөлөөнд орохоос урьдчилан сэргийлэх үүднээс сонгон шалгаруулсан иргэдийн төлөөлөгчийн нэрсийг шүүгч, шүүхийн ажилтан шүүх хуралдаанаас өмнө задруулахыг хориглосон байна.

- *Иргэдийн төлөөлөгчийн ажиллах нөхцөл, хөлс олгох журмыг шинэчлэн баталсан.*

Шүүхийн иргэдийн төлөөлөгчид хөлс олгох журмыг ШЕЗ, Сангийн сайд хамтран баталсан юм. Хэдийгээр шүүхийн иргэдийн төлөөлөгчид олгох 1 цагийн хөлсний хэмжээ бага боловч анх удаа иргэдийн төлөөлөгчид олгох хөлсний хэмжээг журмаар зохицуулсан. Ийнхүү багаар тогтоосон явдал нь иргэдийн төлөөлөгч эцсийн шийдвэр гаргах эрх хэмжээ, чиг үүрэг байхгүй байгаатай холбоотой байна.²⁶² Нөгөө талаас иргэдийг шүүх хуралдаанд оролцохдоо хэргийн материалтай танилцах, нотлох баримт шинжлэн судлахад оролцох, гэрч, шинжээчээс асуулт асуух зэрэг эрхийг хэрэгжүүлдэг тул тэдэнд шаардлагатай ажиллах нөхцөл, баталгааг гаргаж өгөх нь зүйтэй.

Ийнхүү Монгол Улсад анх удаа шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг зохицуулсан бие даасан хуулийг баталсан боловч хуулийн амин сүнс болсон “шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгч оролцох” гэсэн агуулгыг хүчингүй болгосон тул эргэн “хэлбэр”-ийн төдий, үр нөлөө багатай тогтолцоо хэвээр хэрэгжиж байна. Цаашид шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцооны асуудлыг дан ганц бие даасан хуулиар зохицуулах боломжгүй тул шүүхийн тогтолцоо, үйл ажиллагааны хэлбэрийн асуудлыг өргөн хүрээнд авч үзэж, иргэдийн төлөөлөгчийн эрх хэмжээ, чиг үүргийг тодорхойлох шаардлагатай. Нэгэнт “шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгч оролцох” гэсэн зохицуулалт хэрэгжих боломжгүй тул одоогийн хэрэгжиж буй тогтолцоог хэрхэн үр нөлөөтэй болгох, улмаар шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавихад анхаарах асуудлын талаар судлах шаардлагатай буй болсныг харуулж байна.

1.3. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах үйл явц

“Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль”-д зааснаар иргэдийн төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сонгон шалгаруулалтын үндсэн дээр сонгогдон оролцоно. Гэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулиудад томилох зохицуулалт хэвээр байгаа нь хэм хэмжээний зөрчилдөөнийг бий болгожээ.²⁶³ Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн сонгон шалгаруулах тухай асуудал нь шүүгч болон шүүхийн захиргааны байгууллагаас хараат бус, тохиолдлын журмаар сонгон шалгаруулах тухай асуудал юм. Харин

²⁶² Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар шүүхийн иргэдийн төлөөлөгчид олгох хөлсний асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран 2015.05.06-ны өдөр баталсан. Шүүхийн иргэдийн төлөөлөгчид хөлс олгох журмын 2.1-т “Иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон ажилласан иргэний шүүхэд ажилласан 1 цагийн хөлсийг нэг цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож, шүүх хуралдаан дууссаны дараа бэлнээр болон бэлэн бусаар олгоно” гэжээ. Харин Хөдөлмөр, Нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2013.04.11-ний өдрийн 07 тоот тогтоолд “Тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардах энгийн ажилд хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж байгаа ажилтны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэг цагт 1142 төгрөг 85 мөнгө байх”-аар шинэчлэн тогтоожээ.

²⁶³ Хавсралт №1-ээс үзнэ үү

томилох зохицуулалт нь аль хэрэг, маргаанд хэн гэдэг иргэнийг оролцуулах асуудлыг шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэн шийдвэрлэх юм. Гэхдээ хууль хэрэглээний хувьд хэм хэмжээнүүд хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэх юм.

Сонгон шалгаруулах зохицуулалтын хувьд Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 8.6-д заасан иргэдийн төлөөлөгчийн нэрсийн нэгдсэн жагсаалтаас иргэдийн төлөөлөгчийн сонгон шалгаруулах ажлыг тухайн шүүхийн тамгын газар зохион байгуулна” гээд Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг баталж, харин шүүх хуралдаанд сонгон оролцуулах асуудлыг тухайн шүүхийн тамгын газар зохион байгуулахаар хуульчилжээ. Ингэхдээ нэрсийн жагсаалтаас долоо хоног тутам 10-15 хүний нэрсийн дэд жагсаалтыг цахим хэлбэрээр тохиолдлын журмаар гарган авах юм. Шүүх хуралдааны тов гарсны дараа уг дэд жагсаалтад нэр орсон иргэдээс нэгийг сонгох бөгөөд 2 иргэнийг нөөцөд авна. Харин сонгогдсон иргэнд шүүх хуралдаан болохоос ажлын таваас доошгүй хоногийн өмнө мэдэгдэх ёстой. Энэ нь тухайн иргэн шүүх хуралдаан болохоос өмнө өөрийн ажил, цагийг төлөвлөх хугацааг олгож байгаа явдал юм.

Хэрэв иргэн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол энэ тухайгаа тухайн шүүхийн тамгын газрын даргад мэдэгдэх үүрэгтэй. Хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон шалгарсан иргэнийг шүүх хуралдаанд оролцохоос зайлсхийсэн гэж үзэж хуулийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно. Иймд иргэний хувьд шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон тохиолдолд хариуцлагатайгаар шүүх хуралдаанд оролцох ёстой юм. Нөгөө талаасаа хэргийн ээдрээ, төвөгтэй байдлаас хамаарч шүүх хуралдаан хэд хэдэн удаа хойшлох нь иргэдийг шүүх хуралдаанд оролцох оролцоог буруулах сөрөг хандлагатай. Иймээс шүүхийн захиргааны зүгээс иргэдийн төлөөлөгчийг ажиллах нөхцлийг хангахад, шүүгчийн хувьд хэргийн үйл баримт, нотлох баримтыг хангалттай цуглуулж хэргийг хуулийн хугацаанд шийдвэрлэх шаардлагатай болж байна. Өмнө нь тухайн шүүхийн харьяалах нутаг дэвсгэрээс сонгогдсон иргэдийн төлөөлөгчөөс шүүх хуралдаан даргалагч өөрөө томилдог байсан.²⁶⁴

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах нөхцөл, үе шат

Иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа нь хэдийгээр иргэдийн өөрийн хүсэлтээр бүртгэлийн ажиллагаа хийгдэх боловч, аль хэргийг хянан шийдвэрлэхэд оролцохоо өөрөө шийдвэрлэх боломжгүй байдаг онцлогтой. Нөгөө талаар Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэгт зааснаар иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэн үүргээ гүйцэтгэхээс татгалзах буюу үүргээ гүйцэтгээгүй нь түүнд хариуцлага

²⁶⁴ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009)”, 2012 он, Улаанбаатар. 325 дахь тал

хүлээлгэх үндэслэл болдог.²⁶⁵ Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийг хариуцлагатай оролцуулахтай холбоотой юм.

1.4. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх, үүргийн харилцан уялдаа

Хэрэг, маргааны ялгаатай байдал, холбогдох хууль тогтоомжийн бие даасан зохицуулалттай холбоотойгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх, үүргийг ялгаатай байдлаар зохицуулсан боловч нийтлэг байдлаар дараах эрх, үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх(эд) оролцох;
2. Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн, хэрэг, маргааныг хэнээс ч хараат бусаар шийдвэрлэх
3. Шүүх хуралдааныг орхин явахгүй байх, хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд шүүх хуралдаанд хүрэлцэн ирэх;
4. Шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэх;
5. Хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгчтэй уулзахгүй байх;
6. Хэргийн талаар нотлох баримт цуглуулахгүй байх;
7. Өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулахгүй байх;
8. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд иргэдийн төлөөлөгчөөр оролцсон хэргийн талаар мэдээлэл өгөхгүй байх;²⁶⁶
9. Зөвлөлдөх тасалгаанд гаргасан санал, хэлэлцсэн асуудлыг задруулахгүй байх.

Дээр дурдсан нийтлэг эрх, үүрэгт хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжид заасан эрх бүрэн тусгагдаагүй байна. Энэ нь Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу шүүхийн тамгын газар нь иргэдийн төлөөлөгчид шүүх хуралдаанд оролцох үед эдлэх эрх хэмжээ, чиг үүрэг, хүлээх хариуцлага, шүүх хуралдааны дэгийн талаар мэдээлэл өгөхдөө нийтлэг эрх, үүргээс гадна хэрэг, маргааны төрлөөс хамааран хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжид заасан эрх, үүргийг нэмж танилцуулах шаардлагатайг харуулж байна.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бие даасан хуулийг батлан гаргасан боловч иргэдийн төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ялгамжтай байдлаар

²⁶⁵ Хавсралт №1-ээс үзнэ үү.

²⁶⁶ Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр ажилласан иргэн, СГЗ, нэвтрүүлэгч Ж.Бямбаа гуайн ярилцлагад хэргийн талаар мэдээлэл өгсөн байдаг. Түүнээс хэргийн талаар асуусан буюу яриулсан байгаа нь хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх практик бүрэн нэвтрээгүй байгаатай холбоотой байж болохоор байна.

- Та шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийн байр суурьнаас дүгнэлт хэлэхдээ "Залуу хүмүүс гэм буруугаа ухаараасай, ялыг нь хөнгөрүүлж үзээч" гэж хэллээ?

Аливаа гэмт хэрэг үүсэхдээ чухам юунаас, яагаад үүдэв гэдэг чухал. Саяын хэрэг бол согтууруулах ундаа хэрэглэсэн хоёр сайхан залуу нэгнийхээ биед хүнд гэмтэл учруулсан эрүүгийн хэрэг байлаа. Залуу сайхан насандаа 3 хүүхдийн ээж болсон бүсгүй хүн тархиндаа хүнд гэмтэл авч хохирно гэдэг ямар сайн байхав. 21-хэн настай залуу нэг олодох насныхаа хэдэн жилийг чанга дээлэмтэй хорих ангид өнгөрүүлэхээр болно гэдэг төсөөлшгүй хүнд. 2015.03.18 <http://www.judcouncil.mn/main/1382-.html>

оролцож байгаа нь Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтуудаас харагдаж байна. Энэ нь шүүх хуралдаанд хэдэн иргэдийн төлөөлөгч оролцох, ямар байдлаар дүгнэлтээ илэрхийлэх, дүгнэлтийг шүүхийн шийдвэр, шийтгэх ба цагаатгах тогтоолд хэрхэн тусгах талаарх харилцан адилгүй зохицуулалттай холбоотой юм.

1.5. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн гаргасан дүгнэлтийн агуулга, ач холбогдол, хэлбэрийн шаардлага

Иргэд шүүх хуралдаанд оролцож, шүүхийн шийдвэр гаргах процесст оролцож байгаагийн гол шинж нь иргэдийн төлөөлөгч тухайн этгээдийн гэм буруугийн талаар дүгнэлт гаргах явдал юм. Шүүхийн шийдвэрийг шүүх бүрэлдэхүүн гаргах тул тус шийдвэрт иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт хэрхэн тусгагдсанаар дүгнэлтийн агуулга, ач холбогдлыг тодорхойлж болох юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар иргэдийн төлөөлөгчийн гаргасан дүгнэлтийг шүүх шийдвэртээ тусгах²⁶⁷ ба үүнээс өөрөөр иргэдийн төлөөлөгчийн гаргасан гэм буруутай эсэх талаарх дүгнэлтийг шүүхийн шийдвэр, цагаатгах болон шийтгэх тогтоолд тусгах талаар тодорхой зохицуулалт байхгүй байна. “Шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл”-д орсон шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолд дүн шинжилгээ хийхэд иргэдийн төлөөлөгч оролцуулсан эрүүгийн хэргийн 8 шүүх хуралдааны тогтоолд иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн талаар бичээгүй, хяналтын шатны шүүх хуралдааны 1 шийдвэрт иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн талаар өмгөөлөгчийн гаргасан саналыг дурдаж бичсэн байна. Иргэний хэрэгт хяналтын шатны шүүхийн тогтоолд иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг дурдаж бичсэн байна. Харин захиргааны хэргийн 4 шүүх хуралдаанд бүгдэд нь иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн талаар бичсэн байна.²⁶⁸ Энэ нь Монгол Улсын сонгомол шүүхийн шийдвэрүүдэд шүүхийн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг үнэлэх асуудал орхигдож байгаа нь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүх үнэлэх, шүүхийн шийдвэрт иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох асуудал шийдэл хүлээж буйг харуулж байна.

Үүнээс гадна Монгол Улсын хууль тогтоомж болон “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-д шүүхийн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулга, хэлбэрийн шаардлагыг орхигдуулсан гэж үзэж болохоор байна. Учир нь, процессын хуулиудад иргэдийн төлөөлөгч нотлох баримтыг судалж үнэлсний үндсэн дээр шүүгдэгчийн гэм буруугийн талаар саналаа бичгээр гаргах, хэргийн үйл баримт, зохигчийн /хэргийн оролцогчийн/ гэм буруугийн талаар бичгээр дүгнэлт гаргах талаар зааснаар өөрөөр

²⁶⁷ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.3 дахь хэсэгт “Тодорхойлох хэсэгт нэхэмжлэлийн шаардлагын агуулга, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, прокурорын болон иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг тусгана” гэж заасан.

²⁶⁸ Хавсралт №1-ээс үзнэ үү

зохицуулаагүй байна.²⁶⁹ Тодруулбал, дүгнэлтийн хэлбэрийн шаардлагад бичгээр үйлдсэн байхаар заажээ. Харин агуулгын шаардлагад гэм буруугийн талаар бичсэн байхаар заажээ. Энэ шаардлагыг хангаагүй буюу бүрэн бус хангасан дүгнэлтийг шүүх хэрхэн үнэлэх, засвар оруулахыг шаардах эсэх асуудал нээлттэй байна.

Энэ хэсэгт анхаарах нэг зүйл бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийн үйлдэх бичиг баримт нь дүгнэлт бус санал гэж ойлгогдож болох талтай байна.²⁷⁰ Иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийн үйлдэх бичиг баримт нь дүгнэлт байна. Гэтэл Захиргааны хэргийн анхан шатны 8 дугаар шүүхийн 2014.03.21-ний өдрийн 06 дугаар шийдвэрт бичсэнээр Иргэдийн төлөөлөгч М.О шүүх хуралдаан дээр хэлсэн дүгнэлтдээ: "...тухай захиргааны хэргийн материалтай танилцаад доорхи саналыг гаргах нь: ... гэсэн саналтай байна" гэснээс харахад иргэдийн төлөөлөгчид өөрийн үйлдэх бичиг баримтаа дүгнэлт, саналын аль нь болохыг ялгахгүй байх, энэ талаар шүүх хуралдаан даргалагч тайлбарлахгүй байх явдал байгааг харуулж байна.

1.6. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн ажиллах нөхцөл, хөлс

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар иргэдийн төлөөлөгчийн хөлсийг шүүхийн төсвөөс олгоно. Гэхдээ шүүхийн иргэдийн төлөөлөгчид олгох хөлс нь процессын хуулиудад заасан шүүхийн зардалд²⁷¹ хамаарах эсэх нь тодорхойгүй байна. Тодруулбал, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсэгт байцаан шийтгэх ажиллагааны зардлын төрлийг заасан байна. Үүнд иргэдийн төлөөлөгчид олгох хөлсний талаар заагаагүй ч байцаан шийтгэх ажиллагаатай холбогдож гарсан бусад зардал гэдэгт хамаарч болох юм.²⁷² Хэрэв шүүхийн иргэдийн төлөөлөгчид олгох хөлсийг шүүхийн зардалд хамаарна гэж үзвэл түүний хэмжээг тодорхойлох,²⁷³ хуваарилах,²⁷⁴ гаргуулах²⁷⁵ асуудлыг процессын хуулиудад зааснаар шийдвэрлэх боломжтой байна.

²⁶⁹ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2.4, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.5-д энэ агуулгыг заасан.

²⁷⁰ 34.1.Иргэдийн төлөөлөгч нь шүүхийн хэлэлцүүлгийн үед оролцогчид асуулт тавих эрхтэй бөгөөд нотлох баримтыг судалж үнэлсний үндсэн дээр шүүгдэгчийн гэм буруугийн талаар саналаа бичгээр гаргах эрхтэй. Иргэдийн төлөөлөгч саналаа шүүх хуралдаанд уншиж сонсгож болно.

²⁷¹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1. Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг шүүхийн зардал гэнэ.

²⁷² Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 99.1.Байцаан шийтгэх ажиллагааны зардал нь дор дурдсан зардлаас бүрдэнэ:99.1.6.байцаан шийтгэх ажиллагаатай холбогдож гарсан бусад зардал.

²⁷³ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 100 дугаар зүйл. Байцаан шийтгэх ажиллагааны нөхөн төлүүлэх зардлын хэмжээг тодорхойлох. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйл. Нөхөн төлүүлэх шүүхийн зардлын хэмжээг тодорхойлох.

²⁷⁴ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 56 дугаар зүйл. Нөхөн төлүүлэх шүүхийн зардлыг хуваарилах.

²⁷⁵ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 101 дүгээр зүйл. Байцаан шийтгэх ажиллагааны зардлыг гаргуулах

1.7. Шүүхийн иргэдийн төлөөлөгчид хүлээлгэх хариуцлага

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцох тухай мэдэгдэл хүлээн авсан иргэн хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд товлосон шүүх хуралдаанд ирж оролцох үүрэгтэй. Хэрэв шүүхийн үйл ажиллагаанд оролцохоос санаатайгаар зайлсхийсэн бол иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Харин иргэнийг шүүх хуралдаанд оролцох үүргээ биелүүлэхийг ажил олгогч зөвшөөрөл өгөөгүйн улмаас шүүх хуралдаанд оролцож чадаагүй бол ажил олгогчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Үүнээс гадна шүүхийн иргэдийн төлөөлөгчийг хэргийг хянан хэлэлцэж шийдвэр гаргах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаатай холбогдуулж үндэслэлгүй гүтгэсэн нь тогтоогдвол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.²⁷⁶ Одоогоор иргэдийн төлөөлөгчийг гүтгэх гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр гараагүй байна.²⁷⁷

Хоёр. Гадаадын зарим улс дахь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцооны хэлбэрүүд

Эрх зүйн өндөр хөгжилтэй улс орнуудын хувьд иргэдээ шүүн таслах ажиллагаанд оролцуулах эсэх асуудлыг хэлэлцэхээс илүүтэй, хэрхэн үр нөлөөтэй, бодитой оруулах тал дээр анхаарал хандуулж байна. Ийм учраас зөвхөн нэг тогтолцоог нь дагнан хэрэгжүүлэх бус, өөрийн улсын онцлогт нийцсэн байдлаар холимог тогтолцоог сүүлийн үед ихээхэн сонирхох болжээ. Өөрөөр хэлбэл, гол маргаан эдүгээ тангарагтны шүүх буюу хэрэг маргааныг иргэд дангаар шийдэх болон холимог бүрэлдэхүүнээр буюу мэргэжлийн шүүгчид жирийн иргэдтэй хамтран шийдвэрлэхийн аль нь үр дүнтэй вэ гэдэг дээр оршиж байна.²⁷⁸

Дэлхийн улс орнууд шүүн таслах ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулж буй үндсэн хоёр хэлбэр байна. 1 дүгээрт, “jury” буюу тангарагтны шүүх. Энэ тогтолцоог ихэвчлэн Англи-Саксоны эрх зүйн бүлд хамаарах Англи, АНУ, Канад, Австрали зэрэг улс орны шүүхүүд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэж байна. 2 дугаарт “lay judge-Мэргэжлийн хуульч биш шүүгч”²⁷⁹ буюу мэргэшсэн шүүгчид болон жирийн иргэд хамтран хэрэг хянан шийдвэрлэдэг байна. Тухайлбал, ийм тогтолцоотой орны тоонд Герман, Япон, Солонгос зэрэг улс багтаж байна. Нөгөө талаар “тангарагтны шүүх” нэртэй боловч мэргэжлийн шүүгчид

²⁷⁶ Эрүүгийн хуулийн 259 дүгээр зүйл. Шүүгч, иргэдийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, прокурор шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийг гүтгэх.

²⁷⁷ Шүүхийн шийдвэрийн цахим сан /www.shuukh.mn/-д Эрүүгийн хуулийн 259 дүгээр зүйл, иргэдийн төлөөлөгчийг гүтгэсэн гэмт хэргийг шийдвэрлэсэн тогтоол байхгүй.

²⁷⁸ П.Бадамрагчаа, “Шударга ёсны хэмжүүр” сэтгүүл, 2012 оны 1 дүгээр улирал, 36 дахь тал

²⁷⁹ С.Нарангэрэл, “Хууль зүйн Англи-Монгол эх толь”, Улаанбаатар, 2012 он, 323 дахь тал

туслалцаа үзүүлэх чиг үүргээр ажилладаг иргэдийн төлөөлөгчийн оролцоотой улсын нэг жишээ бол ОХУ юм. Эдгээрээс гадна Монгол Улс шиг иргэд нь шүүх хуралдаанд шийдвэр гаргах эрхтэй оролцохгүй, ажиглах, хянах байдлаар оролцдог “идэвхгүй” хэлбэр байна. Энэ чиг хандлагыг зарим судлаач “*hybrid*” гэж тодорхойлжээ.²⁸⁰ Энэ нь иргэд шүүх хуралдаанд оролцох боловч шийдвэр гаргах эрх байдаггүй онцлогтой. Энэ хэсэгт Англи-Саксоны эрх зүйн бүл болон Эх газрын эрх зүйн бүлээс хамаарч улс бүрт харилцан адилгүй байна.

Энэ хэсэгт эрх зүйн бүлийн төлөөлөл болгон ХБНГУ, Япон улс, ОХУ, АНУ, БНСУ, Тайванийн эрх зүйн зохицуулалт, туршлагыг авч үзэв.

2.1.ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалт²⁸¹

(1) Нийтлэг зүйл

Монгол Улс эрх зүйн бүлийн хувьд Эх газрын эрх зүйн бүлд хамаарах бөгөөд тус эрх зүйн бүлийн төлөөлөл болгон ХБНГУ-ын жишээг авч үзье. ХБНГУ-д тангарагтны шүүх гэж байхгүй. Тус улсад мэргэжлийн шүүгч шүүн таслах үйл ажиллагааг явуулдаг бөгөөд шүүх бүрэлдэхүүнтэй хэрэгт мэргэжлийн бус шүүгч /Alderman/ оролцдог.²⁸² Германы Шүүх байгууллагын тухай хуулиар шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоотой шүүх /Schwurgericht/-ийн үйл ажиллагааг журамласан байдаг. Энэ шүүх нь байнгын бус үйл ажиллагаатай бөгөөд мэргэжлийн 3 шүүгч болон 22 мэргэжлийн бус шүүгч буюу шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй. Түүнийг тодорхой давтамжтайгаар, ээлжит хугацаа нь болсон үед ажиллуулдаг бөгөөд хуулиар тодорхой хугацааг заагаагүй, харин муж улсын шүүхийн захиргааны байгууллагаас ийм хугацааг тодорхойлдог.

Түүнчлэн иргэдийн төлөөлөгчийн оролцоотой шүүхийн шүүгчдийг тухайн харьяаллын хэргийн давж заалдах шатны шүүхийн /Oberlandesgericht/ ерөнхий шүүгч томилдог. Энэ гурван шүүгчийн нэг нь шүүх хуралдааны даргалагчийн үүргийг гүйцэтгэнэ. Түүнийг давж заалдах шатны шүүхийн туслах шүүгчдийн дундаас, эсхүл тойргийн шүүхийн /Landgericht/ гишүүдийн дундаас сонгодог. Үлдсэн хоёр шүүгчийг тойргийн шүүх /Landgericht/-ээс тогтмол сонгон ажиллуулдаг.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоотой шүүхийн харьяалан шийдвэрлэх эрүүгийн хэрэг хязгаарлагдмал бөгөөд ердийн шүүхийн адил бүх төрлийн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх эрх хэмжээгүй. Тус шүүх нь төрийн эсрэг гэмт хэргээс бусад хүнд гэмт хэргүүдийг шүүн шийдвэрлэдэг. Шүүхийн иргэдийн төлөөлөгч нь гүйцэтгэсэн үүргийнхээ төлөө хуульд заасан тохиолдолд томилолтын зардлаас бусад цалин хөлс, урамшуулал авдаггүй.

²⁸⁰ П.Бадамрагчаа. “Хэрэг маргааныг хянан хэлэлцэхэд иргэдийн оролцоо”, “Шударга ёсны хэмжүүр” сэтгүүл, Улаанбаатар, 2012 он, №1, 36 дахь тал

²⁸¹ Burt Estes Howard. Trial by Jury in Germany. *Political Science Quarterly*. Vol. 19, No. 4 (Dec., 1904), pp. 650-672. Published by: The Academy of Political Science

<http://www.jstor.org/stable/pdf/2140326.pdf?acceptTC=true>

²⁸² Gerhard Casper and Hans Zeisel. Lay Judges in the German Criminal Courts. *The Journal of Legal Studies*. Vol. 1, No. 1 (Jan., 1972), pp. 135-191. Published by: The University of Chicago Press

<http://www.jstor.org/discover/10.2307/724014?uid=2&uid=4&sid=21106670093493>

Шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр ажиллах этгээд нь дараах нөхцлийг хангасан байх ёстой. Үүнд:

- хэрэг, маргааны оролцогчийн төлөөлөгч буюу түүнтэй хамааралгүй байх;
- эрх зүйн чадвар, чадамжтай байх;
- эрх зүйн мэдлэг, чадвартай байх;
- хянан хэлэлцэж буй хэрэг, маргааны оролцогч болоогүй байх.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчид дараах нөхцөлд хариуцлага хүлээлгэх асуудал үүсдэг. Үүнд:

- үүргээ гүйцэтгээгүй;
- татгалзан гарах үүргээ биелүүлээгүй;
- үүрэг гүйцэтгэх ёсгүй байсан.

(2) Иргэдийн төлөөлөгчийг томилох зохицуулалт

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгох ажиллагааг Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоотой шүүх /Schwurgericht/-д хэрэг хуваарилагдсанаар эхлүүлдэг. Тухайн муж улсын засаг захиргааны нэгж шүүхийн иргэдийн төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх этгээдийн жагсаалтыг бэлтгэх үүрэгтэй. Ингэж гаргасан жагсаалтыг олон нийтийн хяналт, ил тод байдлыг хангах зорилгоор ийнхүү бэлтгэснээс хойш 7 хоногийн туршид олон нийтэд нээлттэй байлгадаг. Энэ хугацаанд хэн бүхэн жагсаалтад багтсан этгээдийг шүүхийн иргэдийн төлөөлөгч байхад тохиромжгүй гэж үзэх, тухайн этгээдийн талаар гомдол гаргах боломжтой. Үүний дараагаар жагсаалт гаргасан муж улсын засаг захиргааны нэгжийн дарга буюу ахлагч жагсаалт болон жагсаалтын талаарх гомдол, эсэргүүцлийг хамтад нь тухайн нэгжийн харьяалах тойргийн шүүхийн шүүгчид хүргүүлдэг.

Тойргийн шүүхийн нэг шүүгч, мужийн засаг захиргаанаас томилсон нэг албан тушаалтан болон “итгэлтэй” 7 хүн /Vertrauensmänner/ буюу нийт 9 хүнээс бүрдсэн хороо жил тутам хуралдана. Энэ хорооны дарга нь тойргийн шүүхийн шүүгч байна. “Итгэлтэй” 7 хүн /Vertrauensmänner/-ийг тухайн тойргийн иргэдийн төлөөллийн байгууллагаас дэвшүүлдэг бөгөөд ингэж дэвшүүлсэн оршин суугч иргэдээс тойргийн шүүх нь хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийг сонгодог.

Хорооны даргалагч, мужийн засаг захиргаанаас томилсон нэг албан тушаалтан болон 3-аас доошгүй “итгэлтэй” иргэний бүрэлдэхүүнтэйгээр жагсаалттай холбоотой гомдлыг хянан хэлэлцэж шийдвэр гаргана. Энэ шийдвэрт давж заалдах эрхгүй. Үүнээс “анхдагч жагсаалт” гарна. “Анхдагч жагсаалт”-аас хороо нь иргэдийн төлөөлөгчөөр ажиллах хүний тоонд нийцүүлэн иргэнийг төлөөлөгчөөр сонгоно. Үүнийг “жилийн жагсаалт” гэж нэрлэнэ.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоотой шүүх хэрэг хянан шийдвэрлэхээс 14-өөс доошгүй хоногийн өмнө шүүгч болон “жилийн жагсаалт”-аас хоёр иргэдийн төлөөлөгч сонгоно. Ийм иргэдийн төлөөлөгчийг Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоотой шүүхийн даргалагч томилно.

(3) Иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагааны зохицуулалт

Иргэдийн төлөөлөгчид шүүх хуралдаанд гэм буруугийн асуудлаар шийдвэр гаргах чиг үүрэгтэй бөгөөд ингэхдээ хуралдаан даргалагчаар дамжуулан асуулт асуух хэлбэрээр хуралдааны явцад оролцоно. Шүүх хуралдаан даргалагчийн зүгээс

асуултыг “хэрэгт хамааралгүй, шаардлагагүй, ач холбогдолгүй” гэж дүгнэснээс бусад тохиолдолд шүүх хуралдааны оролцогчид иргэдийн төлөөлөгчийн асуултад хариулах үүрэгтэй.

(4) Иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлт

Шүүхийн иргэдийн төлөөлөгчид дүгнэлт гаргахдаа шүүх хуралдаан даргалагчийн тусгайлан асуусан бүх асуултад хариулсан байна. Ингэж хариулахдаа “тийм”, “үгүй” гэх байдлаар тодорхой хариулсан байна. Шүүх хуралдаан даргалагч нь иргэдийн төлөөлөгчид тавьсан асуултаа шүүх хуралдаанд нээлттэй, чанга, тод дуугаар уншин сонгоно. Хэргийн оролцогч талууд асуултыг тодруулах хүсэлт гаргах боломжтой.

Шүүх хуралдаанаас өмнө хэргийн үйл баримт, хавтаст хэргийн талаар иргэдийн төлөөлөгчид урьдчилан танилцах эрхгүй бөгөөд шүүх хуралдаан даргалагч нь хэргийн үйл баримтын талаар иргэдийн төлөөлөгчдөд хуралдаан дээр танилцуулж, бүрэн ойлголт өгөхөд анхаарч ажиллана.

(5) Иргэдийн төлөөлөгчийн шүүх хуралдаан дахь дотоод зохион байгуулалт

Иргэдийн төлөөлөгчид дүгнэлтээ “иргэдийн төлөөлөгчдийн тасалгаа”-нд бэлтгэнэ. Энэ тасалгаанд иргэдийн төлөөлөгч Эрүүгийн хууль, Эрүүгийн процессын хууль болон эрх зүйн ном, бүтээлийг авч орох боломжтой. “Иргэдийн төлөөлөгчийн тасалгаа”-нд орсны дараагаар төлөөлөгчид дотроосоо ахлагч-илтгэгчээ сонгоно. Иргэдийн төлөөлөгчид саналаа нууцаар бичгээр гаргана. Санал тэнцсэн тохиолдолд хамгийн ахмад төлөөлөгчийн саналаар санал хураалт шийдвэрлэгдэнэ. Тасалгаан дахь санал хураалтын бусад хэлбэр, арга замын талаар хуульд тусгаагүй бөгөөд уг асуудлыг тасалгаан доторх дэгээр зохицуулна.²⁸³ Иргэдийн төлөөлөгчид шүүх хуралдаан даргалагчийн асуултыг буруу ойлгосон буюу түүнийг хэрхэн ойлгох талаар эргэлзээтэй байгаа бол энэ талаар дахин тодруулсны дараа тасалгаанд буцан орох боломжтой.

Гэм буруугийн талаарх дүгнэлтийг иргэдийн төлөөлөгчийн ахлагч-илтгэгч өөрийн гараар бичсэн байх бөгөөд хариултыг асуулт бүрийн дараа харгалзуулан бичсэн байна. Дүгнэлтэд иргэдийн төлөөлөгчийн ахлагч-илтгэгч гарын үсгээ зурсан байна. Иргэдийн төлөөлөгчид гэм буруугийн талаарх дүгнэлтийг тайлбарлах, нэмэлт нотлох баримт шаардах эрхгүй.

(6) Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг танилцуулах нь

Шүүхийн иргэдийн төлөөлөгчид шүүх хуралдааны танхимд буцаж ирсний дараа төлөөлөгчдийн ахлагч-илтгэгч нь шүүгчид хандаж иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлтийг танилцуулах үүргээ бүрэн ухамсарлаж байгаа тухайгаа мэдэгдээд²⁸⁴ дүгнэлтийг асуулт, хариултын хамт уншин сонгоно. Үүний дараа дүгнэлтэд шүүх хуралдаан даргалагч болон хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, шүүгдэгчид танилцуулна. Хэрэв дүгнэлт хуульд заасан хэлбэрийн шаардлага хангаагүй буюу дутуу байна гэж үзвэл энэ тухай даргалагч мэдэгдэж, иргэдийн төлөөлөгчид тасалгаанд буцаж орно. Тухайн хэрэгт хэд хэдэн шүүгдэгч, хэрэглэх

²⁸³ Иргэдийн төлөөлөгчдийн боловсрол, мэргэжил харилцан адилгүй, өөр түвшинд байх нь нийтлэг тул хурлын дэгийг хуульчлалгүйгээр өөрсдөө тогтоох эрхийг өгсөн байна.

²⁸⁴ “Upon my honor and conscience I certify as the verdict of jurors ... ”

шаардлагатай хууль байгаа тохиолдолд иргэдийн төлөөлөгчид бүрэн бус буюу буруу, алдаатай дүгнэлт гаргасан гэж шүүх үзвэл дараагийн шүүх хуралдааныг хийх бөгөөд энэ тохиолдолд шинэ бүрэлдэхүүнтэй иргэдийн төлөөлөгчдийг шүүх хуралдаанд оролцуулна.

2.2. Япон улсын эрх зүйн зохицуулалт

(1) Нийтлэг зүйл

Япон улсын хувьд 1980-аад оны сүүлээс шүүхийн шинэтгэл эхэлсэн бөгөөд шүүхийн тогтолцоондоо АНУ-ын тангарагтны тогтолцоог бий болгох талаар өргөн хэмжээнд судалгаа хийгдсэн байна. Ингээд 2009 оноос уг шинэтгэл эрчимжиж, шүүгчид болон иргэд хамтран хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож шийдвэр гаргах тогтолцоог төлөвшүүлжээ.

Уг шинэтгэлийг хийх гол зорилго нь Японы шүүхийн тогтолцооны хүрээнд дундаж иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, шүүх эрх мэдлийн хүчийг бий болгох явдал байсан юм. Ялангуяа, эрүүгийн шүүх нь хууль эрх зүйн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх олон улсын чиг хандлагад үндэслэжээ. Хэдийгээр Японы шүүх хуралдаанд иргэдийн төлөөллийг оролцуулах тогтолцоо нь Англи-Саксоны тангарагтны тогтолцоо, Германы холимог тогтолцооны аль аль шинжийг агуулсан боловч илүүтэй Германы тогтолцоотой ойр байдаг²⁸⁵ гэж судлаачдын зүгээс тэмдэглэжээ. Японы шүүхийн иргэдийн төлөөллийг шүүн таслах ажиллагаанд оролцуулдаг уг хэлбэрийн хувьд Англи болон Европын тогтолцооны алийг илүүтэй агуулдаг талаар өнөөг хүртэл зарим судлаачийн зүгээс харилцан адилгүй байр суурьтай байдаг бөгөөд бие даасан өвөрмөц хэлбэрийг бий болгож чаджээ.

(2) Иргэдийн төлөөлөгчийг томилох зохицуулалт

Япон улсын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, шийдвэр гаргаж буй иргэдийг “Saiban-in” гэж нэрлэх бөгөөд Хууль зүйн тогтолцоог шинэтгэх зөвлөлөөс ингэж нэрлэжээ. “Saiban-in” болохын тулд тухайн дүүрэгт оршин суудаг байх шаардлагатай. Түүнээс гадна заавал бүрэн дунд боловсролтой байх шаардлагагүй бөгөөд ял шийтгэлгүй, бие махбодын болон сэтгэцийн хувьд эрүүл байх шаардлагыг хуулиар тавьдаг.²⁸⁶ Нийт бүртгүүлсэн иргэдээс тохиолдлын журмаар сонгож 6 долоо хоногийн өмнө шүүхийн мэдэгдэх хуудсаар шүүх хуралдаанд дуудан ирүүлнэ. Ингээд шүүх хуралдаанд оролцохоор сонгогдсон тохиолдолд мэргэжлийн шүүгчид тэдний эрх, үүрэг, шүүх хуралдааны журмыг тайлбарлаж өгнө.²⁸⁷ Маргааныг шийдвэрлэхэд 6 иргэдийн төлөөлөгч, 3 мэргэжлийн шүүгч оролцох бөгөөд тангарагтны хувьд 20-оос дээш насны хүн бүр²⁸⁸ сонгогдох боломжтой.

²⁸⁵ “Citizen Participation in Criminal Trials in Japan: The Saiban-in System and Victim Participation in Japan in International Perspectives”, “International Journal of Law, Crime and Justice”, (2014) 1-12. P.4
<http://www.isc-sic.org/web/images/stories/miyazawa.pdf>

²⁸⁶ Act on Criminal Trials with Participation of Saiban-in. Act No.63 of May 28. 2004, Article 14

²⁸⁷ “Citizen Participation in Criminal Trials in Japan: The Saiban-in System and Victim Participation in Japan in International Perspectives”, “International Journal of Law, Crime and Justice”, (2014) 1-12, P.3,
<http://www.isc-sic.org/web/images/stories/miyazawa.pdf>

²⁸⁸ Robert M.Bloom, “Jury trials in Japan”, 28 Loy. L.A. Int'l & Comp. L. Rev. 35 (2006). P.7

Түүнээс гадна Монгол Улсын адил “saiban-in” нь шүүх хуралдаанд оролцсон талуудын нууцыг чанд хадгалах үүрэгтэй бөгөөд хэрэв иргэд, байгууллагын холбогдолтой нууцыг задруулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээнэ.²⁸⁹

(3) Иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагааны зохицуулалт

Японы иргэдийн төлөөлөгчийг шүүхээс тусад нь авч үзэх боломжгүй бөгөөд тангарагтны шүүхийн тогтолцоотой зарим талаараа төстэй. Saiban-in шүүх хуралдаанд нотлох баримтыг шинжлэн судлах, хэргийн үйл баримтыг тодруулна. Харин шийдвэр гаргахдаа шүүгчтэй хамтран гэм буруутай эсэх талаар дүгнэлт гаргах боловч эцсийн шийдвэрийг шүүгч удирдан явуулдаг.

Мэргэжлийн шүүгчид, жирийн иргэд хамтран хэрэг хянан шийдвэрлэх нь гэм буруу болон ял оногдуулахад хамтран ажиллах шаардлагатай болдог бөгөөд энэ шүүгчийг жирийн иргэдийн амьдралд ойр байлгахад тустай тогтолцоо гэж үздэг. Өөрөөр хэлбэл, шүүгч хамтран хэрэг шийдвэрлэж байгаа иргэдтэй нэгдсэн нэг саналтай байхын тулд асуудлын талаар дэлгэрэнгүй тайлбарлах, иргэдийн зүгээс өдөр тутмын амьдралын талаар шүүгчид тунгаан бодох боломжийг олгох зэрэг давуу талтай юм. Харин нөгөө талаас иргэд ийнхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа нь тухайн иргэнд ямар нэг дарамт ирэх, шударга шүүхийн тогтолцоог алдагдуулах талтай хэмээн шүүмжилдэг байна.²⁹⁰

2.3. АНУ-ын эрх зүйн зохицуулалт

(1) Нийтлэг зүйл

АНУ-ын шүүхийн систем нь дундад зууны Англиас үүсэлтэй. АНУ-ын хувьд тангарагтны шүүхийн тогтолцоотой бөгөөд жирийн иргэд нь шүүх хуралдаанд оролцож хэрэг хянан шийдвэрлэдэг. Энэ нь ихэвчлэн эрүүгийн хэрэгт гэм буруугийн асуудал хэлэлцэхэд ач холбогдолтой бөгөөд иргэний маргааны хувьд тийм ч түгээмэл бус байдаг.²⁹¹ Гэхдээ эрүүгийн хэрэгт 12 тангарагтан, иргэний хэрэгт 6 тангарагтан оролцдог. Түүнчлэн шүүхийн иргэдийн төлөөлөгчийн асуудал нь иргэн, захиргааны эрх зүйн хүрээнээс илүүтэй эрүүгийн эрх зүй, гэм бурууг тогтоох асуудалтай илүү холбогддог нийтлэг хандлагатай байна. Үүнийг иргэний хэргийг шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгчөөс татгалзаж болдог зохицуулалтаас харж болно.

“Jury” буюу тангарагтны шүүхийн тогтолцоо нь эрүүгийн хэргийн хянан хэлэлцэх шүүх хуралдаанд гурваас дээш мэргэжлийн бус хүнийг нэг бүлэг болгон

<http://digitalcommons.lmu.edu/ilr/vol28/iss1/2>

²⁸⁹ Yoshihiro Takatori, Setsuko Ueno, Chie Miura, Eiko Shibasaki, & Marjorie Culver, “The New Saiban-in (“Lay Judge”) System and Its Effect on the Working Environment”, 2009, p.3.

<http://www.paulhastings.com/assets/publications/1167.pdf>

²⁹⁰ Andrea Ortolani, “Reflections on Citizen Participation in Criminal Justice in Japan: Jury, Saiban-in System and Reform”, “Journal of Japanese Law”, vol. 15 (Spring 2010 No. 29), p.169

http://www.academia.edu/1140807/Reflections_on_Citizen_Participation_in_Criminal_Justice_in_Japan_Jury_Saiban_in_System_and_Legal_Reform

²⁹¹ Ethan J.Leib, “Supermajoritarianism and the American Criminal Jury”, 33 HASTINGS CONST.LQ.141(2006)

оролцуулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахыг ойлгоно.²⁹² Ингэхдээ мэргэжлийн бус хүмүүс нь мэргэшсэн шүүгч биш бөгөөд тухайн гэмт хэргийн үйл явдлын талаар асуулт тавих, гэм бурууг тогтоох, хэргийн зүйлчлэл болон ял шийтгэл оногдуулах асуудлыг хэлэлцэхэд оролцоно.

(2) Тангарагтанг сонгох зохицуулалт²⁹³

АНУ-ын тангарагтныг 2 аргаар сонгодог. Эхнийх нь тангарагтан болохыг хүссэн иргэдийн нэрсийн жагсаалтаас тохиолдлын аргаар сонголт хийнэ. Уг жагсаалтад иргэд өөрсдөө бүртгүүлж болохоос гадна сонгогчдын нэрсийн жагсаалт, жолооны үнэмлэхтэй иргэдийн нэрс болон ажилгүйдлийн тэтгэмж авдаг иргэдийн нэрсийг шууд оруулж болно. Харин дараагийнх нь тангарагтанг сонгох 2 дахь шат буюу шүүх болон өмгөөлөгчийн зүгээс нарийн шалгуурын үндсэн дээр нөөцөөс 12 тангарагтанг сонгож хэрэг хянан шийдвэрлэхэд оролцуулдаг. Гэхдээ уг тогтолцоо муж болон шүүгчдээс хамааран өөр өөр байх бөгөөд зарим тохиолдолд тангарагтны нөөц их байвал шүүгч заримыг нь сонгон үүргээс нь чөлөөлдөг байна. Ерөнхийдөө шүүгч болон өмгөөлөгчийн зүгээс тангарагтан тус бүртэй үзэл бодол, тангарагтан болохыг хүссэн шалтгааны талаар ярилцлага хийдэг. Уг нэрсийн жагсаалт нь 2 жилийн хугацаанд хүчинтэй байдаг.

Тангарагтны нөөцөөс 6-12 хүнийг сонгож шүүх хуралдаанд оролцуулна. Муж улсын онцлогоос хамаарч тангарагтнуудын шүүх хуралдаанд оролцох хэлбэр өөр өөр байдаг. Нийтлэг байдлаар дараах ойлголтууд байна. Үүнд:

- иргэний хэргийн хувьд ялангуяа хязгаарлагдмал хэргийг шийдвэрлэх шүүхийн хувьд 6 тангарагтанг оролцуулах стандарт тогтсон байдаг боловч талуудын нөхцөл байдлаас хамаарч энэ тоог нэмэгдүүлж болно.
- жижиг хэргийг шийдвэрлэхэд 12-оос доошгүй тангарагтанг оролцуулдаг бол хүнд, онц ноцтой эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд 12 тангарагтанг оролцуулна гэсэн ерөнхий шаардлага тавигдана.
- өмнө нь тангарагтны шийдвэр нэгдмэл байх ёстой гэдэг байсан бол одоо уг ойлголт өөрчлөгдөж, тангарагтны 3/4, 5/6 нь тухай хэргийг ингэж шийдвэрлэсэн тухай мэдээлдэг болсон байна.

Энэ нь Монгол Улсын Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт зааснаар нэрсийн жагсаалтаас долоо хоног тутам 10-15 хүний нэрсийн дэд жагсаалтыг цахим хэлбэрээр тохиолдлын журмаар гарган тухайн Шүүхийн тамгын газрын даргаар батлуулахтай төстэй зохицуулалт байна.

(3) Иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагааны зохицуулалт

Тангарагтны оролцооны хоёр тогтолцоо байдаг. Эхнийх нь бага тангарагтны шүүх “*Petit jury*” нь сэжигтний гэм буруутай эсэх талаар дүгнэлт гаргадаг. Харин их тангарагтны шүүх “*Grand jury*” нь сэжигтэнд ял оногдуулна. Ихэнх “*Grand jury*” бүрэлдэхүүнд 16-23 тангарагтан байдаг бол “*Petit jury*” нь 6-12 тангарагтнаас

²⁹² Ethan J. Leib, “A Comparison of Criminal Jury Decision Rules in Democratic Countries”, Ohio State Journal of Criminal Law, Vol. 5, 2008, p.630.

²⁹³ “How are potential jurors selected”

<http://criminal.findlaw.com/criminal-procedure/how-are-potential-jurors-selected.html>

бүрдэнэ. Судлаачдын үзэж байгаагаар “*petit jury*” илүү өргөн хүрээтэй, олон хүнээс бүрддэг байсан бол эрүүгийн хэргийн хувьд тангарагтнууд нэгдсэн шийдэлд хүрэх байдал их байхаар байна.

Үүнээс гадна 6 жилээс дээш ялаар шийтгэж болзошгүй хэрэгт тангарагтан заавал оролцоно. Харин иргэн болон захиргааны хэргийн хувьд хэргийн оролцогч тангарагтнаар шийдвэрлүүлэх эсэхээ өөрөө сонгож, тангарагтнаас татгалзаж болно.

(4) Тангарагтны дүгнэлт

“*Petit jury*” нь шүүх хурал дээр гэм буруутай эсхүл цагаатгах тохиолдолд нэгдсэн нэг шийдвэрт хүрсэн байх ёстой. Хэрэв тангарагтнууд санал хуваагдвал шүүгч “*hang jury*”²⁹⁴ /тангарагтан шийдвэрээ гаргах боломжгүйгээр санал зөрөлдсөн, зөвшилцөж шийдвэр гаргах боломжгүй байх/ эсхүл тангарагтан нэгдсэн саналд хүрээгүй гэсэн шийдвэрийг гаргана. Уг шийдвэрийг талууд хүлээн зөвшөөрөхгүй бол тэдний саналыг үндэслэн прокурор дахин хэрэг үүсгэж болно. Харин “*Grand jury*” нь нэгдсэн саналд хүрэхгүй байж болно. Тангарагтны тоо муж бүрт өөр өөр байх боловч холбооны “*Grand jury*”-гийн хувьд ял оногдуулахад 12 тангарагтан байхад болдог байна.

(5) Тангарагтанд олгох хөлс²⁹⁵

Ажил олгогч нь шүүх хуралдааны явцад тангарагтан болсон өөрийн ажилтны цалинг үргэлжлүүлэн олгож болох хэдий ч Холбооны хуулиар энэ талаар ажил олгогчоос шаарддаггүй. Харин “*Jury Act*”-д Холбооны тангарагтанаар сонгогдон шүүх хуралдаанд ажиллаж, үйлчилгээ үзүүлж байгаа тангарагтанг ажил олгогчийн зүгээс ажлаас халах, сүрдүүлэх, ямар нэг албадлагын шинжтэй үйлдэл хийхийг хориглодог. Түүнчлэн тангарагтнуудад тээврийн зардал, машины зогсоолын төлбөрийг нөхөн олгоно. Хэрэв тангарагтан бүтэн шөнийн турш сууж ажиллах шаардлагатай болсон бол тэдний хоол, орон байрны зардлыг мөн төлдөг байна.

(6) Бусад асуудал

“*Grand jury*”-ийн хувьд олон нийтээс хаалттай байдаг бол “*petit jury*” нь иргэдтэй илүү ойр байдаг. “*Grand jury*” нь зөвхөн гэрчийн мэдүүлэг сонсох, яллах ажиллагаанд оролцдог бол “*petit jury*” нь шүүх хуралдаанд хэргийн оролцогчоос бүхий л мэдээллийг асуух эрхтэй байдаг.

“*Petit jury*”-ийн бүрэлдэхүүнд байгаа тангарагтан нь нэг хэргийг шийдвэрлэхэд оролцох бөгөөд 10-аас багагүй хоногт шийдвэрлэнэ. Олон нийтэд танил болсон хэргийн хувьд хэдэн сараар үргэлжилж болох ч шүүхээс тухайн хэргийг шийдвэрлэсэн бол “*petit jury*”-ийн бүрэлдэхүүнд орсон тангарагтан үүргээ гүйцэтгэж дууссан байдаг. Харин “*Grand jury*”-ийн бүрэлдэхүүнд орсон тангарагтны хувьд 18 хүртэлх сараар томилогддог тул энэ хугацаагаа дуустал өөр бусад хэрэг шийдвэрлэхэд оролцдог байна.

Хэдийгээр АНУ-ын тангарагтны тогтолцоо Монгол Улсын шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцооноос ихээхэн ялгаатай боловч, иргэдийн төлөөллийг шүүн таслах ажиллагаанд оролцуулах сонгодог хэлбэр юм. АНУ-ын хувьд тангарагтан байх нь ихээхэн нэр хүндтэй бөгөөд ажиллах таатай нөхцлөөр хангах, олон нийтийн

²⁹⁴ “Black’s law dictionary”, Revised Fourth Edition, West publishing Co., 1968, P.875

²⁹⁵ Juror pay <http://www.uscourts.gov/services-forms/jury-service/juror-pay>

анхаарлын төвд байгаа хэрэг шийдвэрлэхэд гадны нөлөөнөөс сэргийлэх зэрэг ажлуудыг сайн авч хэрэгжүүлдэг байна.

2.4. БНСУ-ын эрх зүйн зохицуулалт

(1) Нийтлэг зүйл

БНСУ-д иргэдийн оролцоотой шүүн таслах үйл ажиллагаа нь 2007 онд батлагдаж, 2010, 2012 онд нэмэлт, өөрчлөлт орсон “Эрүүгийн хэрэг шүүн таслах үйл ажиллагаан дахь иргэний оролцооны тухай хууль”²⁹⁶-иар тусгайлан зохицуулагдсан. БНСУ-ын Дээд шүүхээс “Шүүхийн тогтолцоон дахь иргэдийн оролцооны хороо”-г байгуулж ажиллуулж байгаа бөгөөд тус хороо нь шүүн таслах үйл ажиллагаан дахь иргэдийн оролцооны талаар шийдвэр гаргах, өөрийн үйл ажиллагаа нь Улсын дээд шүүхийн дүрмээр зохицуулагдах байгууллага юм.

“Эрүүгийн хэрэг шүүн таслах үйл ажиллагаан дахь иргэний оролцооны тухай хууль”-иар иргэдийн төлөөлөгчдийн гаргасан дүгнэлтийг шүүгч заавал дагаж мөрдөх хүчин төгөлдөр баримт гэж үзэхгүй бөгөөд шүүгч болон шүүхийн иргэдийн төлөөлөгч хамтран зөвшилцлийн журмаар шийдвэр гаргадаг.²⁹⁷

Өөр нэг онцлох зүйл бол, иргэдийн төлөөлөгчийн оролцоотой шүүн таслах үйл ажиллагаа нь яллагдагчийн зөвшөөрлийг авсан байх шаардлагатай байдаг. Тодруулбал, шүүх нь иргэдийн төлөөлөгч оролцох боломжтой эрүүгийн хэрэгт яллагдаж буй этгээдээс тухайн шүүн таслах үйл ажиллагааг иргэдийн төлөөлөгчийн оролцоотой явуулах хүсэлт байгаа эсэхийг асуух ёстой байдаг. Яллагдагч нь тухайн эрүүгийн хэрэг шүүхэд шилжсэнээс хойш 7 хоногийн дотор шүүхэд хандаж шүүн таслах үйл ажиллагааг иргэдийн төлөөлөгчийн оролцоотой явуулах эсэхийг бичгээр мэдэгддэг.²⁹⁸

Шүүхийн иргэдийн төлөөлөгчид нь ял төлөвлөж, шүүгчид санал болгодог онцлогтой холбоотойгоор яллагдагчид нь шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн өмнө хэргээ хүлээх явдал байнга нэмэгдэх болжээ.²⁹⁹

(2) Иргэдийн төлөөлөгчийн тоо

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг эрүүгийн хэргийн хүнд, хөнгөний байдлаас хамааран 5, 7, 9 зэрэг сондгой тооны иргэдийн төлөөлөгчийг шүүн таслах үйл ажиллагаанд оролцуулдаг. Тодруулбал, цаазаар авах ял оноож болох буюу бүх насаар нь хорих ял оноож болох хэрэгт 9 иргэдийн төлөөлөгч оролцдог бол, үүнээс бусад хэрэгт 7 иргэдийн төлөөлөгч оролцдог бөгөөд яллагдагч өөрөө буюу түүний өмгөөлөгч зөвшөөрвөл шүүх нь 5 иргэдийн төлөөлөгчийг оролцуулж болдог.

²⁹⁶ Gukmin-eui Hyongsa Jaepan Chamyeo-e Gwanhan Beobryul [Act on Citizen Participation in Criminal Trials]. Statutes of the Republic of Korea http://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=24228&type=new&key=

²⁹⁷ Sang Hoon Han & Kwangbai Park, “Citizen participation in criminal trials of Korea: A statistical portrait of the first four years”, July 5, 2012 <http://people.ucsc.edu/~hfukurai/documents/2-Han-Park.pdf>

²⁹⁸ Article 8. [Act on Citizen Participation in Criminal Trials]. Statutes of the Republic of Korea http://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=24228&type=new&key=

²⁹⁹ Sang Hoon Han & Kwangbai Park, “Citizen participation in criminal trials of Korea: A statistical portrait of the first four years”, July 5, 2012. P.6. <http://people.ucsc.edu/~hfukurai/documents/2-Han-Park.pdf>

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тооны асуудлыг тухай бүр шүүхээс бие даан шийдвэрлэх бөгөөд энэ талаар шийдвэр гаргана. Тухайн хэрэг ээдрээ төвөгтэй гэж үзсэн онцгой тохиолдолд прокурор, яллагдагч, яллагдагчийн өмгөөлөгчөөс зөвшөөрөл авна.³⁰⁰ Есөн иргэдийн төлөөлөгчөөс хэргийн оролцогч-талууд 5 хүртэл төлөөлөгчийг татгалзах эрхтэй бөгөөд 7 төлөөлөгчөөс 4 хүртэл төлөөлөгчийг, 5 төлөөлөгчөөс 3 төлөөлөгчийг татгалзах эрхтэй байдаг. Ийнхүү шүүх хуралдаан дээр шүүхийн иргэдийн төлөөлөгчийг эцэслэн сонгоход ойролцоогоор 1-2 цаг зарцуулдаг байна.³⁰¹

(3) Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт

Хэргийн төрөл, иргэдийн төлөөлөгчийн тооноос хамааран шүүхийн иргэдийн төлөөлөгчийн зүгээс дүгнэлт гаргах, түүнийгээ танилцуулахад ойролцоогоор 20-180 минут зарцуулдаг байна.³⁰² Монгол Улсын хувьд иргэдийн төлөөлөгч дүгнэлт гаргах, дүгнэлтээ танилцуулах хугацааны талаар Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуульд тусгайлан заагаагүй бөгөөд энэ асуудал нь шүүх хуралдаан даргалагчийн шийдвэрээр зохицуулагдах боломжтой.

Иргэдийн төлөөлөгч нь гэм буруугийн талаарх дүгнэлтээ өөрөө бие даан гаргана. Харин гэм буруутай эсэх талаарх иргэдийн төлөөлөгчдийн нэгдсэн дүгнэлтийг тэдний дийлэнх олонхийн саналаар гаргана. Хэрэв иргэдийн төлөөлөгчдийн нэгдсэн дүгнэлтээр яллагдагчийг гэм буруутай гэж үзвэл шүүгч ял оногдуулах бөгөөд иргэдийн төлөөлөгч бүр ял шийтгэлийн талаар саналаа хэлэх боломжтой.³⁰³

Харин яллагдагчийн гэм буруу, ял шийтгэлийн асуудлыг шүүгч бие даан дангаараа шийдвэрлэх бөгөөд иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт, саналыг заавал дагахгүй байж болно. БНСУ-ын шүүхийн практикт иргэдийн төлөөлөгчийн оролцоотой шийдвэрлэсэн нийт хэргийн 90.6%-д нь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт, саналтай дүйцсэн шийдвэрийг шүүхээс гаргасан байна.³⁰⁴

(4) Бусад асуудал

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн урамшуулал:

Шүүхийн иргэдийн төлөөлөгчид урамшуулал олгохоор заасан бөгөөд энэ урамшууллыг тухайн төлөөлөгчийн оролцоотой шүүх хуралдаанаас хорих ял шийтгэгдсэн этгээдийн 2 жилийн хөдөлмөрийн хөлс буюу 5 сая воноос хэтрэхгүй хэмжээтэй торгуулиас тооцно.³⁰⁵ Иргэдийн төлөөлөгч нь шүүн таслах үйл ажиллагаанд оролцохтой холбогдон гарсан замын зардлыг Дээд шүүхийн дүрэмд заасан нөхцлөөр гаргуулах эрхтэй.

³⁰⁰ Article 13. [Act on Citizen Participation in Criminal Trials]. Statutes of the Republic of Korea http://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=24228&type=new&key

³⁰¹ Sang Hoon Han & Kwangbai Park, "Citizen participation in criminal trials of Korea: A statistical portrait of the first four years", July 5, 2012, p.7. <http://people.ucsc.edu/~hfukurai/documents/2-Han-Park.pdf>

³⁰² Sang Hoon Han & Kwangbai Park, "Citizen participation in criminal trials of Korea: A statistical portrait of the first four years", July 5, 2012, p.8. <http://people.ucsc.edu/~hfukurai/documents/2-Han-Park.pdf>

³⁰³ Article 46. [Act on Citizen Participation in Criminal Trials]. Statutes of the Republic of Korea http://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=24228&type=new&key

³⁰⁴ Sang Hoon Han & Kwangbai Park, "Citizen participation in criminal trials of Korea: A statistical portrait of the first four years", July 5, 2012, p.9. <http://people.ucsc.edu/~hfukurai/documents/2-Han-Park.pdf>

³⁰⁵ Article 56, [Act on Citizen Participation in Criminal Trials]. Statutes of the Republic of Korea

Шүүх хуралдаан дахь суудал:

Шүүхийн иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдаанд шүүгч, прокурор, яллагдагч, түүний өмгөөлөгчийн дундах зайны зүүн талд суудаг. Гэрч нь иргэдийн төлөөлөгчийн өөдөөс харсан байрлалд суухаар хуульчилсан байна.

Иргэдийн төлөөлөгчийн жагсаалт:

Жил бүр тойргийн шүүхийн тэргүүн нь нийтийн удирдлага, аюулгүй байдлын сайдад иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтын асуудлаар хандаж тухайн шүүхийн харьяалалд буй 20 болон түүнээс дээш насны иргэний бүртгэлийн мэдээлэл /нэр, нас, хүйс, төрсөн огноо, хаяг/-ийг цахим хэлбэрээр ирүүлэхийг хүсдэг. Сайд тухайн хүсэлтийг хүлээн авснаас хойш тухайн шаардсан мэдээллийг 30 хоногийн дотор тойргийн шүүхэд хүргүүлнэ. Ингэж жил бүр тойргийн шүүхийн тэргүүн нь иргэдийн төлөөлөгчөөр ажиллах боломжтой иргэний анхдагч жагсаалтыг бэлтгэнэ. Энэ жагсаалтаас шаардлагатай тооны иргэдийн төлөөлөгчийг шүүхээс санамсаргүй тохиолдлоор сонгоно. Ингэж сонгох үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байдаггүй бөгөөд энэ нь тухайн иргэдийн төлөөлөгчийн аюулгүй байдалтай холбоотой байдаг.

*Иргэдийн төлөөлөгчийн баталгаа:*³⁰⁶

Хэн ч иргэдийн төлөөлөгчийг гүйцэтгэсэн үүрэгтэй нь холбогдуулан ажлаас чөлөөлөх, айлган сүрдүүлэхийг хориглоно. Мөн шүүн таслах үйл ажиллагаанд нь нөлөөлөх зорилгоор холбоо барих, харилцах, иргэдийн төлөөлөгчийн нэр, хаяг, бусад хувийн мэдээллийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглоно. Бодит аюул, заналхийлэл байна гэж үзвэл иргэдийн төлөөлөгчийн өөрийнх нь хүсэлтээр түүнийг хамгаалах шаардлагатай арга хэмжээ авахаар хуульчилсан байна.³⁰⁷

2.5. ОХУ-ын эрх зүйн зохицуулалт**(1) Нийтлэг зүйл**

ОХУ-ын 1993 оны Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт³⁰⁸ үйлдсэн гэмт хэрэгтээ цаазаар авах ял шийтгэгдэж болох хүн бүр иргэдийн төлөөлөгчийн оролцоотой шүүх /тангарагтны шүүх/-ээр хэргээ шийдүүлэх эрхийг баталгаажуулсан.³⁰⁹ Түүнчлэн ОХУ-ын Төрийн Думаас 2001.11.22-нд баталсан, Холбооны зөвлөлөөс 2001.12.05-нд баталгаажуулж, 2002.07.01-нээс хүчин төгөлдөр болсон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шүүхийн иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагааны талаар тусгайлан зохицуулсан байна.³¹⁰ Тодруулбал, тус хуулийн 12

³⁰⁶ Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн баталгаа, түүнийг хамгаалах зохицуулалт нь Монгол Улсын “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль”-тай төстэй зохицуулалттай байна. Л.Галбаатар

³⁰⁷ Chapter 5. “Measures for protection of jurors”, [Act on Citizen Participation in Criminal Trials], Statutes of the Republic of Korea

³⁰⁸ “Конституция Российской Федерации”, Официальное издание, Москва, Издательство “Юридическая литература”, 2009 <http://www.constitution.ru/official/pdf/constitution.pdf>

³⁰⁹ Статья 20. 2.Смертная казнь впредь до ее отмены может устанавливаться федеральным законом в качестве исключительной меры наказания за особо тяжкие преступления против жизни при предоставлении обвиняемому права на рассмотрение его дела судом с участием присяжных заседателей.

³¹⁰ “Уголовно-процессуальный Кодекс Российской Федерации” (2001, с изменениями от 2014).

дугаар хэсэг, 42 дугаар бүлэг буюу 324-353 дугаар зүйлд иргэдийн төлөөлөгчийн оролцоотой шүүн таслах үйл ажиллагааны талаар хуульчилжээ.³¹¹

ОХУ-ын шүүхийн иргэдийн төлөөлөгчид нь гэм буруутай эсэх асуудлаар дүгнэлт гаргаж даргалагч шүүгчид танилцуулна. Үүний дараа даргалагч шүүгч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд:

- шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн гаргасан “гэм буруугүй” гэх дүгнэлтийг батлах;
- шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн гаргасан “гэм буруутай” гэх дүгнэлтийг батлах буюу шүүгч “гэм буруутай” гэх дүгнэлт гаргаж ял төлөвлөх/Нөгөө талаар шүүхийн иргэдийн төлөөлөгчийн “гэм буруутай” гэх дүгнэлтийг шүүгч “гэм буруугүй” гэж өөрчилж болно./;
- эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох;
- шүүхийн иргэдийн төлөөлөгчөөс татгалзаж тухайн хэрэгт өөр шүүгч, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бүрэлдэхүүнийг дахин томилох.³¹²

(2) Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бүрэлдэхүүн

ОХУ-д Холбооны шүүхийн нэг даргалагч шүүгч, шүүхийн 12 төлөөлөгчөөс тангарагтны шүүх бүрддэг. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг ОХУ-ын 25-70 насны иргэнээс сонгох бөгөөд тухайн иргэн орос хэлний мэдлэгтэй, тухайн хэргийн талаар урьдчилсан дүгнэлтгүй байх шаардлагатай. Бүс нутгийн шүүхийн ерөнхий шүүгчийн мэдэгдлийн үндсэн дээр тухайн бүс нутгийн засаг захиргааны байгууллагаас шүүхийн иргэдийн төлөөлөгчийн жагсаалтыг хариуцан бүрдүүлнэ. Тухайлбал, Приморскийн бүс нутагт тухайн жилд шүүхийн 8000 иргэдийн төлөөлөгч шаардлагатай бол орон нутгийн засаг захиргааны байгууллагаас иргэдийн төлөөлөгчид тавих шаардлага хангасан иргэдийн жагсаалтыг бүс нутгийн засаг захиргааны байгууллагад хүргүүлэх бөгөөд бүс нутгийн шүүхээс засаг захиргааны байгууллагаас эцэслэн ирүүлсэн жагсаалтыг батлах буюу нийтэлж шүүхийн иргэдийн төлөөлөгчийг бүрдүүлнэ. Харин тухайн шүүх хуралдаанд шүүхийн иргэдийн төлөөлөгчдөөс хэнийг оролцуулахыг компьютерийн програмын тусламжтайгаар сонгож тусгайлсан жагсаалт гаргана. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлыг холбооны улсын төсвөөс гаргана.

(3) Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоотой хянан шийдвэрлэх хэргийн төрөл

ОХУ-ын Эрүүгийн хуулиар³¹³ дараах төрлийн гэмт хэргийг тангарагтны шүүх хянан шийдвэрлэдэг. Үүнд:

http://legislationline.org/download/action/download/id/5799/file/RF_CPC_2001_am02.2014_ru.pdf

³¹¹ Раздел XII. Особенности производства в суде с участием присяжных заседателей
Глава 42. Производство по уголовным делам, рассматриваемым судом с участием присяжных заседателей. Уголовно-процессуальный Кодекс Российской Федерации (2001, с изменениями от 2014).
http://legislationline.org/download/action/download/id/5799/file/RF_CPC_2001_am02.2014_ru.pdf

³¹² Статья 350. Виды решений, принимаемых председательствующим. Уголовно-процессуальный Кодекс Российской Федерации (2001, с изменениями от 2014).
http://legislationline.org/download/action/download/id/5799/file/RF_CPC_2001_am02.2014_ru.pdf

³¹³ “Уголовный Кодекс Российской Федерации” (1996, с изменениями от 2012)

http://legislationline.org/download/action/download/id/4250/file/RF_CC_1996_am2012_ru.pdf

- хүнийг санаатай алах гэмт хэрэг, хүн хулгайлах гэмт хэрэг, хүчингийн гэмт хэрэг;
- насанд хүрээгүй этгээдийг худалдах гэмт хэрэг, терроризм.

Түүнчлэн тангарагтны шүүх нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 34, 35 дугаар зүйлийн дагуу зохих шүүхээс шилжүүлсэн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэдэг.

ОХУ-д шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн дунд эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс тодорхой хувь эзлэх болсонтой холбоотойгоор 2010 оны байдлаар иргэдийн 30% нь шүүгчээс илүү шүүхийн иргэдийн төлөөлөгчид итгэдэг, 21% нь шүүгчид илүү итгэдэг гэжээ.³¹⁴

(4) Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрх

ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 333 дугаар зүйлд шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрхийг хуульчилсан байна. Тухайлбал, шүүхийн иргэдийн төлөөлөгч нь тухайн эрүүгийн хэрэгтэй холбоотой хуулийн хэм хэмжээний талаар даргалагч шүүгчээр тайлбарлуулах эрхтэй байна. Харин шүүхийн иргэдийн төлөөлөгч нь шүүхээс гадуур тухайн хэргийн мэдээлэл цуглуулах, хэргийн оролцогчтой буюу шүүх бүрэлдэхүүнд багтаагүй бусад этгээдтэй харилцах, шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн дундах санал, санал хураалтыг задруулахыг тус тус хориглосон. Шүүхийн иргэдийн төлөөлөгч нь хориглосон үйлдэл гаргавал даргалагч шүүгч нэг удаа сануулах бөгөөд хоёр дахь удаагаа зөрчил гаргавал тухайн иргэдийн төлөөлөгчийг гаргаж, өөр төлөөлөгчөөр солих эрхтэй байна.

Иргэдийн төлөөлөгч нь шүүх хуралдаанд хэргийн оролцогчид асуулт тавих эрхээ иргэдийн төлөөлөгчдийн ахлагчаар дамжуулан эдлэх бөгөөд даргалагч шүүгчид танилцуулах асуултыг бичгээр үйлдсэн байх шаардлагатай. Даргалагч шүүгч нь асуултыг томъёолон хэргийн оролцогчид асуулт асуух бөгөөд иргэдийн төлөөлөгчийн асуултыг хэрэгсэхгүй орхих эрхтэй байна.

(5) Шүүхийн иргэдийн төлөөлөгчид дүгнэлт гаргах

Шүүх хуралдаан даргалагч дүгнэлт гаргах цаг болсон талаар үг хэлсний дараа шүүхийн иргэдийн төлөөлөгчид дүгнэлт гаргахаар тусгай тасалгаанд орно. Энэ тасалгаанд иргэдийн төлөөлөгчдөөс өөр хүн орохыг хориглоно. Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг ахлах төлөөлөгч удирдан явуулна. Иргэдийн төлөөлөгчид тавигдсан асуултад хариулж, санал нэгтэй дүгнэлт гаргахыг эрмэлзэнэ. Ийнхүү санал нэгтэйгээр дүгнэлт гаргаж чадаагүй тохиолдолд гар өргөж, илээр санал хураах бөгөөд ахлах төлөөлөгч хамгийн сүүлд саналаа өгнө.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт нь хоёрдмол утгагүй, нэг мөр ойлгогдохоор байх ёстой бөгөөд тавигдсан асуултад “Тийм, гэм буруутай”, “Үгүй, гэм буруугүй” гэх байдлаар хариулсан байна. Санал хураалтын үндсэн дээр тухайн дүгнэлтийг гаргасан бол ахлах төлөөлөгч нь дүгнэлтэд саналын хувийг бичсэн байна. Тавигдсан асуулт, өгсөн хариулт бүхий дүгнэлтийн төгсгөлд ахлах төлөөлөгч гарын үсэг зурсан байна. Талуудын үгийг сонссоны дараа шинэ нөхцөл байдал

³¹⁴ “Jury trials in modern Russia”, *THE ISCIP ANALYST*. (Russian Federation), *An Analytical Review*, Volume XVI, Number 7, 28 January 2010. <http://www.bu.edu/phpbin/news-cms/news/?dept=732&id=55374>

илэрлээ гэж даргалагч шүүгч үзвэл, энэ тухай үг хэлсний дараа шүүхийн иргэдийн төлөөлөгчид дахин дүгнэлт гаргахаар тусгай тасалгаанд орно.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлтийг ахлах төлөөлөгч танилцуулах бөгөөд ингэхдээ тавигдсан асуултуудыг алгасаж, зөвхөн хариултуудыг уншина. Ийнхүү уншиж сонсгосны дараа дүгнэлтийг даргалагч шүүгчид гардуулах бөгөөд хэргийн материалд хавсаргана. Үүний дараагаар даргалагч шүүгч нь шүүхийн иргэдийн төлөөлөгчид талархал илэрхийлээд шүүх хуралдаан дахь иргэдийн төлөөлөгчийн оролцоо дууссаныг мэдэгдэнэ.³¹⁵

2.6. Тайванийн эрх зүйн зохицуулалт³¹⁶

Тайвань улсын тухайд хэрэг, маргааныг мэргэшсэн шүүгч хянан шийдвэрлэх тул иргэдийн төлөөлөгчийн тогтолцоог хуулиар хүлээн зөвшөөрдөггүй. Харин Шүүх яамнаас “Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааныг ажиглах тухай журам”-ыг боловсруулсан бөгөөд уг журам батлагдвал иргэдийн төлөөлөгч шүүн таслах ажиллагаанд ажиглагчийн байр суурьнаас оролцох боломжтой болох юм. Ийнхүү Тайваньд шүүн таслах ажиллагаанд иргэдийн төлөөллийг оролцуулахаар хэлэлцэгдэж байгаа нь дэлхийн нийтийн чиг хандлага, иргэдийн оролцоотой шийдвэр гаргах үйл ажиллагааг сайшааж буйн нэг шинж юм.

(1) Нийтлэг зүйл

Тайваньд иргэд шүүн таслах ажиллагаанд оролцож, шүүхийн шийдвэр гаргахад таслах эрхтэй оролцох нь Тайванийн Үндсэн хуульд Шүүгч нь хуулийн дагуу бие дааж шүүн таслах эрхтэй байж, хэн ч хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно³¹⁷ гэж заасныг зөрчих тул Тайванийн Шүүх яам (*The Judicial Yuan*)-аас 1988 оноос эхлэн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд ардын төлөөллийг оролцуулах тухай судалж, улмаар энэ чиглэлээр хэрэгжүүлэх хэд хэдэн журмын төслийг боловсруулсан байдаг. Үүнд “Эрүүгийн хэрэгт шүүн таслах ажиллагаанд оролцуулах тухай туршилтын журам” (1988 оноос 1998 он хүртэл), “Мэргэжилтнийг шүүн таслах ажиллагаанд оролцуулах тухай туршилтын журам” (2000 оноос - 2006 он хүртэл) орно. Эдгээр төслүүд нь тодорхой ялгаатай хэдий ч иргэдийг хэрхэн мэргэжлийн шүүгчтэй хамтран шүүн таслах ажиллагаанд оролцох, тухайн гэмт хэргийн нотлох баримтыг дүгнэх, хууль, ялын төрөл, хэм хэмжээ зэргийг хэрэглэх талаарх үзэл санаа, зорилгоороо адил болно.³¹⁸

Шүүх яам (*The Judicial Yuan*)-аас хамгийн сүүлд 2012 оны 1 дүгээр сард “Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааныг ажиглах тухай журам”-ын төслийг Гүйцэтгэх яаманд (*The Executive Yuan*) өргөн барьсан. Энэхүү “ажиглагч-иргэдийн төлөөлөгч” хуулийн төсөл нь туршилтын хөтөлбөрт хамаарах бөгөөд үүнийг Гүйцэтгэх яамнаас

³¹⁵ Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн үүрэг дуусгавар болсон нь тэднийг шүүх хуралдааны танхимаас гаргах нөхцөл болохгүй бөгөөд иргэдийн төлөөлөгчид шүүх хуралдаан дуустал танхимд суух эрхтэй. Мөн дүгнэлтийг нь дүгнэн шинжлэхэд ямар нэг хэлбэрээр тайлбар өгөх, оролцох ёсгүй.

³¹⁶ Ц.Мандах “Шүүхийн иргэдийн төлөөлөгч: Тайванийн шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцооны хэтийн төлөв” лавлагаа, “Судалгааны тайлангийн эмхтгэл (2014)”, Улаанбаатар, 2015 он, 176-182 дахь тал

³¹⁷ Тайванийн Үндсэн хуулийн 80 дугаар зүйл.

³¹⁸ <http://www.judicial.gov.tw/Guan-Shen/intro01.asp>

хүлээн зөвшөөрч, одоогоор хууль тогтоох яам (*The Legislative Yuan*)-д хэлэлцэгдэн хянагдаж байна. Тус акт батлагдвал туршилтын хөтөлбөр нь Тайванийн 21 тойргийн шүүхүүд (*district courts*) дотроос өмнөд Тайванийн Чиаи тойргийн шүүх болон Тайбэй хотын Шилин тойргийн шүүхэд гурван жилийн хугацаатай хэрэгжих боломжтой юм.³¹⁹

(2) Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бүрэлдэхүүн

Тайванийн одоогийн шүүхийн тогтолцоогоор хүнд гэмт хэргийг тойргийн гурван шүүгч хамтран хэлэлцдэг ба “хөндлөнгийн шүүгч”-ийн журмаар яллагч (прокурор) болон өмгөөлөгчийн гаргасан тайлбар, хууль зүйн асуултуудыг анхааралтайгаар хэлэлцдэг байна. Хэрэв яллагдагч гэм буруутай нь тогтоогдвол шүүгч ялын хэмжээг тогтоодог.

Энэхүү туршилтын хөтөлбөрөөр таван иргэдийн төлөөлөгч нь ажиглагчаар долоон жил буюу түүнээс дээш хугацаагаар шоронд хорих эсвэл цаазаар авах ял оногдуулах хүнд гэмт хэрэгт хамаарах хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгчидтэй хамт сууж хэлэлцэнэ. Иргэдийн төлөөлөгчид нь 23 ба түүнээс дээш насны сугалаагаар сонгогдсон иргэдээс бүрдэнэ. Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд шүүгчтэй хамт зөвлөлдөх, яллагдагч, гэрч, хохирогчоос асуулт асуухыг зөвшөөрдөг. Яллагч болон өмгөөлөгчийн мэтгэлцээн, гэрч шүүх хуралдаанд оролцох, хохирогч мэдүүлэг өгөх зэрэг аливаа шүүх хуралдааны явцыг иргэдийн төлөөлөгч нь ажиглаж, шийдвэр гаргах хэлэлцүүлгийн үед хэргийг сайтар нягталж судалсны үндсэн дээр яллагдагчийг гэм буруутай эсэх талаар мөн ямар ял оногдуулах тухай саналаа өгнө.

Энэ тогтолцооны зорилго нь шүүх хуралдаан болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн ажиглагч-иргэдийн төлөөлөгч биечлэн оролцож, тухайн үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, улмаар хэргийн нотлох баримтыг үнэлэх, хууль хэрэглэх, ялын хэмжээг тогтоох зэрэг ажиллагааны талаар цогц ойлголттой болгоход оршино. Түүнчлэн шүүгч ажиглагч-иргэдийн төлөөлөгчийн зүгээс гаргасан олон хувилбарт саналыг харгалзан үзэж, хуулийн зорилгод тулгуурласан, ард иргэдийн хууль зүйн сэтгэлгээнд илүү тохирсон шийдвэр гаргах боломжтой юм.³²⁰

(3) Иргэдийн төлөөлөгчийг сонгох

Тайванийн Шүүх яам (*Judicial Yuan*)-аас дэвшүүлсэн шүүх хуралдааныг ажиглах тогтолцоо нь тодорхой шалгуур, журмаар иргэдийн төлөөлөгчийг ард иргэдийн дундаас сонгон шүүх хуралдааныг ажиглуулахаар томилдог тогтолцоо юм. Тухайн ажиглагч нь гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд эхнээс нь дуустал оролцдог ба шүүгчийг шийдвэрээ гаргахад нь таслах эрхтэй оролцдоггүй хэдий ч шүүгч шийдвэрээ гаргахад нь харгалзан үзэж болох саналыг дэвшүүлдэг. Шүүгч саналыг харгалзан үзэхдээ:³²¹

1. энгийн иргэдийг шүүх хуралдаанаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах бололцоогоор хангадаг байх,

³¹⁹ The People's Court. Taiwan Review. <http://taiwanreview.nat.gov.tw/ct.asp?xItem=194416&CtNode=1446> 2015.06.18

³²⁰ Ц.Мандах “Шүүхийн иргэдийн төлөөлөгч: Тайваний шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцооны хэтийн төлөв” лавлагаа, “Судалгааны тайлангийн эмхтгэл (2014)”, Улаанбаатар, 2015 он, 179 дэх тал

³²¹ <http://www.judicial.gov.tw/Guan-Shen/intro01.asp>

2. энгийн иргэдийг шүүх хуралдааны шийдвэр гаргах явцад саналаа илэрхийлж, тухайн саналыг шүүгч шийдвэрээ гаргахад харгалзан үздэг байх зорилготой юм. “Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааныг ажиглах тухай журам”-ын төсөл нь дараах агуулгатай байна.³²² Үүнд:

- энгийн иргэдээс ажиглагч-иргэдийн төлөөлөгчийг сонгох бөгөөд үүнд 23 нас хүрсэн, тухайн шүүхийн нутаг дэвсгэрийн харьяанд 4 сараас дээш хугацаагаар оршин суусан, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн ажиглагч-иргэдийн төлөөлөгчөөр эсвэл ажиглагч-иргэдийн төлөөлөгчийн нөөцөд орохоор сонгогдож болно. Тус ажиглагч-иргэдийн төлөөлөгч нь тухайн хэргийн талаарх нууцыг хадгалах, шүүх хуралдаанд ирэх тухай тангараг өргөх үүрэгтэй байдаг.

- зарчмын хувьд иргэдийн төлөөлөгч зөвхөн хүнд гэмт хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг ажиглана. Иргэдийн төлөөлөгчийн шүүх хуралдааныг ажиглах хөтөлбөр нь эхлэл төдий тул ач холбогдол, зардал зэргийг харгалзан үзэхдээ ажиглагч-иргэдийн төлөөлөгчийг гагцхүү хүнд гэмт хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд ажиллуулахаар болсон байна.

- ажиглагч-иргэдийн төлөөлөгчтэй шүүх хуралдаан 3 мэргэжлийн шүүгч болон 5 иргэдийн төлөөлөгчөөс бүрдэнэ. Энэ загвар нь Япон улстай адилхан ба ажиглагч-иргэдийн төлөөлөгч нь шүүгчидтэй хамт суудаг байна. Ийнхүү шүүгч нь иргэдийн төлөөлөгчтэй хамт сууснаар илүү нягт хамтарч, гэмт хэргийн нотлох баримтыг үнэлэх, хууль хэрэглэх болон ялын хэмжээг тогтоох зэрэг ажиллагааг явуулснаар иргэдтэй илүү ойр гэдгээ харуулдаг. Шүүхээс шаардлагатай тохиолдолд 1-ээс 4 хүртэлх ажиглагч-иргэдийн төлөөлөгчийг сонгон нөөцөд оруулдаг.

- ажиглагч-иргэдийн төлөөлөгч нь зөвхөн шүүх хуралдаанд оролцдог ба шүүх хуралдааны бэлтгэл ажилд оролцдоггүй. Учир нь ажиглагч-иргэдийн төлөөлөгчийг энгийн иргэдээс сонгодог тул цаг завьг нь харгалзан үзэж, зөвхөн шүүх хуралдаанд оролцохыг шаарддаг.

- шүүх нь хүсэлтийн дагуу эсхүл эрхийнхээ хүрээнд ажиглагч-иргэдийн төлөөлөгч оролцох ёстой шүүх хуралдааныг иргэдийн төлөөлөгчгүйгээр явуулж болно. Иргэдийн төлөөлөгч нь хэргийн зохигчтой ямар нэг холбоотой, ашиг сонирхлын зөрчилтэй байх, түүнчлэн тухайн хэрэг ээдрээ төвөгтэй, олон төрлийн нарийн мэргэжлийн мэдлэг шаардсан зэрэг шалтгаанаар шүүх иргэдийн төлөөлөгчтэй шүүх хуралдааныг явуулахад тохиромжгүй гэж үзвэл шүүх хуралдааныг иргэдийн төлөөлөгчгүйгээр явуулж болно.

- шүүх хуралдаан дууссаны дараа ажиглагч-иргэдийн төлөөлөгч зөвхөн саналаа илэрхийлэх эрхтэй ба эцсийн шийдвэр гаргахад санал өгөх эрх эдэлдэггүй. Иргэдийн төлөөлөгчдийн олонхийн саналтай шүүгчийн санал зөрсөн тохиолдолд шүүгч шийдвэртээ тайлбар бичнэ. Шүүгч санал зөрсөн тохиолдолд татгалзсан үндэслэл болон тайлбараа тодорхой бичих шаардлагатай тул иргэдийн төлөөлөгчийн саналыг тодорхой хэмжээгээр харгалзан үзэх боломж бүрэлддэг.

- энэ хөтөлбөр нь одоогоор туршилтын хэлбэрээр явагдаж байгаа ба тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хөтөлбөрийн давуу болон сөрөг талыг тодорхойлох боломж бүрдэх юм. Тус хөтөлбөрийг туршилтын журмаар хэрэгжүүлэх 2 шүүхийг

³²² http://www.rmjcw.cn/gtfz/201203/t20120314_825595.html

сонгохдоо нэг шүүхийг хүн ам ихээр суурьшсан томоохон хотын анхан шатны тойргийн шүүхээс, нөгөө нэг шүүхийг орон нутгийн төвийн анхан шатны тойргийн шүүхээс сонгохоор болсон байна.

(4) Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт

Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааныг ажиглах тогтолцоог туршилтын журмаар нэвтрүүлснээр энгийн иргэд шүүн таслах ажиллагаанд оролцож, саналаа илэрхийлэх эрхийг эдлэх юм. Иргэдийн төлөөлөгчийн гаргасан шийдвэрийг шүүгч харгалзан үзэж болно. Гэхдээ тухайн хэрэгт ял оногдуулах эсэх болон эцсийн шийдвэр гаргах эрх нь шүүгчид хадгалагдана. Хэрэв шүүгч иргэдийн төлөөлөгчдийн шийдвэрийг эс зөвшөөрвөл, тайлбараа амаар болон бичгээр гаргана.³²³

Хэрэв шүүгч нь иргэдийн саналыг харгалзан үзэх нь зүйтэй гэж үзвэл, тус саналд нь хүндэтгэлтэй хандаж, шийдвэртээ тусгадаг ба санал зөрсөн тохиолдолд Үндсэн хуульд тусгасан зарчмын дагуу бие дааж хэргийг шийдвэрлэдэг. Энэ тогтолцоо нь мэргэжлийн бус шүүгчийг шүүх хуралдаанд оролцуулснаас үүсэх үл итгэлцэл, Үндсэн хууль болон бусад хуулийг зөрчинө гэсэн хардлагаас сэргийлж байдгаараа онцлогтой.

Дүгнэлт

Түүхэн хөгжлийн хувьд шүүн таслах ажиллагаанд иргэдийг оролцуулах нь хэмжээгүй эрхт хаант засгийн эрх мэдлийг хязгаарлах, шударга ёсыг сахиулах эрмэлзэлтэй холбоотой байсан бол орчин цагт энэ нь олон нийтийн хяналт, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгод чиглэх болжээ. Иргэд шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа нь шүүхийн ил тод, нээлттэй байдал бэхжих, шүүхийн шийдвэр үндэслэлтэй, ойлгомжтой байх, иргэдийн эрх зүйн мэдлэг дээшлэх, шүүгч иргэд хоорондын харилцаа сайжрах зэрэг олон сайн талыг агуулдаг. Харин нөгөө талаас иргэдийг туршлагатай хуульчидтай эн зэрэгцэн шийдвэр гаргах чадвартай эсэхэд эргэлзэх, хуульчдын зүгээс уг зохицуулалтыг төдийлөн сайшаахгүй байх зэрэг сөрөг хандлагууд байдаг байна.

Монгол Улсын хувьд иргэдийн төлөөллийг шүүн таслах ажиллагаанд оролцуулах, шүүгчийн адил шийдвэр гаргах боломжийг олгож байсан түүхэн уламжлалтай. Энэ тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын аливаа шүүн таслах газруудыг байгуулах дүрэм /1926.04.16/, 1940 оны Үндсэн хууль, 1960 оны Үндсэн хуулиас харж болно. Харин 1992 оны Үндсэн хуулийн 52 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оруулна” гэж заасан нь ерөнхий зохицуулалт бөгөөд ямар байдлаар оролцуулах, хэрхэн бодитой, үр нөлөөтэй тогтолцоог бий болгох асуудлыг тусгайлсан хуулиар зохицуулахаар байна. Хэдийгээр 1994, 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдал, шүүх хуралдаанд оролцох

³²³ The People's Court. Taiwan Review. <http://taiwanreview.nat.gov.tw/ct.asp?xItem=194416&CtNode=1446>
2015.06.20

нийтлэг журмыг тусгасан боловч бодитой, үр нөлөөтэй тогтолцоог хэрэгжүүлж чадаагүй тул УИХ-аас анх удаа шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг өргөн хүрээнд агуулсан, шинэлэг зохицуулалт бүхий Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тухай хуулийг 2012 онд баталсан юм. Гэвч тус хуулийн гол үзэл санаа болсон “шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгч оролцох” гэсэн агуулгыг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн хэмээн Үндсэн хуулийн цэцээс хүчингүй болгосон нь цаашид шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн зохицуулалт ямар байх, хэрхэн үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд анхаарал хандуулах шаардлага бий болсон юм.

Монгол Улсад 2014 онд анхан шатны шүүхээр 2187 хэргийг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн бөгөөд түүнд 4701 иргэдийн төлөөлөгч оролцсон байна.³²⁴ Харин шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр оролцсоноор шүүхийн талаарх тогтсон ойлголт, сэтгэгдлийг хэрхэн өөрчилсөн талаарх сэтгэгдэлд³²⁵ 229 иргэдийн төлөөлөгчийн 21.3 хувь нь өмнө нь шүүхийг шударга бус шийдвэр гаргадаг гэсэн ташаа ойлголттой байсан гэдгээ хүлээн зөвшөөрч, шүүх хэргийг хараат бусаар, бодит байдалд нийцүүлэн нотлох баримтыг тал бүрээс нь шинжлэн судалсны үндсэн дээр шударгаар шийдвэрлэдэг гэсэн ойлголттой болсон байна. Эндээс иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх нэг гол хүчин зүйл бол шүүхийн иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаанд оролцуулах явдал гэж харагдаж байна.

Хэдийгээр шүүхийн иргэдийн төлөөлөгч шүүн таслах эрхгүй боловч иргэдийн төлөөлөгчөөс гарах дүгнэлтийн агуулга, ач холбогдлыг нэмэгдүүлэх, үнэлэх шаардлагатай байна. Тодруулбал, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцож, хэргийн үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар дүгнэлт гаргаж буй боловч тухайн дүгнэлтийг үнэлэх, ач холбогдолтойд тооцох асуудлыг орхигдуулсан хэвээр байна. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар иргэдийн төлөөлөгчийн гаргасан дүгнэлтийг шүүх шийдвэртээ тусгах ба үүнээс өөрөөр иргэдийн төлөөлөгчийн гаргасан гэм буруутай эсэх талаарх дүгнэлтийг иргэний хэргийн шүүхийн шийдвэр, эрүүгийн хэргийн цагаатгах болон шийтгэх тогтоолд тусгах талаар тодорхой зохицуулалт байхгүй байна. Энэ нь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүх үнэлэх, шүүхийн шийдвэрт иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох асуудал шийдэл хүлээж буйг харуулж байна.

Иймд судлаачдын зүгээс өнөөгийн зохицуулалтын хүрээнд шүүхийн иргэдийн төлөөлөгчийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд шаардлагатай дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

³²⁴ Шүүхийн ерөнхий зөвлөл, “Монгол Улсын шүүн таслах үйл ажиллагааны тайлан-2014”, Улаанбаатар, 2015 он, 155 дахь тал.

³²⁵ ШЕЗ-ийн Шүүхийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс, “2015 оны 05 дугаар сарын 04-нөөс 2015 оны 08 дугаар сарын 01-нийг хүртэл хугацаанд Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн явцыг судлах зорилгоор хийгдсэн мониторингийн судалгаа” <http://www.judcouncil.mn/main/2334--.html>

Санал, зөвлөмж

Иргэдийг шүүх хуралдаанд оролцон шийдвэр гаргахад шүүгчийн адил мэдлэг, боловсролтой эсэхэд олон нийтийн зүгээс эргэлзэх боловч энэхүү тогтолцоо нь шүүхийн ил тод, нээлттэй байдал бэхжих, шүүхийн шийдвэр үндэслэлтэй, ойлгомжтой байх, иргэдийн эрх зүйн мэдлэг дээшлэх, шүүгч иргэд хоорондын харилцаа сайжрах олон асуудалд эерэг хариулт өгдөг. Судлаачдын зүгээс тогтолцооны хувьд шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч шүүгчийн адил шийдвэр гаргах процесст оролцдог байх хувилбарыг илүүтэй дэмжиж байна. Одоогийн нөхцөл байдалд шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдал тодорхой бус³²⁶ байх тул дараах зохицуулалтуудыг хийх нь илүү үр нөлөөтэй байж болох юм.

1. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн гаргасан дүгнэлтийг анхан шатны шүүхээс шийдвэр, шийтгэх болон цагаатгах тогтоолд тусгах

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн гаргасан дүгнэлтийг зөвхөн захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэртээ тусгаж буй нь хангалттай бус байна. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн гаргасан дүгнэлтийг иргэний хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, эрүүгийн шүүн таслах ажиллагааны шийтгэх болон цагаатгах тогтоолд тусгах, улмаар дээд шатны шүүхээс уг дүгнэлтийг хэрхэн үнэлсэн талаарх үндэслэл бүхий саналаа магадлал, тогтоолдоо тусгах нь зүйтэй юм. Түүнчлэн “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-д шүүхийн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулга, хэлбэрийн шаардлагыг нэмж тусгах, үүний дараагаар хуулийн төслийг батлуулах шаардлагатай байна.

2. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр оролцуулах тул “томилох” гэсэн ойлголтыг процессын хуулиудаас хасах

“Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль” батлагдсантай холбоотойгоор шүүхийн иргэдийн төлөөлөгчийг шүүхээс томилох бус, сонгон шалгаруулалтын үндсэн дээр оролцуулах болсон. Энэ нь иргэдийн төлөөлөгчийг шүүн таслах ажиллагаанд оролцуулахад шүүгчийн зүгээс ямар нэг ажиллагаа хийгдэхгүй бөгөөд түүнийг сонгон шалгаруулах, оролцуулах асуудал нь тамгын газрын зүгээс хийх зохион байгуулалтын шинжтэй ажил юм. Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд дахь шүүхийн иргэдийн төлөөлөгчийг томилох хуулийн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар өөрчлөх шаардлагатай юм.

3. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх, үүрэг, шүүх хуралдааны журам, оролцооны талаарх тайлбарыг шүүхийн захиргаа бус шүүгч өөрөө тайлбарлах, таниулах

³²⁶ Үндсэн хуулийн цэцээс 2014 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбоотойгоор шүүхийн иргэдийн төлөөлөгч “хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд оролцох” гэсэн зохицуулалтыг хүчингүй болгосон. Энэ нь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцоог “идэвхгүй” байдлаар үйл ажиллагаа явуулахад хүргэж байна гэж үзэж байна.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчид эрх, үүрэг тайлбарлах үүргийг шүүхийн тамгын газар хэрэгжүүлж байгаа нь хангалтгүй буюу оновчгүй байгаа нь практикт ажиглагдаж байгаа бөгөөд үүнийг шүүгчид хуваарилах нь тохиромжтой. Ингэснээр шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо, түүний дүгнэлтийн учир холбогдлыг иргэд илүү ухамсарлаж, түүнээс гарах дүгнэлтийн ач холбогдол нэмэгдэх боломжтой. Энэ нь зөвхөн иргэдийн төлөөлөгчийн хуулийн зохицуулалтыг тайлбарлахаас илүү өргөн хүрээтэй ойлголт юм.

4. Шүүхийн иргэдийн төлөөлөгчид олгох хөлсийг шүүхийн зардалд хамааруулах

“Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль”-д зааснаар шүүхийн иргэдийн төлөөлөгчид олгох хөлсний асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл, Санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран шийдвэрлэсэн. Харин иргэдийн төлөөлөгчид олгох хөлсний хэмжээг тодорхойлох, хуваарилах, гаргуулах асуудлыг процессын хуулиудад зааснаар шийдвэрлэнэ. Энэ нь шүүхийн шийдвэрээс хамаарч шүүхийн иргэдийн төлөөлөгчтэй холбоотой зардлыг хэргийн оролцогч, зохигчдод хуваарилах, улсын төсөв дэх иргэдийн төлөөлөгчтэй холбоотой зардлыг үр дүнтэй зарцуулахад ач холбогдолтой юм.

5. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг тодорхой хугацаанд олон нийтэд нээлттэй байлгах

Тухайн анхан шатны шүүхийн харьяаллын нутаг дэвсгэрт оршин суудаг, 25 насанд хүрсэн, ял шийтгүүлж байгаагүй, сонгогдсон үедээ эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн оролцогч биш, монгол хэлээр чөлөөтэй ярьж, ойлгодог Монгол Улсын иргэн хэн боловч шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцох боломжтой. Энэ нь иргэд шүүн таслах ажиллагаанд өөрийн биеэр оролцох, саналаа илэрхийлэх боломжийг олгосон шинэлэг, бөгөөд ач холбогдол бүхий зохицуулалт юм. Харин уг зохицуулалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр ажиллах иргэн буюу тухайн иргэдийн төлөөлөгчийн жагсаалтад байгаа этгээдийн талаар бусдаас гомдол, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх ёстой. Иймд жагсаалтад бүртгэлтэй иргэдийн зан байдал, ёс суртахууны талаарх бусдаас өгөх үнэлэмжийг тодруулах зорилгоор 10-14 хоногийн хугацаанд олон нийтэд нээлттэй байлгах нь зохимжтой байна. Харин бусад иргэдийн зүгээс ирүүлэх санал, сэтгэгдэл нь бодитой байхад анхаарч ажиллах нь зүйтэй.

Монгол Улсад хэрэгжүүлж болох хувилбар

Дээр дурдсанчлан шүүхийн иргэдийн төлөөлөгчийн өнөөгийн тогтолцоог үр нөлөө бүхий, бодитой хэрэгжүүлэх тогтолцоог бий болгохын тулд асуудлыг илүү өргөн хүрээнд авч үзэх шаардлагатай. Хэдийгээр судлаачдын хувьд шүүхийн иргэдийн төлөөлөгч шүүн таслах ажиллагаанд шүүгчийн адил шийдвэр гаргах эрх хэмжээтэй оролцох нь шүүх эрх мэдлийн байгууллагад ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой боловч өнөөгийн эрх зүйн

зохицуулалтаар шийдвэрлэх боломжгүй байна. Иймд хууль тогтоомжид өөрчлөлт оруулах байдлаар дараах хувилбарыг бий болгож, хэрэгжүүлэх саналтай байна.

Нэг. Эрүүгийн хэргийг шүүн таслах ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийн оролцоог нэмэгдүүлэх;

Эрүүгийн хэргийг шүүн таслах ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийн оролцуулахад онцгой анхаарах шаардлагатай. Ялангуяа, онц хүнд гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн төлөөлөгчийн тоог нэмэгдүүлэх, тэдний дүгнэлтийг авч хэлэлцэх, шийдвэр гаргах процесст оролцуулах нь өндөр ач холбогдолтой байна.

Хоёр. Иргэн болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоог багасгах, маргааны төрлөөр оролцуулах;

Иргэн болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийн оролцоог бууруулж болно. Өнөөгийн зохицуулалтаар бүрэлдэхүүнтэй бүхий л хэрэгт оролцож байгаа иргэдийн төлөөлөгчийг хэргийн төрөл, шийдвэрлэх асуудлаас хамаарч оролцуулах эсэх асуудлыг талууд өөрсдөө шийдвэрлэх, эсхүл хэрэг, маргааны төрлийг тодорхойлох замаар хумих боломжтой.

Үүнээс гадна шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоотой шийдвэрлэх зарим хэргийг тодорхойлох боломжтой. Тухайлбал, жижиг төрлийн хэргийг иргэдийн төлөөлөгч шийдвэрлэх, эсхүл онц ноцтой зарим төрлийн гэмт хэрэгт зөвхөн иргэдийн төлөөлөгч оролцох. Үүний тулд яллагдагч, түүний өмгөөлөгчийн зөвшөөрлөөр буюу хүсэлтээр шүүн таслах ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийг оролцуулдаг байх нөхцөлийг бүрдүүлэх юм.

Гурав. Иргэдийн төлөөлөгчийн шүүх хуралдаан дахь дотоод зохион байгуулалтыг хуульчлах.

Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулиудад зааснаар шүүх хуралдаанд 3 хүртэл тооны иргэдийн төлөөлөгч оролцуулна. Харин нэгдсэн байдлаар дүгнэлтээ хэрхэн гаргах асуудлыг хуулиар зохицуулаагүй байдаг тул дүгнэлтээ нэгтгэн гаргах асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй. Уг асуудлыг заавал хуулиар зохицуулах бус журмаар зохицуулах боломжтой бөгөөд энэ нь практикт өнөөг хүртэл шийдвэрлэж чадаагүй зарим асуудлыг шийдвэрлэх гарц болно. Түүнээс гадна “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийн 12.4-т “Шүүх бүрэлдэхүүн хэргийг ээдрээ төвөгтэй гэж үзвэл шүүгдэгч, хохирогч, хэргийн оролцогч, төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд тав буюу долоо хүртэл иргэдийн төлөөлөгчийг оролцуулж болно” гэж заасны дагуу хэрэв 5-7 хүртэл тооны иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцуулах бол тэдний зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатайг харуулж байна. Үүнээс гадна иргэдийн төлөөлөгчид дүгнэлтээ гаргах “иргэдийн төлөөлөгчдийн тасалгаа”-тай болгох шаардлагатай.

ШҮҮГЧИЙГ СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ³²⁷**Удиртгал**

Шүүгчийг сэлгэн ажиллуулах зорилго нь шүүхийн зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүхийн хүний нөөцийг оновчтой байршуулахад оршино. Дээрх зорилгыг хэрэгжүүлснээр буюу шүүгчийг сэлгэн ажиллуулах нь шүүгчдэд шүүн таслах ажлын дадлага эзэмшүүлэх, туршлага судлуулах, хараат бус байдлыг бэхжүүлэх, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүгчийг гаднын нөлөөлөлд автахаас урьдчилан сэргийлэх, шүүхийн боловсон хүчнийг оновчтой байршуулах зэрэг ач холбогдолтой гэж үздэг.

Гэвч шүүгчийг сэлгэн ажиллуулах эрх зүйн зохицуулалт бүрэн бус бөгөөд сэлгэн ажилласан шүүгчдэд зарим асуудал тулгамдсаар байна. Иймд шүүгчийг сэлгэн ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, сэлгэн ажиллах шүүгчийн эдийн засгийн баталгааг сайжруулах асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай байна. Энэ хүрээнд тус судалгааны ажлыг 1/ Шүүгчийг сэлгэн ажиллуулах түүний эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал 2/ Шүүгчийг сэлгэн ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь гэсэн хоёр үндсэн хэсэгт авч үзэж, түүний үндсэн дээр нэгдсэн дүгнэлт хийж, санал зөвлөмж боловсрууллаа.

Нэг. Шүүгчийг сэлгэн ажиллуулах эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал**1.1. Монгол Улсын шүүгчийг сэлгэн ажиллуулах эрх зүйн зохицуулалт**

Монгол Улсад шүүгчийг сэлгэн ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг түүхэн хөгжлөөс нь авч үзвэл 1993.02.04-ний өдрийн Шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлд Шүүхийн Ерөнхий зөвлөл (цаашид “ШЕЗ” гэх)-ийн бүрэн эрхийг хуульчилсан хэдий ч шүүгчийг сэлгэн ажиллуулах асуудлаарх ШЕЗ-ийн чиг үүргийн эрх зүйн зохицуулалтыг орхигдуулсан байна.³²⁸

³²⁷ Энэ судалгааны ажлыг ШСМСХ-ийн судалгаа хариуцсан референт М.Сэлэнгэ, судлаач Л.Галбаатар нар хамтран гүйцэтгэсэн болно.

³²⁸ Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрх: 1/ зохих байгууллага, албан тушаалтантай зөвшилцөн Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, байршлыг тогтоох тухай саналыг Улсын Их Хуралд оруулах; 2/ бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо, цалингийн хэмжээг тогтоох тухай саналыг Улсын Их Хуралд оруулах; 3/ шүүхийн төсвийн төслийг зохих журмын дагуу Улсын Их Хуралд оруулах, Батлагдсан төсвийг оруулах; 4/ шүүгчийг томилуулах, чөлөөлүүлэх, огцруулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх; 5/ шүүгчийг шилж олох, шалгаруулах; 6/ шүүгчийн сахилгын хороог байгуулах; 7/ шүүгчийг шилжүүлэн томилох; 8/ шүүгчид нэр дэвшигчийг сонгон шалгаруулах болон шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ, мэргэшлийн төвшинд дүгнэлт гаргах журам, шалгуурыг тогтоох; 9/ шүүгч, шүүхийн болон шүүхийн байгууллагын ажилтныг шагнаж, урамшуулах, эрх ашгийг нь хамгаалах; 10/ шүүхийн хуяг, тогтоол гүйцэтгэгчээс албаны дүрэмт хувцас, бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх журмыг зохих байгууллагатай зөвшилцөн тогтоох; 11/ хууль, тогтоомжид заасан бусад эрх

Шүүхийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” 1993 он, №2

Харин 2002 оны Шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгчийг шүүн таслах ажлын дадлага эзэмшүүлэх, туршлага судлуулах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүхийн боловсон хүчнийг оновчтой байршуулах зорилгоор адил шатны шүүхэд өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулж болно.”, 42.2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шүүгчийг танхим хооронд нь Ерөнхий шүүгчийн шийдвэрээр сэлгэн ажиллуулж болно.”, 42.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 42.1-д зааснаар шүүгчийг сэлгэн ажиллуулах шийдвэрийг Ерөнхийлөгч гаргана” мөн хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.4-т “Шүүгчийг томилуулах, сэлгэн ажиллуулах, чөлөөлүүлэх, огцруулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх” зэрэг зүйл, заалтыг үндэслэл болгож шүүгчийг сэлгэн ажиллуулах болсон.

Энэ үеэс анх шүүгчийг эрх зүйн байдлыг нь дордуулахгүйгээр өөрийнх нь саналыг үндэслэн тодорхой зорилготойгоор сэлгэн ажиллуулах эрх зүйн зохицуулалттай болсон хэдий ч уг хуульд сэлгэн ажиллуулах хугацаа болон сэлгэн ажиллах шалгуур үзүүлэлт зэргийг нарийн зааж өгөөгүй байна. Шүүгчийг тодорхой зорилготойгоор өөрийнх нь саналаар Ерөнхийлөгч зарлиг гарган сэлгэн ажиллуулна.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2012 оны Шүүхийн тухай хуульд шүүгчийг сэлгэн ажиллуулахтай холбоотой зүйл заалт байхгүй нь энэ талаарх эрх зүйн орчин дутмаг байгааг харуулж байна.

Шүүхийн тухай 2002 оны хууль нь 1993, 2012 оны Шүүхийн тухай хуулиудтай харьцуулахад шүүгчийг сэлгэн ажиллуулах асуудлыг нарийвчлан зохицуулж өгсөн хууль байжээ. Тодруулбал, Монгол Улсын 2002 оны Шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “...шүүгчийг адил шатны шүүхэд өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулж болно” гэснийг Улсын дээд шүүхээс тайлбарлахдаа “Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийг сэлгэн ажиллуулах саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж, шүүгчийг сэлгэн ажиллуулах шийдвэрийг Ерөнхийлөгч гаргана гэж ойлгоно. Ерөнхий шүүгчдийг хуулийн дээрх заалтын дагуу сэлгэн ажиллуулсан тохиолдолд бүрэн эрхийн хугацааг нь тэдний анх шүүгчээр томилогдсон үеэс тоолно” гэжээ.³²⁹ Энэ заалт Ерөнхий шүүгч сэлгэн ажилласан нь түүний бүрэн эрхийн хугацааг сэлгэн ажилласан хугацаагаар сунгахгүй байх агуулгатай байна.

Шүүгчийг өөрийнх нь саналаар тухайн шатны өөр шүүхэд сэлгэн томилж болох зохицуулалттай.³³⁰ ШЕЗ нь тухайн шүүгчийн өөрийнх нь саналыг үндэслэн тухайн шатны өөр шүүхэд сэлгэн ажиллуулах саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн зарлиг, захирамж гаргана” мөн 12 дугаар зүйлийн 12.16-д “Бүх шатны шүүгчийг хуульд заасны дагуу томилно”³³¹ гэж тус тус заасны дагуу аймаг,

³²⁹ Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол, “Шүүхийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай, 2003 он, №1

³³⁰ Т.Сэнгэдорж, С.Энхмэнд, С.Энхсаруул, “Дэлхийн ба Монголын хуульчид эрх зүй ёс зүй” Улаанбаатар, 2014 он, 73 дахь тал

³³¹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” 1993 он, №3

нийслэлийн шүүх, сум буюу сум дундын шүүх, дүүргийн бүх шатны шүүхийн шүүгчийг ШЕЗ-ийн санал болгосноор Ерөнхийлөгч зарлиг гарган сэлгэн ажиллуулахаар томилдог.

Шүүгчийг сэлгэн ажиллуулах нь шүүгч өөрөө саналаа ШЕЗ-д гарган ШЕЗ-ийн саналыг нь үндэслэн Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж, Ерөнхийлөгч сэлгэн ажиллуулах тухай зарлиг гаргаснаар хэрэгждэг. Энд анхаарах гол зүйл бол шүүгчийн өөрийнх нь саналыг нь авч сэлгэн ажиллуулах явдал юм. Энэ тухай Монгол Улсын шүүхийн тухай хуулиас гадна Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд “Шүүгчийг өөрийнх нь саналаар тухайн шатны өөр шүүхэд сэлгэн томилж болно”³³² гэж заасан.

Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт зааснаар шүүгч нь төрийн тусгай албан тушаалтан бөгөөд мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт зааснаар төрийн жинхэнэ албан хаагч юм. Энэ нь шүүгчтэй холбоотой харилцаанд тус хуулийг хэрэглэж болохыг харуулж байна.

Шүүгчийг сэлгэн ажиллуулах нарийвчилсан зохицуулалт байхгүй тул Төрийн албаны тухай хуульд “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөрийнх нь зөвшөөрснөөр төрийн байгууллага хооронд тэдгээрийн удирдлагын харилцан тохиролцсоны дагуу ажлын тодорхой чиглэлээр 2 жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно. Хэрэв төрийн албан хаагч өөрөө буюу түүнийг сэлгэн ажиллуулж байгаа байгууллага хүсвэл анх илгээсэн төрийн байгууллага болон өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулах хугацааг 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно. Сэлгэн ажиллуулах хугацаа дуусмагц түүнийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн авна.”³³³ гэснийг удиртгал болгох хэдий ч энэ зохицуулалтаар төрийн албан хаагчийг сэлгэн ажиллуулах хугацааг сунгахдаа хэдэн удаа сунгаж болох талаар тодорхой дурдаагүй мөн сэлгэн ажиллах дээд хугацааг зааж өгөөгүй нь уг хугацааг хэд хэдэн удаа сунгаад байх боломжийг бий болгож байна.

Монгол Улсын Дээд шүүхээс Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт заасан “... зөвшөөрсөн ...” гэдгийг тайлбарлахдаа албан тушаалтны шахалт шаардлага, зүй бус нөлөөлөл зэрэг хөндлөнгийн оролцоогүй, төрийн албан хаагчийн өөрийнх нь хүсэл зоригийн илэрхийлэл гэж ойлгох бөгөөд зөвшөөрөл нь бичгийн хэлбэртэй байна. Мөн хэсэгт заасан “...сэлгэн ажиллуулж...” гэдгийг албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээг бууруулахгүйгээр ажлын байр, албан тушаалын тодорхойлолтод заасантай адил төрлийн чиг үүрэг бүхий албан тушаалд шилжүүлж томилох гэж ойлгоно³³⁴ гэсэн нь шүүгч сэлгэн ажиллахдаа хэн нэгний хүсэл, шаардлагад нийцүүлэх биш зөвхөн өөрийн хүсэл сонирхлын үүднээс хараат бус байдлаар санал гарган сэлгэн ажиллах ёстой гэдгийг харуулж байна. Мөн сэлгэн ажиллаж байгаа шүүгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх хэрэгтэйг Монгол Улсын дээд шүүхээс тайлбарласан байна.

³³² Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйл, “Төрийн мэдээлэл” 2012 он, №11

³³³ Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйл, “Төрийн мэдээлэл” 2002 он, №28

³³⁴ Монгол Улсын дээд шүүхийн тогтоол, “Төрийн албаны тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, 2010 он, №08

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн³³⁵ 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Шүүгчийг өөрийнх нь саналаар тухайн шатны өөр шүүхэд сэлгэн томилж болно” гэсэн нь шүүгч өөрөө зөвшөөрөөгүй байхад шүүгчийг сэлгэн ажиллуулахгүй, гагцхүү шүүгчийн саналын үндсэн дээр явагдах ёстой гэдгийг харуулж байна. Ингэхдээ эрх зүйн байдлыг нь дордуулахгүй, цалингийн хэмжээг бууруулахгүйн үүднээс адил шатны шүүхэд сэлгүүлэн ажиллуулна.

Шүүхийн захиргааны тухай хуулийн³³⁶ 8 дугаар зүйлийн 8.1.2-т “Шүүгчийг томилох, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, албан тушаалаас нь чөлөөлөх, огцруулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх” гэж заасан. Энэ нь шүүгчийг гагцхүү Ерөнхийлөгч өөрийн эрх мэдлийн хүрээнд томилж, шилжүүлж, сэлгэн ажиллуулж, чөлөөлөх бүрэн эрхтэйг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, шүүгчийг сэлгэн ажиллуулах асуудал өөр бусад эрх мэдэл бүхий албан тушаалтан бие даан шийдвэрлэхгүй зөвхөн тухайн саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх эрх хэмжээтэй байна.

2006-2014 онуудын сэлгэн ажиллуулсан зарлигт дараах хуулийн заалтуудыг баримталсан байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйл. Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд нийцүүлэн зарлиг гаргана.
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн зарлиг, захирамж гаргана.”³³⁷ Ерөнхийлөгч нь зарлиг гаргахаас гадна бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж гаргана. Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.16 дахь хэсэгт “Бүх шатны шүүгчийг хуульд заасны дагуу томилно.”³³⁸ Шүүгчийг томилох бүрэн эрх зөвхөн Монгол Улсын Ерөнхийлөгчид хамаарна.
3. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Шүүгчийг өөрийнх нь саналаар тухайн шатны өөр шүүхэд сэлгэн томилж болно.”³³⁹ Шүүгч нь сэлгэн ажиллахдаа өөр шатны шүүхэд бус адил шатны шүүхэд ажиллах ёстой. Энэ нь шүүгчийн эрх зүйн байдлыг өөрчлөхгүй байхаар зохицуулсан зохицуулалт юм.

Монгол Улсын хэмжээнд шүүгчийг сэлгэн ажиллуулах тухай дээрх зохицуулалтуудаас өөр эрх зүйн зохицуулалт, нарийвчилсан дүрэм, журам байхгүй нь энэ харилцааг цаашид нарийвчлан зохицуулж өгөх шаардлагатайг харуулж байна.

1.2.Гадаадын зарим улсын шүүгчийг сэлгэн ажиллуулах эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судалгаа

Энэ хэсэгт сонгон судалсан гадаадын зарим орны шүүгчийг сэлгэн ажиллуулахтай холбоотой туршлагыг авч үзлээ. Ингэхдээ Иргэний эрх зүйн (Rom-

³³⁵ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, “Төрийн мэдээлэл” 2012 он, №11

³³⁶ Шүүхийн захиргааны тухай хууль, “Төрийн мэдээлэл” 2012 он, №24

³³⁷ Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” 1993 он, №1

³³⁸ Мөн тэнд

³³⁹ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, “Төрийн мэдээлэл” 2012 он, №11

Германы) бүлийн төлөөлөл болгон БНСУ^{340,341}, Япон улс³⁴², Нийтлэг эрх зүйн (Англи-Саксоны) бүлийн төлөөлөл болгон АНУ-ыг тус тус хамруулав.³⁴³

Эдгээр улсад сэлгэн ажиллуулах шүүгчийн дээд, доод хязгаарыг заагаагүй ч тухайн шүүхийн нийт шүүгчийн 4-5 хувийг сэлгэн ажиллуулж байна.³⁴⁴

АНУ:

Тус улсад муж улсын шүүхийн ерөнхий шүүгч нь тухайн шүүхийнхээ шүүгч нарыг сэлгэн ажиллуулах хуваарийг баталдаг. Ингэхдээ “сэлгэн ажиллуулах шүүгч нь очих газрынхаа оршин суугч биш байх”, “мэргэжил, ур чадварын хувьд сайжрах” гэсэн хүчин зүйлийг харгалздаг. Сэлгэн ажиллуулах хуваарь болон түүний хэрэгжилтэд хүндэтгэх шалтгааны үндсэн дээр өөрчлөлт оруулж болно. Тус хуваарьт 1 жилийн хугацаанд сэлгэн ажиллуулах шүүгчийн нэр, хугацаа, очих газрыг тусгана. Сэлгэн ажиллаж буй шүүгчийг сэлгэн ажиллах хугацаанд ээлжийн амралт олгохгүй.³⁴⁵ Сэлгэн ажиллуулах хуваарийг гаргахдаа тухайн шүүгчтэй зөвлөлдсөн байна. Шинэ шүүгчийг сэлгэн ажиллуулахдаа “тухайн шүүгчийн ашиг сонирхол, санал”, “сургалтад хамрагдсан байдал, туршлага”, бусад хүчин зүйлсийг урьтал болгоно.³⁴⁶

Монгол Улсын хувьд Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т зааснаар бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, энэхүү ажиллагаатай холбоотой заавар өгөх, удирдамжаар хангах, шүүгчид тодорхой хэрэг, маргааныг нэр заан хуваарилах зэргээр шүүгчийн хараат бус байдалд халдахыг хориглоно.³⁴⁷

Эндээс харахад АНУ-ынх шиг Ерөнхий шүүгч нь шүүгчдийг сэлгэн ажиллуулах асуудлыг шийдвэрлэх нь Монгол Улсын хууль тогтоомжтой уялдахгүй байна. Харин Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгчдийг сэлгэн ажиллуулахдаа АНУ-ын жишээнд дурдсан шүүгчийг сэлгэн ажиллуулахад харгалзах хүчин зүйлсийг Монгол Улсад хэрэглэх бүрэн боломжтой гэж үзэж байна.

БНСУ:

³⁴⁰ Oh Seung Jin. Overview of Legal Systems in the Asia-Pacific Region: South Korea. 2004

http://scholarship.law.cornell.edu/cgi/viewcontent.cgi?article=1006&context=lps_lsapr

³⁴¹ Background and Legal System: Republic of Korea.

<http://law.wustl.edu/GSLR/CitationManual/countries/southkorea.pdf>

³⁴² Piyali Syam. Major Differences between the Japanese and American Legal Systems. 2013

<http://onlinelaw.wustl.edu/blog/major-differences-between-the-japanese-and-american-legal-systems/>

³⁴³ The Anglo-American Legal System. <https://www.ache.org/pubs/ShowalterCh1.pdf>

³⁴⁴ Тухайлбал, АНУ-ын Висконсини тойргийн шүүх 249 шүүгчтэй бөгөөд үүнээс 11 шүүгчийг сэлгэн ажиллуулжээ.

<http://wicourts.gov/courts/circuit/index.htm>

<http://county.milwaukee.gov/ImageLibrary/Groups/cntyCourts/documents/15-06JudicialRotation.pdf>

³⁴⁵ Rotation Plan For Superior Court Judges January 2014 - November 2015
http://courts.delaware.gov/Superior/pdf/rotation_plan_2014_15_judges.pdf 15-06 Judicial Rotation - Milwaukee County

<http://county.milwaukee.gov/ImageLibrary/Groups/cntyCourts/documents/15-06JudicialRotation.pdf>

Chief Judge Directives - Judicial Rotation - Milwaukee Housing Foreclosure Help

<http://county.milwaukee.gov/Courts/ChiefJudge/DirectivesJudicialRotation.htm>

³⁴⁶ Rotation of Judicial Assignments https://www.judiciary.state.nj.us/directive/admin/dir_6_88.pdf

³⁴⁷ Монгол Улсын шүүхийн тухай хууль. “Төрийн мэдээлэл”. 2012 он, №11

БНСУ-д бүх шүүгч нь 2-3 жилийн хугацаатайгаар өөр шүүхэд сэлгэн ажилладаг. Сэлгэн ажиллаж буй хугацаандаа олон тооны захиргааны эрх зүйн хэргийг шийдвэрлэх ёстой байдаг. Энд дурдсан ажлын ачаалалтай холбоотойгоор тухайлсан хэрэг, маргааны төрлийг хянан шийдвэрлэхэд суралцах цаг хангалтгүй байдаг.³⁴⁸ Монгол Улсын хувьд шүүгчийг ямар хугацаанд сэлгэн ажиллуулах талаар тусгайлсан зохицуулалт байхгүй.³⁴⁹

Мөн Монгол Улсын хувьд шүүгчийг тодорхой төрлийн хэрэг шийдүүлэхээр сэлгэн ажиллуулах зохицуулалт байхгүй. Монгол Улсад шүүхүүд хэрэг, маргааны төрлөөр дагнасан тул шүүгчийг сэлгэн ажиллуулахдаа хэрэг, маргааны төрлөөр мэргэшсэн байдлыг харгалзах нь зүйтэй.

Япон улс:

Япон улсад захын буюу алслагдмал, хүн ам цөөнтэй газарт шүүгчдийг сэлгэн ажиллуулахыг зорилго болгодог байна. Учир нь тийм нутаг дэвсгэрт шүүгчийн карьер нь дуусч байгаа шүүгчид ажилладаг бөгөөд шинэ, залуу шүүгчдийг сэлгэн ажиллуулах замаар шүүн таслах үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй, хууль ёсны байлгахад анхаардаг. Үүнтэй холбоотойгоор сэлгэн ажиллах сонирхолтой шүүгчийн тоо цөөн байдаг онцлогтой. Шүүгчийг сэлгэн ажиллуулах хугацаа 3 жил байна.³⁵⁰

Монгол Улсын хувьд 2015.06.19-ний өдөр батлагдаж, 2015.07.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж буй “Шүүх байгуулах тухай” хуулийн шинэчилсэн найруулгаар Улаанбаатар хотод Улсын дээд шүүхийг оролцуулахгүйгээр 12 шүүх байгаа бөгөөд 2014 оны байдлаар Монгол Улсын хүн ам хотод 1,990,321, орон нутагт 1,005,628 байгаа нь Монголын нийт хүн амын 50-иас дээш хувь нь хотод амьдарч байгааг харуулж байна.^{351, 352} Энэ нь Монгол Улсад алслагдмал, хүн ам цөөнтэй газарт шүүгчдийг сэлгэн ажиллуулах шаардлага байгааг харуулж байна.

³⁴⁸ Jinyul JU. 3. Problem of Judge Rotation System. Current Issues on the Use of Economics in Korean Antitrust. University Of Chicago the Coase-Sandor Institute Of Law And Economics Colloquia: New Tools In Law And Economics 2013

<http://orientation.uchicagolawandecon.org/readings/colloquia/Ju%20-%20Current%20Issues.pdf>

³⁴⁹ Шүүгчийн эрх зүйн байдлын тухай 2012.03.07-ны өдрийн хуулийн 10-р зүйлийн 10.2-т “Шүүгчийг өөрийнх нь саналаар тухайн шатны өөр шүүхэд сэлгэн томилж болно” гэж заасан хэдий ч сэлгэн ажиллуулах хугацааны талаар заагаагүй байна.

³⁵⁰ J. Mark Ramseyer & Eric B. Rasmusen. The Case for Managed Judges: Learning From Japan after the Political Upheaval of 1993. June 2006

http://scholarship.law.upenn.edu/cgi/viewcontent.cgi?article=1326&context=penn_law_review

University of Pennsylvania Law Review, 154: 1879-930.

www.pennlawreview.com/print/old/the_case_for_managed_judges.pdf

³⁵¹ Улаанбаатар хотод байрлах шүүхүүд: Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх; Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх; Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх; Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх; Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх; Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх; Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх; Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх; Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх; Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх; Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх.

³⁵² Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Хүн амын тоо, аймаг, нийслэл, байршлаар (Оны эцсийн хүн амын тоо). 2015.06.22

http://www.1212.mn/statHtml/statHtml.do?orgId=976&tblId=DT_NS0_0300_004V1&conn_path=12

Иймд Япон улсын туршлага дээр тулгуурлан шүүгчдийг сэлгэн ажиллуулахдаа газар нутгийн байршил, хүн амын тоог харгалзах буюу иргэнд шүүхийн мэргэшсэн үйлчилгээг хүргэхэд нэн түрүүнд анхаарах нь зохистой байна.

1.2.1.Гадаадын зарим улсын Үндсэн хууль дахь сэлгэн ажиллуулахтай холбоотой зохицуулалт

Монгол Улсын хувьд Үндсэн хуульдаа шүүгчийг сэлгэн ажиллуулах асуудлыг тусгайлан заагаагүй. Харин зарим улсад шүүгчийг сэлгэн ажиллуулах асуудал нь Үндсэн хуулийн зүйл, заалтаас эхтэй байна. Тухайлбал, Албани, Афганистан, Грек, Иран, Киргиз зэрэг улсын Үндсэн хуулийн зохицуулалтыг дор дурдсанаар танилцуулж байна.

Албани:

Албани улсын 1998 оны Үндсэн хуулийн 9-р хэсгийн 147-р зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар шүүгчийг хуульд зааснаар сэлгэн ажиллуулах асуудлыг Шүүхийн дээд зөвлөл шийднэ. Шүүхийн тогтолцоог өөрчлөн зохион байгуулах шаардлагаас бусад тохиолдолд шүүгчийг сэлгэн ажиллуулахад түүний зөвшөөрлийг авна. Мөн хуулийн 147-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Шүүхийн дээд зөвлөл нь улсын Ерөнхийлөгч, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Хууль зүйн сайд, Ассамблейгаас сонгогдсон 3 гишүүн, бүх шатны Үндэсний шүүхийн чуулганаас сонгогдсон 9 шүүгчээс бүрдэх бөгөөд улсын Ерөнхийлөгч нь тус зөвлөлийн тэргүүн байна.³⁵³

Афганистан:

Афганистан улсын 2004 оны Үндсэн хуулийн 7-р хэсгийн 132-р зүйлд зааснаар шүүгчийг сэлгэн ажиллуулах асуудал нь хуульд зааснаар Дээд шүүхийн бүрэн эрхийн хүрээнд байна. Дээд шүүх нь шүүхийн захиргааны асуудлыг эрхлэх Шүүхийн захиргааны ерөнхий байгууллагыг байгуулна.³⁵⁴

Грек:

Грекийн 1975 оны Үндсэн хуулийн 88-р зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар хуульд тусгайлан заасан нөхцөлд өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд шүүгчийг өөр шүүх рүү сэлгэн ажиллуулахыг хориглоно.³⁵⁵

Иран:

Иран улсын 1979 оны Үндсэн хуулийн 11-р хэсгийн 164-р зүйлд зааснаар шүүгчийг нийгмийн шаардлагын үндсэн дээр Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурортой зөвшилцсөний дараагаар тухайн шүүхийн ерөнхий шүүгчийн шийдвэр гаргаж шилжүүлэхээс бусад тохиолдолд өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр сэлгэн ажиллуулж болохгүй. Шүүгчийг сэлгэн ажиллуулах асуудлыг хуулиар зохицуулна.³⁵⁶

Киргиз:

³⁵³ Constitution of the Republic of Albania https://www.constituteproject.org/constitution/Albania_2012#s1081

³⁵⁴ The Constitution of the Islamic Republic of Afghanistan https://www.constituteproject.org/constitution/Afghanistan_2004#s447

³⁵⁵ The Constitution of Greece (https://www.constituteproject.org/constitution/Greece_2008#s885)

³⁵⁶ Iran (Islamic Republic of)'s Constitution of 1979 with Amendments through 1989 https://www.constituteproject.org/constitution/Iran_1989.pdf

Бүгд Найрамдах Киргиз улсын 2010 оны Үндсэн хуулийн 6-р хэсэг, 95-р зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар шүүгчийг сэлгэн ажиллуулах асуудлыг Шүүгчийн томилгооны хороо Үндсэн хуульд заасан журмын дагуу хариуцна. Мөн хуулийн Шүүгчийн томилгооны хорооны саналын дагуу Ерөнхийлөгч нь шүүгчийг сэлгэн ажиллуулах асуудлыг шийдвэрлэнэ. Шүүгчийн томилгооны хороо нь шүүгчид болон иргэний нийгмийн төлөөллөөс бүрдэх бөгөөд түүнийг Парламентаас томилдог байна.³⁵⁷

Хоёр. Шүүгчийг сэлгэн ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь

Эрх зүйн зохицуулалт бүрэн буюу хангалттай эсэх асуудлыг тодорхойлохын өмнө шүүгчийг сэлгэн ажиллуулахад практик дээр ямар асуудал үүсч буйг авч үзэх шаардлагатай юм. Иймд 2.1 дэх хэсэгт шүүгчийг сэлгэн ажиллуулахад тулгамдаж буй зарим асуудлыг, 2.2 дахь хэсэгт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг тус бүр авч үзлээ.

2.1. Шүүгчийг сэлгэн ажиллуулахад тулгамдаж буй зарим асуудал

Монгол Улсад 2006-2014 онд нийт 71 шүүгчийг ШЕЗ-ийн саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар сэлгэн ажиллуулсан байна.³⁵⁸ Үүнээс 11 шүүгч нь тэтгэвэрт гарах болон бусад нөхцөлөөр чөлөөлөгджээ. Эдгээр шүүгчээс энэ судалгаанд нийт 35 шүүгч хамрагдсан бөгөөд асуулгын үр дүнг дор авч үзье.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл


№	Утга	Тоололт	Хувь
Таны хүйс			
1	Эрэгтэй	13	37.1
2	Эмэгтэй	22	62.9
Таны нас			
1	31-35	5	14.3
2	36-40	13	37.1
3	41-ээс дээш	17	48.6
Шүүгчээр ажилласан жил			
1	1-5 хүртэл	6	17.2
2	6-10	11	31.4
3	11-15	10	28.4
4	16-20	4	11.5
5	21-ээс дээш	4	11.5
	Нийт	35	100

³⁵⁷ Constitution of the Republic of Kyrgyzstan
https://www.constituteproject.org/constitution/Kyrgyz_Republic_2010#s1014

³⁵⁸ Тус дүн мэдээг Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын хэлтэс болон архивын сангаас бүрдүүлсэн баримт бичгийн хуулбарт хийсэн дүгнэлтээс гаргасан болно.


Судалгаанд оролцсон шүүгчдийн 37.1 хувь нь эрэгтэй, 62.9 хувь нь эмэгтэй бол 14.3 хувь нь 31-35 настай, 37.1 хувь нь 36-40 настай, 48.6 хувь нь 41-ээс дээш настай байна. Үүнээс харахад сэлгэн ажилласан шүүгчдийн олонх нь 46-гаас дээш насных байна. Харин судалгаанд оролцсон шүүгчдийн 17.2 хувь нь 1-5 жил, 31.4 хувь нь 6-10 жил, 28.4 хувь нь 11-15 жил, 11.5 хувь нь 16-20 жил, 11.5 хувь нь 21-ээс дээш жил тус тус ажилласан байна. Сэлгэн ажилласан шүүгчдийн 59.8 хувийг 6-15 жил ажилласан шүүгч эзэлж байгаа нь харьцангуй удаан ажилласан шүүгчдийг сэлгэн ажиллуулсан нь харагдаж байна.

График 1. Шүүгчээр сэлгэн ажилласан хугацаа




Сэлгэн ажилласан шүүгчдийн 16 хувь нь 1-12 сарын хугацаанд, 36 хувь нь 13-36 сарын хугацаанд, 32 хувь нь 36-72 сарын хугацаанд, 16 хувь нь 72-оос дээш сарын хугацаанд тус тус сэлгэн ажилласан байна. Үүнээс харахад нийт сэлгэн ажилласан шүүгчдийн 50 хувь орчим нь 3 жилээс дээш хугацаагаар сэлгэн ажилласан байна. Энэ нь шүүгчийг сэлгэн ажиллуулах хугацааг хуулиар нарийвчлан тогтоогоогүйтэй холбоотой байж болохоор байна.

График 2. Шүүгч сэлгэн ажиллахдаа гэр бүлийнхэнтэйгээ хамт нүүсэн эсэх байдал



Сэлгэн ажилласан шүүгчид сэлгэн ажиллахдаа ганцаараа явж байршсан гэж 42 хувь нь, гэр бүлтэйгээ хамт нүүж байршсан гэж 49 хувь нь бусад буюу тухайн орон нутагтаа сэлгэн ажилласан гэж 3 хувь нь хариулжээ. Гэр бүлийн хамт нүүж байршсан нь олонх болж байгаа нь шүүгчийн орон байрны асуудлыг гэр бүлийн гишүүдийг нь оролцуулан шийдвэрлэх шаардлагатайг харуулж байна. Үүнийг бага хэмжээний ажилчдын орон сууц барих, хүүхдийг нь сургууль, цэцэрлэгт хамруулах нөхцөл боломжийг хангах байдлаар шийдвэрлэх нь зүйтэй юм.

График 3. Шүүгч сэлгэн ажиллахдаа орон байрны асуудлаа шийдсэн байдал




Сэлгэн ажилласан шүүгчдийн 9 хувийг тухайн шүүхээс байраар хангасан, 31 хувь нь өөрөө байр хөлсөлсөн, 16 хувь нь таньдаг айлдаа байрласан, 44 хувь нь бусад буюу өөрийн байранд, эцэг, эхийндээ байсан гэж тус тус хариулжээ. Үүнээс үзэхэд шүүгчдийн хувьд сэлгэн ажиллахад тулгамдаж буй нэг асуудал бол орон байрны асуудал болоод байгаа нь харагдаж байна. Энэ нь цаашид энэ асуудлыг төсвийн хүрээнд бага хэмжээний ажилчдын орон сууц барих эсхүл байр хөлсөлж байгаа тохиолдолд нь тодорхой хэмжээгээр мөнгөн тусламж үзүүлж зохицуулах шаардлагатай болохыг харуулж байна.

Сэлгэн ажиллахад хамгийн хүндрэлтэй тал юу байсан талаар шүүгчид:


- Оройн байрны асуудал;
- Гэр бүлийн гишүүний ажлын байр, санхүүгийн асуудал;
- Хүүхэд асрах, хүүхдийн боловсролын асуудал гэж дурдсан байна.

График 4. Та шүүгчдийг сэлгэн ажиллуулснаар шүүгчдийн ажлын ачаалал тэнцвэржсэн гэж бодож байна уу?



Шүүгчдийг сэлгэн ажиллуулснаар шүүгчдийн ажлын ачаалал тэнцвэржсэн гэж судалгаанд хамрагдсан шүүгчдийн 28 хувь нь, зохих хэмжээнд тэнцвэржсэн гэж 43 хувь нь, тодорхой үр нөлөө мэдэгдээгүй гэж 29 хувь нь үзжээ. Сэлгэн ажилласан шүүгчдийн ойролцоогоор 1/3 нь шүүгчийн ажлын ачаалал тэнцвэржээгүй гэж үзэж байгаа нь цаашид шүүгчдийг ачаалал багатай шүүхээс ачаалал ихтэй шүүх рүү сэлгэн ажиллуулахад анхаарах шаардлагатайг харуулж байна.

График 5. Сэлгэн ажилласнаар шүүн таслах ажлын дадлага, туршлага эзэмшсэн эсэх байдал



Сэлгэн ажилласан шүүгчид сэлгэн ажилласнаараа шүүн таслах ажлын дадлага, туршлага сайн нэмэгдсэн гэж 38 хувь нь, зохих хэмжээнд нэмэгдсэн гэж 44 хувь нь, тодорхой хэмжээнд нөлөөлөөгүй гэж 18 хувь нь тус тус үзжээ. Сэлгэн ажилласнаар шүүгчид шүүн таслах ажлын дадлага, туршлага зохих хэмжээнд нэмэгдсэн гэж шүүгчдийн ихэнх хувь хариулсан нь шүүгчийг сэлгэн ажиллуулах нь шүүгчийн туршлага, улмаар шүүхэд итгэх иргэдийн итгэл нэмэгдэхэд эерэгээр нөлөөлж байгааг харуулж байна.

Харин шүүгчийг сэлгэн ажиллуулахад сул тал буюу шүүгчдэд тулгамдаж буй зарим асуудал байна. Тухайлбал, тухайн шүүх рүү сэлгэн ажиллахад байр хөлслөх зэргээр орон байрны асуудал хүндрэлтэй, энэ нь хувийн амьдралд нь сөрөг талтай байна. Түүнчлэн гэр бүлийн хамт нүүн ирэхэд хүүхдийн боловсрол, гэр бүлийн гишүүний ажлын байрны асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй байна гэж шүүгчид үзсэн байна. Эдгээр хүчин зүйлсийг харгалзан үзэж шүүгчийг сэлгэн ажиллуулахдаа эдийн засаг, нийгмийн баталгааны тал дээр дэмжлэг үзүүлж, тодорхой хэмжээнд шийдвэрлэвэл шүүгчдэд сэлгэн ажиллахад таатай орчин бий болж сэлгэн ажиллах шүүгчдийн тоо нэмэгдэж болох юм.

Сэлгэн ажилласан нийт шүүгчийн 37 хувь нь орон нутгаас орон нутагт, мөн 37 хувь нь орон нутгаас нийслэл, 26 хувь нь нийслэлээс нийслэл гэсэн чиглэлтэй сэлгэн ажилласан байна. Нийслэлээс орон нутаг руу сэлгэн ажилласан шүүгч байхгүй нь шүүгчид орон нутаг руу гэхээсээ илүү хот руу сэлгэн ажиллах сонирхолтой байгааг харуулж байна.³⁵⁹

Сэлгэн ажилласан шүүгчдийн 49 хувь нь анх ажиллаж байсан шүүхдээ одоо хүртэл буцаж очоогүй гэсэн нь “Сэлгэн ажиллуулах хугацаа дуусмагц түүнийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн авна.”³⁶⁰ гэсэн хуулийн заалт хэрэгжээгүй, мөн сэлгэн ажиллах дээд хугацаа тодорхой бус байгаагийн нэг илрэл юм. Томилогдсон хугацаанд сэлгэн ажиллаад аль нэг тал нь сунгах саналгүй бол эгүүлээд шүүгчийг анх ажиллаж байсан шүүхэд нь ажиллуулах нь зүйтэй юм.

Түүнчлэн 6-10 жил, 11-15 жил шүүгчээр ажилласан буюу харьцангуй туршлагатай шүүгчдийг 1-5 жил буюу шинэ шүүгчдээс илүүтэйгээр сэлгэн

³⁵⁹ Монгол Улс нийслэлдээ хэт төвлөрсөн, орон сууц, сургууль, цэцэрлэг гээд бүх зүйл нь орон нутгаасаа илүү хөгжилтэйд байгаа юм.

³⁶⁰ Мөн тэнд

ажиллуулсан нь сэлгэн ажиллуулах замаар шинэ шүүгчдийг шүүн таслах ажлын дадлага, туршлагатай болгохтой нийцээгүй асуудал байж болохоор байна. Иймд 5 жил ажилласан шүүгч нь өөрөө саналаа гаргавал түүнийг сэлгэн ажиллуулах нь зүйтэй юм.

Шүүгчийг сэлгэн ажиллуулахдаа түүнээс зөвшөөрөл, саналыг аваагүй тохиолдол байгаа нь /14 хувь/³⁶¹ шүүгчийн халдашгүй байдал, эдийн засаг, нийгмийн хангамжийн баталгаа зэргийг хөндөж байгаа бөгөөд хуулийн шаардлагыг зөрчиж буй асуудал болж байна. Сэлгэн ажиллуулах харилцаа үүсэх хамгийн эхний үндэслэл, шалгуур бол шүүгчийн өөрийнх нь санал байх ёстой юм.

Судалгаанд оролцсон сэлгэн ажилласан шүүгчдийн 9 хувь нь 2006 онд, 17 хувь нь 2007 онд, 9 хувь нь 2008 онд, 18 хувь нь 2009 онд, 6 хувь нь 2011 онд, 23 хувь нь 2012 онд, 18 хувь нь 2013 онд тус тус сэлгэн ажилласан байна. Энэ нь сэлгэн ажилласан шүүгчийн тоо харьцангуй тогтворгүй буюу хэлбэлзэлтэй байгааг харуулж байна.

Судалгаанд оролцсон шүүгчдийн 73 хувь нь цаашид сэлгэн ажиллахыг дэмжинэ гэж хариулсан бол 21 хувь нь дэмжихгүй, 6 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Эндээс харахад шүүгчдэд тулгамдаж буй орон байр, эдийн засаг, нийгмийн баталгааны бусад асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэчихвэл сэлгэн ажиллахыг дэмжих шүүгчдийн тоо нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна.

2.2. Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь

Энэ судалгааны ажлын 2.1 дэх хэсэгт сэлгэн ажилласан шүүгчдэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлсон. Ийм асуудал нь Монгол Улсад шүүгчийг сэлгэн ажиллуулах талаарх эрх зүйн зохицуулалт бүрэн бус буюу хангалтгүй байгаатай холбоотой байж болох юм. Монгол Улсын шүүгчийг сэлгэн ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг бусад улс оронтой харьцуулбал энэ талаарх бие даасан зохицуулалт дутмаг байна. Тодруулбал, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2,³⁶² Шүүхийн захиргааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2³⁶³, Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйл³⁶⁴ заалтаас өөр эрх зүйн зохицуулалт, журам байхгүй байна. Эндээс харахад шүүгчийг сэлгэн ажиллуулах харилцааг зохицуулж буй хэм хэмжээ нь нэгдмэл бус, салангид хэм хэмжээний түүвэр байдалтай байна.

Энэхүү харилцааг боловсронгуй болгохын тулд шүүгчийг сэлгэн ажиллуулах асуудлаарх бие даасан, нэгдмэл зохицуулалттай байх нь оновчтой байна. Ийм зохицуулалт нь шүүгчийн эрх зүйн байдлын талаарх зохицуулалтыг дордуулахгүй

³⁶¹ Тус судалгааны хүрээнд хийгдсэн санал асуулгын дүн. 2015 он.

³⁶² Шүүгчийг өөрийнх нь саналаар тухайн шатны өөр шүүхэд сэлгэн томилж болно.

³⁶³ Шүүгчийг томилох, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, албан тушаалаас нь чөлөөлөх, огцруулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх;

³⁶⁴ Төрийн жинхэнэ албан хаагчийг өөрийнх нь зөвшөөрснөөр төрийн байгууллага хооронд тэдгээрийн удирдлагын харилцан тохиролцсоны дагуу ажлын тодорхой чиглэлээр 2 жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно. Хэрэв төрийн албан хаагч өөрөө буюу түүнийг сэлгэн ажиллуулж байгаа байгууллага хүсвэл анх илгээсэн төрийн байгууллага болон өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулах хугацааг 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно. Сэлгэн ажиллуулах хугацаа дуусмагц түүнийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн авна.

буюу түүнд нийцсэн байх шаардлагатай. Иймд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлах “Шүүгчийг сэлгэн ажиллуулах журам”-тай болох нь оновчтой байна.

Энэ журамд “Шүүгчийг өөрийнх нь зөвшөөрснөөр тухайн шатны шүүхэд сэлгэн ажиллуулна” гэсэн өгүүлбэрийг зайлшгүй тусгаж өгөх нь зүйтэй. Учир нь сэлгэн ажиллах харилцаа үүсэх хамгийн эхний үе шат бол шүүгч өөрөө хүсэлтээ гаргах явдал юм. Шүүгчийн саналыг ШЕЗ хүлээн аван сэлгэн ажиллуулах эсэхийг шийдвэрлэн тогтоол гарган Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ, Ерөнхийлөгч уг саналыг хуулийн дагуу шийдвэрлэн сэлгэн ажиллуулах тухай зарлиг гаргаснаар шүүгч сэлгэн ажиллана.³⁶⁵

Гадаад улсын туршлагаас харахад сэлгэн ажиллах хамгийн бага хугацааг 6 сараас багагүй байхаар зохицуулсан. Сэлгэн ажиллах хугацаа энэ хугацаанаас бага байвал сэлгэн ажиллахын шүүн таслах ажлын дадлага нэмэгдүүлэх, туршлага судлуулах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зэрэг зорилгууд биелэлтээ олохгүй байж болох тул сэлгэн ажиллах доод хугацааг 6 сараас багагүй гэж зааж өгөх нь зүйтэй юм.

Түүнчлэн уг журамд шүүгчийг сэлгэн ажиллуулахад дараах шаардлагыг тавих нь зүйтэй. Үүнд:

- ✓ Нэг шүүхэд 5 жилээс доошгүй хугацаанд ажилласан шүүгчийг сэлгэн ажиллуулах.

Шүүгчийг өөрийнх нь хүсэлтээр адил шатны шүүхэд сэлгэн ажиллуулах нь шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүн таслах ажиллагааны мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлж, туршлага судлуулж байгаа явдал юм.

- ✓ Шүүгчийг сэлгэн ажиллуулах нутаг дэвсгэр, харьяалал нь тухайн шүүгчийг сонирхлын зөрчил үүсгэх нөхцөлгүй байх.

Шүүгч тухайн сэлгэн ажиллаж байгаа газрынхаа харьяа бус байх нь гаднын нөлөөлөлд автахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм. Гаднын шинжтэй нөлөөлөл нь ихэвчлэн хэн нэгнээс хүлээлгэсэн үүрэг амлалт, найз нөхдийн хариу тус, нутаг ус, садан төрлийн холбоо зэргээс эхэлдэг ба гаднаас нөлөөлөх гэж оролдсон оролдлого нь ямар нэгэн дарамт, гуйлт, хүсэлт зэрэг маш олон төрлийн арга хэлбэртэй байж болдог.

- ✓ Зөвхөн ачаалал багатай шүүхээс ачаалал ихтэй шүүх рүү сэлгэн ажиллуулах.

Ямар тохиолдол болон хугацаанд тухайн шүүхийг болон шүүгчийг ачаалал ихтэй буюу багатай гэж үзэх нь одоогоор тодорхойгүй байгаа тул ШЕЗ нь тухай бүр шүүхийн болон шүүгчийн ажлын ачааллыг тооцож гаргаж байх нь оновчтой юм.

- ✓ Тухайн шүүгчийг сэлгэн ажиллуулснаар ямар үр дүн гарсныг тодорхойлж байх.

Сэлгэн ажилласан шүүгчийн ажлын үр дүнг нь нэг жил бүрээр шүүгчийн мэргэжил, ур чадвар хэрхэн сайжирснаар тодорхойлж, тус үр дүнгийн тайланг ШЕЗ-өөр дамжуулан Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлж дүгнүүлж байх нь зүйтэй.

³⁶⁵ Шүүгчийг өөрийнх нь саналаар тухайн шатны өөр шүүхэд гагцхүү Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн зарлиг гарган сэлгэн ажиллуулдаг.

ШЕЗ болон Ерөнхийлөгчийн тамгын газар уг тайланг хянан үзээд шүүгчийг сэлгэн ажиллуулах хугацааг сунгах эсэх, улмаар шүүгчдийг сэлгэн ажиллуулахдаа анхаарах зүйлсийг тодорхойлсноор шүүгчийг сэлгэн ажиллуулах асуудлыг оновчтой шийдвэрлэнэ.

Хүчингүй болсон 2002 оны Шүүхийн тухай хуулийн³⁶⁶ 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шүүгчийг танхим хооронд нь Ерөнхий шүүгчийн шийдвэрээр сэлгэн ажиллуулж болно” гэж заасныг уг журамд тусгаж өгч болох юм. Иймд Монгол Улсын дээд шүүхэд ажилладаг шүүгч сэлгэн ажиллахад адил шатны өөр шүүх байхгүй тул танхим хооронд сэлгэн ажиллаж болно. Шүүх дотроо сэлгэн ажиллаж байгаа учраас Ерөнхий шүүгчийн шийдвэрээр сэлгэн ажиллуулах нь зүйтэй.³⁶⁷

Харин Монгол Улсын дээд шүүхээс Ерөнхий шүүгчийг сэлгэн ажиллуулах талаар “...Ерөнхий шүүгчдийг хуулийн дээрх заалтын дагуу сэлгэн ажиллуулсан тохиолдолд бүрэн эрхийн хугацааг нь тэдний анх шүүгчээр томилогдсон үеэс тоолно.”³⁶⁸ гэж тайлбарласныг журамд оруулж өгснөөр сэлгэн ажиллах Ерөнхий шүүгчийн бүрэн эрхийн хугацааг хэрхэн тодорхойлоход ойлгомжгүй байдал үүсэхгүй юм.

Дээр дурдсан зүйлсийг үндэслэн судлаачдын зүгээс “Шүүгчийг сэлгэн ажиллуулах журам”-ын төслийг боловсруулсан бөгөөд Хавсралт №1-т дэлгэрэнгүй оруулсан болно.



Дүгнэлт

Шүүгчийг сэлгэн ажиллуулах нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдахад дэмжлэг үзүүлэх арга замын нэг гэж үзэж болохоор байна. Шүүгчийг сэлгэн ажиллуулахтай холбоотой зохицуулалт Монгол Улсад бүрэн бус, хангалтгүйгээс сэлгэн ажилласан шүүгчдийн эдийн засаг, нийгмийн баталгаанд хүндрэл учруулж байна.–АНУ, БНСУ, Япон зэрэг гадаадын зарим улсад Монгол Улстай харьцуулбал шүүгчийг сэлгэн ажиллах хуваарь, шалгуур үзүүлэлт, хугацаа зэргийг нарийвчлан зохицуулж өгсөн байх бөгөөд түүнийг Монгол Улсад хэрэгжүүлэх зүйтэй байна.

Шүүгчийг сэлгэн ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь шүүгч хэрэг маргааныг хуулийн хүрээнд үнэн зөв, хараат бусаар шийдвэрлэдэг гэсэн шүүхэд итгэх иргэдийн итгэл нэмэгдэхэд зохих ач холбогдолтой байна. Монгол Улсад сэлгэн ажилласан шүүгчдийн тооноос харахад шүүгчийг сэлгэн ажиллуулах нь шүүх бүрт хамаатай шүүхийн хүний нөөцийн асуудал гэж үзэж болохоор байна.³⁶⁹

³⁶⁶ Шүүхийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” 2002 он, №29

³⁶⁷ 2006-2014 оны байдлаар УДШ-ийн шүүгчийг танхим хооронд нь сэлгэн ажиллуулсан тохиолдол байхгүй.

³⁶⁸ Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол, “Шүүхийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, 2003 он, №1

³⁶⁹ 2006-2014 онд дунджаар 467 шүүгч ажилласан бол сэлгэн ажилласан шүүгч нь 71 буюу 6.5 хувь байна. Энэ нь дунджаар 10 шүүгчийн 1 нь сэлгэн ажиллаж байгаа болохыг харуулж байна.

Судалгааны санал асуулгад хамрагдсан шүүгчдийн 73 хувь буюу 25 шүүгч цаашид сэлгэн ажиллахыг дэмжиж байна гэсэн нь д цаашид уг харилцааг илүү боловсронгуй болговол шүүгчдийн сэлгэн ажиллах хүсэл сонирхол нэмэгдэн, сэлгэн ажиллах шүүгчийн тоо өсөх хандлагатай болохыг харуулж байна. Эцэст нь, энэ бүгдээс харахад Монгол Улсад шүүгчийг сэлгэн ажиллуулах гэсэн ойлголтыг нэг мөр болгон тусгай журмаар нарийвчлан зохицуулж өгөх хэрэгтэй байна.

Санал, зөвлөмж

Монгол Улсад шүүгчийг сэлгэн ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлаар хийсэн дүгнэлтэд тулгуурлан дараах санал, зөвлөмжийг танилцуулж байна.

1. Шүүгчийг сэлгэн ажиллуулах хугацаа болон түүнийг сунгах хугацааг тодорхой заах.
2. Сэлгэн ажиллуулахад шүүгчийн өөрийн саналыг авахаас гадна:
 - ✓ тухайн ажиллах газрынхаа оршин суугч биш байх,
 - ✓ нэг шүүхэд 5-аас доошгүй жил ажилласан байх,
 - ✓ ачаалал багатай шүүхээс ачаалал ихтэй шүүх рүү ажиллах гэсэн шаардлагыг тавих.
3. Шүүгчид сэлгэн ажиллахад тулгамдаж буй түгээмэл асуудал болох орон байр, эдийн засгийн баталгааг тодорхой төвшинд төсвийн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх.
4. Шүүгчийг сэлгэн ажиллуулах асуудлаарх бие даасан, нэгдмэл зохицуулалт бүхий “Шүүгчийг сэлгэн ажиллуулах журам”-тай болох.

-оОо-



СУДАЛГАА



ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙ БА МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ ДЭХ ИРГЭНИЙ ХЭРГИЙН ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ АЖИЛЛАГАА³⁷⁰

Удиртгал

Судлаачдын бүтээлд тэмдэглэснээр олон улсын гэрээ, эрх зүйн хэм хэмжээг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх явдлыг дэмжих нь Монгол Улсын шүүх эрх мэдлийн салбарт дэвшил авчрах төдийгүй хүний эрхийг хамгаалах эрх зүйн өөр нэгэн боломжит механизмыг хэрэглэх соёл иргэдийн дунд төлөвших нэг боломж юм.³⁷¹

Даяарчлагдаж байгаа өнөө үед Монгол Улсын иргэд хилийн чанадад олноор оршин суух, сурч, хөдөлмөрлөх, зорчих болсонтой холбоотойгоор Монгол Улс болон Монгол Улсын төрийн байгууллагын хувьд хилийн чанад дахь өөрийн иргэдийг хамгаалах, улс орны ашиг сонирхлыг хангахын тулд бусад улстай зохих түвшний харилцаа тогтоох шаардлага улам нэмэгдсээр байна. Дипломат шугамаар бусад улстай харилцах нь цаг хугацааны хувьд удаашралтайгаас гадна дипломат шугамаар шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх ажиллагааг явуулахад зохимжгүй байдаг. Эрх зүйн туслалцааны гэрээ нь хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагуудын хооронд шууд бөгөөд тогтвортой харилцааг тогтоож өгдөг.³⁷² Шүүн таслах үйл ажиллагаа нь тухайн улсын нутаг дэвсгэрийн хүрээгээр хязгаарлагддаг. Ингэхдээ өөр улсын нутаг дэвсгэрт процессын ажиллагааг үргэлжлүүлэх шаардлагатай байдаг.³⁷³ Гэхдээ Монгол Улстай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй улсад шүүх эрх мэдлийг үргэлжлүүлэх асуудал үүсэх боломжтой. Тодруулбал, Монгол Улсаас 17 улстай иргэний хэргийн асуудлаар эрх зүйн туслалцааны гэрээ байгуулсан.³⁷⁴ Харин 2015.12.31-ний өдрийн байдлаар Монгол Улс НҮБ-ын 193 улсаас 172 улстай дипломат харилцаатай байна.³⁷⁵

Гадаад улсын шүүхийн даалгаврыг биелүүлэх, гадаад улсад шүүхийн даалгавар гардуулах иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шүүхүүд хэрэгжүүлэхдээ гадаадын тухайн улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хоёр талт олон улсын гэрээ, ийм гэрээ байхгүй бол Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай 1954 оны Конвенцын /цаашид “1954 оны Гаагийн конвенц” гэнэ/

³⁷⁰ Тус судалгааны ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн судлаач, хуульч Л.Галбаатар гүйцэтгэсэн бөгөөд судалгааны ажлын зөвлөхөөр Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор Ц.Мандах /LL.D/ ажилласан болно.

³⁷¹ Хууль зүйн үндэсний хүрээлэн. Монгол Улсын олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх асуудал (бодлогын судалгааны товч тайлан). “Хууль дээдлэх ёс” (хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, практикийн улирал тутмын сэтгүүл). 2015 он, цуврал 3(53). Улаанбаатар. 2015. 93 дахь тал.

³⁷² Хууль зүй, дотоод хэргийн яам. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх нь (хуульчдад зориулсан гарын авлага). Улаанбаатар. 2009. 12 дахь тал

³⁷³ Мөн номын 12 дахь тал

³⁷⁴ Хууль зүй, дотоод хэргийн яам. Эрх зүйн туслалцааны гэрээний жагсаалт.

http://moj.gov.mn/legal_assistance_treaty.html

³⁷⁵ Монгол Улсын Гадаад хэргийн яам. Дипломат харилцаатай орнууд.

http://www.mfa.gov.mn/?page_id=16448#

зүйл, заалтыг баримтална. 1954 оны Гаагийн конвенц нь иргэний хэргийн эрх зүйн асуудлаар ИХШХШТХ-тай уялдаатай төдийгүй түүнийг нөхөн хэрэглэгдэх шинжтэй юм. Тус конвенцод Монгол Улс төдийгүй НҮБ-ын 49 улс нэгдэн орсон байна.³⁷⁶

Иргэн, гэр бүлийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улсын хоёр талт олон улсын гэрээ нь нарийвчилсан зохицуулалттай, харин 1954 оны Гаагийн конвенц нь ерөнхий зохицуулалттай гэрээ болно. Хоёр талт гэрээгээр тусгайлан зохицуулсан асуудалд Конвенцын энэ талаарх заалтыг баримтлах шаардлагагүй ба харин хоёр талт гэрээнд тусгайлан зохицуулаагүй асуудлаар Конвенцын заалтыг баримтална.³⁷⁷

Олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх тухайд шүүгч, өмгөөлөгчдийн мэдлэг чадвар нэмэгдээгүй гэж хэлж болохоор байна. Мөн шүүх олон улсын гэрээг хэрэглэх талаар ямар чиг үүрэг, байр сууриас оролцох талаар ойлголт шүүгч, өмгөөлөгчдийн дунд төдийлөн сайн биш байна.³⁷⁸ Олон улсын гэрээг хэрхэн хэрэглэх талаар аргачлал, зааварчилга хангалтгүй, олон улсын гэрээний сургалт, мэдээлэл, сурталчилгаа хангалтгүй гэсэн саналыг шүүгч, өмгөөлөгчдийн олонх нь өгсөн бөгөөд энэ нь шүүхийн ажиллагаанд олон улсын эрх зүйн мэргэшсэн шинжээч ажиллах шаардлагатай гэдэг хариултыг сонгосон байдлаас харагдана.³⁷⁹

Шүүгч, өмгөөлөгчдийн эрх зүй хэрэглэх арга зүйн мэдлэг, дадлага сайжирсан нөхцөлд олон улсын гэрээг дотоодын шүүхэд хэрэглэх тал дээр дэвшил гарах боломж нээгдэнэ.³⁸⁰

Энэхүү судалгаагаар дараах асуудлыг дэвшүүлсэн болно. Үүнд:

- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гадаад улсаас эрх зүйн туслалцаа авах ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж, гадаад улстай байгуулсан буюу Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд үндэслэн хэрхэн явуулах;
- Хоёр талт харилцан туслалцаа үзүүлэх гэрээг 1954 оны Гаагийн конвенцоос өмнө хэрэглэх эсэх, тэдгээрийг хэрхэн уялдуулж хэрэглэхийг тогтоох;
- Иргэний хэргийн асуудлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаанд нийгмийн дэг журмыг /order public/ хангах;
- Гадаад улсад шүүхийн баримт бичгийг гардуулах нөхцөл, шаардлагыг хэрхэн хангах;
- Нотлох баримтыг хилийн чанадад бүрдүүлэхтэй холбоотойгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх;

³⁷⁶ Number of Contracting States to the Convention of 1 March 1954 on civil procedure

http://www.hcch.net/index_en.php?act=conventions.status&cid=33

³⁷⁷ Монгол Улсын Дээд Шүүхийн “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” 2008.02.28-ны өдрийн 09 дүгээр тогтоолын 11 дэх заалт. <http://legalinfo.mn/law/details/307?lawid=307>
Ред. Б.Алтангэрэл, Ж.Амарсанаа, Ч.Баттөмөр, Ц.Сарантуяа, Б.Чимид. Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар. Улаанбаатар. 2011. 153 дахь тал

³⁷⁸ Хууль зүйн үндэсний хүрээлэн. Монгол Улсын олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх асуудал (бодлогын судалгааны товч тайлан). “Хууль дээдлэх ёс” (хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, практикийн улирал тутмын сэтгүүл). 2015 он, цуврал 3(53). Улаанбаатар. 2015. 92-93 дахь тал.

³⁷⁹ Мөн сэтгүүлийн 89 дэх тал.

³⁸⁰ Мөн сэтгүүлийн 93 дахь тал.

- Шүүхийн үйл ажиллагаанд гадаадын иргэн, харьяалалгүй хүн тэгш оролцох;
- Гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх, шүүхийн даалгавар биелүүлэхээс татгалзахад ямар шаардлага тавигдах;
- Гадаад улсын шүүхийн даалгаврыг Монгол Улсад гүйцэтгэхээс татгалзах тохиолдлыг тодорхойлох;
- Холбогдох гарах зардлын асуудлыг аль тал ямар хэмжээгээр шийдвэрлэхийг тодорхойлох.

Иймд энэ судалгаагаар Монгол Улсын иргэний хэргийн шүүхийн шүүгчид олон улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан конвенцууд болон эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг Монгол Улсын шүүхэд хэрэглэхэд үүсч буй асуудлыг тодорхойлох, үүнтэй холбоотой олон улсын эрх зүйн баримт бичгүүдийг хэрэглэх арга зүйн зөвлөмж боловсруулахыг зорив.

Нэг. Монгол улсын олон улсын иргэний процессын эрх зүйн зохицуулалт, түүхэн хөгжил

1.1. Онолын үндэслэл, эрх зүйн зохицуулалт

Зарим судлаач “олон улсын иргэний процесс” гэхээс “олон улсын иргэний процессын эрх зүй” гэх нь илүү оновчтой томъёолол гэж тэмдэглэсэн байдаг. Учир нь олон улсын иргэний процессыг хийсвэр шинжтэй нэр томъёо гэж үзэж болох ба ямар нэгэн тодорхой хэргийг олон улсын түвшинд авч үзэх асуудал яригддаггүй бөгөөд янз бүрийн улсын субъектын хоорондын маргааныг хянан шийдвэрлэдэг олон улсын түгээмэл байгууллага байхгүй гэж үздэг.³⁸¹

Практикт ажиллаж буй өмгөөлөгчид олон улсын иргэний процессын эрх зүй нь гадаад элемент бүхий иргэний хэрэгт шүүхийн харьяалал болон маргаанд хэрэглэгдэх хуулийг тодорхойлохтой холбоотой гэж товч тодорхойлсон байдаг.³⁸² Судлаачдын хувьд олон улсын иргэний процессын эрх зүй нь дотоодын шүүх ямар тохиолдолд олон улсын хамаарал бүхий хэргийг харьяалан шийдвэрлэх, гадаадын шүүхийн шийдвэр нь дотоодод хэрхэн үйлчлэх гэсэн үндсэн хоёр асуудлыг зохицуулдаг гэж тэмдэглэсэн байдаг.³⁸³

Өргөн утгаараа, гадаад элемент бүхий иргэний процессын явцад үйлчлэх бүхий л эрх зүйн хэм хэмжээг олон улсын иргэний процесс гэж нэрлэнэ. Тухайлбал, гадаад элемент бүхий иргэний хэргийн шүүхийн харьяалал, гадаадын иргэдийн процессын эрх, гадаад элемент бүхий хэргийг шүүхэд шийдвэрлэхэд тохиолддог онцлог зохицуулалт, гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх болон олон улсын эрх зүйн туслалцааны асуудлыг хамаарч байдаг.³⁸⁴

Олон улсын иргэний процесст баримтлах зарчмуудыг 2004 онд Хувийн эрх зүйг ижилсгэх талаарх олон улсын институт (ЮНИДРУА)-оос боловсруулан

³⁸¹ М.М.Богуславский. Олон улсын хувийн эрх зүй (сурах бичиг). 5 дахь хэвлэл. Редактор Ж.Амарсанаа, эрхэлсэн М.Мөнхбат. Улаанбаатар. 2008. 324 дэх тал

³⁸² International Civil Procedure Law. Staiger, Schwald & Partner

<http://www.ssplaw.ch/en/expertise/areas-of-law/international-civil-procedure-law/>

³⁸³ Э.Байгал. Олон улсын хувийн эрх зүй /анхны хэвлэл/. Улаанбаатар. 2012. 261 дэх тал

³⁸⁴ Э.Байгал. Олон улсын хувийн эрх зүй /анхны хэвлэл/. Улаанбаатар. 2012. 260 дахь тал

танилцуулсан байдаг.³⁸⁵ Олон улсын иргэний процесст баримтлах зарчим нь олон улсын худалдааны маргаан төдийгүй бусад иргэний хэрэгт зохистой шийдвэр гаргахад иргэний процессын стандартыг тогтоосон байна.³⁸⁶ Тус зарчмууд нь 31 зүйлтэй бөгөөд улс орнуудын иргэний процессын олон янзын ялгаатай дүрмийг тохируулах, уялдуулах зорилготой.

Олон улсын иргэний процессын эрх зүйн эх сурвалжид дотоодын процессын тухай хууль болон иргэний процессын эрх зүйд холбогдох олон талт гэрээ, хоёр талт эрх зүйн туслалцааны гэрээ хамаарна.³⁸⁷

Ихэнх улс орон иргэний процессын хууль тогтоомжоо шинэчлэн өргөжүүлж, “олон улсын иргэний процесс” хэмээн нэрлэгддэг нэлээд дэлгэрэнгүй бие даасан эрх зүйн институтийг аажмаар бүрдүүлэх боллоо.³⁸⁸

Монгол Улсын хувьд олон улсын иргэний процессын асуудлыг дотоодын хуулиар буюу ИХШХШТХ-иар зохицуулсан хэдий ч түүнийг бүрэн зохицуулах боломжгүй юм. Энэ байдлыг харгалзан тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д Монгол Улсын Үндсэн хуульд харшлахгүй бол шүүх олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэхдээ олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэж болно гэж заасан.

Энэ нь олон улсын иргэний процессын асуудлаарх нэгдэн орсон олон улсын гэрээ төдийгүй нэгдэн орох боломжтой, тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан олон улсын эрх зүйн зохицуулалтыг шүүхээс хэрэглэж болохыг харуулж байна.

Монгол Улсын гадаад улстай байгуулсан иргэн, гэр бүлийн хэргийн талаарх эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хоёр талт олон улсын гэрээ нь нарийвчилсан зохицуулалттай буюу хоёр талт гэрээгээр тусгайлан зохицуулсан асуудалд 1954 оны Гаагийн конвенцын энэ талаарх заалтыг баримтлах шаардлагагүй байдаг. Харин хоёр талт гэрээнд тусгайлан зохицуулаагүй асуудалд конвенцын заалтыг баримтална.³⁸⁹ Тухайлбал, гадаад улсад шүүхийн даалгавар гардуулах ажиллагааг шүүхүүд хэрэгжүүлэхдээ Монгол Улс тухайн гадаад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх хоёр талт олон улсын гэрээ, ийм гэрээ байхгүй бол 1954 оны Гаагийн конвенцын зүйл, заалтыг баримталж байна. Хэрэв эдгээр гэрээ нь

³⁸⁵ UNIDROIT Principles of Transnational Civil Procedure

<http://www.unidroit.org/instruments/transnational-civil-procedure>

³⁸⁶ Засгийн газар хоорондох байгууллага болох Хувийн эрх зүйг ижилсгэх талаарх олон улсын институт (ЮНИДРУА) нь хувийн эрх зүйг нэг мөр болгох иргэний эрх зүйг ижилтгэн ойртуулах, хөгжүүлэх зорилгоор 1926 онд Ром хотноо байгуулагдсан. Уг байгууллага нь 2015 оны байдлаар нийт 63 гишүүн улстай бөгөөд Монгол Улс хараахан уг байгууллагын гишүүнээр элсээгүй юм. ЮНИДРУА нь голчлон иргэний эрх зүйн материаллаг хэм хэмжээг ижилтгэх, унификаци хийх талаар дагнан ажилдаг болно. ЮНИДРУА нь өнгөрсөн түүхэндээ 70 гаруй судалгаа баримт бичиг төсөлийг боловсруулсан. Үүнээс дийлэнх хэсэг нь олон улсын эрх зүйн акт, конвенц болон загвар хууль, зарчмууд бөгөөд тэдгээрийг боловсруулж ЮНИДРУА-ийн гишүүн орнуудын төлөөлөгчдөөс бүрдсэн дипломат чуулган, хуралдаанаар баталдаг болно.

³⁸⁷ Э.Байгал. Олон улсын хувийн эрх зүй /анхны хэвлэл/. Улаанбаатар. 2012. 263 дахь тал

³⁸⁸ Т.Мэндсайхан. Олон улсын хувийн эрх зүй. Улаанбаатар. 2008. 192 дахь тал

³⁸⁹ Монгол Улсын дээд шүүхийн “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” 2008.02.28-ны өдрийн 09 дүгээр тогтоолын 11 дэх заалт. <http://legalinfo.mn/law/details/307?lawid=307>
Ред. Б.Алтангэрэл, Ж.Амарсанаа, Ч.Баттөмөр, Ц.Сарантуяа, Б.Чимид. Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар. Улаанбаатар. 2011. 153 дахь тал

нарийвчлан зохицуулаагүй бол тус харилцааг нарийвчлан зохицуулсан олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэж болно.

Түүнчлэн хэрэв олон улсын гэрээгээр Монгол Улсын хууль тогтоомжид зааснаас өөр журам тогтоосон бол тухайн шүүх нь иргэний хэргийг хянан шийдвэрлэхдээ олон улсын гэрээний журмыг хэрэглэнэ.³⁹⁰ Иймд шүүгч, хуульчдын хувьд олон улсын иргэний процессын холбогдолтой олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг судалж, танин мэдэх шаардлага байгаа нь харагдаж байна.

1.2. Эрх зүйн түүхэн хөгжил

Монгол Улсад 1992 оноос хойш гадаадын иргэд зорчих, оршин суух болон Монгол Улсын иргэд гадаадад зорчих, оршин суух, сурч, хөдөлмөрлөх явдал тасралтгүй нэмэгдсээр байна.³⁹¹ Үүнтэй холбоотойгоор Монгол Улс болон Монгол Улсын төрийн байгууллагын хувьд хилийн чанад дахь өөрийн иргэдийг хамгаалах улсын ашиг сонирхлыг хангахын тулд бусад улстай зохих түвшний харилцаа тогтоох шаардлага улам нэмэгдсээр байна.

Дипломат шугамаар бусад улстай харилцах нь цаг хугацааны хувьд удаашралтайгаас гадна дипломат шугамаар шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх ажиллагааг явуулахад зохимжгүй байдаг. Шүүх эрх мэдлээр шүүх ажиллагаа тухайн улсын нутаг дэвсгэрийн хүрээгээр хязгаарлагддаг. Ингэхдээ өөр улсын нутаг дэвсгэрт процессын ажиллагааг үргэлжлүүлэх шаардлагатай байдаг.³⁹²

Эрх зүйн туслалцааны гэрээ нь хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагуудын хооронд шууд бөгөөд тогтвортой харилцааг тогтоож өгдөг.³⁹³ Хууль зүйн яамны цахим хуудаст байгаа мэдээллээр эрх зүйн туслалцааны гэрээ нийт 19 байна.³⁹⁴ Монгол Улс анх ЗСБНХУ-тай 1958 онд (1958.08.25) Иргэний ба эрүүгийн

³⁹⁰ Монгол Улсын дээд шүүх. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. Улаанбаатар. 2014. 53 дахь тал

³⁹¹ Монгол Улсын хилээр 2012 онд давхардсан тоогоор 4.5 сая зорчигч нэвтэрсэн бөгөөд гадаадын 623.8 мянган зорчигч орсон байна. Тэдний 94.2 хувь нь 30 хүртэл хоног, 2.7 хувь нь 90 хүртэл хоног, 3.1 хувь нь 90, түүнээс дээш хоногоор ирсэн бөгөөд 73.9 хувь нь Зүүн Ази, Номхон далайн бүс нутагт, 21.3 хувь нь Европ тивд, 3.7 хувь нь Америк тивд, 1.1 хувь нь Ойрх Дорнод, Өмнөд Ази, Африк тивд хамрагдаж байна. Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 57.9 хувийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын (БНХАУ), 13.9 хувийг Оросын Холбооны Улсын (ОХУ), 7.3 хувийг Бүгд Найрамдах Солонгос Улсын (БНСУ), 2.8 хувийг Америкийн Нэгдсэн Улсын (АНУ), 2.8 хувийг Япон улсын, 15.3 хувийг бусад орны иргэд эзэлж байна.

Хилээр орсон гадаадын зорчигчдын 76.3 хувь нь аялал жуулчлалын зорилгоор, 23.7 хувь нь ажиллах, суралцах болон байнга оршин суухаар ирсэн байна. Монгол Улсын хилээр 2012 онд гарсан зорчигчдын 1631.5 мянга буюу 72.3 хувь нь Монгол Улсын иргэд бөгөөд тэдний 85.3 хувь нь хувийн ажлаар гадаадад зорчсон байна. Гадаадад зорчсон манай иргэдийн 77.0 хувь нь БНХАУ (1.2 сая хүн), 13.2 хувь нь ОХУ (214.7 мянган хүн), 3.3 хувь нь БНСУ (54.3 мян.хүн), 6.5 хувь нь бусад оронд зорчсон байна.

Монгол Улсын үндэсний статистикийн хороо. Монгол Улсын статистикийн эмхтгэл. Улаанбаатар. 2013. 44 дэх тал

³⁹² Хууль зүй, дотоод хэргийн яам. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх нь (хуульчдад зориулсан гарын авлага). Улаанбаатар. 2009. 12 дахь тал

³⁹³ Мөн номын 12 дахь тал

³⁹⁴ Хууль зүйн яам. Эрх зүйн туслалцааны гэрээ. http://moj.gov.mn/legal_assistance_treaty.html

хэрэг болон гэр бүл, гэрлэхтэй холбогдсон хэргийн талаар хуулийн туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулсан.³⁹⁵

Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ нь улс орнууд шүүх эрх мэдлийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд харилцан дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулсан хэлэлцээр юм. Энэ гэрээ нь материаллаг, процессын, зөрчилдөөний хэм хэмжээг өөртөө агуулсан байдаг.³⁹⁶

Хоёр талт гэрээгээр дамжин илэрч буй иргэний хэргийн эрх зүйн харилцан туслалцааны гэрээний ач холбогдол нь нэг улсын иргэдийн эд хөрөнгийн болон хувийн эрхийг нөгөө улсын нутаг дэвсгэр дээр хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх явдлыг хангадаг оршино. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ нь дараах үндсэн асуудлыг зохицуулна. Үүнд:

- Хуулийн байгууллагуудын хамтын ажиллагаа;
- Хэргийн шүүхийн харьяалал;
- Гадаадын иргэдийн процессын эрх;
- Шүүхийн баримт бичгийг гардуулан өгөх журам;
- Иргэн, гэр бүлийн хэргийн шүүхийн шийдвэр, тогтоолыг хүлээн зөвшөөрч, биелүүлэх журам;
- Гэрлэлт бүртгэх буюу цуцлах, асран хамгаалагч тогтоох, хүүхэд үрчлэх гэх мэт гэр бүлийн асуудлууд;
- Өв залгамжлал, өвлөгдөх эд хөрөнгийг хамгаалах, өвлөх харилцаанд хэрэглэгдэх эрх зүйг тодорхойлох.³⁹⁷

Монгол Улс иргэн, гэр бүл, аж ахуйн хэргийн эрх зүйн асуудлаар харилцан туслалцаа үзүүлэх хоёр талт олон улсын гэрээг зарим улстай байгуулсан. Энэ улсуудад Унгар, Болгар, Румын, Чех, Югослав, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос, Куб, БНХАУ, Франц, Казахстан, Украин, Польш, ОХУ, Вьетнам, Турк, Энэтхэг, БНСУ хамаарч байна.

Гэхдээ Монгол Улс дээр дурдсанаас бусад улстай буюу олон улсад шүүхийн шийдвэр нь хүлээн зөвшөөрөгддөг АНУ, ИБУИНВУ, Япон, Австрали, Австри, Швейцар, Шинэ Зеланд, ХБНГУ, Дани, Канад зэрэг улстай иргэний хэргийн эрх зүйн асуудлаар харилцан туслалцаа үзүүлэх хоёр талт олон улсын гэрээ байгуулаагүйг Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг гадаадын хуулийн фирмүүд шүүмжилсэн байдаг.³⁹⁸

Цаашид ямар улстай иргэний хэргийн асуудлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хоёр талт олон улсын гэрээ байгуулахыг шийдвэрлэхдээ Монгол Улсын иргэд ихээр зорчдог буюу суурьшдаг байдлыг харгалзах нь зүйтэй юм.³⁹⁹

Өдгөө хүчин төгөлдөр үйлчилж эрх зүйн туслалцааны гэрээнүүдийг 1968 оноос эхлэн 2008 оныг хүртэл тасралтгүй байгуулсаар иржээ.⁴⁰⁰ Үүнээс иргэний ба

³⁹⁵ Т.Мэндсайхан. Олон улсын хувийн эрх зүй. Улаанбаатар. 2008. 195 дахь тал

³⁹⁶ ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төв. Процессын эрх зүйн толь (гарын авлага). Улаанбаатар хот. 2014. 220 дахь тал

³⁹⁷ Э.Байгал. Олон улсын хувийн эрх зүй /анхны хэвлэл/. Улаанбаатар. 2012. 55 дахь тал

³⁹⁸ The Legal Environment for Litigation in Mongolia. Mongolia LEX. Volume I, 2009

<http://www.analp.com/the-legal-environment-for-litigation-in-mongolia/>

³⁹⁹ Э.Байгал. Олон улсын хувийн эрх зүй /анхны хэвлэл/. Улаанбаатар. 2012. 55 дахь тал

эрүүгийн хэргийн талаар харилцан туслалцаа үзүүлэх гэрээ 15 байх бөгөөд зөвхөн иргэний болон худалдааны хэргийн талаарх харилцан туслалцааны гэрээ 2 байна.

Монгол Улсын хувьд олон улсын иргэний процессын асуудлыг олон улсын гэрээнээс гадна дотоодын хууль тогтоомжоор 1992 оноос өмнө зохицуулж ирсэн гэж үзэх үндэстэй. Учир нь 1967.06.29-ний өдөр батлагдсан БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн 6 дугаар хэсэгт “Олон улсын иргэний эрхийн холбогдолтой байцаан шийтгэх ажиллагаа”-ны талаар тусгасан байна.⁴⁰¹ Тодруулбал, тус хуулийн 310 дугаар зүйлд гадаадын шүүхийн даалгаврыг гүйцэтгэх, 311 дүгээр зүйлд БНМАУ-ын шүүх гадаад улсын шүүхээр даалгавар гүйцэтгүүлэх, 312 дугаар зүйлд гадаадын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх талаар заажээ. Ингэхдээ холбогдох журам буюу процессыг гадаад улстай байгуулсан хэлэлцээрээр тодорхойлохоор зохицуулжээ.

Одоо үйлчилж байгаа 2002 оны ИХШХШТХ-ийн “Иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа ба олон улсын хууль тогтоомж” гэсэн 7 дугаар хэсгийн “Олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэсэн 19 дүгээр бүлэгт олон улсын иргэний процессын асуудлыг тусгасан байна. Үүнд хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн болон шүүхийн харьяалал, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх асуудлыг зохицуулжээ. Гэхдээ хуулийн 194.1-т зааснаар Монгол Улсын шүүхийн болон гадаад улсын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журам нь Монгол Улсын хууль тогтоомж, гадаад улстай байгуулсан буюу Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр тодорхойлохоор заасан нь тус бүлэг нь бусад хэм хэмжээ, олон улсын гэрээтэй харилцан уялдаатайгаар хэрэгжихийг харуулж байна.⁴⁰²

Мөн ИХШХШТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.5-д Монгол Улсын Үндсэн хуульд харшлахгүй бол шүүх олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэхдээ олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэж болно гэж заасан. Энэ нь Монгол Улсад олон улсын иргэний процессын асуудлаарх нэгдэн орсон олон улсын гэрээ төдийгүй тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан олон улсын эрх зүйн зохицуулалтыг шүүхээс хэрэглэж болохыг харуулж байна. Тус хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т зааснаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө. Энэ нь ямар олон улсын гэрээ вэ гэх асуулт урган гарна. Монгол Улсын олон улсын гэрээ гэдэг нь олон улсын аливаа гэрээ биш зөвхөн Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон талт болон хоёр талт гэрээг хэлж байгаа болно.⁴⁰³

Иймд Монгол Улс нэгдэн орсон тул 1954 оны Гаагийн конвенц нь Монгол Улсын ИХШХШТХ-тай хамт, харилцан уялдаатай хэрэглэгдэх юм. Хуулийг хэрэглэхдээ конвенцын заалтыг баримтлахад зарцуулах хугацааг тооцох нь зүйтэй

⁴⁰⁰ Монгол Улсаас бусад улстай байгуулсан иргэний ба эрүүгийн эрх зүйн асуудлаар харилцан туслалцаа үзүүлэх гэрээнүүдийн мэдээллийг Хавсралт 1-ээс үзнэ үү.

⁴⁰¹ Ерөнхий редактор Б.Чимид. Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Тавдугаар боть (1958.XI сар-1970 он). Улаанбаатар. 2010 он. 532 дахь тал

⁴⁰² Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002. Төрийн мэдээлэл. 2002 он, №8

⁴⁰³ Ред. Б.Алтангэрэл, Ж.Амарсанаа, Ч.Баттөмөр, Ц.Сарантуяа, Б.Чимид. Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн дэлгэрэнгүй тайлбар. Улаанбаатар. 2011 он. 8 дахь тал

юм. Учир нь шүүхийн даалгавар гардуулах үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн бол ИХШХШТХ-ийн 80.4-т заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн шалтгаан шүүгчийн заасан хугацаанд арилаагүй гэж шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээж, хэргийг хэрэгсэхгүй болгох захирамж гаргах үр дагавартай юм.

Мөн шүүхийн болон шүүхийн бус баримт бичиг гардуулах ажиллагааны дагуу шүүхээс ИХШХШТХ-ийн 39.3-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхдээ хэргийн оролцогчдын эрх ашгийг хангах үүднээс хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх хугацааг аль болох урт хугацаагаар тогтоож болох юм.

1.3. Иргэний хэргийн асуудлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаанд нийтийн дэг журмыг /order public/ хангах

Иргэний хэргийн эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагааны явцад нийтийн дэг журмыг хангах нь улс бүрийн нийтлэг асуудал болсон байна.

Энэ нь бусад улсаас хандсан эрх зүйн туслалцааны хүсэлт нь нөгөө улсын нийтийн дэг журмыг зөрчих буюу зөрчсөн бол хүсэлт авсан улс нь эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах эрхийн тухай ойлголт юм. Энэ нь тухайн хүсэлтийг хэрэгжүүлснээс үүсэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилготой юм. Эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааны явцад нийтийн дэг журмыг хангахын сөрөг тал нь эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах, үүнээс үүдэн эрх зүйн туслалцаа үзүүлэх үе шатыг дуусгавар болгох юм.

Иргэний хэргийн эрх зүйн харилцан туслалцааны явцад тухайн хүсэлтийг биелүүлэх нь хүсэлт хүлээн авагч улсад нийтийн дэг журмыг хангаагүй буюу эрх зүйн туслалцаа үзүүлэх улсын эрх ашигт нийцээгүй тохиолдолд хоёр талын эрх ашигт нийцсэн зохих арга хэмжээ авахад хэцүү байх болно. Иймд олон улсын эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаанд нийтийн дэг журмыг хангах асуудал улс орнуудын хууль тогтоомжид туссан байна. Монгол Улсын эрх зүйн туслалцаа үзүүлэх хоёр талт гэрээнд нийтийн дэг журмыг хангах тухай тодорхой туссан. Гадаад улсууд хоёр талт эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг байгуулахдаа мөн энэ тухай тусгадаг байна. Тухайлбал, БНХАУ-ын дотоодын хууль, БНХАУ-ын эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээнд нийтийн дэг журмын тухай тусгасан бөгөөд нийгмийн дэг журам нь “бүрэн эрхт байдал ба аюулгүй байдал”, “нийгмийн эрх ашиг”, “хуулийн үндсэн хэв журам”, “нийтийн дэг журам” гэх мэт утгаар илэрхийлсэн байдаг.⁴⁰⁴

Монгол Улс БНХАУ-ын хооронд байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний 9 дүгээр зүйлд хэрэв даалгавар хүлээж авсан Хэлэлцэн тохирогч Тал эрх зүйн туслалцаа үзүүлэх нь өөрийн орны бүрэн эрхт болон аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулахаар байна гэж үзвэл эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно. Гэхдээ татгалзсан шалтгааныг даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдэнэ гэж заасан. Түүнчлэн Монгол Улс ОХУ-ын

⁴⁰⁴ Ц.Мандах “Монгол Улс болон БНХАУ-ын Олон улсын хувийн эрх зүйн харьцуулсан судалгаа” докторын зэрэг горилох диссертаци, БНХАУ, Шиан Мэний Их сургууль, 2014 он.187 дахь тал

хооронд байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний 17 дугаар зүйлд мөн энэ талаар заасан байна.

Нийтийн дэг журмын тухай ойлголт нь гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх болон эрх зүйн туслалцаа үзүүлэх үед үүсэж болох сөрөг үр дагавараас урьдчилан сэргийлэхэд дөхөм болох эрх зүйн арга хэрэгсэл юм. Гэсэн хэдий ч нийтийн дэг журмыг хангах зорилгоор хэрэглэх ёстой олон улсын гэрээг баримтлахгүй байх боломжтой юм. Өөрөөр хэлбэл нийтийн дэг журмыг зөв тодорхойлохгүй, хавтгайруулж хэрэглэх нь хоёр талын эрх зүйн туслалцаа үзүүлэх ажиллагаанд сөрөг үр дагавартай юм. Энэ тохиолдолд шүүгч ИХШХШТХ-ийн 10 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан шүүх хуулиуд хоорондоо зөрчилтэй буюу хууль шударга бус, эсхүл нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш гэсэн үндэслэлээр хуулийн хэм хэмжээг хэрэглэхээс татгалзаж болохгүй тухай заалтыг баримтлах нь зөв юм.⁴⁰⁵

1.4. Олон улсын гэрээний үйлчлэлийн залгамж

1992 оны Үндсэн хууль батлагдсанаас хойш байгуулсан хоёр талт олон улсын гэрээ 9 байна. Үүнд Бүгд Найрамдах Франц улс, Бүгд Найрамдах Казахстан улс, Украин улс, Бүгд Найрамдах Польш улс, Оросын Холбооны улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам улс, Бүгд Найрамдах Турк улс, Бүгд Найрамдах Энэтхэг улс, Бүгд Найрамдах Солонгос улстай байгуулсан хоёр талт олон улсын гэрээнүүд хамаарч байна. Эдгээр гэрээний үүргээ Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2-т зааснаар Монгол Улс шударгаар сахин биелүүлнэ.

Харин 1992 оны Үндсэн хууль батлагдахаас өмнө байгуулсан хоёр талт олон улсын гэрээ 8 байна. Үүнд Бүгд Найрамдах Унгар Ард улс, Бүгд Найрамдах Болгар Ард улс, Бүгд Найрамдах Социалист Румын улс, Бүгд Найрамдах Социалист Чехословак улс, Бүгд Найрамдах Социалист Югослав улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос улс, Бүгд Найрамдах Куба улс, Бүгд Найрамдах Хятад Ард улстай байгуулсан хоёр талт олон улсын гэрээнүүд хамаарч байна.

БНМАУ-ын Ардын их хурлаас 1992.01.16-ны өдөр баталсан, 1992.02.12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсөн Монгол Улсын Үндсэн хуулийн хавсралт хууль “БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 1-т: “Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл даган мөрдөж ирсэн бөгөөд мөнхүү Үндсэн хуульд харшлахгүй БНМАУ-ын олон улсын гэрээг Монгол Улс цаашид нэгэн адил дагаж мөрдөнө” гэж заасан.⁴⁰⁶

Энэ заалтыг ойлгохын тулд дараах ойлголтыг тодорхой болгох шаардлагатай байна. Үүнд а/ харшлах б/ олон улсын гэрээ в/ дагаж мөрдөх. “Харшлах” гэх үгийг Монгол Улсын хууль тогтоомжид түгээмэл хэрэглэсэн байдаг. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2-т “Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ” гэж, “Монгол Улсын

⁴⁰⁵ Ц.Мандах “Монгол Улс болон БНХАУ-ын Олон улсын хувийн эрх зүйн харьцуулсан судалгаа” докторын зэрэг горилох диссертаци, БНХАУ, Шиа Мэний Их сургууль, 2014 он. 86-87 дахь тал

⁴⁰⁶ Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын “Эрх зүйн боловсрол” академи. 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд. Улаанбаатар. 2007. 217 дахь тал

үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “... үндэсний аюулгүй байдалд харшилсан үйл ажиллагаа явуулбал үйл ажиллагаа явуулах эрхийг нь хязгаарлаж болно” гэж харшлах гэх үгийг хэрэглэжээ. Гэвч тус үгийн утгыг тайлбарласан эрх зүйн хэм хэмжээ одоогоор алга. Харин тус үгийг Я.Цэвэл гуайн “Монгол хэлний товч тайлбар толь”-д “харш болох, эс нийцэх, үл зохих” гэж тайлбарлажээ.⁴⁰⁷

Эндээс харахад Үндсэн хуульд нийцээгүй буюу зөрчилдсэн олон улсын гэрээг Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ гэж үзнэ.

“Олон улсын гэрээ” гэж 1969 оны “Олон улсын гэрээний эрх зүйн тухай” Венийн конвенцод тодорхойлсноор нэг буюу хоёр, эсхүл өөр хоорондоо холбоотой хэд хэдэн баримт бичигт агуулагдаж байгаа бөгөөд түүний тодорхой нэрээс хамаарахгүйгээр улсуудын хооронд бичгээр байгуулсан, олон улсын эрх зүйгээр зохицуулагдаж байгаа олон улсын хэлэлцээрийг хэлнэ.⁴⁰⁸ Мөн олон улсын гэрээг Олон улсын гэрээний тухай хуульд “Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг буюу хэд хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ” гэж тодорхойлжээ.⁴⁰⁹ Олон улсын гэрээ нь гэрээ, хэлэлцээр, тунхаглал, пакт, контракт, конвенц, протокол зэрэг нэр, хэлбэртэй байна.⁴¹⁰

Олон улсын гэрээг заавал “дагаж мөрдөх” асуудлыг олон улсын эрх зүйд “*pacta sunt servanda*” гэж томъёолдог. Тодруулбал, “Аливаа хүчин төгөлдөр гэрээг түүнд оролцогч улсууд заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд түүнийг үнэнч шударгаар хэрэгжүүлнэ” гэж Олон улсын гэрээний эрх зүйн тухай 1969 оны Венийн Конвенцод тусгасан байдаг. Энэ нь олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн “*Pacta sunt servanda*” буюу гэрээг заавал биелүүлэх зарчим юм.⁴¹¹ Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улс нь олон улсын эрх зүйн үндсэн зарчмуудын нэг болох “гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх” зарчмыг баримтлах талаар заасан. Олон улсын гэрээний тухай хуульд “олон улсын гэрээний үйлчлэлийг түр зогсоох” гэж тухайн олон улсын гэрээг бүхэлд нь буюу түүний зарим заалтыг тодорхой буюу тодорхой бус хугацаагаар дагаж мөрдөхөөс түдгэлзэхийг хэлнэ гэжээ. Дээр дурдсанаас үзэхэд олон улсын гэрээг дагаж мөрдөх нь олон улсын нийтийн эрх зүйгээр тодорхойлсон зарчим бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ заавал биелүүлэх утгыг илэрхийлж байна.

Шүүхийн хувьд эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхдээ хүчин төгөлдөр болсноор заавал даган мөрдөх шинжийг агуулсан, албан ёсоор нийтлэгдсэн,

⁴⁰⁷ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь http://toli.query.mn/dictionary_items/4951

⁴⁰⁸ “Олон улсын гэрээний эрх зүйн тухай” 1969 оны Венийн конвенцын албан бус орчуулга <http://www.legalinfo.mn/law/details/1214>

⁴⁰⁹ Олон улсын гэрээний тухай хууль. Төрийн мэдээлэл. 1994 он, №3

⁴¹⁰ Монгол Улсын Хууль зүйн яам, “Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагалга”. Улаанбаатар. 1993. 25 дахь тал

⁴¹¹ Hans Wehberg. *Pacta Sunt Servanda*. *The American Journal of International Law*. Vol. 53, No. 4 (Oct., 1959), pp. 775-786 <http://www.jstor.org/stable/2195750> ; American Society of International Law and the International Judicial Academy. *Pacta Sunt Servanda*. September 2008 http://www.judicialmonitor.org/archive_0908/generalprinciples.html

дотоодын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардсан заалтгүй, Үндсэн хуульд харшлаагүй Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ.⁴¹²

Эндээс үзэхэд, Үндсэн хуульд харшилсан олон улсын гэрээ гэдэгт гэрээгээр хүлээсэн үүргээ заавал биелүүлэх утгыг илэрхийлсэн, олон улсын эрх зүйгээр зохицуулагдаж байгаа, Үндсэн хуульд нийцээгүй буюу зөрчилдсэн олон улсын хэлэлцээрийг ойлгож болохоор байна. Иймд Үндсэн хуульд харшлаагүй олон улсын гэрээ гэдэг нь дээрх “Үндсэн хуульд нийцээгүй” гэх шинжийг үгүйсгэх буюу гэрээгээр хүлээсэн үүргээ заавал биелүүлэх утгыг илэрхийлсэн, олон улсын эрх зүйгээр зохицуулагдаж байгаа, Үндсэн хуульд нийцсэн буюу зөрчилдөөгүй олон улсын хэлэлцээр юм.

Эндээс дүгнэхэд, 1992 оноос өмнө буюу БНМАУ-аас бусад улстай байгуулсан иргэний болон эрүүгийн хэргийн асуудлаарх харилцан туслалцаа үзүүлэх хоёр талт гэрээ нь Үндсэн хуульд харшлаагүй бөгөөд Монгол Улсын олон улсын гэрээний бүрэлдэхүүн юм. Иймд 1992 оны Үндсэн хууль батлагдахаас өмнө байгуулсан хоёр талт олон улсын 8 гэрээг Монгол Улс цаашид нэгэн адил дагаж мөрдөнө.

Энд анхаарах зүйл бол Монгол Улсын хоёр талт олон улсын гэрээнүүд албан ёсоор нийтлэгдсэн эсэх юм. Учир нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т зааснаар шүүх хүчин төгөлдөр болсон, албан ёсоор нийтлэгдсэн Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ.⁴¹³ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.10-т хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд хэвлэн нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эх гэж үзнэ гэснээс харахад Монгол Улсын олон улсын гэрээг албан ёсоор нийтлэх гэдэг нь “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд хэвлэн нийтлэхийг хэлж байна.⁴¹⁴ Гэвч 2015.12.31-ний байдлаар “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн тусгай дугаарт Монгол Улсын хоёр талт олон улсын гэрээнүүд албан ёсоор нийтлэгдээгүй байна.⁴¹⁵ Гэхдээ энэ нь Улсын Их Хурлын тамгын газар, Гадаад хэргийн яамнаас шийдвэрлэж болох асуудал тул үүнээс үл хамааран албан бусаар нийтлэгдсэн олон улсын гэрээнүүдийг хэрхэн хэрэглэх талаар мэдлэг, чадвартай байх нь чухал юм.⁴¹⁶

Хоёр. Гадаад улсад шүүхийн баримт бичгийг гардуулах

Гадаад улсад шүүхийн баримт бичгийг гардуулах талаар ярихын тулд шүүхийн баримт бичгийг тодорхойлох шаардлагатай. Товчхондоо бол шүүхээс хэрэг

⁴¹² Монгол Улсын Дээд шүүхийн 2008.02.28-ны өдрийн “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” 09 дүгээр тогтоолын 3 дахь заалтаас <http://legalinfo.mn/law/details/307?lawid=307>

⁴¹³ “Төрийн мэдээлэл”. 2012 он, №11

⁴¹⁴ “Төрийн мэдээлэл”. 2007 он, №39

⁴¹⁵ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн тусгай дугаар 10 ботиор хэвлэгдсэн байх бөгөөд түүнд Монгол Улсын хоёр талт олон улсын гэрээнүүд албан ёсоор нийтлэгдээгүй байна <http://www.parliament.mn/legal/tm/categories/2358>

⁴¹⁶ Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2-т зааснаар олон улсын гэрээг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрхлэн тусгай эмхтгэл болгон хэвлэж байна.

хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичгийг шүүхийн баримт бичиг гэж үздэг. Ийм баримт бичгийг гурав ангилж болно. Үүнд:

- Шүүхийн шийдвэр, захирамж зэрэг шүүхээс гаргах эрхийн акт;
- Шүүхийн шинжилгээний баримт бичиг зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд цугларсан буюу бүрдүүлсэн баримт бичиг;
- Баталгаа, гомдол зэрэг шүүн таслах үйл ажиллагааны явцад үйлдсэн бусад баримт бичиг.⁴¹⁷

Гадаад улсад шүүхийн баримт бичгийг гардуулах асуудлыг ИХШХШТХ-иар тусгайлан зохицуулаагүй бөгөөд түүнийг Монгол Улсын нэгдэн орсон 1954 оны Гаагийн конвенц болон хоёр талт олон улсын гэрээгээр зохицуулж байна. 1954 оны Гаагийн конвенцтой уялдаатай буюу түүнийг нэмж дэлгэрүүлж, сайжруулсан конвенцууд бол 1965 оны “Иргэний буюу худалдааны асуудлаарх шүүхийн болон шүүхийн бус баримт бичгийг гадаадад хүргүүлэх тухай” Гаагийн конвенц, 1970 оны “Иргэний буюу худалдааны асуудлаарх хилийн чанад дахь нотлох баримтыг гаргуулан авах тухай” Гаагийн конвенц юм. Энд дурдсан сүүлийн хоёр конвенцод Монгол Улс нэгдэн ороогүй болно.⁴¹⁸ Энд дурдсан гурван конвенцыг судлаачид иргэний хэргийн асуудлаарх олон улсын хамтын ажиллагааны бөгөөд шүүхийн туслалцааны олон улсын багц баримт бичиг гэж үздэг.⁴¹⁹

Жишээ. Монгол Улсын “А” ХК-д холбогдох иргэний маргааныг хянан шийдвэрлэх хэрэгт хамаарах шүүхийн даалгаврыг Москва хотын Арбитрын шүүхээс ирүүлсэн байна. Нэхэмжлэгч нь ОХУ-ын “Б” компани бөгөөд товлосон шүүх хуралдаанд хариуцагчийн төлөөлөгч ирээгүй учир төлөөлөгчийг томилуулах талаар шүүх хуралдааны даалгаварт хүссэн байна. Уг хүсэлтийг Москва хотын Арбитрын шүүхээс ОХУ-ын Хууль зүйн яамаар дамжуулан Монгол Улсын Хууль зүйн яаманд ирүүлжээ. Ийнхүү шүүхийн даалгавар ирүүлэх үндэслэл нь Монгол ба ОХУ-ын байгуулсан иргэний ба эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /1999.04.20/ болно. Хүсэлтийг Монгол Улсын Хууль зүйн яам даалгаварт хамаарах этгээдийн харьяалах анхан шатны шүүхэд хүргүүлж биелэгдэх боломжтой эсэхийг тодорхойлсон бөгөөд даалгаврыг биелүүлэхээс татгалзах үндэслэлгүй бөгөөд даалгаварт заасан ажиллагааг гүйцэтгэж, хариу хүргүүлжээ.⁴²⁰

⁴¹⁷ Black's Law Dictionary - Free Online Legal Dictionary 2nd Ed. See 1 Starkie, Ev. 252

<http://thelawdictionary.org/judicial-documents/>

⁴¹⁸ Status detail, Mongolia <https://www.hcch.net/en/states/other-connected-states/details2/?sid=113>

⁴¹⁹ International Judicial Assistance in Civil Matters (Guidelines). 3rd edition 2003. 2003 by the Private International Law Unit of the Federal Office of Justice FOJ, together with the Division for International Legal Assistance (FOJ), the Directorate of International Law (DFA) and the Office of the Attorney General of Switzerland <http://www.rhf.admin.ch/etc/medialib/data/rhf.Par.0064.File.tmp/wegl-ziv-e.pdf>

⁴²⁰ Э.Байгал. Олон улсын хувийн эрх зүй /анхны хэвлэл/. Улаанбаатар. 2012. 314 дэх талд дурдсан жишээ болно.

Иргэний хэргийн асуудлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хоёр талт олон улсын гэрээ ёсоор гадаад улсад шүүхийн баримт бичгийг гардуулан өгөхөд дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд:

- хүлээлгэн өгөх бичиг баримтын нэрийг заасан байх
- баримт бичиг хүлээн авагч этгээдийн хаягийг тодорхой заасан байх /Шүүхийн бичиг баримтыг хүлээн авбал зохих этгээдийн хаяг нь тодорхойгүй тохиолдолд даалгавар хүлээн авагч байгууллага нь өөрийн улсын хууль тогтоомжид заасны дагуу шаардагдах арга хэмжээг авах үүрэгтэй/
- тухайн улстай байгуулсан эрх зүйн туслалцааны гэрээнд заасан хэлийг хэрэглэх /Хүлээн авч байгаа этгээд нь тухайн баримт бичгийг гэрээнд зааснаас өөр хэлээр хүлээн авахаас татгалзаагүй бол заавал орчуулахгүй байж болно/⁴²¹

1954 оны Гаагийн конвенц ёсоор гадаад улсад шүүхийн баримт бичгийг гардуулан өгөхөд дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд:

- баримт бичгийг хилийн чанадад буй этгээдэд хүсэлт гаргагч улсын консулын хүсэлтээр гардуулах;
- хүсэлтийг түүнийг хүлээн авах эрх бүхий байгууллагын хэлээр үйлдсэн байх;
- хүсэлтэд гардуулбал зохих баримт бичгийн хуулбарыг хоёр хувь хавсаргах.⁴²² Үүнээс гадна дараах нэмэлт боломж бий.⁴²³ Үүнд:
- баримт бичгийг гадаадад байгаа сонирхогч этгээдэд шуудангаар шууд илгээх;
- баримт бичгийг гардуулах үйл ажиллагааг хийж буй улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэгч буюу эрх бүхий албан тушаалтнуудаар дамжуулан эдгээр баримт бичгийг сонирхогч этгээдэд шууд гардуулах;
- улс бүр өөрсдийн дипломат буюу консулын төлөөлөгчөөр дамжуулан гадаадад байгаа этгээдэд өгөх баримт бичгийг шууд гардуулах.

Гэхдээ энд анхаарах зүйл бол, баримт бичиг гардуулах дээрх аргыг зөвхөн сонирхогч улсуудын байгуулсан хэлэлцээрээр зөвшөөрсөн буюу хэлэлцээр байхгүй нөхцөлд нутаг дэвсгэрт нь гардуулалт хийж байгаа улсын зүгээс саад учрахгүй тохиолдолд хэрэглэж болно.

1965 оны “Иргэний буюу худалдааны асуудлаарх шүүхийн болон шүүхийн бус баримт бичгийг гадаадад хүргүүлэх тухай” Гаагийн конвенц нь 2015.12.16-ны байдлаар нийт 69 оролцогч улстай бөгөөд шүүхийн болон шүүхийн бус баримт бичгийг нэг оролцогч улсаас нөгөө улсад хүргүүлэх зорилгоор дамжуулах арга замыг заадаг. Тус конвенцод нэгдсэнээр шүүхийн болон шүүхийн бус баримт бичгийг гишүүн улсуудад хүргүүлэх, зохих этгээдэд гардуулан өгөх ажиллагааг илүү хурдан, шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой юм.⁴²⁴

⁴²¹ Э.Байгал. Олон улсын хувийн эрх зүй /анхны хэвлэл/. Улаанбаатар. 2012. 313 дахь тал

⁴²² 1954 оны Гаагийн конвенцын 1-3 дугаар зүйлээс үзнэ үү.

⁴²³ 1954 оны Гаагийн конвенцын 6 дугаар зүйлээс үзнэ үү.

⁴²⁴ Number of Contracting States to the Convention of 15 November 1965 on the Service Abroad of Judicial and Extrajudicial Documents in Civil or Commercial Matters

<https://www.hcch.net/en/instruments/conventions/status-table/?cid=17>

Шүүхийн бус баримт бичиг гэдэг нь иргэний эрх зүйн асуудлаар нэхэмжлэл гаргах, эрхээ хамгаалахад зохих ёсоор шаардлагатай бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтан болон иргэн, хуулийн этгээдийн зүгээс боловсруулсан буюу гэрчилсэн, гадаадад байгаа этгээдэд хаяглан албан ёсоор дамжуулах баримт бичиг юм.⁴²⁵ Тухайлбал, шүүхийн бус баримт бичигт нотариатын мэдэгдэх хуудас буюу нотариатын үйлдсэн буюу гэрчилсэн баримт бичгийг хамааруулдаг.⁴²⁶ Мөн шүүхийн бус баримт бичигт эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээ, зөвшөөрөл, хүүхэд үрчлэхийг зөвшөөрсөн шийдвэр зэрэг ордог байна.⁴²⁷

Тус конвенцод зааснаар хүсэлт тавьж буй улсын хуульд зааснаар тухайн улсын шүүхийн эрх бүхий байгууллага буюу ажилтан нь баримт бичгийн хүсэлтийг хүлээн авах улсын эрх бүхий төв байгууллагад хүргүүлэхээр дамжуулна. Баримт бичиг хүргүүлэх хүсэлтийг конвенцын хавсралтаар заасан загвар, маягтын дагуу үйлдэгдсэн байх бөгөөд түүнд хүргүүлэх баримт бичгүүдийг хавсаргасан байна. Тус конвенцын гишүүн болсноор дотоодод мөрддөг баримт бичгийн шаардлага, түүнийг хүргүүлэх нөхцөлд өөрчлөлт орохгүй.⁴²⁸ Мөн конвенцын оролцогч талууд эрх бүхий байгууллага, ажилтны хоорондын шууд харилцааг хөндөхгүй бөгөөд баримт бичиг хүргүүлэх арга нь баримт бичгийн агуулга, чанарт нөлөөлөхгүй байхаар зохицуулсан.

Монгол Улстай хоёр талт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулаагүй бөгөөд Монгол Улсын иргэн, хуулийн этгээдтэй иргэний эрх зүйн харилцаанд орох нь нэмэгдэж буй дийлэнх улсууд Гаагийн дээрх конвенцод нэгдэн орсон байна. Энэ нь эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулаагүй улсуудтай шинээр гэрээ байгуулахгүйгээр дээрх Гаагийн хоёр конвенцод нэгдэх замаар конвенцын гишүүн орнуудтай иргэний эрх зүйн асуудлаар хамтран ажиллах, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх боломжтой болохыг харуулж байна.

Хэдийгээр Монгол Улс 1965 оны Конвенцид нэгдэн ороогүй ч эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хоёр талт олон улсын гэрээнд тусгагдсан гадаад улсад шүүхийн баримт бичиг гардуулах ажиллагааг зохицуулсан журам нь 1965 оны Конвенцын зүйл, заалттай зөрчилдөхгүй байгаа тул Монгол Улсын хоёр талт гэрээ байгуулсан улсуудтай шууд хоёр талын харилцан туслалцаа үзүүлэх гэрээг баримталж явуулах боломжтой юм. Харин хоёр талт гэрээ байгуулаагүй улсуудтай 1954 оны Конвенцын хүрээнд энэхүү ажиллагааг явуулна.

Гурав. Нотлох баримтыг хилийн чанадад бүрдүүлэх

⁴²⁵ The ECJ on the meaning of “extrajudicial document” and on the service of such a document according to Regulation No 1393/2007 By Pietro Franzina. 2015

<http://conflictoflaws.net/2015/the-ecj-on-the-meaning-of-extrajudicial-document-and-on-the-service-of-such-a-document-according-to-regulation-no-13932007/>

⁴²⁶ Judgment of the Court of Justice in Case C-14/08. Roda Golf & Beach Resort SL. 2009

http://europa.eu/rapid/press-release_CJE-09-55_en.htm?locale=en

⁴²⁷ Ц.Мандах “Монгол Улс болон БНХАУ-ын Олон улсын хувийн эрх зүйн харьцуулсан судалгаа” докторын зэрэг горилох диссертаци, БНХАУ, Шиа Мэний Их сургууль, 2014 он. 189 дэх тал

⁴²⁸ Конвенцын хавсралт маягтын орос-англи-франц хэл дээрх хувилбарыг эндээс үзнэ үү: <https://assets.hcch.net/docs/7a39aaee-6fb4-4fc5-9731-2181afde76c1.pdf> Бусад хэл дээрх хувилбарыг эндээс үзнэ үү: <https://www.hcch.net/en/instruments/conventions/service/model-form>

Хилийн чанадад нотлох баримтыг бүрдүүлэх асуудлыг Монгол Улсын ИХШХШТХ, 1954 оны Гаагийн конвенц, 1970 оны “Иргэний буюу худалдааны асуудлаарх хилийн чанад дахь нотлох баримтыг гаргуулан авах тухай” Гаагийн конвенцоор тус тус зохицуулж байна. Ийнхүү хилийн чанадад нотлох баримт бүрдүүлэх шаардлагыг шүүгч, судлаачид шүүх хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий шийдвэр гаргахтай холбон тайлбарласан байдаг.⁴²⁹

Жишээ. Монгол Улсын “А” ХК нь тус улсын “Б” ХХК-ны эсрэг худалдан авах гэрээний маргаантай холбоотой нэхэмжлэл гаргажээ. “А” ХК нь маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхийн тулд “Б” ХХК-ний түнш болох худалдан авах гэрээний хамтран оролцогч БНХАУ-ын “С” компаниас холбогдох нотлох баримт гаргуулах шаардлагатай гэж үзэж, шүүхэд хүсэлт гаргажээ. Шүүхээс хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх нь зүйтэй гэж шүүхийн даалгавар гаргахаар шийдвэрлэжээ.

Монгол Улсын ИХШХШТХ-ийн 39 дүгээр зүйлд хилийн чанадад нотлох баримтыг бүрдүүлэх асуудлыг заасан. Энд зааснаар шүүхийн хүсэлтийг биелүүлэх журмыг тухайн улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээгээр, ийм гэрээ байхгүй тохиолдолд дипломат шугамаар тохиролцоно.

Тодруулбал, тус хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т зааснаар хилийн чанадад нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай бол зохигчийн хүсэлтээр шүүх өөрөө, эсхүл эрх бүхий байгууллагаар дамжуулан тухайн улсын зохих байгууллагад хандаж болно. Мөн 39.3-т зааснаар энэ хуулийн 39.1-д заасан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний тусламжтайгаар нотлох баримт бүрдүүлж авсан бол хуулийн 80.3-т зааснаар хэргийн оролцогчийн хүсэлт буюу өөрийн санаачилгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээн явуулах тухай шүүгч захирамж гаргах ба энэ өдрөөс эхлэн хэрэг хянан шийдвэрлэх хугацааг үргэлжлүүлэн тоолно. Хуулийн 80.4-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн шалтгаан шүүгчийн заасан хугацаанд арилаагүй бол шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээж, хэргийг хэрэгсэхгүй болгох захирамж гаргах бөгөөд захирамжид хэргийг шийдвэрлэхэд саад болж байгаа нөхцөл, түүнийг хэрхэн засах талаар тусгана.

Иймд хилийн чанадад нотлох баримт бүрдүүлэх ажиллагааг ямар хугацаанд биелүүлэх талаар иргэний хэргийн асуудлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хоёр талт олон улсын гэрээнд тодорхой зохицуулаагүй тул шүүхээс хуулийн 39.3-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхдээ хэргийн оролцогчдын эрх ашгийг хангах үүднээс хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх хугацааг аль болох урт хугацаагаар буюу нотлох баримт бүрдүүлэхэд хангалттай хугацаа тогтоох нь зүйтэй байна.

Иргэний хэргийн асуудлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хоёр талт олон улсын гэрээ ёсоор нотлох баримтыг гадаадад цуглуулах тухай шүүхийн даалгаварт дараах зүйлийг тусгана. Үүнд:

⁴²⁹ Монгол Улсын дээд шүүх. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. Улаанбаатар. 2014. 125 дахь тал

- Даалгаврыг хүлээн авагч эрх бүхий байгууллагын нэр;
- Хэрэв хүсэлт гаргагч байгууллагад тодорхой мэдэгдэж байгаа бол хүсэлтийг хүлээн авагч байгууллагын нэр;
- Талуудын болон тэдгээрийн төлөөлөгчдийн нэр, хаяг;
- Шүүх ажиллагаанд шаардлагатай нотлох баримт, даалгаврыг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл, хүлээж авах шаардлагатай нотлох баримт;
- Гүйцэтгэх шаардлагатай бусад процесс ажиллагаа.⁴³⁰

Хэрэв хүсэлтийг хүлээн авагч байгууллага нь уг даалгаврыг гүйцэтгэх эрх бүхий байгууллага биш бол зохих эрх бүхий байгууллагад даалгаврыг шилжүүлж, энэ тухайгаа хүсэлт гаргагч байгууллагад мэдэгдэнэ.

Иргэний хэргийн асуудлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хоёр талт олон улсын гэрээнд даалгаврыг хүлээн авах, явуулах асуудлаар харилцах эрх бүхий төв байгууллага нь ихэвчлэн Улсын дээд шүүх, Хууль зүйн яам байна. Энэ талаар Хавсралт №2 буюу “Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу харилцах эрх бүхий төв байгууллагын жагсаалт”-аас танилцана уу.

1954 оны Гаагийн конвенц ёсоор нотлох баримт бүрдүүлэх асуудал нь шүүхийн даалгаврын хүрээнд зохицуулагддаг. Тодруулбал, тус конвенцын “Шүүхийн даалгавар” гэсэн 2 дахь хэсэг, 8-16 дугаар зүйлийг хилийн чанадад нотлох баримт бүрдүүлэхэд баримтална. Тухайлбал, Монгол Улсын шүүхийн байгууллага нь өөрийн хууль тогтоомжийн дагуу хэлэлцэн тохирогч нөгөө улсын холбогдох эрх бүхий байгууллагад хандан иргэний буюу худалдааны хэргийн талаар өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд нотлох баримт бүрдүүлэх хүсэлт бүхий шүүхийн даалгавар гаргаж болно. Энэхүү шүүхийн даалгаврыг Монгол Улсын консул хүсэлт хүлээн авагч улсын тогтоож өгсөн эрх бүхий байгууллагад дамжуулна. Эдгээр эрх бүхий байгууллага нь шүүхийн даалгаврыг биелүүлснийг нотолсон буюу түүнийг биелүүлж чадаагүй шалтгааныг тайлбарласан баримт бичгийг консулд илгээнэ. Ийнхүү дамжуулах үед гарч болзошгүй аливаа бэрхшээлийг дипломат шугамаар шийдвэрлэнэ.

Хилийн чанадад нотлох баримт цуглуулах асуудлаар 1954 оны Гаагийн конвенцыг өргөжүүлж, тус асуудлыг тусгайлан зохицуулсан конвенц бол 1970 оны “Иргэний буюу худалдааны асуудлаарх хилийн чанад дахь нотлох баримтыг гаргуулан авах тухай” Гаагийн конвенц юм. Тус конвенц нь 42 зүйлтэй бөгөөд 3 хэсэгтэй. Үүнд 1/ Хүсэлт гаргах (1-14 дүгээр зүйл), 2/ Нотлох баримтыг дипломат ажилтан, консулын төлөөлөгч болон комиссын гишүүнээр дамжуулан бүрдүүлэх (15-22 дугаар зүйл), 3/ Ерөнхий заалтууд (23-42 дугаар зүйл) хамаарна.

2015.12.16-ны байдлаар тус конвенц нийт 58 оролцогч улстай байх бөгөөд иргэн, худалдааны асуудлаар хилийн чанадаас нотлох баримт гаргуулан авахад хамтран ажиллах арга замын тусгасан. Тодруулбал, конвенцын гишүүн улсууд хоорондоо нотлох баримтыг хүсэлт гаргах болон дипломат, консулын төлөөлөгч, комиссараар дамжуулан авч болохоор заасан. Тус конвенц нь нотлох баримт гаргуулан авах асуудлаар эх газрын эрх зүйн бүл болон Англи-Саксоны эрх зүйн

⁴³⁰ Хууль зүй, дотоод хэргийн яам. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх нь (хуульчдад зориулсан гарын авлага). Улаанбаатар. 2009. 16-18 дахь тал

бүлийн хооронд гардаг ялгаатай асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй аргыг тусгаснаараа ач холбогдолтой юм.⁴³¹

Дөрөв. Шүүхийн үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох

Эрх зүйн туслалцааны гэрээ зэрэг олон улсын иргэний процессын эрх зүйд нэг улсын иргэд нөгөө улсын нутаг дэвсгэрт хувийн болон эд хөрөнгийн эрхийнхээ хувьд өөрийнх нь иргэдийн адил хамгаалалт эдлэх талаар заасан байдаг. Үүнд чөлөөтэй, саад тотгоргүйгээр хууль, шүүхийн байгууллагад хандах эрх хамаардаг.⁴³²

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1-т Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэж заасан. Мөн ИХШХШТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1-т хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явагдана гэж заасан.

Мөн Монгол Улсын хоёр талт олон улсын гэрээнд шүүхийн үйл ажиллагаанд тэгш оролцох талаар тусгасан байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Турк Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /2000.05.02/-ний 16 дугаар зүйлийн 1-т зааснаар хэлэлцэн тохирогч нэг талын иргэн хэлэлцэн тохирогч нөгөө талын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөгдөх, эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах эрхийг тухайн улсын иргэний нэгэн адил эдэлнэ.

Энэхүү шүүхийн өмнө эрх тэгш байх буюу олон улсын иргэний процессын үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох талаарх зохицуулалтыг “Шүүхийн үйл ажиллагаанд тэгш оролцох тухай” 1980 оны Гаагийн конвенцод тусгасан.⁴³³ Тус конвенц нь 1988.05.01-ний өдөр хүчин төгөлдөр болж үйлчилсэн бөгөөд 2015.02.17-ны өдрийн байдлаар 27 оролцогч улстай. Тус конвенцын зорилго нь гадаадын иргэн, тухайн улсад оршин суугч биш гэсэн үндэслэлээр ялгаварлан гадуурхахгүйгээр иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш оролцох эрхийг хангах юм.

Конвенц нь 1965 оны болон 1970 оны Гаагийн конвенцын нэмэлт шинжтэй бөгөөд 6 хэсэг, 36 зүйлтэй. Үүнд 1/ Эрх зүйн тусламж (1-13 дугаар зүйл), 2/ Шүүхийн зардал, хураамжийн баталгаа (14-17 дугаар зүйл), 3/ Шийдвэр, тэмдэглэлийн хуулбар (18 дугаар зүйл), 4/ Саатуулах ба шийдвэрийн биелэлтийн баталгаажуулах (19-20 дугаар зүйл), 5/ Ерөнхий заалтууд (21-30 дугаар зүйл), 6/ Төгсгөлийн заалтууд (31-36 дугаар зүйл) хамаарна.

⁴³¹ Outline of the Hague Convention of 18 March 1970 on the Taking of Evidence Abroad in Civil or Commercial Matters <https://assets.hcch.net/docs/ec1fc148-c2b1-49dc-ba2f-65f45cb2b2d3.pdf>

⁴³² М.М.Богуславский. Олон улсын хувийн эрх зүй (сурах бичиг). 5 дахь хэвлэл. Редактор Ж.Амарсанаа, эрхэлсэн М.Мөнхбат. Улаанбаатар. 2008. 336 дахь тал

⁴³³ Convention of 25 October 1980 on International Access to Justice <https://www.hcch.net/en/instruments/conventions/full-text/?cid=91>

Энэ конвенцод заасан шүүхийн зардал, төлбөр болон баримт бичгийн орчуулгатай холбоотой асуудлыг 1954 оны Гаагийн конвенцод хэрхэн зохицуулсныг дараах дэд хэсэгт авч үзье.

4.1. Шүүхийн зардал, эрх зүйн туслалцааны төлбөр

1954 оны Гаагийн конвенцын 16 дугаар зүйлд зааснаар шүүхийн даалгавар гүйцэтгэх нь аливаа хураамж буюу шимтгэл авах шалтаг болох ёсгүй. Гэхдээ өөр журам тогтоосон хэлэлцээр байхгүй бол хүсэлт хүлээн авагч улс нь хүсэлт гаргагч улсаас гэрч буюу шинжээчид төлсөн мөнгө, түүнчлэн хэрэв гэрч шүүхэд сайн дураар ирээгүй бол шүүхийн тогтоол гүйцэтгэгчийн заавар ёсоор албадлагын арга хэмжээ авсантай холбогдон гарсан шүүхийн зардал, мөн 14 дүгээр зүйлийн хоёр дахь хэсгийг хэрэглэсэнтэй холбогдон үүсч болох зардлыг шаардах эрхтэй.⁴³⁴ Тодруулбал, конвенцод зааснаар шүүхийн зардалд дараах зүйл орно. Үүнд:

- гэрч буюу шинжээчид төлсөн мөнгө
- гэрчийг ирүүлэх албадлагын арга хэмжээ авсантай холбогдон гарсан зардал
- шүүхийн даалгаврыг гүйцэтгэхтэй холбогдон гарсан бусад зардал.

1954 оны Гаагийн конвенцын III бүлэгт шүүхийн зардал төлүүлэх шийдвэрийг биелүүлэх талаар тусгасан байх тул шүүхийн зардал төлүүлэх тухай гадаад улсын шийдвэрийг албадан гүйцэтгэх асуудлыг шүүхүүд Монгол Улс тухайн гадаад улстай хоёр талт гэрээ байгуулсан эсэхээс үл хамааран Конвенцын заалтыг баримтлан шийдвэрлэнэ.⁴³⁵

Монгол Улсын ИХШХШТХ-ийн 5 дугаар бүлэгт шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийн талаар зохицуулсан.⁴³⁶ Мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.10-т зааснаар шүүхээс нотлох баримтыг бүрдүүлэх явцад гарсан зардлыг шүүхийн зардалд тооцно. Тус хуулийн 52 дугаар зүйлийн 52.2-т зааснаар шүүхийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Энэ заалт нь 1954 оны Гаагийн конвенцод заасан зардлыг улсын төсвөөс гаргахад хэрэглэгдэж болох юм. Харин шүүхээс буюу улсын төсвөөс гаргасан дараах зардлыг зохигчоор нөхөн төлүүлэх асуудлыг тус хуулийн 53 дугаар зүйлд тусгасан. Үүнд:

- шинжээч, орчуулагч, хэлмэрчийн тээвэр, байр, хоолны зардал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар гүйцэтгэсэн ажил үүрэгт ажилд нь хамаарахгүй бол ажлын хөлс;
- гэрчийн тээвэр, байр, хоолны зардал, цалин, хөдөлмөрийн хөлс;
- үзлэг хийх, туршилт явуулах, таньж олуулах ажиллагаа явуулахад гарсан зардал;
- эд мөрийн баримт хадгалах зардал;

⁴³⁴ Конвенцын 14 дүгээр зүйлд зааснаар шүүхийн даалгаврыг гүйцэтгэж буй шүүхийн байгууллага нь зохих ёс журмыг дагахдаа өөрийн улсын хууль тогтоомжийг баримтална. Харин хүсэлт гаргагч засаг захиргааны эрх бүхий байгууллага онцгой хэлбэр баримтлахыг хүссэн тохиолдолд ийм хүсэлтийг уг заасан хэлбэр нь хүсэлт хүлээн авагч улсын хууль тогтоомжид харшлахгүй нөхцөлд биелүүлнэ.

⁴³⁵ Монгол Улсын Дээд шүүхийн 2008.02.28-ны өдрийн “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” 09 дүгээр тогтоолын 12 дахь заалтаас <http://legalinfo.mn/law/details/307?lawid=307>

⁴³⁶ ИХШХШТХ-ийн 52.1-т зааснаар шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг шүүхийн зардал гэнэ.

- гэрчийн мэдүүлгийг очиж авсан зардал.

Нөхөн төлөх зардлын хэмжээг “шүүхээс төлсөн хэмжээгээр”, “гүйцэтгэлийн баримтад заасан хэмжээгээр” гаргах талаар ИХШХШТ хуулийн 54 дүгээр зүйлд зааснаас харахад Конвенцод заасан зардлыг Монгол Улсын хувьд зохигчоос бүрэн гаргуулах боломжтой байх тул зардал гарах шалтгаанаар гадаад улсад шүүхийн даалгавар гаргахаас зайлсхийх нь зохимжгүй байна.

4.2. Шүүхийн болон шүүхийн бус баримт бичгийн орчуулга

1954 оны Гаагийн конвенцод шүүхийн болон шүүхийн бус баримт бичгийн орчуулгатай холбоотой асуудлыг тусгасан. Тухайлбал, иргэний болон худалдааны хэргийн талаарх баримт бичгийг хилийн чанадад буй этгээдэд хүсэлт гаргасан улсын хүсэлтээр гардуулах бөгөөд уг хүсэлтийг хүлээн авах засаг захиргааны байгууллагын хэл дээр үйлдсэн байх ёстой. Гэхдээ энэ нь хоёр улсын засаг захиргааны холбогдох байгууллага хоорондоо шууд харилцахад саад болохгүй. Мөн шүүхийн даалгаврыг өөр журам тогтоосон хэлэлцээр байхгүй тохиолдолд хүсэлт хүлээн авагч засаг захиргааны байгууллагын хэлээр буюу сонирхогч хоёр улсын тохиролцсон хэл дээр үйлдсэн, эсхүл дээр дурдсан хоёр хэлний аль нэг дээр үйлдсэн бөгөөд хүсэлт гаргагч улсын дипломат буюу консулын төлөөлөгч, эсхүл хүсэлт хүлээн авагч улсын баталгаат орчуулагчийн гэрчилсэн орчуулгыг түүнд хавсаргасан байна.

Эндээс харахад шүүхийн болон шүүхийн бус баримт бичгийг дараах хэл дээр үйлдэж болохоор байна. Үүнд:

- Баримт бичиг хүлээн авах улсын хэл дээр үйлдэх
- Баримт бичиг илгээх улсын хэл дээр үйлдэх /хоёр улс урьдчилан тохиролцсон байх шаардлагатай/
- Баримт бичгийг гуравдагч улсын хэл дээр үйлдэх /хоёр улс урьдчилан тохиролцсон байх шаардлагатай/

*Жишээ. Монгол Улсын шүүхээс ХБНГУ-ын шүүхэд Монгол Улсаас Берлин хотод суугаа элчин сайдын яамаар дамжуулан шүүхийн даалгавар хүргүүлсэн. Тус даалгавар болон түүний хавсралт баримт бичгүүдийг монгол хэл дээр үйлдсэн бөгөөд түүнийг ЭСЯ-наас герман хэл дээр орчуулжээ.*⁴³⁷

Дээр дурдсан жишээн дээр хоёр улс урьдчилан тохиролцсон тохиолдолд Монгол Улсын шүүхээс холбогдох баримт бичгийг англи хэл дээр үйлдэх, түүнийг ХБНГУ-ын шүүх зөвшөөрөх боломжтой байна.

Хоёр талт олон улсын гэрээнд баримт бичгийн орчуулга, харилцах хэлний талаар мөн зохицуулсан байдаг. Тухайлбал, Монгол Улс Бүгд Найрамдах Солонгос Улстай байгуулсан иргэний болон худалдааны хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /2008.10.15/-ний 7 дугаар зүйлийн 1-т зааснаар

⁴³⁷ Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын мэдээлэл
http://www.mfa.gov.mn/?page_id=26036

Монгол Улсаас хүсэлт гаргах тохиолдолд хүсэлт болон түүнийг дагалдах баримт бичгүүдийг хүсэлт гаргагч талын хэл буюу монгол хэлээр үйлдэх бөгөөд уг хүсэлтэд хүлээн авагч талын буюу БНСУ-ын албан ёсны хэл, эсхүл англи хэлээр орчуулгыг хавсаргана.

Тав. Гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх, татгалзах

5.1. Гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх

Гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх гэдэгт гадаад улсын шүүхийн шийдвэр нь тухайн улсын шүүхийн шийдвэртэй ижил түвшинд иргэний болон бусад эрх, үүргийн баталгаа болж байгааг ойлгоно. Тухайлбал, гадаад улсад гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргасан бол түүнийг биелүүлэх бус хүлээн зөвшөөрөх асуудал яригдана. Гадаадын шүүхийн шийдвэрийг биелүүлэхийн өмнөх нөхцөл нь дотоодын шүүхийн шийдвэрийн талаар харилцан адил байх явдал гэж судлаачид тэмдэглэсэн байдаг.⁴³⁸

Жишээ. Монгол Улсын иргэн “А” нь ОХУ-ын иргэн “Б”-тэй гэрлэн амьдарч байсан бөгөөд Б нь ОХУ-д амьдарч, гэр бүлийн харилцаагүй болсон тул А нь гэрлэлтээ цуцлуулах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах асуудлаар Монгол Улсын шүүхэд хандаж, тус улсын шүүхээс гэрлэлт цуцлах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гаргасан байна. Монгол Улсын шүүхээс тус шийдвэрийг хүлээн зөвшөөрүүлэх хүсэлтэд шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудсыг хавсарган Улсын дээд шүүхээр дамжуулан ОХУ-ын Дээд шүүхэд гаргажээ.

ИХШХШТХ-ийн 194 дүгээр зүйлийн 194.1-т зааснаар Монгол Улсын шүүхийн болон гадаад улсын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх журам нь Монгол Улсын хууль тогтоомж, гадаад улстай байгуулсан буюу Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр тодорхойлогдоно.⁴³⁹ Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1-т зааснаар Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гадаад улсын шүүх, арбитрын шийдвэрийг гүйцэтгэх журмыг энэ хууль, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлно.⁴⁴⁰

Тодруулбал, гадаад улсын шүүхийн болон арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх асуудлыг дотоодын хууль тогтоомжид нарийвчлан зохицуулаагүй бөгөөд Монгол Улсын олон улсын гэрээгээр зохицуулахаар тусгасан байна.⁴⁴¹

⁴³⁸ М.М.Богуславский. Олон улсын хувийн эрх зүй (сурах бичиг). 5 дахь хэвлэл. Редактор Ж.Амарсанаа, эрхэлсэн М.Мөнхбат. Улаанбаатар. 2008. 351 дэх тал

⁴³⁹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002. Төрийн мэдээлэл. 2002 он, №8

⁴⁴⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2002.

⁴⁴¹ Гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх гэж гадаадын шүүхийн шийдвэр Монголын шүүхийн шийдвэрийн нэгэнд адил хуулийн хүчин төгөлдөр гэдгийг хүлээн зөвшөөрөхийг хэлнэ. Хууль зүй, дотоод хэргийн яам. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх нь (хуульчдад зориулсан гарын авлага). Улаанбаатар. 2009. 33 дахь тал

Иргэний хэргийн асуудлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх Монгол Улсын хоёр талт олон улсын ихэнх гэрээнд гэрээний нөгөө талын шүүхийн болон арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх талаар тодорхой бүлэг болгон зохицуулсан. Монгол Улсаас бусад улстай байгуулсан эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээнд шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс татгалзах үндэслэлийг заасан байдаг.⁴⁴² Харин 2008.10.15-ны өдөр байгуулсан “Иргэний болон худалдааны хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд найрамдах Солонгос улс хоорондын гэрээ”-нд шүүхийн болон арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх асуудлыг зохицуулаагүй байна.⁴⁴³

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх асуудлыг Монгол Улс тухайн гадаад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээний заалт болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2., ИХШХШТХ-ийн 18 дугаар бүлэгт зааснаар шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай эрх бүхий этгээдийн хүсэлтээр шийдвэрлэнэ. Монгол Улс тухайн гадаад улстай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулаагүй, эсхүл уг гэрээнд шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай асуудлыг тусгаагүй бол гадаад улсын шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа явуулах асуудлыг шүүх шийдвэрлэхгүй.

Гадаад улсын шүүхийн шийдвэр гэдэгт тухайн маргаантай асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг ойлгоно. Албадан гүйцэтгүүлэх шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болсон, шийдвэрийн үнэн зөв байдал нь түүнийг гаргасан шүүхээр баталгаажсан, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг тухайн шүүх зөвшөөрөн дэмжиж байгаа, шийдвэрийн эх албан ёсоор орчуулагдсан, зохих журмын дагуу ирүүлсэн байх шаардлагатай.

Жишээ. “Х” улсын хөрөнгө оруулалттай А компани болон Монгол Улсын Засгийн газрын хооронд гарсан маргааныг Нидерланд улсын Гааг хотноо байрлах байнгын ажиллагаатай Арбитрын шүүхээс хянан шийдвэрлэж Монгол Улсын Засгийн газрын талд шийдвэр гаргажээ. Тус шийдвэрийг “Х” улсад биелүүлэх нөхцөлтэй байсан бөгөөд А компани нь арбитрын шийдвэрийг сайн дураар биелүүлэхээс татгалзжээ. Х болон Монгол Улс нь Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай 1958 оны Конвенцын оролцогчид. Монгол Улсын Засгийн газраас Х улсын шүүхэд хандан арбитрын шийдвэрийг биелүүлэх тухай хүсэлт гаргасан бөгөөд хүсэлтдээ арбитрын шийдвэрийн баталгаажуулсан хуулбар, арбитрын хэлэлцээр, эдгээр баримт бичгийг Х улсын хэлээр орчуулсан баримтыг хавсаргажээ. Х улсын шүүх нь Монгол Улсын засгийн газрын хүсэлтийг хүлээн авч арбитрын шийдвэрийг заавал биелүүлэх хүчинтэйд тооцож,

⁴⁴² Тухайлбал, Монгол Улс ба БНХАУ-ын байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний 18 дугаар зүйлд шүүхийн шийдвэр хүлээн зөвшөөрөхөөс болон биелүүлэхээс татгалзах үндэслэлийг тусгасан. Ж.Оюунтунгалаг, С.Өмирбек нар. Олон улсын иргэний эрх зүйн гэрээ (гарын авлага). “Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах төсөл”. Улаанбаатар. 2013. 53 дахь тал

⁴⁴³ Олон улсын хувийн эрх зүй-баримт бичгийн эмхтгэл (гурав дахь хэвлэл). Бэлтгэсэн Э.Байгал, Т.Замбага, редактор академич Ж.Амарсанаа. Улаанбаатар. 2014. 391-397 дахь тал

*өөрийн улсын тогтоосон журмын дагуу албадан биелүүлэхээр шийдвэрлэжээ.*⁴⁴⁴

Арбитрын шийдвэр эцсийн бөгөөд заавал биелэгдэх шинжтэй байна. Талууд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар гүйцэтгүүлнэ.⁴⁴⁵ Гадаадын арбитр буюу арбитрын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх тухай хүсэлтийг Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай 1958 оны Конвенцын зүйл, заалтын дагуу ИХШХШТХ-ийн 18 дугаар бүлэгт зааснаар шүүхүүд шийдвэрлэнэ.⁴⁴⁶

Гадаад улсын шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэснээр Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулж болзошгүй, Монгол улсын нийтийн эрх зүйн дүрэмд харш, эсхүл зохигчдын хоорондох тухайн маргааныг Монгол Улсын шүүх хянан шийдвэрлэж, шүүхийн хүчин төгөлдөр өөр шийдвэр гарсан, эсхүл иргэний хэрэг үүсгэгдэн, хянан хэлэлцэгдэж байгаа, тухайн хэрэг Монгол Улсын шүүхийн онцгой харьяалалд хамаардаг, эсхүл гадаад улсын шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болоогүй буюу хүчин төгөлдөр болсон эсэх нь тодорхой бус, шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх талаар шаардлага тавих хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн бөгөөд энэ хугацаа сэргээгдээгүй зэрэг нөхцөл байдал тогтоогдвол гадаад улсын шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай сонирхогч этгээдийн хүсэлтийг шүүх хангахаас татгалзаж, энэ талаарх үндэслэлийг шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд тодорхой заана.⁴⁴⁷

5.2. Шүүхийн даалгавар биелүүлэхээс татгалзах

Өмнөх хэсэгт шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх талаар авч үзсэн. Гэхдээ иргэний хэргийн асуудлаарх эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх ажиллагаанд шүүхийн даалгаврыг биелүүлэхээс татгалзах асуудал үүсдэг. Энэ асуудлыг олон улсын гэрээнүүдэд зохицуулсан байдаг. Тухайлбал, 1954 оны Гаагийн конвенцод шүүхийн даалгаврыг гүйцэтгэхээс татгалзах нөхцөлийг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

- баримт бичгийн үнэн зөв байдлыг тогтоогоогүй бол;

⁴⁴⁴ Нидерланд улсын Гаг хотноо байрлах Арбитрын шүүхээс хянан хэлэлцэж буй Монгол Улсын засгийн газарт холбогдох арбитрын маргаанд тулгуурлан зохиов. <http://www.pcacases.com/web/view/48>

⁴⁴⁵ ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төв. Процессын эрх зүйн толь (гарын авлага). Улаанбаатар хот. 2014. 29 дэх тал

⁴⁴⁶ Монгол Улс 1958.06.10-ны өдөр Нью-Йорк хотноо байгуулсан “Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай” конвенцод 1994.10.24-ны өдөр нэгдэн орсон бөгөөд 1995.01.22-ны өдрөөс тус конвенцыг Монгол Улс дагаж мөрдсөн.

http://www.uncitral.org/uncitral/en/uncitral_texts/arbitration/NYConvention_status.html

Олон улсын хувийн эрх зүй-баримт бичгийн эмхтгэл (гуравдахь хэвлэл). Бэлтгэсэн Э.Байгал, Т.Замбага, редактор академич Ж.Амарсанаа. Улаанбаатар. 2014. 178-181 дэх тал; “Төрийн мэдээл” эмхтгэлийн тусгай дугаар. №2; Convention on the Recognition and Enforcement of Foreign Arbitral Awards (New York, 1958)

<http://www.uncitral.org/pdf/english/texts/arbitration/NY-conv/New-York-Convention-E.pdf>

⁴⁴⁷ Монгол Улсын Дээд шүүхийн 2008.02.28-ны өдрийн “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” 09 дүгээр тогтоолын 12 дахь заалтаас <http://legalinfo.mn/law/details/307?lawid=307>

- хүсэлт хүлээн авагч улсын шүүх эрх мэдлийн хүрээнд шүүхийн даалгаврыг биелүүлэх ажиллагаа ордоггүй бол;
- нутаг дэвсгэрт нь шүүхийн даалгавар гүйцэтгэх ёстой улс шүүхийн даалгаврыг биелүүлэх нь түүний бүрэн эрх, аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй гэж үзвэл.

Энэ тохиолдолд хүсэлт хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага шүүхийн даалгаврыг биелүүлээгүй бүх тохиолдолд хүсэлт гаргасан эрх бүхий байгууллагад энэ тухайгаа нэн даруй мэдэгдэх бөгөөд шүүхийн даалгаврыг гүйцэтгэхээс татгалзсан шалтгааны талаар болон шүүхийн даалгаврыг шилжүүлсэн байгууллагыг зааж дурдана.

Мөн хоёр талт олон улсын гэрээнд тус асуудлыг зохицуулдаг. Тухайлбал, Бүгд Найрамдах Солонгос Улстай байгуулсан иргэний болон худалдааны хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /2008.10.15/-ний 5 дугаар зүйлд шүүхийн туслалцаа үзүүлэхээс татгалзах талаар дараах байдлаар зохицуулсан. Үүнд:

- хэрэв шүүхийн туслалцаа хүссэн хүсэлт нь Хүлээн авагч талын тусгаар тогтнол, аюулгүй байдал, нийгмийн дэг журамд аюул учруулахуйц, эсхүл тухайн хүсэлт нь шүүхийн байгууллагын үндсэн чиг үүрэгт хамаарахгүй гэж үзвэл шүүхийн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болох бөгөөд татгалзах болсон шалтгаанаа хүсэлт гаргагч талд мэдэгдэнэ;
- шүүхийн баримт бичиг гардуулах, гэрчийн мэдүүлэг авах асуудлаар шүүхийн туслалцаа хүссэн хүсэлтийг зөвхөн хүсэлт хүлээн авагч талын шүүх нь нэхэмжлэлд тусгагдсан асуудлаар шүүхийн онцгой харъяалал эдэлдэг, эсхүл хүсэлт гаргасан нэхэмжлэлийг дотоодын хуулийн дагуу зөвшөөрөхгүй гэсэн үндэслэлээр хүсэлт хүлээн авагч тал хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж болохгүй.

Монгол Улсад 2009 онд гадаад орны шүүх, хууль хяналтын байгууллагаас 51 шүүхийн даалгавар ирүүлсэн байна. Үүнд ОХУ-17, Казахстан-2, БНСУ-25, Чех-3, Польш-2, ХБНГУ-2, Франц-2, Турк-1, Австри-2, Унгар-1, Лаос-1, Филиппин-1 шүүхийн даалгавар ирүүлжээ.⁴⁴⁸ Харин Хууль зүйн яамны мэдээгээр Монгол Улсад 2013 онд 8 орны 72 орчим шүүхийн даалгаврыг хүлээн авч, холбогдох ажиллагааг хийсэн байна.⁴⁴⁹ Нэг сарын хугацаанд дунджаар 5 шүүхийн даалгавар ирж байна.⁴⁵⁰ 2015 оны 10 дугаар сард гэхэд Хууль зүйн яамнаас шүүхийн 2 даалгаварт хариу хүргүүлжээ.⁴⁵¹ Энэ нь гадаад улсаас шүүхийн даалгавар ирүүлэх явдал нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна.

⁴⁴⁸ Э.Байгал. Олон улсын хувийн эрх зүй /анхны хэвлэл/. Улаанбаатар. 2012. 276 дахь тал

⁴⁴⁹ Хууль зүйн яамны 2013 оны үйл ажиллагааны товч тайлан

⁴⁵⁰ Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас бэлтгэсэн Яамдын 2002 оны 3 дугаар сард хийж гүйцэтгэсэн ажлын товч мэдээлэлд дурдсанаар Хууль зүйн яам нь ОХУ, БНХАУ-ын Хууль зүйн яамнаас ирүүлсэн 5 шүүхийн даалгавар, иргэд хөдөлмөрчдөөс ирүүлсэн 8 өргөдөл, гомдлыг ОХУ, БНСУ, Чех Улсын Хууль зүйн яаманд уламжилж, шаардлагатай арга хэмжээ авахуулахаар хүргүүлжээ.

⁴⁵¹ Хууль зүйн яамны үйл ажиллагааны 2015 оны 10 дугаар сарын ажлын мэдээ

Энэ нөхцөл байдал нь Монгол Улсад ирсэн шүүхийн даалгаврыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс гадна түүнийг биелүүлэхээс татгалзах нөхцөл ямар байхыг тодруулах шаардлага бий болгож байна.

1954 оны Гаагийн конвенцын 11 дүгээр зүйлд зааснаар шүүхийн даалгаврыг гүйцэтгэхээс зөвхөн дор дурдсан тохиолдолд татгалзаж болно:

- Хэрэв баримт бичиг нь жинхэнэ гэдэг нь тогтоогдоогүй;
- Хэрэв хүсэлт хүлээн авагч улсад шүүхийн даалгаврыг биелүүлэх нь шүүхийн байгууллагын мэдэлд ордоггүй;
- Хэрэв нутаг дэвсгэр дээр нь шүүхийн даалгавар гүйцэтгэгдэх ёстой улс шүүхийн даалгаврыг биелүүлэх явдал нь бүрэн эрх буюу аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй гэж үзвэл.⁴⁵²

Шүүхийн даалгаврыг хүлээж авсан шүүхийн байгууллага нь уг даалгаврыг гүйцэтгэхдээ хүсэлт хүлээн авагч улсын засаг захиргааны байгууллага буюу сонирхогч талуудын хэрэглэдэг бүхий л зөвшөөрөгдсөн албадлагын арга хэрэгслийг ашиглан биелүүлэх үүрэгтэй хэдий ч дээр дурдсан тохиолдлоор шүүхийн даалгаврыг гүйцэтгэхээс татгалзах тохиолдолд татгалзсан шалтгааныг зааж хүсэлт гаргасан засаг захиргааны байгууллагад энэ тухайгаа нэн даруй мэдэгдэнэ.⁴⁵³

Үүнийг шүүхийн ачааллыг багасгах буюу конвенцоор хүлээсэн үүргийг биелүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзах нөхцөл болгох ёсгүй бөгөөд шүүхийн даалгаврыг гүйцэтгэхээс татгалзах шалтгааныг бүрэн, зохих үндэслэлтэй гаргасан байхад анхаарах шаардлагатай юм.

Дүгнэлт

Монгол Улсын иргэд гадаадын улсад, гадаадын иргэдээс Монгол Улсад зорчих, оршин суух, улмаар иргэний эрх зүйн харилцаанд орох явдал нэмэгдсээр байна. Монгол Улс НҮБ-ын 193 улсаас 172 улстай дипломат харилцаатай байх бөгөөд дипломат шугамаар бусад улстай иргэний эрх зүйн асуудлаар харилцах нь цаг хугацааны хувьд удаашралтайгаас гадна шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх ажиллагааг явуулахад зохимжгүй байна.

Монгол Улсын олон улсын иргэний процессын эрх зүйн гол эх сурвалжид Монгол Улсаас 17 улстай иргэний хэргийн асуудлаар байгуулсан эрх зүйн туслалцааны гэрээ болон Монгол Улс зэрэг 49 улс нэгдэн орсон 1954 оны Гаагийн конвенц тооцогдож байна. 1954 оны Гаагийн конвенц нь иргэний хэргийн эрх зүйн асуудлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хоёр талт олон улсын гэрээтэй нягт уялдаатай төдийгүй түүнийг нөхөн хэрэглэгдэх шинжтэй байна. Конвенцын гишүүн бөгөөд хоёр талт гэрээний оролцогч улсын хувьд конвенц нь ерөнхий гэрээ болж байна.

1992 оноос өмнө буюу БНМАУ-аас бусад улстай байгуулсан иргэний хэргийн асуудлаарх харилцан туслалцаа үзүүлэх хоёр талт гэрээ нь Үндсэн хуульд харшлаагүй бөгөөд Монгол Улсын олон улсын гэрээний бүрэлдэхүүн болж байна.

⁴⁵² 1954 оны Гаагийн конвенц

⁴⁵³ Конвенцын 12, 13 дугаар зүйлийг харна уу.

Цаашид ямар улстай иргэний хэргийн асуудлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хоёр талт олон улсын гэрээ байгуулахыг шийдвэрлэхдээ Монгол Улсын иргэд ихээр зорчдог буюу суурьшдаг байдлыг харгалзах нь зүйтэй байна.

Монгол Улстай хоёр талт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулаагүй хэдий ч Монгол Улсын иргэн, хуулийн этгээдтэй иргэний эрх зүйн харилцаанд орох улсууд нэмэгдэж байгаа бөгөөд тэдгээр улсын хувьд Гаагийн 1954 оны Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай конвенц, 1965 оны “Иргэний буюу худалдааны асуудлаарх шүүхийн болон шүүхийн бус баримт бичгийг гадаадад хүргүүлэх тухай” конвенц, 1970 оны “Иргэний буюу худалдааны асуудлаарх хилийн чанад дахь нотлох баримтыг гаргуулан авах тухай” конвенцод нэгдсэн байна. Энэ нь эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулаагүй улсуудтай шинээр гэрээ хийхгүйгээр дээрх Гаагийн хоёр конвенцод нэгдэх замаар конвенцын гишүүн орнуудтай иргэний эрх зүйн асуудлаар хамтран ажиллах, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх боломжтой болохыг харуулж байна.

Гадаад улсын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх асуудлыг дотоодын хууль тогтоомжид нарийвчлан зохицуулаагүй бөгөөд үүнд Монгол Улсын олон улсын гэрээ төдийгүй Монгол Улс нэгдэж ороогүй ч олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг төсөөтэй хэрэглэж болохоор байна. Мөн зардал гарах шалтгаанаар гадаад улсад шүүхийн даалгавар гаргахаас зайлсхийх нь зохимжгүй бөгөөд 1954 оны Гаагийн конвенцод зааснаар зардлыг зохигчоос бүрэн гаргуулах боломжтой байна.

Бусад улсаас ирүүлсэн шүүхийн даалгавар нэмэгдэх хандлагатай байх бөгөөд конвенцод заасан үндэслэлээр даалгаврыг гүйцэтгэхээс татгалзаж болох хэдий ч үүнийг шүүхийн ачааллыг багасгах, конвенцоор хүлээсэн үүргийг биелүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзах нөхцөл болгохоос зайлсхийж, шүүхийн даалгаврыг гүйцэтгэхээс татгалзах шалтгааныг бүрэн, зохих үндэслэлтэй гаргасан байхад анхаарах шаардлагатай байна.

Санал, зөвлөмж

Дээр дурдсан судалгааны үр дүнгээр дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын иргэд ихээр зорчдог буюу суурьшдаг, Монгол Улсад ихээр зорчдог буюу тус улсын иргэдтэй иргэний эрх зүйн харилцаанд түгээмэл ордог улс орнуудтай иргэний хэргийн асуудлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хоёр талт олон улсын гэрээ байгуулах;
- Монгол Улс 1965 оны “Иргэний буюу худалдааны асуудлаарх шүүхийн болон шүүхийн бус баримт бичгийг гадаадад хүргүүлэх тухай” Гаагийн конвенц, 1970 оны “Иргэний буюу худалдааны асуудлаарх хилийн чанад дахь нотлох баримтыг гаргуулан авах тухай” Гаагийн конвенцод нэгдэж орох;
- Шүүхээс шүүхийн болон шүүхийн бус баримт бичиг гардуулах, гардан авах болон нотлох баримт бүрдүүлэх асуудлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхдээ хэргийн оролцогчдын эрх ашгийг хангах үүднээс хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхдээ боломжит хугацаа тогтоох,

- Иргэний хэргийн харилцан туслалцаа үзүүлэх болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх асуудлаарх Монгол Улсын олон улсын гэрээг хэрхэн хэрэглэх талаар шүүгч, өмгөөлөгчдөд зориулсан сургалт, мэдээлэл, сурталчилгааг нэмэгдүүлэх. Энэ хүрээнд олон улсын эрх зүйн хэм хэмжээ, хоёр талт олон улсын гэрээ, тэдгээрийг практикт эрх зүйн хэм хэмжээ болгон хэрэглэх шүүхийн практикийг судалж, мэдсэн байхыг шаардах нь зөв юм.
- Гаагийн бага хурлын Байнгын товчооноос эрхлэн гаргасан 1954 оны Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай конвенц, 1965 оны “Иргэний буюу худалдааны асуудлаарх шүүхийн болон шүүхийн бус баримт бичгийг гадаадад хүргүүлэх тухай” Гаагийн конвенц, 1970 оны “Иргэний буюу худалдааны асуудлаарх хилийн чанад дахь нотлох баримтыг гаргуулан авах тухай” Гаагийн конвенцыг хэрхэн хэрэгжүүлэх талаарх зөвлөмж, гарын авлагыг монгол хэл дээр орчуулж, хуульч, шүүгч, хууль хэрэглэгчдийн хүртээл болгох.
- “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдээгүй байгаа Монгол Улсын 1992 оноос өмнө байгуулсан зарим хоёр талт олон улсын гэрээнүүдийг албан ёсоор нийтлэх;
- Иргэний хэргийн асуудлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хоёр талт олон улсын гэрээнд даалгаврыг хүлээн авах, явуулах асуудлаар харилцах эрх бүхий төв байгууллагыг тодорхой болгох. Тухайлбал, 1992 оноос өмнө хуучин тогтолцооны үеэд ашиглаж байсан шүүх, прокурор, улсын нотариатын байгууллагуудын төв байгууллагууд, хуулийн байгууллагууд гэсэн нэршлүүдийг шинэчилж тодорхой болгож, 1992 оноос хойш зохион байгуулалтад орсон байгууллагуудын нэрсийг хэлэлцэн тохирогч улстай шинэчлэн тохирох. Тухайлбал, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, шүүхийн захиргааны дээд байгууллага гэж өөрчлөх эсэхийг шийдвэрлэх.⁴⁵⁴

-оОо-

⁴⁵⁴ Жишээ нь БНСУ-тай байгуулсан эрх зүйн харилцан туслалцааны гэрээнд БНСУ-ын харилцах эрх бүхий төв байгууллага нь Үндэсний шүүхийн захиргаа байх тул Монгол тал нь түүнтэй адил төстэй байгууллага гэдэг утгаараа шүүхийн захиргааны дээд байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөл байж болох юм.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙГ ДАВЖ ЗААЛДАХ, ХЯНАЛТЫН ШАТНЫ ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШИЙДВЭРИЙН ҮНДЭСЛЭЛ, ТӨРӨЛ⁴⁵⁵

Удиртгал

Шүүхийн шийдвэр тогтвортой байх нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал хүчин зүйл байх тул анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр хууль хэрэглээний болон процессын зөрчилгүй нэгдмэл байх, хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх явдлыг нь чухал. 2014 онд ШСМСХ-ээс “Иргэний хэргийг давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн шийдвэрийн үндэслэл, төрөл” судалгааг хийж, танилцуулсан бол 2015 онд захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт орсон, хүчингүй болсон шалтгааныг судаллаа. Судалгааны хүрээнд 2012-2014 онд Улсын дээд шүүхээр хянагдсан захиргааны хэргийн шийдвэр, магадлалыг цуглуулж, анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулсан, хүчингүй болсон шалтгаан, нөхцлийг судалж, дүн шинжилгээ хийн, нийтлэг давтагдаж байгаа процессын зөрчил болон хууль хэрэглээний алдаатай байдлыг илрүүлж цаашид авч хэрэгжүүлэх санал, зөвлөмжийг боловсрууллаа. Энэ судалгаагаар давж заалдах болон хяналтын шатны шүүхээр шийдвэрлэгдэж, аль нэг шатанд нь өөрчлөлт оруулж, хүчингүй болгон шийдвэрлэсэн захиргааны хэргүүдээс сүүлийн 3 жилийн хугацаанд шийдвэрлэгдсэн газар, ашигт малтмал болон үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргааныг сонгон авч судалсан болно.

Шүүхийн шийдвэр, магадлалыг өөрчилсөн, хүчингүй болгосон үндэслэл, процессын зөрчил

1. Газрын маргаан

2012-2014 онд газрын маргаантай холбоотой давж заалдах болон хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэгдэж, аль нэг шатанд нь өөрчлөлт орж, хүчингүй болгон шийдвэрлэсэн 116 маргаан байна. Үүнээс 2012 онд 31 хувь, 2013 онд 26.7 хувь, 2014 онд 42.2 хувь нь хянан шийдвэрлэгдсэн. Эдгээрээс нийт маргааны 40 хувийг хэвээр үлдээж, 17.4 хувьд өөрчлөлт оруулж, 42.2 хувийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. Үүнийг он тус бүрээр нь хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 1. Газрын маргаантай холбоотой шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээсэн, өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон

Он	Хэвээр үлдээсэн	Өөрчлөлт оруулсан	Хүчингүй болгосон
2012	44.4%	19.5%	36.1%
2013	50%	9.7%	48.3%
2014	36.8%	20.4%	42.8%

⁴⁵⁵ Энэ судалгааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх ШСМСХ-ийн судалгаа хариуцсан референт М.Сэлэнгэ, судлаач Ж.Ганзориг болон гэрээт судлаачид Улсын дээд шүүхийн шүүгч П.Соёл-Эрдэнэ, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Д.Баатархүү нар хамтран гүйцэтгэсэн болно.

Судалгаанд хамрагдсан газрын маргаантай хэргийг дотор нь маргааны төрлөөр нь авч үзвэл нийт маргааны 41 хувь нь газар давхардуулан олгосноос үүдэлтэй, 16.1 хувь нь газар эзэмшүүлэх эрхгүй этгээд газар эзэмшүүлснээс үүссэн, 9 хувь нь нийтийн эзэмшлийн газрыг иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлснээс үүссэн, үлдэх 33.9 хувийг тусгай хамгаалалттай, инженерийн шугам сүлжээ бүхий, төмөр замын зурвас зэрэг газар эзэмшүүлсэн, бусдад газар эзэмшүүлэх эрх шилжүүлснээс үүссэн зэрэг маргаан эзэлж байна. Эдгээр маргааны төрлийг дотор нь нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээр нь авч үзвэл нийслэл, дүүргийн Засаг даргаас өмнөх гаргасан захирамжуудаа газрын тухай хууль тогтоомж зөрчсөн гэж үзэн хүчингүй болгосноос үүссэн, кадастрын зураг тодорхойгүйгээс газар давхардуулан олгосонтой холбоотойгоор үүссэн, сум, дүүргийн Засаг дарга нарын гаргасан захирамжийг дээд шатны буюу аймаг, нийслэлийн Засаг дарга хүчингүй болгосонтой холбоотой, нийтийн эзэмшлийн зам талбайд орон сууц, барилга барих зөвшөөрөл олгосон, зөвшөөрлийг цуцалсантай холбоотой, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгогдоогүй байхад дур мэдэн газар ашигласантай холбоотой, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхээ хуулийн дагуу баталгаажуулаагүйгээс тухайн газар дээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос үүдэн гарсан, мөн усны сан бүхий болоод дархан цаазтай газарт тогтоосон дэглэм, журмыг зөрчиж газар олгосонтой холбоотойгоор үүссэн маргаан гэх мэт байсан байна.

Дээрхээс харахад шат шатны Засаг даргын газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх олгосон захирамжийг шинээр томилогдсон буюу дээд шатны Засаг дарга нь хүчингүй болгосонтой холбоотойгоор иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, барилга байгууламж барих, хөрөнгө оруулалт хийх, газрын төлбөрийг төлж байсан зэрэг хохирол учирсан зэрэг маргаан зонхилж байна. Судалгаанаас үзэхэд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг өөрчилж, хүчингүй болгосон байдал шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэнтэй харьцуулахад илүү байгаа нь шүүхүүд газрын маргааныг шийдвэрлэхдээ доорх ялгаатай байдлыг гаргаж байгаатай холбоотой нь ажиглагдлаа.

Хяналтын шатны шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон 49 хэрэг байгаагаас 27 хэргийг анхан шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан нь нийт хүчингүй болсон хэргийн 55.1 хувийг эзэлж байгаа бөгөөд анхаарал татахуйц тоон үзүүлэлт гэж үзэж болохоор байна. Энэ нь анхан шатны шүүх Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүргийг шүүхийн зүгээс биелүүлээгүйтэй холбоотой байна.

Жишээ 1: Хэргийн товч агуулга

Нэхэмжлэгч “С” ХХК-иас Нийслэлийн Засаг дарга болон Баянзүрх дүүргийн Засаг даргад холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2011 оны 115 дугаар захирамж, Баянзүрх дүүргийн Засаг даргын 2008 оны 324 дүгээр захирамжийн иргэн

Г.О-т холбогдох хэсэг, эдгээр захирамжийг үндэслэн олгогдсон газар эзэмшүүлэх гэрээ, гэрчилгээг тус тус хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

1. Шүүхээс шийдвэрлэсэн байдал:

Анхан шатны шүүхээс: Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3, 21.5.3, 31 дүгээр зүйлийн 31.2, 33 дугаар зүйлийн 33.1.2, 33.4, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасныг тус тус баримтлан маргаан бүхий захирамжуудыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хангасан байна.

Давж заалдах шатны шүүхээс: Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.4, 88.3.3 дахь хэсэгт тус тус заасныг баримтлан хэргийг мөн шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан байна.

Хяналтын шатны шүүхээс: Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

2. Шүүхийн шийдвэр, магадлалд хийсэн дүн шинжилгээ:

Нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн эсэхийг тогтооход шаардлагатай нотлох баримт, тухайлбал, нэхэмжлэгчийн эзэмшиж буй газрын кадастрын зураг, нэхэмжлэгч өөрийн эзэмшиж байгаа газартаа барилга барихдаа хаагуур орц, гарцтай байхаар төлөвлөсөн, төлөвлөгөөний дагуу барилга байгууламж баригдсан эсэх, тус компанийн эзэмшил газарт тухайн маргаантай газрын хэсгээр орж гарахаас өөр боломжгүй бол үүнийг нотлох зураг, дүгнэлт зэргийг бүрдүүлэхгүйгээр маргааны үйл баримтад дүгнэлт өгөх боломжгүй гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, шүүх нэхэмжлэгчийн эрх хэрхэн зөрчигдсөнийг тогтоохдоо зөвхөн маргаан бүхий захирамжтай холбоотой нотлох баримтуудыг цуглуулахаас гадна нэхэмжлэгчийн өөрийн эзэмшиж байгаа газар, тухайн газар дээр барьсан барилга байгууламжийн төлөвлөлт, холбогдох баримтуудыг шалган, тогтоож, хэрэгт авалгүйгээр зөвхөн гуравдагч этгээдийн газар эзэмшүүлсэнтэй холбоотой баримтуудад дүгнэлт хийж шийдвэрлэсэн нь хэргийг дахин хэлэлцүүлэх үндэслэл болжээ.

А. Хяналтын шатны шүүхээс нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэхдээ дараах байдлаар дүгнэлт хийсэн нь судалгаанд хамрагдсан хэргүүдэд нийтлэг ажиглагдаж байна. Үүнд, маргаан бүхий захиргааны актыг хүчингүй болгох үндэслэл тогтоогдоогүй байхад анхан шатны шүүх нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн, анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэхдээ үндэслэл тодорхой бус байсан, нэхэмжлэгч маргаан үүсгэх эрхтэй эсэхийг шалгаж тогтоосны үндсэн дээр нэхэмжлэлийн шаардлагыг хангах эсэхийг шийдвэрлэх байсан зэргээс шүүхийн шийдвэр хүчингүй болсон байна.

Б. Хяналтын шатны шүүхээс шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэхдээ дараах байдлаар дүгнэлт хийжээ. Үүнд, нэхэмжлэгчээс нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөн байхад анхны шаардлагын хүрээнд дүгнэлт өгч шийдвэрлэсэн, нэхэмжлэгч өөрийн эрх зөрчигдсөнтэй холбогдуулан хэд хэдэн үндэслэл заасан байхад үндэслэл тус бүрд дүгнэлт өгч, түүнтэй холбоотой нотлох баримтуудыг цуглуулалгүйгээр шийдвэрлэсэн, газар эзэмших хүсэлт шийдвэрлээгүйтэй холбоотой маргааныг шийдвэрлэхдээ

нэхэмжлэгч газар эзэмших хүсэлт хэзээ, хаана гаргаж байсан эсэх, нэхэмжлэгчийн эзэмшихээр хүсэлт гаргасан газар нь маргаж буй газар мөн эсэхийг шалгаж тодруулалгүйгээр шийдвэрлэсэн, нэхэмжлэлд дурдагдсан үндэслэлүүд нь нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолтой хэрхэн холбогдож байгаад дүгнэлт хийгээгүй, нэхэмжлэгч, хариуцагчийн хооронд эрх, үүргийн ямар харилцаа үүссэнийг тодруулалгүйгээр хэргийг шийдвэрлэсэн, хуулийн шаардлага хангаагүй нотлох баримтыг үнэлсэн, нотлох баримтаар тогтоогдоогүй үйл баримтад дүгнэлт хийсэн, хэрэгт авагдсан бичмэл нотлох баримтууд зөрүүтэй байдлаар авагдсан байхад шалгаж тодруулаагүй, нэхэмжлэгчийн эрх зөрчигдсэн талаар зөв дүгнэлт хийсэн атлаа актын биелэлтийг түдгэлзүүлж шийдвэрлэсэн, хэргийн оролцогчийн эрх зүйн байдлыг шалгаж тодруулаагүй гэсэн үндэслэлүүдээр дахин хэлэлцүүлэхээр буцаагдсан байна.

В. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алдааны улмаас хэргийг *дахин хэлэлцүүлэхээр буцаасан* үндэслэлүүдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрчлөгдсөн байхад түүнд хэргийн материалыг танилцуулалгүйгээр хэргийг шийдвэрлэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг шийдвэрлээгүй зэрэг зөрчлүүд гаргаснаас шийдвэр хүчингүй болсон байна.

Г. Хяналтын шатны шүүхээс 2012-2014 онд нийт 49 хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосноос магадлалыг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээсэн 21 хэрэг байгаа бөгөөд давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг дараах байдлаар өөрчилж, хүчингүй болгосон нь буруу болжээ. Үүнд, давж заалдах шатны шүүх хэрэгт ач холбогдолгүй үйл баримтыг шалгаж тогтоох шаардлагагүй байхад шалгаж, тогтоосны дараа дүгнэлт өгөх боломжтой гэсэн үндэслэлээр дахин хэлэлцүүлэхээр буцаасан, түүнчлэн өмнөх газар эзэмшигч, ашиглагчийн үйлдэлд нэхэмжлэгчийг буруутгасан, агуулгын хувьд зөрчилтэй дүгнэлт хийсэн, хэрэгт авагдсан үйл баримтуудаар нэгэнт нотлогдсон байхад хэрэгт ач холбогдолгүй, тухайн хэрэгт хамааралгүй, актын үндэслэлд дурдаагүй баримтыг цуглуулж, дахин шалгуулахаар буцаасан, анхан шатны шүүхээс холбогдох зарим нотлох баримт шаардсан, уг баримт байхгүй талаар шүүхэд мэдэгдсэн байхад дахин тодруулахаар шийдвэрийг хүчингүй болгож, буцаасан нь буруу байснаас магадлал хүчингүй болсон байна.

Газрын маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалд хийсэн судалгаанаас үзэхэд шүүгчид Газрын тухай хууль болон газрын харилцаатай холбоотой бусад хуулиудын агуулгыг буруу ойлгож хэрэглэсэн гэхээс илүүтэй маргааны үйл баримтыг хэрэгт авагдсан нотлох баримтад тулгуурлан хөдөлбөргүй тогтоож, хууль зүйн үндэслэлтэй дүгнэлт хийгээгүйгээс шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангахгүй байдал түлхүү ажиглагдаж байна. Түүнчлэн хяналтын шатны шүүх болон давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрт орсон өөрчлөлтүүдэд тогтоох хэсэгт баримталсан хуулийн нэр, зүйл, заалтыг буруу бичсэн, оновчтой бус хуулийн заалтыг баримталсан, огт хуулийн заалт баримтлаагүй зэрэг алдаа, зөрчил бага байгаа ч дурдалгүй өнгөрч болохгүй юм.

Жишээ 2: Давж заалдах шатны шүүхээс “иргэн О нь эрхийн зөрчилтэй буюу 2 гудамжны уулзвар, зорчих хэсгийг хааж, явган хүний болон автомашины замын зориулалтаар ашиглаж байсан газрыг иргэн Б-гээс худалдан авсан, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авалгүйгээр инженерийн шугам сүлжээн дээр барилга барьсан зэргээр Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.6 дахь хэсгийг⁴⁵⁶ зөрчсөн байна” гэж үзэж нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэснийг хяналтын шатны шүүхээс “маргаан бүхий газар нь явган хүн, автомашины зорчих хэсгийг хязгаарлаагүй, тухайн орчны айл өрхүүд газрын кадастрын зурагт заасан хэмжээ, байрлалд өөрийн хашаагаа татаагүй, тэлж барьснаас зорчих хэсэг нарийссан” гэж үзэж нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, гуравдагч этгээдийн гомдлыг хангасан байна.

Эндээс дүгнэхэд нотлох баримтыг шүүхүүд өөр өөрөөр үнэлсэн, цаашид газрын маргааныг шийдвэрлэхдээ газрын кадастрт хэрхэн дүгнэлт өгөх, шүүх маргаан бүхий газарт үзлэг хийх тогтсон журамтай болох шаардлагатай байна. Тухайлбал одоогийн шүүхийн практикт маргаан бүхий газарт үзлэг хийхдээ зөвхөн зураг авах байдлаар хязгаарласнаас газрын хэмжээ ойлгомжгүй үлддэг. Иймд тухайн орчны байдлыг харуулсан, тухайн газар дээр юу байгаа, ямар инженерийн шугам сүлжээ байгаа, тэдгээрийн хоорондын зай, ямар зүйлтэй хиллэж байгаа, орц гарцыг тодорхой харуулсан хэмжээс бүхий гар зураглал хийдэг нэгдсэн стандарттай болохоос гадна энэ талаар захиргааны хэргийн шүүгчдэд мэргэжлийн талаас нь сургалт явуулж, зохих хэмжээний мэдлэгтэй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Түүнчлэн шүүх маргаж буй газар нь тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан эсэхийг зарим тохиолдолд тодруулах боломж хомс байгаагаас хэрэг шийдвэрлэхэд бэрхшээл учирч байгаа нь цөөнгүй. Учир нь, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд, ялангуяа, гэр хорооллын газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нарийвчлан оруулж өгөөгүйгээс шүүхүүд энэ талаар өөр өөр байдлаар дүгнэлт өгч шийдвэрлэх тохиолдол байна.

2. Ашигт малтмалын маргаан

Давж заалдах болон хяналтын шатны шүүхээр 2012-2014 онд хянан шийдвэрлэгдэж, аль нэг шатанд нь өөрчлөлт орж, хүчингүй болгон шийдвэрлэсэн ашигт малтмалын маргаантай хэргийн тоо 30 байна. Үүнээс 2012 онд 43.3 хувь, 2013 онд 40 хувь, 2014 онд 16.6 хувь нь хянан шийдвэрлэгдсэн. Эдгээрээс нийт маргааны 43.3 хувийг хэвээр үлдээж, 6.6 хувьд өөрчлөлт оруулж, 50 хувийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж буй маргааны дотор ашигт малтмалын маргаан багагүй хувийг эзэлж байгаагаас Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээр харьяаллын хувьд түлхүү шийдвэрлэгдсэн байна.

⁴⁵⁶ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, “Төрийн мэдээлэл” 2002, №27

Хүснэгт 2. Ашигт малтмалтай холбоотой маргаантай холбоотой шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээсэн, өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон

Он	Хэвээр үлдээсэн	Өөрчлөлт оруулсан	Хүчингүй болгосон
2012	38.4%	7.7%	53.9%
2013	41.6%	8.3%	50%
2014	60%	0	40%

Судалгаанд хамрагдсан ашигт малтмалын маргаантай хэргийг дотор нь маргааны төрлөөр нь авч үзвэл нийт маргааны 59 хувь нь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон захиргааны актыг хүчингүй болгуулах, 22 хувь нь ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон захиргааны актыг хүчингүй болгуулах, 7 хувь нь ашигт малтмалын талбайн давхцлын маргаан, 3 хувь нь барьцаанд тавьсан тусгай зөвшөөрөлтэй холбоотой, үлдэх 15 хувийг тусгай хэрэгцээнд авсан газар нутагт тусгай зөвшөөрөл олгосон, тусгай зөвшөөрлийг шилжүүлэхтэй холбоотой захиргааны байгууллагын гаргасан акттай холбоотой маргаан байна. Хүчингүй болсон, өөрчлөлт орсон шийдвэр, магадлалыг судалж үзэхэд шүүхүүд хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн, тухайн харилцаанд хамааралгүй хууль хэрэглэсэн гэсэн үндэслэл дийлэнх хувийг эзэлж байгаагаас гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөнөөс дахин хэлэлцүүлэхээр буцаагдсан хэрэг 11 буюу судалгаанд хамрагдсан хэргийн 36 хувь нь байна.

Жишээ 1: Анхан шатны шүүх маргааны үндэслэл болсон нотлох баримт болох хайгуулын ажлын зардлын хэмжээг газар дээр нь шалгалт хийхдээ баримтжуулсан бичлэгийг хэрэгт хавсаргасан хэдий ч хэргийг хэлэлцэх үед шинжлэн судлалгүйгээр, шийдвэр гаргахдаа уг нотлох баримтыг үнэлж дүгнэсэн, давж заалдах шатны шүүх энэ алдааг анхааралгүй шийдвэрийг хэвээр үлдээсэн зөрчил гаргасан байна. Мөн түүнчлэн хэргийн нөхцөл байдал хангалттай тогтоогдоогүй, хэргийн оролцогчдын тайлбар зөрүүтэй байхад хуульд заасан нотлох үүргээ хэрэгжүүлэлгүйгээр шийдвэрлэсэнээс дахин хэлэлцүүлэхээр буцаагдсан.

Жишээ 2: Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсэгт⁴⁵⁷ “Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл тогтоогдсоноос хойш ажлын 10 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигчид энэ тухай мэдэгдэл өгөх бөгөөд түүнд тусгай зөвшөөрлийг цуцлах болсон үндэслэлийг тодорхой заана” гэж заасан байхад хариуцагч талаас нэхэмжлэгчид мэдэгдээгүй гэж, хариуцагчаас мэдэгдэл хүргүүлсэн боловч хаягтаа байгаагүй гэж маргасан байхад шүүх нэхэмжлэгчийн албан ёсны хаяг өөрчлөгдсөн эсэх, өөрчлөгдсөн бол энэ тухай хариуцагчид мэдэгдсэн эсэх талаар нотлох баримт цуглуулалгүйгээр шийдвэрлэсэн нь буруу гэж хяналтын шатны шүүх үзсэн байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргааны зохих хувийг тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах өргөдөл хүлээж авахгүй байгаа хариуцагчийн буруутай үйл ажиллагааг хууль бус болохыг тогтоолгох маргаан эзэлж

⁴⁵⁷ Ашигт малтмалын тухай хууль, “Төрийн мэдээлэл” 2006, №30

байгаагаас дээрхийн адил нотлох баримт дутуу бүрдүүлснээс дахин хэлэлцүүлэхээр буцаагдсан хэрэг нэлээдгүй гарчээ.

Жишээ 3: Сумын Засаг даргаас байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд баталж өгөөгүйгээс тусгай зөвшөөрөл сунгуулахыг хүссэн өргөдлийг хүлээн авахгүй байгаа, нэхэмжлэгчээс шалтгаалаагүй гэж тайлбарлан маргаж байна. Анхан шатны шүүх Засаг дарга ямар шалтгаанаар төлөвлөгөөг баталж өгөхгүй байсан, нэхэмжлэгч хэдийд Засаг даргад хандсан эсэхийг шалгаж, баримтаар нотолсны үндсэн дээр хэргийг шийдвэрлэх байсан гэж шийдвэрийг хүчингүй болгосон байна.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацааг тогтоохтой холбоотой маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт давж заалдах шатны шүүхээс өөрчлөлт оруулсныг хяналтын шатны шүүхээс хэвээр үлдээжээ.

Жишээ 4: Нэхэмжлэгч “Б” компани ашигт малтмалын хайгуулын 5348Х дугаартай тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацааг тогтоосон акт гаргахыг хариуцагчид даалгуулахыг хүссэн нэхэмжлэлийн шаардлага гаргасан.

Анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэхдээ “тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх боломжит хугацаа тогтоож” шийдвэрлэсэн байна. Харин давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүх үйл баримтад үндэслэлтэй дүгнэлт хийсэн боловч “боломжит хугацаа” гэж хуульд заагаагүй тодорхой бус хугацаа заасан нь буруу гэж үзэж, Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсэгт заасан хугацаагаар тооцох нь зөв гэж өөрчлөлт оруулж шийдвэрлэснийг хяналтын шатны шүүх зөв гэж үзсэн байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлсэнтэй холбоотой маргааны хувьд голдуу шилжүүлэн авч буй хуулийн этгээдийн нэхэмжлэлээр хэрэг үүсгэгдэн хянагдаж байгаа бөгөөд шилжүүлэн өгч байгаа хуулийн этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдээр татан оролцуулсны үндсэн дээр хэргийг шийдвэрлээгүйгээс дахин хэлэлцүүлэхээр буцаасан, мөн хариуцагч төрийн захиргааны байгууллага нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх тохиолдолд хэн нэгэн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөөгүй гэж үзвэл шүүх хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжтой байхад ингэж шийдвэрлээгүйгээс шүүгчийн захирамжийг эргэж хянах тохиолдол гарч байгааг анхаарах шаардлагатай байна.

Хяналтын шатны шүүхээс хууль буруу тайлбарлаж, хэрэглэсэн гэж үзэж магадлалыг хүчингүй болгосон хэргийн хувьд:

Жишээ 5: Хэргийн товч агуулга

Нэхэмжлэгч “Н” ХХК-иас Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн даргад холбогдуулан Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 295 дугаар шийдвэрийн “Н” ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах, тус компанийн тусгай зөвшөөрлийг сэргээлгэхийг хүссэн нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

1. Шүүхээс шийдвэрлэсэн байдал:

Давж заалдах шатны шүүхээс: Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.1-д заасныг баримтлан нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.

Хяналтын шатны шүүхээс: Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

2. Шүүхийн шийдвэр, магадлалд хийсэн дүн шинжилгээ:

Давж заалдах шатны шүүхийн "... хуулиар хориглосон талбайд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулах боломжгүй, нэгэнт нөхөн олговор авах эрхээ алдсан "Н" компанийн тусгай зөвшөөрлийг нөхөн олговор төлөгдсөнтэй адилтган үзэж цуцалсныг буруутгах үндэслэлгүй..." гэж дүгнээд нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосныг хяналтын шатны шүүхээс "Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.3-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговрыг "бүрэн төлсөн" тохиолдолд төрийн захиргааны байгууллага гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт олгогдсон ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг цуцлахаар заасан. Ашигт малтмал хайх, ашиглахыг хуулиар хориглосон талбайд тусгай зөвшөөрөл шударгаар эзэмшиж байгаа этгээдийн хувьд тусгай зөвшөөрөл цуцлагдсан тохиолдолд зөвхөн нөхөн олговор авахаас өөр эрх байхгүй байхад нөхөн олговор авах хүсэлт гаргах хугацаагаар хязгаарлаж, тусгай зөвшөөрлийг цуцалж буй захиргааны байгууллагын үйл ажиллагаа нь нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн" гэж үзсэн байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр төлөх хугацааг "компанийн захирал өвчтэй байснаас төлөх боломжгүй байсан" гэх шалтгааныг дурдаж, тусгай зөвшөөрлөө сэргээлгэх шаардлага бүхий нэхэмжлэл гаргасныг шүүхүүд өөр өөрөөр тайлбарлаж шийдвэрлэснээс үзэхэд хуулийн этгээдийн захирал өвчтэй байх нь хуулийн этгээдээс тусгай зөвшөөрлийн төлбөр төлөхтэй шууд хамааруулан ойлгох эсэх нь эргэлзээтэй. Түүнчлэн хяналтын шатны шүүхээс давж заалдах болон анхан шатны шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсэгт баримталсан хуулийн нэр, зүйл, заалтыг буруу бичсэн, оновчтой бус хуулийн заалтыг баримталсан алдаа, зөрчил гаргасантай холбоотой өөрчлөлтийг оруулсан нь бага биш боловч анхаарахгүй байж болохооргүй юм.

3. Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн маргаан

2012-2014 онд үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн маргаантай холбоотой давж заалдах болон хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэгдэж, давж заалдах болон хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэгдэж, аль нэг шатанд нь өөрчлөлт орж, хүчингүй болгон шийдвэрлэсэн хэргийн тоо 44 байна. Үүнээс 2012 онд 43.1 хувь, 2013 онд 27.2 хувь, 2014 онд 29.5 хувь нь хянан шийдвэрлэгдсэн. Эдгээрээс нийт шийдвэрийн 77.3 хувийг хэвээр үлдээж, 6.8 хувьд өөрчлөлт оруулж, 15.9 хувийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 3. Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн маргаантай холбоотой шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээсэн, өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон

Он	Хэвээр үлдээсэн	Өөрчлөлт	Хүчингүй
----	-----------------	----------	----------

		оруулсан	болгосон
2012	79.1%	5.2%	15.7%
2013	66.6%	25%	8.4%
2014	84.6%	0	15.4%

Улсын бүртгэлийн маргаан нь захиргааны хэргийн шүүхийн харьяаллын асуудлыг хөндсөн, ээдрээ төвөгтэй байдаг бөгөөд энэ нь мөн иргэний эрх зүйн асуудал болох өмчлөлийн асуудлыг өөртөө шингээсэн байдаг. Одоогийн практикт захиргааны хэргийн шүүх нь улсын бүртгэлийн байгууллага, түүний албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас улсын бүртгэл буруу хийгдсэн бол бүртгэл болон түүний үндсэн дээр олгогдсон гэрчилгээг хүчингүй болгуулах, зохих журмын дагуу бүртгэхийг даалгах нэхэмжлэлийг хянан хэлэлцэж байна. Харин тухайн маргаан бүхий өмчийг өмчлөх эрхтэй этгээд хэн болохыг тогтоох нь иргэний шүүхийн харьяаллын асуудал болно. Гэтэл бодит байдалд тухайн өмч нь хэний өмч байснаас хамаарч улсын бүртгэл үнэн зөв хийгдсэн эсэхэд дүгнэлт өгөх шаардлага тулгардаг тул шүүх иргэний эрх зүйн асуудалд дүгнэлт хийх тохиолдол байна. Гэвч ийнхүү дүгнэхдээ өмчлөгч мөн болохыг тогтоосон агуулгатай дүгнэлт хийх, эсхүл талуудын хооронд байгуулсан гэрээний хүчин төгөлдөр байдлыг үнэлэх нь иргэний эрх зүйн харилцаанд хамаарах тул энэ тохиолдолд шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгийг хэрхэн бичих талаар зохих сургалтыг шүүгчдийн дунд зохион байгуулах хэрэгцээ үүссэн байна.

А. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарч байгаа алдаа дутагдал

Нэхэмжлэлийн шаардлагын агуулга, нэхэмжлэлийн үндэслэлтэй хэрхэн уялдаж байгааг шүүхээс тодруулахгүй байх, мөн хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг бүрэн гүйцэд цуглуулаагүй, талуудын тайлбарыг нэг бүрчлэн шалгаагүй, түүнд холбогдох баримтыг бүрэн цуглуулаагүйгээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан тохиолдол элбэг байна. Хамгийн их анхаарал татаж байгаа асуудал нь хөөн хэлэлцэх хугацаатай холбоотойгоор шүүхүүд өөр өөр дүгнэлт хийж хэргийг шийдвэрлэсэн байдал ажиглагдлаа. Үүнд, нэн ялангуяа, орон сууцны хувьчлалтай холбоотой маргаан нь олон жилийн өмнөх үйл баримтыг шалгах болдог. Тухайлбал, нэхэмжлэгчээс “1999 оноос хойш заргалдсан” гэхэд үүнтэй холбоотой нотлох баримт тодорхойгүй, захиргааны байгууллагаас ямар хариу өгсөн нь тодорхойгүй, хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан, тухайн үеийн Орон сууц хувьчлах товчооны бичиг баримт олдохгүй, Орон сууц хувьчлах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5, 7 дугаар зүйлийн 1-д зааснаар⁴⁵⁸ хэн орон сууцыг хувьчлан авах эрхтэй байсан үйл баримтад дүгнэлт өгөхөд хүндрэл үүсч байна.

Давж заалдах шатны шүүхээс “нэхэмжлэгч ямар учраас 1996 оноос хойш уг орон сууцандаа амьдраагүй, гуравдагч этгээд хэний зөвшөөрлөөр тухайн орон сууцанд амьдрах болсон зэргээр тухайн маргаан бүхий орон сууцны хууль ёсны эзэмшигч нь хэн болохыг тогтоосны дараа хувьчлал, улсын бүртгэлийн асуудлыг шийдвэрлэх” гэж нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэснийг хяналтын шатны шүүхээс “холбогдох албан тушаалтнаас хувьчлалын асуудлыг шалгаж тодруулах, хэргийн оролцогчдыг чирэгдүүлэхгүйгээр тухайн сууцтай хамаарал бүхий

⁴⁵⁸ Орон сууц хувьчлах тухай хууль, 1996

хэд хэдэн маргааныг эцэслэн шийдвэрлэх шаардлагатай” гэсэн үндэслэлээр хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн дундын өмч хөрөнгөөр бүртгэсэн маргаанд давж заалдах шатны шүүхээс “орон сууцны зээлийг хэн төлж ирсэн, гүйлгээ хийсэн баримт цуглуулах” гэсэн үндэслэлээр хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасныг хяналтын шатны шүүхээс “хэлцэлд оролцоогүй учир хамтран өмчлөгч биш байна, уг орон сууцыг худалдан авахад зарцуулсан мөнгийг нэхэмжлэхэд энэ бүртгэл саад болохгүй” гэж нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийджээ. Үүнээс дүгнэхэд, ямар тохиолдолд иргэний хэргийн шүүхээр тэргүүн ээлжид шийдүүлэх, өмчлөгч нь мөн эсэхийг баттай нотлох баримтыг цуглуулах хүрээнд шүүхээс ямар ажиллагаа хийвэл зохих талаар тодорхой үйл баримтад тулгуурлан сургалтыг шүүгчийн дунд зохион байгуулж, энэ талаар нэгдсэн ойлголтод хүрэх шаардлагатай байна.

Б.Хууль хэрэглээ, нотлох баримтын үнэлгээ

Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д⁴⁵⁹ мэдүүлэг гаргагч нь тухайн үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгч гэдгийг баттай нотлох баримт байхгүй бол улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана. Иймд захиргааны хэргийн шүүх энэ хүрээнд хяналтыг хэрэгжүүлж, бүртгэл хуулийн дагуу эсэхийг шалгах болдог. Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.10 дахь хэсэгт⁴⁶⁰ зааснаар газар дээрх үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчийг дагах замаар газрын асуудал шийдэгдэх, эсхүл газрын өмчлөгчийг дагаж үл хөдлөх хөрөнгө өмчлөгчийн асуудал цаашлаад улсын бүртгэлийн асуудал хөндөгдөх эсэхийг нарийвчлан судлах шаардлагатай. Шүүхүүд улсын бүртгэл хуулийн дагуу бүртгэгдсэн эсэхийг шалгахдаа уг бүртгэлийн улмаас хэний, ямар эрх хөндөгдсөн болохыг сайтар тодруулах шаардлагатай бөгөөд энэ талаар шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт заавал тусгаж хэвших нь зүйтэй юм.

Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т зааснаар гэрээгээр үүссэн барьцааг барьцаалагч, барьцаалуулагчийн хамтарсан мэдүүлгээр бүртгэх ёстой ба хэрэгт авагдсан барьцааны гэрээг бүртгүүлэх мэдүүлгээс үзэхэд барьцаалагч, барьцаалуулагч нар нь хамтарсан мэдүүлэг гаргаагүй болох нь тогтоогдсон байна. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллага барьцааны гэрээний мэдүүлэг нь хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгаж тодруулах үүргээ биелүүлээгүй буруутай байна. Гэвч захиргааны байгууллагын дээрх алдаатай бүртгэлийн улмаас “нэхэмжлэгчийн хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөөгүй” гэж дүгнэснийг хяналтын шатны шүүхээс хэвээр үлдээжээ.

Гэрлэлтээ батлуулахыг гэрлэгчид зөвшөөрсөн боловч гэр бүлийн хөрөнгө хуваах маргаанаас үүдэж, “захиргааны байгууллагад биечлэн ирээгүй” гэсэн үндэслэлээр хожим улсын бүртгэлийг хүчингүй болгуулахаар маргасныг шүүхээс гэрлэгчдийн хэн нэгний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг улсын бүртгэл хийсэн

⁴⁵⁹ Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” 2003, №25

⁴⁶⁰ Газрын тухай хууль, “Төрийн мэдээлэл” 2002, №27

үйлдэл зөрчөөгүй гэж нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ. Анхан болон давж заалдах шатны шүүхээс “маргаан бүхий хүзүүвчний барилгын өмчлөгч нь хэн болох нь тодорхойгүй” гэсэн үндэслэлээр захиргааны байгууллагыг дахин шинээр тодруулж, акт гаргахыг даалгаж, маргаан бүхий улсын бүртгэлийг түдгэлзүүлж шийдвэрлэсэн бол хяналтын шатны шүүхээс “маргаан бүхий барилгын суурийн хэмжээ тодорхойгүй, барилгын сууриар олгогдсон газарт маргаж байгаа газар хамаарч байгаа эсэх нь тодорхойгүй” гэж нотлох баримт цуглуулахаар хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбогдуулан хувьцаа эзэмших, үүсгэн байгуулах баримт бичиг, түүнд орсон өөрчлөлтийг бүртгэсэн улсын бүртгэлтэй холбогдуулан талууд маргадаг бөгөөд захиргааны байгууллагаас улсын бүртгэлийг үйлдэхдээ дагаж мөрдөх дүрэм, журам олноор гаргадаг байна. Гэтэл эдгээр дүрэм, журам нь Хууль зүйн яаманд бүртгэгдээгүй, олон дахин өөрчлөгддөг зэргээс нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэлтэй байна. Нөгөөтээгүүр бүртгэлтэй холбоотой зарим маргааныг шүүхүүд өөр өөрөөр шийдвэрлэсэн тохиолдол байгаа бөгөөд шүүх хуулийн хүчин төгөлдөр шийдвэр, тогтоолуудаар бүртгэлүүд нь илт хууль бус болох нь тогтоогдож, гэрчилгээнүүд нь хүчингүй болсон үл хөдлөх хөрөнгөтэй цаг хугацаа, үйл баримт, үр дагаврын хувьд ижил үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн маргааныг дээрхийн адилаар дүгнэхгүй байх боломжгүй нөхцөл байдал байгаа, нөгөө талаас хэргийн нөхцлүүдийг ямар үед өөр, ялгаатай гэж үзэх нь тодорхойгүй байна.

Дүгнэлт

Энэ судалгааг шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх зарчмын хүрээнд шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр байдал, өөрчлөгдөж, хүчингүй болж байгаа шалтгаан, нөхцлийг олж тогтоох, цаашид энэ чиглэлээр ямар арга хэмжээ авах талаар зохих саналыг дэвшүүлэх зорилгоор гүйцэтгэсэн. Судалгааны явцад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илэрсэн алдаа, зөрчлийг хэрэг тус бүрээр судалсан бөгөөд нийтлэг байдлаар дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

1. Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлийн агуулгыг зөв тодорхойлох ажиллагаа нь шүүгчээс хэрэгт хамааралтай, ач холбогдолтой нотлох баримт цуглуулах хүрээ хязгаар болж байдаг бөгөөд нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлийг шүүхээс зөв ойлгоогүй, тодорхойгүй байхад түүнийг тодруулахгүйгээр хэргийг хянан шийдвэрлэснээс хэрэгт хамааралгүй нотлох баримт цуглуулах, хэрэгт хамааралтай нотлох баримтыг цуглуулахгүй орхиж байна. Энэ нь хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаах үндсэн шалтгаан болж байна. Захиргааны хэргийн нэхэмжлэл нь ихэвчлэн 2-3 нэхэмжлэлийн шаардлагатай, шаардлага тус бүр өөрийн гэсэн үндэслэлтэй байдаг тул шүүхийн шийдвэр хэвээр үлдэх гол үндэслэл болох нэхэмжлэлийн шаардлага тодруулах ажиллагааг зөв хэрэглэж хэвшүүлэхэд анхаарах зайлшгүй шаардлагатай байна.

2. Нотлох баримтыг зөв тогтоох, үнэлэх асуудлын хүрээнд нотлох баримтыг цуглуулахдаа маргааны үйл баримтад ач холбогдолтой, хамааралтай талаас нь ямар баримт, үндэслэлийг нотолж байгаа, энэ нь өөр бусад нотлох баримттай

хэрхэн уялдаж байгаа, эсхүл хэрэгт хамааралгүй, ач холбогдолгүй гэж үзсэн бол тэр үндэслэлээ шүүхийн шийдвэрт тодорхой тайлбарлаж бичих шаардлагатай байна. Судалгаанаас үзэхэд шүүх хэрэгт авагдсан эсрэг, тэсрэг нотлох баримтыг хэрхэн үнэлснээ тодорхой бичдэггүй, улмаар давж заалдах болон хяналтын гомдол “нотлох баримтыг бүрэн үнэлээгүй, шүүх нэг талыг барьж хэргийг шийдсэн” гэсэн үндэслэлээр гардаг. Иймд шүүх цуглуулсан нотлох баримтаа хэрхэн харьцуулж үнэлэх, түүнийг шүүхийн шийдвэрт хэрхэн тусгахад анхаарч ажиллаж ёстой байна. Мөн талуудын маргаж буй үндэслэл тус бүрд нотлох баримтыг бүрэн цуглуулах, дараа нь эрх зүйн дүгнэлтийг үндэслэл тус бүрд хийх ажиллагааг бүрэн гүйцэд хийгээгүй нь хэрэг хүчингүй болох, хэргийн оролцогчид гомдол гаргах үндэслэл болж байна.

3. Газрын маргааныг шүүхээр шийдвэрлүүлэх тоон үзүүлэлт нь иргэд, хуулийн этгээдийн газар, эзэмших, өмчлөх, ашиглахтай холбоотой харилцаа, мөн газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах сонирхол ихээр нэмэгдэж байгаатай уялдаж энэ хэмжээгээр нэмэгдэж байгаа бөгөөд захиргааны хэргийн шүүхээр нийт шийдвэрлэгдэж байгаа хэргийн талаас илүү хувийг зөвхөн газрын маргаан эзэлж байгаагаас тодорхой харагдаж байна. Иймд газрын маргааныг шийдвэрлэхэд шүүхүүд нотлох баримтыг бүрэн гүйцэд, хангалттай бүрдүүлсний үндсэн дээр хэргийг шийдвэрлэх, маргаан бүхий газрын үзлэгийг шүүхээс мэргэжлийн хэмжээнд хийх шаардлага зүй ёсоор гарч байна. Ингэснээр газрын маргааныг үндэслэлтэй зөв шийдвэрлэхэд онцгой ач холбогдолтой гэж үзэж байна. Шүүхийн практикаас харахад зарим газрын маргааны хувьд шүүхээс газрын үзлэгийг газар дээр нь очиж, хэргийн оролцогчдыг бүрэн хамруулж хийснээр хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломж цөөнгүй байгаа нь харагдлаа.

4. Улсын бүртгэлийн маргааны хувьд хэргийн харьяаллын асуудлыг онцгой анхаарч, иргэний хэргийн шүүхийн шийдвэрлэвэл зохих өмчлөгч хэн болохыг тогтоох асуудлаар дүгнэлт өгөхгүй байхыг хатуу анхаарч, орон сууц хувьчлалын маргаанд хөөн хэлэлцэх хугацааг сайтар тодруулж, холбогдох баримтыг цуглуулж, хэргийг шийдвэрлэх шаардлагатай байна. Мөн улсын бүртгэлийн байгууллагаас гаргасан хуульд тусгаагүй асуудлаар нарийвчлан гаргасан дүрэм, журмыг хэрэглэхдээ хуульд нийцсэн эсэх, тухайн маргаан үүсэх цаг хугацаанд хүчин төгөлдөр байсан эсэхэд анхаарвал зохино.

Санал, зөвлөмж

Судалгааны хүрээнд гарсан нийтлэг алдаа, зөрчлийн талаар нэгдсэн сургалт зохион байгуулах шаардлагатай байна. Сургалтад материаллаг болон процессын хуулийн хэрэглээ, онолын мэдлэгийг дээшлүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг хэрхэн баримтлах талаарх сургалтыг шүүгчдийн дунд зохион байгуулах хэрэгцээ байна. Эдгээр сургалтын сэдвүүдийг дараах байдлаар санал болгож байна. Үүнд:

- Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлийг зөв тодорхойлох;
- Нотлох баримтыг үнэлэх ажиллагааг шүүхийн шийдвэрт тусгах;
- Сахилгын зөрчилд хариуцлага тооцох хөөн хэлэлцэх хугацаа;

- Үр дүнгийн гэрээ үнэлж дүгнэх журам;
- Дундаж цалин хөлс тодорхойлох журам;
- Улсын бүртгэлийн маргааныг өмчлөлийн маргаанаас ялгах нь;
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг хэрхэн хэрэглэх;
- Санхүүгийн тайлан тооцоог бэлтгэх, бүртгэх, тайлагнах арга;
- Хөрөнгийн элэгдэл тооцох, түүнийг бүртгэх арга;
- Нэмэгдсэн өртгийн албан татвар;
- Татварын маргаанд хэрэглэгдэх олон улсын гэрээ;
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй тогтоох;
- Маргаан бүхий газарт үзлэг хийх ажиллагаа зэрэг болно.

-oOo-





**ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ШҮҮГЧДИЙН ТОО БА 100.000 ХҮН АМД НОГДОХ
ШҮҮГЧИЙН ТООН ХАРЬЦУУЛАЛТ⁴⁶¹**

Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хэргийн ачаалал, нийт хүн амын тоон үзүүлэлтийг харгалзан шүүгчдийн тоог тасралтгүй нэмэгдүүлэх нь шүүхийн хүний нөөцийн бодлогын нэг хэсэг юм. Энэ нь шүүн таслах ажиллагаа хуулийн хугацаанд байх, шүүхийн үйлчилгээг иргэдэд түргэн, шуурхай бүрэн хүргэхэд ихээхэн ач холбогдолтой.

Эрх зүйн тогтолцооноосоо хамаарч дэлхийн улс, орнуудад шүүгч нь мэргэшсэн, мэргэжлийн бус, орон тооны бус мэргэжлийн гэсэн өөр өөр төрөл байдаг. Тус судалгаанд орон тооны мэргэшсэн шүүгч буюу бүтэн цагаар ажиллаж шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлдэг шүүгчдийн тоог тухайн улсын хүн амын 100 мянган хүнд ногдож буй дундаж тоогоор харуулав.⁴⁶²

Д/д	Улсын нэр	Шүүгч тоо	
		Тухайн улсын нийт шүүгчийн тоо	100.000 хүн ам тутамд ногдож буй шүүгчийн тоо
1	Япон	2880	2.25
2	Бүгд Найрамдах Ирланд улс	147	3.2
3	Шотланд ⁴⁶³	185	3.5
4	Уэльс	1984	3.6
5	Гүрж	234	5.2
6	БНСУ ⁴⁶⁴	2837	5.8

⁴⁶¹ Тус лавлагааг ШСМСХ-ийн судлаач Г.Солонго боловсруулан бэлтгэв.

⁴⁶² Тус хүснэгтэд 52 улсын шүүгчийн тоог нийт хүн амын тоонд харьцуулсан судалгааг 2010 оны байдлаар гаргасан болно.

European judicial systems edition 2012 (201 data) Efficiency and quality of justice, CEPEJ

<https://books.google.mn/books?id=YI-sb-5om3UC&pg=PA147&lpg=PA147&dq=number+of+judges+per+100.000&source=bl&ots=N0-naCgVlj&sig=oik6cY76WgXJcFk1respwL9kb6Y&hl=mn&sa=X&ved=0CE0Q6AEwBmoVChMllfAgbytyAIV2CqlCh3jfANh#v=onepage&q=number%20of%20judges%20per%20100.000&f=false>

⁴⁶³ Тус хүснэгтийн 1-47 хүртэлх улсуудын шүүгчдийн дунджаар 70%-85% хувь нь анхан шатны шүүхийн шүүгч, 12%-30% хувь нь давж заалдах шатны шүүхийн шүүгч, 10% орчим хувь нь дээд шүүхийн шүүгч болно.

⁴⁶⁴ 2015 оны байдлаар <http://www.scourt.go.kr/supreme/index.html>

7	Азербайжан	600	6.7
8	Армен	220	6.7
9	Англи	3726	6.75
10	Денмарк	501	9.0
11	Малти	39	9.3
12	Испани	4689	10.2
13	АНУ ⁴⁶⁵	32501	10.43
14	Турк	7727	10.6
15	Франц	6945	10.7
16	Итали	6654	11.0
17	Норвеги	549	11.2
18	Швед	1081	11.5
19	Албани	373	11.7
20	Молдав	443	12.4
21	Кипр	104	12.9
22	Швейцар	1142	14.5
23	БНХАУ ⁴⁶⁶	205000	14.8
24	Бельги	1607	14.8
25	Монгол	454	14.9
26	Нидерланд	2530	15.2
27	Бүгд Найрамдах Исланд улс	52	16.3
28	Эстон	224	16.7
29	Австри	1491	17.8
30	Грек	2041	18.0
31	Финланд	967	18.0
32	Португали	1956	18.4
33	Румын	4081	19.0

⁴⁶⁵ АНУ, Англи, Япон улсуудын судалгааг “Хуульч мэргэжилтний хүн амын тухай судалгаа”-г үндэслэв.
Цахим эх сурвалж /<http://www.moj.go.jp/content/000102262.pdf/>

⁴⁶⁶ 2012 оны байдлаар http://rmfyb.chinacourt.org/paper/html/2013-06/07/content_64729.htm?div=-1#
https://en.wikipedia.org/wiki/Demographics_of_China

34	Украин	8823	19.3
35	Латви	472	21.2
36	ОХУ	32313	22.6
37	Литуани	767	23.6
38	ХБНГУ	19832	24.3
39	Босни ба Герцеговин	938	24.4
40	Словак	1351	24.9
41	Польш	10625	27.8
42	Андорра	24	28.2
43	Унгар	2891	29.0
44	Бүгд Найрамдах Чех улс	3063	29.1
45	Болгар улс	2198	29.8
46	Македони	664	32.3
47	Серби	2455	33.7
48	Люксембург	188	36.7
49	Монтенегро	260	41.9
50	Сан-Марино	14	42.2
51	Хорват	1887	42.8
52	Словени	1024	49.9
53	Монакогийн Гүнт улс	36	100.3

Судалгаанаас харахад нийт хүн амын тоон үзүүлэлтэд шүүгчдийн эзлэх хувь хэмжээ харьцангуй ялгаатай байна. Энэ нь тухайн улс орны газар зүйн байршил, хүн амын тоо, эрх зүйн тогтолцоо, шүүхийн байгууллагын системийн онцлог зэргээс хамаарч байна.

Монгол улсын хувьд: 2015 оны 10 дугаар сарын байдлаар, Монгол Улсын нийт хүн ам 3.044.972,⁴⁶⁷ нийт шүүгчийн тоо 454 байгаа нь 100.000 хүн ам тутамд 14.9 шүүгч ногдож байна. Лавлагааны хүрээнд судалсан 52 улсын 100,000⁴⁶⁸ хүн ам тутамд ногдох шүүгчийн дундаж тоо нь 20.04 байгаа бол Монгол улсын хувьд 14.9 байгаа нь дунджаас бага байгааг харуулж байна.

-оОо-

⁴⁶⁷ 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар Монгол Улсын хүн амын тоог Үндэсний статистикийн хорооны мэдээнд үндэслэн гаргасан болно. <http://www.nso.mn/>

⁴⁶⁸ НҮБ, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн Банк, судалгаандаа хэрэглэдэг аргачлалаар гаргасан болно https://en.wikipedia.org/wiki/Sampling_distribution

ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ШҮҮГЧЭЭР ТОМИЛОГДОХ НАСНЫ ДООД ХЯЗГААРЫГ ТОГТООСОН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ⁴⁶⁹

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр томилж болно.

Гадаадын зарим улс орнуудад шүүгчээр томилох насны доод хязгаарыг харилцан адилгүй зохицуулсан байна. Түүнчлэн анхан шатны шүүхийн шүүгчийн насны доод хязгаарыг тодорхой заагаагүй боловч шүүгч болохын тулд тодорхой шат дараалсан шалгуурыг хангасан байхыг шаарддаг байна. Ингээд дараах хүснэгтэд шүүгчээр анх удаа томилогдох насны доод хязгаарыг тогтоосон зохицуулалтын дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулна.

Д/д	Улсын нэр	Шүүгчээр томилох насны доод хязгаар	Тайлбар
1	БНХАУ	23 нас	БНХАУ-ын Шүүгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар шүүгч болох хүн дараах шаардлагыг хангасан байна: 1. БНХАУ-ын иргэн байх 2. 23 насанд хүрсэн байх 3. БНХАУ-ын Үндсэн хуулийг эрхэмлэн дээдэлдэг байх. 4. Улс төр, мэргэжлийн өндөр ёс суртахуунтай бөгөөд бие зөв авч явдаг байх 5. Эрүүл мэндийн хувьд эрүүл байх 6. Их дээд сургуулийг хууль зүйн мэргэжлээр төгссөн эсхүл их дээд сургуулийн бусад мэргэжлийг төгссөн бөгөөд хууль эрх зүйн мэдлэгтэй, мэргэжлээрээ 2 жил ажилласан, эсхүл эрх зүйн бакалаврын зэргийг эзэмшиж, нэг жил мэргэжлээрээ ажилласан, хууль зүйн магистр болон хууль зүйн докторын зэрэгтэй бол ажилласан жил шаардахгүй байж болно.
2	АНУ /Техас муж/	25 нас	АНУ-ын Техас мужийн хувьд орон нутгийн шүүхэд 25 насанд хүрсэн, мэргэжлээрээ 4 жил ажилласан туршлагатай байхыг шаарддаг бол эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч 35 насанд хүрсэн 10-аас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан байх ёстой.
3	АНУ /Жоржиа муж/	25 нас	АНУ-ын иргэн байх, сүүлийн 2 жил оршин суусан, насны доод хязгаар нь 25 хүрсэн, сонгуулийн эрхтэй, ахлах сургуулийн диплом эсхүл түүнтэй адилтгах сургалт, хөтөлбөрт оролцсон байх.

⁴⁶⁹ Тус лавлагааг ШСМСХ-ийн захирал Ц.Мандах, шүүхийн судалгаа хариуцсан референт Т.Түмэнцэцэг, Х.Сэлэнгэ, судлаач Б.Ариунзаяа нар боловсруулан бэлтгэв.

4	ОХУ	25 нас	Шүүгчээр томилогдох иргэн нь 25 нас хүрсэн, хууль зүйн дээд боловсролтой, 5-аас доошгүй жил хуулийн мэргэжлээрээ ажилласан ОХУ-ын иргэн байна. ⁴⁷⁰
5	Гондурас	25 нас	Гондурас Улсын Үндсэн хуулийн 52 дугаар зүйлд зааснаар шүүгч болох насны доод хязгаар 25 бөгөөд Гондурас улсад төрсөн, нэр хүнд бүхий, бусдад хүлээн зөвшөөрөгдсөн, шүүгчээр ажиллахад тохиромжтой хүнийг томилдог байна. ⁴⁷¹
6	Эстони	25 нас	Эстони улсын иргэн байх, хууль зүйн дээд боловсролтой, Эстони хэлийг бүрэн эзэмшсэн, шүүгчээр ажиллах ур чадвар бүхий өндөр ёс зүйтэй байх ёстой. Үүнээс гадна шүүгч нь гэмт хэрэгт шийтгэгдэж байгаагүй, шүүх, нотариат болон шийдвэр гүйцэтгэх байгууллагаас албан тушаалаас нь чөлөөлсөн шийдвэр гараагүй, Эстони улсын хуульчдын холбооноос хөөгдөөгүй, сахилгын арга хэмжээ авагдаагүй, дампуураагүй байх ёстой. ⁴⁷²
7	Этиоп	25 нас	Анхан шатны Холбооны шүүхэд 25 нас хүрсэн, хууль зүйн салбарт ажилласан туршлагатай, ур чадвар, хичээл зүтгэлтэй, шударга, нэр хүнд бүхий хүнийг шүүгчээр томилно. ⁴⁷³
8	Гүрж	30 нас	Бүгд найрамдах Гүрж улсын Үндсэн хуулийн 86.1 дэх хэсэгт зааснаар шүүгчээр томилогдох хүн нь Гүрж улсын иргэн, 30 нас хүрсэн, эрх зүйн өндөр мэдлэгтэй, хууль зүйн салбарт 5-аас доошгүй жил ажиллаж туршлага хуримтлуулсан байна. ⁴⁷⁴
9	Польш	30 нас	Польш улсын хувьд Дүүргийн шүүхийн шүүгчид дараах шаардлага тавьдаг. Польш улсын иргэн байх, эсхүл албан ёсны иргэншилтэй байх, нэр хүнд бүхий байх, хууль зүйн магистраас доошгүй зэрэгтэй байх, 30-аас доошгүй настай, шүүгчийн шалгалтад тэнцсэн, 5-аас доошгүй жил шүүхэд туслалт шүүгчээр ажилласан байх ёстой. ⁴⁷⁵
10	Словени	30 нас	Анхан шатны шүүхийн шүүгчээр томилогдох иргэн нь Словени улсын иргэн, словени хэлийг бүрэн эзэмшсэн, биеийн ерөнхий эрүүл мэнд сайн, 30 нас хүрсэн, Словенид хууль зүйн дээд боловсрол эзэмшсэн, эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэг эзэмшсэн, хуульчийн

⁴⁷⁰ Chapter 7. Judicial Power

<http://www.constitution.ru/en/10003000-08.htm>

⁴⁷¹ Honduras's Constitution of 1982 with Amendments through 2013

https://www.constituteproject.org/constitution/Honduras_2013.pdf?lang=en

⁴⁷² Legal professions - Estonia

http://ec.europa.eu/civiljustice/legal_prof/legal_prof_est_en.htm

⁴⁷³ Federal Democratic Republic of Ethiopia <http://www.cilc.nl/cms/wp-content/uploads/2014/11/CILC-Ethiopia-D-05-0103.pdf>

⁴⁷⁴ The constitution of georgia

<http://www.friends-partners.org/oldfriends/constitution/constitution.georgia.html>

⁴⁷⁵ Legal professions - Poland

http://ec.europa.eu/civiljustice/legal_prof/legal_prof_pol_en.htm

			шалгалтад тэнцсэн, шүүгчийн албан тушаалд тохирохуйц байна. ⁴⁷⁶
11	Словак	30 нас	Словак улсад шүүгчээр томилогдох иргэн нь 30 нас хүрсэн, хууль зүйн дээд боловсролтой, эрх зүйн бүрэн чадамжтай, шүүгчийн ажил эрхлэхэд эрүүл, зан чанар, ёс суртахууны өндөр шаардлага хангасан, Словак улсад байнга оршин суудаг, шүүгчийн шалгалтыг амжилттай өгч тэнцсэн байна.
12	Унгар	30 нас	Унгар улсын Үндсэн хуулийн 26.2 дахь хэсэгт зааснаар шүүгчээр томилогдох иргэн 30 нас хүрсэн Унгар улсын иргэн байх, үүнээс гадна ямар нэгэн гэмт хэрэгт холбогдож байгаагүй, сонгуульд санал өгөх эрхтэй, хууль, эрх зүйн дээд боловсролтой, мэргэжлийн ур чадвартай, хуульд тусгайлан зааснаар санхүүгийн тайлангаа гаргаж өгсөн байх гэсэн шаардлагуудыг тавьдаг байна. ⁴⁷⁷
13	Никарагуа	35 нас	Никарагуа улсын хувьд шүүгчээр ажиллах насны доод хязгаар нь 35-аас багагүй, 75-аас ихгүй байх ёстой. Уг насны хязгаар нь зөвхөн анхан шатны шүүхийн шүүгч бус, бүх шатны шүүхийн шүүгчид хамааралтай. Үүнээс гадна шүүгчээр томилогдох иргэн нь Никарагуа үндэсний байх ёстой. Хэрэв өөр үндэстэн бол 4 жилийн өмнө уг улсын харъяаллаас татгалзсан байх, иргэний болон улс төрийн эрхтэй, өмгөөлөгч, нотариатын үйл ажиллагаа явуулах эрхээ шүүхээр түдгэлзүүлсэн, өндөр ёс суртахуунтай, цэргийн идэвхтэн гишүүн бус, уг үүргээсээ 12-оос доошгүй сарын өмнө татгалзсан, дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллага, гадаадад улсад суралцахаас бусад тохиолдолд сүүлийн 4 жилийн хугацаанд тус улсад оршин суусан байх ёстой. ⁴⁷⁸
14	Непал	Нас заагаагүй	Непал улсын хувьд дүүргийн шүүхийн шүүгчээр томилогдох иргэн нь Непал улсын иргэн байх, хууль зүйн бакалавр зэрэгтэй байх, хамгийн багадаа 4 жилийн хугацаанд шүүхэд ажилласан байх ёстой.
15	Англи улс	Нас заагаагүй	Насны доод хязгаарыг зааж өгөөгүй боловч дунджаар 40-өөс дээш насны хүнийг томилдог жишиг байна. Барристар, эсвэл Солистараар тодорхой хугацаанд ажилласан хуульчид дундаас томилдог.
16	Австрали	Нас заагаагүй	Австрали улсад шүүгч болохын тулд хуулийн сургуульд суралцсан, 8-аас доошгүй жил хуульчаар ажилласан /одоогийн байдлаар дунджаар 20 орчим жил ажилласан хүнийг илүүтэй сонгож байна/, өндөр ёс суртахуунтай, нэр хүнд бүхий байх ёстой. ⁴⁷⁹

⁴⁷⁶ Legal professions - Slovenia

http://ec.europa.eu/civiljustice/legal_prof/legal_prof_sl_en.htm

⁴⁷⁷ Legal professions - Slovakia

https://www.constituteproject.org/constitution/Hungary_2011.pdf

⁴⁷⁸ Nicaragua's Constitution of 1987 with Amendments through 2005

https://www.constituteproject.org/constitution/Nicaragua_2005.pdf

⁴⁷⁹ How to Get on Judge Judy

http://www.ehow.com/how_5116104_judge-judy.html

17	Австри	Нас заагаагүй	Хуулийн сургууль төгссөний дараа шүүхийн практикт суралцахын тулд шүүгч бэлтгэх хөтөлбөрт хамрагдах ёстой. Уг хөтөлбөрт 4 жилийн хугацаанд суралцахдаа дүүргийн шүүх, орон нутгийн шүүх, прокурорын байгууллага, хохирогчдыг хамгаалах төв, өмгөөлөгчдийн нийгэмлэг болон нотариатын байгууллагад ажиллана. Ингээд шүүгчийн шалгалтад тэнцсэн тохиолдолд шүүгчээр томилогддог байна. Шалгалтад зөвхөн Австрийн иргэд оролцох боломжтой байдаг. ⁴⁸⁰
18	Сальвадор	Нас заагаагүй	Сальвадор улсын Үндсэн хуулийн 179 дүгээр зүйлд зааснаар анхан шатны шүүхийн шүүгч нь Сальвадор улсын иргэн, хуульч, ур чадвартай, өндөр ёс суртахуунтай, мэргэжлээрээ ажилласан туршлагатай байна. ⁴⁸¹
19	Герман	Нас заагаагүй	Хууль зүйн сургуульд 3 жилээс дээш суралцаж төгсөөд улсын 1 дүгээр шалгалтад тэнцэж, 2 жилийн дадлага курсийг дүүргэн, улсын 2 дугаар шалгалтыг өгснөөр шүүгч болно. Улсын дээд шүүхийн шүүгч бол 35-аас дээш насны байх хэрэгтэй.
20	Дани	Нас заагаагүй	Насны хязгаар заагаагүй. Хууль зүйн сургуулийг төгссөний дараа давж заалдах шатны аль нэг шүүхэд 9 сарын турш дадлагажин шалгуулна. Шүүгчдийн зөвлөлөөс шалгаруулна.
21	Итали	Нас заагаагүй	Насны хязгаар заагаагүй. Улсын дээд шүүхийн шүүгч нь 20 жилээс дээш шүүхийн салбарт ажилласан туршлагатай, их сургуулийн профессороор 15 жил ажилласан байхыг шаарддаг.
22	БНСУ	Нас заагаагүй	Үндсэн хуулиар шүүгчийн насыг заагаагүй хэдий ч шүүгч болох хүн дараах 5 шатыг давах ёстой. Үүнд: 1. Бакалаврын боловсрол эзэмших ба уг боловсрол нь 3-4 жилийн эрх зүйн эсхүл эрх зүйгээс бусад мэргэжил байна. 2. Их сургуулийн хууль зүйн мэргэжлийн сургуульд суралцаж магистрын зэрэг эзэмшинэ. Зөвхөн эдгээр сургуулийг төгссөн хүн хуульчийн шалгалтад орох эрхтэй болдог. 3. Хуульчийн шалгалтыг өгч тэнцэх. 4. Хууль, шүүхийн судалгаа, сургалтын институтэд 2 жилийн мэргэшүүлэх хөтөлбөрт хамрагдах. 5. Хууль, шүүхийн судалгаа, сургалтын институтэд амжилттай суралцаж, ихэвчлэн эхний 200-д багтсан сурагч Дээд шүүхэд туслах шүүгчээр томилогдох хүсэлт гаргадаг бөгөөд Дээд шүүх орон нутгийн шүүхүүдэд туслах шүүгчээр 2 жилийн хугацаатайгаар хуваарилдаг. Туслах шүүгчээр ажиллах хугацаандаа хэрэг шийдэхгүй бөгөөд шүүн таслах ажиллагаатай холбоотой мөрдөн шалгах болон судалгааны ажлыг хариуцаж хийдэг байна. Туслах шүүгчээр 2 жил ажилласны дараа Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөл

⁴⁸⁰ This page provides an overview of the legal professions in Austria.

https://e-justice.europa.eu/content_legal_professions-29-at-en.do?member=1

⁴⁸¹ Constitution Of The Republic Of El Salvador, 1983

<http://confinder.richmond.edu/admin/docs/ElSalvador1983English.pdf>

			хэлэлцэж шүүгчээр томилдог байна. Шүүгч нь дор хаяж 5 жилийн туршлагатай болсон бол ганцаарчилж хэргийг шийдвэрлэх эрхтэй болно. ⁴⁸²
23	Фижи	Нас заагаагүй	Фижигийн Үндсэн хуулийн 105.2 болон 105.6 дахь хэсэгт зааснаар шүүгчээр томилогдох хүн мэдлэг ур чадвартай байхыг шаардахаас гадна өндөр ёс зүйтэй байх шаардлага тавигддаг. Шүүгч болохын тулд өмнө нь шүүхэд ажиллаж мэргэшсэн байх, 15-аас доошгүй жил хуульчаар ажилласан туршлагатай, өндөр ёс зүйтэй, сахилгын арга хэмжээ авагдаж байгаагүй, ял шийтгэгдэж байгаагүй хүнийг томилно. ⁴⁸³
24	Франц	Нас заагаагүй	Насны хязгаар заагаагүй. Хууль зүйн сургууль төгсөгчдөөс тусгай шалгалтын журмаар томилдог. Их сургуулийн багш, өмгөөлөгч, төрийн албан хаагч дундаас шууд шалгаруулж болдог. ⁴⁸⁴
25	Испани	Нас заагаагүй	Насны доод хязгаар заагаагүй. Хууль зүйн сургуульд бакалаврын зэрэг хамгаалсан Испани улсын иргэн нь улсын шалгалт өгч тэнцэх ёстой. Тэнцсэн этгээд нь эрх олгох сургалтад 1 жилийн турш суралцах ёстой. Энэ сургалт нь шүүхүүд дээр практик хичээл заалгах маягаар явагдана. Сургалтыг дүүргэж тэнцвэл шүүгчээр томилогдоно. Улсын дээд шүүхийн шүүгч нь 15-аас дээш жил ажилласан мэргэжлийн өндөр мэдлэг, чадвартай хуульч, шүүгчдээс томилогддог. ⁴⁸⁵
26	Канад	Нас заагаагүй	Канад улсын Шүүгчийн тухай хуульд анхан шатны шүүхэд томилогдох насны доод хязгаарыг заагаагүй байна. Харин хуульчийн мэргэжлээр эсхүл шүүхэд 5-аас доошгүй жил ажилласан байхыг шаарддаг ч бодит байдалд 10-аас доош жил ажилласан хүнийг шүүгчээр томилж байгаагүй байна. ⁴⁸⁶
27	Киргиз	Нас заагаагүй	Бүгд найрамдах Киргиз улс Үндсэн хуульдаа анхан шатны шүүхийн шүүгчийн насны доод хязгаарыг зааж өгөөгүй. Харин тусгайлсан хуулиар Киргиз улсын иргэн, 65-аас доошгүй настай, эрх зүйн өндөр мэдлэгтэй, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх ёстой гэсэн шаардлага тавигддаг. ⁴⁸⁷

⁴⁸² Law of South Korea

<http://www.chinacourt.org/article/detail/2014/11/id/1485347.shtml>
https://en.wikipedia.org/wiki/Law_of_South_Korea#District_Courts

болон

⁴⁸³ The Judicial Appointment Process in British Columbia and the Supreme Court of Canada
<http://www.paclii.org/fj/Fiji-Constitution-English-2013.pdf>

⁴⁸⁴ <http://www.kantei.go.jp/jp/sihouseido/dai7append/gaikoku.pdf> /

⁴⁸⁵ Judiciary of Spain

https://en.wikipedia.org/wiki/Judiciary_of_Spain#Judges_and_magistrates/

⁴⁸⁶ The Judicial Appointment Process in British Columbia and the Supreme Court of Canada
 Backgrounder http://www.bclaws.ca/EPLibraries/bclaws_new/document/ID/freeside/00_96379_01#section6

болон <http://www.lawconnection.ca/content/judicial-appointment-backgrounder>

⁴⁸⁷ The Law Of The Kyrgyz Republic <http://www.wipo.int/edocs/lexdocs/laws/en/kg/kq084en.pdf> болон
[http://www.libertas-institut.com/de/Mittel-](http://www.libertas-institut.com/de/Mittel-Osteuropa/Law%20on%20Supreme%20Court%20and%20Local%20Courts.pdf)

[Osteuropa/Law%20on%20Supreme%20Court%20and%20Local%20Courts.pdf](http://www.libertas-institut.com/de/Mittel-Osteuropa/Law%20on%20Supreme%20Court%20and%20Local%20Courts.pdf)

28	Чех	Нас заагаагүй	Чех үндэстэн байх, хууль зүйн өндөр мэдлэгтэй, зан харилцаа сайтай, хууль зүйн дээд боловсролтой, шүүгчийн ажлыг гүйцэтгэж чадах өндөр ёс суртахуунтай, шүүгчийн мэргэжлийн шалгалтад тэнцсэн байна. ⁴⁸⁸
29	Швед	Нас заагаагүй	Швед улсын иргэн байх, мөн Шведэд хуулийн сургууль төгссөн, эсхүл Скандинавын орнуудад хуулийн зэрэг авсан байх, дүүргийн болон захиргааны шүүхэд 2 жилийн хугацаанд туслах ажилтан хийсэн байна.
30	Япон	Нас заагаагүй	Япон улсын Үндсэн хуульд зааснаар анхан шатны шүүхийн шүүгчийн насны доод хязгаарыг заагаагүй байдаг бөгөөд шүүгч болох хүн ийн багадаа 10 жил туслах шүүгч, прокурор, өмгөөлөгч зэрэг хуулийн ажил эрхэлсэн байх ёстой. ⁴⁸⁹

Шүүгчээр ажиллах насны доод хязгаар тогтоосон байдлыг авч үзвэл судалгаанд хамрагдсан улсуудад дунджаар 25-30 нас байхаар хуульчилсан байна. Ингэхдээ зөвхөн насны доод хязгаар тавиад зогсохгүй нэмэлт олон шаардлагыг тусгасан байна. Эндээс анхаарал татаж буй нэг асуудал нь зарим улс орнууд шүүгчийн насны доод хязгаарыг хуульчлахаас илүүтэй олон шат бүхий шалгуурыг тавьсан байх бөгөөд үүнд тодорхой нас хамаарахгүй байна. Өөрөөр хэлбэл, зөвхөн тус шалгуурыг давсан тохиолдолд шүүгчээр ажиллах, зарим тохиолдолд туслах шүүгчээр ажиллах болзлыг хангасан гэж үзэж байна. Энэ нь шүүгчийн ажил нэн хариуцлагатай бөгөөд нэр дэвшигчээс өндөр ур чадвар, ёс зүйг шаардаж байгааг харж болно. Хэдийгээр шүүгчийн насны доод хязгаарыг тавиагүй боловч практикт 10-20 жил хуульчаар ажилласан хүнийг шүүгчээр томилох байдал ажиглагдаж байна. Иймд анхан шатны шүүхийн шүүгчийн насны доод хязгаарыг тогтоохоос гадна түүнд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх нь ихээхэн ач холбогдолтой байна.

-оОо-

⁴⁸⁸ Legal professions - Czech Republic

http://ec.europa.eu/civiljustice/legal_prof/legal_prof_cze_en.htm

⁴⁸⁹ The Constitution of Japan

http://japan.kantei.go.jp/constitution_and_government_of_japan/constitution_e.html

ӨРШӨӨЛ БОЛОН УУЧЛАЛЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ⁴⁹⁰

Нэг. Ойлголт

Өршөөл, уучлал нь хүн төрөлхтний түүхэнд сонирхолтой ул мөрийг үлдээжээ. Хамгийн эртний эрх зүйн баримт бичигт тооцогддог Хаммурапи хааны хуульд уучлал үзүүлэх ойлголт анх тусгагдсан бол Английн эзэн хаан олон зуун жилийн туршид өршөөл энэрэл, уучлал үзүүлж байсан тухай түүхэн баримт бий. Уучлал нь шударга ёсны тогтолцооны зайлшгүй элементийн зэрэгцээ бас төрийн сан хөмрөгийг бүрдүүлэх нэг эх сурвалж болж байсан байх юм. Тухайлбал, Английн эзэн хаад уучлалыг тодорхой үнэ цэнэтэйгээр худалдах замаар шинэ дэлхий ертөнцийг нээхэд зарцуулж байв.⁴⁹¹

Уучлал (Pardon), өршөөл (Amnesty), өршөөл+уучлал (Clemency), өршөөл энэрэл (Grace in Monaco), ивээл (Mercy in Sweden) зэрэг ялгаатай байдлаар томъёологдож ирсэн эдгээр ойлголт нь өдгөө бичмэл үндсэн хуультай дийлэнх улсын эрх зүйн тогтолцоонд өөрийн бат байр суурийг эзэлсэн гэж хэлж болно. Зарим уучлал нь эрх зүйн төдийгүй улс төрийн сонирхолтой хэлэлцүүлгийн бай болж байв. Тухайлбал, Италийн Ерөнхийлөгч Карло Чиаampi Ромын поп ламын амь насыг бусниулахаар завдсан этгээдийг уучилсан, Францын Ерөнхийлөгч Жак Ширак хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн боловч 89 насыг насалсан Маурис Папоныг уучлахаас татгалзсан, Саудын Арабын эзэн хаан II Хассан 1800 гаруй хүнд 1999 онд уучлал үзүүлсэн зэрэг нь тухайн цаг үеийн нийгэм, улс төрийн төдийгүй олон нийтийн анхаарлыг ихэд татаж байв.

Ихэнх улс оронд уучлал үзүүлэх бүрэн эрхийг улс төрийн албан тушаалтан буюу Ерөнхийлөгчтэй улс оронд төрийн тэргүүн нь хэрэгжүүлдэг онцлогтой. 1998 оны байдлаар Европын 46 улсын 32 нь Ерөнхийлөгчтэй байсан бөгөөд эдгээрээс 31 улс нь уучлал үзүүлэх бүрэн эрхийг Ерөнхийлөгч нь хэрэгжүүлэхээр Үндсэн хуульдаа тусгасан байжээ.⁴⁹² Үүнээс 19 улсад Ерөнхийлөгч өөрийн уучлал үзүүлэх бүрэн эрхээ бусад субьекттэй “хуваалцахгүй”, үндсэн хуулийн ямар нэгэн нэмэлт нөхцөл, шаардлагагүй хэрэгжүүлэхээр тусгасан байв. Эдгээрээс 14 улсад Ерөнхийлөгчийг бүх ард түмнээс шууд сонгох тогтолцоо үйлчилж байжээ. Харин 12 улсад Ерөнхийлөгч уучлал үзүүлэх бүрэн эрхээ ямар нэг засаг төрийн субьекттэй “хуваалцахаар” эсхүл Үндсэн хуулийн нэмэлт нөхцөл, шаардлагын хүрээнд хэрэгжүүлэхээр заасан байв.⁴⁹³

Өршөөл ба уучлалын ялгааг тодорхойлох нь: Өршөөл (Amnesty) ба уучлал (Pardon) нь ялын шинжтэй аливаа эрх зүйн үр дагавраас чөлөөлөх зорилготойгоороо нэлээд төстэй учир тэдгээрийг өөр хооронд нь яг таг ялгахад төвөгтэй. Нийтлэг жишгийн үүднээс авч үзвэл өршөөлийг ял шийтгэхээс өмнө

⁴⁹⁰ Тус лавлагааг Шүүхийн мэдээлэл хариуцсан ахлах референт С.Билгүүн, судлаач Л.Галбаатар боловсруулан бэлтгэв.

⁴⁹¹ Jody C. Baumgartner and Mark H. Morris, “Presidential Power Unbound: A Comparative Look at Presidential Pardon Power”, *Politics and Policy*, Vol. 29, No. 2, Jun 2001, p.212

⁴⁹² Мөн тэнд

⁴⁹³ Мөн тэнд

тодорхой категорийн хүмүүс үзүүлэх бол уучлалыг ял шийтгэсний дараа тодорхой хувь этгээдэд үзүүлдэг⁴⁹⁴ гэж ойлгодог. Блейкийн хууль зүйн тайлбарт өршөөл (amnesty) гэдэг нь төрөөс тодорхой бүлэг хүмүүст, ихэвчлэн улс төрийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд үзүүлэх уучлал бөгөөд эрүүгийн ял шийтгэхээс өмнө үзүүлдэг⁴⁹⁵, уучлал (pardon) гэдэг нь эрүүгийн ял шийтгэлийг хэрэгсэхгүй болгох, эрх зүйн үр дагаврыг нь арилгах ойлголт бөгөөд гол төлөв төрийн тэргүүн хэрэгжүүлдэг⁴⁹⁶ гэж тодорхойлжээ. Харин улс үндэстний түвшинд авч үзвэл өршөөл болон уучлалын талаар өөр өөр ойлголт тодорч ирнэ.⁴⁹⁷ Тухайлбал, өршөөлийг (amnesty) нийтлэг уучлал (General Pardon) хэлбэрээр ойлгож хэрэглэдэг улсууд бий. Унгарын Үндсэн хуульд Үндэсний Ассамблей нь нийтлэг уучлалыг үзүүлэх бол Ерөнхийлөгч нь хувь этгээдэд чиглэсэн уучлалыг үзүүлэх эрхтэй байхаар тусгажээ. Эсрэгээр Японы Үндсэн хуульд нийтлэг өршөөл (General Amnesty), тухайлсан өршөөл (Special Amnesty) үзүүлнэ гэж заасан нь бусад улс орнуудын Үндсэн хууль дахь уучлалтай дүйдэг.

Өршөөл (Amnesty): Өршөөл буюу “Amnesty” гэх ойлголт нь Грекийн “amnestia” (мартах) гэсэн үгнээс гаралтай бөгөөд үйлдсэн гэмт хэргийг нь “бүрэн”, “шууд мартах” гэх утгаар хэрэглэдэг. Хууль тогтоох байгууллагын өршөөл нь Франц зэрэг иргэнлэг эрх зүйн орнуудад хэрэглэгдэж байжээ. Өршөөл үзүүлэх нь дараах шинжтэй:

- (1) хууль батлах замаар өршөөл үзүүлнэ.
- (2) өршөөлийг тодорхой нэр заагаагүй хүмүүст буюу хуульд заасан нөхцлөөр хэрэглэдэг.
- (3) Гэмт хэрэг, ялыг тооцохгүй болоход чиглэдэг.

Өршөөлийг улс төр, эдийн засаг, цэргийн үймээн самууны дараа үзүүлэхэд тохиромжтой гэж үздэг.⁴⁹⁸

Уучлал (Pardon): Уучлал буюу “pardon” гэх ойлголтыг эртний Францын эрх зүйд хэрэглэсэн байх бөгөөд латин хэлнээ “perdonare” буюу “чөлөөтэй болгох” гэсэн үгнээс гаралтай. Түүнийг төрийн тэргүүн буюу эзэн, ноёны зүгээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ял шийтгэлээс бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөхөд хэрэглэгддэг. 18 дугаар зуунд Чезаре Беккариа өөрийн “Гэмт хэрэг ба ялын тухай” алдарт бүтээлдээ “уучлал үзүүлэх явдал нь хууль тогтоох болон шүүх эрх мэдлийн алинд ч хамаарахгүй бие даасан эрх мэдэл болжээ” гэж шүүмжилсэн байдаг.

Уучлал үзүүлэх эрх нь ихэнх улсад улс төрийн тэргүүнд хадгалагддаг. 1998 оны байдлаар Европын 46 улсын 32 нь Ерөнхийлөгчтэй байна. Тэдгээр улсын 31-т

⁴⁹⁴ Anja Seibert-Fohr, ‘Amnesties’ in R Wolfrum (ed), “The Max Planck Encyclopedia of Public International Law” (OUP 2012)

⁴⁹⁵ “Black’s Law Dictionary”, 7th Edition, 2004, p. 99

⁴⁹⁶ Мөн толь бичгийн 1230 дугаар талд

⁴⁹⁷ Josepha Close, “[Amnesty Provisions in the Constitutions of the World: A Comparative Analysis](http://www.academia.edu/10231932/Amnesty_Provisions_in_the_Constitutions_of_the_World_A_Comparative_Analysis)”, p. 2, [http://www.academia.edu/10231932/Amnesty Provisions in the Constitutions of the World A Comparative Analysis](http://www.academia.edu/10231932/Amnesty_Provisions_in_the_Constitutions_of_the_World_A_Comparative_Analysis)

⁴⁹⁸ Amnesty and Pardon, Leslie Sebba and Richard s. Frase, “Encyclopedia of Crime and Justice”, Vol. 1, 2002.

<http://find.galegroup.com/gic/infomark.do?&source=gale&idigest=5240efa7b366f5e884b288775e253a14&pr odId=GIC&userGroupName=gale&tabID=T001&docId=CX3403000020&type=retrieve&version=1.0>

нь Ерөнхийлөгч уучлал үзүүлэх асуудлыг Үндсэн хуульдаа тусгасан.⁴⁹⁹ Тэдгээр улсын 19-т нь Ерөнхийлөгч тус бүрэн эрхээ төрийн бусад эрх мэдэлтэй хуваалцахгүй гэжээ. Энэ нь магадгүй 14 Ерөнхийлөгч нь шууд сонгуулиар сонгогддогтой холбоотой. 12 улсад Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгч нь бүрэн эрхээ хуваалцдаг байна. Үүний зургаа нь шууд сонгуулиар, зургаа нь парламентаас сонгогддог.⁵⁰⁰

Хоёр. Зарим улсын үндсэн хуульд тусгасан байдал

Нэгдсэн үндэстний байгууллагын гишүүн 193 орноос 186 улсын Үндсэн хуульд өршөөл, уучлалын талаар ямар нэг хэлбэрээр тусгасан байна. Үүнээс 105 улсын Үндсэн хуульд өршөөл, уучлалыг хоёуланг нь тусгажээ. Эдгээр улсад Аргентин, Бразил, Египт, Франц, Индонези, Итали, Мавритани, Монгол, Нидерланд, Перу, ОХУ, Швейцарь, Тунис, Турк, Украин зэрэг улсууд орно.

Түүнчлэн 77 улс орон үндсэн хуульдаа зөвхөн уучлалын тухай тусгажээ. Эдгээр улсад хамтын нөхөрлөлийн орны 53 улс /Австрали болон Канадыг оролцуулахгүйгээр/, Камерун, Мозамбик, Өмнөд Африк, Афганистан, Герман, БНХАУ, Иран, Непал, Норвеги, Судан, Тайланд, Арабын нэгдсэн Эмират гэх улсууд багтаж байна.

Харин Камбоджи, Гватемаль, Лаос, Монтенегро зэрэг улсад зөвхөн өршөөлийн тухай заажээ. Андорра, Австрали, Босни Герцеговина, Канада, Сири, Саудын Араб, Иемен зэрэг 7 улсын Үндсэн хуульд өршөөл уучлалын талаар тусгаагүй байна.

2.1.Өршөөл, уучлалын талаар дэлхийн улсуудын Үндсэн хуульд тусгасан байдал⁵⁰¹

Өршөөл, уучлалын талаар заасан байдал	Үндсэн хуулийн тоо (Нийт: НҮБ-ын гишүүн 193 улс)
Өршөөл буюу уучлалын талаар заасан	186
Өршөөл ба уучлалын талаар заасан	105
Зөвхөн уучлалын талаар заасан	77
Зөвхөн өршөөлийн талаар заасан	4
Өршөөл, уучлалын алийг нь ч заагаагүй	7
Хууль тогтоох буюу гүйцэтгэх эрх мэдэл	Үндсэн хуулийн тоо (Нийт: НҮБ-ын гишүүн 193 улс)
Өршөөл болон уучлалын талаар заасан	105
Өршөөл = хууль тогтоох эрх мэдэл /	79

⁴⁹⁹ Jody C. Baumgartner, Mark H. Morris. "Presidential Power Unbound: A Comparative Look at Presidential Pardon Power", 2001. p.213 <http://professional.jodyb.net/Pardons.pdf>

⁵⁰⁰ Amnesty and Pardon, Leslie Sebba and Richard s. Frase, "Encyclopedia of Crime and Justice", Vol. 1, 2002.

<http://find.galegroup.com/gic/infomark.do?&source=gale&idigest=5240efa7b366f5e884b288775e253a14&prodId=GIC&userGroupName=gale&tabID=T001&docId=CX3403000020&type=retrieve&version=1.0>

⁵⁰¹ Josepha Close, "Amnesty Provisions in the Constitutions of the World: A Comparative Analysis", 2015 http://www.academia.edu/10231932/Amnesty_Provisions_in_the_Constitutions_of_the_World_A_Comparative_Analysis болон <https://aninternationallawblog.wordpress.com/2015/01/05/amnesty-provisions-in-the-constitutions-of-the-world-a-comparative-analysis/> хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

уучлал = гүйцэтгэх эрх мэдэл	
Өршөөл болон уучлал = гүйцэтгэх эрх мэдэл	13
Өршөөл болон уучлал = хууль тогтоох эрх мэдэл	3
Өршөөл = хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдэл / Уучлал = гүйцэтгэх эрх мэдэл	5
Өршөөл = мэдээлэл байхгүй / Уучлал = гүйцэтгэх эрх мэдэл	5
Зөвхөн өршөөлийн талаар заасан	4
Өршөөл = хууль тогтоох эрх мэдэл	1
Өршөөл = хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдэл	3
Зөвхөн уучлалын талаар заасан	77
Уучлал = гүйцэтгэх эрх мэдэл	77
Өршөөл буюу уучлалын талаар огт заагаагүй	7
Өршөөлтэй холбоотой ангилал	Өршөөлийн талаар заасан Үндсэн хуулиуд (нийт: 109)
Бүрэн хэмжээгээр өршөөх эрх мэдэл	104
Тусгайлан олонхийн шаардлага	14
Өршөөл үзүүлэхэд санал асуулга явуулахгүй	10
Өршөөл хүчин төгөлдөр болох	2
Зөвхөн улс төрийн гэмт хэрэгт өршөөх	9
Өршөөл үзүүлэхгүй гэмт хэрэг	13
=> олон улсын гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй	7

Түүхэн уламжлалын үүднээс авч үзвэл өршөөл, уучлал үзүүлэх нь тухайн улсын бүрэн эрхт байдлын нэг үзүүлэлт болж байв. Орчин цагт уучлал үзүүлэх бүрэн эрхийг гол төлөв төрийн тэргүүнд (Эзэн хаан, ерөнхийлөгч г.м), өршөөл үзүүлэх бүрэн эрхийг хууль тогтоогчдод харьяалуулжээ. Өршөөл, уучлалын талаар үндсэн хуульдаа заасан 105 улс орноос 79 улсад буюу дийлэнхэд нь өршөөлийг хууль тогтоох эрх мэдэлд, уучлалыг төрийн тэргүүний бүрэн эрхэд хамааруулжээ. Үлдсэн 26 улсаас 13 улсад (Бутан, Болив, Чех, Дани, Эритрея, Исланд, Индонез, Япон, Монако, Мьянмар, Словак, Испани, Туркменистан) өршөөл болон уучлал үзүүлэх бүрэн эрхийг гүйцэтгэх эрх мэдэлд харьяалуулжээ. Эсрэгээр Никарагуа, Швейцарь, Уругвай зэрэг улсад эдгээр эрхийг парламентад харьяалуулсан байна.

2.2. Парламент болон гүйцэтгэх эрх мэдэлд хамтад нь харьяалуулсан

№	Улсын нэр	Ерөнхийлөгч	Парламент
1.	Румын	Ерөнхийлөгч нь тус улсын Үндсэн хуульд зааснаар үндэсний тусгаар тогтнол, эв нэгдэл, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын илэрхийлэл,	ҮХ-ийн 73 дугаар зүйлийн 3 (i) хэсэгт зааснаар парламент нь өршөөл буюу олон этгээдийг хамарсан уучлал (amnesty or

		бэлгэ тэмдэг мөн бөгөөд Үндсэн хуулийн 94 дүгээр зүйлийн 94 (1) d хэсэгт зааснаар хувь хүнд хамаарах уучлал (Individual pardon) үзүүлэх бүрэн эрхтэй. ⁵⁰²	collective pardon) үзүүлэх эрхтэй.
2.	Австри	Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн с заалтад зааснаар Ерөнхийлөгч нь давж заалдах бүх шат нь дууссан этгээдэд уучлал үзүүлэх, шүүхээс оногдуулсан ял шийтгэлийг хөнгөрүүлэх, чөлөөлөх, ивээл үзүүлэх (act of grace) эрх зүйн актын хувьд ял шийтгэлийг хүчингүй болгох, ял шийтгэлийн эрх зүйн үр дагавраас чөлөөлөх, эрүүгийн процессын ажиллагаанд байгаа хэргийг хэрэгсэхгүй болгох бүрэн эрхтэй.	93. Шүүхээр шийтгэгдэх нийтлэг хэрэгт үзүүлэх өршөөлийг холбооны хуулиар батална.
3.	Грек	ҮХ 47 дугаар зүйл. 1.Ерөнхийлөгч нь ХЗ-н сайдын саналыг харгалзан шүүгчдийн дийлэнхээс бүрдсэн зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр уучлал (pardon) үзүүлэх, шүүхээс оногдуулсан ялыг бууруулах, хэрэгсэхгүй болгох, ял шийтгэлтэй холбоотой аливаа эрх зүйн үр дагаврыг арилгах эрхтэй. 2. Ерөнхийлөгч энэ хуулийн 86 дугаар зүйлд заасан сайдын холбогдсон хэргийг зөвхөн парламенттай зөвшилцсөний үндсэн дээр уучилна.	ҮХ-ийн 47 дугаар зүйл 3. Өршөөлийг зөвхөн улс төрийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд парламентын нийт гишүүдийн 3/5-ийн саналаар баталсан хуулиар үзүүлнэ. 4. Өршөөлийн хуулийг нийтлэг хэрэгт хамааруулан батлахгүй.
4.	Энэтхэг	72.1 Ерөнхийлөгч нь ял шийтгүүлсэн этгээдэд уучлал үзүүлэх, тэнсэх, хойшлуулах, ял шийтгэлийг хөнгөрүүлэх бүрэн эрхтэй. ⁵⁰³	Тус улсын Үндсэн хуульд парламентад холбогдсон тусгайлсан эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

⁵⁰² Румын улсын Үндсэн хууль

⁵⁰³ Энэтхэг нь муж улсуудаас бүрдсэн төрийн байгууламжтай бөгөөд Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийн 72 дугаар зүйлд заасны дагуу уучлал үзүүлэх бүрэн эрхтэй хэдий ч мөн хуулийн 161 дүгээр зүйлд зааснаар муж улсын захирагч нь адил бүрэн эрхтэй. Ялгаа нь муж улсын захирагч зөвхөн хөнгөн хэргийг уучлах эрхтэй байхад Ерөнхийлөгч бусад хэрэгт уучлалыг үзүүлнэ. Ерөнхийлөгч болон захирагч нь уучлал үзүүлэх бүрэн эрхээ сайд нарын зөвлөлтэй зөвшилцөн тэдний гаргасан зөвлөмжийн хүрээнд уучлал үзүүлэх бөгөөд ингэснээр уучлал нь захиргааны арга хэмжээ болохын хувьдаа шүүхийн хяналтад багтана.

4.	Итали	<p>Үндсэн хуулийн 87 дугаар зүйл Ерөнхийлөгч нь уучлал үзүүлэх, шүүхээс оногдуулсан ял шийтгэлийг хөнгөрүүлж болно.</p> <p>Ерөнхийлөгчийн бусад зарлигийн адилаар тухайн асуудал хариуцсан засгийн газрын гишүүн уучлал үзүүлэх зарлигт гарын үсэг зурах бөгөөд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр энэ засгийн газрын гишүүн нь хууль зүйн сайд байхаар шийдвэрлэжээ.⁵⁰⁴</p>	<p>Үндсэн хуулийн 79 дүгээр зүйл.</p> <p>Өршөөл болон уучлалыг парламентын дээд, доод танхимын нийт гишүүдийн гуравны хоёрын саналыг авсны үндсэн дээр эцсийн санал хураалтаар батална.</p> <p>Энэ хууль нь өршөөл, уучлалыг үзүүлэх хугацааг заасан байна.</p> <p>Хууль батлагдсаны дараа үйлдсэн гэмт хэрэгт өршөөл, уучлал хамаарахгүй.</p>
5.	ХБНГУ	<p>Үндсэн хуулийн 60 дугаар зүйл</p> <p>2. Ерөнхийлөгч нь Холбооны улсын нэрийн өмнөөс хувь этгээдэд уучлал үзүүлж болно.</p> <p>3. Ерөнхийлөгч энэхүү бүрэн эрхээ холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно.</p> <p>Муж улсын хувьд холбооны түвшингийн хэрэгт хамаарахаас бусад бүх хэрэг муж улсын бүрэн эрхэд хамаарах бөгөөд зарим муж улс нь энэ бүрэн эрхийг кабинетэд, дийлэнх мужид мужийн Ерөнхий сайдад олгожээ.</p>	<p>Тус улсын Үндсэн хуульд парламентад холбогдсон тусгайлсан эрх зүйн зохицуулалт байхгүй байна.</p>
6.	Португал ⁵⁰⁵	<p>Үндсэн хуулийн 134 дүгээр зүйлийн f хэсэгт зааснаар Ерөнхийлөгч нь Засгийн газартай зөвлөлдсөний дараагаар гэмт хэрэг болон ялаас уучлал үзүүлэх эрхтэй.</p>	<p>Үндсэн хуулийн 161-р зүйлийн f хэсэгт зааснаар Бүгд найрамдах улсын Ассамблей нь өршөөл болон уучлал үзүүлэх бүрэн эрхтэй.</p>
7.	Польш ⁵⁰⁶	<p>Үндсэн хуулийн 139 дүгээр зүйлд зааснаар Ерөнхийлөгч нь уучлал үзүүлэх бүрэн эрхтэй. Ингэхдээ Төрийн шүүхээс ял шийтгэсэн хувь хүмүүст уучлал үзүүлэхгүй.⁵⁰⁷</p>	<p>Тус улсын Үндсэн хуульд парламентын</p>
8.	Унгар ⁵⁰⁸	<p>Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Ерөнхийлөгч нь</p>	<p>Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт</p>

⁵⁰⁴ Constitutional Court of Italy

⁵⁰⁵ Constitution of the Portuguese republic seventh revision [2005]

⁵⁰⁶ The Constitution of the Republic of Poland of 2nd April, 1997

⁵⁰⁷ Төрийн шүүх нь тус улсын Үндсэн хуулийн 198 дугаар зүйлд заасны дагуу Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Сайд нарын зөвлөлийн гишүүд, Төв банкны Ерөнхийлөгч, Хяналтын дээд зөвлөлийн Ерөнхийлөгч, Радио телевизийн зөвлөлийн гишүүд, Ерөнхий сайдаас яамны асуудлыг хариуцуулсан албан тушаалтнууд, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч нарын албан тушаалын бүрэн эрхийн хугацаанд Үндсэн хууль, бусад хууль зөрчсөн зөрчлийг хянан шийдвэрлэх харьяалалтай.

⁵⁰⁸ Hungary's Constitution of 2011

		хувь хүнд уучлал үзүүлэх бүрэн эрхтэй.	зааснаар Үндэсний Ассамблей нь өршөөл үзүүлэх бүрэн эрхтэй.
9.	Финлянд ⁵⁰⁹	Үндсэн хуулийн 105 дугаар зүйлд зааснаар Ерөнхийлөгч нь Дээд шүүхээр дамжуулан хүсэлт ирсэн тохиолдолд хувь хүний үйлдсэн гэмт хэрэгт шүүхээс оногдуулсан ялаас бүрэн болон хэсэгчлэн уучлал үзүүлж болно.	Үндсэн хуулийн 105-р зүйлд зааснаар өршөөлийг зөвхөн хууль батлах замаар үзүүлнэ.
10.	Франц	Үндсэн хуулийн 17-р зүйлд зааснаар Ерөнхийлөгч хувь хүнд уучлал үзүүлэх бүрэн эрхтэй.	Үндсэн хуулийн 34-р зүйлд зааснаар өршөөл үзүүлэх нь хууль тогтоох эрх мэдлийн байгууллагад хамаарна.

2.3. Өршөөл, уучлал үзүүлэх бүрэн эрхийг зөвхөн гүйцэтгэх эрх мэдэлдээ харьяалуулдаг улсын жишээ

№	Улсын нэр	Ерөнхийлөгч	Парламент
1.	Туркменистан	Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн бөгөөд Үндсэн хуулийн 53 дугаар зүйлийн 12 дугаар хэсэгт Ерөнхийлөгч нь уучлал (Pardon), өршөөл (Amnesty) үзүүлэх бүрэн эрхтэй	Өршөөлийн талаар тус улсын Үндсэн хуулийн парламентад (Mejilis)-т холбогдох бүрэн эрхийг тусгаагүй.
2.	Испани ⁵¹⁰	Испанийн вант улсын эзэн хаан нь төрийн тэргүүний үүргийг гүйцэтгэх бөгөөд Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн (i) хэсэгт зааснаар Эзэн хаан нь хуулийн дагуу өршөөл+уучлал үзүүлэх бүрэн эрхтэй боловч нийтлэг байдлаар батлахгүй гэжээ.	Өршөөлийн талаар тус улсын Үндсэн хуулийн парламентад холбогдох бүрэн эрхийг тусгаагүй.
3.	Словакийн БНУ ⁵¹¹	Тус улсын Үндсэн хуульд заасны дагуу төрийн тэргүүн нь Ерөнхийлөгч бөгөөд мөн хуулийн 102 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхийлөгч нь өршөөл (Amnesty), уучлал (pardon) үзүүлэх, шүүхээс оногдуулсан ял шийтгэлийг хөнгөрүүлэх, эрүүгийн хэрэг үүсгэхгүй эсхүл үргэлжлүүлэн шалгахгүй байх талаар зарлиг гаргаж болно.	Өршөөлийн талаар тус улсын Үндсэн хуулийн парламентад холбогдох бүрэн эрхийг тусгаагүй.
4.	Мьянмар	Төрийн тэргүүн нь Ерөнхийлөгч бөгөөд Үндсэн хуулийн 204 дүгээр	Өршөөлийн талаар тус улсын Үндсэн хуулийн парламентад

⁵⁰⁹ The Constitution of Finland 11 June 1999

⁵¹⁰ Spanish Constitution, 1978

⁵¹¹ The Constitution of The Slovak Republic

		зүйлд заасны дагуу уучлал үзүүлэх, Үндэсний батлан хамгаалах, аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн дагуу өршөөл үзүүлэх бүрэн эрхтэй.	холбогдох бүрэн эрхийг тусгаагүй.
5.	Монако	Үндсэн хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Эзэн хааны зөвлөлтэй зөвлөлдсөний дагуу Хунтайж (Prince) нь уучлал, өршөөл үзүүлэх, гадаадын иргэн харьяалалгүй этгээдийг иргэний харьяалалд авах бүрэн эрхтэй.	Өршөөлийн талаар тус улсын Үндсэн хуулийн парламентад холбогдох бүрэн эрхийг тусгаагүй.
6.	Япон	Япон улсын эзэн хаан нь төрийн тэргүүн байх бөгөөд Үндсэн хуулийн 7 дугаар зүйлд зааснаар эзэн хаан нь ерөнхий болон тусгайлсан өршөөл үзүүлэх, ял шийтгэлийг хөнгөрүүлэх, ялаас тэнсэх, эрхийг сэргээх Засгийн газрын шийдвэрийг батлах бүрэн эрхтэй. Үндсэн хуулийн 73 дугаар зүйлд зааснаар Засгийн газар нь ерөнхий болон тусгай өршөөл үзүүлэх, ял шийтгэлийг хөнгөрүүлэх, ялаас тэнсэх, эрхийг нь сэргээх асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй.	Өршөөлийн талаар тус улсын Үндсэн хуулийн парламентад холбогдох бүрэн эрхийг тусгаагүй.
7.	Филиппин	7 дугаар зүйлийн 19 дүгээр хэсэгт зааснаар импичментээс бусад хэрэгт шүүхийн шийдвэрээр ял шийтгүүлсэн этгээдэд Ерөнхийлөгч уучлал үзүүлэх эрхтэй. Мөн Ерөнхийлөгч нь Конгрессын нийт гишүүний олонхийн зөвшилцлийн үндсэн дээр өршөөл үзүүлэх эрхтэй. ⁵¹²	Өршөөлийн талаар тус улсын Үндсэн хуулийн парламентад холбогдох бүрэн эрхийг тусгаагүй.
8.	Индонез	Үндсэн хуулийн 14-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Ерөнхийлөгч нь Дээд шүүхийн саналыг харгалзан уучлал үзүүлж болно. 2 дахь хэсэгт зааснаар Ерөнхийлөгч нь хууль тогтоох байгууллагын саналыг харгалзан өршөөл үзүүлж болно. ⁵¹³	-
9.	Бутан	Үндсэн хуулийн 2-р зүйлийн 16 дахь хэсэгт зааснаар Төрийн тэргүүн буюу Хаан нь өршөөл болон уучлал	-

⁵¹² The Constitution of Philippines 1987

⁵¹³ The Constitution of Indonesia 1945 (reinst. 1959, rev. 2002)

		үзүүлэх, ял шийтгэлийг бууруулах эрхтэй. ⁵¹⁴	
10.	Боливи	Үндсэн хуулийн 172-р зүйлийн 14 дэх хэсэгт зааснаар Ерөнхийлөгч нь хууль тогтоох байгууллагын зөвшөөрснөөр буюу баталснаар уучлал болон өршөөл үзүүлэх эрхтэй. ⁵¹⁵	-
11.	Чех	Үндсэн хуулийн 62-р зүйлийн “g”-д зааснаар Ерөнхийлөгч нь уучлал үзүүлэх эрхтэй. Мөн 63-р зүйлийн 1 дэх хэсгийн “к”-д зааснаар Ерөнхийлөгч нь өршөөл үзүүлэх эрхтэй. ⁵¹⁶	-
12.	Дани	Үндсэн хуулийн 3 дахь хэсгийн 24-т зааснаар Хаан нь уучлал болон өршөөл үзүүлнэ. Мөн хаан нь зөвхөн хууль тогтоох байгууллагын зөвшөөрснөөр Дээд шүүхээс ял шийтгэл ногдуулсан сайд нарт уучлал үзүүлж болно. ⁵¹⁷	-
13.	Исланд	Үндсэн хуулийн 29-р зүйлд зааснаар Ерөнхийлөгч нь онцгой шалтгаан байгаа бол гэмт хэрэг дэх прокурорын ажиллагааг зогсоож болох шийдвэр гаргаж болно. ⁵¹⁸ Мөн Ерөнхийлөгч нь уучлал болон өршөөл үзүүлэх эрхтэй. Гэхдээ парламент зөвшөөрөөгүй тохиолдолд прокурорын ажиллагаанд байгаа эсхүл Импичментийн шүүхээс ял оногдуулсан сайд нарт уучлал үзүүлэх асуудлыг шийдвэрлэхгүй.	-
14.	Эритрей	Үндсэн хуулийн 42-р зүйлийн 12 дахь хэсэгт зааснаар Ерөнхийлөгч нь 27-р зүйлийн (5)(b)-д зааснаар уучлал болон өршөөл үзүүлэх бүрэн эрхтэй. 27-р зүйлийн (5)(b)-д уучлал болон өршөөл үзүүлэхэд хууль батлах шаардлагагүй гэжээ. ⁵¹⁹	-

Гурав. Нэмэлт мэдээлэл

Өршөөл, уучлалын ялгаа

⁵¹⁴ The Constitution of Bhutan 2008

⁵¹⁵ The Constitution of Bolivia (Plurinational State of) 2009

⁵¹⁶ The Constitution of Czech Republic 1993 (rev. 2013)

⁵¹⁷ The Constitution of Denmark 1953

⁵¹⁸ Constitution of Iceland 1944

⁵¹⁹ Eritrea 1997 https://www.constituteproject.org/constitution/Eritrea_1997?lang=en

- Өршөөлийг хэсэг бүлэг хүмүүст ерөнхийд нь хэрэглэгддэг бол уучлал нь хувь хүмүүст хэрэглэнэ.
- Уучлалыг гүйцэтгэх засгийн тэргүүн буюу ерөнхийлөгчийн зүгээс хувь хүний үйлдсэн гэмт хэргийн ялаас уучлахад хэрэглэнэ.
- Өршөөлийг гэмт хэргээс хэлтрүүлэхэд хэрэглэх бол уучлалыг нигүүлсэхэд хэрэглэнэ.
- Өршөөлийг улс төрийн нөхцөл байдалтай холбоотойгоор буюу улс төрийн хүчний оролцоотойгоор хэрэглэнэ.
- Уучлалыг гэмт хэрэгтэнд оногдуулсан ялаас багасгахад хэрэглэнэ.
- Уучлалыг ял шийтгүүлсэн гэмт хэрэгтэнд үзүүлэх бол өршөөлийг үзүүлэх этгээд нь ял шийтгүүлээгүй байж болдог.⁵²⁰

-oOo-



⁵²⁰ Difference between Amnesty and Pardon, 2013 <http://www.differencebetween.com/difference-between-amnesty-and-vs-pardon/>

ШҮҮХ ХУРАЛДААНЫ ЯВЦЫГ ОЛОН НИЙТЭД ШУУД ДАМЖУУЛАХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА⁵²¹

Оршил

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг дамжуулах буюу 'trial by media' гэх ойлголт нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийгэмд үзүүлэх нөлөө нэмэгдсэнтэй холбоотой байдаг.⁵²²

Шүүх хуралдааны бичлэгийг телевиз, радио зэрэг олон нийтийн хэвлэл мэдээлэл, социал медиагаар шууд дамжуулах асуудал нь ховор тохиолддог хэдий ч зарим тохиолдолд шүүгчийн шийдвэрээр шүүх хуралдааныг олон нийтэд шууд дамжуулахыг тодорхой нөхцөл, хязгаарлалтын хүрээнд зөвшөөрдөг байна. Ихэнх тохиолдолд шүүгчид "нээлттэй шүүх"⁵²³ зарчмыг цахим хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөнөөр дамжуулан, сурталчлах асуудалд болгоомжилсон байр суурьнаас ханддаг. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг шууд дамжуулах нь шүүх хуралдааны хэргийн оролцогчид ялангуяа эрүүгийн хэргийн гэрч, хохирогч, хариуцагч, иргэдийн төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангаж, хамгаалах үүднээс шүүх хуралдааны явцыг иргэд, олон нийтэд шууд нэвтрүүлэхийг зөвшөөрдөггүй байна. Түүнчлэн олон нийтийн шүүхэд итгэх итгэлд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой гэсэн эргэлзээтэй мөн холбоотой байдаг.

Тус лавлагаанд Европын зөвлөлийн 2003/13 тоот "Эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах тухай" зөвлөмж, АНУ, Япон, БНСУ, Их Британи, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах зэрэг улсын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шүүх хуралдааныг дамжуулах эрх зүйн зохицуулалт болон туршлагыг авч үзлээ.

Нэг. Европын зөвлөлийн зохицуулалт⁵²⁴

Европын зөвлөл нь 1949 онд байгуулагдсан олон улсын байгууллага бөгөөд 47 гишүүн улстай. Үүнээс 27 улс нь Европын холбооны гишүүн улс юм.⁵²⁵ Европын зөвлөлийн сайд нарын хороо нь тус зөвлөлийн шийдвэр гаргах байгууллага бөгөөд 47 гишүүн улсын гадаад хэргийн сайд нараас бүрддэг. Сайд нарын хорооны шийдвэр нь түүнийг гишүүн улсууд соёрхон батлах буюу зөвлөмжийг засгийн

⁵²¹ Тус лавлагааг ШСМСХ-ийн судлаач Г.Солонго, Б.Ариунзаяа, Л.Галбаатар нар боловсруулан бэлтгэв.

⁵²² Effect of trial by media before courts

<http://www.lawteacher.net/free-law-essays/commercial-law/effect-of-trial-by-media-before-courts-law-essay.php>

⁵²³ Нийтийн эрх зүйд 'open court' буюу "нээлттэй шүүх" гэдэгт олон нийт шүүх хуралдааныг нээлттэй байлгах эрхтэй холбон ойлгодог. Тодруулбал, шүүхийн үйл ажиллагаа нь түүнийг ажиглагч этгээдэд чөлөөтэй, нээлттэй байх нээлттэй шүүхийн шинжийг ойлгоно. (West's Encyclopedia of American Law, edition 2. Copyright 2008 The Gale Group, Inc.

<http://legal-dictionary.thefreedictionary.com/Open+Court>).

⁵²⁴ Тус бүлгийг ШСМСХ-ийн судлаач Л.Галбаатар боловсруулан бэлтгэсэн болно.

⁵²⁵ The Council of Europe in brief <http://www.coe.int/en/web/about-us/our-member-states>

газрууд хэрэгжүүлэх байдлаар гишүүн улсуудын заавал дагаж мөрдөх хэм хэмжээ болдог.⁵²⁶

Европын зөвлөлийн сайд нарын хорооноос 2003.07.10-ны өдөр баталсан 2003/13 тоот “**Эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах тухай**” зөвлөмжид гишүүн орнууддаа хандан гурван зүйлийг тэмдэглэсэн байдаг. Үүнд:

1. Үндсэн хуулийн зүйл, заалттай зөрчилдөхгүйгээр буюу түүний хязгаарлалтын хүрээнд энэ зөвлөмжийн хавсралтаар баталсан зарчмыг хэрэгжүүлэх шаардлагатай бүх арга хэмжээг авах;
2. Энэхүү зөвлөмж болон түүний хавсралтаар оруулсан зарчмыг зохих ёсоор орчуулан өргөн хүрээнд түгээх;
3. Энэхүү зөвлөмж болон түүний хавсралтаар оруулсан зарчимд шүүхийн эрх бүхий байгууллага болон цагдаагийн алба, хуульчдын төлөөллийн байгууллага, хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдийн анхаарлыг хандуулах.

“Эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах тухай” зөвлөмжийн хавсралтаар орсон зарчим нь 18 зүйлтэй⁵²⁷ бөгөөд үүнийг хавсралт №3 дэлгэрэнгүй үзнэ үү.

Энэхүү зөвлөмжийг нээлттэй шүүхийн эрх зүйн асуудлыг нэг бүрчлэн, дэлгэрэнгүй тодорхойлсон олон улсын эрх зүйн баримт бичиг гэж үзэж болохоор байна. Тус зөвлөмжөөс харахад нээлттэй шүүх нь зөвхөн шүүх хуралдааныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах эсэх асуудлаас илүү өргөн агуулгатай бөгөөд шүүх, цагдаагийн алба ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн зохистой харьцааг хангах, ингэхдээ хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх тухай үзэл санаа юм.

Хоёр. Гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт, туршлага⁵²⁸

1. АНУ

Сүүлийн жилүүдэд Конгресс, олон нийт болон хэвлэл мэдээллийн төлөөлөгчдийн дунд Дээд шүүх болон бусад Холбооны шүүхийн хуралдааныг телевиз болон электрон хэрэгслээр дамжуулан үзүүлэх асуудлыг дэмжих болсон. Хэдийгээр Дээд шүүхээс шүүх хуралдааныг цахим хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулан үзүүлэхийг зөвшөөрч байгаагүй ч шүүхээс өөрийн цахим хуудсаар санал болон мэтгэлцээний бичвэр тэмдэглэлийг хэвлүүлж ирсэн⁵²⁹. Олон нийт нь шүүхээс Үндэсний архивт хүлээлгэн өгсөн мэтгэлцээний бичлэг болон шүүхийн шийдвэрийг авч ашиглах боломжтой байдаг.⁵³⁰ Одоогийн байдлаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх Холбооны улсын 53 дугаар дүрмийн дагуу

⁵²⁶ About the Committee of Ministers http://www.coe.int/T/CM/aboutCM_en.asp

⁵²⁷ Recommendation Rec (2003)13 of the Committee of Ministers to member states on the provision of information through the media in relation to criminal proceedings (*Adopted by the Committee of Ministers on 10 July 2003 at the 848th meeting of the Ministers' Deputies*) <https://wcd.coe.int/ViewDoc.jsp?id=51365>

⁵²⁸ Тус бүлгийг ШСМСХ-ийн судлаач Г.Солонго, Япон улсын эрх зүйн зохицуулалт, туршлагыг судлаач Б.Ариунзаяа бэлтгэсэн болно.

⁵²⁹ АНУ-ын Дээд шүүхээс долоо хоног бүрийн сүүлээр тус шүүхийн цахим хуудасд байршуулдаг http://www.supremecourt.gov/oral_arguments/argument_audio.aspx

⁵³⁰ Lorraine H.Tong, “Televising Supreme Court and other Federal Court Proceedings: Legislation and Issues” (November 8, 2006) <<https://www.fas.org/sgp/crs/secretary/RL33706.pdf>>.

эрүүгийн хэргийн холбооны шүүх хуралдааны зургийг авах, бичлэг хийж нэвтрүүлэхийг хориглодог⁵³¹ бол АНУ-ын Шүүхийн зөвлөгөөн /US Judicial Conference/ нь дүүргийн эрүү, иргэний хэргийн шүүх хуралдааны бичлэг хийх, телевизээр нэвтрүүлэхийг хориглодог. Гэхдээ Шүүхийн зөвлөгөөний бодлогоор давж заалдах шатны шүүх тус бүр нь өөрийн шүүх хуралдааныг телевизээр эсхүл бусад цахим хэрэгслээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгож болдог байна. Хэдийгээр Дээд шүүхийн болон бусад Холбооны шүүх хуралдааны бичлэгийг хийх зөвшөөрөл олгох талаар хууль тогтоомжийн төслийг Конгресст өргөн мэдүүлсэн боловч одоогоор батлагдаагүй байна.

Дээр дурдсанчлан АНУ-д шүүх хуралдааныг, нэн ялангуяа, эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг шууд дамжуулан нэвтрүүлэхийг хориглосон байдаг.⁵³² 1994 онд О'Жэй Симпсоны хэргийн шүүх хуралдааныг шууд дамжуулсан явдлыг ихэнх шүүгчид шүүхийн тогтолцоонд сөргөөр нөлөөлсөн, шүүхийн нэр хүндийг олон нийтийн дунд унагаж, шүүхэд итгэх иргэд, олон нийтийн итгэлийг бууруулсан гээд шүүгчид хуралдааны танхимд камер оруулж, бичлэг хийхийг хориглох шийдвэр гаргажээ.⁵³³

2010 оны 9 дүгээр сард Америкийн Шүүхийн зөвлөгөөнөөс “Холбооны болон тойргийн шүүхийн зарим төрлийн иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны видео бичлэгийг олон нийтэд дамжуулснаас үүсэх сөрөг үр нөлөөг үнэлэх туршилтын төсөл”-ийг баталсан. Энэ төсөл нь гурван жилийн хугацаатайгаар 2011 оны 7 дугаар сараас эхлэн хэрэгсэн бөгөөд төслийн хүрээнд дараах дүүргийн холбооны болон тойргийн шүүхүүдэд туршилт хийгдэж байна.⁵³⁴ Үүнд: (1) Алабама дундад дүүрэг, (2) Калифорнийн хойд дүүрэг, (3) Флорида мужийн өмнөд дүүрэг, (4) Гуам дүүрэг, (5) Иллинойс мужийн хойд дүүрэг, (6) Айова Өмнөд дүүрэг, (7) Канзас дүүрэг, (8) Массачусетс дүүрэг, (9) Миссури зүүн дүүрэг, (10) Небраскагийн дүүрэг; (11) Охайо мужийн хойд дүүрэг, (12) Охайо мужийн өмнөд дүүрэг; (13) Теннесси муж баруун дүүрэг, (14) Вашингтоны баруун дүүрэг зэрэг болно.⁵³⁵

2. Япон улс

Япон улсын Үндсэн хуулийн 2 дугаар зүйлд шүүх хуралдаан нээлттэй байх зарчмыг тусгасан байна. Энэ зарчим нь ихэвчлэн хаалттайгаас бусад шүүх хуралдааны явцыг үзэж сонирхох эрхийг иргэдэд олгосноор хэрэгждэг. Шүүх хуралдааны танхимд сонсогч иргэдэд зориулсан суудал байдаг бөгөөд иргэд

⁵³¹ “Холбооны дүрэм 53. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа: Шүүх хуралдааны танхимд гэрэл зураг авах болон шууд нэвтрүүлэг хийхийг хориглоно. Энэ хууль болон өөр бусад хууль тогтоомжид

зааснаас бусад тохиолдолд шүүх хурал, шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг шууд нэвтрүүлэхийг хориглоно.”

<http://federalevidence.com/pdf/2010/CamerasICt/Cameras_Fed_R_Crim_P_53.pdf>

⁵³² Rule 53. Courtroom Photographing and Broadcasting Prohibited

https://www.law.cornell.edu/rules/frcrmp/rule_53

⁵³³ O. J. Simpson murder case https://en.wikipedia.org/wiki/O._J._Simpson_murder_case

⁵³⁴ Cameras And Electronic Devices In The Federal Courtroom <http://federalevidence.com/node/1345>

⁵³⁵ Энэ туршилтын төслийн тайлан болон холбогдох материалыг дараах холбоосоос харж болно. <http://federalevidence.com/node/1345/>.

хүсэлт гаргаснаар шүүх хуралдааны явцыг ажиглах, үзэх боломжтой байдаг. Энэ тохиолдолд шүүх хуралдааны явцад ямар нэгэн зураг авах, бичлэг хийхийг хориглодог бөгөөд хэрэв зураг авах, бичлэг хийх бол Ерөнхий шүүгчээс зөвшөөрөл авах ёстой. Япон улсын хууль тогтоомжид шүүх хуралдааны явцыг зураг авч, дүрсэд буулгах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон телевизээр нэвтрүүлэх, интернетээр цацах зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулсан зохицуулалт байхгүй байна. Гэхдээ энэ асуудлыг зохицуулсан эрх зүйн зохицуулалт шаардлагатай хэвээр байна.

Анх шүүх хуралдааны үеэр бичлэг хийх, зураг авах, хэвлэл мэдээллээр нэвтрүүлэх явдлыг зөвшөөрдөг байсан боловч тухайн үеийн бичлэгийн камер, дагалдах хэрэгсэл нь овор ихтэй, дуу чимээтэй байсны улмаас шүүх хуралдаанд ихээхэн саад болдгийн улмаас хориглогдох болжээ. 1945 онд нэгэн шүүх хуралдаанаар маш олон камер, хэрэгслийн дундаас гэрэлтүүлэгч багаж нь хугарч шүүгчийн дээр унаж гэмтээсэн байна. Үүнээс эхэлж шүүх хуралдааны танхимд хэвлэл мэдээллийнхнийг оруулж бичлэг хийх, зураг авахыг зарчмын хувьд хориглож эхэлжээ.⁵³⁶

Шүүх хуралдааны явцын тухай бичлэг хийхдээ Ерөнхий шүүгчээс зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд бичлэг хийх хэвлэл мэдээллийн төлөөлөгч нь энэ асуудлыг урьдаас зохицуулж, зохих зөвшөөрлийг авсан байна. Нэг хуралд нэг л хүнд бичлэг хийхийг зөвшөөрөх бөгөөд жижиг оврын мэргэжлийн камер 1 ширхгийг л хуралдааны танхимд оруулна. Үүнээс өөр тоног төхөөрөмжүүд болох гэрэлтүүлэгч, дуу хураагуур, шууд дамжуулах хэрэгсэл зэргийг шүүх хуралдааны танхимд авч орохыг хориглоно.

Эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд гагцхүү хохирогч байхгүй үед бичлэгийг хийж болно. Бичлэг хийх этгээд нь үзэгчдийн суудал талаас бичлэгийг хийнэ. Гагцхүү шүүгч, шүүгчдийн суудал, оролцогчдын суудал зэргийг дүрс бичлэгт буулгаж авахыг зөвшөөрнө. Шүүх хуралдааны бичлэг хийхэд дараах зүйлсийг хориглоно:

- шүүгчээс өөр шүүх хуралдааны оролцогчдын дүрс бичлэг, зургийг авахыг хориглоно;
- үзэгчдийн суудлаас үзэж сонирхож буй бусад этгээдүүдийн дүрс бичлэг, зургийг авахыг хориглоно;
- шүүх хуралдааны оролцогчдын дүрс бичлэг, зургийг авахыг хориглоно.

Зураг авах, бичлэг хийх зөвшөөрөл авсан этгээд нь шүүгчийг энэ ажиллагааг дуусгахыг шаардсаны даруйд бичлэг, зураг авалтаа шууд дуусгаж, шүүх хуралдааны танхимыг орхиж гарна.⁵³⁷ Бичлэг хийх хугацаа нь 2 минут байх бөгөөд энэ хугацаанд гагцхүү шүүгч танхимд орж ирэх, шүүх хуралдаан эхэлснийг зарлах хүртэлх хугацааг багтаана. Бичлэг хийх 2 минутын хугацаа нь дуусмагц бичлэг, зураг авалтыг нэн даруй зогсоох үүрэгтэй. Харин шүүх хуралдааныг үзэж сонирхсон этгээдээс яриа авах, болсон үйл явдлын тухай асууж болно.

⁵³⁶ でもなぜ”イラスト”でしか法廷の様子を見ることが出来ないの？

<http://matome.naver.jp/odai/2142362426613701801>

⁵³⁷ 法廷内カメラ取材の標準的な運用基準

http://www.pressnet.or.jp/statement/report/910101_88.html

Түүнчлэн шүүх хуралдааны сүүлийн хэсгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж болно. Сүүлийн үед шүүх хуралдааныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх нь шүүхийн нээлттэй байх зарчмыг бодитоор хэрэгжүүлэх явдал болж байна гэдэгтэй санал нэгдэх хуульчдын тоо нэмэгдэж байна.⁵³⁸

3. БНСУ

БНСУ-ын Шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1-5 дугаар хэсгүүдэд шүүх хуралдааныг олон нийтэд шууд нэвтрүүлэх талаар тодорхой зохицуулжээ.⁵³⁹ Зарчмын хувьд шүүх хуралдаан ил тод, олон нийтэд нээлттэй байх ёстой боловч энэ нь аль шүүхэд хэргээ шийдвэрлүүлж байгаагаас ихээхэн хамааралтай байна. Тухайлбал, эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг зураг, дүрс бичлэгт буулгахдаа хэргийн оролцогчдын нэр болон дүрсийг нууцлалгүйгээр олон нийтэд мэдэгдэж, нэвтрүүлсэн тохиолдолд энэ алдааг гаргасан аливаа этгээд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байдаг.

Шүүгч дараах тохиолдолд олон нийтэд шүүх хуралдааныг шууд нэвтрүүлэхийг зөвшөөрч болно. Үүнд, шүүхийн аюулгүй байдал, нийгмийн хэв журамд онцгой аюул учирч болзошгүй гэж үзсэн тохиолдолд шүүгч шүүх хуралдааныг хаалттай зарлах бөгөөд энэ тохиолдолд шүүх хуралдааныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд нэвтрүүлж болдог байна. Энэ тохиолдолд шүүгч олон нийтэд шүүх хуралдааныг хаалттай явуулж буй шалтгаанаа тодорхой тайлбарлах ёстой байдаг. Учир нь шүүхийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй байгааг мэдэх нь ард түмний үндсэн эрх юм.⁵⁴⁰

2015 оны 9 дүгээр сарын 18-нд БНСУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Янг Сунг-тэ нь “Супермаркетын ажиллах цагийн хуваарийн хязгаарлалтын талаарх шүүх хурал”-ыг шууд нэвтрүүлэхээр шийдвэр гаргасан байна. Тус шүүх хурлыг Дээд шүүхийн цахим хуудас, цахим портал “Naver”-ээр болон шууд нэвтрүүлж, Солонгосын үндэсний телевизээр нэвтрүүлсэн байна. БНСУ-ын Дээд шүүхээс шүүх хуралдааны явцыг шууд нэвтрүүлэх нь иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэхээс гадна олон нийтийн зүгээс шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай танилцах боломжийг олгоно гэж үзжээ. Улмаар БНСУ-ын Дээд шүүхээс иргэд, олон нийтэд шүүхийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод явуулах үүднээс тодорхой хэргүүдийн шүүх хуралдааныг шууд нэвтрүүлж байхаар болсон байна.⁵⁴¹

4. Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах улсын /ӨАБНУ/ Үндсэн хуулийн үндсэн хэсгийн 16, тэр дундаа 16 (1) (а)-д хүн бүр хэвлэл болон бусад хэвлэл мэдээллийн эрх чөлөөг багтаасан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, түүнчлэн мэдээлэл, үзэл санаа, хүлээн авах / эсвэл түгээх эрх чөлөөг баталгаажуулсан байна.⁵⁴² ӨАБНУ-ын

⁵³⁸ 情報公開訴訟とインカメラ審理

http://www.sangiin.go.jp/japanese/annai/chousa/rippou_chousa/backnumber/2010pdf/20100701090.pdf

⁵³⁹ General principles of the Court http://united-korea.org/code_judicial/article_0310.htm

⁵⁴⁰ Supreme court of Korea http://united-korea.org/code_judicial/article_0310.htm

⁵⁴¹ <http://eng.scourt.go.kr/eboard/NewsListAction.work?gubun=41&pr=1>

⁵⁴² Constitution of the Republic of South Africa, 1996 - Chapter 2: Bill of Rights

эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 152 дугаар зүйлд “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид зааснаас /Хүүхдийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн хэргийг шаардлагатай тохиолдолд хаалттай шүүх хуралдаанаар явуулдаг/ бусад тохиолдолд нээлттэй хуралдаан хийж болно” гэж заасан байна.⁵⁴³ Хэдий тийм боловч шүүх хуралдааныг шууд нэвтрүүлэх асуудал дээр тухайн хэвлэл мэдээллийн агентлаг түүний төлөөлөгч нь Өмнөд Африкийн Дээд шүүхийн шүүгчид хүсэлт гаргадаг бөгөөд шүүх хуралдааны аль хэсгийг шууд нэвтрүүлэх аль хэсгийг нь нэвтрүүлэхгүй байх зэрэг асуудлыг тухайн шүүх хурлыг даргалж буй шүүгч, ерөнхий прокурор мөн тухайн хэргийн яллагдагч нар харилцан зөвшилцсөний үндсэн дээр шүүгч шийдвэр гаргадаг байна. Шүүгч шийдвэртээ яагаад тухайн шүүх хуралдааныг шууд нэвтрүүлэх болсон шалтгаан, үндэслэлээ маш нарийн тусгадаг байна. Эрүүгийн хэргийн шүүх хурлыг олон нийт болон дэлхий дахинд нээлттэй CNN, BBC болон бусад мэдээллийн сувгаар цацсан шүүх хурал бол 2012 оны Лондонгийн Паралимпийн гүйлтийн аварга Өмнөд Африкийн Бүгд Найрамдах улсын иргэн Оскар Писториусын хүн амины гэмт хэрэгт сэжиглэгдсэн хэрэг юм. Оскар Писториусын шүүх хуралдааныг олон нийт, дэлхий дахинд шууд нэвтрүүлэхийг зөвшөөрсөн шүүгч Токозиль Масипа шийдвэртээ дараах үндсэн эрх болон хязгаарлалтуудыг тусгасан байна.

Үүнд: Үндсэн хуулийн эрхийг хангах - Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх , - Шударга шүүхээр шүүлгэх эрх - Шүүх хуралдаан нээлттэй байх зарчим, - Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хэрэгжүүлэх эрхүүдийг ханган шүүх хурлыг бүрэн дуу-хязгаарлагдмал дүрс бичлэг дуу болон дүрс зургийн хэлбэрээр цацахыг зөвшөөрсөн байна.⁵⁴⁴

Дээр дурдсан улсуудын практикаас харахад шүүх хуралдааны явцыг зураг болон дүрс бичлэгт буулган авч, олон нийтийн дунд нэвтрүүлэх явдлыг сүүлийн үед дэмжих хандлагатай байна. Харин шүүх хуралдааны хэргийн оролцогчдын хувь хүний нэр хүнд, нууц, шүүхийн аюулгүй байдлыг хангах зэрэг зорилгоор хуулийн хүрээнд шүүгч шийдвэртээ тодорхой үндсэн эрхийг ханган мөн тодорхой хязгаарлалтуудыг маш нарийн тусгаж шүүх хуралдааныг шууд нэвтрүүлэхийг зөвшөөрдөг байна.

-oOo-

<http://www.gov.za/documents/constitution/chapter-2-bill-rights#16>

⁵⁴³ Criminal procedure act 51 of 1977 <http://www.justice.gov.za/legislation/acts/1977-051.pdf>

⁵⁴⁴ South Africa: North Gauteng High Court, Pretoria
<http://www.saflii.org/za/cases/ZAGPPHC/2014/37.html>

ШҮҮГЧИЙН АЖЛЫН АЧААЛЛЫГ ТООЦОХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА⁵⁴⁵

Дэлхийн улсуудын шүүхийн байгууллага шүүхийн үйлчилгээг олон нийтэд бүрэн чанартай хүргэхийн тулд шүүхийн хүний нөөцийг зохистой хуваарилах аргыг хайсаар байна. Шүүх, шүүгчийн ажлын ачаалал, шүүхийн үйлчилгээг чанаржуулах хэрэгцээ тогтмол нэмэгдэж байгаа ч, шүүхийн зардлыг бууруулах, хэмнэх асуудал байнга тулгарч байна.⁵⁴⁶ Тухайлбал, АНУ, ХБНГУ зэрэг өндөр хөгжилтэй улс орнууд шүүхийн хүний нөөцийг хэрхэн үр дүнтэй бүтээмжтэй, зарцуулахын тулд жил бүр тодорхой давтамжтайгаар шүүхүүдэд хэргийн ачааллын судалгааг хийж байдаг.

Шүүхэд ирж буй нийт хэргийн хэмжээгээр эсхүл тухайн тойрог, дүүргийн хүн амын тоотой харьцуулан тооцоолох замаар шүүхийн хүний нөөцийн зохистой хэрэгцээг тодорхойлох аргачлалыг ихэнх улс орон түгээмэл хэрэглэж байна. Энэ нь хэдийгээр харьцангуй хялбар аргачлал болов ч шүүхийн хүний нөөцийн хэрэгцээ, шүүгчийн ажлын ачааллыг нарийвчлан тооцон гаргадаггүй. Шүүхэд ирж буй нэхэмжлэл, хэрэг нь маргааны төрөл, хэргийн ээдрээ төвөгтэй байдал, хэргийн оролцогчдын тоо зэрэг хүчин зүйлсээс хамаарч шийдвэрлэх хугацаа нь харилцан адилгүй байдаг. Тухайлбал, нэг шүүгч олон тооны харьцангуй хялбар хэргүүдийг нэг өдөр шийдвэрлэж болох бол өөр шүүгч олон хэргийн оролцогчтой, ээдрээ төвөгтэй ганц хэргийг шийдвэрлэхэд хэдэн өдөр, хэдэн сар ч зарцуулж болно.⁵⁴⁷ Үүний дээр шүүгч нэг хэрэгт хэр их хугацаа зарцуулах нь шүүхийн захиргааны ажилтны дэмжлэг, мэдээлэл хялбар авах боломж бололцоо, шүүхийн мэдээллийн технологийн хөгжил, шүүх байрладаг газрын хууль эрх зүйн соёлын төлөвшилт зэргээс хамаарна.⁵⁴⁸

Дэлхийн улсууд шүүх, шүүгчийн ажлын ачааллыг тооцохдоо тухайн улсын шүүхийн байгууллага, хууль эрх зүйн тогтолцоо, шүүхийн байршил, онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр өөрийн орны нөхцөлд тохируулан дараах гурван уламжлалт аргачлалыг дангаар нь эсхүл тус гурван аргачлал дээр тулгуурласан дөрөв дэх аргачлалыг хэрэглэж байдаг. Үүнд:

- Тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулж буй цаг, минутаар нь ачааллыг тооцох буюу “хэргийн жингийн ачааллаар үнэлэх аргачлал” /*the Weighted Caseload Method*/;
- Дельфи аргачлал /*the Delphi Method*/;
- Норматив аргачлал /*the Normative Method*/;
- Холимог аргачлал зэрэг болно.

⁵⁴⁵ Энэхүү лавлагаа нь ШСМСХ-ийн судлаачид Г.Солонго болон Д.Аюуш нарын хамтран гүйцэтгэсэн “Шүүгчийн ажлын ачаалал, түүнийг тооцох аргачлал” сэдэвт бодлогын судалгааны хүрээнд боловсруулагдсан болно.

⁵⁴⁶ Dr.Heicke Gramkov, “Estimating staffing needs for justice sector”, Justice and development paper series # 19/2012, The Legal Vice Presidency, The World Bank, 2012

⁵⁴⁷ Andreas Lienhard, Daniel Kettiger Research on the caseload management of courts: Methodological questions, Utrecht Law Review, Volume 7, Issue 1 January 2011

⁵⁴⁸ Church, Thomas. 1986. —Examining Local Legal Culture. American Bar Foundation Research Journal 10 (3): 446–518.

Хэргийн жингийн ачааллаар үнэлэх аргачлал нь хэргийг маргааны төрөл, ээдрээ төвөгтэй байдлаар нь ялгаж, шүүгчийн ижил төсөөтэй хэрэг шийдвэрлэсэн давтамж, тухайн хэрэгт хийгдэж буй ажиллагаа бүрд зарцуулсан хугацааг тодорхойлсны үндсэн дээр шүүгч тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд зарцуулсан нийт хугацааг тооцон гаргадаг. Хэргийн жингийн ачаалал гэдэг нь шүүхэд ирсэн тодорхой нэг хэргийг хүлээн авснаас хойш хэргийг шийдвэрлэж дуусах хүртэлх хугацаанд хийсэн ажиллагаа тус бүрд зарцуулж буй дундаж хугацааг хэлнэ. Үүгээр хэргийн ачааллын үнэлгээг гаргана. Тус аргачлал нь хэргийг ээдрээ төвөгтэй байдлаар нь хэмжээний үндсэн дээр шүүгчийн ажлын ачааллыг тодорхойлдог хэдий ч практикт шүүгчийн гүйцэтгэдэг бусад ажиллагааг тооцдоггүй байна. Түүнчлэн энэ аргачлал нь шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өмнө болон дараа нь гүйцэтгэсэн ажиллагаа болон өдөр тутмын бусад ажлыг тооцдоггүйгээрээ шүүгчийн ажлын ачааллыг дутуу үнэлдэг талтай байдаг.

Хэргийн жингийн ачааллаар үнэлэх аргачлалыг шүүгчийн ажлын ачаалал, шүүхийн нөөц хангамжийг хэрэгцээг тодорхойлоход түгээмэл хэрэглэгддэг аргачлал юм.⁵⁴⁹ 1970-аад оноос хойш энэ аргачлалыг АНУ-д хэрэглэж бүрэн хэвшсэн байна. 2000 оны байдлаар АНУ-ын 15 мужийн шүүхүүд тус аргачлалаар шүүгчийн ажлын ачааллыг тооцон гаргаж байна.⁵⁵⁰ Түүнчлэн холбооны тойргийн шүүхүүд тус аргачлалыг ашиглан шүүгчийн ажлын ачааллыг тооцох баялаг туршлага хуримтлуулжээ.⁵⁵¹ Энэ талаар олон тооны судалгааны тайлан, мэдээлэл, холбооны болон мужийн шүүхийн тайлан зэрэгт гарсан байдаг.⁵⁵²

Европын Холбооны улс болох ХБНГУ нь 1970-аад оны эхэн үеэс хэргийн ачааллын судалгааг анхан болон давж заалдах шатны шүүхэд хийж эхэлсэн⁵⁵³ бол Европын бас нэг улс болох Нидерландын Вант улс нь энэ чиглэлээр чамгүй их туршлага хуримтлуулжээ.⁵⁵⁴ Сүүлийн жилүүдэд Европт “шүүхийн хэргийн жингийн ачаалал ба шүүгчийн ажлын ачаалал” сэдвээр олон тооны судалгаа, шинжилгээний ажил хийгдэх болсон. Тухайлбал, шүүхийн удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, боловсронгуй болгох чиглэлээр Бельги улсын Хууль зүйн яамнаас

⁵⁴⁹ Cf Stenz, “Improving Weighted Caseload Studies in Limited Jurisdiction Courts”, 1988-1989 The Justice System Journal 13, no.3, p.379.

⁵⁵⁰ Cf. B.J.Ostrom et al., Florida Delphi based-Weighted Caseload project, History of the Project, 2000, pp.3 et seq.

⁵⁵¹ Cf. B.S. Meierhoefer et al., The Caseload Experiences of the District Courts from 1972-1983: A Preliminary Analysis, FJC Staff Paper, Federal Judicial Center, 1985

⁵⁵² Cf. A.M.Bickel, Caseload of the Supreme Court and what, if Anything, to do About It, 1973; J.Jacoby, Case weighting Systems for Prosecutors, Guidelines and Procedures, 1987; V.E Flango et.al., How do States Determine the Need for Judges, 1993; A.B.Aikman et al., Designing a Judgeship Needs Process for Florida, Gryphon Consulting Services, 1998

⁵⁵³ ‘Richterzeitstudien’ Cf. Bundesrechtsanwaltskammer, Tatsachen zur Reform der Zivilgerichtsbarkeit, Vol.II,1974 pp.60 et seq.; Bundesrechtsanwaltskammer, Tatsachen zur Reform der Zivilgerichtsbarkeit, Vol.I,1974 pp.182 et seq.; G.Griebeling, Die Arbeitszeit des Richters, DRiZ 71 pp.228 et seq; R.Zwiesele&R.Bender, ‘Betriebswirtschaftliche Methoden und Vorschläge zur Verbesserung der Justizorganisation’;

⁵⁵⁴ R.Depre et al., Etude de faisabilité de la mise en oeuvre d’un instrument de mesure de la charge de travail destinée au siège, p.3.

шүүхийн хэргийн ачааллын талаар хэд хэдэн судалгаа хийсэн бол Швейцарь улсад олон тооны судалгаа хийгдэж байгааг дурдаж болно.⁵⁵⁵

Хэргийн жингийн ачааллаар үнэлэх аргачлалыг дараах дарааллаар гүйцэтгэнэ. Үүнд:

№	Үйл ажиллагаа
1.	Судалгаа хийх шүүх болон хэрэг, маргааны төрлийг сонгоно.
2.	Тодорхой нэг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хийгдэж буй ажиллагааг тодорхойлно.
3.	Хоёрдугаар алхмыг хэрэгжүүлэхэд шүүгчийн зарцуулж буй дундаж хугацааг тооцно.
4.	Өөр өөр төрлийн хэрэг, маргаан хянан шийдвэрлэхэд хийгдэж буй ижил төстэй ажиллагааны дундаж хугацааг тооцно.
5.	Шүүгчийн ажлын дундаж хугацааг түүний нэг хэрэг, маргаанд зарцуулсан хугацаагаар үржүүлснээр тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны “ачаалал”-ыг тооцно.
6.	Шийдвэрлэж буй хэрэг тус бүрийн ажиллагааны “ачаалал”-д үржүүлснээр тухайн хэрэгт зарцуулсан нийт хугацааг тооцно.
7.	Шүүгчийн тодорхой нэг хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулж буй дундаж хугацааг тооцно.
8.	Шүүгчийн тодорхой нэг хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулсан нийт хугацааг шүүгчийн ажлын дундаж хугацаанд хуваана.

Дельфи аргачлал гэдэг нь хууль зүйн салбарын шинжээч, мэргэжилтнүүдээс /шүүгч болон хуулийн салбарын бусад мэргэжилтнүүд/ санал асуулга авсны үндсэн дээр шүүгчийн төрөл бүрийн хэрэг, маргаанд зарцуулж буй дундаж хугацааг тооцсоноор шүүгчийн ажлын ачааллыг тооцох аргачлал юм. Энэ аргачлалын дагуу шүүгчийн ажлын цагийг урьдчилан тооцоолсноор шүүхийн хүний нөөцийн хэрэгцээ, бодлогыг тодорхойлох боломжтой юм. Дельфи аргачлал нь хэргийн жингийн ачааллаар үнэлэх аргачлалтай төстэй хэдий ч шүүгчийн ажлын ачааллыг тооцох үнэлгээ нь хэт субъектив бөгөөд зорилтот бүлгийн туршлагаас ихэд хамааралтай байдаг нь энэ аргачлалын сул тал нь болдог.

Норматив аргачлал⁵⁵⁶ гэдэг нь шүүгчийн ажлын ачааллыг тооцоход эдийн засгийн хувьд хамгийн хэмнэлттэй, энгийн аргад тооцогддог. Энэ аргачлалаар нэг тойрогт байрших шүүхүүдийн хэргийн ачааллыг харьцуулах замаар /үүнд, тухайн тойрог дахь нийт хэргийн тоог нийт шүүгчдийн тоонд хувааж тооцно/ шүүгчийн ажлын ачааллыг гаргана. Энэ байдлаар нэг хэрэгт ногдох шүүгчийн тоог ойролцоогоор гаргана.

Дээрх гурван аргачлал нь шүүхийн хэргийн ачаалал болон шүүгчийн ажлын ачааллын харилцан хамаарлыг тоон үзүүлэлтээр гаргаснаараа шүүгчийн ажлын ачааллыг үнэлэхэд хэрэглэгддэг үндсэн хэмжүүр болж чаддаг. Гэвч эдгээр аргачлал нь шүүгчийн ажлын ачааллыг бүрэн дүүрэн, хангалттай хэмжээгээр тооцоолж чаддаггүй. Эдгээр нь шүүгчийн хэрэг үүсгэхээс өмнөх, шүүхийн шийдвэр

⁵⁵⁵ Cf.A.Lienhard&D.Kettiger, ‘Geschäftslastbewirtschaftung bei den Gerichten’, 2009 ZBI, pp.413 et seq.;

⁵⁵⁶ Монгол Улсын хувьд шүүгчийн хэргийн ачааллыг энэхүү аргачлал дээр үндэслэн гаргаж байгаа нь харагдаж байна.

гарсны дараах болон шүүгчийн гүйцэтгэдэг бусад ажлыг тооцоолдоггүй. Иймд АНУ-ын Холбооны болон мужийн шүүхүүдэд шүүх болон шүүгчийн ажлын ачааллыг тооцоходоо тухайн мужийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, өмгөөлөгчдийн тоо, шүүгчийн ажил үүргийн хэрэгцээгээр өөр муж, газруудад явахад зарцуулсан хугацаа зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр тухайн мужийн онцлогт тохируулан дээрх гурван аргачлалыг нийлүүлсэн *Hybrid* буюу *хολимог* аргачлалыг боловсруулсан юм.

Хολимог аргачлалыг дээрх гурван уламжлалт аргачлалд тулгуурлан АНУ-ын “Насанд хүрээгүй этгээд болон гэр бүлийн шүүхийн шүүгчдийн үндэсний зөвлөл” нь “Хүүхдийн асрамжлагчийг тогтоох хэргийг хянан шийдвэрлэж буй шүүгч”-ийн ажлын ачааллыг тооцох шинэ аргачлал гаргажээ. Энэ аргачлалаар дараах зургаан хүчин зүйлсийг авч үзсэнээр шүүгчийн ажлын ачааллыг тооцно:

№	Үйл ажиллагаа
1.	Хүүхдийн асрамжлагчийг тогтоох хэргийг хянан шийдвэрлэж буй шүүгчийн хэрэг үүсгэхээс өмнөх, хэрэг үүсгэсний дараах буюу тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд гүйцэтгэж буй бүхий л ажиллагааг тооцоолно.
2.	Шүүх хуралдааны хугацаа ба чанарыг харьцуулан тооцоолно.
3.	Нэг жилд нийт “хүүхдийн асрамжлагчийг тогтоох” хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тоог гаргана.
4.	Тухайн шүүхэд ажиллаж буй нийт шүүгчдийн тоог гаргана.
5.	Шүүгчийн жилдээ ажиллаж буй дундаж хугацааг гаргана. ⁵⁵⁷
6.	Шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдолтойгоор гүйцэтгэсэн ажлуудыг тооцно.

Шүүгчийн ажлын ачаалал тооцох аргачлалын бүтэц⁵⁵⁸

Шүүгчийн ажлын ачааллыг тооцоход дараах дөрвөн хүчин зүйлсийг тооцож гаргана. Үүний тулд мөн шүүхийн захиргааны ажилтны ажлын ачааллыг тооцоноор шүүгчийн ажлын ачааллыг илүү бодитой тооцох боломжтой байдаг. Үүнд:⁵⁵⁹

№	Үйл ажиллагаа
1.	Шүүгчийн гүйцэтгэж буй бүхий л ажиллагаанд зарцуулж буй дундаж хугацааг тооцно.
2.	Шүүхийн хүлээн авсан бүхий л хэрэг, маргааныг тодорхой давтамж, төсөөтэй ажиллагаа зэрэг үзүүлэлтээр ангилна. Ингэж ангилах нь шүүгчийн ажлын ачаалал тооцох аргачлалын үндэс нь болдог.
3.	Шүүхийн хэргийн хөдөлгөөн, хэрэг хуваарилалтыг шүүх тус бүрээр жилээр нь тооцож гаргана.

⁵⁵⁷ National Council of Juvenile and Family courts, Juvenile and Family Court Journal 64, no.2, Spring, 2013

⁵⁵⁸ National Center for State Courts, Kansas District Court Judicial and Clerk Staff Weighted Caseload Study, October 31,2011

⁵⁵⁹ National Center for State Courts, Kansas District Court Judicial and Clerk Staff Weighted Caseload Study, October 31,2011

<p>4. Шүүгч болон шүүхийн захиргааны ажилтны гүйцэтгэж буй өдөр тутмын ажлыг үндсэн хоёр ангилалд хувааж тооцно. Үүнд:</p>
<ul style="list-style-type: none"> • Хэрэг үүсгэхээс өмнөх ажиллагаа, хэрэг үүсгэсний дараах ажиллагаа, шүүх хуралдаан, шүүхийн шийдвэр гаргасны дараах ажиллагаа болон хэрэгтэй холбоотой бусад ажиллагаа зэрэг орно.
<ul style="list-style-type: none"> • Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад ажил гэдэгт хууль, эрх зүйн судалгаа, шүүгчийн сургалт, шүүгчийн зөвлөгөөн зэрэг ажилтай холбоотойгоор бусад шүүгчтэй хийх уулзалт, бусад хурал, зөвлөгөөн, гадаад, дотоод томилолт, өвчтэй, чөлөөтэй байсан хугацаа, цайны завсарлага зэргийг тооцох боломжтой.

Дээрх дарааллаар шүүгчийн ажлын ачааллыг тооцсоноор шүүгчийн өдөрт хэрэг хянан шийдвэрлэхэд зарцуулахад шаардлагатай хугацааг гаргаж, үүнээс ямар төрлийн ажиллагааг гүйцэтгэх нь шүүгчээс их хугацаа шаардаж байгааг тооцоолох боломжтой болдог. Ингэснээр шүүгчийн ажлын ачааллыг бууруулахад ямар төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэдгийг боловсруулахад ач холбогдолтой.







ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖ⁵⁶⁰

Удиртгал

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ бол нэг төрлийн эрдэм шинжилгээний ажил мөн. Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийснээр бодит хэрэг маргаан дээр ажиллахаас гадна үүссэн маргааныг хууль, эрх зүйн талаас нь задлан шинжилж, бүхий л эрх зүйн онол, үзэл санаа, шүүхийн практикийг судлах боломж өгдгөөрөө сонирхолтой, бас үр өгөөжтэй судалгаа байдаг. Энэ нь оюутнуудын хууль хэрэглээний чадвар болон асуудалд дүн шинжилгээ хийх чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ, судлаач эрдэмтдийн бас нэгэн оюуны бүтээл болдог.

Иймд энэхүү арга зүйн зөвлөмжийн зорилго нь шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээг хөгжүүлж, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх явдлыг хэвшүүлэхийн тулд эрдэмтэн, багш, судлаачдыг шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх нэгдсэн аргачлал, арга зүйгээр хангах явдал болно. Энэ зорилгын хүрээнд, уг зөвлөмжид шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ гэж юу болох, түүний ашиг тус, ач холбогдол болон баримтлах зарчмуудыг тусган өгч, шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний байж болох бүтэц, агуулгыг тодорхойлохыг зорьсон юм.

Хуульч, судлаач, хууль зүйн сургуулийн оюутнууд гэх мэт шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх зорилготой хэн бүхэн энэхүү зөвлөмжийг ашиглаж болно. Мөн бүх шатны шүүхийн шийдвэрүүд дээр энэ арга зүйг ашиглаж болохоор байна. Гагцхүү эрүү, иргэн, захиргааны хэргийн шийдвэрийн тус бүрийн онцлогоос хамаарч энэхүү аргачлал нь төгс нийцэхгүй байхыг үгүйсгэхгүй. Цаашид шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх арга зүй, аргачлал нь салбар эрх зүйн онцлог, судлаачийн арга барилаас шалтгаалан олон хэлбэр, хэв маягийг үүсгэж болох боловч тэдгээрийн үндэс, тулгуур нь энэхүү зөвлөмж болно гэдэгт найдаж байна.

Нэг. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний ерөнхий ойлголт

1.1. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний тодорхойлолт

Монгол Улсад шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ гэж юу болох талаар тогтсон тодорхойлолт ховор. Гэвч агуулга, шинж чанарыг нь харгалзан дараах байдлаар тодорхойлж болох юм. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ нь тодорхой нэг шүүхийн шийдвэрийг хууль зүйн болон хэлбэрийн талаас нь задлан шинжилж, хууль зүйн асуудал, хууль хэрэглээ, онол практикийн холбоо хамаарал, ач холбогдлын талаар тайлбарлан бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл юм.

1.2. Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх зорилго

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх гол зорилго нь шүүхийн шийдвэрийг зөв уншиж ойлгох, шүүхээс хуулийг хэрхэн тайлбарлан хэрэглэж байгаа талаарх онол ба хууль хэрэглээний холбоо хамаарлыг судлах, шийдвэрийн эрх зүйн ач холбогдол зэргийг тайлбарлахад оршино.

⁵⁶⁰ Тус арга зүйн зөвлөмжийг ШСМСХ-ийн судлаач Б.Ариунзаяа /LL.M/ боловсруулав.

1.3. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний ач холбогдол

1) **Эрх зүйн хөгжлийг хурдасгана.**

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийснээр шүүхийн шийдвэрийг шинжлэх ухааны судалгааны эргэлтэд оруулан, онол практикийг уялдуулан судлах боломжийг нээж, эрх зүйн асуудлуудыг нээн илрүүлэх, тэдгээрийг шийдвэрлэх зэргээр үндэсний эрх зүйн хөгжилд хувь нэмэр оруулна.

2) **Хууль зүйн сургалтын чанарыг сайжруулна.**

Судлаач, оюутнууд шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийснээрээ эрх зүйн онол ба хууль тогтоомжийн уялдаа холбоо, хууль хэрэглэх арга зүйг танин мэдэхээс гадна шүүхийн шийдвэр бичих, боловсруулах арга техникт суралцана. Мөн судалгааны ажил хийхдээ тухайн сэдвийн хүрээнд шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийснээр судалгааг илүү бодитой, баялаг, үр нөлөөтэй болгоно.

3) **Шүүхийн нэр хүндийг өсгөнө.**

Сайн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийн, түүний ач холбогдлыг гарган ирснээр, нийгмийн дунд тухайн шүүгч, шүүхийн нэр хүндийг дээшлүүлнэ.

4) **Шүүгчийн хариуцлагыг нэмэгдүүлнэ.**

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийснээр шүүгч нар аливаа асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэсэн гэдгийг харуулж, цаашлаад шүүхийн шийдвэрийн бичвэр, үндэслэл сайжрах замаар шүүгчийн хариуцлагыг нэмэгдүүлнэ.

1.5. Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх субъект

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх этгээд нь хуульч, судлаач, хууль эрх зүйн сургуулиудын оюутнууд гэх мэт хэн ч байж болно.

1.6. Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд баримтлах зарчим

Судлаач нь нийтийн дарамт, хууль дүрэм журмын хориглолт болон хөндлөнгийн оролцоонд үл автан мэдлэг олж авах, судалгаа хийх академик эрх чөлөөтэй. Үүний зэрэгцээ үндэслэлтэй, судалгаатай, академик ёс зүйг чандлан баримтлах үүрэг хариуцлагатай. Үүнд тухайлбал,

1) *Бусдын оюуны бүтээлийг хүндэтгэх*⁵⁶¹

2) *Байгууллагын болон хувь хүний нууцыг хамгаалах*⁵⁶²

3) *Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх* зэрэг үнэт зүйлүүдийг ойлгоно.

1.7. Дүн шинжилгээ хийх шүүхийн шийдвэр

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхдээ, Улсын дээд шүүхийн тогтоол болон **хүчин төгөлдөр** давж заалдах шатны шүүхийн магадлалыг сонгон авахыг санал болгож байна. Мөн дуулиантай эсхүл шинэлэг асуудлыг хөндсөн анхан шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж болох авч хүчин төгөлдөр болсон эсэхийг нягтлан шалгах хэрэгтэй.

⁵⁶¹ Бусдын бүтээлээс иш татахдаа заавал ишлэл хэрэглэж байхыг анхаарна уу.

⁵⁶² Нууцын тухай холбогдох хуулиудад заасан нөхцөлийг анхаарна уу. Хэргийн агуулгыг (факт) танилцуулахад хэргийн оролцогчдын нэрийг үсгээр орлуулах нь зүйтэй. Тухайлбал, гадаадын зарим өндөр хөгжилтэй орнуудад (АНУ, Япон) нэхэмжлэгчийг Х, хариуцагчийг Y, гуравдагч этгээдүүдийг А, В, С гэх мэт нэрлэдэг жишиг байна.

Хоёр. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний үндсэн бүтэц

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ нь салбар эрх зүйн онцлог болон судлаачийн арга барилаас шалтгаалан олон янзын хэлбэр, хэв маягийг үүсгэн хөгжүүлэх нь дамжиггүй. Тиймээс энэхүү арга зүйн зөвлөмж нь гагцхүү байж болох бүтэц, түүний элементүүд буюу бүрдэл хэсгүүдийг санал болгож байгаа гэдгийг анхаарах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, доорх элементүүд буюу бүрдэл хэсгүүд нь заавал баримтлах дараалал биш байна.

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ нь 1/ Хэргийн агуулга буюу факт, 2/ Шийдвэрийн агуулга, 3/ Дүн шинжилгээ гэсэн үндсэн хэсгүүдтэй. Түүнчлэн 4/ Дүгнэлт гэсэн хэсгийг нэмж болно.

Үндсэн хэсэг		Агуулга
1	Эхлэл	<ul style="list-style-type: none"> ➢ Шүүхийн шийдвэрийн нэр ➢ Оршил
2	Хэргийн агуулга /факт/	<ul style="list-style-type: none"> ➢ Гол үйл явдал ➢ Өмнөх шатны шүүхийн шийдвэр, түүний үндэслэл
3	Шийдвэрийн агуулга	<ul style="list-style-type: none"> ➢ Тухайн шийдвэр, түүний үндэслэл
4	Дүн шинжилгээ	<ul style="list-style-type: none"> ➢ Маргаантай асуудал ➢ Эрх зүйн онол, судлаачдын үзэл санаа ➢ Ялгаатай ба төсөөтэй шүүхийн шийдвэр ➢ Судлаачийн хувийн үзэл бодол, байр суурь
		<ul style="list-style-type: none"> ➢ Хэлбэрийн болон хууль зүйн техникийн шаардлага
5	Дүгнэлт	<ul style="list-style-type: none"> ➢ Шүүхийн шийдвэрийн ач холбогдол ➢ Цаашид судлах шаардлагатай асуудал ➢ Товч дүгнэлт
6	Эх сурвалж	<ul style="list-style-type: none"> ➢ Ашигласан ном, өгүүлэл, бусад дүн шинжилгээ г.м

Гурав. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний агуулга

3.1.Эхлэл

Аливаа шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхдээ тухайн шийдвэрээ танилцуулах шаардлага гарна. Өөрөөр хэлбэл, ямар шийдвэр дээр дүн шинжилгээ хийх гэж буй, мөн тухайн шийдвэрийн бүрэн эхийг хаанаас олж болохыг агуулсан шүүхийн шийдвэрийн нэрийг танилцуулна. Шүүхийн шийдвэрийн нэр нь заримдаа шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний гарчиг болдог.

➢ Шүүхийн шийдвэрийн нэр

Иргэн, эрүү, захиргааны хэргийн онцлогоос хамаараад шүүхийн шийдвэрийг нэг аргаар нэрлэх хүндрэлтэй байна. Иймд судлаач сонгосон шийдвэрийн онцлогт тааруулж дараах 2 түгээмэл аргуудаас сонгон хэрэглэнэ үү.

- 1) Талуудын нэрээр нэрлэх

Нэхэмжлэгч хариуцагчийн нэрийг оролцуулна. Онцгой субъекттэй хэргийг шийдвэрлэсэн, мөн жишиг тогтоохуйц өндөр ач холбогдолтой гэж үзсэн шийдвэр дээр энэ аргыг хэрэглэж болохоор байна.

2) Маргааны агуулгаар нэрлэх

Уншигчдад хэргийн талууд хэн байх нь ач холбогдолгүй тохиолдолд энэ аргыг хэрэглэж болно. Энэ аргын онцлог нь уншигчдад шүүх ямар асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн гэдгийг олж харах боломжийг өгдөг. Үүнээс гадна дүн шинжилгээ хийж буй судлаач нь шийдвэрийн маргаантай асуудлыг зөв ойлгосон эсэхийг илтгэх шалгуур болдог.

➤ **Шийдвэрлэсэн шүүх, шийдвэрийн огноо, дугаар**

Сонгож авсан шүүхийн шийдвэрийг аль шүүхээс гаргасан, тухайн шийдвэрийн албан ёсны дугаар, огноог танилцуулах шаардлагатай.

➤ **Шийдвэрийн нийтлэгдсэн эх сурвалж**

Дүн шинжилгээ хийх гэж буй шийдвэрийг бүрэн эхээр ямар албан ёсны эх сурвалжаас авч болох вэ гэдгийг заана. Шүүхийн шийдвэрийн цахим сайтыг ишлэхдээ хэргийн индексийг зааж өгч болно.

➤ **Оршил**

Зарим дүн шинжилгээг харахад, “Хэргийн агуулга”-ын өмнө “Оршил” эсхүл “Тавигдаж буй асуудал” зэргээр тухайн шийдвэрийг сонгосон үндэслэл, ач холбогдол, хөндөж буй асуудлаа нэг өгүүлбэрээр дурдсан байх нь бий. Гэвч энэ бол заавал байх элемент биш, сонголтот бүрдэл хэсэг байна. Тус 2 аргыг хэрэглэсэн жишээг толилуулъя.

Цэцийн шийдвэрийн дүн шинжилгээ

УИХ э.Н.Хайдав (2007)¹

¹ УИХ э.Н.Хайдав, ҮХЦ, Дүгнэлт 2, 2007.02.23, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ

Үндэслэлгүйгээр ажлаас халагдсаны улмаас ажилгүй байсан хугацааны олговрыг гаргуулахтай холбоотой хэрэг¹

¹ Улсын дээд шүүхийн 2014 оны 4 дүгээр сарын 22-ны 214 дугаар тогтоол /Монгол улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл, I боть, 255 дахь тал/

3.2.Хэргийн агуулга /факт/

Энэ хэсэгт болсон үйл явдлыг танилцуулна. Өөрөөр хэлбэл, шийдвэрт тусгагдсан мэдээлэл дээр боловсруулалт хийж гол үйл баримтыг орхигдуулалгүй тодорхой байдлаар өгүүлнэ. Ингэхдээ нэхэмжлэгч хариуцагчийн тайлбараас шууд хуулбарлалгүйгээр, үнэн зөв хэмээн шүүхээр тогтоогдсон үйл баримтуудыг танилцуулна. Гол үйл баримт гэдэг нь шийдвэрийн үйл баримтууд дотроос тухайн үйл баримт өөрчлөгдвөл шийдвэрийн үндэслэл өөрчлөгдөж болох байсан үйл баримтыг хэлнэ.

Мөн энэ хэсэгт өмнөх шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл /процессын түүх/, давж заалдсан гомдлын агуулга зэрэг өнөөг хүртэлх ямар процесс үйл ажиллагаа явагдсаныг танилцуулна. Зарим дүн шинжилгээнд өмнөх шатны шүүхийн шийдвэрүүдийг “Шийдвэрийн агуулга” хэсэгт оруулах нь ч бий. Иймд аль хэсэгт оруулахыг судлаач өөрөө сонгож болохоор байна.

3.3.Шийдвэрийн агуулга

Шийдвэрийн агуулгыг танилцуулахдаа, “магадлалыг хүчингүй болгосон” эсхүл “магадлалыг хэвээр үлдээсэн” эсэхийг дурдаад, гол үндэслэлийг нь утга агуулгыг гажуудуулахгүй өгүүлнэ. Иймд үндэслэх хэсгийг бүрэн эхээр нь хуулбарлахгүйгээр гол хэсгийг нь ишлэх маягаар танилцуулж болно. Зарим тохиолдолд шийдвэрээс шууд ишилж бичих нь уншигчдыг төөрөгдүүлэхгүй байх арга юм.

3.4.Дүн шинжилгээ

Энэ хэсэгт дараах элементүүдийг хамааруулан анализ хийнэ. Эдгээр элементүүд нь дараалал биш, бүрдэл хэсгүүд тул гарцаагүй доорх дарааллыг баримтлан, дэд хэсгүүдэд хуваах шаардлагагүй. Өөрийн арга барилаар дүн шинжилгээг бичиж болно.

➤ Маргаантай асуудал

Судлаач нь тухайн шийдвэрээр ямар асуудлыг хөндөж тавьсныг тодорхойлон тайлбарлах шаардлагатай. Шүүхийн шийдвэрийн эрх зүйн асуудал нь процессын болон материаллаг эрх зүйн асуудал гэж хуваагдана. Гэхдээ процессын журам зөрчсөнтэй холбоотой шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх нь тийм ч ач холбогдолтой биш. Тиймээс материаллаг эрх зүйн асуудал хөндсөн шүүхийн шийдвэрийг сонгон, материаллаг эрх зүйн асуудлыг энд хөндөж тавих юм.

Зарим шүүгчид эрх зүйн асуудлыг маш товчхон бичсэн байдаг. Гэхдээ дүн шинжилгээ хийх гэж буй судлаачдын хувьд бүрэн хэмжээний эрх зүйн асуудлыг гаргаж ирэх нь илүү чухал юм. Зарим тохиолдолд шүүх шийдвэртээ эрх зүйн асуудлыг товч тодорхойлон бичээгүй байдаг учраас судлаачид үүнийг өөрсдөө танин мэдэх хэрэгтэй болдог. Ийм тохиолдолд талууд эрх зүйн асуудлыг хэрхэн тодорхойлж, тайлбарласныг сайн судлах хэрэгтэй. Энэ хэсэгт асуудлыг хөндөж тавьсны дараа тухайн асуудалд өгсөн шүүхийн хариулт, үндэслэлийн учир шалтгааны холбоо хамаарлыг өгүүлж болно. Өөрөөр хэлбэл, асуултад шүүх “тийм” гэж хариулсан уу, “үгүй” гэж хариулсан уу? Яагаад ингэж хариулсныг дүн шинжилгээ хийж буй судлаач нь шийдвэрлэсэн байдалтай уялдуулан бичиж болно.

➤ **Эрх зүйн онол, судлаачдын үзэл санаа**

Судлаач нь дээрх эрх зүйн асуудал, маргаантай холбоотой эрх зүйн онол, тайлбар, үзэл баримтлал, судлаачдын үзэл санааг тусгана. Ишлэлийг зайлшгүй хэрэглэвэл зохино.

➤ **Ялгаатай ба төсөөтэй шүүхийн шийдвэр**

Судлаач тухайн эрх зүйн асуудалтай холбоотой өмнө нь гарч байсан шүүхийн шийдвэрүүдийг судалж тусгана. Өмнө нь ижил төсөөтэй маргааныг шүүхээс хэрхэн шийдвэрлэж байсан, ямар үзэл баримтлалыг баримталсан бэ гэдгийг гаргаж ирнэ. Ингэхдээ аль болох Улсын дээд шүүхийн шийдвэрийг, хэрэв тухайн маргаантай холбоотой Улсын дээд шүүхийн шийдвэр байхгүй бол давж заалдах шатны шүүхийн магадлалыг сонгож болно. Хэрэв эдгээрийн аль аль нь байхгүй тохиолдолд анхан шатны шүүхийн шийдвэрийг сонгон судалж болно.

Өмнө нь гарсан шүүхийн шийдвэрүүдийг хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар нь ангилж бичих нь уншигчдад тустай. Тухайлбал, эдгээр нь дүн шинжилгээ хийж буй шүүхийн шийдвэртэй ижил байр сууриас шийдвэрлэсэн үү, эсрэг байр сууриас шийдвэрлэсэн эсэхийг ялган бичиж болно. Ингэж бичихдээ тухайн шийдвэрийн нэр, үндэслэлийн гол хэсгийг нь танилцуулна. Өмнө нь гарсан шүүхийн шийдвэр нь их байх тусам сайн боловч бүгдийг нь дүн шинжилгээндээ бичвэл хэт нуршуу болох эрсдэлтэй тул онц ач холбогдолтой гэсэн шийдвэрүүдийг сонгон авах нь зүйтэй юм.

➤ **Судлаачийн хувийн үзэл бодол, байр суурь**

Судлаач өөрийн хувийн үзэл бодол, байр сууриа илэрхийлэхдээ учир шалтгааны хувьд итгэл үнэмшил төрүүлэхүйц үйл баримтуудыг өөрийн оюун дүгнэлтээр харьцуулж үзэн, хэр үндэслэлтэй вэ гэдгийг бичиж тэмдэглэнэ.

Тухайлбал, ямар асуудал үүссэн, түүнтэй холбоотой онол, үзэл баримтлал хэрхэн үзэж байгаа, шүүх түүнийг хэрхэн шийдвэрлэв, хуулийг хэрхэн тайлбарлав, ямар үзэл баримтлалыг барив, мөн өөрийн үзэл бодол хэрхэн үзэж байгаа, шүүхийн шийдвэртэй ижил байр суурьтай байна уу, эсрэг байр суурьтай байна уу гэх мэт асуудлуудыг гаргаж ирэх юм. Мөн тухайн шийдвэрийн үндэслэлд бичигдсэн хууль тогтоомж нь ямар хүрээгээр хязгаарлагдаж байгаа буюу шийдвэрийн хамрах хүрээг гаргаж ирж болно.

➤ **Хэлбэрийн болон хууль зүйн техникийн шаардлага**

Энэ нь сонголтот бүрдэл хэсэг бөгөөд хэлбэрийн талаас анхаарал татахуйц зүйл байна гэж үзвэл судлаач энэ талаар өгүүлж болно. Ингэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйл, мөн Улсын дээд шүүхийн 2006 оны 4 сарын 25-ны “Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлалын тухай” зөвлөмжийг ашиглаж болно. Түүнчлэн утга найруулга, үг үсгийн алдаа зэрэг техникийн шаардлага талаас үнэлэлт өгч болно.

3.5. Дүгнэлт

Товч дүгнэлт бичнэ. Мөн дараах зүйлсийг тодруулан бичвээс шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ нь үр нөлөөтэй болох юм.

➤ **Шүүхийн шийдвэрийн ач холбогдол**

Шийдвэрийн ач холбогдлыг гаргаж тавихдаа, тухайн шийдвэрийн эрх зүйн хөгжилд оруулж буй хувь нэмэр, бусад шийдвэрүүдийн дунд эзлэх байр суурийг нь

тодорхойлж өгнө. Тухайн маргаантай асуудлыг шүүх шийдвэрлэснээрээ ямар шинэ хандлага, алхам, тайлбарыг бий болгов? Ямар нэгэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэв үү? Шүүхийн практик нэгэн шинэ хандлагыг тогтоож чадсан уу? зэргийг тайлбарлан бичнэ.

Шийдвэрийн ач холбогдлыг “Дүгнэлт” хэсгээс гадна “Оршил” хэсэгт, мөн “Дүн шинжилгээ” хэсэгт ч бас өгүүлж болохоор байна. Үүнийг мөн л судлаач өөрөө сонгохоор байна.

➤ ***Цаашид судлах шаардлагатай асуудал***

Уг шийдвэрт дүн шинжилгээ хийх явцад шинээр үүсэж буй асуудал, судлах шаардлагатай зүйл зэрэг үлдсэн нэмэлт асуудлыг энэ хэсэгт тэмдэглэж болно.

3.6.Эх сурвалж

Дүн шинжилгээ хийхэд ашигласан ном зохиол, сурах бичиг, өгүүлэл, илтгэл, бусад дүн шинжилгээ зэргийг багтаана.

-oOo-



ХАВСРАЛТ

Хавсралт №1 /Шүүх дэх иргэдийн төлөөлөгчийн оролцоог оновчтой бүрдүүлэх нь/

Хүснэгт 1. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг оролцуулах нөхцөл

№	Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг оролцуулах нөхцөл	Эрх зүйн эх сурвалж
1	-Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна.	Монгол Улсын Үндсэн хууль, 1992: Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг
2	- Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ ил тод байдал, шударга ёс, олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор иргэдийн төлөөлөгчийг хуульд заасан журмын дагуу оролцуулах бөгөөд иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.	Монгол Улсын шүүхийн тухай хууль, 2012: 8.4.
3	- Анхан шатны шүүх эрүүгийн хэрэг, эрх зүйн маргааныг анхан шатны журмаар, хамтын зарчмаар хянан шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийг оролцуулна. - Шүүхийн иргэдийн төлөөлөгч шүүгчийн дангаар шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцохгүй. - Хэрэг, маргааныг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд нэг иргэдийн төлөөлөгч оролцуулна.	Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2012: 3, 12 дугаар зүйл
4	- Шүүх анхан шатны журмаар хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэхэд 3 хүртэл иргэдийн төлөөлөгчийг оролцуулна. - Шүүхэд шилжиж ирсэн хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй энэ хуулийн 31-35-р бүлэгт дурдсан журмын дагуу ⁵⁶³ иргэдийн төлөөлөгч, улсын яллагч, өмгөөлөгчийг заавал оролцуулан шүүх хуралдаанаар хэлэлцэнэ.	Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002: 34.2, 383.1.
5	- Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг Шүүхийн тухай хуульд заасны дагуу оролцуулна. - Хэргийг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд гурав хүртэл иргэдийн төлөөлөгчийг оролцуулна.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002: 79.1, 86.1.
6	- Захиргааны хэргийг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд 3 хүртэл иргэдийн төлөөлөгч оролцуулна.	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2002: 56.1

⁵⁶³ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 31-р бүлэг. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа. 32-р бүлэг. Шүүх хуралдааны ерөнхий нөхцөл. 33-р бүлэг. Шүүх хуралдааныг эхлэх. 34-р бүлэг. Шүүхийн хэлэлцүүлэг. 35-р бүлэг. Шүүх хуралдааны шүүмжлэл, шүүгдэгчийн эцсийн үг.

Хүснэгт 2. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах нөхцөл, үе шат

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах нөхцөл, үе шат	Эрх зүйн эх сурвалж
<p>1.1. Шүүхийн ерөнхий зөвлөл иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах журам, иргэдийн төлөөлөгчийг сургалтад хамруулах нэгдсэн төлөвлөгөөг тус тус батална.</p> <p>1.2. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тухайн орон нутгийн хүн амын тоог үндэслэн баталсан жишиг тоог харгалзан иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг тухайн орон нутгийн анхан шатны шүүхийн тамгын газраас нутгийн захиргааны байгууллагатай хамтран гаргана.</p> <p>1.3. Иргэдийн төлөөлөгчийн нэрсийн нэгдсэн жагсаалтаас иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулах ажлыг тухайн шүүхийн тамгын газар зохион байгуулна.</p> <p>1.4. Шүүх иргэдийн төлөөлөгчийн нэрсийн нэгдсэн жагсаалтаас долоо хоног тутам 10-15 хүний нэрсийн дэд жагсаалтыг цахим хэлбэрээр тохиолдлын журмаар гарган тухайн шүүхийн тамгын газрын даргаар батлуулна.</p> <p>1.5. Шүүх хуралдааны тов зарлагдмагц энэ хуулийн дэд жагсаалтад нэр нь орсон нэг, нөөцөд хоёр иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаан тус бүрд сугалаагаар хуваарилна.</p> <p>1.6. Шүүх хуралдаанд оролцох тухай шүүхийн мэдэгдэх хуудсыг шүүх хуралдаан болохоос ажлын таваас доошгүй өдрийн өмнө иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон шалгарсан иргэнд хүргүүлж мэдэгдэнэ.</p> <p>1.7. Шүүхийн мэдэгдэх хуудсыг хүлээн авсан иргэдийн төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаантай⁵⁶⁴ бол энэ тухайгаа тухайн шүүхийн тамгын газарт нэн даруй мэдэгдэнэ.</p> <p>1.8. Шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчөөр сонгогдон шалгарсан иргэний ажил олгогчид мэдэгдэл хүргүүлнэ.</p>	<p>Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2012: 8.1, 8.2, 9.1-9.6</p>

Хүснэгт 3. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг томилох нөхцөл, үе шат

№	Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг томилох нөхцөл, үе шат	Эрх зүйн эх сурвалж
1	<p>- Тухайн шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон хуваарийн дагуу томилно.</p> <p>- Томилогдсон иргэдийн төлөөлөгч мэдэгдсээр байхад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол зохигчийн зөвшөөрлөөр түүний эзгүйд шүүх хуралдаан явуулж болно. Харин зохигчийн аль нэг нь үүнийг зөвшөөрөөгүй бол шүүх хуралдааныг хойшлуулна.</p>	<p>Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002: 79.2, 100.8</p>
2	<p>- Тухайн шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасны дагуу томилно.</p> <p>- Томилогдсон иргэдийн төлөөлөгч нь татгалзан гарах үндэслэл байхгүй бол шүүх хуралдаанд заавал оролцоно.</p>	<p>Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2002: 51.2, 51.3</p>

⁵⁶⁴ Хүндэтгэх шалтгаан гэдэгт тус хуулийн 9-р зүйлийн 9.8-д 1/ эмнэлгийн магадлалаар баталгаажсан эрүүл мэндийн нөхцөл байдлын улмаас шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон; 2/ ажил олгогчийн баталгаажуулсан албан томилолттой байсан; 3/ бага насны хүүхэд болон бусад этгээдийг асран хамгаалж байгаа бөгөөд энэ талаар хорооны Засаг даргын тодорхойлолттой бол; 4/ хүндэтгэн үзэх бусад шалтгаантай байсныг тус тус хамааруулсан.

Хүснэгт 4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх, үүрэг

№	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх, үүрэг	Эрх зүйн эх сурвалж
1	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх, үүрэг</p> <ol style="list-style-type: none"> 1. шүүхийн хэлэлцүүлгийн үед оролцогчид асуулт тавих эрхтэй; 2. нотлох баримтыг судалж үнэлсний үндсэн дээр шүүгдэгчийн гэм буруугийн талаар саналаа бичгээр гаргах эрхтэй; 3. иргэдийн төлөөлөгч саналаа шүүх хуралдаанд уншиж сонсогж болно; 4. нотлох баримтыг шинжлэхэд оролцож, аль ч үед тодруулах асуулт тавих эрхтэй; 5. иргэдийн төлөөлөгчид санал зөрсөн тохиолдолд саналаа тус тусдаа гаргаж болно. 6. Шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол энэ тухай урьдчилж бичгээр шүүхэд заавал мэдэгдэх үүрэгтэй. 7. Шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр шүүгдэгчид асуулт тавьж болно. 8. Шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр шүүхийн хэлэлцүүлгийн аль ч үед гэрчид асуулт тавина. 9. шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр шүүхийн хэлэлцүүлгийн аль ч үед шинжээчид асуулт тавих эрхтэй. 10. шүүгдэгчийн гэм буруугийн талаар саналаа уншиж сонсогж болно. 	<p>Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002: 34, 242, 261.3, 263.2, 267.5, 271.3, 272.3, 279.2, 320.1.7, 383 дугаар зүйл</p>
2	<p>Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх, үүрэг</p> <ol style="list-style-type: none"> 1. хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх; 2. хуульд заасан үндэслэлээр шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах, нотлох баримтыг шинжлэхэд оролцох; 3. зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, шинжээчид асуулт тавих; 4. хэргийн үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар бичгээр дүгнэлт гаргах; 5. шүүгчдийн зөвлөлгөөнөөс хуваарилсан шүүх хуралдааныг таслахгүй байх; 6. өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлын нууцыг задруулахгүй байх; 7. хуульд заасан шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэх. 8. хэргийн үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар гаргасан дүгнэлтийг шүүх хуралдаанд уншиж сонсоно. 9. эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас дүгнэлтээ бичгээр гаргах боломжгүй бол энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлж, амаар дүгнэлт гаргаж 	<p>Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002: 86, 113 дугаар зүйл</p>

	болно.	
3	<p>Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх, үүрэг</p> <ol style="list-style-type: none"> 1. шүүхийн байранд хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх; 2. нотлох баримт шинжлэхэд оролцох; 3. хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гэрч, шинжээчид асуулт тавих; 4. нэмэлт нотлох баримт цуглуулах талаар хүсэлт гаргах; 5. хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн гэм буруутай эсэхийн талаар дүгнэлт гаргах; 6. өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудлыг задруулахгүй байх; 7. хуульд заасан шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэх. 8. хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн гэм буруутай эсэхийн талаар гаргасан иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүх хуралдаанд уншиж сонсгоно. 9. хуульд заасан үндэслэл байвал захиргааны хэрэг хянан шийдвэрлэхэд үл оролцох ба өөрөө татгалзан гарах үүрэгтэй. 10. хүсвэл өөрийн татгалзан гарч буюу гаргагдаж байгаа тайлбар гаргах. 	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2002: 56, 64, 65 дугаар зүйл
4	<p>Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бусад эрх, үүрэг</p> <ol style="list-style-type: none"> 1. хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх(эд) оролцох; 2. хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх. 3. хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн, хэрэг, маргааныг хэнээс ч хараат бусаар шийдвэрлэх 4. шүүх хуралдааныг орхин явахгүй байх, хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд шүүх хуралдаанд хүрэлцэн ирэх; 5. шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэх; 6. хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгчтэй уулзахгүй байх; 7. хэргийн талаар нотлох баримт цуглуулахгүй байх; 8. өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулахгүй байх; 9. хэвлэл мэдээллийн хэрэгсэлд иргэдийн төлөөлөгчөөр оролцсон хэргийн талаар мэдээлэл өгөхгүй байх; 10. зөвлөлдөх тасалгаанд гаргасан санал, хэлэлцсэн асуудлыг задруулахгүй байх. 	Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль, 2012: 3, 4 дүгээр зүйл

Хүснэгт 5. Шүүхийн сонгомол шийдвэрүүдэд иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг тусгаж, түүнийг үнэлсэн байдал

№	Шүүхийн шийдвэр	Тоо 565	Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт, дүгнэлтийг үнэлсэн байдал
1	Эрүүгийн хэрэг		
1.1	Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014.06.12-ны өдрийн 750 дугаар цагаатгах тогтоол	3	Тогтоолд дүгнэлтийн талаар бичээгүй.
1.2	Сум дундын 4 дүгээр шүүхийн 2014.05.19-ний өдрийн 38 дугаар шийтгэх тогтоол	3	Тогтоолд дүгнэлтийн талаар бичээгүй.
1.3	Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014.04.07-ны өдрийн 440 дүгээр шийтгэх тогтоол	3	Тогтоолд дүгнэлтийн талаар бичээгүй.
1.4	Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014.01.17-ны өдрийн 110 дугаар шийтгэх тогтоол	3	Тогтоолд дүгнэлтийн талаар бичээгүй.
1.5	Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014.02.28-ны өдрийн 292 дугаар шийтгэх тогтоол	3	Тогтоолд дүгнэлтийн талаар бичээгүй.
1.6	Сум дундын 24 дүгээр шүүхийн 2014.02.11-ний өдрийн 19 дүгээр шийтгэх тогтоол	3	Тогтоолд дүгнэлтийн талаар бичээгүй.
1.7	Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 4 дүгээр шүүхийн 2014.07.25-ны өдрийн 91 дүгээр шийтгэх тогтоол	3	Тогтоолд дүгнэлтийн талаар бичээгүй.
1.8	Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014.03.03-ны өдрийн 301 дүгээр шийтгэх тогтоол	3	Тогтоолд дүгнэлтийн талаар бичээгүй.
1.9	Улсын Дээд шүүхийн эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2014.06.25-ны өдрийн 248 дугаар тогтоол	-	Тодорхойлох хэсэгт хяналтын шатны шүүхэд ялтны өмгөөлөгч О.Ц гаргасан гомдол болон тус шүүх хуралдаанд хэлсэн саналдаа "...мөн иргэдийн төлөөлөгчдийн "тухайн гэмт хэрэгт хохирогчийн буруутай үйлдэл нөлөөлсөн, гэмт хэргийг санаатай эсхүл болгоомжгүй үйлдсэнийг нотлох баримт байхгүй" гэх дүгнэлтийг шүүх харгалзан үзэлгүй, зөвхөн яллах талын байр суурьнаас шийдвэр гаргаж, шүүгдэгчийн хууль ёсны эрх ашгийг зөрчсөн"

⁵⁶⁵ Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тоо

			гэснийг дурдаж бичсэн байна.
2	Иргэний хэрэг		
2.1	Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2014.01.07-ны өдрийн 02 дугаар тогтоол	-	Түүнээс гадна уг хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх үед иргэдийн төлөөлөгч "... С.Ц нь хилс хэргээр ял эдэлснээр эрүүл мэндээр хохирсон" гэснийг анхан шатны шүүх хэрхэн үнэлсэн талаар шийдвэрт тусгагдаагүй байна.
3	Захиргааны хэрэг		
3.1	Захиргааны хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014.01.17-ны өдрийн 02 дугаар шийдвэр	1	Иргэдийн Төлөөлөгчөөс шүүх хуралдаанд гаргасан дүгнэлтдээ: "Өлгий сумын ... дугаар багийн иргэн О.Л нь Өлгий сумын ... дугаар багаас бусад газарт үйлчилгээ явуулах газар эзэмшиж болно гэсэн шийдвэр, Газрын тухай хуулийг зөрчсөн байна. Иймд нэхэмжлэл нь үндэсгүй байна" гэв. ⁵⁶⁶
3.2	Захиргааны хэргийн анхан шатны 8 дугаар шүүхийн 2014.03.21-ний өдрийн 06 дугаар шийдвэр	3	Иргэдийн төлөөлөгч М.О шүүх хуралдаан дээр хэлсэн дүгнэлтдээ: "Нэхэмжлэгч "СС" ХХК-ийн захирал Д.Н, хариуцагч Дорнод аймгийн Засаг дарга О.Д нарын "Газар эзэмших эрхийг хүчингүйд тооцох тухай" аймгийн Засаг даргын 2014.01.16-ны өдрийн А/13 дугаар захирамжийг хүчингүйд тооцуулах тухай захиргааны хэргийн материалтай танилцаад доорхи саналыг гаргах нь: Энэ хэргийн талаар аймгийн Засаг дарга Ү.Д-гийн 2013.11.13-ны өдрийн А/304 тоот захирамж нь ямар нэг хувийн болон улс төрийн шинжийг агуулаагүй гэж үзэх үндэслэлтэй байгаа учир одоогийн аймгийн Засаг дарга О.Д-гийн 2014.01.16-ны өдрийн А/13 тоот захирамж нь хүчинтэй бус гэж үзэхээр байгаа учир хэргийн материалд байгаа үнэн бодит байдалд нь тулгуурлан шийдвэрлэх нь зүйтэй гэсэн саналтай байна" гэв. ⁵⁶⁷
3.3	Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн 2014.02.05-ны өдрийн 57 дугаар шийдвэр	1	Иргэдийн төлөөлөгч М.Т шүүх хуралдаанд гаргасан дүгнэлтдээ: "ХД" ХХК-ийн нэхэмжлэлтэй Татварын ерөнхий газрын Татварын улсын байцаагч нарт холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг хэлэлцэн шийдвэрлэсэн шүүх хуралд иргэдийн төлөөлөгчийн гаргах санал дүгнэлтийг тооцох: "ХД" ХХК-ийн гомдол хүсэлтийг, нотлох баримтыг мэтгэлцээний зарчмаар гүнзгийрүүлэн судалж, тодотгон тогтоосон

⁵⁶⁶ Тогтоох хэсэгт: ...нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.

⁵⁶⁷ Тогтоох хэсэгт: Дорнод аймгийн Засаг даргад холбогдох, "СС" ХХК-ийн "Газар эзэмших эрхийг хүчингүйд тооцох тухай" Дорнод аймгийн Засаг даргын 2014.01.16-ны өдрийн А/13 дугаар захирамжийг хүчингүй болгуулах"-ыг хүссэн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.

			зүйлүүдийг үндэслэн шийдвэрлэх нь зүйтэй байна. Нэхэмжлэгч талын зөрүүтэй ойлголт байсан нь тогтоогдлоо” гэв. ⁵⁶⁸
3.4	Захиргааны хэргийн анхан шатны 16 дугаар шүүхийн 2014.03.18-ны өдрийн 09 дүгээр шийдвэр	1	Иргэдийн төлөөлөгч дүгнэлтэндээ: “Захиргааны хэргийн анхан шатны 16 дугаар шүүхэд Увс аймгийн Завхан сумын харъяат Ю овогт Г.Д-гийн нэхэмжлэлтэй захиргааны хэргийн шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 56 дугаар зүйлийг баримтлан өнөөдрийн шүүх хуралдаанд оролцож байна. Нэхэмжлэлийн үндэслэл нь: Увс аймгийн аудитын газар Завхан сумын сургуулийн төсвийн орлого зарлагад 2011, 2012 онуудыг хамруулан шалгалт хийж дүнг аймгийн Засаг даргад танилцуулан энэ дагуу Засаг дарга Ю.Х захирал Г.Д-г мөнгө, санхүүгийн ашиглалт, зарцуулалтад доголдол гаргасан гэж үзээд сургуулийн захирлын албан тушаалаас нь халах захирамж гаргасныг миний алдаа зөрчил биш нягтлан бодогчийн санхүүгийн асуудал учир би халагдахгүй, сургуулийн захирлаар эгүүлэн томилуулах тухай нэхэмжлэл гаргажээ. Өнөөдрийн шүүх хуралдаанд оролцсон нэхэмжлэгч, хариуцагч нарын тайлбар болон хавтас хэрэгт авагдсан бичгийн баримтуудаас үзэхэд Увс аймгийн Засаг даргын захирамж хуулийн уялдаа холбоо зөрчилтэй гарсан боловч нэхэмжлэгч нь шаардлагаа нэмэгдүүлсэн учир эцэслэн шийдвэрлэх боломж үүсэхгүй байна” гэв. ⁵⁶⁹

⁵⁶⁸ Тогтоох хэсэгт: Нэхэмжлэгч “ХД” ХХК-ийн гаргасан “Татварын ерөнхий газрын Улсын төсвийн орлого хяналтын газрын Хяналт шалгалтын хэлтсийн татварын улсын байцаагч У.Б, Д.Н нарын 2011 оны 4 дүгээр сарын 29-ний 210061 дүгээр актын тогтоох хэсгийн хоёр, дөрөв дэх хэсгийг хүчингүй болгуулах” тухай нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.

⁵⁶⁹ Тодорхойлох хэсэгт: нэхэмжлэгч Г.Д-н нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, Увс аймгийн Засаг даргын 2013 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Захирлын үүрэгт ажлаас чөлөөлж, үүргийг түр орлон гүйцэтгэгчээр авч ажиллуулах тухай” Б/89 дугаартай захирамжийг хууль бус болохыг тогтоон хүчингүй болгож, Г.Д-г Завхан сумын дунд сургуулийн захирлын албан тушаалд эгүүлэн тогтоосугай.

**Хавсралт №2 /Олон улсын иргэний процессын эрх зүй ба Монгол
Улсын шүүх дэх иргэний хэргийн харилцан туслалцаа үзүүлэх
ажиллагаа/**

**Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу харилцах эрх бүхий төв
байгууллагын жагсаалт**

№	Гэрээний нэр	Эрх бүхий төв байгууллага	
		Гэрээлэгч	Монгол Улс
1	Бүгд Найрамдах Унгар Ард Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /1968.11.22/	Шүүх, прокурор, улсын нотариатын байгууллагуудын төв байгууллагууд	Шүүх, прокурор, улсын нотариатын байгууллагуудын төв байгууллагууд
2	Бүгд Найрамдах Болгар Ард Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /1968.11.27/	Шүүх, прокурор, нотариатын байгууллагууд	Шүүх, прокурор, нотариатын байгууллагууд
3	Бүгд Найрамдах Социалист Румын Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /1972.11.25/	Шүүх яам, Ерөнхий прокурорын газар	Улсын Дээд Шүүх, Улсын Ерөнхий Прокурорын газар
4	Бүгд Найрамдах Социалист Чехословак Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /1976.10.15/	Улсын Ерөнхий Прокурорын газар, Шүүх яам	Улсын Ерөнхий Прокурорын газар, Хууль зүйн яам
5	Бүгд Найрамдах Социалист Югослав Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /1981.6.8/	Хуулийн байгууллагууд	Хуулийн байгууллагууд
6	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /1988.10.29/	Шүүх, прокурор, улсын нотариатын болон эрх бүхий бусад төв байгууллага	Шүүх, прокурор, улсын нотариатын болон эрх бүхий бусад төв байгууллага
7	Бүгд Найрамдах Куба Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /1988.10.29/	Шүүх, прокурор, улсын нотариатын болон эрх бүхий бусад төв байгууллага	Шүүх, прокурор, улсын нотариатын болон эрх бүхий бусад төв байгууллага
8	Бүгд Найрамдах Хятад Ард Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /1989.08.31/	БНХАУ-ын Шүүх Яам, БНХАУ-ын Ардын дээд шүүх	Хууль зүйн яам, Дээд шүүх
9	Бүгд Найрамдах Франц Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /1992.02.27/	Хууль зүйн яам	Хууль зүйн яам

10	Бүгд Найрамдах Казахстан Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /1993.10.22/	Хууль зүйн яам, Улсын Ерөнхий Прокурорын газар	Хууль Зүйн яам, Улсын Ерөнхий Прокурорын газар, Улсын Дээд Шүүх
11	Украйн Улстай байгуулсан иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /1995.06.27/	Хууль Зүйн Яам, Улсын Дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар	Хууль зүйн яам; Улсын Дээд шүүх
12	Бүгд Найрамдах Польш Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /1998.10.19/	Хууль зүйн яам	Хууль зүйн яам
13	Оросын Холбооны Улстай байгуулсан иргэний ба эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /1999.04.20/	Хууль зүйн яамны байгууллагууд, Дотоод явдлын яам, прокурор, шүүх, нотариатын байгууллага түүнчлэн өөрийн эрх мэдлийн асуудлаар бусад байгууллага	Хууль зүйн яамны байгууллагууд, прокурор, шүүх, Цагдаагийн Ерөнхий газар, нотариатын байгууллага, түүнчлэн өөрийн эрх мэдлийн асуудлаар бусад байгууллага;
14	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /2000.04.17/	Хууль зүйн яам, Ардын дээд прокурорын газар	Хууль зүйн яам, Улсын Ерөнхий прокурорын газар
15	Бүгд Найрамдах Турк Улстай байгуулсан иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /2000.05.02/	Хууль зүйн яам	Хууль Зүйн яам
16	Бүгд Найрамдах Энэтхэг Улстай байгуулсан иргэний ба аж ахуйн хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /2001.01.03/	Хууль, эрх зүй, компанийн асуудал эрхэлсэн яам	Хууль зүйн яам
17	Бүгд Найрамдах Солонгос Улстай байгуулсан иргэний болон худалдааны хэргийн талаар эрхийн туслалцаа, харилцан үзүүлэх тухай гэрээ /2008.10.15/	Үндэсний шүүхийн захиргаа	Дээд Шүүх

Хавсралт №3 /Шүүх хуралдааны явцыг олон нийтэд дамжуулах гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт, туршлага/

“Эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах тухай” зөвлөмж

1-р зарчим. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэл өгөх

Олон нийт нь шүүхийн эрх бүхий байгууллагын болон цагдаагийн албаны үйл ажиллагааны мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүлээн авах ёстой. Иймд сэтгүүлчид зөвхөн энэ зарчимд заасан хязгаарлалтын хүрээнд эрүүгийн хэргийн шүүхийн тогтолцооны чиг үүргийн талаар чөлөөтэй мэдээлж, тайлбар хийх ёстой.

2-р зарчим. Гэм буруугүйд тооцох

Шударга шүүхээр шүүлгэх эрхийн хэсэг болох гэм буруугүйд тооцох зарчмыг хүндэтгэх. Энэ ёсоор эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаатай холбоотой мэдээлэл, дүгнэлтийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зөвхөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гэм буруугүй байж болох талаарх таамаглалыг хөндөхгүйгээр түгээнэ.

3-р зарчим. Мэдээллийн үнэн зөв байдал

Шүүхийн эрх бүхий байгууллага болон цагдаагийн алба нь зөвхөн хангалттай үндэслэлтэй таамаг дээр үндэслэсэн баталгаажсан мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгнө. Тодорхой заасан мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгнө.

4-р зарчим. Мэдээлэл олж авах

Шүүхийн эрх бүхий байгууллага болон цагдаагийн алба нь тухайн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны мэдээллийг хууль ёсоор олж авах боломжийг сэтгүүлчдэд олгох бөгөөд дээрх байгууллагууд нь ийм мэдээллийг олж авах явдлыг ямар нэг ялгаварлан гадуурхалтгүйгээр бүх сэтгүүлчдэд ижил байлгана.

5-р зарчим. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг мэдээллээр хангах арга зам

Шүүхийн эрх бүхий байгууллага болон цагдаагийн алба нь тухайн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны мэдээллээр хэвлэл мэдээллийн хэрэгслийг хангах арга замаа өөрөө шийднэ. Ямар нэг ялгаварлан гадуурхалгүйгээр мэдээллийг эрх бүхий ажилтан хэвлэлийн мэдээ, хэвлэлийн бага хурал зэрэг хэлбэрээр хүргэнэ.

6-р зарчим. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явц дахь тогтмол мэдээлэл

Олон нийтийн ашиг сонирхолтой холбоотой эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нөхцөл буюу олон нийтийн анхаарлыг татсан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны талаар шүүхийн эрх бүхий байгууллага болон цагдаагийн алба нь мөрдөн байцаалтын нууцыг задруулахгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад болохгүйгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдэгдэх ёстой. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа урт хугацаанд үргэлжилж буй тохиолдолд мэдээллийг тогтмол өгч байна.

7-р зарчим. Мэдээллийг ашиглахыг хориглох

Шүүхийн эрх бүхий байгууллага болон цагдаагийн алба нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцын мэдээллийг арилжааны зорилгоор буюу хууль сахиулахтай холбоогүйгээр ашиглах ёсгүй.

8-р зарчим. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцын мэдээллийн нууцыг хамгаалах

Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцийн 8-р зүйлд заасны дагуу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдогч болон бусад этгээдийн нууцаа хамгаалах эрхийг хүндэтгэнэ. Ялангуяа насанд хүрээгүй хүн, гэрч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэр бүлийг онцгойлон хамгаална. Ямар ч тохиолдолд тухайн этгээдийн хувийн мэдээллийг задруулах нь хортой үр нөлөөтэй байна.

9-р зарчим. Залруулах, тайлбар өгөх эрх

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр ташаа буюу нэр төрийг нь гутаан мэдээлсэн бол тэдгээр оролцогч нь түүнийг залруулах буюу өөрийгөө хамгаалан тайлбар өгөх эрхтэй байна. Ингэж залруулах эрх нь шүүхийн эрх бүхий байгууллага болон цагдаагийн албаны зүгээс гаргасан ташаа мэдээллийн үед ч хэрэгжинэ.

10-р зарчим. Шүүхийн өмнөх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны талаарх тухайн мэдээллийг олон нийтэд өгөх нь шүүгчид, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн шударга байдал, үйл ажиллагаанд ихээхэн хэмжээний хохирол учруулах эрсдэлтэй бол шүүхийн эрх бүхий байгууллага болон цагдаагийн алба нь тийнхүү мэдээлэл өгөхөөс түдгэлзэнэ.

11-р зарчим. Шүүхийн өмнөх шатанд шүүх хуралдаанаас өмнө олон нийтэд мэдээлэл өгөх нь

Сэжигтэн, яллагдагчийн талаарх мэдээлэл нь түүний шударга шүүхээр шүүлгэх эрхийг зөрчсөн буюу тийнхүү зөрчихүйц нөхцөл бий болгосон гэж үзвэл тухайн этгээд өөрт нь учирсан гэм хорыг арилгуулахаар шаардах буюу хууль зүйн зохих арга хэмжээ авах эрхтэй.

12-р зарчим. Сэтгүүлчдийг нэвтрүүлэх

Сэтгүүлчид нээлттэй шүүх хуралдаан, шийдвэр сонсгох үйл ажиллагаанд ямар нэг хязгаарлалтгүйгээр буюу баталгаа гаргахгүйгээр нэвтрэхийг зөвшөөрнө. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцийн 6-р зүйлд заасны дагуу хаалттай шүүх хуралдаанд сэтгүүлчид нэвтрэхгүй.

13-р зарчим. Шүүх хуралдааны танхимд сэтгүүлчдийг нэвтрүүлэх

Хүндэтгэх шалтгаантайгаас бусад тохиолдолд эрх бүхий байгууллага нь шүүх хуралдааны танхимд сэтгүүлчдэд зориулсан, шаардлага хангахуйц тодорхой тооны суудлыг бэлтгэсэн байна.

14-р зарчим. Шүүх хуралдааны танхимаас шууд дамжуулах, бичлэг хийх

Хуулиар зөвшөөрсөн буюу шүүхийн байгууллага тийнхүү шийдвэрлэснээс бусад тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслийн зүгээс шүүх хуралдааны танхимаас шууд дамжуулах, бичлэг хийж болохгүй. Зөвхөн шүүгч, шүүхийн иргэдийн

төлөөлөгч, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хохирогч, гэрч, бусад оролцогчдод зүй бусаар нөлөөлөх ноцтой эрсдэлгүй үед л шүүх хуралдааныг дамжуулахыг зөвшөөрнө.

15-р зарчим. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг дэмжих

Хүндэтгэх шалтгаантайгаас бусад тохиолдолд шүүх хуралдааны тов, ял шийтгэлийн мэдээлэл зэрэг хууль зүйн үйл явдлын мэдээллийг сэтгүүлчдэд тэдгээрийн хүсэлтээр эрх бүхий байгууллага цаг тухайд нь өгнө. Сэтгүүлч нээлттэй шүүх хуралдааны шийдвэрийн хуулбарыг хүлээн авахад түүнд ямар нэг хэлбэрээр саад хийхгүй. Сэтгүүлчид шүүхийн шийдвэрийг олон нийтэд түгээх, танилцуулах боломжтой байна.

16-р зарчим. Гэрчийг хамгаалах

Гэрчийн зөвшөөрлийг урьдчилан авсан буюу гэрчийн талаарх мэдээлэл нь олон нийтэд аль хэдийн ил болсноос бусад тохиолдолд гэрчийг илчлэх, түүний биеийн байцаалтын мэдээллийг задруулахгүй. Амь нас, аюулгүй байдалд нь аюулд учруулахаар бол гэрчийг хэзээ ч илчлэхгүй. Зохион байгуулалттай гэмт хэрэг буюу гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн гэмт хэргийг хянан шалгах үйл ажиллагаанд гэрчийг хамгаалах зохих ёсны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

17-р зарчим. Шүүхээс оногдуулсан ял шийтгэлийн хэрэгжилтийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх

Хорих ангийн аюулгүй байдал, хорих ангийн алба хаагч болон хоригдлын эрх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын зохих үйл ажиллагаанд хохирол учруулахгүйгээр хорих ангид ял эдэлж буй этгээдтэй холбоо барихыг сэтгүүлчдэд зөвшөөрнө.

18-р зарчим. Шүүхээс оногдуулсан ялыг эдэлж дууссаны дараа хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх

Шүүхээс оногдуулсан ялыг эдэлж дууссан этгээдийн анх үйлдсэн гэмт хэрэг нь дахин олон нийтийн санааг зовоох буюу дахин олон нийтийн анхаарлыг түгшээсэн тохиолдолд тухайн этгээдийн хувийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, задруулахын тулд түүнээс зөвшөөрлийг нь авсан байх, нийгэмшихэд нь хохирол учруулахгүй байх, Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцийн 8-р зүйлд заасан хувийн нууцаа хамгаалах эрхийг зөрчихгүй байх ёстой.

-оОо-